FRIEDRICH EBERT STIFTUNG

MONGOLIAN INSTITUTE FOR INNOVATIVE POLICIES



ХҮН БҮРТ ХҮРТЭЭМЖТЭЙ МОНГОЛЫГ БҮТЭЭХ ТҮҮХҮҮД

UNTOLD

UNTOLD: ХҮН БҮРТ ХҮРТЭЭМЖТЭЙ МОНГОЛЫГ БҮТЭЭХ ТҮҮХҮҮД

Энэхүү бүтээлийг Фридрих-Эбертийн сангаас Бодлогын Инновацийн Хүрээлэнтэй хамтран бэлтгэн гаргав. Тус номны аливаа агуулга, мэдээллийн үнэн зөв нь Фридрих-Эбертийн сан болон Бодлогын Инновацийн Хүрээлэнгийн байр суурьтай нийцэж байх албагүй болно.

Номын төслийн багт:	М. Сайнбуян (Антолд төслийн менежер) Ж. Мэндээ (Антолд төслийн багийн зөвлөх) Б. Сарангуа (ФЭС-гийн хөтөлбөрийн менежер)
Редактор:	Рияа Тикку (Англи хэл) С. Өсөхбаяр (Монгол хэл) Л.Алтанзаяа (Монгол хэл) Н.Соёлгэрэл (Монгол хэл)
Блогпост нийтлэлч:	Ж. Мэндээ Б. Булган Ч. Нямсүрэн Т. Ганчулуун Б. Дэлгэрбаяр Б. Идэрболд Б. Батдэлгэр Ж. Ананд С. Одмаа Т. Өэлүн
Эхийг бэлтгэсэн:	Ё.Батболд

©ХБНГУ-ын Фридрих-Эбертийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар болон Бодлогын Инновацийн Хүрээлэнгээс эрхлэн гаргав. Уг бүтээлийн эрх хуулийн дагуу хамгаалагдсан тул зөвшөөрөлгүйгээр болон эшлэлгүйгээр хуулбарлах, олшруулах, хэсэгчлэн авах, ашиглах, арилжааны зориулалтаар хэвлэн нийтлэхийг зохиогчийн эрх зөрчсөнд тооцно.

ХҮН БҮРТ ХҮРТЭЭМЖТЭЙ МОНГОЛЫГ БҮТЭЭХ ТҮҮХҮҮД

2021 он

АГУУЛГА

	Өмнөх үг	5
	Оршил	6
1.	Г.Баттулга “Ангараг гараг руу аялахыг хүсдэг нэгэн”	7
2.	Л.Алтангэрэл “Баавгай олон янз байдгийн адилаар хүн ч олон янз”	21
3.	Б. Чулуундолгор “Нийслэл хотын маань гудамж аюулгүй, эрүүл байгаасай гэж хүсдэг”	39
4.	Ч.Ундрахбаяр “Бие даан амьдрах тогтолцоог Монголд”	61
5.	Д.Мандахнаран “Гурван хэмжээст хэвлэгчээр протез хийж буй инженер”	81
6.	Такахаши Кимико ““Чадахгүй” гэж зогсохгүйгээр “Юу чадах вэ?” гэдэг дээрээ төвлөр”	95
7.	Г.Самбууданзан “Ирээдүйгээ өөрсдөө бүтээцгээе”	111
8.	Д.Мөнхзул “Хүүхэд бүхэн сурах эрхтэй”	133
9.	Анне Тулкин “Хөгжлийн бэрхшээлтэй иргэд хотод нуугдаж амьдардаг”	155
10.	А.Хаш “Зүгээр л найз нь бай!”	161
11.	А.Лхамсүрэн “Санаа зовох зүйлгүйгээр чөлөөтэй харилцацгаая!”	173
12.	Э.Энхзул “Сурагчид маань өөрийн эрхгүй хайр татсан”	187
13.	В.Ойдов “Боловсрол бол өрсөлдөх чадвар”	203
14.	Н.Лигдэн “Өөрийгөө битгий нуу, нийгэмдээ ил гарцгаая!”	219
15.	Б.Бат-Эрдэнэ “Ажилдаа ямар ч саадгүй замаар хүрээд очихыг мөрөөддөг”	233
16.	В.Ганзориг “Хүртээмжтэй нийгмийг бий болгоход олон нийтийн оролцоо чухал”	249
17.	Б.Алтмаа “Хөгжлийн бэрхшээлтэй иргэд мэргэжлийн боловсрол эзэмшин хөдөлмөрлөх боломж бий”	267
18.	Чиба Хисао “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн идэвхитэй оролцоо нийгмээс хамааралтай”	283
19.	Д.Гэрэл “Англи хэл сурснаар Фулбрайтын тэтгэлэг авч АНУ-д сурсан”	289
20.	Д.Одгэрэл “Согогзүйгээс тусгай хэрэгцээт боловсрол руу”	323
21.	Ш.Мөнхцэрэн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хөгжлийн асаргааны төв бий болоосой гэж хүсдэг”	343
22.	С.Сэлэнгэ “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдэд зөв мэдлэг, мэдээлэл хамгийн чухал”	359
23.	Б.Алтанцэцэг “Спортоор дамжуулан хүртээмжтэй нийгмийг цогцлоох нь”	373
24.	Д.Батзаяа “Нийгэмд эпилепсиг ойлгохгүй байгаа нь харамсалтай”	393
25.	Т.Туяажаргал “Асран хамгаалагчийг дэмжихгүйгээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих боломжгүй”	405
26.	Ц. Уянга “Хүнд төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ч гэсэн хөгждөг”	419
27.	Ч. Элбэгдорж “Эпилепситэй хүүхэдтэй аав ээж нарт туслахыг хүсдэг”	431
28.	Г.Болормаа “Сэтгэлзүйн үйлчилгээг хүссэн хүн болгон нь авах хэрэгтэй”	443
29.	Л.Соёлмаа “Дохионы хэлний видео дуудлагын үйлчилгээг нэвтрүүлсэн”	459
30.	Ж. Оюунчимэг “Монголд дохионы хэлмэрч, орчуулагч нар илүү олон болоосой”	475
	Дүгнэлт	487
	Англи хувилбар	491

ӨМНӨХ ҮГ



Монголд тусгай хэрэгцээт иргэдэд тулгарч буй асуудлууд нь тэр бүр хөндөгдөхгүй үлдсэн хэвээр байна. Улс төрийн түвшин дэх төлөөллийн дутмаг байдал болон тэдгээр иргэдэд тулгамдаж буй асуудлуудын талаарх нийгмийн ойлголт сул байгаа нь энэ хүрээнд ажиллах хэрэгцээ шаардлага байгааг харуулж байгаа юм.

Монгол дахь Фридрих-Эбертийн Сангаас Монголын нийгэм дэх хүртээмжтэй байдлын тухай шинэлэг санаануудыг дэмжихийг үргэлж хүссээр ирсэн ба хамгийн анхны алхам нь олон нийтэд ил болоогүй бүхий л түүхүүдийг олж, сонсох явдал байсан юм. Фридрих-Эбертийн Сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар болон Бодлогын Инновацийн Хүрээлэнгээс санаачилсан “Антолд-Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн дэлгэгдээгүй түүхүүд” цуврал подкаст нь Та бүхэнд бидний мэдээгүй олон түүхүүд байдаг талаарх анхдагч ойлголтыг өгөх болно. Бид энэхүү номоороо дамжуулан өөрсдийн түүхээ хуваалцаж буй тэдгээр хүмүүсийн тухай сонсоод үзэхийг Та бүхэнд уриалж байна. Тухайлбал, тусгай хэрэгцээт иргэд Монголд тулгамдаж буй саад бэрхшээлийг хэрхэн даван туулж амьдарч байгаа гэх мэт.

Эдгээр түүхүүд нь биднийг бодлогошруулсны зэрэгцээ сэтгэл хөдөлгөм мэдрэмжийг бидэнд өгсөн. Мөн түүнчлэн эдгээр түүхүүд нь ирээдүйд Монголд хэрхэн илүү хүртээмжтэй нийгмийг бий болгох гайхалтай санаануудыг ч агуулж байгаа юм.

Миний зүгээс Бодлогын Инновацийн Хүрээлэнгийн хамт олон болох Ж.Мэндээ, М.Сайнбуян, Д.Бямбажав, Рияа Тикку, С.Өсөхбаяр, Л.Алтанзаяа нартаа зөв хүнээ олж ярилцан, тэдний яриаг сайтар сонсож олон нийтэд хүргэсэн явдалд талархал илэрхийлмээр байна.

Түүнчлэн, манай ФЭС-гийн хамтран зүтгэгчид Б.Сарангуа болон Ё.Батболд нартаа подкастын цуврал болон номыг бүтээн олны хүртээл болоход оруулсан хичээл зүтгэлд нь талархал илэрхийлье.

Мөн түүнчлэн манай подкастад орсон бүхий л зочдодоо халуун талархлаа илэрхийлье. Подкаст болон блогпостоор гарч ирсэн бүхий л байр суурь, санаанууд намайг гайхшируулж байсан. Фридрих-Эбертийн Сангийн зүгээс олны анхааралд өртөөгүй эдгээр нийгмийн бүлгийг болон бодлогын өөрчлөлтийг дэмжихийг зорих болно. Ийм ч учраас бид энэхүү бүтээлээ төгсгөл биш, харин ч эхлэл гэж харж байгаа бөгөөд цаашид гарч ирэх бүхий л асуудлууд дээр хамтран ажиллана хэмээн найдаж байна.

Бенедикт Ивановс
Фридрих-Эбертийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгч

ОРШИЛ



Антолд хэрхэн үүссэн түүхийг та бүхэнтэйгээ товчхон хуваалцъя гэж бодлоо. Өнгөрсөн 2020 оны 09 дүгээр сард миний бие Ковид-19-ийн тархалтын улмаас Улсын онцгой комиссоос тогтоосон 21 хоногийн тусгаарлалтад орсон юм. Тухайн үед хамтран ажиллагсад маань нэгэн консалтинг төсөл дээр намайг хуваарилсан байв. Тухайн төсөл нь Германы хүмүүнлэгийн байгууллагын зүгээс Монголд хэрэгжүүлэх төсөлд зөвлөх үйлчилгээ үзүүлэх явдал байсан бөгөөд төслийн хүрээнд миний бие Монгол дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг судлахаар болсон юм. Энэхүү ажлыг эхэлж байх үед хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх судалгаа, статистик мэдээллүүд хангалттай байсан ч бүгд л Үндэсний Статистикийн Хорооноос гаргасан 107.1 мянган иргэд Монголд байдаг хэмээх тоон мэдээлэл болон тэдэнд тулгарч буй саад бэрхшээлийг тоочсон нэг л их урт жагсаалтууд байсныг анзаарч билээ.

Сонирхолтой нь, тэдгээр тоо баримтууд хөгжлийн бэрхшээлээсээ болон зовж шаналж буй иргэд эсвэл хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ асарч буй иргэд, тэдэнтэй ажилладаг хүмүүст яг өнөөдөр ямар асуудал тулгамдаж буйг хэлэхгүй байсан юм. Мөн Монголд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжиж буй, дэмжсэн эсвэл дэмжихээр амласан үйл ажиллагаануудын дийлэнхийг гадаадын иргэд эсвэл олон улсын байгууллагууд хийдгийг анзаарсан. Үүний дараахан өвлийн нэг сайхан өдөр, Фридрих Эбертийн Сан (ФЭС)-гийн суурин төлөөлөгч асан Др. Нийлс Хегевишт Сэлбэ голын хажуугаар Таван буудал хүртэлх багадаа өсч торнисон газраа үзүүлэн алхах зуураа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг нийгэмд хэрхэн таниулах талаарх ярилцаж явсан юм. Ярианы явцад подкаст болон блогпост хийх санаа анх төрсөн юм. Тэдгээр иргэдийн түүхийг нийгэмд таниулах нь зүйтэй хэмээн бид санал нийлсэн билээ.

Уг подкастын санааг М.Сайнбуян (Сайнаа) маань огтхон ч эргэлзэлгүйгээр дэмжин ийнхүү Антолдын баг бүрдсэн юм. Сайнаа өмнө нь өөрийн сонирхлоор подкаст хийж байсан төдийгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар бид ижил байр суурьтай байсан юм. Тэрээр мөн л 21 хоногийн тусгаарлалтаас гараад удаагүй, нийгмийн сайн сайхны төлөө ажил хийх хүсэл нь оргилж байсан тул цаг хугацааны тохироо бүрдсэн байв. Азтай тохиолоор Др. Нийлс Хегевиш монгол хэл дээрх эхний 10 подкаст, англи хэл дээрх 10 блогпостыг дэмжсэн нь ФЭС-ийн үнэт зүйлтэй нийцсэнээс гадна Ковид-ын хөл хорионы улмаас үйл ажиллагаанууд хязгаарлагдсаны улмаас төсөв үлдсэн байсантай холбоотой байсан юм. Сайнаа бид хоёр түүнээс хойш эхний 10 дугаараа гаргахаар хичээнгүйлэн ажилласан ба ФЭС-ийн менежер Б.Сарангуа болон англи блогпостын редактор Рияа Тикку нар Антолдийг маань зүрх сэтгэлээрээ дэмжиж байсныг дурдахад таатай байна. Антолд маань албан ёсоор Фейсбүүк, Твиттер, Инстаграмд тавигдахын хажуугаар “Монголиа Фокус”-т англи хэл дээрх блогпостүүд маань давхар цацагдаж байсан. Подкастынхаа засварыг хийх юмуу эсвэл блог бичих гээд зочдынхоо яриаг хэд хэдэн удаа сонссоны дараагаар бид эргэн тойрноо

өөрөөр харж эхэлсэн. Жишээлбэл, барилгуудын орц гарц, шат, лифт, бие засах өрөө, явган хүний зам гэх мэт зүйлсийг харан тэргэнцэр, таягтай яваа иргэддээ санаа зовохын хажуугаар тэдгээрийг барьж байгуулах явцдаа бусдын хэрэгцээг үл хайхарсан инженерүүд, барилгын ажилчдыг нь бодон дургүйцэж байсан бол мөн нөгөө талдаа тусгай хэрэгцээт иргэдийнхээ өмнө өөрийгөө буруутан болсон мэт санаж байснаа нуух юун. Мөн цар тахлын үеэр гарч буй төрийн бодлого, шийдвэрүүддээ тусгай хэрэгцээт иргэдээ нийгмийн үйлчилгээнд хамруулах арга замыг орхигдуулж байсанд ихээхэн эмзэглэж байлаа. Огцом зогсч, хөдлөх болгонд жирийн хүн ч унаад гэмтэхээр жолоодож буй нийтийн тээврийн жолооч нарын үйлдэл нэг л биш санагдана. Мэдээж тэдгээр хүмүүс хамгийн стресстэй нөхцөл болох бага цалин хангамж, ундуутай зорчигчид, ууртай дарга нар болон үргэлж түгжрээнд байдаг Улаанбаатар хотын замд ажлын цагаа өнгөрөөж байгааг ойлгож байгаа.

Түүнчлэн бид бас хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэйгээ төдийлөн харилцдаггүй, ярилцдаггүй болохыг 45-60 минутын ярилцлага сонсон өөрсдийн үнэтэй цагаа зориулан англи хэл дээр блог бичиж байсан, сайн дураараа нэгдсэн нийтлэлч нар бүгд хүлээн зөвшөөрч байлаа. Манай блогпостыг бичсэн Б.Булган, Ж.Ананд, Ч.Нямсүрэн, Т.Ганчулуун, Б. Дэлгэрбаяр, Б.Батдэлгэр, С.Одмаа, Б.Идэрболд болон Т.Өэлүн нартаа талархалаа илэрхийлье.

Бид бүхэн олон подкаст бэлтгэн, блогпост бичиж байхдаа төслийнхөө үр дүнг ном хэлбэрээр нийтийн хүртээл болгох хэрэгтэй гэдгийг ойлгосон бөгөөд энэ санаачилгыг маань дэмжин ажиллахаар болсон ФЭС болон суурин төлөөлөгч ноён Бенедикт Ивановст баярлалаа. Номын эхийг бэлтгэсэн гайхалтай чадварлаг Ё.Батболд, номын редакторын ажлыг сэтгэл зүрхээ гарган хийсэн төслийн зөвлөх С.Өсөхбаяр болон Л.Алтанзаяа нартаа мөн халуун талархал дэвшүүлье. Мөн монгол хэл дээрх блогпостын редакторыг хийж байсан Н.Соёлгэрэлд баярлалаа. Хэдийгээр бид гучаас илүү их ярилцлагыг хийсэн боловч зарим зочид маань ярилцлагаа олон нийтэд хуваалцахдаа бэлэн биш байсан. Гэсэн хэдий ч бид төрийн удирдлагууд, тусгай хэрэгцээ шаардлагатай иргэд, тэдний ойр дотныхон болон бусад бүхий л хүмүүст чухал мессеж хүргэж чадсан гэдэгтээ итгэлтэй байна. Цаашид ч Антолд пласаараа дамжуулан хүртээмжтэй, хүмүүнлэг нийгмийг цогцлоохын төлөө өөрсдийн багахан ч гэсэн хувь нэмрийг оруулсаар байх болно. Хүн болгон сайн сайхан, аз жаргалын төлөө адилхан мөрөөдөж, хүнд хэцүүг туулж өнгөрүүлдэг. Ялангуяа цар тахлын нөхцөлд тулгарч буй асуудлуудаа хамтдаа даван туулахын тулд харилцан биесээ хүндэтгэж, дутуугаа нөхөж, дундуураа дүүргэж байх хэрэгтэй санагдана. Эцэст нь хэлэхэд бид Монгол дахь ФЭС-ийн хамт олонд Антолд подкаст болон блогпостыг биеллээ олох боломжоор ханган, энэ цаг мөчид энэхүү номыг таны гар дээр хүргэж буйд гүнээ талархал илэрхийлье.

Ж.Мэндээ
Стратегийн судалгааны хүрээлэнгийн дэд захирал, эрдэмтэн-нарийн бичгийн дарга.

АНТОЛД ТӨСЛИЙН БАГТ



Ж.Мэндээ

Стратегийн судалгааны хүрээлэнгийн дэд захирал, эрдэмтэн-нарийн бичгийн дарга. Канад Улсын Британиш Колумбийн их сургуульд Ази, Номхон далайн бодлогын магистр, мөн сургуульд Улс төр судлалын докторын зэрэг хамгаалсан.



М. Сайнбуян

МУИС-ын олон улсын эдийн засгийн харилцааны чиглэлээр бакалаврын зэрэг хамгаалж түүний дараагаар Канадын Вотерлүүгийн их сургуулийг улс төр судлалаар, БНСУ-ын Ёнсей их сургуулийг эдийн засгийн ухааны чиглэлээр тус тус магистрын зэрэг хамгаалсан.



Б. Сарангуа

ХБНГУ-ын Фридрих-Эбертийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын хөтөлбөрийн менежер

ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН



Рияа Тикку

Лондонгийн их сургуульд зөрчил мөргөлдөөн, хүний эрх болон шударга ёсны улс төрийн чиглэлээр магистрын зэрэг хамгаалсан. Одоо Монголд судалгааны хүрээлэнгүүд болон олон улсын ТББ-уудад редактор болон зөвлөх үйлчилгээг үзүүлж байна.



С.Өсөхбаяр

Австралийн Күинсландийн их сургуулийн хуулийн магистрын зэрэг хамгаалсан. Хуулийн салбарт олон улсын байгууллага болон хувийн хэвшилд ажиллаж байсан туршлагатай.



Н.Соёлгэрэл

Тэрээр МУИС-ийг улс төр, нийгэм судлаач мэргэжлээр төгссөн. Улс төрийн шинжлэх ухааны магистрын зэрэгтэй. Стратегийн судалгааны хүрээлэнд гадаад бодлого, аюулгүй байдал судлалаар мэргэшин ажиллаж байна.

БЛОГПОСТ НИЙТЛЭГЧИД



Б. Булган

Канадын Британи Колумбийн их сургуульд уул уурхайн инженерийн сургуульд докторант бөгөөд өмнө нь Монгол дахь Канадын элчин сайдын яаманд гадаад бодлогын шинжээчээр ажиллаж байсан. Монголын уул уурхайн корпорацид мөн ажиллаж байсан туршлагатай.



Ч.Нямсүрэн

АНУ-ийн Тэнгисийн явган цэргийн Төгсөлтийн дараах сургуульд Азийн улс орнуудын аюулгүй байдал судлалын чиглэлээр магистрын зэрэг, Австралийн Үндэсний их сургуульд Цэргийн болон батлан хамгаалах судлалын чиглэлээр магистрын зэрэг тус тус хамгаалсан.



Т.Ганчулуун

Монголын Үндэсний Батлан Хамгаалахын их сургуулийг төгсч АНУ-д ложистик оффицерийн сургалтад сурсан. Одоогийн байдлаар АНУ-ын Усан Цэргийн магистрын сургуульд яван суралцах гэж байна. Өмнө нь тэрээр НҮБ-ын Өмнөд Судан дах энхийг сахиулах үйл ажиллагаа болон НАТО-гийн Афганистан дах энхийг сахиулах үйл ажиллагаануудад тус тус алба хаажээ.



Б.Дэлгэрбаяр

Канадын Британи Колумбийн их сургуульд Менежментийн чиглэлээр магистрын зэрэг саяхан хамгаалсан бөгөөд өмнө нь тус сургуульдаа улс төр судлалын чиглэлээр бакалаврын зэрэг хамгаалсан байна.



Т.Өэлүн

Канадын Британи Колумбийн их сургуульд уул уурхайн инженерийн чиглэлд магистрын зэрэг хамгаалсан. Түүний судалгааны сонирхол нь байгаль орчин хамгаалал, тогтвортой нөөцийн хөгжил болон STEM салбар дахь жендэрийн тэгш байдал байдаг.



Б.Идэрболд

LETU Mongolia сургуульд дата судлаачаар төгссөн бөгөөд Германы Филиппс Их Сургуульд улс төр судлалаар бакалаврын чиглэлээр төгссөн. Мөн тэрээр НҮБХХ-т бодлогын инновацийн чиглэлээр зөвлөхөөр ажиллаж байна.



Б.Батдэлгэр

Монгол Улсын Их Сургуулийн Олон Улсын Харилцааны сургуулийг 2013 онд төгссөн бөгөөд уул уурхай, барилга, мэдээлэл технологи зэрэг бизнесийн олон төслүүдэд гадны түншүүдтэй хамтран ажиллаж, компанийн гадаад харилцааны чиглэлээр туршлага хуримтлуулсан.



Ж.Ананд

Канадад саяхан ахлах сургуулиа төгсөн бөгөөд Улаанбаатар хотод төрсөн. Тэрээр спорт болон шинжлэх ухаанд сонирхолтой.



С.Одмаа

Канадын Британш Колумбийн Их сургуульд Эдийн засгийн ухааны чиглэлээр магистрын зэрэг хамгаалж өдгөө Канадын Фиделити хөрөнгө оруулалтын компанид дата шинжээчээр ажиллаж байна.

зочид


Г.Баттулга


Л.Алтангэрэл


Б.Чулуундолгор


Ч.Ундрахбаяр


Д.Мандахнаран


Такахаши Кимико


Г.Самбууданзан


Д.Мөнхзул


Анне Тулкин


А.Хаш


А.Лхамсүрэн


Э.Энхзул


В.Ойдов


Н.Лигдэн


Б.Бат-Эрдэнэ


В.Ганзориг


Б.Алтмаа


Чиба Хисао


Д.Гэрэл


Д.Одгэрэл


Ш.Мөнхцэрэн


С.Сэлэнгэ


Б.Алтанцэцэг


Д.Батзаяа


Т.Туяажаргал


Ц.Уянга


Ч.Элбэгдорж


Г.Болормаа


Л.Соёлмаа


Ж.Оюунчимэг

АНГАРАГ ГАРАГ РУУ АЯЛАХЫГ ХҮСДЭГ НЭГЭН



Г.Баттулга

Энэхүү подкастыг Монголын бодлогын инновацийн хүрээлэн, Германы Фридрих-Эбертийн сантай хамтран бүтээв. Антолд подкастаар дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэднийг тойрсон асуудлын талаар ярилцах болно.

Сайн байцгаана уу, эрхэм хүндэт сонсогчид оо, Антолд подкастын маань анхны зочноор Ганбаатарын Баттулга ах маань хүрэлцэн ирж орохоор болсон байна. Танд баярлалаа. Та сонсогч нарт өөрийгөө дэлгэрүүлээд танилцуулахгүй юу?

Сайн байна уу? Сонсогчдодоо ч гэсэн энэ өдрийн мэндийг хүргэе. Намайг Ганбаатарын Баттулга гэдэг. “Түгээмэл Хөгжил” буюу “Универсал Прогресс” гээд Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн анхны бие даан амьдрах төвд төслийн менежер хийж байсан. Одоо Австралийн Засгийн Газрын тэтгэлэгт хөтөлбөрт тэнцээд, одоо Австрали явахаа хүлээж байгаа учир ажилгүй байгаа. Нягтлан бодогч мэргэжилтэй, Засагт хан дээд сургуулийг 2016 онд төгссөн. Эхнэр хүүхдийн хамт амьдардаг.

Та тэтгэлэгт хөтөлбөрт материалаа бүрдүүлэхдээ яаж бүрдүүлж байсан бэ? Англи хэлний шалгалт нь хэцүү гэж би сонсож байсан. Танд ямар санагдаж байсан бэ?

Гадаадад сурч өөрийгөө илүү боловсруулмаар санагдсан. Монголд зарлагдаж байгаа гаднын тэтгэлгүүдийг судалж үзэхэд Австралийн Засгийн Газрын

тэтгэлэг гэр бүлээ авч явахыг зөвшөөрдөг, маш тохиромжтой санагдсан. Гэр бүлийн хүн нь тэнд бүтэн цагийн ажил хийх боломжтой, хүүхдүүдийг тэнд сургууль, цэцэрлэгт өгөхөд асуудалгүй байдаг гэх зэрэг зүйлүүд нь таалагдсан. Тэгээд 2018 онд анх материалаа өгч байсан. Эхний удаад тэнцээгүй. Дараа жил нь дахиж материалаа өгөөд тэнцсэн. Энэ тэтгэлэгт хөтөлбөр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст харьцангуй уян хатан нөхцөлийг тавьдаг. Жишээ нь хөгжлийн бэрхшээлгүй хүмүүст бол англи хэлний АйЛЦ-ийн шалгалтын (IELTS) дундаж оноо 6 болон түүнээс дээш гэж заадаг бол намайг материалаа өгч байсан үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст дундаж оноо 5.5 шаардлагатай байсан. Тухайн хөтөлбөрт тэнцсэний дараа сургуулийнхаа босго оноог авах шаардлагатай байдаг. Тэр оноог авахын тулд хөтөлбөрөөс зургаан сарын эрчимжүүлсэн англи хэлний сургалтад суулгадаг. Тэр сургалтад суугаад сургуулийнхаа босго оноо буюу АйЛЦ-ийн (IELTS) 6.5 дундаж одоо авах юм бол явахад бэлэн болж байна гэсэн үг.

Тань шиг гадаад дотоодын тэтгэлэгт тэнцээд явсан хүмүүс хэр их байдаг вэ?

Яг хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд байдаг гэсэн. Гэхдээ харьцангуй тоо нь тун цөөхөн юм байна. Би ямар ч байсан яг энэ хөтөлбөрөөр явсан, тулгуур эрхтний бэрхшээлтэй Өсөхөө гээд нэг бүсгүйг танина. Бусад хүмүүсийг нь бол сайн мэдэхгүй.

Монголын нөхцөлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ч гэсэн тэтгэлэгтээ бэлдээд, гадаадад тэтгэлэг аваад явахад танд юу нь саад бэрхшээл болж байгаа юм шиг санагддаг вэ?

Австралийн Засгийн Газрын тэтгэлэг учраас аль болох хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоо, тэднийг бусадтай эрх тэгш авч үзэх үүднээсээ хүртээмжийн асуудал, багш нар, ажилчдын хандлагын асуудал дээр анхаарч ажилласан нь харагдаж байсан. Сурах орчин бол нэг их асуудал байгаагүй. Бид нар өөрсдийгөө 100% дайчлаад сурах шаардлагыг л тавьж байсан.

Баттулга ах маань цаашдын хүмүүст үлгэр дуурайл болоод явж байгаа гэж би ойлгож байна. Хөгжлийн бэрхшээлтэй олон хүн цаашдаа гадаадад боловсрол эзэмшээд, эх орондоо ирээд өөрчлөлт хийх, хөгжүүлэх боломжтой гэж би харлаа.

Боломжтой. Боломжгүй асуудал бол байхгүй. Хамгийн гол нь гадаадад сурахад нэгдүгээрт тэнд сураад буцаж ирээд Монгол Улсын хөгжилд чи яг ямар хувь нэмэр оруулах юм? Зорилго чинь илүү тодорхой байх хэрэгтэй. Дараа нь хэлний шалгуур. Ерөнхийдөө зорилго чинь ирээдүйд Монгол Улсын хөгжилд ингэж хувь нэмрээ оруулна гэсэн тодорхой, үнэ цэнтэй байх хэрэгтэй.

Та Монгол Улсын хөгжилд хувь нэмэр оруулах гэдэгт юу гэж бичиж байсан бэ?

Тийм эссе бичнэ шүү дээ. Би 2018 онд материал өгч байх үедээ “Түгээмэл Хөгжил” төвд ажиллаж байсан. Бид нар төсөл дээр ажиллахаар мэдээлэлд анализ хийх шаардлага их гарна. Жишээ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам дээр нэг мэдээлэлтэй, Үндэсний статистикийн хороон дээр бас нэг өөр мэдээлэлтэй. Ингээд мэдээлэл их ч хоорондоо уялдаа холбоо байхгүй, төсөлд аваад ашиглая гэхэд хэцүү байдаг. Тэгэхээр нь би Австралид мэдээллийн аналист (data analyst) мэргэжлээр сурч мэдээлэлтэй ажилладаг хүн болж буцаж ирснийхээ дараа байгууллагынхаа хөгжилд, цаашлаад Монгол Улсын хөгжилд хувь нэмэр оруулна гэж бичсэн чинь тухайн үедээ тэнцээгүй. Тэгээд 2019 онд дахиж материалаа өгөхдөө зорилгоо өөрчлөөд аялал жуулчлалын салбарт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоо хэр их юм бэ гэдэг дээр судалгаа хийж үзсэн. Монголд битгий хэл гадаадад энэ тал дээр судалгаа хийгдсэн эрдэм шинжилгээний ажил эсвэл мундаг доктор профессоруудын гаргасан өгүүлэл их цөөхөн байдаг юм байна. Тэгээд би ерөөсөө үүнийг барьж аваад өөрийнхөө ирээдүйг тодорхойлоод, энэ чиглэлээр сурч ирээд Монгол Улсын ялангуяа аялал жуулчлалын хөгжилд хувь нэмрээ оруулъя гээд эссегээ бичсэн. Товчхондоо бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 100% хүртээмжтэй үйл ажиллагаа явуулж байгаа аялал жуулчлалын цогцолбор, зочид буудлуудыг ганц хөдөө орон нутаг биш хотод ч гэсэн бий болгоход бодлогын төвшинд ажиллана гэж зорилго тавьсан.

Би нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 29% нь л одоо хөдөлмөр эрхэлдэг гэж 2018 оны статистик баримт харлаа л даа. Эдгээр хүмүүсийн боловсролын төвшинг үзэхээр бага боловсролтой 2000 хүн, суурь боловсролтой 4000, бүрэн дунд боловсролтой 2000, техник мэргэжлийн 8000, боловсролгүй 5000, дээд боловсролын бакалавр болон магистртай зэрэгтэй 257, тусгай мэргэжлийн 1734 гэх жишээтэй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо 2020 оны байдлаар 108,000 ба тэндээс 30,000 нь л ажил хийдэг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт гэдэг юм.

Монголын төвшинд ямар байдаг вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд чи сая статистик тоо хэллээ.

Бодит байдлыг танаас асуух гэсэн юм.

Би энэ статистик тоог яг сайн мэдэхгүй байна. Гэхдээ бодит байдал дээр би өөр дээрээ жишээ авч яръя. Анх 2016 онд сургуулиа төгсчхөөд мэргэжлээрээ буюу нягтлан бодогч мэргэжлээр өргөдөл өгч байхад хоёр гурван газар хүрч ирээд уулз гэж хариу өгсөн. Би хоёр газар нь очсон боловч тухайн байгууллагын маань үйл ажиллагаа явуулдаг оффис нь тэр барилгын гурван давхарт байрладаг, оффис нь лифтгүй. Эсвэл лифттэй ч гаднах довжоо нь хүртээмжтэй налуу замгүй. Орлоо ч гэсэн ариун цэврийн өрөөний асуудал хүртээмжгүй гэх мэтчилэн зүйлүүдээс

болоод би хэцүү юм байна даа гэсэн ойлголт авч байсан. Угаасаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагад ажиллаж байсан учраас манай гишүүд ч гэсэн маш хэцүү байдаг гэж ярьж байсан маш олон кэйсүүд мэднэ. Сая нэг мэдээ харж байхад ХНХЯ хэдэн жилдээ эхлээд бодлогоо боловсруулаад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ гэж байсан. Тооны хувьд маш олон хүмүүсийг ажлын байраар хангаад байж болно. Гэхдээ эргээд тэр хүмүүс ажлын байран дээр хэр тогтвортой ажиллаж байна вэ? гэдгийг нь бас авч үзэх хэрэгтэй. Яагаад гэвэл жишээ нь би нэг ажлын байранд ажилд орлоо гэж бодъё. Тэр мөнгөтэй компанийн ажлын байр байсан, намайг ажилд авахын тулд ариун цэврийн өрөөгөө сайхан засаад, гаднаа налуу зам хийгээд, лифттэй болголоо. Надад дэд бүтцийн хүртээмжийн хувьд ажиллахад асуудалгүй байна. Гэхдээ хамт ажилладаг хүмүүс маань миний онцлог хэрэгцээг ойлгохгүй, би тэр хүмүүстэй зөрчилдөөд байх юм бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тэр ажлын байран дээр уддаггүй. ХНХЯ жишээ нь хөгжлийн бэрхшээлтэй олон хүнийг ажлын байраар хангана гэж бодлогоо тодорхойлчихсон бол түүнтэйгээ уялдаад тухайн ажлын байраар хангагч, ажил олгогч эздийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, ажилчдыг бүрэн хэмжээний сургалтад хамруулах гэх мэтчилэн арга хэмжээнүүд нь дагалдаж явах ёстой.

Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх ойлголт, хандлага сул байдаг гэж та боддог уу?

Би арван жилийн өмнө осолд орсон тэр үеийг одоо үетэй буюу арван жилийн дараатай харьцуулах юм бол бага багаар өөрчлөгдөж байгаа. Гэхдээ ер нь бол сул байдаг.

Би гадуур явахад хөгжлийн бэрхшээлтэй хүн маш цөөхөн харагддаг. Энэ юутай холбоотой гэж боддог вэ?

Миний бодлоор хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцоход нь саад болж байгаа гурван үндсэн хүчин зүйл байгаа. Нэгдүгээрт дэд бүтцийн хүртээмж. Миний сая хэлсэн шат, довжооны асуудал. Хоёрдугаарт хүмүүсийн хандлага, төлөвшил. Гуравдугаарт Засгийн газраас боловсруулаад гарч байгаа бодлогыг хэрэгжүүлж байгаа байгууллагууд маань хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлог хэрэгцээг төдийлөн харж чадахгүй байна. Гарч байгаа бодлого, шийдвэртээ зөв тусгаж чадахгүй байна гэж харагдаад байгаа. Үүний шийдэл нь олон янзын шийдэл байж болно. Нэг шийдэл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүний эрх, тэдний нийгмийн оролцоог хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагууд олон нийтийн хандлага, ойлголтыг өөрчлөх, бусдыг уриалан дуудах сайн дурын үйл ажиллагааг төрийн байгууллагуудтай хамтарч, зөвшилцөж явуулж байна. Нөгөөх нь миний бодлоор хууль эрх зүйн хүрээнд сайн хууль гаргаад, тэр хуулиа

маш сайн сурталчлан таниулах юм бол энэ хандлага өөрчлөгдөнө гэж бодож байна. Жишээ нь би 2017 онд Японы ЖАЙКА-гийн санхүүжилтээр ХНХЯ-ны дэргэд Улаанбаатар хотын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн оролцоог дээшлүүлэх хөтөлбөрт хамрагдсан. Хөтөлбөрийн хүрээнд би Япон улсад хөгжлийн бэрхшээлтэй залуу манлайлагчдын чадавхыг бэхжүүлэх 45 хоногийн эрчимжүүлсэн сургалтад суусан. Энэ сургалтад Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцийн зүйл заалтыг Япон улс хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар таниулахаар хөгжил буурай улс орнуудаас залуучуудыг сонгож сургалтад хамруулсан. Тэр сургалтаар Япон улс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хөдөлмөр эрхлүүлэхийн тулд жижигхэн инкубатор төвүүд байгуулсан байсан. Тэр төвүүд дээр тухайн дүүргийн хөдөлмөр эрхлэх хүсэлтэй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг (гэхдээ бүгдийг нь хавтгайруулж биш) хөдөлмөрт хэдэн сар бэлтгээд дараа нь бодит ажлын байран дээр гаргадаг юм байна лээ.

Япон ч юм уу таны өөр явж байсан газруудаас харахаар Монголд ийм л юм байгаасай гэж бодогддог зүйл байдаг уу?

Байдаг. Шууд хэлэхэд ялгаварлан



гадуурхалтыг арилгах хуультай болчихоосой гэж боддог. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэлтгүй бэлгийн цөөнх, хүүхдүүд, бага ястнуудыг ялгаварлан гадуурхах явдал маш их байдаг. Гадаадад эдгээрийг зохицуулсан гол хүчин зүйл нь ерөөсөө л ялгаварлан гадуурхалтыг арилгах, ялгаварлан гадуурхлын эсрэг хүчтэй хууль байдаг. Тийм хуулиуд Японд, Америкт байдгийг би мэднэ. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль 2016 оны 2 дугаар сарын 5-нд батлагдсан ч гэсэн энэ хууль маань ерөнхий, тунхаг шинжтэй. Тэр хуулиа дагаж гарах дүрэм журам нь ХНХЯ дээрээ төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор одоо хүртэл боловсруулагдаагүй. Гадаадад миний харсан кэйс гэвэл ялгаварлан гадуурхалтыг арилгах тэр хууль нь маш хүчтэй. Жишээ нь манай улсад тэр хууль батлагдлаа гэхэд тэр хуулийг дагаж хэрэгжүүлснээрээ магадгүй бид нарын хүсээд байгаа хүмүүсийн хандлага, дэд бүтцийн хөгжил хэдэн жилийн дараа аяндаа бүрэлдээд ирнэ. Дараагийн үе, тэрний дараагийн үедүүдэд тэр хуулийн дагуу хүмүүсийн хандлага өөрчлөгдөөд ирэх учраас тэр хуультай хуульгүй хүмүүс гоё болно гэж боддог.

Монголд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн зүгээс ирж байгаа хандлага ямар байдаг вэ?

Өмнөх үетэй харьцуулах юм бол харьцангуй гайгүй. Ямар ч улсын иргэдийнх нь тооны 4%-ийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эзэлдэг. Хүмүүс өөрсдөө л хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эргэн тойронд юу болж байна, бодлого, шийдвэр яаж байна гэдгийг харахгүй бол энэ чинь цөөнх учраас мэдээлэл нь маш бага бөгөөд тэр мэдээллийг ойлгодог хүмүүс цөөхөн байдаг. Тийм учраас олон нийтэд таниулан сурталчлах ажлыг мэдээллийн хэрэгслээр маш их хийх хэрэгтэй. Бас энэ асуудлыг боловсролоор дамжуулж шийдэж болно. Би жишээ нь 10 жилдээ нийгмийн хичээлээр хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэж ямар хүмүүс байдаг вэ гэдгийг үзэж байсан эсэхээ санадаггүй. Яг тулгуур эрхтний бэрхшээлтэй, харааны бэрхшээлтэй, сонсголын бэрхшээлтэй хүний хэрэгцээ нь ийм байдаг гэж үзэж байгаагүй. Бүр нарийвчлаад гаргаж ирсэн 10 жилийн сургуулийн хичээлийн агуулга байгаа юм уу? Хэрвээ боловсролын системд үүнийг маш зөвөөр оруулж ирвэл ирээдүйд бие хүн болж төлөвших иргэд маань ойлголттой болно. Нэг ангийн гучин хэдэн хүүхдээс барилгын инженер, эмч, эрх зүйч, хуульч төрж л таарна бүр Улсын их хурлын гишүүн болохыг үгүйсгэхгүй шүү дээ. Тэр хүмүүс чинь багадаа ойлголт авчихсан учраас ямар ч асуудалгүй болно.

Улаанбаатар хотод хөгжлийн бэрхшээлтэй 35,000 орчим хүн амьдардаг. Ихэнх нь буюу 70-аад мянга нь хөдөө орон нутагт амьдарч байна. Та хөдөө орон нутгийн хүмүүсийг талаар юу гэж боддог вэ?

Бүр хэцүү юм байна лээ. Жил болгон залуучуудын чуулга уулзалт гэж хийдэг байсан юм. Тэр уулзалтын хүрээнд би

2016 онд Өмнөговь аймагт очиж байсан. Хүмүүсийн ойлголтын зөрүү маш их байдаг. Дэд бүтцийн хүртээмжийн асуудал бол ярилтгүй. Хүмүүсийн ойлголт надад яагаад хэцүү санагдсан гэвэл бид нар тухайн үеийн аймгийн засаг дарга болон удирдах байгууллагын хүмүүстэй нь уулзсан юм. Тэр хүмүүс бид нар тэгш хамруулан сургах боловсролыг хэрэгжүүлэхийн тулд сургуульдаа тусгай анги нээгээд, тэр ангидаа тэр аймгийнхаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сургаад, тэднийг сургах багш нараа бэлдээд бусад ангиас тусад нь байлгана гэж байсан. Тэр бол маш буруу ойлголт. Яагаад гэвэл нэг сургуульд тусдаа ангид, тусгай багшаар хичээл заалгана гэвэл ялгаагүй л нийгмээсээ тусгаарлагдана. Тэр тусдаа ангид байгаа хүүхдүүдийг жирийн хүүхдүүд гадуурхах үйлдэл гаргаж бүр эсрэгээрээ юм болох магадлалтай. Үүний бодит жишээг би Японд явж байхдаа харж байсан. Бид нарыг зүгээр нэг Японы ерөнхий боловсролын сургуульд аваачиж үзүүлж байсан. Тэнд би тархины саажилттай тэргэнцэр дээр суудаг, хөл, гар нь саажилттай, яриа нь ч муу хүүхэд хөгжлийн бэрхшээлгүй хүүхдүүдтэй хамтдаа нэг ангид суугаад хичээлээ үзэж байхыг харсан. Тэр хүүхэд мэдээж бичиж чадахгүй, уншихад ч хэцүү. Тэр хүүхдийн хажууд туслах багш байсан ба тэр хүн хүүхдийн тухайн өдрийн хичээл бүрийг хажууд нь суугаад бичиж өгдөг. Бас тэр хүүхэд өөрийгөө илэрхийлэхдээ муу, бусдаасаа маш удаан ярьдаг учраас ярьж байгаа юмыг нь сонсоод багшид нь хэлнэ. Багшаас тухайн хүүхдэд хэлэх зүйлийг нь дамжуулж хэлнэ. Мэдээж саажилттай хүүхэд учраас шүлс нь гоожиход шүлсийг нь арчаад, хоолны цагаар хоолыг нь өгдөг. Ариун цэврийн өрөө ороход нь хажууд нь туслаад явдаг. Түүний хажууд ахиад нэг багш байгаа. Тэр хүн бол арай илүү боловсролынх нь төвшин, гэрийн даалгаварт нь анхаарал хандуулдаг яг онцгой хэрэгцээтэй хүүхдүүдтэй харьцаж сурсан багш. Тэнд юу болоод байна гэвэл ирээдүйн нийгмээ л бүгдэд хүртээмжтэй байдлаар бэлдээд байна. Хамт сурч байгаа хүүхдүүд нь хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй хамт сурна гэдэг чинь багаасаа тэр хүмүүсийн онцлог хэрэгцээг ойлгосон хүмүүс болох байхгүй юу. Тэр надад аягүй гоё санагдаж байсан. Тэр сургуульд ороход шат довжооны асуудал алга, бүх ариун цэврийн өрөө нь мулти-фанкшионал тойлет (multi-functional toilet) буюу бүрэн тоноглогдсон өрөө. Тэнд ганцхан хөгжлийн бэрхшээлтэй хүнд гэхгүй бүх хүнд зориулсан байсан. Жишээ нь нялх нярай хүүхэдтэй эцэг эх хүүхдийнхээ сурлагад анхаараад сургууль дээр ирээд, нярай хүүхдийнхээ памперсыг солих болбол тэр ариун цэврийн өрөөг ашиглаад маш тав тухтай памперсыг нь солих боломжтой. Тэр улсуудад тийм арга барил хэрэгжүүлээд явж байна.

Бас гэр хороололд амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс жорлон орох, гэрээсээ гарахад хэцүү. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан автобус цөөхөн байдаг юм шиг байгаа юм. Хорин ширхэг гэсэн үү?

Бид нарын сайн мэддэг урт цэнхэр автобус анх хорин ширхэг орж ирж байсан. Тэр автобус орж ирэх болсон түүх нь бас их сонин. Түгээмэл Хөгжил төв 2014 онд "Нийтийн тээврийг нийтэд" гэдэг уриатай хөдөлгөөн өрнүүлж байсан. Тэр нь манайх ганцаараа биш бусад залуучуудын, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтраад өрнүүлсэн хөдөлгөөн байсан. Сүүлдээ бид нар гарч жагсаж бүр жижиг хэмжээний мөргөлдөөн шахуу юм болж цагдаа нартаа тулгарсан. Тэгээд бид нарыг нийслэлийн удирдлагууд хүлээж авч уулзаад, удахгүй парк шинэчлэл хийх гэж байгаа, тийм учраас та нар жоохон хүлээцтэй хандвал автобуснууд орж ирнэ гэсэн. Түүний дараагаар хорин ширхэг автобус орж ирж байсан. Тэр автобуснууд зөвхөн хотын төвөөр явдаг шүү дээ, хотын зах руу явахгүй. Дараа нь бид нарт тулгарч байсан нэг асуудал бол жолооч, кондуктор нарын хандлагын асуудал. Аягүй хэцүү байдаг байсан, одоо ч хэцүү. Автобус чинь цаггайгаа уралдана. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчлэхийн тулд заавал карма луугаа орж боржууртай ижил төвшинд зогсож байж налуу замаа буулгах ёстой гээд аймаар цаг ордог учраас би нэг удаа сууж байхад ерөөсөө амар байгаагүй. Бараг л татаад орчих, үсрээд орчих, босож чадах уу гэж асуугаад байсан.

Та хүмүүсийн хандлагыг ямар байгаасай гэж боддог вэ?

Хүмүүс мэдээлэлтэй, мэдлэгтэй байвал тэр хандлага нь төлөвших байх. Хамгийн гол нь тэр хандлагыг төлөвшүүлэхийн тулд нэгдүгээрт зөв хууль эрх зүйн орчин хэрэгтэй байна. Жишээ нь миний хэлсэн тэр ялгаварлан гадуурхалтыг арилгах тухай хуультай болчихвол хүмүүс хүссэн хүсээгүй тэр хуулийг хэрэгжүүлээд явдаг болно. Тэр хуулийг хэрэгжүүлээд явахаар магадгүй арван жил, хорин жил, гучин жилийн дараа тэр хуультай хуульгүй хүмүүст ийм хандлага тогтоно. Дээрээс нь хуулиа таниулан сурталчлах үйл ажиллагаа маш дутуу байна.

Хоёулаа хууль, төр засгийн бодлого нэлээн ярьчихлаа одоо таны түүхийн талаар сонсъё гэж бодлоо. Та 10 жилийн өмнө осолд орсон гэж байсан. Осолд орохоос нь өмнө болон осолд орсных нь дараа танд хэр өөрчлөлт гарсан бэ?

Осолд орохоосоо өмнө зүгээр л урсгалаараа явдаг залуу байсан. Нэг их нийгмийн идэвх байхгүй. Зүгээр л 10 жилийн сургуулиа төгсөөд, оюутан болоод хичээлээ хийгээд явж байсан. Осолд орсны дараа юу ойлгосон бэ гэвэл бид нар чинь нийгмийн амьтан тиймээс нийгэмд болж байгаа үйл явдал, гарч байгаа бодлого, шийдвэрт бид нар маш сайн анхаарлаа хандуулж байх ёстой. Хүмүүс үүнийг улс төрийн идэвхтэй холиод байж магадгүй. Тийм биш, зүгээр л нэг бодлого гарахад бид нарын тухай юу өгүүлсэн байна, ямар зүйл заалт байна гэдгийг нь л харчих хэрэгтэй. Амьдрал ямар үнэ цэнэтэй юм, гэр бүл гэдэг чинь ямар үнэ цэнэтэй юм, хүн өвчин зовлонтой тартагтаа тулахаар яг юу боддог эсвэл хүнд эрч хүч өгөөд амьдралын төлөө зүтгэх гол хүчин зүйл

нь юу байдаг юм гээд төлөвшсөн, ойлгож ухаарсан зүйлүүд маш их байгаа. Одоо ч гэсэн сураад явж байгаа.

Та осолд орсны дараа мэдээж сэтгэл зүйн хувьд маш их гүн стресст орсон байх. Тэр үед та хэнд хандаж байсан бэ? Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан сэтгэл зүйн төв гэж байдаг уу? Тэр хүмүүсийн сэтгэл зүйг яаж дэмжих ёстой вэ?

Тэр маш хэцүү асуудал. Осолд ороод явж чадахаа больчихлоо, төсөөлж байсан амьдрал орвонгоороо эргэчихлээ. Мэдээж сэтгэл зүйн хувьд аймаар хэцүү болж, маш их сэтгэлээр унана. Би бол амиа хорлох гэж оролдож байсан, азаар бүтээгүй. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд осолд орсны дараа очдог нөхөн сэргээх төв гэж байдаг ч сэтгэл зүйн тал дээр нөхөн сэргээх эмчилгээ ерөөсөө байдаггүй. Бариа хийнэ, зүү тавина, өвчин намдаана. Тэр хүнийг сэтгэл зүйн тал дээр нь дэмжих сэтгэл зүйч эмнэлэг, нөхөн сэргээх төвд байдаг эсэхийг мэдэхгүй. Би л лав тухайн үедээ ёстой сонсож байгаагүй. Ёстой галзуурах үедээ галзуурч, инээх үедээ инээж байгаад л унаж босоод л, унаж босоод л давж тулсан. Тэрнээс биш тийм айхтар сэтгэлийн хаттайдаа эсвэл сэтгэл зүйчид хандаж байсан юм байгаагүй. Би өөрийгөө бас азтай гэж боддог. Тухайн үед надад нэг ийм юм тохиолдсон. “Эм Жи Эл” гээд радиод хөтлөгч хийдэг Хаш гэдэг хүн байдаг. Тэр ах тухайн үед сайн үйлсийн аян өрнүүлээд гэртээ өвчин зовлонтой ганцаардаж байгаа, хэнээс тус эрэхээ мэдэхгүй, сэтгэл зүйн гүн хямралд орсон хүмүүсийг хайж олоод, тэр хүмүүстэй гэрт нь эсвэл гадуур уулзаад, сэтгэл санааг нь хуваалцаад ярилцдаг байсан. Тэр сайн үйлсийн аяныхаа талаар нэг радиод ярилцлага өгч байхад нь манай аав ээж хоёр сонсоод, холбоо бариад, тэрнээс хойш Хаш ах манайд ирж ярилцдаг болсон. Тэрнээс хойш миний амьдралыг үзэх үзэл өөрчлөгдөж, би амьдрах ёстой юм байна гэдэг бодол надад суусан.

Танд тухайн үед яг юу гэж хэлсэн бэ? Зөндөө юм ярих уу?

Ярихгүй сэдэв гэж байхгүй. Хаш ах өөрөө тийм нээлттэй, хамаагүй, гоё хүн. Тухайн үед ганцаараа ирэхгүй, янз бүрийн хүмүүстэй хамт ирнэ. Заримдаа ямар амьдрал үзэж, яаж явсан юм гээд тэр хүмүүсийн түүхийг сонсоно хэрвээ надаас асуувал би өөрийнхөө тухай ярина. Долоо хоногтоо 1-2 удаа ирдэг байсан. Тэгээд он жил өнгөрч яахын аргагүй би сэтгэл зүйн хувьд ч өөрчлөгдөөд л ирсэн. Заримдаа сэтгэл зүйн хувьд хүндхэн болчихсон байсан хүмүүсээ нийлүүлээд шинэ жил тэмдэглэх зэрэг бага хэмжээний үйл ажиллагаа бас зохион байгуулдаг байсан. Тэрнээс хойш би гайгүй болоод, би ер нь нийгэмших ёстой юм байна гэж бодсон. Тэгээд л анх Монголын үндэсний тэргэнцэртэй иргэдийн холбоон дээр очоод нийгэмшиж эхэлж байсан.

Таны анх нийгэмших гээд зориг ороод гадаа гарахад хүмүүсээс авч байсан хандлага ямар байсан бэ?

Тухайн үед чинь нэг их сайн юм мэдэхгүй шүү дээ. Гэртээ гурав дөрвөн жил өвчин зовлондоо шаналчихсан байж байгаад гэнэт гадаа гарахаар эхлээд өөрөөсөө ичнэ. Таньдаг мэддэг хүнтэй тааралдвал санаа зовмоор юм гээд л бодно. Тэр чинь төлөвшөөгүй байна гэсэн үг. Юун тэр дэд бүтцийн хүртээмж, ийм л байдаг юм байлгүй дээ л гэж бодно. Яагаад гэвэл гадагшаа явж үзээгүй, ёстой юм үзэж нүд тайлаагүй байсан. Тухайн үед тэргэнцэртэй иргэдийн холбоонд ажилд орсон. Нийгмийн амьдралд ороод ирэхээр энэ нь болохгүй байгаа юм байна. Энэ хүмүүс ийм гоё зүйлийг зорьж яваад байгаа юм байна гэдгийг нь ойлгож эхэлнэ. Тэгээд би өөрөө үүний төлөө явах ёстой юм байна гэдэг мэдрэмж бага багаар авч эхэлнэ. Тэгээд гадагшаа яваад ирэхээр ийм байдаг юм чинь Монголд ийм аймаар ялгаатай байна. Үүнийг шийдэх шийдэл нь юу вэ гээд л гарц хайж эхэлнэ.

Таны хувь хүний хүсэл мөрөөдөл юу вэ?

Мөрөөдөл гэвэл Ангараг дээр очиж



үзмээр байна. Зорилго гэвэл шал өөр л дөө.

Зорилго нь тэгвэл юу вэ?

Ойрын зорилго гэвэл гадаадад сураад ирнэ. Сурч ирээд ямар ч байсан бодсон зүйлүүдээ хийнэ. Хийх арга зам хайна.

Таны бодсон зүйл аялал жуулчлалтай холбоотой юу?

Тэр тал дээр яг 100% төвлөрч ажиллана гэвэл би бас сайн мэдэхгүй л байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 100% хүртээмжтэй аялал жуулчлалын цогцолбор гэвэл ганцхан дэд бүтэц яригдах гээд байна л даа. Би бол бүр бодлогын төвшинд орж ажиллаж, өөрчлөлт хиймээр байна. Гэхдээ бас өрийнхөө хувийн юмнуудыг хийнэ байх.

Танд өөрөө яримаар байгаа зүйл байгаа юу?

Боловсролын тухай хуулийн шинэчлэл явагдаад байгаа. Тэр хуульд яг тэгш хамруулан сургах боловсрол, насан туршийн боловсрол гэж юу вэ гэдгийг маш ойлгомжтойгоор оруулах. Мөн өмнө нь ярьсан шиг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд тусдаа нэг ангид биш, бүх сурагчидтай хамт сурахад ямар нөхцөл бололцоог хууль эрх зүйн хүрээнд зааж өгөх ёстой юм гэдгийг одоо оруулж өгөхгүй бол магадгүй хэдэн жилийн дараа дахиад л энэ асуудал яригдах болно. Миний ажиллаж байсан Түгээмэл хөгжил төв болон бусад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагууд үүн дээр ажиллаж байгаа. Бид нар энэ хуульд иймэрхүү зүйл заалтыг ингээд суулгуулмаар байна гээд гоё хүсээд л, яриад л байдаг гэтэл хуулийн боловсруулалтад төрийн зүгээс оролцож байгаа албан хаагчид, хууль боловсруулагч нар бид нарын тухай ойлголт бага учраас санхүүжилт дээр нь иймэрхүү асуудал байна гээд өөрөөр хараад, аль болох хасаж хаях гээд байдаг.

Багаас нь ойлголт, хандлагыг нь төлөвшүүлэх юм бол дараа нь тэр хүмүүс бүх шатандаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн хүртээмжтэй бодлого, шийдвэр гаргах юм байна гэж ойлголоо?

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн биш юниверсал дизайн гээд бүх нийтэд зориулсан гэж явдаг. Ганцхан хөгжлийн бэрхшээлтэй иргэн биш, нялх нярай хүүхдээ тэргэн дээр түрсэн эмэгтэй, жирэмсэн эмэгтэй, таяг тулсан, хөгшин настай хүмүүс бүгд хэрэглэх боломжтой юниверсал дизайн буюу түгээмэл загвар гэх тийм зүйлтэй холбогддог. Манайхан бол хүртээмжтэй ариун цэврийн өрөө гэвэл суултуурын хажууд гарны түшлэг хийдэг гэж ойлгоод байгаа. Тэр тийм биш. Япон, Америкт мулти-фанкшионал тойлет гэдэг зүйл яригдаж байна. Би зүгээр л Японд электрон бараа зардаг Акеа гээд зах ороход тэнд бүх давхар нь мулти-фанкшионал тойлеттэй байсан. Тэрнийг ганцхан хөгжлийн бэрхшээлтэй хүн хэрэглэхгүй гэдгийг тэд ойлгоод байна. Бид нарын дунд нэг л ийм ариун цэврийн

өрөө байхад хөгжлийн бэрхшээлтэй, бэрхшээлгүй бүх хүмүүс ашиглах юм байна гэдгийг ойлгочхоод тэрийгээ хэрэгжүүлээд байгаа юм. Гэтэл одоо бид нарт юу яригдаад байна гэвэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан гэж яриад байгаа биз. Магадгүй арван жилийн дараа, энэ зориулсан чинь буруу, бүх нийтэд зориулсан байх хэрэгтэй гэж явна. Энэ чинь хүмүүсийн хөгжил, улс орны хүмүүсийн ойлголт, ухамсар, төлөвшил, хүмүүсийн хандлага гээд нийгмийн шат дамжлагаараа ингэж явдаг юм шиг байна. Хандлагатай байж болох ч тэрийг төлөвшүүлэх гэдэг чинь бас нэг том асуудал. Тэр хандлага нь төлөвшчихсөн хүмүүс арай өөр шатанд юмыг хараад байна. Бид нар дөнгөж төлөвшиж эхэлж байгаа учраас зориулсан гэж яриад байна.

Ямар тогтсон үзэл бид нарыг хойш нь татаад байна вэ?

Өрөвдөх хандлага. Монголд бол "хөөрхий хар залуугаараа тэргэнцэр дээр суучхаж дээ" ч гэдэг. Америкт надад тохиолдсон жишээ яръя. Би Америкт "professional fellowship" программ гээд бас 45 хоногийн хугацаатай манлайлагч залуучуудын чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрт хамрагдаж байсан. Би тэнд очоод Вашингтонд үйл ажиллагаа явуулдаг бие даан амьдрах төвд дадлагажигчаар 14 хоног ажилласан. Би ганцаараа явсан учраас надад туслах хүн байхгүй. Эхний нэг хоёр өдөр метроныхоо чиглэлийг олох гэж төөрсөн. Төөрчхөөд "уучлаарай, уучлаарай" гээд хүмүүст хандахад хүмүүс тоохгүй яваад өнгөрдөг. Бүр ойртож очиж байж "уучлаарай би төөрчихлөө эндээс ийшээ явах гэсэн юм, би аль дугаартай метронд суух вэ" гэж асуувал, өө гээд аймаар уриалагхан тусалдаг. Тэрнээс хэн ч танд туслах уу гэж хүрээд ирэхгүй. Яагаад гэвэл хүн болгонд "dignity" буюу нандин чанар гэдэг зүйлтэй төрдөг. Хүний заяагдмал эрх. Хамгийн гол нь АНУ болон бусад хөгжилтэй орнуудад дэд бүтцийг бүгдийг нь 100% хүртээмжтэй болгочихсон учраас би хэнээс ч тусламж гуйх шаардлагагүйгээр нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцоод явах боломжтой. Тэгэхээр тэнд амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлгүй хүмүүс ч гэсэн тийм дэд бүтэцтэй орчинд, энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд надаас ямар ч тусламж хэрэггүй гэдэг ойлголтоор багаасаа төлөвшчихсөн учраас би тэр хүн дээр очиж тусламж гуйхгүй л бол хэн ч над дээр ирж "танд туслах уу, түрээд өгөх үү" гэхгүй. Монголд бол өөр. Сая чи бид хоёрыг шатаар гарч ирэхэд л шууд нэг залуу харангуутаа би өргөөд өгөх үү гээд гүйгээд хүрээд ирсэн. Энэ хүмүүсийн, нийгмийн ойлголтын зөрүү байгаа юм. Тэрнээс тэнд байгаа хүмүүс хүйтэн хөндий, хүн чанаргүйдээ биш тэртэй тэргүй хөгжлийн бэрхшээлтэй хүн явахад чөлөөтэй гэдэг ойлголт аль багаас нь суучихсан байгаа нь тэр.

Монголд тиймэрхүү хандлага харагдаад байдаг. Бас тэр хүмүүсийг давж харьцах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тоохгүй байх бас нэг хандлага харагддаг.
Өмнө ярьсан шиг хууль эрх зүйгээр бид нарт тийм хандлагыг төлөвшүүлэх

хэрэгтэй. Одоо яагаад байна гэвэл хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар ийм хандлагатай байгаач ээ, хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэдэг чинь ийм хүмүүс гээд бусдыг уриалаад байгаа. Манайд зөв хандлагыг төлөвшүүлэхийн тулд олон нийтийн сайн дурын үйл ажиллагаанууд явагдаж байхад тэр өндөр хөгжилтэй орнуудын жишээг авч үзэхээр хүчирхэг хууль зохицуулж байдаг. Тэр хуулийг дагахгүй бол ямар шийтгэл, торгууль байгаа юм гэдэг нь тодорхой. Тэгэхээр хүссэн хүсээгүй гучин жил, дөчин жил тэр хуулийг дагаад яваад ирэхээр үр хүүхдүүд нь аав ээжийгээ даган дуурайна. Тэгээд хандлагатай болчихно. Тэр хандлага төлөвшөөд тэр нийгэм аягүй гоё юм шиг харагдаад байгаа юм. Үнэн хэрэг дээрээ ард нь аймаар чанга хууль байгаа. Жишээ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ялгаварлан гадуурхдаг, дорд үздэг эсвэл шоглох гээд байдаг зүйлүүдийг бол бид нар мянга уриалаад нэмэргүй. Тодорхой хэмжээний зарим ухамсартай хүмүүс нь авах л байх. Бүх нийтийг бол чанга хуулиар зохицуулна.

НҮБ-ын конвенцоос эхлээд Монголд саяхан шинэ хуультай боллоо. Хуулийн хэрэгжилт ямар явдаг юм бол? Та сая тунхаглал төдий явж байгаа гэж хэлсэн шүү дээ. Тэгэхээр тэр хуулийн хэрэгжилт, биелэлт, хяналт нь ямархуу байдаг юм бол?

Одоо үе үеийн Засгийн газрууд бодлого боловсруулаад, төлөвлөгөөгөө гаргаад явж л байгаа байх. Жишээ нь аль 2009 онд манайх НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүний эрхийн конвенцид нэгдэж орсон. Тэрнээс хойш гарч байгаа бодлого шийдвэрүүд нь яг уялдаж байна уу, үгүй юу гээд бид 2016 онд хуультай болсон.
Бас нэлээн л хожуу хуультай болж байна шүү дээ.

Хууль маань өөрөө ерөнхий учраас хэрэгжүүлэхэд дагалдах журмууд нь батлагддаг юм байна. Гэтэл тэр журмууд нь батлагдаж дуусаагүй, одоо хүртэл процесс нь явагдаж байгаа. Манай төвийн нэг гишүүн ярьж байсан нэг бодит жишээ хэлэхэд тэр хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүн магистрт сурахад төлбөрийг нь улсаас даана гэсэн нэг зүйл заалт байгаа. Гэтэл журам нь боловсруулагдаж гараагүй учраас боловсролын байгууллага дээр очоод хэн мөнгийг нь төлөх юм, журам нь хаана байна гээд зөрүү үүсэж байгаа юм. Тэгэхээр тэр хууль хэрэгжихгүй л байгаа биз дээ. Тэр дагалдах дүрэм журам нь одоо хүртэл процесс нь явагдаж л байгаа байх.

Сүүлийн асуултаа ковид цар тахалтай холбоотойгоор асууя гэж бодож байна. Дэлхий нийтээрээ л цар тахлын нөлөөгөөр ажил эрхлэлт буурч, хүмүүсийн сэтгэл санаанд сөргөөр нөлөөлж байна. Нийтээрээ л хэцүү байгаа боловч таны бодлоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ямар нөлөөтэй байгаа вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хоорондоо бие биеийгээ явуулаад нэг пост яваад

байсан. Тэр нь хөл хорионд байлаа гээд надад ерөөсөө мэдрэгдэх юм алга гэсэн утгатай. Дэд бүтцийн хүртээмжээс болоод гарч чадахгүй байнга л гэртээ байдаг учраас хориод байгаа юм уу, яагаад байгаа нь ерөөсөө мэдрэгдэх юм алга гэсэн. Тэр хүмүүс тийм ёгт байдлаар өөрийнхөө санаа бодлыг илэрхийлсэн постууд явж байсан. Хөл хорионы үед нэг асуудалтай байсан зүйл нь хэрвээ хөгжлийн бэрхшээлтэй иргэд энэ өвчнийг авах юм бол яаж гэрээс нь зөөвөрлөөд эмнэлэгт хүргэх вэ? Эмнэлэгт очоод ямар орчинд байлгах вэ гэдэг дээр бодлого, дүрэм журмууд нь тодорхой биш байгаа. Бас 100% хатуу хөл хорионы үед байнгын эм уудаг, эмчилгээтэй байдаг эсвэл байнгын катетер хэрэглэдэг хүмүүст гарч ороход, хэрэгтэй зүйлээ худалдаж авахад нь ямар байсан бэ? гэвэл хэцүү байсан.

Урилгыг минь хүлээн авч эхний дугаарын маань зочин болж оролцсон Баттулга ахдаа баярлалаа. Таны цаашдын сурлага хөдөлмөр, ажил үйлсэд нь амжилт хүсье ээ!

Баярлалаа.

БААВГАЙ ОЛОН ЯНЗ БАЙДГИЙН АДИЛААР ХҮН Ч ОЛОН ЯНЗ

Л.Алтангэрэл



Сайн байцгаана уу, эрхэм хүндэт сонсогчид оо, Антолд подкастын маань ээлжит дугаар эхлэхэд бэлэн болоод байна. Энэхүү дугаарт Монголын аутизмын холбооны гүйцэтгэх захирал Алтангэрэл оролцож байна. Та урилгыг хүлээж авсанд баярлалаа.

За баярлалаа. Бас манайхыг зорьж санал болгосонд баярлалаа. Олон залууст хүрдэг, их сайхан подкаст гэж сонсоод их баяртай хүлээж авсан.

Баярлалаа. Сонсогчдодоо эхлээд өөрийгөө болон холбооныхоо талаар дэлгэрэнгүй мэдээллийг өгөхгүй юу?

Намайг Алтангэрэл гэдэг. Би Монголын Аутизмын холбоо төрийн бус байгууллагын гүйцэтгэх захирал. Энэ байгууллага маань 2014 онд байгуулагдсан. Аутизмтай хүүхэд залуусын амьдралын чанарыг дээшлүүлэхийн төлөө нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага юм. Аутизм гэхээр хүмүүс сайн ойлголтгүй байж магадгүй. Аутизм нь хөгжлийн бэрхшээлийн нэг төрөл бөгөөд нийгэмшихүй, харилцахуйн тал дээр илүү их асуудалтай гэдгийг нь мэдэх байх. Жишээ нь "Бороoны хүн" гээд кинонд гардаг ах нь аутизмтай байдаг. Эсвэл "Далайн диваажин" гээд Жет Лигийн тоглосон кино байдаг. Энэ Жет Лигийн тоглосон киноны хүү нь аутизмтай залуу байдаг.



Бас “Сайн эмч” гээд нэг кино сүүлийн үед их гарч байгаа олон ангит киноны гол дүрийн эмч залуу бас аутизмын хүрээний эмгэгтэй байдаг. Миний хувьд би өөрөө энэ Аутизмын холбоог анх 2014 онд үүсгэн байгуулалцсан эцэг эхчүүдийн нэг. Өнөөг хүртэл гүйцэтгэх захирлын албыг хашиж байна. Би өөрөө 2 хүүтэй, том хүү маань одоо 18 настай, аутизмтай. Нэг иймэрхүү байдлаар товчхон танилцуулъя даа.

Монголд аутизмын хүрээний эмгэг гэдэг ойлголт хожуу орж ирсэн байх?

Ерөнхийдөө Монголд аутизмын талаар ярьж эхэлсэн үе нь 2010 он юм байна. Яагаад 2010 он гэвэл тухайн үед АДРА гээд олон улсын байгууллага сэтгэцийн болон бусад мэргэжлийн эмч нарт гадаадын улс оронд хөгжлийн бэрхшээлийг ийм ийм ангиллаар ангилж байна, ингэж кодолдог юм байна гэсэн сургалтаар хүмүүс мэддэг болсон. Тэрнээс биш 2010 онд манай Монголд нэг вирус шиг юм давхиж орж ирээд тараагүй. Ерөнхийдөө тэр ойлголт, хандлага нь тухайн үедээ орж ирсэн гэсэн үг.

Тэгвэл тэрнээс өмнө буруу л оношилдог байсан гэсэн үг үү?

Тэрнээс өмнө өөр оноштой байсан л гэсэн үг. Ялангуяа тухайн үедээ Сэтгэцийн эрүүл

мэндийн үндэсний төв (СЭМҮТ) ийн эмч өөрөө ярьж байсан. Өмнө нь 1985 онд 18 настай залуу эмч нарын зөвлөгөөнөөр ороод 55 эмч тойрч суугаад учрыг нь олохгүй хүнд хэлбэрийн шизофрени гэж оношлоод явуулж байсан. Эргээд бодоход тэр залуугийн гаргадаг байсан үйлдэл, байгаа байдлыг харахаар аутизм байсан байна гэж тэр эмч ярьж байсан. Ингээд бодохоор магадгүй 1960, 1970, 1980, 1990-ээд онд аутизмтай хүн байсан байх. Тухайн үед аутизм гэдэг ойлголт байхгүй, тийм ангилал байхгүй байсан учраас магадгүй шизоферни ч юм уу, сэтгэцийн өвчин ч юм уу ямар нэгэн ангилалд хамрагдаад явж байсан байх л гэж бодож байна. Тэгэхээр 2010 оноос хойшоо оношилгоонууд бол харьцангуй аутизм гээд зөв нэр томьёогоороо оношлогдоод явж байгаа гэсэн үг.

Анх орж ирсэн 2010 оноос хойш өдийг хүртэл 11 жил өнгөрсөн байна. Энэ хугацаанд аутизмын хүрээний эмгэгийн эрүүл мэндийн салбар дахь хүний нөөц, ялангуяа тэрийг зөв оношилдог эмч, ажилтнууд хэр бэлтгэгдэж гарсан бэ?

Энэ бол төрийн бодлого болж хийгдээд явах ажил байгаа. Гадаадын улс орнуудад, жишээ нь аутизмын хүрээний эмгэг, Дауны синдром гээд тус тусдаа ангилалтай байдаг. Ангилалтай гэдэг нь тус тусдаа бэрхшээл болгоод харчихсан байдаг. Монгол Улсад та бүхний мэдэж байгаачлан хөгжлийн бэрхшээлийг тав ангилдаг. Харааны бэрхшээл, сонсгол, тулгуур эрхтэн, тэгээд оюун ухааны бэрхшээлтэй. Тэгэхээр энэ аутизм, Даун, тархины саажилттай хүмүүсийг хаа нэгтээ оруулах хэрэгтэй болно. Тэгэхээр жишээ нь аутизм гэхээр хэл яриа биш, сонсгол биш, хараа биш, тулгуур эрхтэн биш учраас оюуны ухааны бэрхшээл гэдэг ангилал луу оруулчихаж байгаа юм. Тэгэхээр массаараа хүмүүс оюуны хомсдолтой ч гэдэг юм уу, оюуны бэрхшээлтэй гээд бас ойлгож болохгүй. Халамжид хамрагдахын тулд, ямар нэгэн ангилалд хамааралтай байхын тулд гэдэг үүднээсээ оюуны бэрхшээлийн ангилал луу орж байгаа юм. Энэ оюуны бэрхшээл гэдэг ангилал луу ороод хаашаа харьяалагдах вэ гэвэл сэтгэц гэдэг тал луугаа харьяалагдаж явдаг. Тэгэхээр Шар хадны эмнэлэг буюу СЭМҮТ-д ихэвчлэн оношилгоо хийгддэг. СЭМҮТ-д яг аутизмаар мэргэшсэн эмч байхгүй. Гэхдээ эмч нар маань олон хүүхдүүдийг үзэж байгаа олон жилийн туршлагатай учраас оношилгоогоо тодорхой хэмжээнд хийдэг болсон. Харьцангуй энэ 11 жилийн хугацаанд оношилгоо бол тодорхой хэмжээнд бол сайжирсан гэж хэлж болно. Гэхдээ яг мэргэшсэн хүн гэвэл одоохондоо байхгүй байгаа. Би харин оношилгооны тал дээр олон улсын стандартыг дагадаг гэж харсан л даа.

Монгол Улсад оношлоод явдаг газрууд ер нь хэр байдаг вэ?

Аутизмыг бол F84 гэсэн кодоор кодолж явдаг. Энэ нь олон улсад зөвшөөрөгддөг тэр код нь байж байгаа. Энэ маань болохоор F84 кодолчихлоор гадаадад ч тэр, Монголд ч тэр ойлгомжтой болдог. Оношилгоо,

үнэлгээ гэдэг хоёр тусдаа зүйл байдаг. Оношилгоо гэдэг маань юу вэ гэвэл танай хүүхэд аутизмтай юм байна гээд оношилж байна. Үнэлгээ гэдэг асуудал дараа нь яригддаг. Жишээ нь 5 настай хүүхэд байлаа гэж бодоход биологийн нас нь 5 настай гэтэл сэтгэхүйн буюу өөртөө үйлчлэх, бие даах, хэл ярианы чадварууд нь хэдэн настай вэ гэдгийг нь үнэлгээгээр гаргаж ирдэг юм. Магадгүй 5 настай хүүхэд хэл ярианы хувьд 4-5 үгтэй байвал 1 настай хүүхдийн төвшинд байж болно. Эсвэл өөртөө үйлчлээд хувцсаа өмсөх дээр хөл гар нь сул, биеэ даан өөртөө үйлчилж чадахгүй бол магадгүй тэр 3 настай байна гээд чадварыг үнэлж байгаа юм. Тэгэхээр оношилгооноос гадна үнэлгээ гэж тусдаа явна. Манайд бол оношилгоо бол хийж байгаа, үнэлгээг зарим нэг газруудад хийж эхэлсэн.

Тэгвэл эрт үнэлгээгээ хийлгэх нь сайн уу?

Аль болох эрт илрүүлэх тусмаа сайн. Эрт илрүүлэх, эрт эмчлэх гэдэг үг сүүлийн үед их гарч ирж байгаа. Тэгэхээр магадгүй оношилгоогоо эрт хийлгээд, боломжтой бол үнэлгээгээ эрт хийлгэвэл зүгээр. Боломжтой бол гэдгийг би ямар утгаар хэлж байна гэвэл үнэлгээ заавал бас хийлгэх ёстой гэсэн үг биш. Гэхдээ огт хийлгэхгүй байж болно гэсэн үг бас биш. Хүсвэл хийлгэж болно гэж байгаа юм. Үнэлгээгээ хийлгээд, үнэлгээнээсээ хүүхдийнхээ чадварыг тогтоож авна. Жишээ нь 5 настай хүүхэд байлаа гэхэд за хэл яриа нэг настай юм байна. Бие даах нь гурван настай юм байна. Хоол ундаа идэж уух, өөртөө үйлчлэх чадвар нь 2 настай юм байна. Танин мэдэхүй нь 1 ой 8 сартай юм байна гээд чадваруудаа мэдээд авчихвал эцэг эхчүүд хүүхэдтэйгээ ажиллахдаа энэ хэсэг нь жаахан сул байсан, энэ тал дээр түлхүү ажиллая ч гэдэг арга барилаа олоход үнэлгээ чухал байдаг юм. Сүүлийн үед манайд СЭМҮТ юм уу, улсын чанартай эмнэлгүүдэд үнэлгээ шууд хийгдэхгүй байгаа. Зүгээр АйКю (IQ) үнэлгээ хийж байгаа. Ганц нэг хувийн байгууллагуудад үнэлгээ хийж байгаа нь тодорхой хэмжээний өртөг төлбөртэй байдаг учраас зарим хүмүүст хүндрэл, ачаалал болж болзошгүй. Тиймээс заавал гэж шаардахгүй, хүсвэл та хийлгэж болно гэдэг байдлаар л явдаг.

Таны бодлоор Монголд хүүхдэд нь аутизмын шинж тэмдэг илрээд байхад эцэг эхчүүд нь энэ талаар мэдлэггүй хүмүүс хэр их байдаг вэ?

Аутизм гаднаас нь харахад шууд бие махбодод илрэх шинж тэмдэг сул, цөөн байдаг. Жишээ нь Дауны синдромтой хүүхдийг гаднаас нь харахад мэдэгддэг эсвэл харааны, сонсголын, тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхдийг гаднаас нь хараад мэдэгддэг бол аутизмтай хүмүүсийн хувьд гаднаас хараад ямар нэгэн шууд шинж тэмдэг байдаггүй. Гол асуудал бол аутизмд 3 гол бэрхшээл байдаг. Нэгдүгээрт хэл яриа, хоёрдугаарт нь нийгэмшихүй. Гуравдугаарт нь төсөөлөн бодох, аливаа зүйлийг танин мэдэх чадвар. Тэгээд хэл яриа, нийгэмшихүй нь ихэвчлэн хүүхдийг харилцаанд орж эхлэх үед буюу цэцэрлэгт орж хүмүүстэй харьцаад эхлэх үеэс илүү

анзаарагддаг. Тэгэхээр эцэг эхчүүд маань, ялангуяа гаднаас хараад анзаарагдах шинж тэмдэг байхгүй байсан хүүхэд нь сургууль, цэцэрлэгт ороод нийгмийн харилцааны явцад илэрхий шинж тэмдэг анзаарагдвал анзаарахаас биш, бусад тохиолдолд бараг анзаардаггүй. Ялангуяа аутизмтай хүүхдүүдийн хувьд 4:1-ийн харьцаатай байдаг. 4:1-ийн харьцаатай гэдэг нь аутизмтай 5 хүүхэд байхад 4 нь эрэгтэй, 1 нь эмэгтэй байдаг. Ээж аавууд яадаг гэвэл эрэгтэй хүүхэд оройтож хэлд ордог, зүгээр зүгээр эсвэл аав нь оройтож хэлд орсон юм, зүгээр зүгээр гэдэг. Тиймэрхүү байдлаар хүүхдийнхээ харилцааны, хэл ярианы хоцрогдлыг үнэхээр аутизмтай холбоотой хоцрогдол байна уу эсвэл бусад хүчин зүйл үү гэдгээ анзаарах тал дээрээ сул байдаг. Тэгээд анзаарчихсан ч гэсэн гаднаа илрэх илэрхий шинж тэмдэг байхгүй нөхцөлд эцэг эх хүлээн зөвшөөрөхдөө их удаан ялангуяа эрэгтэй хүүхэд бол бас л үнэтэй хүүхэд шүү дээ. Жишээлбэл ээж нь анзаараад манай хүүхэд нэг л өөр байна гэхэд аав нь үгүй, миний хүү тийм байх ёсгүй, миний хүү зүгээр гээд байдаг. Эхэн үедээ бүх л гэр бүлд гардаг асуудал, яваандаа хүүхдийнхээ нөхцөл байдлыг ойлгоод ирэхээр анзаарч эхэлдэг. Тэгэхээр зарим талдаа эцэг эхчүүд сул хандах гээд байдаг зүйлүүд гардаг.

Эцэг эхчүүд сул хандаж байгаа нь тухайн хүмүүсийн өөрсдийнх нь аутизмын хүрээний эмгэгийн талаарх ойлголтгүй байгаагийнх уу эсвэл хүлээн зөвшөөрөхийг хүсэхгүй байна гэсэн үг үү?

Аль аль нь байгаа гэж харж байна. Нэгдүгээрт, ойлголт байхгүй байна. Ерөөсөө аутизм гэж юу вэ гэдгээ мэдэхгүй байгаа учраас хүлээж авч чадахгүй байгаа байж магадгүй. Хоёрдугаарт, сая хэлдэг хүсэхгүй байж болно. Аутизм бол хөгжлийн бэрхшээлийн ангилал луу ордог. Тэгэхээр "миний хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй болоод байхдаа яадаг юм, зүв зүгээр л байна шүү дээ, энэ явж, харж, өөрөө хоолоо идэж чадаж байна" гэдэг. Тэгэхээр аль аль нь байгаа байх гэж бодож байна. Ялангуяа энэ удаад би ойлголтыг илүү яримаар байна. Ойлголтын тухайд ялангуяа саяын буруу ойлголтууд. Угаасаа эрэгтэй хүүхэд оройтож хэлд ордог эсвэл зүгээр л байна шүү дээ гээд бусад хүмүүсийн ийм анзааргагүй байдал бас нөлөөлдөг. Дээрээс нь хөгжлийн бэрхшээл гэдэг нь манайханд их хүнд тусдаг. Ерөөсөө өөрөө юу ч хийж чадахгүй, нийгмээс тусгаарлагдсан, ямар нэгэн эд эрхтний гажигтай, согогтой гэдэг байдлаар бид хүүхэд байхаасаа хүлээгээд авчихсан болохоор тэр ойлголт нь өөрөө буруу байгаа юм. Аутизмын хүрээний эмгэг өөрөө саяын ярьсан харилцаа, нийгэмшихүйн тал дээр асуудал байгаа гэдгийг ойлгох юм бол магадгүй эцэг эхчүүд эрт анзаараад, эрт арга хэмжээ авахад үр дүнтэй гэж бодож байна.

Та сая хүмүүс хөгжлийн бэрхшээлийг хүндээр хүлээж авдаг гэж хэллээ. Энэ нь багаасаа хөгжлийн бэрхшээлийн талаар боловсрол бага олгосон учраас тэгж хүндээр хүлээж авч байгаа юу?

Сүүлийн үед тэгш хамруулалт гэж яриад, Ерөнхий боловсролын сургууль дунд ганц нэг сул хараатай эсвэл бэрхшээлтэй хүүхдүүд явж эхэлж байна. Өмнө нь буюу сүүлийн 20, 30 жилийн жишээнээс харахад яг танай ангид хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байсан уу?

Байгаагүй.

Хэрвээ ямар нэгэн тулгуур эрхтний, сонсголын эсвэл магадгүй бага зэрэг оюуны бэрхшээлтэй хүүхэд байсан бол та нар тэр хүүхдээ харж өснө. Тэргэнцэртэй хүүхдэд ийм бэрхшээл тулгардаг, сонсголын бэрхшээлтэй хүүхдэд ийм бэрхшээл тулгардаг, оюуны бэрхшээлтэй хүүхэд ингэдэг юм байна гээд мэддэг болно. Ингэхээр нь бид ингээд туслах юм байна, үүн дээр нь өөрөөр нь орхичих юм байна гэдгийг та нарт анхнаас нь хэлж өгөөгүй. Дээрээс нь тийм орчин байгаагүй. Тэгэхээр хүүхэд байх үеэсээ биеэрээ мэдэрдэг, ойлгодог тэр туршлага, туршилтаа бид нар хийж чадаагүй учраас өөрөө ирээдүйд тийм хүүхэдтэй болохоор “Яагаад би гэж?” “Би ямар ч буруу юм хийгээгүй”. “Яагаад би бараг шийтгэл амсах ёстой болов оо?” гэх маягаар хүлээж аваад байдаг. Гэтэл энэ бол нийгэмд байдаг жирийн л нөхдүүдийн нэг. Нөгөө баавгай олон янз байдаг. Цагаан баавгай ч байдаг, панда ч байдаг, бор баавгай ч байдаг гэдэг шиг хүн болгон олон янз байдаг.

Стандартын хүн гэж хаана байна? Жишээ нь Сайнааг стандартын хүн гэж үзвэл бүх эмэгтэйчүүд Сайнаа шиг болох ёстой биз дээ? Гэтэл өндөр нам, урт богино, бүдүүн нарийн, том алаг нүдтэй, онигор нүдтэй гээд хэзээ ч стандартын юм байхгүй гэдэг шиг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бол энгийн хүмүүстэй харьцуулахад магадгүй 1 зүйлээрээ жоохон дутуу байж болохоос биш бүр байж боломгүй гаж зүйл биш юм. Тэгэхээр үүнийг бид нар цэцэрлэг, сургуульд байхдаа мэдрээд явчихвал цочирдож, хүндээр хүлээж авдаггүй тэр нийгэм бий болно. Эсрэгээр хөгжлийн бэрхшээлтэй хүн ч амьдралд илүү бэлтгэгддэг. Яагаад гэвэл хүмүүстэйгээ зэрэгцэн оршоод явчхаж байна. Эрүүл хүмүүс ч гэсэн энд 1 бэрхшээлтэй хүн байдаг, түүний онцлог нь тэр, бид энэ үед нь тусална, энэ үед нь харьцахгүй байж болно гэдэг зааг ялгаагаа ойлгодог байвал их зүгээр байдаг. Тэр үүднээсээ сүүлийн үеийн тэгш хамруулалт гэдгийг их дэмжээд байгаа. Тэгэхээр эцэг эхчүүд маань ч гэсэн энэ тал дээр хүүхдийнх нь ангид 1 бэрхшээлтэй хүүхэд байхад хол байгаарай, битгий ойртоорой, битгий тоглоорой гэдэг байдлаар хандахаасаа илүү, тэгвэл найздаа хэрэгцээтэй үед нь туслаарай, чи бас мэдээд аваарай гэвэл тэр хүүхдэд бас маш өндөр боловсрол олгож байгаа хэрэг юм. Яагаад гэвэл өөрийнхөө эрүүл саруул байгааг тэр хүүхэд анзаарч, талархаж эхэлнэ. Бусдад тусалдаг, хүнлэг болж эхэлнэ.

Анх 2018 оноос тэгш хамруулан сургах тухай тогтоол яамнаас гарсан гэж та хэлсэн. Тэр үеэс эхлээд аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдүүд ерөнхий боловсролын сургуульд явж эхэлж

чаддаг болсон гэсэн үг үү эсвэл өмнө нь ч гэсэн явдаг байсан уу?

Ерөнхийдөө аутизмтай хүүхдүүд олон янз байдаг. Жишээлбэл 10 хүүхэд байхад 10-уулаа өөр байдаг юм. Тэрнээс 1 аутизмтай хүнийг мэддэг бол бүх хүмүүс тийм гэж үзэж болохгүй. Аутизм дотроо сонгодог аутизм, өндөр чадвартай аутизм, аспергер гэсэн ангилагдаад явчихдаг. Тэгэхээр магадгүй 2018 оноос өмнө маш хөнгөн хэлбэрийн аутизмтай хүүхдүүд тодорхой хэмжээнд ерөнхий боловсролын сургуульд хамрагдаад явж байсан байх. Харин 2018 оноос эхлээд тэр журам гарснаас хойш сургууль хүүхдийг хүлээж авах үүрэгтэй болсон юм. Тэгэхээр тодорхой хэмжээгээр хүүхдүүд хамрагдаж эхэлж байгаа. Мэдээж 1 ангид ойролцоогоор 1-2 хүүхэд гэж явж байгаа. Гэтэл тэр нь заавал аутизмтэй биш, ямар ч бэрхшээлтэй байж болно. Хүүхдүүд хүлээж авах эрх зүйн орчин нь үүсчихсэн гэсэн үг. Тэр хүрээндээ эцэг эхчүүд хүүхдүүдээ сургуульд харьцангуй хамруулаад эхэлчихсэн байгаа.

Хэдийгээр хууль тогтоомж нь гарсан ч гэсэн сургуулиуд маань дэд бүтцээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулж хангаж чадсан болов уу?

Журмын хүрээнд хүүхдүүд бол хамрагдаад явж байгаа. Аутизмтай хүүхдүүдийн хувьд дэд бүтцийн асуудал болох налуу зам, цахилгаан шат эсвэл харааны бэрхшээлтэй



хүмүүст зориулсан тактелин зам, брайль үсэг гэсэн шаардлага харьцангуй гайгүй байдаг. Магадгүй тэргэнцэртэй хүүхэд явж эхэлж байгаа нөхцөлд тэр хүүхдийг анги луугаа ороход замын саадуудыг налуу болгох, босгыг нь байхгүй болгох зүйлүүдийг хийж байгаа байх. Сүүлийн үеийн баригдаж байгаа сургуулиуд юниверсал загвар гэдэг үүднээсээ харьцангуй шийдэгдээд явж байгааг харахад таатай байдаг.

Тэрнээс гадна багш, сурган хүмүүжүүлэгч нарын аутизмын талаарх ойлголт хэр байдаг вэ? Нэлээн сүүлийн үеийн ойлголт болохоор зарим хүмүүс үнэнийг хэлэхэд мэдэхгүй л явж байгаа шүү дээ, тийм ээ?

Багш нар маань бас олон талтай байгаа. Үнэхээр аутизмтай хүүхэдтэй ажиллаад явах хүсэл эрмэлзэлтэй багш байхад, угаасаа улсын сургуульд одоо 50, 60 хүүхэдтэй байхад дахиад 1 бэрхшээлтэй хүүхэд орж ирээд, хэзээ нь би ажиллах юм бэ гэж үзэх хүн ч байгаа. Тэгэхээр аль алийг нь буруутгах, зөвтгөх аргагүй. Гэхдээ нэгэнт л журам гарсан учраас төр маань бас тэр хэмжээгээр зохицуулалтыг нь бас хийж өгөх ёстой гэж бодож байгаа. Харьцангуй багш гэдэг хүн нь хүнд түгээн дэлгэрүүлье, заая гэдэг хүсэл эрмэлзэл нь байдаг учраас сургалт, янз бүрийн юмаар дамжуулаад ажиллая, болгоё, бүтээе гэсэн багш нар их байдаг. Монголын аутизмын холбоо 2019 онд Боловсрол соёл шинжлэх ухааны яамтай хамтраад 10,000 багшийг аутизмтай хүүхэдтэй ажиллах, тэгш хамруулах бэлтгэл хийлгэж, сургалтад хамруулъя гэсэн 5 жилийн том төлөвлөгөөг гаргаад, ажлаа эхлүүлсэн. Тэгээд 2019 онд бид Улаанбаатар хотын 9 дүүргийн 600 багшийг яамтайгаа хамтраад сургалтад хамруулсан. Дандаа ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, сургалтын менежер гэсэн хүмүүсийг хамруулсан. Харамсалтай нь цар тахал гараад бидний сургалт одоо зогсчихсон байна. Үүнтэй холбогдуулаад бид нар нийтдээ 6 удаагийн сургалтыг яаман дээр доод тал нь 80-100 багш цуглуулан сургалт хийсэн. Бид нар дүүрэг дүүргээр 6 сургалтыг хийсэн. Сургалтаа хийхдээ бид нар аутизмтай хүүхдийн онцлог, аутизмтай хүүхэдтэй ажиллах арга зүй, дээрээс нь гарын авлага гаргаж өгсөн. Харьцангуй багш нартаа мэдээлэл түгээх ажлыг эхлүүлээд явж байгаа хэдий ч энэ маань урт хугацааны ажил байдаг. Тухайн багш хүүхэдтэй ажиллана, туршлага хуримтлуулна, яг тэр арга аргачлал хүүхэд болгоны онцлог нь өөр учраас дараагийн хүүхдэд таарна гэсэн үг бас биш. Тэгэхээр ямар ч байсан эхлэлийг нь тавьчихсан, явж л байгаа. Багш нар маань олон талаасаа дэмждэг. Багш гэдэг хүн чинь дандаа тэргүүнд явдаг хүн учраас бид нар цаашид сайхан хамтын ажиллагаанууд өрнүүлж чадна гэж найдаж байгаа.

Одоогийн байдлаар танай холбоонд хэдэн аутизмтай хүүхэд залуучууд бүртгэлтэй байдаг вэ?

Манай холбоо 2014 онд байгуулагдсанаас

хойш одоо 8 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байна. Манай хүүхэд аутизмтай юм байна, танайд бүртгүүлье гээд хандсан 800 орчим гэр бүл бүртгэлтэй байгаа. Яагаад манайд бүртгүүлж байгаа вэ гэвэл манай улсын хэмжээнд оюуны бэрхшээлтэй хүний тоо гэдэг статистик тоо байхаас биш яг аутизмтай нь хэд юм, Даунтай нь хэд юм, тархины саажилттай нь хэд гэдэг тоо яг байдаггүй. Тийм учраас манай холбоо бодлогын хүрээнд улсдаа тодорхой хэмжээний мэдээ мэдээлэл гаргаж өгөх, гишүүд буюу аутизмтай хүмүүсийнхээ эрх ашгийг ярьж танилцуулах, тоо баримттай байх нь чухал гэдэг үүднээсээ сайн дурааараа бүртгэл хийдэг. Гэхдээ зөвхөн хандсан хүнийг л бид бүртгэнэ. Тэрнээс үндэсний хэмжээнд эрэл хайгуул судалгаа хийгээд олж илрүүлэх ажлыг бол мэдээж чадахгүй.

Аутизмтай хүмүүсийн насны ангилал нь хэр байдаг вэ?

Одоогоор хамгийн хөгшин нь 31 настай хүн байна. Магадгүй өмнө нь ярьж байсан шиг өөр оноштой ч аутизмтай хүмүүс байхыг үгүйсгэхгүй. Бид нар яг 2014 оноос хойших бүртгэлээрээ 2010 оноос хойш оношлогдсон хүмүүсийнхээ дунд үзэхэд 31-тэй хүн байдаг. Ерөнхийдөө аутизм өөрөө 2 наснаас ихэвчлэн оношлогддог. Яг цэцэрлэгт яваад, нийгмийн харилцаанд ороод ялгаатай байдал нь анзаарагдаад эхэлдэг үе бол 2 нас байгаа. Тэгэхээр 2-10 хүртэлх настай хүүхдүүд одоо яг бүртгэлтэй хүмүүсийн бараг 70%-ийг эзэлж байгаа. Тэгээд 10-16 нас хүртэлх нь бараг 20% байхад, 16-аас дээшээ, 18-аас дээшээ 10% арай хүрэхгүй байх, 7% гэсэн байдалтай байна. Ерөнхийдөө дийлэнх нь 2-10 насныхан гээд ойлгочхож болно.

Нийгэм одоо аутизмын талаар ойлгоод ирэхээр жишээлбэл манай 30, 40 дөчин настай эсвэл 50, магадгүй 60 настай энэ ах аутизмтай байсан юм байна гэж хүрч ирээд хандаж байсан тохиолдол байгаа юу?

Мэр сэр холбогддог. Танай фэйсбүүк дээр бичсэн мэдээллийг харахаар яг багадаа хийж байсан, залуудаа хийж байсан үйлдлүүд нь аутизмтай хүн шиг байдаг юм гээд ганц нэг хүн холбогдож байсан. Тэрнээс яг тэр хүн өөрөө давхиж ирээд эсвэл гэрийнхэн нь давхиж ирээд энэ хүнийг одоо яах вэ? гэдэг асуудал мэдээж яригдахгүй. Манайх чинь төрийн бус байгууллага, ямар нэгэн эмнэлгийн, эмчилгээний үйлчилгээ үзүүлдэг газар биш. Дээрээс нь аутизм өөрөө өвчин биш учраас янз бүрийн эмчилгээ, сувилгаа, асаргаа хийнэ гэсэн юм байхгүй. Янз бүрийн сургалтын аргууд, терапинууд (therapy) байдаг. Тэгэхдээ магадгүй 50, 60 хүрчихсэн хүнд одоо юу хийх вэ? Тэгэхээр амьдралынхаа хугацаанд магадгүй тодорхой хэмжээнд төлөвшөөд, бэрхшээлтэй учрахдаа учраад л, туулахдаа туулаад л явж байгаа байх гэж харж байгаа.

Нөгөө 800 гаруй бүртгэлтэй гэр бүлийн ихэнх нь хотынх уу? Орон нутгаас бас хүмүүс байдаг уу?

Ер нь бол хотынхон дийлэнх байдаг. Хөдөө орон нутгаас бас гадаадаас их холбогддог. Гадаадад харьцангуй их 10 орчим хувь нь байж магадгүй. Тэгэхээр бараг 80-100 орчим гэр бүл гадаадад байхыг үгүйсгэхгүй. Яагаад гэвэл гадаадад харьцангуй мэдлэг мэдээлэл сайтай, ойлголтоо авчихдаг. Тэнд оношилгоо, үнэлгээгээ хийлгэж, системтэй үйлчилгээгээ авчихдаг. Тэд нар мэдээж Монголд ийм үйл ажиллагаа явуулдаг байгууллага байна гэхээр бид нартай холбогдоно, бүртгүүлнэ. Дээрээс нь гадаадад ийм эх сурвалж гарч, гадаадад ийм юм хийгдэж байна гээд мэдээллээ хуваалцана. Орон нутгаас мэдээж холбогдоно. Цахим холбоо, сүлжээ, фэйсбүүк янз янзын юмаар хүмүүс их холбогдоно. Дээрээс нь 4-р сар чинь аутизмыг таниулах сар байдаг учраас хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл өгөөд явахаар хүмүүс бас үзсэн, харсан хүмүүс нь холбогддог.

Миний танаас асуух гээд байгаа зүйл бол хот хөдөөгийн ялгаа хэр байна? Магадгүй та сургалт хийгээд хөдөө ч явж байхад хүлээж авч байгаа хандлага нь хот хөдөөгөөр ялгарч байна уу?

Мэдээж хотод бол дийлэнх нь байгаа. Хотын хүмүүс бол харьцангуй мэдээлэлтэй ойрхон. Хамгийн наад зах нь 1 гарын авлага тогтмол гардаг боллоо гэхэд хотынхон холбооноос ирээд авах боломжтой.



Хөдөөнийхөн бол боломж муутай, мэдээллээс хол байдаг. Дээрээс нь тэр болгон хүмүүс интернет ашигладаг билүү гэдэг асуудал гарч ирнэ. Тэр үүднээсээ мэдээж хөдөө орон нутгийнхан мэдээллээс жоохон хоцрогдсон байх тохиолдол байдаг. Хөдөө бол ихэвчлэн хамгийн том асуудал юу вэ гэвэл жишээлбэл сургалт хийгээд явахад сумдаас гарч ирэх асуудал хэцүү. Бид нар сум болгоныг тойроод явж чадахгүй. Нэг аймгийн төв дээр сургалт хийгээд, мэдээлэл өгөөд явъя гэхээр аймгийн төв дээр байгаа хүмүүс л ирж оролцоод, суманд эсвэл малчны хотонд байгаа хүмүүс үлдчих гээд байдаг. Үүнийг шийдэх ямар ч арга байхгүй. Яагаад гэвэл бид өөрсдийнхөө боломж, нөөц бололцоогоор л хийж байгаа учраас үндэсний хэмжээний мал тооллого гэдэг шиг бид өрх болгоноор ороод тоолоод явж чадахгүй. Мэдээллийн хувьд яах аргагүй орон нутгийнхан жоохон мэдээллээс холдоод байдаг юм.

Тэгвэл Монголд гарч байгаа статистик бага тоогоор гардаг гэж ойлгож болох юм байна. Ер нь дэлхий нийтэд статистик тоо баримт хэр байдаг вэ?

Манайх ерөнхийдөө бодитой тоо гэж хэлэхэд хэцүү. Гадаадын улс орнууд бол бүртгэл тооцоогоо маш сайн хийдэг. Америкийн 2014 онд гаргасан судалгаагаар 68 хүүхэд тутмын 1 нь аутизмтай байсан. Харин 2018 оны тооцоогоор 58-д 1 гээд энэ тоо нэмэгдээд байгаа биз? Тэгэхээр 58-д 1 гээд бодохоор Монголд бол тэд гэсэн тоо байхгүй. Би ярианы явцад 200-д 1 гээд үзэх юм бол Монгол Улсын 3 сая хүн амд багадаа 20,000 орчим аутизмын хүрээний эмгэгтэй хүн байхаар таамаглал дэвшүүлээд байгаа юм. Энэ бол албан ёсны тоо биш, зүгээр таамаглал.

Одоо танай холбооны талаар мэдээлэл авмаар байна. Ихэнх холбоонууд нөлөөллийн үйл ажиллагаа ихээр явуулдаг. Танайхаас нийгэмд зориулсан ямар ямар нөлөөллийн үйл ажиллагааг явуулж байна вэ?

Тэгэхээр манайх 2014 онд байгуулагдсан, Аутизм ассошиэйшн (Autism association) гэдэг фэйсбүүк хаягтай. Мөн аутизм.мн (www.autism.mn) гээд цахим хуудас байгаа. Үүгээрээ дамжуулаад мөн телевиз радиогоор дамжуулаад гол нь нийгэмд ойлголт хандлагыг зөв өгье, зөв мэдлэг, мэдээлэлтэй болгоё гэдэг байдлаар янз бүрийн видео, шторк, постер, танилцуулга гэсэн зүйлүүдийг их хийж, ярьдаг. Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас жил бүрийн 4 дүгээр сарын 2-ны өдрийг аутизмтай хүмүүст зориулсан, нэг ёсны аутизмыг таниулах өдөр болгож 2008 онд тунхагласан байдаг. Яагаад ингэж тунхагласан бэ гэвэл аутизмтай хүмүүсийг зөвөөр ойлгоё, хүлээн зөвшөөрье, ялгаварлан гадуурхалтыг зогсооё гэдэг үүднээс 4-р сар бол бүхэлдээ аутизмыг таниулах сар гэж явдаг. Зарим нэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр аутизмтай тэмцэх гэдэг байдлаар ороод байдаг нь буруу юм. Энэ хүрээнд ч гэсэн манайх 4-р сард

олон нөлөөллийн ажлуудыг төлөвлөж байна. Гол нь бидний нөлөөлөл дандаа фэйсбүүк, интернет сүлжээнд түгээх байдлаар хүмүүст хүрдэг. Та бүхэн аутизм монгол эсвэл аутизмын тухай гээд юутүб (youtube), фэйсбүүк (facebook) янз бүрийн газраар хайвал холбогдох мэдээллүүд гарч ирнэ. Тэрнийг бас сонирхоод үзээрэй гэж хүсмээр байна. Манай холбооны гаргасан их олон хөөрхөн видео, шторкууд байдаг.

Би үзэж яваад нэлээн мэдээлэлтэй болсон. Сонсогч нар маань ч гэсэн сонсоорой гэж уриалж байна. Хэдийгээр би жирийн Монголын дундаж давхаргын хүн гэхэд аутизмын талаар ойлголт багатай байсан. Энэ ярилцлагыг хийхийн өмнө аутизм гэж сонсож байсан ч яг юу байдаг юм, өвчин юм уу, эмгэг юм уу, тэрийгээ ч ялгахгүй байдалтай байсан. Тэгээд танай холбооноос гаргасан мэдээллүүдийг хараад ийм учиртай юм байна гээд нэлээн мэдээлэлтэй болсон.

Цаашдаа улам их амжилт хүсэж, олон хүмүүс бас мэдээсэй гэж хүсэж байна. Нэмээд асуух гэж байгаа зүйл бол ажил эрхлэлтийн талаар асууя гэсэн бодол байна. Аутизмын хүрээний эмгэгтэй хүмүүс шинэ орчинд мэдрэг гэж уншсан. Шинэ ажилд орох, гэрээсээ гараад ажлын шинэ, өөр орчинд орох нь хэр байдаг вэ?

Одоо яг энэ хөдөлмөр эрхлэлтийн асуудал яригдаж байна. Манай нийт бүртгэлтэй гишүүдийн 70 орчим хувь нь 2-5 нас гэж хэлсэн. Тэрнээс дээшээ 16, 18 хүрчихсэн залуусын асуудал одоо яг яригдаж байгаа. Тэгэхээр энэ хүмүүс нийгэмд зүгээр нэг халамж авагч байдлаар баймааргүй байна. Яагаад гэвэл би аутизмтай хүмүүсийг өөрсдөө маш их ажлын нөөц, капитал гэж харж байгаа. Аутизмтай хүмүүс янз бүрийн хөл гарын, тулгуур эрхтний бэрхшээл, саад байхгүй учраас тэр хүмүүсийг ашиглаад, ажиллуулаад явах бүрэн боломжтой.

Ганцхан манай хууль эрх зүйн орчин, дээрээс нь өнөөгийн байдлаар оюуны бэрхшээлтэй гэдэг ангилалд орчихсон энэ хүмүүсийн ажлын байрны асуудал одоохондоо бүрэн төгс шийдэгдээгүй байна. Монголд 25 хүнтэй албан газарт 1 хөгжлийн бэрхшээлтэй хүн байж болно гэсэн хуулийн заалттай. Ихэвчлэн энэ заалт маань оюуны бус бэрхшээлтэй хүмүүсийн асуудал дээр яригдаад байдаг. Хэдийгээр аутизмтай хүмүүс бүгд оюуны бэрхшээлтэй биш ч бас энэ хүмүүсийг яаж ажиллуулах вэ, ямар нөөц байдлаар ашиглах вэ гэдэг асуудал яригдаад, бид нар энэ чиглэлээр ажиллаж байгаа. Үүнтэй холбогдуулаад нэгдүгээрт хаана ажиллах вэ гэдгийг судлах хэрэгтэй болно. Дээрээс нь тэр хүмүүсээ анхан шатны хөдөлмөрт бэлтгэх сургалтууд хийгдэнэ. Энэ ажлууд маань дандаа сургуулийн өмнөх боловсролоос эхэлнэ. Сууж сураагүй хүн ажил хийнэ гэж байхгүй болохоор эхлээд сургуулийн өмнөх боловсрол, дахиад ерөнхий боловсролын сургууль, магадгүй тэрний дараа Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв (МСҮТ) гэсэн байдлаар явж байж хөдөлмөр эрхлэлтийн асуудал яригдана. Таны сая асуусан шиг аутизмтай хүмүүс

шинэ орчин нөхцөлд мэдрэг байдаг хүчин зүйлүүд бол гарч ирнэ. Үүнийг тодорхой хэмжээгээр хүүхдүүд маань сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын дамжлагуудаар даваад явчихна. Ажлын байран дээр ирсэн нөхцөлд тухайн ажлын байрны холбогдох хүмүүстэй нь ярьж тохиролцоод ямар ажлын байранд байлгах вэ, ямар орчин нөхцөлд байх вэ гэдгийгээ дараа нь шийдэж болох байх гэж бодож байна. Гэхээр эхний ээлжид хөдөлмөр эрхлэх гэж байгаа хүн маань тодорхой хэмжээнд бэлтгэгдэх хэрэгтэй. Бэлтгэгдэнэ гэдэг нь жирийн хүн шиг шалгалтыг нь өгөөд бүх хүмүүстэй адилхан өрсөлдөөд тэнцээд орно гэдэг тийм шалгуур биш. Нэг талаас аутизмтай хүн тодорхой хэмжээнд ажиллах бэлтгэлтэй байна. Нөгөө талаас тэр хэмжээнд нь албан байгууллага, ажил олгогч хүлээж авааД тэр орчныг нь бүрдүүлээд, тэр хүнийг капиталынх нь хувьд ашиглах тэр тогтолцоог нь бүрдүүлнэ гэсэн ийм хоёр талын асуудал яваад байгаа юм. Тэгэхээр магадгүй мэдрэг байдал, шинэ орчинд дасан зохицох эсвэл аливаа юмыг хүлээж авах гэдэг асуудлуудыг явцдаа шийдвэрлээд явчихвал хөдөлмөр эрхлэлт гэдэг тийм хүнд асуудал биш гэж харж байгаа.

Одоогийн байдлаар аутизмын хүрээний эмгэгтэй хөдөлмөр эрхэлж байгаа кэйс та мэдэх үү?

Аутизм дотроо олон ангилалтай. Хөнгөн 1, 2 залуус ажил эрхэлж байгаа. Гэхдээ нийтлэгээрээ уг нь ажил эрхэлдэг болчихвол зүгээр байна. Тэгэхээр үүнийг бас бодоод хойшдынхоо үйл ажиллагаандаа төлөвлөөд явж байгаа.

Тэгвэл ихэнх нь ажил эрхлээгүй гэртээ байгаа эсвэл зарим нь сургуульд явж байгаа гэсэн үг. Тэгэхээр цаашдаа ажил эрхлэлтийн талаар хөндөж ярихгүй бол энэ хүмүүс насаараа гэр бүлийнхээ харьяанд бие дааж чадахгүй байна гэсэн үг үү?

Одоогийн туршлага юу байна вэ гэвэл 10 жилийн сургуулиа төгслөө, тэрнээс цаашаа явах газар үгүй гэдэг шиг болчхоод байгаа юм. Тэгэхээр энэ асуудлыг шийдэхийн тулд магадгүй цаашаа МСҮТ-д суралцах шаардлагатай бол суралцаад, цаашаа ажлын байранд гарна. Хэрвээ ажлын байранд тэр хүн гараад ирвэл сая ярьсан хүмүүстэй харилцах чадвар сайжирна, нийгэмшихүй сайжирна, магадгүй бие дааж амьдрах чадвар сайжирна. Энэ хүрээнд гэртээ суудаг, гэрийнхэн нь асран хамгаалдаг, ямар ч зорилгогүй хүн болохоос урьдчилан сэргийлж байгаа юм. Ингэхийн тулд сая ярьсан сургуулийн өмнөх боловсролоос нь эхлээд 1 ангид хүүхдүүд байгаад ирвэл магадгүй ажлын байран дээр аутизмтай хүн хажууд нь ажиллахад багаасаа аутизмтай, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг мэддэг залуус тоохгүй. Өө байж л байдаг юм. Аутизмтай хүнтэй ингэж харьцвал болно, ингэж харьцвал болохгүй гээд зохистой юмаа мэдээд явчихдаг учраас ирээдүйд ямар нэгэн асуудал гарахгүй гэж бодож байна. Тэгэхээр энэ үүднээс нь анхнаас нь аль

аль талдаа системтэй явах боломжтой гэж харж байна.

Танаас Аутизмын холбооны гүйцэтгэх захирлын үүднээс олон асуулт асуулаа. Одоо би таныг аутизмтай хүүхэдтэй Монголын иргэн хүний хувиас асуулт асууя. Таны хүсэл мөрөөдөл юу вэ?

Зүгээр л хувь хүний хувьд асуусан бол дэлхийгээр аялах ч юм уу гоё гоё юм ярих байх. Аутизмтай хүүхэдтэй ээжийн хувьд гэвэл хүүхдээ үлдээгээд үхэхдээ сэтгэл амар баймаар байна. Энэ юу гэсэн үг вэ гэвэл би 2 хүүтэй. Том нь 18 настай, бага нь 11 настай. Тэгээд том хүү маань аутизмтай. Түүнд 11 настай эрэгтэй дүү нь байна. Гэхдээ дүү, ах, эгч нь юм уу, хэн нэг нь заавал тэр хөгжлийн бэрхшээлтэй хүнээ асрах ялтай юм шиг үлдээмээргүй байна. Монголын хувьд ах дүүсийн харилцаа гэдэг их чухал. Бид дандаа бие биеийгээ дэмжиж явдаг тогтчихсон уламжлалтай. Гэхдээ ирээдүйд нийгэм өөрчлөгдөнө. Дээрээс нь дүү нь ч гэсэн өөрийн гэсэн амьдралтай, гэр бүлтэй болно. Тэр үед ах нь гээд 1 хүнийг дандаа маллаад, чирээд аваад явах хэцүү. Жишээ нь би тийм ялыг ирээдүйн бэрдээ тулгахад хэцүү. Чи миний хүүтэй сууж байгаа бол заавал ахыг нь харж явах ёстой шүү гэж би хэлж чадахгүй. Тэгэхээр хүүгээ бие даагаад үлдэхэд нь, өөрөө үлдэх гэдэг нь бие даагаад тодорхой хэмжээний өдөр тутмынхаа амьдралаа аваад явчихдаг, магадгүй шаардлагатай гэрээ хэлцэл, том худалдан авалт хийх үед нь дүү, дүүгийнх нь эхнэр цуг яваад өгчихдөг байдлаар үлдээхийг хүсдэг. Тийм учраас одоо том хүүгээ хоол хийж сургах, гэрээ цэвэрлэж сургах байдлаар харж байгаа. Манай хүү зураг зурах дуртай. Одоо Анима дүрслэх урлаг, дизайны сургуулийн 3-р курсийн оюутан. Сонирхсон хүн фэйсбүүкээр аутизмтай зураач Хувьт гээд хайвал гарч ирж магадгүй. Би бол өөдрөгөөр, нэг ёсондоо дүүд нь ч дарамт болохгүй, ирээдүйн бэрдээ, гэр бүлд нь ч дарамт болохгүй байгаагаар төсөөлдөг. Хүү маань өөрөө биеэ даагаад болбол нийгэмд татвар төлөгч болоод, цаашилбал бүр гэр бүлтэй болбол болоосой л гэсэн мөрөөдөл байна.

Мөрөөдөл нь биелэх болтугай!

Одоо танай хүүхдийн талаар бас асууя. Дотоод сэтгэл нь ямархуу хүүхэд вэ?

Аутизмыг дотор нь сонгодог аутизм, өндөр чадвартай аутизм, аспергер гэж 3 ангилдаг. Сонгодог аутизм гэдэг нь хүнд тал луугаа ордог. Манай хүүгийн хувьд сонгодог аутизмдаа ордог юм. Гэхдээ хэл яриагаар зөвхөн хэрэгцээгээ илэрхийлдэг. Бие даах чадвар нь харьцангуй гайгүй. Мэдээж дотоод сэтгэлээ жишээ нь "ээж ээ би ийм юм бодож байна, би тэгж бодож байна" гэж илэрхийлж чадахгүй. Гэхдээ маш сайхан зөөлөн сэтгэлтэй, юмыг их удаан боддог юм шиг санагддаг. Ерөнхийдөө хүнтэй хандаж байгаа хандлага, харилцаанаас нь харахад үнэхээр тийм өр зөөлөн, их сайхан сэтгэлтэй л юм шиг санагддаг.

Та анх хүүгээ аутизмтай гэдгийг нь

сонсоход ямар санагдаж байсан бэ? Танай хүү хэдэн настай байсан бэ?

Манай хүү 2002 онд төрсөн. Тэгээд 2003 онд би Япон луу аспирантурт, мастерт сурахаар явсан юм. Явахдаа том хүү, нөхөртэйгөө бид гурвуулаа, гэр бүлээрээ явсан. Тэгээд тэнд 1 ой 6 сартай байхад нь Японы улсын цэцэрлэгт өгсөн. Сарын дараа цэцэрлэгийн эрхлэгч нь Хувьтын ээж ээ тантай ярих юм байна гэсэн. Юу вэ? гэсэн чинь манай Японд ийм тогтолцоо байдаг гэсэн. Тэд нар танай хүүхэд бусдаас өөр, сонин, гажиг байна гэж шууд хэлэхгүй. Ийм хүүхэд хөгжлийн төв байдаг, бид танд цаг аваад өгье. Та хүүхэдтэйгээ нэг очоод үз гэхээр нь би тухайн үедээ гадаадаас ирсэн хүүхэд хэл ойлгохгүй болохоор л тэгдэг юм байна гэж бодоод тэгье тэгье гээд очсон. Тэр хөгжлийн төв дээр 3 хоног очсон. Тэр хугацаанд мэргэжилтнүүд нь хүүхэдтэй маань тоглоод л, надаас зарим нь асуумж аваад л, юм ярилцаад л одоо бодоход тэр 3 хоногийн хугацаа бол оношилгоо, үнэлгээний хугацаа байсан юм билээ. Тэндээс танай хүүхэд аутизмын хүрээний эмгэгтэй байна гэж би анх сонссон. Тухайн үедээ сонсоод нэг их тоогоогүй. Яагаад гэвэл би өөрөө ч бараг аутизмаа сайн мэдэхгүй, бараг ярьдаг болчихвол асуудал шийдэгдэнэ гэж боддог байсан. Манай хүүхэд Хувьт гэдэг нэртэй, үнэхээр хувьтай хүүхэд гэж би боддог. Яагаад гэвэл 1 ой 6 сартайдаа оношлуулаад, 6 нас 6 сар хүртлээ Японд байсан хугацаандаа системтэй цогц үйлчилгээ, терапист, сургалт бүгдийг нь авчихсан. Суурь нь үнэхээр гайхалтай сайхан тавигдсан учраас миний анхны шок харьцангуй бага байсан.





Тэр чинь одоо 2003-4 оны асуудал шүү дээ, Монголд аутизмын талаар ойлголт, мэдээлэл огт байхгүй байсан. Магадгүй би нэг эмнэлэгт очоод үзүүлэхэд танай хүүхэд шизофренитэй эсвэл сэтгэцийн хүнд өвчин байна гэвэл эсрэгээр би яаж шоконд орох байсан бол? Тэгэхээр бас нэг бодлын гадаадад сонссон, дээрээс нь системтэй үйлчилгээ аваад ирсэн учраас би өөрийгөө азтайд тооцдог, хүүгээ ч бас азтайд тооцдог. Тэр хэмжээгээрээ миний хүүгийн хөгжил их аятайхан байсан гэж бодож байна. Магадгүй би Монголд мэдэхгүй байсан бол хавар, намарт нь тариа хийлгэж Шар хадны эмнэлэгт хэвтүүлээд эсрэгээр эмийн гаж нөлөө ч гарч магадгүй. Үүнийг ийм нээлттэй хэлэх эсэхээ сайн мэдэхгүй байгаа ч миний хувийн бодол учраас ямар ч болгочихсон байх юм билээ гэж боддог. Тэр үүднээсээ би Японд олж сонссондоо их баяртай байдаг. Харьцангуй бага цочирдсон, дээрээс нь үйлчилгээгээ сайн авсан учраас би одоо ингээд сэтгэл хангалуун ирээдүйгээ их гэгээлгээр харж байгаа.

Та дараа нь Монголд гэр бүлтэйгээ ирэхэд ямар санагдсан бэ?

Би 2007 онд сургуулиа төгсөөд, 2008 онд Монголд ирсэн. Тэр үед ерөнхийдөө аутизмын талаар ойлголт, мэдээлэл байхгүй байсан. Тэгээд нэг хэсэг тоогоогүй явсан л даа. Тэгж явж байгаад 2010-11 он хавьцаанаас ерөөсөө л болохгүй байна, эмнэлэгт үзүүлээд аутизм гээд ярихаар эмч нь мэдэхгүй, манай хүүхэд ийм гээд ярихаар хүмүүс ойлгохгүй юм, яах вэ? гэж их боддог байсан. Тэгээд 2011 оны үед сэтгэцийн эмч нар маань харьцангуй аутизмын талаар ойлголттой болоод ирчихсэн. Тэр үеэс одоо тэтгэвэртээ гарчихсан Шар хадны эмнэлгийн Энхтуяа эмч болон бусад эмч нар, бас аутизмтай хүүхдүүдийн эцэг эхчүүдтэй анх холбогдог, уулзаж байсан. Яагаад гэвэл би СЭМҮТ-д 2011 онд очоод Энхтуяа эмчтэй уулзахад, эмч надад "хөөх би аутизмтай 5 дахь хүүхдээ харж байна, ийм төрлийн аутизм байдаг юм аа?" гээд эмч хүртэл 5 хүүхэд үзэхэд тавуулаа өөрөө байдаг гээд гайхаж байсан. Тэр үүднээсээ ерөөсөө Монголд аутизмын талаар ойлголт байхгүй, хэн ч мэдэхгүй юм байна. Тийм учраас ямар нэгэн юм хийх ёстой юм байна гээд нөгөө 5 хүүхдийн ээж аавуудтай эмчээрээ дамжуулж холбогдоод бас танил талынхаа хүрээгээр холбогдох хүмүүстэй уулзаад, бид 2013 онд ярилцаж байгаад 2014 оны 1 сард холбоогоо байгуулж байсан юм.

Танд бага насны аутизмтай хүүхдүүдийн эцэг эхэд өгөх зөвлөгөө юу байна вэ?

Аутизмын шалтгаан одоогоор

тодорхойгүй. Юунаас болсныг нь хэн ч мэдэхгүй. Дэлхийн шинжлэх ухаан хайж л байна, судалж л байна. Тийм учраас аутизмтай боллоо гээд битгий бие бие биеийгээ буруутгаарай. Яагаад би ингэж хэлж байгаа вэ гэвэл нэг хэсэг аутизм тэрнээс болсон, энэнээс болсон гэж их худлаа цуурдаг байсан. Тэр байтугай манай дээр нэг ээж зөвлөгөө авах гэж ирж байсан. Тэр ээжид нэг эмч "чи яасан их эход харуулсан юм. Хүүхдийг эход их харуулахаар аутизмтай болдог юм шүү дээ" гэж хэлсэн байгаа юм. Тэгээд гараад ирэхээр нөхөр нь чамаас боллоо чи л эход харуулж явсаар байгаад л ингэлээ гээд буруутгаад, муудалцаад эхэлнэ. Тэгэхээр үүнийг хэн нэгэн хүн хэлсэн бол хамаа байхгүй. Гэтэл эмч хэлэхээр яг тийм юм шиг бодож, бие биенээ буруутгах асуудал гардаг. Өөр нэг аутизмтай хүүхэдтэй эмээ ирж байсан жишээг зориуд хэлмээр байна. Тэр эмээ "би ганц хүүтэй, манай удамд ийм хүн байхгүй. Манай бэрийн талд харин нэг оюуны бэрхшээлтэй хүүхэд байдаг. Тэгэхээр манай бэрийн талаас байж магадгүй, би эрүүл саруул удамтай баймаар байна. Тийм учраас та манай бэрд зөвлөгөө өгөөд танай талд байна, ээжээс нь үүдэлтэй гээд хэлээд өгөөч" гээд ирж байсан.

Тэгэхээр нэгдүгээрт дэлхийн шинжлэх ухаан аутизмыг юунаас үүсэлтэй вэ, юунаас болж вэ гэдгийг нь тогтоогоогүй байхад Монголчууд бид нобелийн шагнал авах гэж байгаа юм шиг таамаг дэвшүүлээд хэрэггүй гэж байгаа юм. Хоёрдугаарт бие биенээ буруутгах ямар ч шаардлага байхгүй. Дээрээс нь би хүмүүст ичих, харамсах зүйл хэзээ ч байх ёсгүй гэж хэлдэг. Аутизмтай хүүхэдтэй болчхоод юунаас болов, би яагаад ийм болов, би архи уудаггүй, тамхи татдаггүй, эв эрүүл, сав саруул шүү дээ гээд энэ асуудлаа засаж чадахгүйгээс хойш харамсаад байх хэрэггүй. Хоёр дахь нь ичих асуудал байхгүй. Юунаасаа ичих юм, Яагаад ичих ёстой юм? Эсрэгээр энэ хүүхдийг чи өсгөж чадна гээд бурхан явуулж байна. Би тэгвэл энэ хүүхдийг ёстой яаж өсгөхийг хараарай гэж хүн амьдрах ёстой. Тэгж л амьдраасай л гэж хүсэж байна.

Аутизмтай мундаг хүмүүс зөндөө байдаг, тийм ээ?

Ер нь бол тийм. Үэг хэсэг аутизм бол суутнуудын өвчин гэж нэрлэдэг байсан. Яагаад гэвэл 1700, 1800 онд амьдарч байсан Эйнштэйн, Бетховен, Микеланжело зэрэг алдартнуудыг аутизмтай байсан байж магадгүй гээд түүхэн эх сурвалжууд бичээд байдаг юм байна. Тухайн үед аутизмын тухай ойлголт байхгүй байсан. Дэлхийн дээр аутизмын тухай ойлголт анх 1934 онд л гарч ирсэн. Тэрнээс өмнө ойлголт байхгүй байсан учраас хүмүүс мэддэггүй байсан. Тэгээд гучин хэдэн оноос хойш мэддэг болоод байгаа юм. Тэгэхээр дэлхий дээр ийм алдартай, суутай, мундаг хүмүүс зөндөө байгаа. Гэхдээ бүх аутизмтай хүмүүс гоц авьяастан, суутан гэж бодож болохгүй. Гол нь хүүхдээ зөв чиглүүлээд явах хэрэгтэй.

Эрт оношлуул, эрт илрүүл. Хэрвээ асуудал байвал асуудалтайгаа нүүр тулгар. Чадах

юмаа л хийнэ, би юу хийж чадах вэ гэдгээ л хийнэ. Тэгж л чадвал хэр эрт эхэлнэ, тэр хэмжээгээр үр дүн нь сайн гарна. Хувь заяанаасаа зугтааж яах юм бэ?

Таны хэлсэн "хүн болгон өөр байдаг гэдэг шиг".

Тэгэхээр юм болгон өөр учраас бүгдээрээ пандатай адилхан болох гээд яахав, бүгдээрээ хүрэн баавгай болох гээд яахав. Хүн болгон өөр өөрийн ялгаатай онцлогтой. Тэр хүн ч тэр, бид нар бүгдээрээ өөр шүү гэдгийг л хүлээн зөвшөөрчихвөл амар болно.

Манай подкастын маань цаг өндөрлөх дөхөж байна. Ковид цар тахал аутизмтай хүүхэд, залуучууд, тэдгээрийн гэр бүлд хэрхэн нөлөөлж байгаа вэ?

Ер нь бол аутизмтай гэлтгүй бүх хүмүүст л нөлөөлж байна. Би хувийн зүгээс ярихад манай хүү Анима дүрслэх урлаг, дизайны сургуульд явдаг. Цар тахлаас болоод сургууль нь амарчихлаа. Тэгэхээр хүүхэд чинь тэр урлагийн сургуульд очоод гоё хөгжим сонсоод, зургаа зураад таашаал авдаг байсан бол одоо гэртээ байнга хоригдож байна. Бараг гэрээсээ гарахгүй болчхож байна. Цонх онгойлгож хошуугаа жоохон гаргаж л бараг салхи амьсгалж байна. Тэгэхээр энэ бол зөвхөн нэг айлын жишээ. Гэтэл маш олон айлд яг энэ асуудлууд үүсэж байгаа. Ковид нэг талаасаа эрүүл мэндийн хувьд маш их том сорил болж байна нөгөө талаасаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хөгжлийн ахицад маш их дарамт болж байгаа. Яагаад гэвэл хүүхдүүд сурсан юмаа байнга бататгаж байх ёстой байтал ингээд зогсчихлоор эсрэгээр ухралт явагдаж байж магадгүй юм. Энэ талаасаа үзвэл эрүүл мэндийн талаасаа ч тэр, нийгэмшихүйн талаасаа ч тэр тухайн хүүхдийн хөгжлийнхөө хувьд бол жоохон ухралттай л цаг үе болчихлоо.

Цаг гарган подкастанд маань орж аутизмын хүрээний эмгэгийн талаар гоё яриаг өгч, ойлголтыг бидэнд дэлгэрүүлсэн танд баярлалаа. Таны цаашдын ажил үйлс, амьдралд аз жаргал, сайн сайхныг хүсье! Хүүд нь бас амжилт хүсье! Их мундаг анимэ зурдаг зураач болох байх гэж бодож байна.

За баярлалаа. Олон залуус сонсдог энэ сайхан нэвтрүүлэгтээ биднийг урьж оролцуулсанд баярлалаа. Миний хувийн болон холбооны хийж байгаа үйл ажиллагаа, үзэл бодол залуусын маань сэтгэл зүрхэнд хүрээсэй, ойлголт хандлагыг нь өөрчлөөсэй гэж найдаж байна. Тэгээд маш их баярлалаа. Бас залуустаа маш их амжилтыг хүсье! Танай хамт олонд бас ажлын амжилт хүсье ээ! За баярлалаа.

НИЙСЛЭЛ ХОТЫН МААНЬ ГУДАМЖ ХҮҮХДЭД АЮУЛГҮЙ, ЭЭЛТЭЙ БАЙГААСАЙ ГЭЖ ХҮСДЭГ

Б.Чулуундолгор



Сайн байцгаана уу, эрхэм хүндэт сонсогчид оо, Антолд подкастын маань ээлжит дугаар эхлэхэд бэлэн болоод байна. Энэхүү дугаарт Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооны тэргүүн Чулуундолгор оролцож байна. Та урилгыг минь хүлээн авсанд баярлалаа. Сонсогчдодоо өөрийгөө дэлгэрүүлээд танилцуулахгүй юу?

Сайн байцгаана уу, сонсогчид оо? Намайг Чулуундолгор гэдэг. Би Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоонд ажилладаг. Эдийн засагч мэргэжилтэй. Төрийн бус байгууллагад хүний эрхийн чиглэлээр 10 гаруй жил дагнан ажиллаж байна. Нөхөр, хүүгийн хамт амьдардаг.

Та холбооныхоо талаар дэлгэрүүлээд танилцуулахгүй юу?

Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо 2005 онд байгуулагдсан. Одоогоор орон нутгийн 7 аймагт салбар зөвлөлтэй. Архангай, Баянхонгор, Хэнтий, Дархан-Уул, Өвөрхангай гэсэн энэ аймгуудад нэлээн идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг. Энэ жилээс бид Сэлэнгэ, Увс аймгуудад салбар зөвлөлөө байгуулаад явж байна. Холбоо маань “тэгш оролцоот, хүртээмжтэй нийгэм” гэсэн эрхэм зорилготой, үндсэн дөрвөн чиглэлд үйл ажиллагаа явуулдаг. Нэгдүгээрт, хөгжлийн

бэрхшээлтэй иргэдийн эрхийг таниулах, хөгжлийн бэрхшээлийн талаар эерэг хандлага түгээх чиглэлээр нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Хоёрдугаарт, орчны хүртээмжийг сайжруулах. Барилга, явган хүн зам талбай, нийтийн эзэмшлийн зам талбайн хүртээмжийн асуудлаар дагнаж ажилладаг. Гуравдугаарт, бид нар гишүүдийг идэвхжүүлэх, чадавхжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Манайх 700 гаруй гишүүнтэй. Жилдээ гишүүддээ чиглэсэн 5-6 арга хэмжээ тогтмол хэрэгжүүлдэг. Бусад үед бол гишүүдийг эмнэлэгт зуучлахад түлхүү анхаарч ажилладаг. Дөрөвдүгээрт, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрх, тэр дундаа бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрхийн чиглэлээр сүүлийн 5 жил түлхүү ажиллаж байна. Холбооны ажиллах хүч гэвэл бид нар яг 10 хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг. Нийгмийн ажилтан, үйл ажиллагаа хариуцах менежер, санхүү, хүний нөөцийн менежер, мэдээллийн ажилтан, холбооны дэргэдэх хаягдал цаасаар гар урлалын бүтээгдэхүүн хийдэг “Эко Гифт” (Eco Gift) хоршооны ажилтан, тэргэнцэр засварын төвийн ажилтан. Иймэрхүү бүтэцтэйгээр холбоо маань үйл ажиллагаагаа явуулаад одоо 16 дахь жилдээ орж байна.

Та анх байгуулсан үүсгэн байгуулагчдынхнь нэг байсан гэсэн?

Анх 2005 онд тэргэнцэртэй иргэдийн холбоо байгуулагдаж байх үед тэргэнцэртэй хүмүүс гудамж талбайд харагддаггүй, бид нарыг гадуур явахад хүмүүс их гайхаж хардаг байсан. Тухайн үед тэргэнцэртэй хүмүүс олуулаа цугларах өрөө тасалгаа олдохгүй учраас бид нар ихэвчлэн Хүүхдийн парк эсвэл Маршалын гүүрний тэнд цуглардаг байсан. Бид нар драмын театрын өмнө гадаа цугларааД, анхныхаа хурлыг хийгээд, дүрмээ ярилцаад, батлаад Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоог байгуулж байлаа. Тэр үеийг бодвол одоо холбоо маань зөндөө бэхжиж, олон ч гишүүдтэй болсон. Бид нар үйл ажиллагаа явуулах ямар ч байргүй зөвхөн тамга, гэрчилгээтэйгээр л үйл ажиллагаа эхэлж байсан. Төрийн бус байгууллагын ажил чинь цалинтай, цаг нартай ажил биш дандаа сайн дураараа хийдэг ажил. Энэ сайн дурын ажиллагааг цаг цагийн тэргэнцэртэй хүмүүс хичээл зүтгэл гаргаж ажиллаж байсны хүчинд одоо байгууллага маань үндэсний хэмжээний, тогтвортой, нийгэмд нөлөөлдөг хүчтэй төрийн бус байгууллагуудын нэг болоод явж байхад баяртай байдаг.

Танд тухайн үед яагаад би энэ газар ажиллах, хөгжүүлэх ёстой юм байна гэсэн бодол төрсөн бэ?

Энэ их түүхтэй. Би Өвөрхангай аймагт хөдөө суманд байхдаа гэмтэл авсан. Дэлхий дээр би ганцаараа л хамгийн хүнд хэцүү юмыг үүрээд явж байна гэсэн бодолтой, эмзэг хүүхэд байсан. Дараа нь хотод ирсэн. Тэр үед Тахилт гээд дандаа нуруу нугасны гэмтэлтэй, тэргэнцэртэй хүмүүсийг авч сувилдаг Сэргээн засах үйлчилгээний төв байдаг байсан. Би тэнд нэг удаа сувилуулахдаа маш олон

тэргэнцэртэй хүмүүсийг харсан. Тэр сувиллын захирал Энхтуяа гээд байнга инээдэг эгч байсан. Бас Цогцэцэг гээд Монгол Улсын Гавьяат Жүжигчин, циркийн жүжигчин эгч бас байсан. Би гэмтсэнийхээ дараа ерөөсөө инээдэггүй, нэг л гунигтай хүн байсан. Тэгээд тэр хоёр эгчийг гайхаж хараад тэргэнцэртэй байж ийм гоё байж, инээж болдог юм уу гэж анх удаа бодсон. Тэндээс их урам авсан л даа. Амьдрахад заавал явдаг байх, тэргэнцэртэй байх ялгаа байхгүй юм байна. Өөрийгөө л хөгжүүлэх нь чухал юм байна гэдэг сэдлүүдийг авсан. Дараа нь хотод суурьшаад, удалгүй Бизнесийн дээд сургуульд орж эдийн засагч мэргэжлээр суралцсан. Сургуульд сурч байхдаа би нэг банканд л ажилд орно. Сууж байгаад хийхэд надад яг тохирох ажил гэж боддог байсан. Сургуулиа төгсөөд банканд орох гэсэн чинь ажилдаа ирж очих таксины зардал нь миний авах цалинтай яг тэнцүү байсан. Тэр нь чухал биш байлаа гэж бодоход ажлын орчинд надад ариун цэврийн болон бусад уулзалтын өрөө ашиглахад дандаа саадтай байсан. Би хэд хэдэн банк дээр очоод "чамайг авах боломжгүй байна" гэсэн хариу сонссон. Дараа нь би хөдөлмөрийн биржид хандахад, "тэргэнцэртэй хүнийг авах ажлын байр одоогоор байхгүй байна" гэсэн хариу өгсөн. Тэр үеэс би нийгэм шударга бус, тэгш бус байдаг юм байна. Над шиг хүнд ижил тэгш хандлага байхгүй юм байна гэдгийг бага багаар ойлгож эхэлсэн. Тэгээд төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаанд илүү их идэвхтэй оролцож эхэлсэн. Анх 2005 онд Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооны хүмүүстэй нэгдэн янз янзын үйл ажиллагаанд нь оролцоод явдаг байсан. Тэгээд 2007 онд сонгууль болж тэргэнцэртэй иргэдийн холбооны тэргүүн гэсэн үүрэгт ажлыг хүлээж аваад одоо хүртэл ажиллаж байна. Тэгэхээр өөрт тулгарсан асуудал, бэрхшээлээс үүдэн энэ чиглэлээр хүний эрхийн байгууллагад ажиллах шаардлага тулгарсан. Манай ангийн оюутнууд бүгд төгсөөд ажилд орсон байхад би л ажилд орж чадахгүй байсан. Үүнийг анзаараад, энэ байдлыг сайжруулахын төлөө явах ёстой юм байна гэж бодсон. Тухайн үедээ тэгш бус байна гэдгийг маш сайн ойлгож байсан. Тэр үед идэвхтэй ажиллаж байсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаанд хамрагдаад илүү их ойлголттой болсон. Тэгээд өөрийнхөө асуудлыг өөрөө л гаргаж ирэхгүй бол хэн ч миний асуудалд хөндлөнгөөс оролцоод, миний асуудлыг шийдэхгүй юм байна гэдгийг маш сайн ойлгосон.

Та одоо болон 2005 оныг харьцуулахад одоогийн байдал танд хэр санагддаг вэ?

Би 2005 онд хөдөөнөөс орж ирээд үсчинд үсээ засуулах гэсэн юм. Тэгсэн хоёр үсчин нь бие биенээ харж гайхаад, нудраад, "үсээ засуулъя гэнэ" гэж байсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хүн гэж харахгүй, тэргэнцэртэй хүн бараг үзээгүй, "ийм хүмүүс үсээ засах шаардлага байдаг юм уу" гэсэн маш хүнд хандлагатай байсан. Одоо бол гадуур явж байхад, энд тэнд хурал зөвлөгөөнд орж байхад ялгаварлах

хандлага огт байхгүй болчихсон. Барилга байгууламжийн орчин хангалттай сайн болж байна. Ялангуяа 2017 оноос хойших барилга байгууламжууд бүгд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн орц гарцыг шийдсэнээр хийгдэж, төлөвлөгддөг болсон. Зам талбай, нийтийн тээврийн хувьд бол ганц нэг замын налуулалт хийсэн ч гэсэн 2005 онтой бараг л ижилхэн байна. Тэгэхдээ би 2005 онд автобусаар явж чаддаггүй, такси л байнга барьдаг байсан. Одоо ч гэсэн энэ асуудал хэвээрээ л байна. Дүгнээд хэлэхэд олон нийтийн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлах, тусад нь авч үзэх хандлага арилсан. Харин барилгаас бусад дэд бүтцийн орчин төдийлөн сайжирсангүй. Хууль эрх зүйн орчин бол харьцангуй сайжирсан. Тэр үеийг бодвол Монгол Улс Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцод нэгдсэн, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай хуультай болсон. Хуулийг хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөр нь батлагдаад хэрэгжсэн амжилтууд бас байна. Төрийн бус байгууллагаараа төсөөлөхөд ч гэсэн одоо бид илүү хүчтэй, олуулаа, нийгэмд нөлөөлөх чадвартай болсон гээд бодвол хөгжил бас байна гэж боддог. Гэхдээ удаан байна.

Сая та холбооныхоо талаар ярьж байхдаа дөрвөн чиглэлд үйл ажиллагаа явуулдаг гэж ярьсан. Би эмэгтэйчүүдийн эрхийн талаар илүү дэлгэрүүлж асуух гэсэн юм. Саяхан хөгжлийн бэрхшээлтэй охид хөвгүүд үе тэнгийнхэнтэйгээ харьцуулахад бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэл гурав дахин өндөр байдаг тухай судалгааны материал уншсан юм. Та энэ талаар жаахан дэлгэрүүлээд ярьж өгвөл?

Бид 2012 онд Монголын Эмэгтэйчүүдийн сан дээр хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг чадавхжуулах нэг жижиг төсөл хэрэгжүүлсэн. Бид дэмжих бүлэг байгуулаад, peer consuling буюу дотооддоо бүлгийн ярилцлага хийсэн юм. Эмэгтэйчүүд тойрч суугаад, энэ доторх яриа энд л үйлдэнэ гээд өөрт тулгамдаж байгаа асуудлуудаа ярилцсан. Бас нэг эмэгтэйчүүдийн эмч авч ирээд нөхөн үржихүйн эрүүл мэндийн сургалтыг эмэгтэйчүүддээ явуулсан. Тэгсэн чинь эмэгтэйчүүд маань бид нарт жирэмслэлтээс хамгаалах арга хэрэгслийн талаар мэдээлэл хэрэггүй эсрэгээрээ яаж жирэмслэх вэ? гэдэг мэдээлэл хэрэгтэй байна гэсэн. Яагаад гэвэл бид нар бусад хүмүүс шиг гараад өөрийнхөөрөө байя гэхээр дандаа орчны саадтай тулгардаг учраас өөрсдийнхөөрөө байж чадахгүй байна. Найз залуутай болох боломж бараг гарахгүй. Гараад л явах гэхээр аавыгаа, ахыгаа дагуулж явахаас өөр арга байхгүй. Нэгдүгээрт, тэр хүмүүсийн дэргэд би хүнтэй уулзах, танилцах боломж гарахгүй байна. Хоёрдугаарт, эмнэлэгт үзүүлье гэхээр эмнэлгийнхэн намайг гайхаж хүлээж авч байна. Эмнэлгийн үзлэгийн орон дээр гарч чадахгүй байна гэсэн олон асуудал ярьсан. Тэндээс хөгжлийн бэрхшээлтэй байдлаасаа болоод эмэгтэйчүүдийн эрх, ялангуяа бэлгийн болон нөхөн үржихүйн эрх нь маш их зөрчигддөг юм байна гэдэг

ойлголтыг аваад энэ чиглэлээр тасралтгүй ажиллаж эхэлсэн. Энэ хооронд бид хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүлийн хүчирхийллийн чиглэлээр хоёр ч судалгаа хийлээ.

Монголын нийгмийн хамгааллын систем хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг гэр бүлд нь даатгадаг. Өөрөөр хэлбэл хэрвээ би хөгжлийн бэрхшээлтэй бол эмчилгээ, үйлчилгээ, төлбөр, гэрээс гарах, сэтгэл зүйн асуудал, стресс бухимдал гээд миний бүх асуудлыг миний гэр бүлийнхэн хариуцдаг. Гэтэл олон улсад бие даан амьдрах систем үйлчилдэг. Нийгмийн халамж, хамгааллын систем нь маш сайн хөгжсөн учраас энэ хүний сэтгэл зүй, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлтийн төвшин ямар байна гэж над дээр үнэлгээ хийгээд тэр болгонд нь чиглэсэн нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээнүүд ирдэг. Гэр бүлд нь даатгаж орхих нь хоёр том сөрөг үр дагаврыг бий болгож байна. Нэгдүгээрт, хөгжлийн бэрхшээлтэй хүн гэр бүлийнхнээсээ 100% хамааралтай болчихдог. Хоёрдугаарт, гэр бүлийнхэн хэт их хайрлах, хамгаалах сэтгэхүйгээр харж ханддаг учраас хөгжлийн бэрхшээлтэй хүн идэвхгүй, өөрийнхөө асуудлыг бусдад даатгасан иргэн болж хувирдаг юм байна. Нөгөө талд гэр бүлийнхэн нь маш их стресстэй. Насан туршдаа ажил хийхгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ хараад



амьдарч байгаа эцэг эхчүүд зөндөө байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэр бүлийнхнээсээ 100% хараат байгаа нөхцөлд гэр бүлийн хүчирхийлэлд өртөх магадлал маш өндөр байдаг. Бидний судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй охид, хөвгүүдийн хэзээ, хэнтэй гэр бүл болох, хэзээ хүүхэд гаргах асуудлыг ихэнх тохиолдолд гэр бүлийнхэн нь шийддэг байдал анзаарагдсан. Жирэмслэх үед эцэг эх нь эрс дургүйцдэг эсвэл дөнгөж насанд хүрээд ирэхээр нь "чи эртхэн хэнээс ч хамаагүй хүүхэдтэй бол бид нарыг өсгөөд өгье, бид нарын дараа чамд хэрэгтэй" гэсэн хүчээр тулгалт үүсгэдэг хандлагууд их байдаг. Тэгэхээр гэр бүлтэй болох асуудал чинь хувь хүний өөрийнх нь эрхийн асуудал. Өөрөө шийдвэр гаргах ёстой байтал дандаа хөндлөнгөөс оролцдог нь манай судалгаагаар гарч ирсэн. Энэ юунаас үүдэлтэй вэ гэвэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэр бүлийнхнээсээ 100% хараат байгаагаас үүдэлтэй юм байна гэдгийг бид нар гаргаж ирсэн. Мөн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрхийн асуудал дээр эмч, эмнэлгийн ажилтнууд, нийгмийн ажилтнуудын харилцаа, хандлага бас их нөлөөтэй байна.

Нийгэмд хөгжлийн бэрхшээл удамшина гэдэг ойлголт маш бөх бат яваад байна. Анагаахын шинжлэх ухаанаар бол ихэнхдээ удамшдаггүй, удамшдаг тодорхой цөөн тооны өвчнүүд л байдаг гэж хэлдэг ч гэсэн яагаад ч юм тэр хүмүүсийн дотор удамшина гэдэг хандлага их байдаг. Тэгээд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг жирэмслэх тохиолдолд ялангуяа хөдөө орон нутагт эх болон урагт эрүүл мэндийн хүндрэл үүснэ эсвэл удамшина гэж үздэг учраас хамгийн түрүүнд үр хөндүүлэх, жирэмснийг таслан зогсоох зөвлөгөө өгдөг. Зарим үед бүр шаарддаг. Хөдөө орон нутагт компанит ажил болгож хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд 3 сар тутамд жирэмснээс хамгаалах тариа хийдэг тохиолдол гарсан. Хэрвээ жирэмслэлтээс хамгаалах тариагаа хийлгээгүй тохиолдолд нийгмийн хамгаалал, халамжийн ажилтан нь группийг нь сунгахгүй гэж дарамталдаг кэйс маш олон гарсан. Тэгэхээр энэ бол хүний эрхийн маш том зөрчил юм гэдгийг бид нар 2018 онд Хүний эрхийн үндэсний комисстой хийсэн судалгаагаар гаргаж ирсэн байгаа. Энэ нь хөгжлийн бэрхшээл удамшдаг, хөгжлийн бэрхшээлтэй хүн ээж болох, эхнэр болох чадваргүй гэсэн хандлагаас үүдэлтэй байдаг.

Би тэргэнцэртэй болсныхоо дараа хүүтэй болсон. Тэгээд яг жирэмсэн болоод, жирэмсний хяналтад орох, төрөх үйл явц бол надад бүр аймаар хүнд байсан. Яагаад гэвэл жирэмсний хяналтад ороход маш 3 давхарт гарч био хими өг, 2 давхарт гарч цээжний зураг авахуул гээд маш олон шинжилгээ бүрдүүлж өгдөг. Эмнэлгийн орчин лифтгүй учраас жирэмсэн хүн байнга хүнээр өргүүлж явах хэцүү. Тэр хүн алдчих юм бол эрсдэлтэй шүү дээ. Тэгээд дарааллыг нь хүлээнэ, хүлээж байх хооронд бие засмаар болно. Гэтэл ариун цэврийн өрөөнд тэргэнцэр орох боломжгүй гээд маш олон асуудалтай тулгарч байсан. Жирэмсний үед хяналтад байхдаа "би байнга суугаа байх учраас надад бусдаас

өөр зөвлөгөө хэрэгтэй байна, та надад зөвлөөч" гээд эмчид хандахад "над дээр тэргэнцэртэй хүн олон үзүүлж байгаагүй учраас би ямар зөвлөгөө өгөхөө мэдэхгүй байна" гэж эмч хэлдэг. Тэгээд жингээ үзүүлье гэхэд эмнэлгүүдэд байдаг бүх жин зогсож үзүүлдэг гэтэл би зогсож чадахгүй. Уг нь суугаа жин хэмжигч байдаг ч тэр нь манай эмнэлгүүдэд байхгүй учраас би хүүхдийнхээ өсөлтийг хянаж чадахгүй байдалтайгаар төрж байсан. Гэхдээ сайн эмч зөвлөж, дэргэд минь байсан болохоор азаар эрүүл саруул, ямар ч хүндрэлгүй л төрсөн. Миний хувьд Улаанбаатар хотод амьдардаг, харьцангуй өөрийнхөө үзэл бодлыг сайн илэрхийлээд, шаардаад явдаг хүний хувьд л ийм асуудал тулгарч байхад хөдөө суманд, багт байгаа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй төрнө гэдэг бол маш хүнд юм байна гэж харсан. Асуудал байгааг олж харсан учраас судалгаа хийсэн. Судалгаагаар миний бодож байснаас ч илүү олон асуудал ажиглагдсан. Бас 2018 онд хэдэн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй бэлгийн замын халдварт өвчнөөр өвдөөд, ямар үйлчилгээ авсан бэ гэдэг тоо улсын хэмжээнд гардаггүй байсан. Ийм мэдээлэл, судалгааг байхгүй байгаа нь энэ чиглэлд зориулсан бодлого, үйл ажиллагаа хийгдэлгүй орхигдсон сэдэв юм гэдгийг бид нар судалгаагаараа гаргаж ирсэн. Гэхдээ Хүний эрхийн комисстой хамтарч хийсэн учраас энэ судалгаа 2018 оны Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын арван наймдугаар илтгэлд манай судалгаа тусгагдсан. Мөн түүнчлэн судалгаа маань Улсын Их Хурал дээр бас танилцуулагдаад, Улсын Их Хурлаас Засгийн газарт дөрвөн чиглэлд үүрэг өгсөн. Энэ бол маш том амжилт гэж бид хардаг. Одоо үеийг миний хүүхэд төрүүлж байсан 2013 онтой харьцуулах юм бол эмнэлгийн нөхцөл байдал шал өөр болсон. Бид өнгөрсөн онд ковид цар тахлаас өмнө холбооныхоо эмэгтэйчүүдийг нөхөн үржихүйн эрүүл мэндийн үзлэгт хамруулаад Улаанбаатар хотод байгаа гурван төрөх эмнэлэгт үзүүлэхэд бүгд өндрийн тохируулгатай үзлэгийн ортой болсон байсан. Орц, гарц хаалга бүр нь тэргэнцэртэй хүн ороход хүртээмжтэй, эмнэлгийн ажилтнуудын харилцаа, хандлага ч гэсэн шал өөр болсон байсан. Тэгэхээр нөхцөл байдал их сайжирч байгаа юм байна гэж бид харж байгаа.

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд өөрсдөө шийдвэр гаргаж чадахгүй байна гэж та сая ярилаа. Үүнд нэгд гэр бүл ч нөлөөлж байна, хоёрт өөрөө ч идэвхгүй болчихсон байна. Тэгэхээр өөрсдөө шийдвэр гаргаж чадахгүй байхад гэр бүл төлөвлөлт гэдэг асуудал яаж шийдэгддэг вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх хоёр төрлийн хандлага үзүүлдэг юм байна. Маш их өрөвдөөд хайрлаад, өөрийнх нь хүслээр байлгадаг. Бараг хоолыг нь аманд нь халбагадаж өгч, өмсөх хувцас, бүх юмыг нь бэлдэж өгөөд юугаар ч дутаахгүй байлгадаг. Гэтэл ийм эцэг эх өөрийгөө би хүүхдээ маш сайн анхаарч, юугаар ч дутаахгүй байлгаж байна гэж бодож байгаа боловч тэнд нэг асуудлыг орхигдуулдаг нь өөрөө сонголттой байх, өөрөө шийдвэр

гаргах эрхийг нь хаачихдаг. Багаас нь эхлээд хүүхэд өөрөө шийдвэр гаргах, ямар нэгэн юманд оролцох чадамжгүй иргэн болоод өсчихдөг. Энэ бол маш том алдаа. Би 16 настай байхдаа гэмтсэн. Намайг гэмтсэн байхад ээж аав маань хөл чинь даарахгүй гээд надад буриад гутал өмсгөдөг байсан. Гэтэл миний үеийн хүүхдүүд их гоё гутал, гоё жинсэн өмд өмсөөд л байдаг би өмсмөөр байсан ч гэсэн чи хөл гар муутай учраас чамд нэмэргүй гээд буриад гутал өмсгөөд суулгачихдаг. Би тэрнээсээ их ичдэг байсан. Эцэг эхчүүд анхаарах нэг зүйл бол хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хайрлана, хамгаална гэдэг чинь зүгээр өрөвдөөд хайрлах биш, ерөөсөө л сонголтыг нь өөрт нь өгөх асуудал. Хувцас авах гэхэд зүгээр дулаан хувцас миний хүүхдэд тохирно гээд авч ирэхээсээ илүү, дагуулж яваад чи юу өмсмөөр байна? улаан өнгийг өмсмөөр байна уу, шарыг өмсмөөр байна уу. Ямар гутал өмсмөөр байна гээд өөрөөр нь сонгуулаад авах нь их чухал. Энэ өрөвдөх хайрлах хандлага эцэг эхчүүдийн дунд төдийгүй нийгмийн дунд ч гэсэн их байдаг. Нөгөө нэг хандлага нь найз нөхдөөсөө хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэдгээ нуугаад, ялгаварлан гадуурхдаг. Тэр хүүхдүүдийг тусдаа өрөөнд оруулж цоожлоод хоол оруулж өгөөд амьд ургамал төдий байлгаад байдаг хандлага бас байдаг. Тэгэхээр энэ хоёрын дундах хандлага л бид нарт хэрэгтэй байгаа юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хэт их өрөвдөж хайрлахгүйгээр өрсөлдөгч, хамтран зүтгэгч гэж харж хандах нь хамаагүй илүү байдаг. Миний хувьд хөгжлийн бэрхшээлийн чиглэлээр төрийн бус байгууллагууд дотроо бол намайг тэгж ялгаварлаж харьцах хандлага байдаггүй. Эсрэгээрээ танай судалгаагаар ингэж гарсан байна, танайх бараг энэ чиглэлээр дутуу ажиллаж байна гэдэг шүүмжлэлүүдийг аваад илүү их ажиллах ёстой юм байна гэсэн шаардлагууд дотор л ажилладаг.

Гэтэл өөрийнхөө төрж өссөн хөдөө суманд ах дүү нар дээрээ очих эсвэл 10 жилийн найзуудтайгаа уулзахад намайг хэтэрхий их өрөвдөөд л, хайрлаад л ядарч байна уу, даарч байна уу гээд халамжлаад эхэлдэг. Ингээд эхлэхээр би өөрөө чөлөөтэй байж чадахгүй. Би өөр хүн шүү дээ гээд л өөрийнхөө чөлөөтэй байдлаа хумьчихдаг. Тэгэхээр бусад хүмүүстэй харьцдаг шиг энгийн харьцаа бол их чухал. Дүгнээд хэлэхэд өөрөө шийдвэр гаргах эрх, өөрийн сонголттой байх эрх бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хамгийн чухал байдаг юм. Миний хүүхдэд шөлтэй хоол сайн гээд хийгээд өгөхөөсөө илүү миний хүү өнөөдөр ямар хоол идэх вэ гээд асуугаад тэр хоолыг нь хийж өгөх. Хэрвээ хүүхдийн чинь хөл, гар нь хөдөлдөг бол чи тэгвэл төмсөө арилга, ээж нь махыг нь хэрчье гэж аль болох өөрийг нь дандаа оролцуулаад хийх хэрэгтэй. Өөрт нь тохирсон үүрэг хариуцлагыг дандаа өгдөг байх нь маш чухал санагддаг. Нийгмийн хандлага харьцангуй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эерэг болсон ч гэсэн эсрэгээрээ зарим хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хэтэрхий унжгар, сул дорой, халамж шаардсан байдалтай байна гэж заримдаа хардаг.

Бид нар чинь олон гишүүдээсээ ажилд

зуучилдаг. Ажилд зуучлахад юу гэж хэлдэг вэ гэвэл "манай ажил 8.00 цагт эхэлдэг учраас би өглөө болгон 6.00 цагт босоод байсан чинь ядраад ажлаасаа гарчихсан" гэж хэлж байгаа. Тэгэхээр харамсалтай байгаа байхгүй юу. Яагаад гэвэл бүх л хүн ямар нэгэн ажил хийхийн тулд өөрийнхөө эрүүл мэндийн, тав тухын эрсдэл гаргаад 6.00 цагт босоод 8.00 цагт ажилдаа ирж байгаа. Тэгэхээр өөрийгөө дайчлаад бусдын адил байя гэж байгаа бол эрсдэлийг даван туулаад, дасан зохицоод явах л ёстой. Тэгээд л ажилд оронгуутаа бас нэг хүн "би ажилдаа орсон ч манай ажлын газрынхан намайг хараад хоорондоо шивнэлдээд байсан, тэр нь надад эвгүй байсан учир ажлаасаа гарчихсан" гээд ярьж байсан. Тэгэхээр энэ бас тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүний өөрийнх нь хандлага байсан байж магадгүй гэж харагдаж байна. Тэд нарын хувьд магадгүй өөрийг нь ярьсан ч байж болно, яриагүй ч байж болно. Тэгэхээр нийгэмшээгүй, өөрийгөө хамгийн чухал нэгдүгээр хүн гэж үзээд, бусдыг намайг яах нь вэ гэсэн байдлаар хардаг нь өөрт нь саад болдог юм байна гэсэн бодол төрсөн. Тэгэхээр яг 2005 оныхтой харьцуулахад 2021 онд нийгмийн хандлага шал өөр болчихсон байгаа үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс би хөгжлийн бэрхшээлтэй, явж чадахгүй, харж чадахгүй, сонсож чадахгүй гэж суухаасаа илүү би юуг хийж чадах вэ гэдэг дээрээ л төвлөрөх нь их чухал. Тэгэх юм бол мэдээж орчны бага зэрэг саад байгаа ч гэсэн хүлээгээд авах нийгмийн хандлага маш сайн болчихсон. Гэхдээ энэ бол цаг хугацааны явцад сайжрах байх гэж бас үе үе боддог. Тэгэхдээ бас 100% хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн буруу ч бас биш л дээ. Яг ингэж хандаж байгаа нийгмийн хандлага бас л байж л байгаа байх. Миний ажлын орчин илүү хүлээж авдаг орчин учраас би тэгж хардаг байж магадгүй.

Таны яриаг сонсоход сонголт гэдэг зүйл хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд маш бага юм болов уу гэсэн бодол төрлөө.

Тийм. Би энэ гоё үсчин лүү оръё гэхэд дандаа гадна талын шатыг нь хардаг, дотроо лифттэй эсэхийг нь асуудаг. Тэгээд л лифтгүй гэвэл, за за гээд л би налуу замтай, орж гарахад саадгүй газрыг л дандаа сонгодог. Тэгэхээр бид нарын хувьд сонголт маш багатай байдаг. Гэтэл хүний эрх, эрх чөлөөний нэгдүгээр шалгуур үзүүлэлт бол сонголттой байх гэж үздэг юм байна. Өнөө орой хоолоо идэх, гараад дэлгүүрт орох, найз нөхөдтэйгөө уулзах, цаашлаад ажилд орох, хүссэн сургуульдаа сурах, сонгох сонгогдох эрх гээд олон сонголт хийгдэнэ. Яагаад хөгжлийн бэрхшээлтэй хүн Улсын Их Хурлын гишүүн болж болохгүй гэж? Яагаад аль нэг яаманд ажиллаж болохгүй гэж? Яагаад аль нэг яамны сайд нь хөгжлийн бэрхшээлтэй хүн байж болохгүй гэж? ХБХХЕГ-т яагаад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бүгдээрээ ажиллаж болохгүй гэж гэсэн бодлууд бас байдаг шүү.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй эсвэл хүүхэдтэй хэрхэн зөв ярилцах ёстой байдаг юм бэ?

Ерөөсөө л яг найз нөхдийн хэмжээнд энгийнээр харьцах. Тэгээд “өө сайн байна уу, чи тэргэнцэртэй байж мундаг юм аа” гээд л яриад эхлэх юм бол яриа цаашаа явахгүй. Тэрний оронд “чи үүнийг юу гэж бодож байна? Би энэ асуудлыг ингэж боддог. Чиний үзэл бодол юу вэ?” гээд хөгжлийн бэрхшээл дээр нь төвлөрөхгүй яриа эхлэхвэл та хоёрын яриа цаашаа явна л гэж ойлгох хэрэгтэй. Хэн нэгэн хөгжлийн бэрхшээлтэй найз чинь байдаг бол эсвэл дүү чинь, ах чинь байдаг бол энгийн яриа ярих нь их чухал. Дандаа хөгжлийн бэрхшээлтэй дээр нь төвлөрсөн яриа бол их эмзэг дээрээс нь бусдаас өөр гэдгийг нь байнга сануулаад та хоёрын яриа урт үргэлжлэхгүй. “Чи тэргэнцэртэй байж мундаг юм аа, чи харахгүй байж мундаг юм аа” гээд л яриад эхлэх юм бол тэгээд л цаашаа нэг их яриа явахгүй. Тэрний оронд “ковидын вакцины талаар чиний үзэл бодол юу байна? Би бол энэ нь сайн гэж бодож байна, чи юу гэж бодож байна. Чи яагаад ингэж бодож байна эсвэл нийтийн тээврээр тэрэгтэй хүн зорчиж болохгүй байгааг” чи юу гэж



бодож байна гээд үзэл бодлыг нь сонсох байдлаар ярьж, энгийн харьцах юм бол та хоёрын яриа цаашаа урт өрнөнө. Бас хөгжлийн бэрхшээлтэй хүний юмыг харах өнцөг өөр болдог. Жишээлбэл миний гэмтээгүй байх үе, гэмтсэний дараа амьдралыг харж байгаа хандлага их өөр болсон. Илүү бодох цаг хугацаа надад гарч ирсэн байх. Тэгэхээр амьдрал ямар үнэ цэнэтэй юм бэ гэдгийг илүү ойлгодог л доо. Тиймээс бидний яриа хамаагүй өөр байх ч талд бий. Ажиглаад байхад хөгжлийн бэрхшээлтэй хүний яриа бусад залуучуудад ухаарал өгдөг байх талтай.

Та сая хөдөлмөр эрхлэлтийн талаар ярьсан. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт болон түүнээс үүдэн гарч байгаа ямар асуудал өнөөдөр Монголын нийгэмд тулгараад байгаа вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй гэхээсээ илүү ер нь иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар л бид нарт цөөн тоон баримт байна. Хөдөлмөрийн насны хөдөлмөр эрхлэх боломжтой 70,000 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна. Тэдгээрийн бараг 10 хүрэхгүй хувь нь л хөдөлмөр эрхэлж байна гэсэн нэг тоо саяхан явж байсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал маш чухал байдаг. Хэрвээ хөдөлмөр эрхлэлтийн асуудал нь шийдэгдэх юм бол тэрийгээ дагаад сэтгэл зүйн байдал, нийгмийн оролцоо, орлого, амьжиргаа гээд олон асуудал шийдэгдэнэ. Тэгэхээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлыг шийднэ гээд нийгмийн халамжийг нэмэх биш зүгээр хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг шийдвэл илүү өргөн хүрээнд асуудал шийдэгдэнэ гэж боддог.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр үндэсний хөтөлбөр гэж байдаг. Тэгээд тэр хөтөлбөрийн хүрээнд жилд нэг удаа хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллагуудад санхүүгийн дэмжлэг олгодог. Бид түүнд оролцохын тулд төслөө бичээд, тендерийн тухай хуулийн дагуу тендерийн бичиг баримтаа бүрдүүлээд өгдөг. Хэрэвээ шалгараад тэнцвэл тэндээс санхүүжилт авах байдлаар л нэг хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг шийдэж байна. Тэгэхдээ энэ бол үнэхээр хангалтгүй. Манай байгууллагын хувьд бол харьцангуй мэдээлэл дунд байгаа учраас энэ бүх мэдээллийг аваад бас энэ хөтөлбөрүүд нь оролцоод явдаг. Гэтэл Баян-Өлгий аймгийн аль нэг суманд байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулдаг аж ахуйн нэгж энэ талаар мэдэж байгаа юм уу? Эсвэл тэр суманд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр төрийн бус байгууллага байгаа юм уу? энэ их эргэлзээтэй. Энэ өөрөө маш хязгаарлагдмал бодлого гэж бид нар хардаг.

25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж байгууллага 4 хүртэлх хувьдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг авч ажиллуулна гэсэн нэг хуулийн заалт байдаг. Тэр заалтыг хэрэгжүүлэх тухай ерөнхийлөгчийн 128 дугаар зарлиг гарсан

байгаа. Тэр зарлигийн дагуу заавал ажиллуул хэрвээ ажиллуулаагүй бол хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд мөнгөн торгууль төл гэдэг заалт байдаг. Энэ зарлиг гарахаас өмнө энэ санд 1 тэрбум гаруй төгрөг цуглардаг байсан бол, зарлиг гарснаас хойш хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 8.3 тэрбум төгрөг цугларсаны 60 орчим хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон бусад иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр зарцуулагдсан, харин үлдсэн санхүүжилт юунд зарцуулагдсан нь одоогоор тодорхойгүй байна. Эрх бүхий хүмүүст хандаад бид нар энэ мөнгө хаана байна вэ? Энэ мөнгийг бидний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр зарцуулаач ээ гэсэн шаардлагыг одоо өгөөд л яваад байгаа. Тэгэхээр яаж шийдэх ёстой вэ гэвэл хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд мөнгө цугларааД, санхүүгийн эх үүсвэр бол байна. Тэгэхээр санхүүгийн эх үүсвэрээр нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилд авч байгаа аж ахуйн нэгжүүдийн орчныг нь хүртээмжтэй болгох, тухайн байгууллагын ажилтнуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг таниулах, ялгаварлахгүй хандах хандлагыг төлөвшүүлэх. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд нь нийгмийн дунд аж төрөх, хариуцлагатай байх, ажлын орчинд бусадтай нийцтэй харьцах, сэтгэл зүйн дэмжлэг, хандлага олгох сургалтууд хийгээд ажилдаа ирж очих нийтийн тээврийн асуудлыг нь шийдэхэд энэ мөнгийг зарцуулах юм бол хөдөлмөр эрхлэлт яг бодитоор бий болно л гэж хардаг.

Тэрнээс биш хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилд ав, авахгүй бол торгоно гэдэг энэ хууль төдийлөн оновчтой биш. Яагаад гэвэл ажилд авъя, хуулиа хэрэгжүүлье гээд байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилд авдаг. Гэтэл тэр ажилд орсон хөгжлийн бэрхшээлтэй хүн өөрөө сэтгэл зүйн хувьд бүрэн бэлтгэгдээгүй, дандаа л гэртээ өөрийнхөө хүссэн цагтаа босоод өөрийнхөө дураар байж байсан хүн гэнэтхэн өглөө болгон 6.00 цагт босоод 9.00 цагт ажилдаа очихоор ядардаг. Эхний хоёр гурван улиралдаа эрүүл мэндийн хувьд илт доройтдог асуудал эхний ээлжид гардаг. Дээрээс нь сэтгэл зүйн хувьд ч, бие махбодын хувьд ч ачаалал авдаг. Ингээд ирэхээр эрүүл мэнд сэтгэл зүйд нь зөндөө өөрчлөлт гардаг. Үүнд нь чиглэсэн үйлчилгээ байхгүй учраас энэ эрсдэлтэй үеэ давж туулахгүй ихэнх ажилд орсон хүмүүс буцаад гардаг. Тэгээд л хоёр талд хэцүү байдал үүсэж байгаа юм. Нөгөө хуулиа хэрэгжүүлье гэж хүсээд ажилтныг авсан компани ч эрсдэлд ороод, танай хүн чинь ажилдаа ирэхгүй байна гэхээр хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилд зуучилсан төрийн бус байгууллага ч гэсэн эрсдэлд ордог. Хөгжлийн бэрхшээлтэй хүн маань ч гэсэн өөрөө бас гэнэт ачаалал аваад бас эрсдэлд орчихдог. Сэтгэл зүйг нь дэмжих, эхлээд өдрийн цөөн цагаар явж байгаад л урт болгодог дасан зохицох хугацаа эсвэл дунд нь амрах боломж олгох зэрэг зохицуулалт хэрэгтэй байна. Эрүүл мэндийн нөхцөлийг нь хянах, ажилдаа ирж очих унааг нь зохицуулах, ажлын орчныг нь тав тухтай амрах өрөөтэй болгох эсвэл 2 цаг ажиллаад 15 минут амардаг өрөөтэй байх стандарт ер

нь байдаг. Тэр өрөөг нь бий болгох дээр санхүүгийн дэмжлэг үзүүлэх байдлаар цогцоор нь шийдэх хэрэгтэй. Хөдөөгийн нэг суманд байгаа иргэн Дулмаа байлаа гэхэд тухайн суманд тэргэнцэртэй хүн ажилд авах компани байхгүй бол тэгээд л тэр хүний хөдөлмөр эрхлэлтийн асуудал шийдэгдэхгүй орхигдох болж байгаа юм.

Тэгэхээр гүнд нь ороод, бодлого боловсруулж байгаа хүмүүс яг энэ асуудал дунд явж байгаа бидний үгийг маш сайн сонсоод, бодлого төлөвлөлтөөрөө бодитойгоор хэрэгжүүлэх нь маш чухал. Бодлого боловсруулж байгаа хүмүүсийн хувьд аж ахуйн нэгжүүдэд бид шаардлага хүргүүлчихсэн, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажилд авах ёстой гэсэн бодол л байгаа байх. Гэтэл энэ чинь бодит байдал дээр болохгүй байна гэдгийг бид нар одоо хараад байгаа юм. Яагаад гэвэл сэтгэл зүй нь бэлтгэгдээгүй, ажлын байрны орчин бэлтгэгдээгүй, ажилдаа ирж очих нийтийн тээвэр нь бэлтгэгдээгүй учраас энэ хуулийн заалт чинь гүйцэд хэрэгжихгүй байна. Тэгэхээр яаж шийдэх вэ? Гаргалгаа нь ч гэсэн бидэнд байна. Тэгэхээр бодлого гаргахдаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оролцуулах нь их чухал. Зөвхөн Улаанбаатар хотод биш Баянхонгор аймагт аймгийн засаг дарга ч гэсэн энэ чиглэлийн бодлого боловсруулахдаа Баянхонгорт байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ дуу хоолойг сонсдог, Архангайд нь тэр орон нутгийнхаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ дуу хоолойг сонсдог байх нь их чухал.

Монголд ер нь сэтгэл зүйн дэмжлэг үзүүлдэг байгууллага байдаг уу?

Яг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар дагнасан сэтгэл зүйч байдаггүй. Ийм хэрэгцээ бол маш өндөр байгаа. Би ч гэсэн яг хөгжлийн бэрхшээлтэй болсныхоо дараа тэргэнцэртэй байдлыг хүлээн зөвшөөрөх гэж олон жилийг өнгөрүүлж байсан. Хөгжлийн бэрхшээлтэй байдлаа даван туулах, хөгжлийн бэрхшээлтэй гэдгээ хүлээн зөвшөөрөхөд сэтгэл зүйн үйлчилгээ хэрэгтэй. Сургууль, ажилд орох, гэр бүл төлөвлөхөд ч гэсэн сэтгэл зүйн үйлчилгээ хэрэгтэй. Тэгэхээр энд том хоосон орон зай байгаа. Энэ чиглэлээр ямар ч үйлчилгээ байхгүй. Тэгэхээр энэ чиглэлээр хүмүүс бэлтгэгдвэл бид нарт бол маш их хэрэгцээтэй байдаг.

Магадгүй миний нөхцөл байдлыг надаас асуухгүй байсан нь надад стресс болчихсон. Ингээд асуугаад ярилцаж байгаа нь надад тодорхой хэмжээний сэтгэл зүйн дэмжлэг болж, өөртөө итгэх итгэлийг бий болгож байдаг. Миний үгийг сонсож, миний үгийг бусдад хүргэж байна гэдэг бол энэ мэтээр олон подкаст, нэвтрүүлгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг оролцуулаад явбал энэ чинь нөгөө талдаа бас сэтгэл зүйн үйлчилгээ, сэтгэл зүйн дэм болно. Тэрнээс хүрч ирээд чи ёстой мундаг юм гээд миний толгойг илэх бол ерөөсөө сэтгэл зүйн дэмжлэг биш гэдгийг л нийгэм даяараа ойлгох нь чухал. Яаж энэ хүмүүсийг дэмжих вэ гэвэл зүгээр л гудамж талбайн хог цэвэрлэх байсан ч тэр бүх юмандаа оролцуул.

Тэрнээс өрөвдөж хайрлах нь чухал биш гэдэг том концепцыг л бүгдээрээ ойлгох ёстой юм.

Та сая эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудал орхигдсон сэдэв гэж хэлсэн шүү дээ. Ийм орхигдсон сэдэв бас мэдээлэл хүртээмжгүй байгаа үед эмэгтэйчүүд маань нөхөн үржихүйн болон бэлгийн асуудлын талаар мэдээллийг хаанаас олж авах вэ?

Энэ өөрөө их том асуудал л даа. Маш чухал сэдэв сонгож байна гэж үзэж байна. Манай судалгаанд оролцогсод ХДХВ нь халдварладаг өвчин мөн үү, биш үү гэсэн асуултад халдварладаггүй өвчин гэж 1/3 нь хариулсан. Тэгэхээр ДОХ-ын талаар ямар ч мэдлэг, мэдээлэлгүй болох нь харагдаж байгаа юм. Яагаад гэвэл ДОХ-ын талаар хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр маш их шүү дээ. Монголд их хэмжээний санхүүжилттэй олон төсөл хөтөлбөр хэрэгждэг ч гэсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулаагүй, ДОХ-ын талаар мэдээллээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртэл түгээгээгүй учраас энэ хэсэг хүмүүс энэ талын мэдээлэлгүй явж байна. Манай судалгаанд оролцогсдын 16% нь л эмч, эмнэлгийн байгууллагаас нөхөн үржихүйн зөвлөгөө авдаг бусад нь зурагт, фэйсбүүк, найз, ээж, эгчээсээ гээд дандаа албан бус эх сурвалжаас мэдээлэл авдаг гэж хариулсан байсан. Гэтэл зурагт, интернетэд байгаа мэдээллүүд яг найдвартай мэдээллийн эх сурвалж биш. Тэгэхээр энэ нь өөрөө маш эрсдэлтэй байна гэсэн үг. Тэгэхээр эмч, эмнэлгийн ажилтнуудаас дөнгөж 16% гэдэг чинь бас цөөхөн хувь, тэгээд үлдсэн 84% нь бол баталгаагүй эх сурвалжаас энэ мэдээллийг авдаг.

Тэргэнцэртэй хүмүүсийн харах, сонсох үйлдэл алдагдаагүй учраас мэдээллээ хэвийн аваад явах боломжтой. Гэтэл харааны, сонсголын бэрхшээлтэй хүмүүс энэ тал дээр маш их хаагдмал. Бичсэн материалыг уншиж чадахгүй, зөвхөн сонсох замаар мэдээллийг олж авдаг. Тэгэхээр хаанаас мэдээлэл олж авч байна вэ гэвэл ихэнх нь төрийн бус байгууллагуудын хийж байгаа хамт олон, бүлгийн сургалтаас энэ мэдээллийг олж авдаг гэж хариулсан байсан. Харааны, сонсголын бэрхшээлтэй хүмүүст мэдээлэл хүртээмжгүй байгаа учраас интернет болон зурагтаас мэдээлэл төдийлөн авч чаддаггүй. Энэ бол маш их анхаарал татсан асуудал юм.

Манай холбооны дэргэд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн 9 бүлэг байгуулаад, 120 гаруй залуучуудыг чадавхжуулж явдаг. Тэдний дотор харааны бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бүлэг байдаг. Бид нөхөн үржихүйн эрүүл мэндийн сургагч багш бэлдээд, тэр бүлгийнхэнд нөхөн үржихүйн эрүүл мэндийн хичээл заах үед даавар бол ийм учиртай, өндгөвч нь ийм үүрэгтэй гээд л хичээл заах гэсэн чинь даавар, өндгөвч гэдэг үгний утгыг ойлгохгүй байсан. Тэгэхээр энэ тохиолдолд цаашаа тэр дааврын үүрэг, өндгөвчийн бүтцийг

ярих ямар ч боломжгүй юм. Боловсролын асуудал ийм доогуур хэмжээнд байгаа. Харааны бэрхшээлтэй хүмүүс Бест ФМ гээд радиогоороо дамжуулан ерөнхий мэдээлэл авдаг ч тэр мэдээлэл дунд нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдээлэл бараг байдаггүй. Тэгээд жирэмсэн болох, жирэмслэлтээс хамгаалах, сарын тэмдгийн мөчлөг гээд охидод хэрэгтэй нарийн асуудлууд байдаг. Тэр болгоныг бараг мэдэхгүйгээр байгалийн зөнгөөрөө өсдөг. Сайн ээж аав байвал нэг хэлж өгдөг. Ээж аав нь төдийлөн боловсролтой биш эсвэл олон хүүхэдтэй бол хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ орхиод бусад охидууддаа анхааралаад явдаг үзэгдэл түгээмэл байдаг. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдээлэл их чухал учраас одоо анхаарахгүй бол хэсэг бүлэг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал бүр орхигдсон байна гэж бид харсан. Тэгээд бид энэ чиглэлээр тодорхой үйл ажиллагаа хийж байгаа. Эмч, эмнэлгийн ажилтнуудад зориулсан, хүний эрхэд суурилсан эрүүл мэндийн үйлчилгээ гэсэн 4 модультой сургалтын гарын авлага 2020 онд боловсруулаад дууссан. Тэгээд 2021 онд эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтраад анагаахын эмч, эмнэлгийн ажилтан бэлтгэдэг их, дээд сургуулийн төгсөлтийн дараах хөтөлбөрт оруулахаар ажиллаж байна. Тэгэхээр эмч нар мэргэжил дээшлүүлэх кредит оноо цуглуулах сургалтад суухдаа манай сургалтад хамрагдаад, хөгжлийн



бэрхшээлтэй хүмүүсийн эрх, хүний эрхэд суурилсан эрүүл мэндийн үйлчилгээний талаар илүү мэдлэгтэй болно. Тэгснээрээ эмч, эмнэлгийн ажилтнуудын харилцаа хандлага сайжирна гэж харж байгаа.

Нөгөө талд бид хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох 8 модультой сургалтын багц хөтөлбөрийг боловсруулаад дууссан. Энэ улиралдаа багтаагаад хэвлэлтэд өгөх ёстой. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэгийг харааны бэрхшээлтэй, сонсголын бэрхшээлтэй, оюуны бэрхшээлтэй хүмүүс ойлгохоор хүртээмжтэйгээр боловсруулж байгаа гэсэн үг. Тэгэхээр нөхөн үржих эрхтэн тогтолцоонд ийм юм ордог гэдгийг бусад сургалтууд бол үзүүлэн дээр заагаад энэ бол өндгөвч, энэ бол умай, энэ бол үтрээ байгаа юм гээд заагаад үзүүлдэг. Гэтэл үүнийг харааны бэрхшээлтэй хүн ойлгодоггүй. Тэгэхээр харааны бэрхшээлтэй хүнд ойлгуулахын тулд бид нар мулиаж дээр тайлбарлаж, гарт нь бариулж үзүүлж, дасгал ажил хийлгэе гэж төлөвлөж байгаа. Оюуны бэрхшээлтэй хүмүүст илүү зургаар ойлгуулъя гээд модулиудаа боловсруулаад явж байгаа. Энэ бол маш их хөрөнгө, хүч шаардсан ажил байгаа юм. Бид 2 жил гаруй ажилласан, сайн бүтээл болох байх гэж найдаж байгаа.

Тэгээд үүнтэй зэрэгцээд гэр бүлийн хүчирхийлэл гэдэг асуудал бас гарч ирнэ. Гэр бүлийнхнээсээ хамааралтай байдаг ихэнх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тэтгэвэр тэтгэмжээ өөрөө зарцуулдаггүй. Чи яагаад зарцуулахгүй байгаа юм бэ? гэсэн асуултад “намайг харж хандаж байгаа хүн маань ээж аав болохоор эд нар л зарцуулах нь зөв шүү дээ. Би тэрийг аваад юу хийх вэ дээ, ямар гэрээс гарах биш” гээд л хариулдаг. Гэтэл хүний эрхийн өнцгөөс харвал тэтгэвэр тэтгэмжээ өөрөө захиран зарцуулах эрхтэй байдаг гэдгээ мэдэхгүй, гэр бүлийн хүчирхийлэлд байна гэдгээ өөрсдөө мэдэхгүй ийм тохиолдол бүр 80-90 хувьтай байна. Тэгэхээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст гэр бүлийн хүчирхийллийг таниулах үйл ажиллагаа маш их хэрэгтэй. Чи өөрөө тэтгэвэр тэтгэмжээ захиран зарцуулах эрхтэй, өөрөө сонголттой байх эрхтэй, хэзээ, хэнтэй гэрлэх, хэдэн хүүхэдтэй болохоо зөвхөн чи өөрөө шийднэ. Тэрнээс хэн нэгэн эмч юм уу, халамжийн ажилтан эсвэл ээж аав чинь шийдэхгүй гэдгийг хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд өөрсдөө мэддэг байх нь их чухал. Тэгэхээр энэ бүх мэдээллүүд нийгэмд байгаа ч гагцхүү хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бэрхшээлийн онцлогт тохирсноор байдаггүй. Тийм учраас бид үүнийг тохируулсан байдлаар гаргаж байгаа. Бас манай холбооны цахим хуудас дээр энэ чиглэлийн хүртээмжтэй видео контентууд сүүлийн жилүүдэд нэлээн хэд гарсан байгаа.

Мэдээллийн байгууллагууд бас их анхаармаар санагддаг. Подкастыг бол харааны бэрхшээлтэй хүмүүс сонсох боломжтой учраас их хүртээмжтэй гэж хардаг, мэдээж сонсголын бэрхшээлтэй

хүнд бол хүртээмжгүй. Гэхдээ юм уншиж чадахгүй, бичиг үсгийн боловсролгүй хүмүүс бол подкаст сонсох нь илүү хүртээмжтэй гэж харж байгаа.

Таны цаашдын хүсэл мөрөөдөл юу вэ?

Би аз жаргалтай сайхан гэр бүлтэй хүн. Хүүдээ чанартай боловсрол эзэмшүүлж, эрүүл, аюулгүй орчинд амьдруулах юмсан гэж хүсдэг. Би хүүгээ сургуульд нь явуулаад бусад ээж аав шиг ороод авч чаддаггүй, сургуулийнх нь хашааны гаднаас л тосож авдаг. Одоохондоо хоёрдугаар анги болохоор дандаа очиж авдаг. Гурав, дөрөвдүгээр ангид ороод, том болоод ирэхээр гудамжаар нааш цаашаа өөрөө явдаг болно. Тэр үед нийслэл хотын маань гудамж явган зорчигчид, хүүхдэд аюулгүй эрүүл байгаасай гэж их хүсдэг.

Яг одоо бол манай хүүхэд сургуулиасаа гэр хүртлээ ганцаараа зам хөндлөн гараад ирнэ гэдгийг би төсөөлж чадахгүй байна, маш аюултай. Өдөрт маш олон осол гарч, хүмүүс бэртэж гэмтээд л, эсвэл амь насаа алдаж байгаа тохиолдлуудыг хараад их эмзэглэдэг. Тэгэхээр ийм нэг аюулгүй, эрүүл орчинд л амьдрахыг их хүсдэг. Тэгэх юм бол би ч гэсэн гаргах тоолондоо машинд суугаад явахгүй, тэргэнцрээрээ нийтийн тээвэрт суугаад ажилдаа ирж очдог байвал хэчнээн амар вэ. Одоо бол би ажилдаа явахын тулд дандаа нөхрөөрөө хүргүүлдэг. Нөхрөөрөө хүргүүлэхийн тулд тэргэнцрээ ачих болоход миний хоёрдугаар ангийн хүү тэргэнцрийг маань өргөөд машины багажинд хийж өгдөг. Тэр болгонд орчин саадгүй байсан бол миний хүү заавал бусад хүүхдүүдээс илүү ачаалал үүрэхгүй шүү дээ гэж их эмзэглэдэг. Гэтэл үнэхээр боломжгүй учраас л ийм их ачаалал үүрээд байна. Тэгээд энэ нөхцөл байдал хурдан арилаасай, төр нийгмийн байдал тогтворжоосой гэж боддог.

Манай улс их баян орон шүү дээ. Тэр мөнгө хөрөнгөө энэ зам, нийгмийн дэд бүтцийн салбартаа зарцуулаад бүх хүмүүсийг саадгүй, аюулгүй, тав тухтай амьдардаг, зорчдог нийгэм л бий болоосой л гэж хүсдэг. Энэ бол харахад их том юм хүсээд байгаа юм шиг боловч надад өдөр тутам тулгардаг асуудал учраас би энэ явган хүний замын асуудал, нийтийн тээврийн асуудал шийдэгдээсэй гэж маш их хүсдэг.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд маань гэр хороололд нэлээн байгаа шүү дээ, тийм ээ?

Улаанбаатар хотод 30,000 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаагийн 8,000 нь л орон сууцанд амьдарч байгаа юм. Тэгэхээр 20,000 гаруй нь гэр хороололд амьдарч байгаа. Тэгээд гэр хороололд гудамжаар тэргэнцэртэй явна гэдгийг та нар төсөөлөөд үзэх юм бол маш хэцүү шүү дээ. Өвөл дэгэн догонтой, нэг чулуун дээр очоод л дугуй нь гацчихна. Энэ бэрхшээлтэй байдлаасаа болоод олон зуун мундаг чадвартай залуучууд нийгэмд гарч хөдөлмөрлөж чадахгүй гэртээ байгаад байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн асуудлыг шийднэ, халамжийн хувийг нэмэгдүүлнэ гэдэг үгэнд би ёстой дургүй. Тэдэн хувь гэж

нэмэгдэж байгаа нь үсрээд л 4000, 5000, 10,000 төгрөг нэмэгддэг. Нэг удаагийн таксины мөнгөний маань ч зардалд хүрэхгүй. Цаасан дээр харахад юм хийсэн болж харагдаад байдаг.

Тэрний оронд Улаанбаатар хотод явж байгаа нийтийн тээврийн автобуснуудаа тэргэнцэртэй хүн зорчих боломжтой болгоод, явган хүнийхээ замыг засаад, замын гарцыг налуулгатай хийчих юм бол бид нар нэмж байгаа 10,000 төгрөгөөс илүү их орлогыг нийгэмдээ хувь нэмрээ оруулаад, өөрсдөө олох гээд байгаа юм. Тэр битгий хэл дээрээс нь ажил хийж байгаа учраас татвараа төлөөд, нийгмийн баялаг бүтээгч иргэн болох боломжтой. Тэрнээс биш гэрт нь суулгаад, халамж өгөөд, ковидын үеийн 100,000 төгрөгийн нэмэгдэл гэдэг бол бидний амьдралын асуудлыг шийдэхгүй. Тэрний оронд зүгээр дэд бүтэц, нийгмийн орчныг л хүртээмжтэй болгочих юм бол бид нар өөрсдөө ажил хийгээд, улс эх орондоо татвараа төлөөд, өөрсдөө тэр өгч байгаа халамжийн мөнгөнөөс чинь хэд дахин илүү орлого



олоод, ажиллаад явах боломжтой. Энэ 100,000 гаруй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дунд чадвартай олон зуун залуучууд байгаа. Маш сайн хуульч, эдийн засагч байж байгаад гэмтээд, тэргэнцэр дээр суугаад гэртээ байж байгаа хүмүүс зөндөө байна шүү дээ. Тэгээд гарч оръё гэхээр нийгмийн дэд бүтэц нь болохгүй, нийтийн тээврээр явж чадахгүй. Өдөр болгон такси бариад яваад байх мөнгө, санхүүгийн боломж байхгүй.

Ер нь бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг шийдэхийн тулд орчны саадыг багасгах нь л хамгийн чухал. Хэдий чинээ орчны саад бага байна, хөгжлийн бэрхшээл төдий чинээ багасдаг. Хэдий чинээ орчны саад их байна, хөгжлийн бэрхшээл төдий чинээ ихэсдэг. Үүнийг бид нар амьдрал дээр их олон зүйлээс хардаг. Манайхан хурал, уулзалтаар гадагшаа яваад бүгдээрээ ярьдаг. Гадагшаа явах онгоцонд суугаад л би эрх чөлөөтэй хөгжлийн бэрхшээлгүй иргэн болж хувирдаг. Гадаадад очоод дуртай юмаа үзээд л, хараад л, автобусаар, метрогоор саадгүй зорчиж эхэлдэг. Монголд ирээд л миний тэргийг буулгаад өгөөч, намайг ийшээ өргөөд өгөөч, намайг энэ бордюр дээр гаргаад өгөөч, миний тэргэнцрийг машин луу өргөөд хийгээд өгөөч гээд л хүн гуйж эхлээд л хөгжлийн бэрхшээлтэй гэдгээ утгаар нь мэдэрч эхэлдэг гэж ярьдаг юм. Тэгэхээр энэ чинь орчны саад багасахаар хөгжлийн бэрхшээл багасдаг юм байна гэдгийг л нотлоод байгаа юм. Тэгэхээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлыг шийдэхийн тулд орчны саадыг л багасгах хэрэгтэй. Орчны саад гэдэгт зөвхөн явган хүний зам, нийтийн тээвэр, барилга байгууламжаас биш мэдээллийн хүртээмж бас ордог. Та бүхний подкаст бол харааны бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байна. Сонсголын бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй ямар контент байж болох вэ? гэдгийг бас бодоорой. Эсвэл танай подкаст чинь бичлэгтэй, дээр нь дохионы орчуулагчтай явах юм бол сонсголын бэрхшээлтэй залуучууд үүнийг сонсож эхэлнэ гэсэн үг. Энэ талаас нь бодож эхэлж байж л хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлыг шийдэх байх.

Таны санал, зөвлөмжийг хүлээж авна аа! Баярлалаа. Ковид цар тахал хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хэрхэн нөлөөлж байна вэ?

Маш их нөлөөллөө шүү дээ. Ялангуяа хөл хорионы үед олон хүний эрх зөрчигдөж, олон асуудалтай тулгарлаа. Бид нарын дуу хоолой нийгмийн цөөнхийн цөөнх гэдгээрээ их сул учраас бид нар дуу хоолойгоо хүргээд, сонсож байгаа төр засаг байгаа эсэхийг мэдэхгүй л байна. Бид нар нэг судалгаа хийгээд ХНХЯ болон ХБХХЕГ-т хүргүүлсэн ч ямар нэгэн хариу ирээгүй. Бид судалгааныхаа тайланг сошиалаар илүү нийгэмд түгээж байгаа. Ямар асуудал гарч ирсэн бэ гэвэл манай судалгаанд оролцсон 200 орчим хөгжлийн бэрхшээлтэй хүний 79% нь орлогогүй болсон эсвэл орлого буурсан гэж хэлсэн. Тэдгээр хүмүүсийн 61% нь хүнсний талонд эсвэл хүнсний ямар нэгэн тусламжид хамрагдаж чаддаггүй. Дээрээс

нь өвлийн улиралд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс түлээ нүүрснийхээ мөнгийг хэмнэх зорилгоор бас өвлийн улиралд эрсдэлтэй болдог учраас өндөр, халтиргаатай газар амьдрхаасаа илүү нийтийн байранд амьдардаг. Нийтийн байранд амьдраад ирэхээрээ харьяа дүүрэг дээрээ байхгүй байна гэдэг шалтгаанаар хороо, дүүргээс олгож байгаа тусламж, дэмжлэгт хамрагдаж чадахгүй хоцордог. Тэр битгий хэл өрхийн эмнэлгийн үйлчилгээнд ч хамрагдаж чаддаггүй.

Сая ковидын үеэр харьяаллын биш гэдэг шалтгаанаар эрүүл мэндийн, эдийн засгийн, хоол хүнсний дутагдалд орсон тохиолдол маш их гарсан. Улаанбаатар хотод амьдардаг тэргэнцэртэй хүмүүс ах дүү нарынхаа дэмжлэгтэйгээр нэг хуучин ч хамаагүй машин аваад, гар ажиллагаа хийгээд явдаг. Хүүхдээ сургуульд нь зөөнө, хүнсээ цуглуулна, ажилдаа явна. Бусад хүмүүсийн л адил бид нарын ард амьдрал байгаа учраас машинаараа л энэ бүх ажлаа зохицуулдаг. Хөл хорио тогтоогоод, зөвхөн зөвшөөрөлтэй машин явна гээд бүх машин явахыг хязгаарласан шүү дээ. Тэгэхээр тэргэнцэртэй иргэдийн машин бас хязгаарлалтад орчихно. Бусад хүнтэй адилхан өглөө 10.00 цагаас орой 7.00 цаг хүртэл явж байгаа автобусаар нь явж чаддаг бол яваад хүнсээ авах байсан, тийм ч боломж байхгүй. Би бүрэн хориод ороод, хүнсээ цуглуулж чадахгүй, аптек орж хэрэгтэй эм тариа, эмнэлгийн хэрэгслээ авч чадахгүй байдалд хүрсэн. Энэ байдалд илүү урт хугацаанд үргэлжилсэн бол бараг өлсгөлөнд нэрвэгдэх магадлалтай болж байгаа юм. Тэгээд ах дүү, найз нөхдийнхөө дэмжлэгийг авч байж хүнсээ авах байдлаар зохицуулж эм тариагаа залгуулж байсан. Гэтэл тэд нар яг миний авдаг шархны лентийг олж авч чадахгүй, яг миний авдаг, миний эрүүл мэндэд тохирдог хүнсийг авч ирж өгч чадахгүй байгаа тохиолдол гарч л байсан. Тэгээд цөөхөн хоног тулдаа л тэсээд өнгөрсөн. Тэгээд эндээс юу хэлмээр байна гэвэл ковидын үеийн онцгой байдлын үеийн дүрэм журмыг гаргахдаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцлог хэрэгцээг тооцож, олон талаас нь үнэлж харж байж дүрмээ гаргахгүй бол болохгүй байна.

Би бол хөл хорионы үеэр хүмүүсийн дэмжлэг аваад харьцангуй гайгүй байсан гэтэл гэр хороололд цор ганцаараа амьдардаг тэргэнцэртэй хүн байгаа. Тэр хүн яасан бол гэж надад бодогдсон. Утас харилцаа холбоогүй, нэгжний ч мөнгөгүй байвал яах вэ? Нэн ядуу амьдарч байгаа хүмүүс байгаа шүү дээ. Тэгэхээр тэр хөгжлийн бэрхшээлтэй, ганцаараа амьдардаг, ах дүү тусалдаг хүнгүй хүмүүс яасан бол? Манай гишүүд дотор лав жоохон хүүхэдтэйгээ амьдардаг ганц бие хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зөндөө байдаг. Тэд нар яасан бол гээд асуухаар надаас илүү хүнд нөхцөл байдалтай тулгарч эдийн засаг, хоол хүнсний дутагдалд орсон зүйл гарсан.

Тэгэхээр онцгой нөхцөлд гаргаж байгаа шийдвэрүүд хүмүүсийг орхигдуулсан шийдвэр гаргасан байна, тийм ээ?

Биднийг орхигдуулсан шийдвэр гаргаж

байгаа юм. Ковидын үед манай гордокт амьдардаг нэг гишүүний нэлээн хүнд кэйс. Тэргэнцэртэй хүмүүс удаан сууснаас болж цооролт, шархтай болдог ба эдгэрэлт нь маш удаан явагддаг. Тэгээд цооролт хүндрээд, бохирдоод, халууранд эмч лүү залгахад "наадах чинь ковидын шинж тэмдэг байж магадгүй учраас хоёр цаг тутамд халуунаа үзээд, гурав хоногийн турш ажиглаад надад эргээд мэдэгдээрэй" гэсэн зөвлөгөө өгсөн. Тэгтэл нөгөө хүн өөрөө энэ өвчнөөр олон жил өвдсөн учраас шарх бохирдсоноос болоод халуурч байна гэдгээ мэдэж байсан. Сүүлдээ түргэн тусламж 2-3 удаа дуудсан ч наадах чинь ковидын шинж тэмдэг гээд ерөөсөө ирэхгүй болохоор нь аргаа бараад өмнө нь эмчлүүлж байсан эмчтэйгээ холбогдоод би халууранд болохоо байлаа гээд очиж үзүүлээд, эмнэлгийн тусламж авсан. Тэгээд эмч "чи бараг цөөхөн цаг алдсан бол цусанд чинь бохир ороод, амиа алдах эрсдэлтэй байж ээ, яаж амжиж ирэв ээ" гэж хэлсэн байгаа юм. Эндээс юу харагдаж байна гэвэл эмнэлгийн байгууллагууд хэт их ковид дээр төвлөрөөд бусад эмнэлгийн тусламж, үйлчилгээ тогтмол авах шаардлагатай хүмүүсийнхээ асуудлыг орхигдуулаад байна гэж дүгнэж байна. Эмч тэгж хэлсэн, нээрээ ковид байж магадгүй гээд гурав хоносон бол нөгөө хүн маань бараг амь насаа алдах аюултай байсан юм. Асуудлыг мэдэхгүй, эрсдэлтэй байгаа юм.

Аймаар юм аа.

Тэгээд бас манай нэг эмэгтэйн хүүхэд нь халууранд дуудлага өгсөн чинь "яаж халуурч байна, хэд хүртэл халуурч байна" гэж асуусан гэсэн. Тэгээд ингэж халуурч байна гэтэл "наадах чинь ковидын шинж тэмдэг байна. Цаг тутамд халууныг нь үзээд, надад мэдээлээд бай" гэж хэлсэн. Өмнө нь энэ кэйсийг сонссон байсан учраас айгаад нялх хүүхдээ хурдхан шиг хотод эмнэлэгт аваачиж үзүүлсэн гэсэн. Энэ кэйсүүд яг ковидын хөл хорионы үеэр гарсан л даа. Тэгэхээр төрийн үйлчилгээг үзүүлж байгаа ажилтнууд хүний эрхийн мэдрэмжтэй, ажилдаа сэтгэлтэй байхгүй бол хэт их нэг юманд төвлөрсөн энэ хандлагын дунд эмзэг бүлгийн иргэд чинь эрсдэлд орох магадлал өндөр юм байна гэдгийг подкастаар дамжуулж хэлмээр санагдсан юм. Мэдээж ковидын үеийн иргэдэд эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх журам гэж гарсан байгаа байх л даа. Гэхдээ энэ үед ч гэсэн архаг, суурь өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн урьд нь өвдөж байсан өвчлөлүүд нь сэдэрнэ шүү дээ. Өвдөлт нэмэгдээд, үйлчилгээнүүд нь байхгүй болохоор өмнөх өвчнийг халдварт өвчинтэйгөө хамруулж авч үзээд байгаа нь иргэдийн эрүүл мэнд, амь насанд нь аюул учрах нөхцөл болж байна гэж бид судалгаагаар гаргаж ирсэн.

Цаашдаа дэлхий нийтэд юу ч тохиолдоо билээ? Тэгэхэд бид нар зөвхөн нэг юм луугаа төвлөрөлгүй бүх нийтийг хамарсан хүртээмжтэй бодлого, төлөвлөлт хэрэгжүүлээсэй гэж бодож байна.

Аливаа бодлого шийдвэр гаргахдаа бүх хүний асуудлыг хамруулах хэрэгтэй. Сая

төрсөн ээжийг эмнэлгээс гаргаж байгаа кейсийг бид хараад “бид нар халдвар аваад очих юм бол бүр дуусах юм байна л даа, үйлчилгээ байхгүй юм биш үү?” гэж ярилцаж байсан. Тэргэнцэртэй хүн очвол яах вэ? Тэнд нь ариун цэврийн өрөө байгаа юм уу, шат довжоо нь ямар байгаа юм? Харааны бэрхшээлтэй, сонсголын бэрхшээлтэй хүн очвол яах юм? Ямар үйлчилгээ үзүүлж, хэн харилцаа үүсгэх юм? гээд нийгмийн маш олон чухал асуудлууд байдаг. Гэтэл “зүгээр нэг төрсөн ээжид ийм хариуцлагагүй хандаж байхад, бид нарт бол үйлчилгээ бараг байхгүй юм биш үү” гээд л бид нар хоорондоо ориад, гашуун ч гэсэн инээлдэж л байлаа.

Танд цаг гарган подкастад маань орж үнэтэй яриа, зөвлөгөө, цааш анхаарах зүйлүүдийг хуваалцсанд баярлалаа. Таны ажил үйлс, амьдралд нь аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе!

Баярлалаа. Подкастыг зохион байгуулж байгаа залуучууддаа бас баярлалаа. Би замбараагүй ярьсан бол уучлаарай. Та бүгдийн ажилд амжилт хүсье. Тэгээд сонсогчдодоо ч гэсэн бас хүний эрхийг ямагт дээдэлж хүртээмжтэй, аюулгүй, эрүүл нийгмийг бий болгоход бүгдээрээ сайхан оролцоотой байя, дуу хоолойгоо хүргэдэг байя гэж бас уриалъя аа.

БИЕ ДААН АМЬДРАХ ТОГТОЛЦООГ МОНГОЛД НЭВТРҮҮЛЖ БУЙ ЗАЛУУ



Ч.Ундрахбаяр

Сайн байцгаана уу, эрхэм хүндэт сонсогчид оо, Антолд подкастын маань ээлжит дугаар эхлэхэд бэлэн болоод байна. Энэхүү дугаарт "Түгээмэл Хөгжил" Монголын анхны бие даан амьдрах төвийн тэргүүн, үүсгэн байгуулагч Ундрахбаяр оролцож байна. Та урилгыг маань хүлээн авч подкастад маань орж байгаад маш их баярлалаа. Та эхлээд сонсогчдодоо өөрийгөө дэлгэрүүлээд танилцуулахгүй юу?

Урьж оролцуулж байгаад бас танай байгууллагад баярлалаа.

Намайг Ундархбаяр гэдэг. Би хориод жилийн өмнө нуруу нугасны гэмтэл авааД тэргэнцэртэй нийгмийн амьдралд оролцдог болсон. Хөгжлийн бэрхшээлтэй хүн. Одоо эхнэр гурван хүүхэдтэйгээ хамт амьдардаг. Түгээмэл Хөгжил төвд ажилладаг, төвийн үүсгэн байгуулагчдын нэг нь байгаа юм. Уг нь би Япон хэлний багш, орчуулагч мэргэжилтэй. Гэхдээ мэргэжлээрээ ажиллаагүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн салбарт ажилласан туршлагатай.

Та Түгээмэл Хөгжил төвийнхөө талаар дэлгэрүүлээд танилцуулахгүй юу?

Би 2008 онд Япон улсад Ази, Номхон Далайн бүсийн орнуудын хөгжлийн бэрхшээлтэй залуучуудыг суралцуулдаг 1 жилийн хөтөлбөрт хамрагдсан. Тэр хөтөлбөрт хамрагдаад явж байхдаа дэлхийн олон улсад хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах эрх гэдэг тогтолцоо байдгийг анх олж мэдсэн. Тэр тогтолцоог Японд байхдаа илүү их судалж, Монгол улсад яах аргагүй хэрэгтэй, цаашдаа хэрэгжүүлэх ёстой

систем юм байна гэж бодсоны үндсэн дээр буцаж ирээд одоо хамт ажиллаж байгаа хүмүүстэйгээ энэ байгууллагыг үүсгэн байгуулж байсан. Монголд анх бие даан амьдрах эрх, бие даан амьдрах тогтолцоо гэдэг зүйлийг бий болгох зорилготой үүссэн байгууллага. Одоо бидний зориод байгаа тогтолцоо маань хууль эрх зүйн хүрээнд суусан гэхдээ хэрэгжилт нь амьдрал дээр хараахан буугаагүй байна. Түгээмэл Хөгжил төв энэ тогтолцоог бий болгохын тулд гишүүнчлэл үүсгэж, гишүүдийнхээ эрхийг хамгаалах чиглэлээр ажилладаг. Манайх 18 ажилтантай, тэдний 11 нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байдаг. Үйл ажиллагаагаа 4 чиглэлд зохион байгуулж ажилладаг. Задлаад яривал маш их цаг авах учраас товчхондоо бол ийм байгууллага байдаг.

Монгол Улсад бие даан амьдрах төв, бие даан амьдрахын тогтолцоо гэдэг бол шинэ ойлголт гэж би бодож байна. Тэрнээс өмнө тийм байгууллага, ойлголт Монголд байгаагүй юу?

Огт байгаагүй. Хүмүүс сонсоход хөгжлийн бэрхшээлтэй хүн бие дааж амьдрах гэсэн ерөнхий дүр зураг буудаг. Би ч гэсэн анх Японд энэ тогтолцоо системийг үзэж танилцаж байсан. Намайг Японд суралцаад, буцаж ирээд энэ байгууллагыг байгуулаад байж байхад төрийн байгууллагын зарим хүмүүс та нарын зорьж байгаагаар бол би ч гэсэн бие дааж хараахан амьдарч эхлээгүй байна гээд л шууд утгаар нь хүлээж авч, гайхаж байсан. Тэгэхээр яах аргагүй шинэ үзэл, ойлголт юм байна.

Дэлхий нийтэд ч гэсэн сүүлд гарч ирсэн үү?

Ер нь бол энэ түүхийг нь яривал их сонирхолтой л доо. Дайны дараа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал илүү их яригдаж эхэлсэн байдаг. Ялангуяа Япон, Азийн орнуудад дайны уршгаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс их бий болсон. Тэр хүмүүсийг яах вэ гэдэг асуудал улс орон бүрийн толгойн өвчин болж ирсэн. Жишээлбэл Японд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тусгай байдлаар асрамжлах төвд байрлуулж, тэндээ насаар нь амьдруулах зорилготой тогтолцоо хийгдэж байсан бол 1960 оноос эхлээд эрхийн хөдөлгөөнүүд үүсэж эхэлсэн. Хүмүүс энэ тогтолцоог эсэргүүцэж “Бид нар хүний биеийг олж төрчхөөд ийм шорон шиг хаагдмал ертөнцөд амьдарч бусад хүмүүсийн адил аз жаргалыг мэдрэх боломжгүй байна” гэдэг юмыг хүмүүс гаргаж эхэлж байсан. Энэ үед харамсалтай нь нэлээн хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ ээж нь өөрийн гараар үгүй хийсэн асуудал Японд гарсан байна. Тэр асуудал шүүхэд очоод нэлээн их яригдсаны үр дүнд нөгөө ээжийг цагаатгасан шийдвэр гарсан. Яагаад гэвэл тухайн ээж “миний хүүхэд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй. Би өөрөө бас хүнд өвчтэй хүн. Би хүүхдээсээ түрүүлээд байхгүй болчихвол миний хүүхэд надаас хойш ийм харгис, хэцүү нийгэмд амьдрахад бүр хэцүүднэ гэдэг утгаараа би өөрөөсөө өмнө үгүй хийчихлээ” гэж ярьсан юм байна. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудалд том цочроо болж,

хөдөлгөөн эхлүүлэх тулах эх үүсвэрийг нь тавьжээ. Яагаад төр ийм зүйлийг хүлээн зөвшөөрч байгаа юм бэ?

Төр хоёр зүйлийн нэгийг нь хийх хэрэгтэй юм байна. Нэг бол хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэг зүйлийг ер нь байхгүй болгоё, төрүүлэхгүй болгоё, устгая. Эсвэл бид нар бусад хүмүүстэй яг адилхан нийгмийн амьдралд эрх тэгш оролцох хэрэгтэй байна гэдэг утгаараа Японд 1960-70 оноос эхлээд Японыг цочроосон том том хөдөлгөөнүүд гарч эхэлсэн. Гэхдээ ийм төрлийн хөдөлгөөн дэлхийн ихэнх оронд тус тусдаа асуудалтайгаар яг ижил явагдаж байж. Энэ хөдөлгөөнүүд дэлхий даяар явагдсаар бие даан амьдрах эрх гэдэг зүйлийг гаргаад ирсэн юм байна. Тэгэхээр улс орон бүрд адилхан шинэ үзэл хандлагаар эхэлсэн ч гэсэн бүгдийн хэрэгцээ, шаардлага нь яг адилхан байсан. Хүмүүс асрамжид байхгүй, нийгмийн амьдралд гаргахын тулд олон асуудал хэрэгцээтэй. Байр орон сууц, амьдрах орчны хүртээмж, боловсрол эзэмших, ажил хөдөлмөр эрхлэх гэдэг үндсэн хэрэгцээ нь хүний эрхэм нандин чанар гэдэг зүйлээ мэдрээд, яг хүний дайны амьдрахад төрийн олон дэмжлэг, тогтолцоо хэрэгтэй гэдгийг гаргаж ирсэн байх.

Тэгэхээр Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг гэр бүл нь л ер нь харж ханддаг шүү дээ. Танай төв үйл ажиллагаагаа явуулсан энэ 11 жилийн хугацаанд Монголд ямар өөрчлөлтүүд гарсан бэ?

Би анх гэмтэл аваад, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлгөөнд идэвхтэй оролцож эхэлсэн үеэ эргээд харвал маш их өөрчлөлт гарсан. Нэгдүгээрт, нийгмийн сэтгэлгээний хувьд ч гэсэн төрийн бодлого, үйл ажиллагаанд ч гэсэн өөрчлөлт гарсан. Хоёрдугаарт, өөрчлөлт орж байгаа зүйл бол эрх зүйн орчин. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өөрсдийнх нь идэвх оролцоо, хөдөлгөөн нэмэгдсэнийх байх. Нөгөө талаасаа олон улсын төвшинд нэгдсэн ойлголт, хандлагыг бий болгох эрх зүйн бичиг баримтууд гарч байгаа. Гуравдугаарт, улс орны нийгмийн хөгжил эргээд хүний сэтгэлгээнд бодит зүйлс дээр өөрчлөлтийг оруулж байна. Харамсалтай нь хангалттай биш байна. Цаг тухайдаа бодитойгоор хэрэгжих ёстой зүйлс маань амьдрал дээр буух нь удаан байгаа нь тиймхэн ч гэсэн өөрчлөлт бол орж байгаа.

Одоо танай төвөөс бие даан амьдрах тогтолцооны төсөл хөтөлбөрт оролцоод, бие дааж амьдарч байгаа хүмүүс байгаа юу?

Их сайхан асуулт байна. Бид нар өөрсдөө бие даан амьдрах тогтолцооны талаар өргөн ойлголттой. Амьдралд нэн шаардлагатай энэ системийг бий болгохоор зорьж байхдаа өөрсдөө бодитоор харуулах ёстой юм байна гэдгийг ойлгосон. Эхэндээ бид дандаа нийгэмд таниулах ажлуудыг хийдэг байсан. Явц дундаа системийг бий болгох ёстой гэдэг лүү их анхаарч эхэлсэн. Гуравт нь зориод байгаа тогтолцоогоо

бусдад ялангуяа бий болгох гээд байгаа төрийн байгууллагууддаа харуулах хэрэгтэй юм байна гэж үзээд олон загвар төслүүд боловсруулж байна. Эдгээр үндсэн загвар төслийн нэг нь нэлээн хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй, хүний дэмжлэг туслалцаа шаардлагатай, нийгмийн амьдралд оролцох, үйлдэл хийх боломжтой 3 залууг сонгож авааД гэр бүлтэй нь ярилцаад бие даан амьдруулж байна. Нэлээн хүнд гэмтэлтэй залуус учраас 3 залуу маань бие даахын хэрээр олон асуудал үүсэж эхэлнэ.

Энэ үед Монголд туслах тогтолцоо гэж тэр хүнтэй огт хамааралгүй хүнийг сургаж хөгжүүлээд, цагийн ажилтан болгоод, цалин урамшууллын тогтолцоог нь бий болгоод, дүрэм журмыг нь гаргаад тэр залуучуудын хэрэгцээтэй үед нь туслуулдаг. Туслалцаа авахаас гадна гэмтэл бэртэлтэй байсан хүмүүс чинь нийгмийн амьдралд эргээд ороход сэтгэл зүйн хувьд дасан зохицохын тулд олон асуудал хэрэгтэй учраас тэрийг дэмжих үйлчилгээнүүдийг бий болгож байна. Жишээ нь бие даан амьдрах хөтөлбөр болон пийр коунслинг гэж ярьдаг үйлчилгээнүүдийг хамт явуулж байна. Залуучууд маань бие дааж амьдарч байгаа учраас хөгжиж, чадваржаад ажил хөдөлмөр эрхлэх ёстой. Ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүс нийгмийн харилцаанд орж үүрэг хүлээж, сонголт хийж, түүнийхээ дагуу үүрэг хариуцлага хүлээгээд амьдарна гэсэн үг. Ийм хэд хэдэн жишээнүүд байна. Өөрөөр бол орчныг хүртээмжтэй болгож, яаж хүртээмжтэй болгож байгаагаа харуулахад чиглэсэн янз янзын нөлөөллийн ажлууд болон бодит кэйсүүд хийж байна. Мөн олныг хамарсан буюу бие дааж амьдарч эхлээгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг цаашид бие даан амьдрахад нь бэлтгэх буюу үүрэг хариуцлага, сонголт, шийдвэртэй амьдрах чадварт сургах ажлуудыг хийж байна. Бие даан амьдрах эрхийн хүрээнд нийтдээ 4 төсөл явагдаж байна.

Энэхүү төслүүд хаанаас санхүүжиж, хөрөнгө мөнгө нь шийдэгдэж явдаг вэ?

Энэ тогтолцоо Монголд шинэ ойлголт байсан учраас шууд дэмжье, санхүүжүүлье гэдэг юм байхгүй байсан учраас бид олон улсын дэмжлэг туслалцаа авах хэрэгтэй болсон. Түгээмэл Хөгжил төв дэлхийн бие даан амьдрах төвийн сүлжээ, Ази, Номхон Далайн орнуудын бие даан амьдрах сүлжээ, ойр дотно ажилладаг 7 орны сүлжээнд байдаг. Нэгдүгээрт, энэ сүлжээнүүдээсээ арга зүйн болон санхүүгийн дэмжлэг авдаг. Хоёрдугаарт, нэг үеэ бодвол Монгол Улсад олон улсын сангууд, олон элчин сайдын яам хүний эрхэд суурилсан системийг дэмжиж санхүүжилт олгодог болсон. Бид нар Канадын сан, Ай Фо олон улсын байгууллага, нээлтийн нийгмийн хүрээлэн, Германы хамтын ажиллагааны нийгэмлэг зэрэг газруудаас санхүүжилт авч байсан. Гуравдугаарт, манай бие дааж амьдарч байгаа залуучууд өөрсдөө хүчин зүтгэл гаргаж янз янзын ажлыг гардан зохион байгуулж санхүүжилт босгож байна.

Хүн чинь яг амьдралд оролцоод өөрт нь

янз янзын бэрхшээлтэй асуудал тулгарах тусам улам чадваржиж, улам хатуужиж байдаг юм байна. Тэгэхээр манай залуучууд яван чангараад, улам сайжраад л, мөн өөрсдийнхөө эрхийг хамгаалахад юу хийх ёстойгоо ойлгоод ирэхээрээ хүний нийгэмд бий болгох, байх ёстой зүйлсээ өөрсдөө таниад эхлэхлээрээ зарим ажил аяндаа ингээд жигдэрдэг юм байна. Ганцхан мундаг залуучуудын үр дүнд биш ч юм байна, бас тэрийг дэмжиж байгаа хамт олон, туслах үйлчилгээ хийж байгаа залуучууд гээд л олон хүмүүсийн оролцооны үр дүнд л ийм болдог юм байна.

Та нар цагийн ажил маягаар явдаг хувийн туслах гээд залуучуудын талаар ярьж байгаа шүү дээ. Энэ хүмүүсээ яаж сургадаг вэ?

Анх хувийн туслах гээд цөөхөн залуучууд эхлээд явж байхад их сонирхолтой юм болдог байсан. Нэгдүгээрт, хамт олон, гэр бүлийнхэн нь дургүйцэх. Зарцын, боол хүний ажил юм шиг санагдаж дургүйцэх, эсэргүүцэх, болиулах гэдэг. Эсвэл найз нөхөд нь чи зарц боолын ажил хийж байгаа юм уу гээд шоолдог. Хоёрдугаарт, хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй харилцаж, ажиллаж үзээгүй хүмүүс хувийн туслах гэж юу вэ гэдгээ мэдэхгүйгээс болоод буруу



ойлголт үүсдэг байсан. Тэгээд тэднийг сургаж, ойлголт хандлагыг нь нэмэгдүүлэх ёстой юм байна гээд хоёр чиглэлд ажиллаж байна. Нийгэмд чиглэсэн хандлага өөрчлөх нөлөөллийн ажлууд хийж байна. Тэр нь ажил гэхээсээ илүү хөгжлийн бэрхшээлтэй хүн яагаад нийгмийн амьдралд оролцох ёстой юм, тэрний үр дүнд бусад хүн, нийгэм хэрхэн яаж хождог юм. Мөн оролцуулахын тулд бид нарт юу хэрэгцээтэй байна гэдэг талаас нь яриа, таниулга, лекцийн ажил сургуулиудаар явж хийдэг. Үүний үр дүнд залуучууд та нарын ажлыг сонирхож байна эсвэл би оролцъё гээд хүрээд ирдэг. Тэр үед нь техникийн сургалт гэж ярьдаг илүү мэргэжлийн онол, практик хосолсон 2 хоногийн албан ёсны сургалтаа эхэлдэг. Тухайн сургалтыг хангасан залуучуудаа албан ёсоор хувийн туслах гээд, цагийн ажилтан болгоод явдаг. Олон улсад ч гэсэн яг энэ системээр явагддаг сургалтын хөтөлбөрүүд байдаг. Бид нар Японы сургалтын хөтөлбөрийг илүү нутагшуулах маягтайгаар зохион байгуулаад хэрэгжүүлдэг.

Одоо 3 залуу бие даан амьдарч байгаа гэсэн шүү дээ. Тэгэхээр энэ залуус хэр хугацаанд бие даан амьдарч байгаа вэ? Мөн амьдралыг болон ертөнцийг харах, нийгэмтэй харьцах үзэл хандлагад нь ямархуу нөлөө гарсан гэж та дүгнэж байна вэ?

Энэ гурван залуугаас маань гадна гэр бүлтэйгээ амьдардаг ч гэсэн ээж аав, гэр бүлээсээ дэмжлэг авахгүй, хувийн туслах үйлчилгээ аваад ажил төрөл, нийгмийн амьдралд оролцдог хэд хэдэн залуучууд байгаа. Туслах үйлчилгээ аваад өдөр тутмын нийгмийн амьдралд оролцдог 10 гаран залуучууд байна. Оюутан голцуу нийт 40 орчим залуучууд цагийн ажил хийж байна. Тэр сүүлийн асуулт их сонирхолтой асуулт байна. Би сүүлд бодож байхад надад энэ ажлыг хийхэд сайхан зүйл тохиолдоно мэдээж хэрэг хэцүү бэрхшээлтэй зүйл тулгарна. Тэр болгонд ажлаасаа сэтгэл ханамж авах нэг зүйл бол саяны асуултын хариулт юм байна.

Нэг удаа ажилдаа ороод ирсэн чинь манай гишүүд ирчихсэн оффис маань дүүрэн пижигнээд л, зарим нь тэнд ажил хийгээд л, зарим нь дуу шуу болоод л, тоглоод л, наргиан хийгээд л. Тэр дунд хөгжлийн бэрхшээлгүй цагийн ажилтан, сайн дурын залуучууд оффист битүү байна аа. Анх хөгжлийн бэрхшээлтэй залуучуудтай дөнгөж танилцаж байхад юун ярилцах, гэр орноосоо гарах дургүй, хөгжлийн бэрхшээлээс үүдсэн хүндрэл бэрхшээл, сэтгэл зүйн айдастай байгаа нь хэд хэдэн залуучуудын харцанд нь л ойлгомжтой байдаг байсан. Гэтэл одоо тэд нар маань ийм идэвхтэй тэр том оффисыг зохион байгуулаад, ажлыг удирдаад, уур амьсгалыг маш хөгжилтэй болгоод сайхан байлгаж байна. Тэр уур амьсгал, нөхцөл байдлыг харахаар нэг их сайхан санагдаж энэ л миний сэтгэл ханамж юм байна даа гэж бодож байсан.

Хөгжлийн бэрхшээлтэй болоод харамсаад үхчихмээр ч юм шиг, амиа хорлочихмоор ч юм шиг тийм үе надад ч гэсэн байсан.

Одоо тэр үе аль хэдийнээ байхгүй болчихсон. Одоо бусад хүнтэй адилхан үүрэг хариуцлага, ажил амьдралтай, бэрхшээл зовлон дунд холилдоод, бусдын л адил байгаа байдал маань миний хувьд зорилго байсан юм байна гэж бодсон. Одоо бол манай залуус тэгж өөрчлөгдөж. Одоо бусад залуучуудыг бас татаж өөрсөд шигээ болгох. Тэдэнд юу хэрэгтэй, түүнийг яаж бэлтгэх ёстой вэ гээд бодоод, зориод ажиллаж байгаа байдлыг нь харахад маш их өөрчлөлт орж гэж хардаг.

Та 10 гаруй жилийн хугацаанд төвөө удирдаад явж байхад нэлээн л хүндрэл бэрхшээл гарч байгаа байх. Хүндрэл бэрхшээлүүд хаанаас гарч байна гэж та боддог вэ?

Нийтлэг 2 зүйлээс үүсдэг юм шиг санагддаг. Нэгдүгээрт, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд яг өөр өөрийнхөө зорьсон тус тусынхаа ажлыг хэрэгжүүлэхэд нийгмээс ирж байгаа сөрөг хандлага яах аргагүй байдаг. Буруу ойлголт, хандлагаас үүдсэн үйл ажиллагаанд нь төвөг болох, бодит хэрэгжүүлэх үйл ажиллагааг нь сааруулдаг хандлага. Эсвэл хөрөнгө босголт, үйл ажиллагаанд энэ нийгмийн хандлага бодитоор сөрөг нөлөө үзүүлдэг. Нөгөөх нь менежментийн асуудал. Жишээлбэл манай байгууллага бие даан амьдрах эрх гэдэг зүйлийг анх бий болгосон. Ямар ч туршлагагүй хүмүүс нэгдэж шинэ системийг бий болгохын төлөө ажилласан учраас бидний хувьд эхэн үедээ арга туршлага, санхүүжилт, өдөр тутмын байгууллагын менежмент гэж ярьдаг зүйл дутагдаж байсан. Хэдий төрийн бус байгууллага ч гэсэн бид нар яг л бизнесийн байгууллага шиг менежмент, маркетинг, удирдлага, бүтцийн үйл ажиллагааны зохион байгуулалт хийж байж ажил маань амжилттай урагштай явах юм байна. Тийм зүйл бидэнд алхам тутамд нь байгаагүй. Бид нар өөрсдөө алхам тутамдаа суралцах хэрэгтэй болсон. Тэгээд энэ маань бол яахав тодорхой хэмжээний бэрхшээл байсан. Үйл ажиллагаа бүх л зүйлээ өөрсдөө зохион байгуулж хэрэгжүүлдэг болохоор ямар нэгэн тогтсон төсөвгүй, санхүүжилтээ өөрсдөө босгодог учраас санхүүгийн асуудал бас нэлээн их асуудал үүсгэдэг байсан.

Японы бие даан амьдрах төвүүд хаанаас санхүүжиж явдаг юм бэ?

Улс орон болгонд эхэн үедээ яг л адилхан бэрхшээл тулгардаг юм байна. Шууд төрийн бодлого тогтолцоонд ийм систем байхгүй учраас эхэн үедээ үүнийгээ төрд таниулахын тулд хөрөнгө босголт хийх гэж маш их үздэг. Бид ч бас адилхан арга зарчмаар яваа юм байна гэж үздэг. Би Японд суралцаж байх хугацаандаа 4 бие даан амьдрах төвөөр явж үзсэн. Тэд 2-3 төрлөөр санхүүжилт босгодог юм байна. Нэгдүгээрт нь хувийн туслах үйлчилгээ, зөвлөх үйлчилгээ, пийр коунслинг, бие даан амьдрах гэдэг зүйлс маань бүгд төрийн бодлогод байдаг, төрийн хэрэгжүүлэх ёстой үйлчилгээ юм. Тэгэхээр эдгээр үйлчилгээг төртэй гэрээлэх маягаар хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа

хэрэгжүүлж дуусаад төрөөс санхүүжилтээ авдаг. Тэр дундаас менежментийн аргаар байгууллагын урсгал зардлыг гаргаж байдаг. Хоёрдугаарт бие даан амьдран төвүүд сүүлийн үед сошиал энтерпрайс гэж яриад байгаа нийгмийн бизнесийн үйл ажиллагаа эрхэлж байна. Жишээлбэл 1 бие даан амьдрах төв 1 нийгмийн байгууллагатай хамтарч усан үзмийн тариалан эрхлээд, тэндээсээ тодорхой хувиар нь өөрсдөө түүхий эд аваад, вино үйлдвэрлээд, зарж бордуулах, тэгээд эргүүлээд олсон ашгаа үйл ажиллагаандаа зарцуулдаг. Эсвэл памперс үйлдвэрлээд ахмад настангуудад хуваарилдаг. Зарим нэгэн бие даан амьдрах төвүүд тухайн хотынхоо вэб сайтыг нь хөтөлж байдаг. Эсвэл компьютертой холбоотой санхүүгийн тайлан тооцоо бүх зүйлийг нь хийдэг үйлчилгээ үзүүлж тодорхой хэмжээний санхүүжилт босгож байдаг гээд л янз янзын хэлбэрээр сошиал интерпрайс хэлбэрээр бизнесийн үйл ажиллагаа хийж байдаг. Танай байгууллага, аж ахуйн нэгж, байшин чинь яавал хүн болгонд хүртээмжтэй болох вэ гэдэг дээр нь зөвлөгөө өгдөг үйлчилгээ, тоног төхөөрөмжийг нь зааж өгдөг нэг сонирхолтой байгууллага байсан. Сүүлийн үед Япон ийм хүртээмжтэй байдлаараа өрсөлдөж, маркетинг хийдэг болсон. Тэгэхээр яг үүн дээр нь зөвлөгөө өгөөд, сургалт зохион байгуулаад, танилцуулах гээд янз янзын аргаар л санхүүжилт босгож байна. Тэгэхээр бид нар ч гэсэн тэрийг туршиж үзэж байгаа. Нэгдүгээрт үйл ажиллагаа үйлчилгээгээрээ хөрөнгө босголт хийх. Хоёрдугаарт нь нийгэмд аж ахуйн нэгжүүдэд хандсан сургалт, зөвлөгөө өгөх ажлыг хийж байна.

Та сая их гоё жишээнүүдийг хэллээ. Монголд бол хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэхээр гэртээ гэрийнхнийхээ асаргаанд байж байдаг, ажил хөдөлмөр эрхэлдэггүй гэсэн ойлголт давамгайлдаг. Тэгэхээр Японы жишээ бол хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажил хөдөлмөр эрхлээд, нийгмийн харилцаанд мундаг, идэвхтэй оролцож байгааг харуулсан маш гоё жишээнүүд байна. Таны зүгээс төлөвлөж байгаа ажлууд юу байна?

Бид нар зориод байгаа системээ бодитоор бий болгох. Энэ систем бий болчихвол маш олон хүмүүс хэн нэгэн хүнийг харахгүйгээр өөрийнхөө эрх чөлөө, хүслээрээ сонголт хийн нийгмийн амьдралд бодитоор оролцох боломжтой болно. Энэ бол хийсвэр зүйл бол биш, ямар нэгэн онол бол биш. Тэгэхээр шинэ үйлчилгээнүүдийг Монголд бий болгохыг зорьдог. Үүний үндсэн дээр хүмүүс нийгмийн амьдралд оролцоод ирэхээр аяндаа өөрсдөө чадваржиж, үүрэг хариуцлагаа ухамсарлаж эхэлдэг. Ажил хөдөлмөр эрхлэх, боловсрох хөгжих асуудлаа өөрсдөө шийдээд эхэлдэг. Ойрын хугацаанд зорьж байгаа бас нэг зүйл маань гэвэл хөдөлмөр зуучлал. Хувийн туслах үйлчилгээ, бие даан амьдрах эрх гэдэгт заавал хөгжлийн бэрхшээлтэй бүх хүн хамрагдах шаардлагагүй л дээ. Өөрөө бие даан амьдралд оролцох, үйлдэл хийх боломжтой хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс шууд боловсрол

эзэмших, ажил хөдөлмөр эхлэх боломжтой байдаг. Харин тэд нарт хэрэгцээтэй нэг зүйл нь тэднийг хөгжүүлээд, зуучлаад ажлын байранд хүргэх гэдэг асуудал Монголд дутмаг байгаа. Сүүлийн үед хэсэг төрийн бус байгууллагууд ярилцаад, энэ ажлыг бид хийх гээд зорьж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хөгжүүлээд, зуучлахаас гадна аж ахуйн нэгжид ойлголт өгөх, аж ахуйн нэгжийг хөгжлийн бэрхшээлтэй хүнийг авах дуртай болгож сонирхол хүслийг нь өдөөх хэрэгтэй байна. Тэгээд яавал тэд нарт хүсэл төрүүлж болох вэ? гэдгийг судалж, туршиж үзэж байна. Ганц хоёр ажил хийж үзсэний зарим нь амжилттай болж байна. Энэ зүгээр нэг зуучлалын үйл ажиллагаа биш. Хүнийг хөгжүүлээд, ажлын байранд нь тогтвортой байлгахад нь дэмжээд, эргүүлээд аж ахуйн нэгжийг нь бас ойлголт хандлагыг нь сайжруулж дэмжих юм. Энэ дунд нь төрийн бодлого, үйл ажиллагааг холбох ажлыг төлөвлөж байна.

Таны хийсэн судалгааг харж байхад төрийн албан хаагч нарын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх ойлголт бага байдаг гэж бичсэн байсан. Төрийн албан хаагч нарын ойлголтыг яаж нэмэгдүүлэх вэ?

Наадах чинь бас зөв л асуудал байна. Ер нь бол яах аргагүй дутмаг байдаг. Хөгжлийн бэрхшээл, хүний эрхийн тухай суурь ойлголтыг багаас нь боловсролоор олгодоггүй учраас бид нар чинь насанд хүрсэн хойноо огт ойлголт мэдлэггүйгээр ийм зүйлтэй шууд тулгардаг. Ийм зүйлд тухайн хүн яг юунд чиглэж ажиллах гэж байгаагаа ухамсарлаад, ойлгож мэдээд орвол хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь бодитой болгох юм байна гэж бодсон. Хүн нийгэмд заавал бүх зүйлийг төгс мэддэг байх шаардлагагүй. Төрийн зарим үйл ажиллагааг тухайн чиглэлээр мэргэшсэн төрийн бус байгууллага гэрээлэн гүйцэтгэдэг байвал энэ яриад байгаа зүйлийг нөхөх боломжтой юм байна гэж би судалгаанаасаа олж харсан. Тэгээд бүх зүйлийг төр дангаараа толгой дээрээ авч хийх биш, үүрэг, хариуцлагаа хуваарилаад, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, тухайн чиглэлдээ мэргэшсэн хувь хүн, мэргэжилтнийг гэрээлээд гүйцэтгүүлдэг байвал сая яриад байгаа тэр дутмаг зүйл маань нөхөгдөх боломжтой.

Та паблик прайвейт партнершипийг / public private partnership/ хэлж байна уу?

Тийм, орчин үед бас нийгмийн эгэх хариуцлага ч гэж яриад байна.

Та эгэх хариуцлагын талаар дэлгэрүүлж ярьж өгөөч?

Би үүнийг яг судалсан, гаргаж ирсэн ч юм биш. Энэ маань Монгол Улсад Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгээр хэрэгжсэн нэлээн том төсөл. Энэ төслийг харж байгаад яах аргагүй хэрэгцээтэй зарим зүйлсийг нь би судалгаандаа татаж оруулсан юм. Миний ойлгосноор эгэх хариуцлага гэдэг нь үүрэг хариуцлага, хяналт, харилцан ярилцах,

ойлголцох, хариу үйлдэл үзүүлэх гэсэн нэг ийм 4 процессыг хэлдэг юм байна. Хөгжлийн бэрхшээлийн салбарт жишээ авч ярья. Урьд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг хувь хүн бөгөөд түүний гэр бүлийн асуудал гэж үздэг байсан. Шууд л гэр бүлд нь нялзайдаг. Орчин үед бол нийгмийн хариуцлага байсан гэдэг утгаараа нийгмийн хариуцлагыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд, төлөөллийн байгууллагууд төртэй хамтарч ажиллах, өөрсдийнхөө асуудлыг төрийн үйл ажиллагаанд тусгах, тэрийгээ хэрэгжүүлэхийн тулд харилцан ярилцах, аль аль талдаа хариуцлага хүлээх, аль аль талыгаа хянах, хариу үйлдэл буюу тэрэн дээр нь үндэслэсэн хэрэгцээтэй үйлчилгээг нь үзүүлэх маягийн механизмыг ойлгох юм байна. Ер нь иймэрхүү асуудлыг л хөнддөг юм байна даа гэж бодсон. Хэн нэгний үүрэг хариуцлага гээд орхихгүй төр, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн хамтын ажиллагааны циклийг л хэлдэг юм байна. Түүнээс гадна иргэдийн оролцоо, хяналт, зохион байгуулалт маш чухал болж ирдэг гэдгийг судалгаан дээр танилцуулсан байсан.

Би тэндээс зарим асуудлыг нь өөрийнхөө



судалгаанд иш татаж оруулсан юм. Судалгаа хийж байхад бас нэг сонирхолтой асуудал гарч ирсэн нь нэг эрдэмтэн тодорхойлолт хийсэн байсан. Тухайн нийгмийг ямар нийгэм байна вэ? гэдгийг шатлал гэдэг юмаар харуулсан байсан. Миний санаж байгаагаар нэгдүгээрт нь нийгэм үл оролцоо буюу заах, эмчлэх шаттай. Жинхэнэ оролцоог орлуулах гэж бий болгосон үе шат. Энэ шат манайд өнгөрч байгаа үе болов уу гэж бодож байна. Хөгжлийн бэрхшээлийн салбартаа дахиад жишээ авъя. Төрөөс хөгжлийн бэрхшээлтэй хүнд заах, сургах, эмчлэх асуудал голлодог. Тэгвэл төлөвлөх, үйл ажиллагаа хэрэгжүүлэх, эмчлэх, заах, сургах зүйлдээ төрийн талаас голлох учраас иргэд, үйлчилгээ авч байгаа хүмүүс оролцдоггүй юм байна. Ийм нийгмийг үл оролцоо буюу заах, эмчлэх үе шат гэдэг гэнэ. Хоёрдугаар үе шат нь хэлбэрдэх, дүр үзүүлэх үе шат байдаг. Энэ нь арай жаахан ахисан шат бөгөөд мэдээллийн чиг урсгалыг хүмүүст өгөхдөө тэднээс санал асуулга авдаг. Тэгэхдээ хэдэн хүн оролцуулсан, хэдий хэмжээний юмнуудыг хамруулсан гэвэл тоо баримтыг чухалчилж, эцсийн шийдвэрийг төр өөрөө гаргадаг. Гуравдугаар үе шат бол жинхэнэ иргэний засаг буюу түншлэл төлөвлөсөн бүрэн эрх. Энэ үе шат маань яг эгэх хариуцлага юм шиг байна. Яг төр болон иргэд хамтран циклд оролцож хэн хэн нь үүрэг, хариуцлагатайгаар хэн хэн нь бас ярилцаж зөвшилцсөний үр дүнд үйл ажиллагааг бий болгодог.

Манайх хоёрдугаар үе шатанд явж байгаа юм шиг санагддаг. Сүүлийн үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хамаарч байгаа маш олон хууль эрх зүйн баримт бичиг гарч байна. Үүндээ бид нарыг оролцуулж, бид нараас асууж байгаа нь сайн тал. Тоо баримтад тэдэн байгууллагыг оролцуулж, тэдэн хүнийг хамруулаа гээд бид нарыг дурдаж байгаа ч харамсалтай нь эцсийн шийдэл дээрээ оролцуулдаггүй. Нөгөө сайхан хууль эрх зүй нь цаасан дээр байгаад байдаг, бодит амьдрал дээр бууж өгдөггүй. Манайх хууль эрх зүйгээр ярих юм бол Азийн орнуудтай харьцуулахад дээгүүрт орох байх. Тэгэхээр манайх одоо хэлбэрдэх, дүр үзүүлэх үе шатанд байгаа юм уу даа. Сая асуудаг эгэх хариуцлага маань бодитоор амьдралд хараахан хэрэгжээгүй байгаа зүйлсээ хэрэгжүүлэхийн төлөө зорихыг хэлэх байх.

Сая танаас Түгээмэл Хөгжил төвийн тэргүүний хувиар олон асуулт асуулаа. Одоо иргэн Ундрахбаяр гэдэг хүнийх нь хувьд асуулт асуумаар санагдаж байна. Та хүсэл мөрөөдлөө хуваалцахгүй юу?

Хүсэл мөрөөдөл гэвэл их айхтар албархуу яриа болчих гээд байдаг юм. Би нэлээн залуу яг ид хүсэл мөрөөдөлтэй болдог насан дээрээ гэмтэл аваад, маш их цочроод ямар нэгэн алсын хараа, бодож байсан бүгд л унтарч байлаа. Дахиад сэтгэл санаа, бие эрхтний хувьд сэргээд, дахиад л шинэ хүсэл мөрөөдөлтэй болж л дээ. Тэгж байх үед нь аз болж гэр бүлийнхээ дэмжлэгээр сургуульд суралцсан. Мөн боломж гараад Японд суралцаж байхад нөгөө юм маань бүр илүү лавширч байсан. Тэр мөрөөдөл

юу байсан бэ гэвэл нэгдүгээрт би хүний дайны амьдрах ёстой юм байна. Тэгэхийн тулд надад ийм тогтолцоо систем, орчин нөхцөл хэрэгтэй юм байна. Түүнийг бий болгохын тулд яах аргагүй миний энэ ажлыг хийх хэрэгтэй юм байна. Тэгэхээр яг л Япон, Солонгос, Хятад, Герман, Америкт байдаг тэр жишээг л Монголд бий болгох нь миний хүсэл сонирхол юм даа. Яг л тэр зүйлийг эрх зүйн төвшинд, бодит амьдрал дээр Монголд бий болгох юм даа гээд жоохон сүртэй, албархуу юм хүсдэг. Өөр хувийн сонирхол гэвэл би их этгээд юм хүсдэг. Би өөрөө их өндөр юманд дуртай. Өндөр уул, байгаль орчин их сонирхдог. Өндрөөс үсрэх, шүхрээр буух гээд хараахан эхлүүлээгүй байгаа ч гэсэн иймэрхүү юмыг их сонирхож үздэг. Уулын цана энэ тэр гээд ганц нэгийг нь туршиж үзсэн.

Та яагаад, юунаас болж гэмтэл авсан юм бэ?

Маш товчхондоо бол тухайн эмчийн маань эмчилгээний тактикийн алдаанаас болоод нуруу нугасны гэмтэлтэй болох шалтгаан болсон. Эхэндээ тархины гэмтэл аваад тухайн үед оюутан байхдаа ажил төрөл хийгээд явж байгаад бас ядаргаанд орсон байсан. Энэ нь тархины менингит гэж болдог юм байна л даа. Тэгээд тархины менингитээр нэлээн хүндээр өвчилсөн үед нуруунаас нугасны ус гэж авдаг. Тухайн эмч маань тактикийн алдаа гаргаад бас жоохон ур чадвар, сэтгэл дутсан гэж үздэг. Одоо бол би үүний тухай огт бодож харамсдаггүй. Тухайн үедээ хэцүү байсан, тэгээд энэ байдалдаа дасан зохицоод ч тэр үү мартагдчихаж.

Тухайн үедээ яг тархины гэмтэл авсан гэдгээ мэдэхгүй явж байсан уу? Эсвэл тоохгүй явж байсан уу? Яг юу болж байсан бэ?

Залуучууд, хүүхдүүд янз янзын гэмтэл бэртэл авч л байдаг гэсэн нэг тийм хайнга хандлага байдаг шүү дээ. Тэрний л нэг хэлбэр л байсан. Онцлог нь гэмтэл авснаа мэдэхгүй удааж хүндрүүлээд, дээрээс нь ядаргаа нэмэгдээд тархины менингит болоод эмчлэгдээд эдгэрчихсэн байсан. Тэр үед нь л тактикийн алдаанууд гарч ирсэн юм шиг байна лээ.

Миний асуух гэсэн зүйл гэвэл Монголд токсик маскулинити /toxic masculinity/ гэж ярьдаг шүү дээ. Эрэгтэй хүн өвдсөн ч өвдсөнөө бараг хэлэх ёсгүй, сэтгэлээр унасан ч гэсэн чи юу гэж шалчганаад байгаа юм гэдэг нэг тийм хандлага байдаг. Монгол эр хүн гэж өвчин ярьдаггүй, гүндүүгүй эрэгтэй хүнийг хэлнэ гэсэн тийм хандлага нийгэмд харагддаг шүү дээ. Би хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн статистик харахад эрэгтэй хүмүүс илүү их бэртэж гэмтсэнээсээ болоод хөгжлийн бэрхшээлтэй болж байгаа тоо баримт их харсан. Тэгэхээр та энэ токсик маскулинити гэмтэл аваад цаашид хөгжлийн бэрхшээлтэй болоход нөлөөлж байгаа гэж боддог уу?

Магадгүй, байгаа байх. Яг би тийм судалгаа хараагүй ч тийм байж болох юм гэж санал

нэгдэж байна. Эрэгтэйчүүдийн эрхэлж байгаа ажил мэргэжил, орчин нөхцөл үүнд шууд хамаатай. Бас тэр хувь хүний хэнэггүй байдал мэдээж их нөлөөлнө. Сэтгэл санаа болон зан төлөвийн хэнэггүй байдал надад ч гэсэн бас нөлөөлсөн байх. Яах аргагүй тоо баримт харахаар хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэйчүүд давамгай байдаг. Гэхдээ харамсалтай нь бас нэг ийм юм байдаг. Одоо манай байгууллага зуун жар гаруй гишүүнтэй. Эмэгтэй гишүүд ихтэй. Ямар нэгэн зохион байгуулалт хийж хүч хаясан томоохон үйл ажиллагаа, ажил дээр эмэгтэйчүүд голдуу оролцдог. Тэгэхээр хэнэггүй юм шиг мөртлөө сэтгэлийн хатаараа эмэгтэйчүүд илүү юм шиг санагддаг. Эрэгтэйчүүд нь тэр айдас, сэтгэл зүйн дарамтаа даван гарахад өөр олон асуудал хөндөгдөх юм байна л даа. Би ч гэсэн гаргаад байж чаддаггүй, илэрхийлчхэж болдоггүй дотогшоо хүн. Тэгэхээр тэр байдал маань бүр их дарамт үүсгэдэг. Би ажлын шугамаар хөгжийн бэрхшээлтэй, бэрхшээлгүй олон хүмүүстэй уулзалт хийж ярилцдаг. Тэгээд яг туршлагаасаа харахад маш олон залуус тэр хүнд байгаа айдас зовуур, сэтгэл санааны асуудлаа давж чаддаггүй нь анзаарагддаг. Түүнийгээ яаж гаргах, илэрхийлэх арга барил их дутмаг юм шиг санагддаг.

Тэгэхээр багаас нь гаргаж сургадаггүй. Жоохон эрэгтэй хүүхэд гүйж байгаад унахад эр хүн уйлдаггүй юм гэдэг хандлага багаас нь байдаг байх?

Ерөнхийдөө тийм юм шиг байна. Эргэн тойрныхоо хүмүүсээс санаа зовоод ядаж л уянгын кино үзэхээрээ эрчүүд хүний дэргэд нулимсаа гаргаж чадахгүй бариад байдаг. Бусдад харагдах юм бол ичмээр зүйл болчихмоор санагдаад тэр юм нь бүр тогтоод нөлөөлдөг байх. Шууд сэтгэлийн хөдлөлөө илэрхийлж ээж аавдаа баярлалаа, эхнэр хүүхдэдээ ч гэсэн хайртай шүү гээд хэлж чаддаггүй. Хамт олон, найз нөхөд нь налиг шалиг боллоо гэж хэлдэг учраас ингээд бугшаад тийм болдог байж болох талтай. Тэр бол амьдрал дээр харагддаг зүйл.

Би тэрнээс болоод эрт эмчлэгдэх боломж байхад цаг нь хэтрээд байна уу гэж хувьдаа дүгнээд байгаа. Тэгэхээр бас таны саналыг сонсох гэсэн юм?

Хүний сэтгэл эрхтэн гэдэг нь үнэн гэдгийг би өөрөө ч гэсэн гэмтсэнийхээ дараагаар л маш их сайн ойлгож байна. Нэг их хөгширчихсөн амьтан биш л дээ гэхдээ нас яваад ирэхээр үүнийг бүр их мэдэрдэг юм байна. Сэтгэл санаа бол маш хүчтэй юм байна. Сэтгэл санаагаа дагаад ядаргаанд орох, олон асуудал үүсэх нь бодит зүйл юм байна. Янз янзын юм уншихаар хүний ид 26-27 нас хүртлээ залуу хүний дархлаа нь ундарч байдаг учраас энэ юм мэдрэгддэггүй юм байна. Яг тэр дархлаа дуусаад хуримтлуулсан дархлаагаараа цаашдаа явдаг тэр үедээ ирэхэд сэтгэл санаа эрхтэн юм гэдгийг биеэрээ мэдэрдэг юм байна. Бид ч гэсэн сэтгэл бол эрхтэн мөн гэдэг утгаар нь үйлчилгээ үзүүлэх ёстой гэж үздэг. Тэр пийр коунсилинг (peer counseling) гэдэг үйлчилгээ үүнтэй

адилхан. Пийр коунслинг гэдэг үйлчилгээг хэн нэгэн мэргэшсэн сэтгэл зүйч, эмч мэргэжилтэн хийдэг зүйл биш. Яг энэ асуудал, бэрхшээлийг биеэрээ үзсэн хөгжлийн бэрхшээлтэй хүн гэмтээд яах учраа олохгүй байгаа дараагийн хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ярилцах, хуваалцах, тэр хүний сэтгэл санааг нь онгойлгох замаар хийдэг үйлчилгээ юм.

Монголд яриад байгаа системээс маш их ялгаатай зүйл. Тэгээд би ч гэсэн чамтай адил зүйл хэлмээр байна. Хэрвээ намайг гэмтэл авах үед яг одооных шиг тогтолцоо систем, ийм төрийн бус байгууллагууд, ийм юм ярьдаг хүмүүс байсан бол би хөл дээрээ босохгүй юм гэхэд маш хурдан нийгэмших байсан. Тэгээд маш хурдан хөлөө олж өөрийнхөө амьдралд хэрэгцээтэй зүйлээ олоод авах байсан байх. Энэ бол үнэхээр бодитой зүйл. Яг намайг гэмтэж байх үед ядаж надад ирээд тэргэн дээр чи ингэж суух ёстой, хөлөө ингэж тавих ёстой, ингэж бие засах ёстой, ингэж жорлон луу шилжих ёстой гэж зөвлөх хүн байгаагүйд би үнэхээр харамсдаг. Ийм юмыг биеэрээ үзсэн хүн л зөвлөж чаддаг. Хичнээн ээж аав, ах дүү нь сэтгэл санаагаар ойлгоод байгаа ч гэсэн тэд үүнийг бие эрхтнээрээ мэдрээгүй учраас нөгөө хүн нь юмаа гэр бүлдээ гаргаж чаддаггүй бугшаад байгаад байдаг.

Олон асуудал үүсдэгийн нэг нь эрэгтэй хүний хувьд бэлгийн амьдрал. Үүнийг хэн нэгэн сэтгэл зүйч, эмчид очоод ярих ямар ч боломж байхгүй. Тэгэхээр яг тэрэн шиг харааны бэрхшээлтэй хүмүүс хоорондоо ярилцаж, сонсголын бэрхшээлтэй хүмүүс л хоорондоо яг энэ сэдвээр ойлголцож чадна. Мэдээж хэрэг би хөгжлийн бэрхшээлгүй маш олон залуучуудтай ажилладаг ч гэсэн тэд нартай огт ярьж болохгүй сэтгэлийн нарийн юм байдаг. Ижилхэн хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ярилцахад нөгөө санаануудаа шууд ойлголцдог. Үүнийг олон улсын төвшинд аль хэдийн үзэж танилцаад, бие даан амьдрах хөдөлгөөнөөр харуулаад, энэ чинь төсөв санхүү, тогтолцоо системтэй үйлчилгээ юм байна, энийг удирддаг хүн нь ийм байх ёстой юм байна гээд явсан. Тэгээд бид ч гэсэн энэ ажлын хүрээнд тун удахгүй 4 сард дахиад хоёр дахь шатны пийр коунслингийн сургалтыг Японы нэг байгууллагаас авах гээд бэлтгэж байна. Тэнд манай 8 залуу бэлтгэгдээд, яг энэ чиглэлээр мэргэшээд пийр коунслер болох гэж байна. Дахиад хэлье сэтгэл зүйч, мэргэжилтэн бол биш. Тэр хүний сэтгэлийн гүн дэх айдас хүйдсийг уудалж гаргадаг, түүнийг даван туулахад нь дэмжлэг үзүүлдэг, дараагийн амьдралдаа орох, дасан зохицоход нь дэм үзүүлэх хүмүүс байдаг. Чи сая их гоё сэдэв хөндөөд гаргаад ирлээ.

Хүн гэдэг чинь сэтгэлийн амьтан гэдэг шиг сэтгэл санаанаас бүх юм шалтгаална шүү дээ.

Тийм. Чи өмнө тулгарч байсан төвөгтэй асуудал гээд асууж байсан шүү дээ. Би өөрөө юмыг амархан хүлээж авдаг хүн шиг байгаа юм. Амархан баярладаг, амархан сэтгэл санаагаар унадаг. Одоо бага зэрэг

дасаж өөрийгөө удирдаж сурч байгаа. Төвөө байгуулаад эхэлж байх үед нэг юм тулангуут л шууд унана. Тэгээд л бараг энэ ажлаа болимоор ч юм шиг, хаяад хаа нэг тийшээ явмаар ч юм шиг санагддаг байсан. Манай гүйцэтгэх захирал Авирмэд гээд нас, ажил амьдралын туршлагын хувьд ч гэсэн нэлээн их мэдлэг туршлагатай, хувь хүн нь бас их уужуу сэтгэлгээтэй ах байдаг. Хэрвээ хажууд тэр ах маань байж дэмжлэг үзүүлээгүй бол одоо Түгээмэл Хөгжил төв байхгүй, бужигнаж байгаа энэ олон залуучууд нэгдэхгүй байх байсан болов уу гэж боддог. Тэгэхээр сэтгэл санаа гэдэг бол маш тийм том эрхтэн юм байна. Үнэхээр надад бол алхам тутамд мэдэгддэг.

Цаашид хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэхэд яаж анхаарах ёстой вэ?

Олон л арга байгаа гэж бодож байна. Нэгдүгээрт нь сая ярьсан пийр коунслинг эсвэл бие даан амьдрах хөтөлбөрөөр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст сэтгэл зүйн асуудлаа даван туулах эсвэл бэрхшээлийн хэлбэрийг нь таниулж ойлгуулах, тэрэндээ дасан зохицож амьдрах мэдлэгийг олгох хэрэгтэй. Тийм юмгүйгээр эмч нар шууд л "чи хичээх юм бол эдгэнэ ээ. Хөл дээрээ босно" гээд хэлчихдэг. Тэгэхээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гэр бүл бүх эдийн засаг, хөрөнгө санхүү, сэтгэл зүй гээд бүх юмаа тэрэнд зориулж байна. Харамсалтай нь бүтдэггүй. Нуруу нугасны гэмтлийг эдгээж чадахгүй гээд



дэлхий нийтээрээ шинжлэх ухаан хүлээн зөвшөөрсөн байхад бид нар энд бөөдөөд л эсвэл бариа засал хийлгэж, зүү тавиулж байгаад л босох гээд бүх юмаа зориулаад байдаг. Эцсийн мөчдөө хамаг цаг хугацаа дуусчихсан, тодорхой хэмжээний хөрөнгө санхүү явчихсан байдаг.

Хамгийн хэцүү юм нь сэтгэл зүйн асуудал. Тэгэхээр ийм юм болохоос нь өмнө тэр хүнд гэмтэж бэртээд эмнэлэгт байхад нь ядаж энэ талаар ярилцах боломж олгох хэрэгтэй. Гэмтлийн эмнэлэгт үүний талаар ярилцдаг хүмүүс эсвэл бид нар эмнэлэгтэй гэрээлээд эсвэл хэн нэгэн сэтгэл зүйч дээр орж тэр сэтгэл санааны асуудлыг даван туулж, дасан зохицоход нь туслах хэрэгтэй юм шиг санагддаг. Намайг Японд явж байхад жишээлбэл нугасны гэмтэл авсан залуучууд эмнэлэгт тодорхой хугацаагаар хэвтэхдээ эмчилгээ хийлгэхийн хажуугаар спортоор хичээллэж байна. Тэргэнцэртэй саг, цанаар хичээллэх зэргээр ямар нэгэн байдлаар сэтгэл санааг нь сатааруулах ажил хийдэг. Мөн тэр хүнийг бие эрхтэн нь чангаруулж дасан зохицуулж байдаг. Тэргэнцэр дээрээ суух, орчны нөхцөлд өөрийгөө аваад явах чадварыг нь сургаж байдаг. Иймэрхүү зүйл Монголд огт байхгүй.

Би жишээ нь биологиор суралцаж байсан бол гэмтсэнийхээ дараагаар багш болбол би суугаагаараа багшлахад боломжтой. Тухайн хүний эзэмшсэн мэргэжлийг нь яахав гэх мэтийн гол нь залгуулсан ажлууд хэрэгцээтэй байгаа юм. Эхэн үед нь зөвлөгөө өгөх талаар бид гэмтлийн эмнэлэг, анагаахын сургуультай ярилцаж, хөндөж үзсэн. Одоо ямар шатанд явж байгааг нь сайн мэдэхгүй байна. Харамсалтай нь манайхан шууд л анагаах чиглэлээс нь ямар нэг аргаар л эдгээх гээд сэтгэл санааг нь хаячхаад байдаг талтай.

Та сая геологиор сурч байсан гэсэн. Сургуулиа төгсчхөөд Япон хэлний чиглэлээр сурсан уу?

Жишээ авсан юм. Би геологи биш түүх, археологийн чиглэлээр сургуульд сурч байгаад эхний жил нь сургалтын төлбөрөөс болоод чөлөө авсан юм. Тэгээд сургалтын төлбөрөө хийдэг мундаг баатар болж ажил төрөл хийж байхдаа хөгжлийн бэрхшээлтэй болсон. Гэрт нэг сэтгэл санааны хувьд хэцүү хүн байхад гэр бүлийн уур амьсгал хэцүү болчихдог шүү дээ. Бүгд л намайг дагаад унтраад, харанхуй бүүдгэр байдаг. Дараа нь тухайн үед Япон хэлний багш байсан манай бэр эгчид тэр байдал мэдрэгдсэн юм уу нэг өдөр “чи дэмий санаашраад, дээшээ хараад байж байхдаа энийг цээжилчихээд байж бай” гээд хэдэн үсэг орхиод явсан. Одоо бодоход Япон хэлний хирагана үсэг байж л дээ. Би тэрийг нь сатаарах гэж юм уу нэг мэдсэн чинь нүдэн баримжаагаар тогтоочхож.

Дараа нь Тахилт гээд тэргэнцэртэй хүмүүс амардаг сувилалд ээжтэйгээ амарч байсан чинь аялж явсан хэсэг Япон эмээ өвөө нар ирээд, нэг эмээ манай өрөөнд ороод

ирсэн. Тэгсэн миний орон дээр суучхаад, надтай ярих гэж оролдоод л тэгсэн чинь би мэддэг хэдэн хирагана үсгээрээ ганц нэг мэддэг үгээ хэлсэн бололтой нөгөө эмгэн маань баярлаад л байсан. Гурав хоногийн дараа явахдаа надад “би чамд эмчилгээний зардал өгмөөр байна чи хөл дээрээ босоорой. Би чамд тусалмаар байна” гэсэн. Дараа нь тэр хүн маань над луу эмчилгээний зардал явуулсан байсан. Тэгээд би тэр мөнгөөрөө зардал хийгээд урагшаа эмчилгээ хийлгэхээр явсан. Хэдэн төгрөг үлдэхээр нь ээжтэйгээ ярилцахад “энэ эмээтэйгээ ярилцахын тулд хэл хэрэгтэй учраас чи Япон хэл үзвэл яасан юм вэ” гэж зөвлөсөн. Тэгээд тэр ярианаас болоод би сургалтын төвд бүртгүүлсэн. Сургалтын төвийн маань багш “чи дэмий ингэж байхаар сургуульд сурч хамт олонтой болох нь дээр” гэсэн. Тэгээд япон хэлний ангид орсон. Япон хэлийг зорьж судлаагүй, явсаар байгаад л япон явах сэжим гараад л явсан даа.

Таныг оюутан байхад ямар байсан бэ?

Намайг яг оюутан байхад маш хэцүү байсан. Нэгдүгээрт манай гэр 5 давхарт байдаг. Би хичээлдээ автобусаар явах боломжгүй. Одоо бол тодорхой хэмжээний хүртээмжтэй автобус бий болж байна шүү дээ. Орчны хүртээмж яригдаж эхэлж байсан тухайн үед бол үнэндээ тэргэнцэртэй хүн гарч ордог тухай ойлголт байхгүй байсан. Тухайн үед би 1-2 л тэргэнцэртэй хүнтэй таарч байсан. Ганц өөрийгөө тэргэнцэртэй юм шиг санадаг байлаа. Тэгээд хичээлдээ явна гэдэг бол том асуудал. Өдөр тутам хаа хол орбитоос такси хөлсөлнө. Аавын үүрэг бол өдөр шөнөгүй ажил хийж таксины мөнгө олох бол ээж намайг сургуульдаа очиход хүртээмжтэй ариун цэврийн өрөө байхгүй учраас бие засуулах гээд сургуулийн гадаа шил бариад зогсож байдаг байсан. Яваандаа анги хамт олон маань дасаад, ангийн залуучууд маань шат босгоор дээш нь доош нь өргөөд тусалдаг болсон. Тэр битгий хэл манай ангийн охидууд гудамжинд явж байхад намайг бие засуулах гээд тойроод, хаагаад зогсчихсон би дунд нь шилэндээ шээж байсан. Тэгээд манай ангийн нэг охин тэрийг асгах гээд л явсан. Эргээд бодоход их хэцүү бөгөөд хөгжилтэй тиймэрхүү маягаар 4 жил явсан. Заримдаа би юм уухгүй явж сурсан гэж хөгжилдөхдөө ярьдаг. Юм уухаар бие засах хэрэгтэй болдог болохоор хичээлээ дуустал гүрийх хэрэг гарна. Мэдээж хэцүү байсан ч гэсэн сайхан байсан. Эргээд бодоход оюутан цаг надад бас их юм ойлгуулсан цаг үе байж гэж боддог. Тэр дундаас би ангийнхаа охинтой танилцаж, гэр бүлтэй болж одоо хүртэл бид 2 амьдарч байна.

Та дараа нь бас Санхүү эдийн засгийн дээд сургуульд сурсан уу?

Тийм, тэр бол ажлын шаардлага байсан. Байгууллага удирдаж байгаа хүн янз янзын мэдлэгтэй байхгүй бол болдоггүй юм байна. Бүх зүйлийг өөрөө хийхдээ гол нь биш, мэдлэгтэй байж залуучуудаа

хөгжүүлэх ёстой гэдэг үүднээс санхүүгийн чиглэлийн тодорхой хэмжээний мэдлэг эзэмших хэрэгцээтэй болсон. Дээрээс нь удирдлагын ур чадвар эзэмших ёстой гэдэг утгаараа судалж байгаад Санхүү эдийн засгийн дээд сургуулийн магистрын хөтөлбөрт хамрагдсан.

Таны Боловсролын их сургууль болон Санхүү эдийн засгийн дээд сургуульд сурсан зай нь хэдэн жилийн дараа байсан бэ?

Би анх 2003 онд Ирээдүй дээд сургуульд Япон хэлний ангид орсон. Харамсалтай нь миний төгсөх жил Ирээдүй сургууль маань хаагдсан. Тэгээд бөөн асуудал болж байж Монгол Улсын Боловсролын их сургуульд ороод Япон хэлний ангийг 2007 онд төгссөн. Япон явж ирээд 2013 онд Санхүү эдийн засагт сурсан учраас нэлээн зайтай юм байна.

Тэгэхэд танд ядаж хүртээмжийн хувьд сайжирсан байдал харагдаж байсан уу?

Би нэг өдөр хичээлдээ явж байгаад лифтэн дотор захирал Батсүрэн багштай таарсан. Захирал харж байснаа "манай сургууль бас энэ залуу ордог юм аа, чамд юу хэцүү байна?" гээд асуусан. Би "багш аа асуудалгүй л дээ гэхдээ гадаа зогсоол, явах ороход шат хэцүү юм" гээд хариулсан. Тэгсэн чинь "тэрийг янзална, өөр юу хэцүү байна" гэсэн "өөр юмгүй дээ ариун цэврийн өрөө" гэж хэлсэн. Тэгсэн дараагийн өдөр нь хичээлдээ ирэхэд ариун цэврийн өрөөг сайхан янзалчихсан, налуу замыг маань орж гарахад их амар болгочихсон байсан. Тэгэхгүй бол ангийнхан маань байнгын үүрнэ, өргөнө гээд их төвөгтэй байсан. Манай ангид бас харааны бэрхшээлтэй нэг эмэгтэй байсан. Мэдээж хүн чинь яг нүүр тулж байж л асуудлыг ойлгодог учраас багш нар тэр эмэгтэйг суралцах боломжоор нь хангах гээд үздэг байсан. Тэгэхээр багш нарт маань ч гэсэн анх удаа тэргэнцэртэй, харааны бэрхшээлтэй оюутан сургуульд ороод ирэхээр янз янзын зүйл дээр суралцах, төлөвлөх, зохион байгуулах хэрэгцээ гарч байсан байх. Ямар ч байсан бид 2 хоёулаа ямар нэгэн асуудалгүй суралцаад, сургуулиа амжилттай төгссөн.

Та тухайн үед захиралтайгаа таарснаараа дараа дараагийн хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад орох гарах налуу зам, ариун цэврийн өрөөний асуудлыг түрүүлээд шийдэж өгсөн юм болов уу гэж бодож байна.

Магадгүй л юм. Гэхдээ сургууль бас хууль эрх зүйн орчноо дагаад төлөвлөж байсныг нь түргэтгэсэн байж болох юм. Удирдлага хүн ойлгох ёстой юм байна. Би ч гэсэн ямарваа нэг зүйлийг өөрөө үзэж танилцсаны дараа ажлынхаа залуучуудын хэлээд байгаа зүйлийг илүү сайн ойлгодог. Тэрнээс өөрөө мэдрээгүй байж хийсвэрээр юманд хандах гээд хэцүү байдаг учраас тэр талаас нь харахад Батсүрэн багшид дэм өгсөн байж болох юм. Одоо ч Батсүрэн багш хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй хамааралтай асуудал гарахаар хаяа нэг юм асууж байдаг. Багш маань ч гэсэн алхам тутамдаа суралцаж байгаа байх.

Одоо подкастын маань цаг өндөрлөх дөхөж байна. Ковид цар тахал танд болон танай байгууллагын үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгаа вэ?

Бусадтай адилхан даа. Эдийн засгийн хувьд бид нарын төлөвлөсөн байсан маш олон ажил бүгд зогссон. Бид нар өнгөрсөн жил 10 жилийнхээ ойг угтаад 10 том ажил төлөвлөөд Ази, Номхон Далайн бүсийн орноос нийтдээ 8 орон урих гэх зэрэг ёстой маш том том ажлууд төлөвлөөд жилийн өмнөөс бэлтгэж байсан чинь бүх ажил дууссан. Тэр битгий хэл олон улсын байгууллагатай ажиллаж байсан 2 жилийн хамтын ажиллагаа дууссан нь үнэхээр харамсалтай байсан. Үүнийг дагаад манай эдийн засгийн боломжууд бас хумигдаж байгаа. Гэхдээ бид нар айдсаас илүүтэйгээр их сонирхолтой байна. Том ажлууд маань зогссон ч гэсэн төлөвлөж байсан бусад ажлууд маань явагдаж байгаа. Хамтын ажиллагаатай байгууллагууд харилцаагаа үргэлжлүүлж байгаа. Нөгөө талдаа хүн гэдэг чинь өөрөө нийгмийн амьтан юм байна. Олны дунд хөгжиж байж сэтгэл санаандаа байгаа хүнд хэцүү зүйлээ давж байдаг. Гэтэл ковид болж тусгаарлагдаж, ганцаардаж байгаа байдал гишүүдээс маань маш их мэдрэгддэг.

Ажилтнууд бид бол өдөр шөнөгүй залхтлаа л ажиллаж байна, онлайнаар харилцаж байна. Гишүүдийн хувьд хэцүү байх шиг байгаа юм. Ганцаардаж, сэтгэл санаагаа хуваалцах хүнгүй, тэр байдлаа гэр бүлдээ гаргах эсвэл гэр бүлийн уур амьсгал бүх гишүүдийн хувьд биш ч гэсэн бас сэтгэл зүйн дарамт үүсгэдэг юм байна. Хөгжлийн хувьд бас хоцрогдож байна. Нөгөө талаасаа бид нар огт боддоггүй байсан давуу тал бас байна. Цахим орчинд ажиллахын тулд шинэ технологийг ашиглах хэрэгцээ, шаардлага үүсч байна. Манай ажлын залуучууд ялангуяа энэ 4-5 сарын дотор маш хурдан хөгжиж байна.

Бид нарын ажил тасалдахгүй байх ёстой учраас бүх цахим хэрэглээг ашиглаж ажлаа явуулах тал дээр манай залуучууд, би ч гэсэн суралцаж байна. Нөгөө талаасаа цахимаар ажиллахад зогсоо зайгүй байдаг учраас маш их ядардаг юм байна. Байгууллагын төлөөллийн хувьд ялангуяа би янз янзын хурал семинар, уулзалтад их оролцох ёстой байдаг. Заримдаа бараг 5-10 минутын зайтайгаар хуралдах хэрэг гардаг нь хувь хүнийг ядраадаг юм байна. Тэгээд төлөвлөлт сайн хийхгүй бол болдоггүй юм байна. Байгууллагын өөрчлөлтөд бол ийм байна. Оффисын хувьд бол бид энэ боломжийг ашиглаад хуримтлуулсан зардлаараа хүн цөөнтэй байгаа дээрээ засвар хийж байгаа. Манайх чинь хүн маш ихтэй, бужигнаж байдаг учраас засвар хийх боломж байдаггүй байсан. Энэ боломжийг ашиглаад ажиллах орчин нөхцөлийнхөө тохь тухаа хангаад авъя гээд Түгээмэл Хөгжил төвөө тойрсон засварын ажлууд хийгдэж байна. Өөр нэг давуу тал гэвэл хэдийгээр хил хаагдсан ч гэсэн онлайнаар гадаад харилцаа маш идэвхтэй явагдаж байна. Гадаад харилцаа, байнгын гишүүд хоорондын уулзалт, янз янзын жижиг төлөвлөлтүүд, ярилцлагууд

хийе гээд харилцаа маань илүү нягтарч байгаа. Урьд нь заавал Монголд ирж байж харилцдаг байсан бол одоо цахим уулзалтууд их болж байна.

Цаг гаргаж манай подкастад оролцсонд маш их баярлалаа. Таны ажил үйлс, амьдралд болон Түгээмэл Хөгжил төрийн бус байгууллагад амжилтыг хүсье ээ!

ГУРВАН ХЭМЖЭЭСТ ПРИНТЕРЭЭР ПРОТЕЗ ХИЙЖ БУЙ ИНЖЕНЕР

Д.Мандахнаран



Сайн байцгаана уу, эрхэм хүндэт сонсогчид оо, Антолд подкастын маань ээлжит дугаар эхлэхэд бэлэн болоод байна. Энэхүү дугаарт Мандахнаран гэдэг залуу оролцож байна. Та өөрийгөө эхлээд сонсогчиддоо танилцуулахгүй юу?

Сайн байцгаана уу, энэ сайхан өдрийн мэндийг бүх сонсогч нартаа хүргэе!

Юуны өмнө надад яриа хийх боломж олгосон та бүхэнд баярлалаа. Намайг Доржсүрэнгийн Мандахнаран гэдэг, Техлоид компанид ажилладаг. Мэргэжлийн хувьд механик инженер мэргэжилтэй. Сүүлийн жилүүдэд 3D принтер ашиглан янз бүрийн хэв загвар бүтээж байгаа. Хүний хэрэглээг хялбар болгох санаа дэлхий дахинд түгээмэл болж байгаатай холбоотой энэ чиглэлийг сонгосон. Би 3D принтер ашиглан хиймэл гар хийх сонирхолдоо хөтлөгдөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулж хиймэл гар хийдэг. Анх сонирхлын төвшинд л байсан гэж хэлж болно. Харин хүүхдэдээ тааруулж хийж чадсаны дараа нийгэмд хэрэгтэй зүйл юм байна гэсэн итгэл үнэмшилтэй болсон.

Анх протез хийх санаа яаж гарч ирсэн бэ?

Би “Шинэ Монгол” технологийн дээд сургуулийг механик инженерийн мэргэжлээр төгссөн. Сурч байх хугацаандаа шинэлэг техник технологид дуртай байсан. Нэг өдөр манай багш 3D

принтер буюу гурван хэмжээст хэвлэгчээр янз бүрийн юм хийж болох талаар ярьсан. Тэгээд багштайгаа ярьж байгаад “хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд яагаад 3D хэвлэгчээр протез буюу гар хийж болохгүй гэж” гэсэн санаа анх төрсөн. Тэр үеэс хойш хиймэл гар буюу протез хийж эхэлсэн. Үүний тулд эхлээд олон улсад ашиглаж байгаа 3D хиймэл гарны, гурван хэмжээст принтерийн, техник технологи, машины төрөл, материалын судалгаа зэргийг хийсэн. Мөн хүүхдүүдэд хиймэл гарны загварыг гаргах ажил хийсэн.

Энэ протезыг ямархуу материалаар хийдэг вэ? Мөн арчилгаа, цэвэрлэгээ болон хийсэн протезууд хэр удаан эдэлгээтэй байдаг вэ?

Яг 3D хэвлэгчийн хувьд материал маань ПЭлЭй (PLA), ЭйБиЭс (ABS), СиПиЭй (CPA) гэсэн 3 үндсэн төрөлтэй байдаг. Бүгд пластик ашиглаж бүтээгддэг чанарын хувьд өөр өөр төвшинд байдаг материалууд юм. Протез үйлдвэрлэхэд эдэлгээтэй материал их шаардагддаг тул олон улсад ч, манайд ч гэсэн голчлон ЭйБиЭс-ийг ашиглахад тохиромжтой гэж үздэг. Цэвэрлэгээний хувьд өдөр тутамд ашигладаг цэвэрлэгээний материалаар ямар ч асуудалгүй цэвэрлэж болно. Эдэлгээ хамгийн багадаа 6 сар асуудалгүй ашиглах боломжтой. Хэрвээ янз бүрийн асуудал гарвал хэвлэгч ашиглаад эвдэрсэн, гэмтсэн хэсгийг нь 3 хоногийн дотор засуулах боломжтой учраас бусад протезуудаас онцлогтой.

Тэгэхээр сая протез гар хийсэн гэж хэлсэн шүү дээ. Тэгэхээр гараа тусгай мэдрэлтэй нь яаж холбодог вэ?





Уламжлалт гаруудыг хүний мэдрэлтэй холбоод, цахилгаанаар ажиллуулахыг зорьдог бол 3D хэвлэгчээр хэвлэсэн гар тухайн хэрэглэгчийн механик үйлүүдээр дамжиж ашиглагддаг. Жишээлбэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гарны алга эсвэл гарны үе бүрэн бүтэн байлаа гэхэд атгах, хөдөлгөх хүчийг нь ашиглаад гар маань ажилладаг байгаа. Манай нийгэмд олон төрлийн гарны загвартай хүүхдүүд байгаа. Эхлээд хүүхдийнхээ гарны үеийн хэмжээг авдаг. Дараа нь компьютер дээр протезийн хэмжээсийг тооцоолж хэрэглэхэд бэлэн болгоно. Хэвлээд гаргасны дараа угсраад хүүхдээ зүүлгэж таарч, эвтэйхэн байгаа эсэхийг нь тодруулдаг. Ямар загвартай гартай болмоор байна гэдгийг нь хүүхэдтэйгээ ярилцаад шийддэг. Жишээлбэл эмэгтэй хүүхдэд ягаан өнгийн гар, эрэгтэй хүүхдэд супер баатрын гар гэх зэрэг тухайн хүүхдийнхээ хүссэн загварыг гаргаж өгч болдгоороо 3D принтерээ ашигласан протез онцлогтой байдаг.

Тухайн хүний хэрэгцээ, сонирхолд тааруулсан гарууд хийж байгаа гэсэн үг юм байна.

Тийм. Загвар, өнгөний хувьд хэрэглэгч хүүхэд маань өөрөө сонгоод хэвлүүлэх боломжтой.

Хүүхдүүдээс гадна том хүнд хийж байсан уу?

Том хүний протезийн хувьд асуудалгүй, олон төрөл байдаг гэж үздэг. Яагаад хүүхдүүдэд хийдэг вэ гэвэл хүүхэд сар, жил өнгөрөх тусам гарынх нь хэмжээ өөрчлөгдөж байдаг. Нэг үгээр хэлбэл том болж байна гэсэн үг. Тиймээс цаг





хугацаа өнгөрөх тусам гар байнга солих шаардлагатай болдог. Өмнө нь эцэг эхчүүд хүүхдээ гар авч өгөхийн тулд нэлээн их мөнгө зарцуулдаг байсан. Харин одоо 3D принтер ашигласнаар тэр асуудлуудыг бүгдийг нь шийдэх боломжтой гэж бодож байгаа. Жишээлбэл 5-р ангийн хүүхэд 6-р ангид ороход гар нь томорчихсон, хуучин жижиг гар нь таарахгүй болоход хямд үнээр, богино хугацаанд тохирсон гартаа болох боломжтой.

Том хүмүүс нэг төрлийн гартай байдаг. Жоохон хүүхдүүдэд л хэрэгтэй байдаг юм байна.

Тийм, яг үнэн.

Монголд байдаг протезуудаас юугаараа ялгаатай вэ? Монголд ер нь технологи нь ямар байдаг вэ? Хэрвээ судалсан бол үнэ нь бас хэд байдаг вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан хиймэл гар маш асуудалтай гэж хувьдаа харж байгаа. Протезийн үйлдвэрээс судалгаа авахад зөвхөн Хятад улсаас резинэн гар оруулж ирдэг гэсэн дүгнэлтэд хүрсэн. Хятадаас Монгол руу ирэхэд 2-3 сар зарцуулдаг ба ирээд тухайн хүүхдэдээ таарах нь эргэлзээтэй. Эсвэл үнийн хувьд өсөж, буурч байдаг талтай. Харин 3D хэвлэгчээр хийсэн хиймэл гар маань 3-4 хоногийн дотор бэлэн авч болдог.

Мандахнаран маань хүүхдүүдтэй анх яаж холбоо барьж байсан бэ? Анх холбогдож байхад хэр найрсгаар хүлээж авч байсан бэ?

Анх эмнэлгүүд, протезийн үйлдвэрүүд зэрэг газруудаар нэлээн явсан. Тэгэхэд яг бэлэн жагсаалт байхгүй ч өмнө нь хандаж байсан хүмүүсийн холбогдох утасны дугаарыг эхнээс нь хайж олсон. Тэгээд тухайн хүмүүс рүү яриад танай хүүхдэд ийм зүйл хийж өгвөл яаж байна гэхэд бүгдээрээ сайхан хүлээж авсан. Дараа нь хүүхдүүдтэйгээ уулзаад ярихад нээлттэй, жаахан хүүхдийн хувьд сонирхол нь нэлээн өндөр байсан. Жишээлбэл робот шиг гартай болчихлоо гээд маш их баярлаж байсан тохиолдлууд их байдаг. Тэгэхээр Монголд орж ирдэг резинэн

гарны хувьд ганц хоёр асуудалтай байдаг. Үнэр ихтэй байдаг. Жишээлбэл хүүхэд хичээлээ хийж байхад их үнэртдэг. Гадаад үзэмжийн хувьд сайн биш учраас тухайн хүүхдийн итгэл, сэтгэл зүй нөлөөлдөг. Тухайн хүүхдэдээ зориулаад тусгайлан хийдэг учраас 3D-ээр хэвлэсэн гар илүү тохиромжтой. Жишээлбэл нэг эрэгтэй хүүхдэд 3D хэвлэгчээр яг Айронмэнийх шиг загвартай гар хийж өгөхөд тухайн хүүхдийн өөртөө итгэх итгэл нэмэгдээд сургуульдаа идэвхтэй явдаг болсон.

Одоо хүүхдүүдтэйгээ байнга холбоотой байдаг уу? Магадгүй тэр хүүхдүүд том болоод, гар нь таарахгүй ахиж ирж байгаа юу?

Ер нь бол холбоотой байгаа. Хэвлэлтийн хувьд гэвэл түүхээс нь ярьж өгье. Би анхны загвараа гаргахдаа 3D принтерийн тухай ямар ч ойлголтгүй байсан. Тэгээд компьютер дээр хүүхдийнхээ гарны загварыг гаргаад шууд хэвлэнэ гэж бодсон. Тэгээд 1-2 хоногийн дотор хангалттай нэг гар хийнэ гэсэн бодолтой явсан. Яг анхныхаа загвараа 3D хэвлэгчээр хэвлэхэд 10-аад хоног зарцуулсан. Хүн анх бодоход их амархан юм шиг санагддаг ч яг цаг нь тулахаар олон хүндрэлүүд байдаг юм байна. Миний ашигласан принтер тийм ч сайн чанарынх биш, бас анх удаа 3D принтер ашигласан болохоор хэмжээс нь зөрөх, дундаа зогсох, хоорондоо наалдах зэрэг асуудлууд тулгарч байсан. Тэгээд өдөр болгон өдөр оройгүй нийтлэл уншиж, бичлэг үзэж богино хугацаанд хэвлэх хэмжээний туршлагатай болсон. Хэрвээ хүүхдүүд маань гараа сольё, гараа ийм загвартай болгомоор байна хэмээн хандахад шууд харилцаад, богино хугацаанд хийж өгдөг.

Мандахнаран маань энэ протезийг ганцаараа хийдэг үү? Эсвэл өөр хүмүүстэй хамтарч хийдэг үү? Нэлээн л ажиллагаа ордог байх даа.

Анх багштайгаа хамтраад, 2 оюутантай баг болоод нийтдээ 4-үүлээ хийдэг байсан. Яг одоогоор манай багш АНУ-д тэтгэлгээр сурч байгаа учир үүнийг ганцаараа хариуцаж байгаа. Одоо хангалттай мэдлэг,



туршлагатай болсон болохоор ганцаараа ч гэсэн асуудалгүй зүтгээд байна.

Тэгэхээр 1 протез хийхэд Монголоос худалдан авч байгаа протезуудаас үнийн хувьд хэр их зөрүү байдаг вэ?

Уламжлалт хиймэл гарны хувьд гэвэл 1,000-14,000 долларын үнэтэй байдаг. Харин 3D принтер ашигласан хиймэл гар маань тухайн хүүхдийнхээ гарны хэмжээснээс хамаарч 300,000 төгрөгөөс доош өртөгтэй хийгддэг. Өмнө нь та бүхэнд хэлсэн Хятадаас орж ирдэг хиймэл гарууд 450,000 төгрөг хавьцаа өртөгтэй ирдэг байгаа. Тийм болохоор 3D принтерээр хэвлэсэн гар хамаагүй хямдхан бөгөөд хугацааны хувьд ч гэсэн 1-2 хоногийн хооронд үйлдвэрлээд гаргах боломжтойгоороо онцлог байгаа.

Монголд протез хийдэг газрууд маань протез хийх хүчин чадал, техник технологи нь байдаггүй гэсэн үг үү?

Өмнө нь хийдэг байсан юм байна. Би



“Эрхэм чанар” гээд Монгол дахь бараг №1 протезийн үйлдвэр дээр очоод захиралтай нь ярилцаж байхад хүүхдүүд байнга өсөж, торниж байдаг болохоор хүүхдэд зориулсан гарыг үйлдвэрээс бага багаар байнга гаргахад хүндрэлтэй гэж ярьж байсан. Мөн Хятадаас хүүхдүүдэд зориулж бэлэн гар шууд зөөвөрлөж авчирсан нь хамаагүй дээр гэж ярьсан л даа. Анх тэр яриаг нь сонсоод энэ 3D хэвлэгчээр хиймэл гар хийх юм бол олон хүнд тустай юм байна гэдэг дүгнэлтэд хүрээд, маш их сонирхож хийж эхэлсэн.

Би сая 2020 оны судалгаа уншиж байхад манай улсын хэмжээнд жилдээ Сэргээн засалт, сургалт үйлдвэрлэлийн төв болон “Эрхэм чанар” гэсэн энэ 2 газарт тусгай хэрэгцээнд зориулж жилдээ ойролцоогоор 1,500-1,700 орчим хүний хиймэл гар, хөл зэрэг протез хийдэг юм байна. Одоо Мандахнаран маань хүмүүстэйгээ холбогдоод явж байхад чиний 3D принтерээр гар хийдгийг мэдэхгүй хүмүүс их байдаг уу? Өөрийгөө таниулах ажлыг хийж байсан уу?

Хүүхдүүдийн эцэг эхчүүдтэй холбогдоод ийм юм хийж байгаа юм гэж анх танилцуулдаг байсан. Хүүхдүүдэд хиймэл гар хийгээд явахад цаашаагаа тардаг л даа. Жишээлбэл нэг хүүхдэд хийлээ гэж бодоход тухайн хүүхдийн аав ээж эсвэл хүүхэд өөрөө цаашаа хүмүүст хэлээд ам дамжин явдаг. Яг бизнест бүтээгдэхүүн зарж байгаа юм шиг явдаггүй. Яг хийлгэе гэсэн хүнд нь хийж өгөөд мөн аль болох нийгэмдээ ач тустай юм хийе ээ гэсэн бодолтой явдаг.

Анхныхаа хийсэн хиймэл гарыг 11 настай хүүхэд бэлэглэсэн гэж би сонссон. Түүний талаар гоё дэлгэрүүлж ярьж өгөхгүй юу?

Анх 11 настай хүүд хиймэл гар хийж өгч байсан. Уулзаад асуудлуудыг нь сонсож байхад өмнө нь хэлсэнчлэн нэгдүгээрт үнэр ихтэй, хоёрдугаарт тухайн хүүхдийн гарт нь тааруулаагүй Хятадаас орж ирсэн резинэн гар ашиглаж байсан. Эрэгтэй хүүхэд гэхэд таарсан ганц гар нь эмэгтэй хүүхдийн гар байсан болохоор хичээл дээрээ тэр гараа зүүж чаддаггүй, гэртээ хичээлээ хийх гэхэд маш их үнэртдэг, үеийнхээ хүүхдүүдийн дунд зүүгээд явахад “чи эмэгтэй хүүхдийн гартаа явж байгаа юм уу?” гэж асуух хандлага хүүхдүүдээс ирж байсан. Яг тэр асуудлуудыг нь сонсчхоод тухайн хүүхдийнхээ гарт тааруулж загвараа гаргахын тулд эхлээд хэмжээсийг нь аваад, “ямархуу гартай болмоор байна” гэж хүүхдийнхээ сонирхлыг нь асуусан. Тухайн хүүхэд маань роботод маш дуртай хүүхэд байсан. Тэгээд яг роботын загвартай төстэй гар хийж өгсөн. Мөн 3D хэвлэгчээр хийсэн гар маань эдэлгээний хувьд бас резинэн гараас хамаагүй эдэлгээ сайтай гэж би бас хувьдаа үздэг. Яагаад гэвэл резинэн гар нэг талаараа цоорлоо гэхэд нөхөх арга байхгүй. Харин 3D хэвлэгч ашиглаж бүтээсэн хиймэл гарны аль ч хэсгийг солиод хэвлэж болдог.

Үйлдлүүдийн хувьд яг ижилхэн үү? Эсвэл 3D принтерээр хийсэн гар нь илүү сайн үйлдэл хийж байна уу?



Одоо 3D хэвлэгчээр хийсэн гар олон улсад атгах, тавих ойр зуурын үйлдлүүдийг хийдэг. Миний хувьд энэ гар дээр ажиллаад, нэлээн сонирхолтой болоод тэгээд хүүхдүүдэд зориулж нэмэлт төхөөрөмж (gadget) нэмсэн. Нэмэлт төхөөрөмжүүдийг оруулж өгснөөр илүү хүнд материалыг өргөх, зураг зурах боломжийг хүүхдүүдэд олгодог. Мэдээж үнийн хувьд маш хямд. Жишээлбэл, тухайн хүүхдийн эцэг эх нь санхүүгийн бэрхшээлтэй байлаа гэж бодоход бүтэн гарыг авахгүйгээр нэг хэсгийг нь солих, хэсэгчлэн авах боломжтой.

Технологийн хувьд шинэчлээд явах бас боломж байгаа гэж харж байгаа юу?

Би хөл болон хүний ясан дээр 3D принтерийг ашиглаж үзье гэсэн бодол байгаа. Жишээлбэл гэмтэлтэй хөлөнд тааруулж 3D принтрээр хийсэн бүтээгдэхүүнийг хэрэглэх боломжтой гэж үзээд тэр талаар судлаад эхэлчихсэн байгаа.

Ер нь маш их хөрвөх чадвартай, тэгээд зөвхөн гар гэлтгүй бас бусад эрхтнүүдийг ч гэсэн хийх боломжтой гэж би ойлголоо. Хуруу ч юм уу тиймэрхүү зүйл хийдэг үү?

Би хурууг яг хийж үзээгүй ч олон улсад хийдэг юм байна. Гэхдээ хийлгэе гээд хүн ирвэл би нээлттэй хүлээж авна. Яагаад гэвэл

олон улсад хийгдчихсэн болохоор тэрийг судлаад Монголд оруулж ирэх хангалттай боломж байгаа гэж бодож байгаа.

Энэ техник технологиор илүү хямд өртөгтэй, илүү шинэчлэх боломжтой протез хийж байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй олон хүмүүст хэрэгцээтэй зүйл байна. Энэхүү техник технологи гэдэг зүйл цаашид шинэ зүйлийг авчраад эсвэл амьдралыг арай амар хялбар болгоод явах тал дээрээ өөрөө юу гэж боддог вэ?

Одоо их сургуульд байсан үеийнхээ тухай ярья. Би механик инженерээр төгссөн. Бидний амьдралд өдөр тутамд асуудлууд тохиолддог. Тухайн асуудлыг шийдэх шийдэл нь яг өөрөө судалж үзэх юм бол хаа сайгүй байдаг юм байна лээ. Би инноваци, техник технологи сонирхоод хийгээд үзэх юм бол хэн ч, ямар ч асуудлаа өөрөө шийдээд явах боломжтой гэж боддог. Тэгээд 3D хэвлэгч принтерийн хувьд Монголд ойрын арван хэдэн жил нэлээн сайн хөгжих байх гэсэн бодолтой байгаа.

Өөрөөс чинь гадна 3D принтерээр юм хийдэг хүмүүс байдаг болов уу?

Одоо 3D принтер хэрэглэгч, ашиглалтын групп гээд фэйсбүүк групп байдаг. Тэр группд хүмүүс хэвлэсэн юмнуудаа хоорондоо хуваалцдаг, мэдлэгээ хоорондоо ярилцдаг юм байна лээ. Би бас нэлээн гадуур явж үзэхэд инновацийн төвүүд, эрдэм шинжилгээний хүрээлэнд бас 3D принтер ашигладаг хүмүүс байдаг. Монголд яг хиймэл гар дагнаад хийсэн хүмүүс маш цөөхөн. Анх Монголд энгийн хиймэл гар хийж, хүмүүст тусалж байсан нэг Солонгос хүн байсан. Яг Монголчууд дундаа гэвэл намайг анх 2016-17 онд хийж байхад яг тийм гар хийсэн тохиолдол сонсогдож байгаагүй.

Би 3D принтерээр хэвлэсэн гарыг нь хараагүй, яаж хийж байгааг нь мэдэхгүй болохоор үнэнийг хэлэхэд толгойд буухгүй байна. Тэгэхээр яг яаж хийдэг процессын тухай бас хуруугаа яаж холбодог вэ? Тэр талаар дэлгэрүүлж ярьж өгөхгүй юу?

Яг 3D гарны хувьд тухайн хүүхдийнхээ гарны байгаа хэсэг, жишээлбэл үе, тохой нь байлаа гэж бодоход яг тэр тохойнх нь хэмжээ байхад л хангалттай. Яг тэр тохойноос нь эхлээд эсвэл алганаас нь эхлээд компьютер дээрээ хүүхдэд зориулж загвар гаргадаг. Тэр загвараа гаргахдаа хүүхэдтэйгээ өнгө үзэмжийнх нь талаар ярилцаад, компьютер дээр симюляц тооцоо хийнэ. Бас компьютер дээр атгах үеийнх нь тооцоо болон хаалганд нь таарч байна уу гэдэг тооцоо хийнэ. Мөн хэр удаан ашиглахаар байна гэдэг тооцоо бас хийдэг. Яг тооцоогоо хийснийхээ дараа принтерээр хэвлэж эхэлдэг. Ингээд хэвлэхэд 1-2 хоног зарцуулдаг. Хэвлээд дараа нь нэмэлт ганц хоёр материал шаардагддаг. Тэр материалуудаа аваад угсралтад хагас өдөр зарцуулж, хэрэглэгчдээ бэлэн болгоход ойролцоогоор 2-3 хоног зарцуулдаг.

Тухайн хүүхэдтэйгээ 2-3 сарын дараа эргэж холбогдоод ямар асуудал байна гэдгийг нь бас ярьдаг.

Тэгэхээр гар болон хурууны хэсгүүд 3D принтерээсээ хэвлэгдэж гарч ирэхдээ бүхлээрээ гарч ирдэг юм уу? Эсвэл тус тусад нь хэвлээд дараа нь нийлүүлээд холбодог юм уу?

Тухайн хүүхдийн үений хэмжээснээс их хамаардаг. Жишээлбэл хуруугүй хүүхэд байна гэж бодоход яг тухайн хүүхдэд зориулаад гарын алга хэсгийг нь үлдээгээд хурууг нь хэвлэдэг.

Өмнө нь хоёулаа суугаад ярьж байхад протез хийлгэсэн хүүхэд протезтой гараараа бичсэн гэж ярьж байсан. Магадгүй маш олон хүнд сонирхолтой байж магадгүй учраас тэр тухай ярьж өгөхгүй юу?

Тухайн хүүхэд маань зөвхөн эрхий хуруутай хүүхэд байсан. Яг бичсэн гэвэл бас өрөөсгөл. Гарыг ашиглаад том хэмжээнд А үсэг бичих боломжтой байдаг ч жирийн хүмүүс шиг жижиг хэмжээнд бичих боломжгүй. Яагаад гэвэл 3D хэрэглэгч маань цахилгаан ашигладаггүй болохлоор иймэрхүү нарийн үйлүүдийг хийх боломжгүй. Гэхдээ том хэмжээнд зураг зурах эсвэл үсэг бичих боломжтой. Хүүхэд маань яг анх удаа баруун гараараа А үсэг бичиж үзсэн учраас өөрөө нэлээн сэтгэл догдолсон. Төрснөөсөө хойш тийм гартай байсан болохлоор анх удаа А үсэг бичсэндээ маш их баярласан. Бас ээж нь ч гэсэн нэлээн сэтгэгдэл өндөр байсан.

Хэрвээ би байсан бол маш их сэтгэл хөдлөхөөр юм байна. Бас технологи инновацийн старт апын тэмцээнүүдэд орж байсан гэж ярьсан. Яг энэ протез гараараа орж байсан уу, эсвэл өөр санаануудыг дэвшүүлсэн үү?

Ер нь голчлон протез гараараа орсон. Яагаад тэр тэмцээнүүдэд оролцсон бэ гэвэл яг одоо манай улсын хэмжээнд ийм гарны бэрхшээлтэй, өдөр тутам резинэн гар ашиглах шаардлагатай хүүхдүүд олон байдаг юм байна гэсэн судалгаа хийсэн. Тийм болохоор тэр хүүхдүүдэд туслах, нийгэмдээ хэрэгцээтэй зүйл хийхийн тулд хөрөнгө оруулалт шаардлагатай. Тиймэрхүү тэмцээнүүдэд оролцоод хөрөнгө оруулалт авснаараа олон хүүхдэд туслах боломжтой болно. Тэгээд 2019 онд Улаанбаатарын хэмжээнд Сийд Старс гэдэг тэмцээнд ороод шилдэг 10 гарааны компанийн нэгээр шалгарсан.

Тэгэхээр хүнд хэрэгцээтэй зүйл гэдэг утгаараа шилдэг аравт орсон байх гэж бодож байна. Цаашдаа тиймэрхүү инноваци технологийн чиглэлийн тэмцээн уралдаанд орох бодолтой байгаа юу?

Ер нь бодол байгаа. Мэдээж хиймэл гараа бас хөгжүүлээд явах ч хүмүүсийн хөл эсвэл ясны асуудлууд дээр нь тулгуурлаж 3D бүтээгдэхүүн хийх сонирхолтой байгаа гэж хэлсэн. Тийм болохоор олон хүнд туслахын тулд хөрөнгө оруулалт татах

шаардлагатай болохоор хөөцөлдөж үзнэ гэсэн бодолтой байгаа.

Тийм тэмцээнүүдэд ороод явахад хүмүүсийн хандлага хэр байдаг бэ? Жишээ нь шүүж байгаа хүмүүс нь тиймэрхүү протезийн талаар сайн мэдлэггүй эсвэл протезтой хүмүүс нийгэмд олон байна гэдгийг ойлгохгүйгээр зүгээр өнгөрөх хандлага байдаг уу?

Би нэлээн хүмүүст ярьж үзэхэд сонсож байгаа хүмүүсийн бараг 80-90% нь эерэгээр хүлээж авдаг. "Анх удаагаа ийм юм сонсож байна, 3D принтерээр ийм юм бас хийж болдог юм уу" гээд нэлээн эерэг сэтгэгдлүүд ирдэг. Шүүгчидтэйгээ ярилцахад яг бизнес болохын хувьд гэвэл "гарааны компаниудад эхлээд мөнгө их хэрэгтэй болдог, тийм болохоор тэр тал дээрээ анхаарвал зүгээр шүү дээ" гэсэн сэтгэгдлүүд ирж байсан. Ярьсан хүмүүсийн дундаас "аягүй гоё гар болсон байна", "ийшээ очиж үзвэл яадаг юм", "Би чамд ингэж тусалъя, тэгж тусалъя" гэсэн олон саналууд ирж байсан.

Протез хийж эхэлснээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар өөрийн чинь хандлага хэр өөрчлөгдсөн бэ? Өмнө нь тийм байсан, одоо тийм болсон гэх зүйл байгаа юу?

Нэлээн өөрчлөгдсөн. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй харилцахад нэг л эвгүй, тааламжгүй ойлголт нийгэм дунд байдаг. Гэвч яг тулаад харьцаад ирэхээр шал өөр гэдгийг нь мэдэрсэн. Яг харилцахад илүү нээлттэй, илэн далангүй, сайхан сэтгэлтэй



хүмүүс байсан. Нийгмийн дунд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг харах өнцөг эерэг тал луугаа өөрчлөгдөж байгаа гэдэгт би жил ирэх тусам итгэж байгаа. Тэгээд цаашаа харилцаад явахад тус дэм болж, хамт ажиллахад амар байдаг. Нийгэмдээ хандаж хэлэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг анх харахад эвгүй байдаг ч гэсэн яг харилцаад эхлэхээрээ бас сайн хүмүүс байдаг юм байна гэдгийг ойлгосон.

Манай Мандахнаран миленниал, жен зи гэдэг билүү, аль үе вэ?

Би тэр нарийн ширийн юмыг бол сайн мэдэхгүй байна гэхдээ X, Y, Z-ийн аль нэг л гэж боддог. Намайг бага байхад Монголд 2D принтер орж ирэхэд шинэ юм орж ирлээ гээд их өөрчлөлт болж байсан. Яг 3D хэрэглэгчдийн хувьд гэвэл бас яг үүнтэй адил гэж бодож байна. Өнөөдөр 2D принтерийг ажлын хүрээнд хүн болгон ашиглаж байна. Тэгээд би 3D принтерийг хэрэглэгчид маань тун удахгүй яг иймэрхүү өргөн хэрэглээтэй болно гэж бодож байгаа. Шинэлэг технологи маань дэлхийд гараад нэлээн удчихлаа, яг сонирхоод, хэрэглээд үзэх юм бол нэлээн сонирхолтой шүү, хэрэглэж үзээрэй гэж уриалмаар байна.

Миний асуух гэсэн асуулт бол чиний үе тэнгийнхэн, найз нөхдийн чинь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг харах өнцөг, хандлага ямархуу вэ? Чиний үеийн залуучууд хэрхэн харж байгааг мэдэх гэж асуусан юм.

Би 10 жилд Японд сурч байсан. Тэр үед анги болгонд нэг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг заавал суулгадаг байсан. Мэдээж тухайн хүүхдэд юу хэрэгтэй байна гэдэг дээр багш нь дэмждэг, тэгээд бусад хүүхдүүд бас их зөвөөр ойлгодог. Японд 1-р ангиас хойшоо бараг хамт сураад эхэлдэг учраас дунд, ахлах ангид ороод тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг харах өнцөг маань маш их өөрчлөгдчихдөг. Олон жил хамт нэг ангид сурахаар хүүхдүүд хоорондоо дасаад, ахлах ангидаа ороход ямар ч асуудалгүй жирийн үе тэнгийн найзууд шиг харилцаад явчихдаг. Монголын хувьд гэвэл яг тиймэрхүү бодлого байвал багш, эцэг эх, сургууль нь дэмжээд явчихдаг бодлогууд одоо хэрэгжиж байгаа. Тэгэхдээ илүү сайжрах боломжтой гэж хувьдаа харж байгаа. Үе тэнгийнхний хувьд гэвэл үе үеэрээ харах өнцөг нэлээн эерэг тал уруугаа өөрчлөгдөж байгаа гэж би боддог.

Манай өмнөх оролцогч нар маань бас багаасаа хамт сурдаг энэ Японы жишээг бас ярьж байсан. Тэгэхээр тэр жишээний маань бодит хүн манай Мандахнаран болж таарлаа.

Би яг 10 жилдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст иймэрхүү юм хийж өгнө гэж ерөөсөө бодож байгаагүй. Тэгээд яг инноваци, техник технологийн сонирхолтой болоод ийм юм хийж болох юм байна гэж бодоод, тэр сонирхолдоо хөтлөгдөөд л явчихсан. Хүүхэд байхдаа боддоггүй юмнууд том болоод, эрийн цээнд хүрэхээр шал өөр өнцгөөс харагддаг юм байна. Тэгээд шинэ

технологийг сонирхоод эхлэхээр өдөржин шөнөжингөө бодогддог. Тэгээд л унтахдаа ийм юм хийж болох нь гэсэн шинэ санаа төрөхөөр тэмдэглэлийн дэвтэр дээрээ бичдэг, их сонирхолтой ажил л даа.

Өөрийнхөө санааг нүдэнд харагдаж, гарт баригдахуйц бүтээгдэхүүн болгоод гаргана гэдэг маш сонирхолтой санагдаж байна. Цаашдаа хэтийн төлөвлөгөө ямархуу байна?

Хиймэл гарны хувьд хүрч ирээд, хийлгэе гэсэн хүмүүст асуудалгүй хийж өгнө. Одоо шинэлэг технологиуд дэлхий дахинд нэвтэрч байна, тэдгээрийг Монголд ашиглавал зүгээр гэж бодож байна. Бас одоо Монголын нийгэм асуудалтай байгаа зарим асуудлуудыг шийдье гэсэн бодол байгаа. Тэгээд хөл болон ясан дээр цаашлаад яг 3D хэрэглэгчийнхээ хувьд судлаад явъя гэсэн бодол байгаа.

Урилгыг минь хүлээн авч, оролцож байгаад маш их баярлалаа. Магадгүй энэ 3D принтерээр протез хийдэг гэдгийг мэдэхгүй явсан хүмүүс олон байгаа байх. Цаашдаа ч гэсэн Мандахнаранд олон хүмүүс хандаад протез хийлгэх байх. Манай подкастын хамгийн сүүлийн асуулт ковидтой холбоотой байдаг. Энэ ковид цар тахал протез хийх үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байна вэ? Эсвэл протез хэрэгтэй байгаа хүүхэд олоход хүндрэл тулгарч байна уу?

Уламжлалт төмөр үйлдвэрлэдэг ч юм уу үйлдвэрт заавал хүн байх ёстой. Харин 3D хэвлэгчийн хувьд гэвэл компьютер дээр загвараа гаргачхаад шууд хэвлэх товч дарахад л болчихдог учраас хүмүүсийн хэрэгцээ бага гардаг. Тийм болохоор ковидын хувьд бусад салбаруудыг бодвол асуудал харьцангуй бага гэж би бодож байна. Мэдээж хэрэглэгчидтэйгээ утсаар, чатаар, видео яриа хийгээд явчихдаг.

Ийнхүү манай подкастанд хүрэлцэн ирж орсон Мандахнарандаа маш их баярлалаа. Цаашдынх нь ажилд амжилт хүсье! Антолд подкастаар дамжуулж өөрийнхөө хэлэхийг хүсэж байгаа зүйл байвал ашиглаад хэлж болно шүү.

Одоогийн нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулж подкаст хийж байгааг би анх удаагаа сонсож байна. Яг үнэндээ манайхан чинь ихэвчлэн бизнес, ном гээд шал өөр өөр юмнууд ярьдаг. Подкастандаа урьж оролцуулсанд баярлалаа. Би өмнө нь оролцож байсан хүмүүсийн ярилцлагыг сонсоод нийгэмд одоо дутагдаад байгаа сонирхолтой асуудлуудыг хөндсөн болохоор маш чухал подкаст гэж бодож байгаа. Тэгээд та бүхэн сайн үйлс хийж байгаа юм байна. Энэ подкаст нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хандах хандлагыг нэлээн өөрчилнө гэж бодож байна. Тийм болохоор сайн үйлс улам дэлгэрэх болтугай гэсэн ерөөл дэвшүүлье. Тэгээд та бүхний ажил амьдралд хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе!

За баярлалаа.

Бүгдээрээ хамтдаа хөгжлийн бэрхшээлтэй

иргэдийг, хүүхдүүдийг ойлгож, хүндэтгэж байя. Нийгэмдээ бүгдээрээ гэрэл асаая, хайр түгээе гэдэг уриаг хэлмээр байна.

За баярлалаа танд.



“ЧАДАХГҮЙ” ГЭЖ ЗОГСОХГҮЙГЭЭР “ЮУ ЧАДАХ ВЭ” ГЭДЭГ ДЭЭР ТӨВЛӨР

Такахаши Кимико



Сайн байцгаана уу, эрхэм хүндэт сонсогчид оо, Антолд подкастын маань ээлжит дугаар эхлэхэд бэлэн болоод байна. Энэхүү дугаарт Сүжеташанд төрийн бус байгууллагын гүйцэтгэх захирал Такахаши Кимико оролцож байна. Та урилгыг маань хүлээн авсанд баярлалаа. Та өөрийнхөө болон төрийн бус байгууллагынхаа талаар дэлгэрэнгүй мэдээллийг бидэнд өгөхгүй юу?

Сайн байцгаана уу? Намайг Кимико гэдэг. Өнөөдөр намайг дуудаж ярилцлагад оролцуулж байгаад баярлалаа. Манай байгууллага Сүжеташанд гэдэг нэртэй. Энэ Сүжет бол бурхан багшийн түүхтэй холбоотой. Сүжет гэдэг Энэтхэг эмэгтэйн нэртэй байгууллага. Манай байгууллага анх 2011 оноос хөгжлийн бэрхшээдэг хүүхдүүдэд сургалт зохион байгуулж ирсэн бөгөөд би өөрөө цэцэрлэгийн багш, сургуулийн өмнөх насны мэргэжлийн хүн.

Та Монголд анх хэзээ ирсэн бэ?

Би анх бүр 1998 онд ирж байсан. Тухайн 1998-2000 он хүртэл Дарханд ЖАЙКА-гийн сайн дурын гишүүнээр ажиллаасан. Тэрний дараа 3 жил Японд байж байгаад 2004 оноос одоо хүртэл Улаанбаатарт амьдарч байна.

Та Улаанбаатарт 2004 онд ирснийхээ дараа Сүжеташанд төрийн бус байгууллагаа байгуулсан юм уу?

Би 2004-2010 оны хооронд хувийн цэцэрлэгт ажиллаж байсан. Манай байгууллага 2011 оноос онд үүсгэн байгуулагдсан.

Та төрийн бус байгууллага байгуулах болсон шалтгаан нь юу вэ? Яагаад төрийн бус байгууллага байгуулахаар шийдсэн бэ?

Хувийн цэцэрлэгт ажиллаж байх үед "сургуулийн өмнөх боловсролын талаар надад багш нарт заах юм байхгүй, дууссан юм байна" гэж бодож байсан үед хөгжлийн бэрхшээлтэй буюу тархины саажилттай хүүхэдтэй хүн над дээр ирээд "Кимико багш аа манай хүүхдийг аваад өгөөч ээ" гэж гуйсан. Тэр хүүхдийн тухай энэ хүүхэд цаашдаа яаж амьдрах вэ? гээд хүүхдийн ирээдүйн тухай жаахан бодсон. Тэр үед хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тухай одоо үе шиг их ярьдаггүй байсан. Тэгээд тэр хүүхдийг яах вэ? гэж бодоод, "ийм бэрхшээлтэй хүүхдийн талаар надад хийх юм байгаа юм байна" гээд төрийн бус байгууллага нээсэн юм.

Анх та төрийн бус байгууллагаа байгуулаад явж байхад хүндрэл бэрхшээлүүдтэй тулгарч байсан байх. Ямар ямар бэрхшээл тулгарч байсан бэ? Танд хамгийн хэцүү нь юу байсан бэ?

Монголын хуулийн дагуу санхүү, нийгмийн даатгал, татварын асуудал надад маш их хэцүү байсан. Би багш мэргэжилтэй. Хүүхэд хараад, хүүхэдтэй л ажиллаж байсан учраас ерөөсөө санхүүний талаар мэдэхгүй. Монголд ажил дээр хэрэглэж байгаагүй шинэ үгнүүд олон гарч ирсэн. Нэгдүгээрт энэ бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллахаас илүү маш хэцүү байсан. Хоёрдугаарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллая гэж бодсон ч гэсэн мэдэхгүй, сураагүй, сурах зүйл их гарсан. Тийм учраас хүүхдүүдтэй ажиллаж байх үедээ би өөрөө интернетээс, номноос их юм уншдаг байсан.

Та анх төрийн бус байгууллага байгуулж байх үедээ ямар хүмүүстэй нийлж байгуулж байсан бэ? Ганцаараа шууд байгуулъя гээд байгуулж байсан уу, эсвэл монгол хүмүүстэй хамтарч байгуулж байсан уу?

Манайд одоо ч гэсэн багш гэдэг хүн би ганцаараа байгаа. Үүнд олон янзын учир шалтгаан байгаа. Жишээлбэл олон хүн байвал санхүүгийн талаар ч гэсэн мөнгө их хэрэгтэй болно. Тийм болохоор олон багштай хамтарч ажиллаж чадаагүй. Тийм учраас би бусад байгууллагуудтай хамтраад ажиллая гэж бодсон. Жишээлбэл бусад байгууллагатай хамт ажиллах нь илүү үр дүнтэй гэж бодоод Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхдүүдтэй Эцэг Эхийн Холбоо, Нийслэлийн Боловсролын Газар, НҮБ-ийн Хүүхдийн Сан ЮНИСЕФ, Дэлхийн Зөн, өөр цэцэрлэг дээр очиж үзэж байсан. Би ганцаараа багшилдаг учраас хүлээж авах хүүхэд маш цөөхөн учраас багш нэмж ажиллуулъя гэсэн бодолтой байсан. байгаа. Харин манай байгууллага дээр ирж уулзаж байсан хүмүүс "Кимико багш аа та өөрөө цэцэрлэг нээж ажиллахгүй юм

уу” гэж надад зөндөө хэлсэн. Нэг байшин бариад, цэцэрлэг баривал “өө Кимико багш энэ ажлыг хийж байна даа” гэж хүмүүс бодно байх. Тийм учраас би мөнгө байсан ч цэцэрлэг нээхгүйгээр Монголын бусад байгууллагатай хамтарч ажиллана гэсэн санаатай байсан.

Та сургууль, цэцэрлэгт явдаггүй хүүхдүүдэд ихэвчлэн боловсрол олгодог байсан, одоо ч олгож байгаа, тийм ээ?

Тийм. Эхний 5 жилд хөгжлийн бэрхшээлтэй учраас цэцэрлэгт орж чадаагүй хүүхдүүдийг гэртээ үзэж байсан. Дараа нь сургууль цэцэрлэгт орж чадаагүй хүүхдийн групп сургалт гээд гэртээ ойрхон нэг газарт хүмүүсийг цуглуулаад явуулдаг байсан. Одоогоор явж байгаа хүмүүс бий, бас яваагүй хүмүүс бас бий.

Та Монголд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллахдаа юун дээр илүү анхаардаг вэ?

Эхний үед хүүхдэд юм суръя, сурмаар байна гэсэн хүслийг хүүхдэд төрүүлье гэж бодож байсан. Одоо бол бэрхшээлтэй учраас тэр санаагаа бүр хаяад, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй харьцъя гэсэн бодлоор л бэрхшээлтэй хүүхэдтэйгээ хамт байгаа.

Танд Монгол болон Японд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүдийн ялгаа харагддаг уу?

Би Японд байхдаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар ажил хийж үзээгүй хүн. Монголд ирээд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй гүнзгий ажиллаж эхэлсэн. Тийм учраас яг ялгаа гэвэл надад байгаа ч юм шиг, үгүй ч юм шиг санагддаг. Гэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхчүүд бүгдээрээ үргэлж хүүхдийнхээ ирээдүйн тухай санаа зовдог. Бүр хүнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тухайд бол эцэг эхчүүд нь дандаа айдаг байж магадгүй. Тийм учраас яг Монгол, Япон гэж бодохгүйгээр бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүд бүгд ижил санаатай байдаг гэж боддог.

Та Монголд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд боловсрол олгоод явж байна. Тэгэхэд боловсролын салбарыг харахаар Монголд юуг нь өөрчлөөсэй гэж боддог вэ?

Эцэг эхээс төрсөн хүүхэд бүр ижилхэн биш. Тархины саажилт ч гэсэн Монгол хүмүүс шиг маш олон янз байгаа. Жишээлбэл Монгол хүмүүс дотор кофенд дуртай эсвэл сүүтэй цайнд дуртай хүн бий. Сүүтэй цайнд дуртай хүмүүс дотор давс их, бага, ерөөсөө хийхгүй цай уудаг янз бүр хүмүүс байж байгаатай ижилхэн тархины саажилт дотроо хүнд, хөнгөн гэвэл маш олон янз байдаг. Аутизм, оюуны бэрхшээ л ч гэсэн адилхан. Тэгж бодвол бэрхшээлтэй гэж онош байгаа ч гэсэн оношноос гаргаад энэ хүүхдийг юу чадах, юу чадахгүйг тодорхой мэдээд, хүүхэддээ таарах хичээлээ заах хэрэгтэй гэж бодож байгаа. Жишээлбэл би одоо 50 гарсан хүн. Монголд 50 гарсан хүн дэлхий, засаг

газар, хобби гээд янз бүрийн зүйлийн тухай ярина. Би бол дандаа хүүхдийн талаар ярьж ирсэн учраас хүүхдийн талын үгнүүд арай чөлөөтэй байгаа. Засгийн газар, дэлхийн тухай бол миний мэдэхгүй үг олон бий. Миний нас ямар ч хамаагүй шүү дээ. Миний мэдэж байгаа үгийн төвшинд таарч ярихгүй бол би юу ч ойлгохгүй.

Та бас маш олон гоё гоё төслүүдийг хэрэгжүүлсэн байсан. Би хараад ийм гоё төслүүдийг хэрэгжүүлдэг Япон хүн байдаг юм байна гээд бүр гайхсан. Та саяхан Гоё ирээдүй гээд төсөлд оролцоод, хөдөө орон нутгаар явсан байсан. Та тэр төслийнхөө талаар ярьж өгөхгүй юу?

Бид нарт ч гэсэн ингэмээр юм байна гэсэн санаа, мөрөөдөл гэж байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд дөнгөж 5, 6, 10 настай учраас гоё юмыг нүдээрээ харж, чихээрээ сонсоогүй тул ирээдүйн тухай сайн бодож чадахгүй учраас бид нар хүүхдийн гоё ирээдүйн тухай бодох хэрэгтэй. Гэхдээ гоё гэдэг янз бүр шүү дээ. Зарим хүн багш гоё гэж бодож байхад, зарим нь мужаан, машин засварчин, цагдаа гоё гээд янз бүр байгаа. Тийм учраас гоё ирээдүйн тухай бид нар бодно. Гэхдээ хүүхэд төсөөлөхгүй, сайн мэдэхгүй учраас бид олон төрлийн юм үзүүлж, хүүхэддээ янз бүрийн боломжийг гаргаж туршлагатай, харьцаатай гоё ирээдүйг хүүхдүүддээ өгөг үүднээс би өөрөө явсан юм.



Энэ төсөл дээр та гоё ирээдүй гэдгийг хүүхдүүдэд таниулах үүднээс ярилцсан гэсэн үг үү?

Тийм, ингэж хүүхэдтэйгээ хамт байвал яах вэ гээд эцэг эхчүүдтэй ярилцсан. Бэрхшээлгүй хүүхдүүдийн ч ирээдүйн тухай бодоход амар биш. Гэхдээ бэрхшээлтэй хүүхдүүдийн тухай бодоход бүр хэцүү. Жишээлбэл гар ажиллахгүй, оюуны хоцрогдолтой байгаа хүүхдийн талаар том болоод юу чадах вэ, үсгээ цээжлээгүй бол яах вэ? гээд бодно. Үсгээ цээжлээгүй ч гэсэн ямар нэгэн аргаар, тусламж аваад амьдарч чадна гэж би бодож байна. Тийм учраас хүүхдийнхээ ирээдүйн тухай хааяа хааяа бодож хүүхэдтэйгээ харьцаж байгаарай. Жишээлбэл оюун ухаан хоцорч байгаа ч гэсэн бие бялдрын талаар асуудалгүй бол хамт гэрийн ажлаа хийгээд, төмс хальслаад, угаагаад гээд бодвол ирээдүй өөр байна. "Чадахгүй байна аа, чадахгүй байна аа гээд чадахгүй дээр нь төвлөрөх юм бол ирээдүйн тухай бид нар бодож чадахгүйд хүрч байгаа учраас юу чадах вэ?" гэж бодох хэрэгтэй гэж эцэг эхчүүдтэй ярилцаж байсан.

Та заах арга барил дээрээ юуг анхаарч ажилладаг вэ?

Багш нарт бол хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй харьцахдаа эвий эвий гэж биш, энгийн хүн шиг харьцаатай бай. Эвий эвий гэж харьцахын оронд, юу чадах вэ? гэж бодох хэрэгтэй гэж багш нартаа хэлдэг. Энэ хүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг өө яасан хэцүү юм бэ? гэж бодохоос илүү энэ хүүхэдтэй би яаж харьцах ёстой юм бэ? Би яавал энэ хүүхэд илүү инээдэг болох вэ? гэсэн бодолтой ажиллаарай гэж хэлдэг. Эцэг эхчүүдэд бол хүн бүр нэг хүн. Тэгээд сая ярьсан чадахгүй зүйл дээр төвлөрөхгүйгээр, чаддаг юмыг олоод дуртай юмаар нь хүүхдийнхээ хөгжлийг сайжруулъя гэж хэлдэг.

Та хүүхдүүдтэй ажиллахдаа ямар талаас нь хүүхдүүдийг илүү хөгжүүлээсэй гэж боддог вэ?

"Би чадна, би хиймээр байна" гэсэн бодолтой болгоё гэж боддог.
Өөрт хүсэл бий болгох ёстой байна шүү дээ, тийм ээ?

Жишээ нь харанхуй өрөөнд так гэж нэг дарахад гэрэлтэй ассан. Яагаад гэрэлтэй болсон бэ? Тэр бол магадгүй дуу чимээ сонсоод гэж бодож магадгүй. Харж чаддаг хүнд бол харанхуй өрөө гэрэлтэй болсон байгаа. Эхлээд яагаад тэгсэн бэ? гэсэн сонирхлыг нь төрүүлээд, үүнийг дарвал гэрэл асна, үүнийг дарвал унтрана гэж хийх арга зааж өгнө.

Та сая хөдөө эцэг эхчүүдэд гоё ирээдүй төслөөрөө семинар хийгээд явахад хөдөө болон хотын ялгаа мэдрэгдсэн үү?

Гоё ирээдүй төслийн хүрээнд 1 л аймагт очоогүй. Бусад аймгуудад эцэг эхчүүдтэй би уулзсан. Тэгэхэд эцэг эх бүрийн санаа зовж байгаа, хүсч байгаа зүйл ижил байсан. Гэхдээ суманд амьдарч байгаа эцэг эхчүүд

боломж багатай. Интернет сайн хүрэхгүй. Би юмаа ярьж чадах боловч миний нүүр царайг гаргаж чадаагүй. Хотын хүмүүс бол камер нээгээд, миний нүүр царайг хараад ярьж болно. Суманд байгаа тэр хүмүүст ялангуяа боломж маш бага учраас хотод байгаа хүмүүсийг бодвол боломж нь жаахан хэцүү гэж бодож байна.

Та авиа зөв дуудлагыг хөгжүүлэх ном гаргасан. Та яагаад энэ номыг гаргах болсон бэ?

Эцэг эхчүүдээс надад хэлдэг зүйл нь бараг 100% манай хүүхэд ярихгүй байна аа гэдэг. "Кимико багш аа, манай хүүхэд ярихгүй байна аа, яах вэ?" гэдэг. Эцэг эхчүүд, хүүхэдтэй уулзаад ярихгүй байгаа шалтгааныг нь бага багаар мэдэж авдаг. Яаж хүүхдийн ярианы хөгжилд туслах вэ? гэж бодоод энэ номны загварыг бодож олсон. Би анх 30 настайдаа монгол хэл сурч эхлэхэд надад маш хэцүү байсан. Багш сайн зааж өгч байгаа ч би үг цээжилж чадахгүй, цэвэрхэн ярьж чадахгүй байсан. Хүүхэд бас адил байх. Жишээ нь юу гэнэ ээ, юу ярьж байгаа юм, чиний яриаг би ойлгохгүй байна гэхэд би сэтгэл дотроо гунигладаг. Хүүхэд бас ижил байх гээд сонирхолтой хэлбэрээр дасгал гэж бодохгүйгээр амны дасгал болдог номыг гаргая гэж бодсон.

Жишээлбэл энэ номонд авиаг хэрхэн зөв дуудах аргуудыг оруулсан гэсэн. Та ганц хоёр жишээ ярьж өгөхгүй юу?

Энэ номыг хэл ярианы Мөнхнасан багшаас зөвлөгөө аваад, миний санаагаар ярианы шад гэдэг аргаар хийсэн. Жишээлбэл бусад хүмүүс хэрээ яаж дуугардаг вэ? гэж асуувал "гуаг гуаг" гэж дуугарна. Тэгэхдээ 2 настай, зарим 3 настай ч гэсэн сайн ярихгүй байгаа хүүхэд бол гуаг гуаг гэж дуугарахаасаа өмнө "гуга гуга" гэж дуугардаг. Гуга гугагийн гэж дуугарахын



өмнө “уа уа” гэж байна. Ярианы шат байгаа гэсэн багшийн санааг аваад эцэг эхчүүдэд, багш нартаа тайлбарлаж өгсөн. Хэрээг “гуаг гуаг” гэж ярьж чадахгүй хүүхдийг гуаг гэж ярианч ээ гэж шаардалгүйгээр, “гуга гуга” гэж хэлүүлэлгүй гуаг болохгүй. Гуга байхгүй учраас гуаг болохгүй гэж бодоод “ууаа”-гаасаа эхэлдэг. Би шад гаргаж чадсан гэж маш их баяртай байсан. Хоёрдугаарт амьдралд ч гэсэн амны дасгал болдог авиа олон байдаг. Жишээ нь хоол идэхэд ням ням ням гээд амаа хөдөлгөдөг. Бид нар мах хазаж байхад хэл наашаа цаашаа хөдөлгөж байдаг нь бас хэлний дасгал болдог. Тийм учраас идэж байхад ч гэсэн амны дасгал болж байгаа гэсэн нэг жишээ.

Та номоо гаргаад олон эцэг эхчүүдэд өгсөн үү?

Энэ номыг зарж байгаа учраас номын дэлгүүрт байгаа. Би Хөвсгөл аймагт номын дэлгүүрт ороход миний ном байхад нь аймаар баярласан.

Та бас насанд хүрэх шат гээд хүүхдийн хүмүүжлийн талаарх цуврал ярилцлагад орсон байсан. Та хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хүмүүжилд хамгийн чухал нь юу гэж боддог вэ?

Бид нартай бол итгэлцэл. Айж байгаа хүндээ бид нар сэтгээлээ нээж чадахгүй. Энэ хүн дандаа намайг загинадаг гэж бодвол бид тэр хүнтэй бодсон юмаа чөлөөтэй ярьж чадахгүй. Бас бид нарыг тоохгүй хүнд ч гэсэн энэ хүн намайг тоохгүй, дургүй байна гэж бодвол бид нар тэр хүнтэй харьцах хүсэлгүй болно. Тийм учраас эхлээд итгэлцэл маш чухал. Тэрний дараа сэтгэл хөдөлгөж, бие хөдөлгөх. Биеийн хөдөлгөөн сэтгэл хөдлөлтэй маш их холбоотой байдаг. Жишээлбэл нэг кафед ороод маш гоё амттай кофе, амттай торт идье гэж бодоод идэхэд үнэхээр амттай кофе, амттай торт байсан бол бид нар баярлаад дахиж тэнд очьё гэж сэтгэл хөдөлнө. Магадгүй найзтайгаа утсаар ярья гэж сэтгэл хөдөлнө. Тэгээд дахиж найзтайгаа уулзаад гоё гэж санагдсан учраас дахин ирнэ. Тийм болохоор сэтгэлийн хөдөлгөөн маш их холбоотой байгаа даа. Энэ талаар ярьж, хүүхэдтэйгээ харьцахдаа сэтгэл хөдлөлөөр нь дамжуулж харьцах нь чухал гэж бодож байна.

Тэгэхээр эхдээд хүүхдийн сэтгэлийг нь хөдөлгөж байж биеийг нь хөдөлгөнө гэсэн санаатай юу?

Тийм, гэрэл асаах бас адилхан. “Өө юу вэ” гэж бодсоны дараа өөрөө асаамаар, өөрөө олмоор байдаг тэр бас сэтгэлийн хөдөлгөөнтэй холбоотой шүү дээ.

Тэрнээс гадна бас итгэлцэл чухал юм байна, тийм үү?

Итгэлцэл байхгүй бол би гэрэл асаамаар байна гэж бодсон ч гэсэн хэлж чадахгүй, чимээгүй сууна. Итгэлцэл бол дурааараа харьцаа биш, зөв харьцаа юм шүү. Бүгдийг зөвшөөрөх бас биш шүү дээ. Болохгүй юм байвал болохгүй гэдгээр нь, сайн байвал сайн гэдгээр нь ярина.

Монголд эцэг эхчүүд хүүхдээ "эвий эвий" гэж их харьцдаг. Танд ямар санагддаг вэ?

Эвий эвий нь бас байгаа. Гэхдээ хатуу тал ч бас байгаа. Баланс муу юм шиг санагдаж байгаа ч гэсэн зарим нь хэтэрхий "эвий эвий", зарим нь хэтэрхий хатуу. Хоёр янз байгаа юм байна.

Тийм байж магадгүй. Гэхдээ уучлаарай би Монголд байгаа учраас тэгж хэлж байгаа байх гэхдээ дэлхийн бүх эцэг эхчүүд бүгдээрээ тийм байж магадгүй. Би зөвхөн Монголд биш Япон бас тийм хүн байгаа байх гэж бодож байна.

Ковид цар тахлын үед танай байгууллага ажиллаж байгаа юу?

Ажиллаж байгаа.

Ковид цар тахал танай байгууллагын үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгаа вэ?

Манай байгууллага онлайнаар сургалт явуулж байгаа. Онлайнаар явж байгаа ч гэсэн биеэр үзэх туршлага маш муу байгаа гэж санагдаж байна. Жишээлбэл онлайнаар багшийг харж, багшийн дууг сонсож, багш юм үзүүлж байна. Хэдийгээр хүүхэд харсан ч гэсэн тэр бүр барьж үзэж чадаагүй учраас хатуу юм уу, зөөлөн юм уу мэдэхгүй. Хүүхэд биеэр үзэж байж илүү туршлагатай болдог. Халуун юмыг халуун гэж бодоод л цаашдаа болгоомжтой болно. Машин хажуугаар нь хурдан явбал машин аюултай гэж биеэрээ үзээд илүү сайн мэддэг. Онлайнд бол тэр талаараа хэцүү. Тэгээд манай хүмүүсийн хичээл их тасарч байгаад уучлаарай.

Би танаас танай байгууллага болон таны хийж байсан төслүүдийн талаар асуулаа. Одоо таны тухай мэдэх гэсэн юм. ЖАЙКА-д ажиллаад дараа нь та яагаад Монголд буцаж ирэх болсон бэ?

Тэр үед бол зоригтой ирээгүй, учраарай. Японд 3 жил байсан ч Монгол хэлээ мартаагүй байсан. Тэр үед ЖАЙКА-гийн шугамаар хамт ирж байсан найз Улаанбаатарт ажиллаж байсан. Тэгээд би зуны амралтын үед найзтайгаа уулзъя гэж ирэхэд "Кимико манай цэцэрлэгт ажил байгаа шүү дээ" гэж хэлсэн. Тэгээд л би буцаад ирье дээ гэж бодоод буцаж ирсэн.

Та тухайн үедээ монгол хэл яаж сурч байсан бэ? Гадаад хүмүүс ерөнхийдөө Монгол хэлний дуудлага нь ч хэцүү гэдэг шүү дээ.

Тийм хэцүү, хэцүү. ЖАЙКА-гийн шугамаар Монголд ирэхээс өмнө бид нар 3 сар яг монгол багшаар хичээл заалгасан учраас дэлгүүр яваад юмаа авч чадна, хүнтэй харьцаж чадна. Одоо ч гэсэн миний хувьд монгол хэл хэцүү байдаг. Миний яриаг сонсоод "та юу ярьж байгаа юм, би ойлгохгүй байна" гэж байгаа хүмүүс олон байна.

Би анх удаа Монголоор аймаар сайн ярьдаг гадаад хүнтэй уулзаад надад маш гоё санагдаж байна.

Таны хүсэл мөрөөдөл юу вэ?

Миний мөрөөдөл бараг 10 жилийн өмнөхөөрөө байгаа. Энэ бол мөрөөдлөө бодит болгох. Одоогоос 10 жилийн өмнө манай байгууллага анх байгуулагдаж байхад хүүхэдтэйгээ ажиллахаас илүү санхүүгийн талаар бодохоор сэтгэлд гуниг төрдөг байсан. Би хүүхэдтэйгээ ажиллах хэрэгтэй ч гэсэн их цаг авсан ийм юм хийх, шинэ юм сурах хэрэгтэй байсан. Тэр үед больё больё, энэ нь амар гээд Япон руу буцаж ч чадах байсан. Эсвэл төрийн бус байгууллагаа хаагаад хувийн цэцэрлэгүүдэд ажиллаж чадах байсан. Гэхдээ би хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар ингэж болмоор байна гэдэг санаагаа бодит болгоё гэж хичээж байсан байгаа. Чадахгүй байна, энэ ажлыг хийхгүй гээд гомдох амархан, хүнийг муу гэж ярих маш амархан. Засгийн газар муу гэж ярих амархан. Гэтэл би гомдохоосоо илүү "би юу хийж чадах вэ, би юу хийх ёстой вэ, яагаад ийм байгууллага нээсэн юм бэ? гэж бодоод, гомдсон ч гэсэн эхлээд тайвшраад, дараа дахиж урагшаа явъя" гэж бодсон. Хүн бүрд гомдох үе гардаг. Гэхдээ өөрийнхөө мөрөөдлийг дагая, мартахгүй байя гэсэн бодол байсан. Ийшээ, тийшээ явсан ч гэсэн энэ надад байдаг миний гол зорилго. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд учраас чадахгүй гэж битгий төвлөр гэдэг нь миний зорилготой холбоотой. Би яагаад энэ хүүхдүүдтэй хамт байна вэ? гэж бодвол чадахгүй дээрээ төвлөрөлгүйгээр, энэ хүүхэд нүдээрээ над руу хариу өгч байна. Хашхирч байсан ч тэгж байгаад тайван болно гэж аргаа олоод цаашаа явна. Тийм учраас бодит болгож, хичээх хэрэгтэй.

Аливаа мөрөөдлийг бодит болгох нь чухал гэсэн санааг та хэлж байгаа юм байна?

Тийм, мөрөөдөл жаахан өөр байж магадгүй.

Таны зүгээс бид нарт өгөх зөвлөгөө юу байгаа вэ? Жишээлбэл хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар үйл ажиллагаа явуулж байгаа олон байгууллагууд байгаа л даа. Тэр газруудад танд сая өгснөөс өөр өгөх зөвлөгөө юу байгаа вэ?

Буцааж хариу хэлэх. Заримдаа Монгол хүмүүстэй хамт хурал хийхэд "өө ямар гоё санаа вэ? Тэгье тэгье" гэж дуусдаг. Тэгээд цаашаа явах санаа байна, явахгүй юм бас байгаа. Явахгүй санаа байвал холбоо барьж чадахгүй болдог. Тэр яах вэ, Яасан бэ? гэж асуувал утсаа ч авахгүй алга болдог. Би мэдэхгүй гэж байгаа юм. Тэр үед тийм ээ гэж олсон санаа салхинд хийсч байгаа юм шиг санагддаг. Яагаад тийм санаа гарсан юм бэ, яагаад хурал хийсэн бэ, юу хиймээр болоод хурал хийсэн бэ? гэж буцаад ярилцах хэрэгтэй. шүү дээ. Хүмүүс дандаа доошоо хараад уйтгартай царай гаргаад явахгүй, дээшээ харж явна гэсэн үг. Яана аа гээд доошоо газар хараад явахгүй, урагшаа хараад, тэнгэр хараад би чадна гэж бодоод явдаг. Гэхдээ бид нар бодсон юмаа бодит болгоё гэвэл хөл харах хэрэгтэй гэж боддог. Яг

юун дээр байна вэ, яагаад энд байна вэ? Тэгэхгүй бол худлаа төлөвлөгөө гарна. Жишээлбэл хөгжлийн бэрхшээлтэй, сайн ярья чаддаггүй, зөвхөн аа аа аа аа гэж илэрхийлдэг хүүхэд байна гэж бодъё. Бүх юм нь аа аа аа. Цай ууя гэж хэлж чадахгүй. Хуруугаараа заагаад, нүдээрээ заагаад, миний гараас хөтөлж аваад намайг авч яваад аа аа гэж ус руу заадаг. Энэ хүүхдийг ус уумаар байна аа гэж ярьж чаддаг болгомоор байна. Чи ус гэж хэл, ус уумаар байна гэж хэлэхгүй яасан юм гэж хэлсэн ч яагаад ус уумаар байна? гэж ярьж чадахгүй байгаа шалтгааныг нь мэдэхгүй бол хэзээ ч ярьж чадахгүй. Амны асуудал юм уу, ус гэдэг үг цээжлээгүй юм уу? Цээжлээгүй бол ус уумаар байна гэж ярьж чадахгүй. Улсын хэмжээнд бэрхшээлтэй хүүхдийн талаар яриад байж болно, гэхдээ хиймээр байна. Салхитай хамт явдаг төлөвлөгөө хэрэггүй биз дээ. Хөл хараад 1, 2, 3 гээд урагшаа явж чаддаг төлөвлөгөө хэрэгтэй. Тэгээд энийг маш чухал гэж боддог. Гэхдээ энэ амархан биш. Заримдаа өөрийнхөө хөлийг хараад хүмүүс яана аа гэж өөрөө ичнэ, яагаад урагшаа явахгүй байгаа юм бэ? гэж гомдоно, зарим нь уурладаг. Тийм үед би гэртээ цэвэрлэгээ хийдэг. Одоо гэртээ байгаа учраас чангаар дуу дуудна, шоколад иднэ, кофе ууна. Тэгээд сэтгэл тайван болоод миний мөрөөдөл ийм байсан, миний чадал ийм байна гэж дахиж хөл харж чадна байх.

Яг бодит байдлаа хараад, шалтгааныг нь харах чухал гэж би таны санааг ойлголоо. Та Монголд олон жил амьдарсан. Магадгүй дунд нь Япон руу олон явдаг байх. Монголд хөгжлийн бэрхшээлтэй хүн амьдрахад танд нөхцөл байдал хэр санагддаг вэ?

Гадаад хүн монголд ирээд үү?

Жишээлбэл би Монголд хөгжлийн бэрхшээлтэй хүн байсан бол миний амьдрах орчин ямар байгааг та гаднын хүний өнцгөөс харвал ямар санагддаг вэ?

Би монголын зарим гудамжаар яваад монголчууд япон хүнээс илүү тэнцвэр сайтай юм гэж боддог. Зам ийм хэцүү үед ч гэсэн хүн ерөөсөө унахгүй, замтай таарч явж чаддаг. Гэхдээ тархины саажилт эсвэл ямар нэгэн биеийн асуудалтай хүнд одоо ч гэсэн маш хэцүү. Гаднаас ирсэн хүн бүр бэрхшээлгүй хүмүүст хэцүү, бэрхшээлтэй хүмүүст бүр хэцүү гэж боддог байх. Бусдаар бол монгол хүмүүс нээлттэй, чөлөөтэй. Тиймээс хэрвээ би таксинд суугаад ийшээ явмаар байна гэвэл, чи хаанаас ирсэн юм бэ? Эхний тааралдсан хүн л яриа өрнүүлдэг. Ийм зам мэдэхгүй байна, ийм юм мэдэхгүй байна гэвэл туслах хүн маш олон. Тэр талаараа бол маш санаа амар байдаг

Би өмнө нь хүмүүстэй ярилцлага хийж байхад япон жишээг их авдаг. Багаас нь хүүхдүүдийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй хамт нэг ангид сургадаг гэж сонссон. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүн ажил хийхээс өмнө инкубатор гээд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажилд сургадаг төв байдаг гэж сонссон. Тэндээ

ажилд дадлагажсаныхаа дараа жинхэнэ ажил дээр гардаг гээд маш олон гоё гоё жишээнүүдийг сонссон. Тэгээд танд монголд нэг ийм зүйл байвал зүгээр эсвэл Монголд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд чиглэсэн ийм юм байвал зүгээр гэсэн бодол байгаа юу?

Хамт сурах талаар бол янз бүрийн хүмүүс янз янзаар бодож байгаа. Тэнд бас олон янзын асуудал байдаг. Одооны Монголын ирээдүй гэж бодвол хүүхдийн чадахгүй юман дээрээ биш чаддаг юман дээр төвлөрөх хэрэгтэй. Жишээлбэл Дауны хам шинжтэй хүмүүсийн холбоо нэг кафе нээсэн байсан. Тэдний ажилтнууд маш соёлтой. Сайн байна уу та, энд суух уу гэж сандал гаргаж өгнө. Би очоод маш баяртай байсан. Та юу уух вэ гэхэд би менюгээ хараад латте ууна гэж хэлвэл үйлчлэгч цээжилж авна. Цээжлэхгүй ч байж болно. Цээжлэхгүй яана аа гэж бодохгүйгээр хэрвээ цаасан дээр латте, американо, каппучино гэж меню байвал би латтен дээр цэг тавиад өгнө. Цээжилж чадахгүй ч гэсэн ажиллаж чадна. Тэгээд хэн латте захисан бэ? гэдгийг мартсан ч гэсэн тэнд Кимико гэж нэр байвал та энэ Кимико мөн үү эсвэл уншиж чадахгүй бол цаасаа надад үзүүлээд энэ таных мөн үү? гэж асуувал, энэ Кимико минийх шүү гээд авна. Тиймээс цээжилж чадахгүй учраас, бичиж чадахгүй учраас гэж зогсохгүй менютэй ижил захиалганы цаас байгаад балтай ирвэл, би өөрөө цэг тавьж чадна. Нэгдүгээрт тийм бодлоор хамт ажиллая гэж бодоорой. Бие эрхтний талаар бас янз бүрийн хүмүүс бий. Жишээлбэл манай энд ойр ойр шээдэг 1 хүүхэд ирсэн. Тэр асуудал бол тэр хүнд захирагддаггүй, биеийн асуудал байдаг. Магадгүй 30 минутын дотор ариун цэврийн өрөө рүү 1 явах шаардлагатай болдог. Тийм учраас биеийн асуудлын талаар мэдэж авбал ажиллаж чадах хүмүүс олон байгаа байх гэж бодож байна. Тэр хүний биеийн байдлын талаар юу чадна, юу чадахгүй гэдгийг мэдсэний дараа чадаж байгаа юмыг нь хийлгэнэ гэсэн үг. Тэгвэл ажил хийх боломжтой олон хүн байна байх.

Монголд өмнө нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сургууль, цэцэрлэгт хамрагдаж чаддаггүй байсан юм уу? Та тэгээд анх төрийн бус байгууллага байгуулсан уу?

Хувийн болон улсын цэцэрлэг авч байсан. Гэхдээ авч чадаагүй шалтгаан нь одоогийнх шиг аваарай ёстой үүрэг байхгүйн дээр яаж ажиллах вэ гэдэг мэдэхгүй байсан байх. Жишээлбэл би оюун ухааны хоцрогдолтой хүүхэдтэй яаж ажиллах вэ, аутизмтай хүүхэдтэй яаж ажиллах вэ? Энэ хүүхдийг гээд ирсэн чинь ангидаа 20, 30 хүүхэдтэй тэгээд яаж ажиллах вэ? гэж аргаа мэдэхгүй байсан учраас одоог бодвол маш цөөхөн байсан ч авч байсан. Манай байгууллага яагаад нээгдсэн гэвэл цэцэрлэгт орж чадаагүй хүүхэд тэр үед олон байсан.

Анхандаа танайх хэдэн хүүхэдтэй байсан бэ?

Эхний үед 17 хүүхэдтэй байсан. Машин байхгүй учраас автобусаар явна. Өдөрт 3

айлд очоод миний цаг дуусна. Би тэгээд харанхуй болоход гэр хороололд байх хэрэггүй гэж бодоод харанхуй болохоос өмнө өвөл бол 16.00 цагаас өмнө гэр лүүгээ ирээд сургалтын материал хийдэг байсан. Гэртээ очсон ч гэсэн янз бүрийн бэлдэх ажил их байсан учраас өдөрт 3 хүүхэд дээр очдог байсан.

Та өөрөө хүүхдүүдийн гэр лүү явж заадаг байсан уу эсвэл хүүхдүүд ирдэг байсан гэсэн үг үү?

Эхний 3 жил бол дандаа хүүхдийн гэрт очиж байсан.

Та очоод хэдэн цаг ойролцоогоор заадаг байсан бэ?

Одоо ч гэсэн долоо хоногтоо 1 удаа 1 цаг. Нэг цагаас илүү байвал хүүхдийн анхаарал сарнидаг. Ер нь нэг цагт ч гэсэн анхаарч чадахгүй учраас бага багаар хувааж хийнэ.

Та зөвхөн ганцаараа л яваад л заадаг уу эсвэл танаас гадна бас өөр багш нар байдаг уу?

Би ганцаараа явна.

Одоо машинтай юу эсвэл бас автобусанд суудаг уу?

Сүүлийн нэг жил корона болоод машин барьж чадаагүй болсон учраас машинаа зарсан. Тэгэхээр 8 жил машинтай байсан. Эхний 2 жил хагас автобусаар явсан. Дараа нь машинтай байсан учраас би Улаанбаатар хотын ямар автобус, хаашаа явахыг бас сайн мэддэг.

Ихэнх хүүхдүүд гэр хороололд байдаг уу эсвэл орон сууцанд байдаг уу?

Ойрын жилд бол орон сууцны хүн олон байгаа. Гэхдээ би тэд нарыг сонгоогүй. Өмнө нь надтай холбоо барьж байсан хүмүүс гэр хороололд ихэнх нь байсан, одооны надтай холбоо барьж байгаа хүмүүс орон сууцны хүмүүс.

Таньтай өөрсдөө холбоо бариад хүүхдээ хичээл заалгамаар байна гээд ирдэг юм байна, тийм ээ?

Би өөрөө гэр хороолол, ямар дүүрэг гэж шийдсэн юм бол байхгүй.

Хүүхдүүдийн хөгжлийн бэрхшээл бүр өөр өөр. Тэгэхээр хүүхдүүддээ очоод таны заадаг материалууд өөр өөр байдаг уу? Эсвэл төстэй зүйл заадаг уу?

Надаас маш сайн асуулт асуусанд баярлалаа. Миний заадаг хичээл бүгдээрээ ижил сэдэв байдаг. Бэрхшээл, нас, төвшин хамаагүй бүгдээрээ ижил сэдэвтэй байгаа. Жишээлбэл манжингийн үлгэр уншаад суръя гэхэд бүгдээрээ ижил материал харна. Бүгдээрээ манжингийн үлгэр ярина. Гэхдээ тархины саажилттай харандаа сайн барьж чадахгүй хүүхэд байвал будах ажлын тухай би бодох хэрэгтэй. Гараар будах уу, хөлөөрөө будах уу? Харандаагаа барьж чадахгүй бол хамт хараандаа барьж хүүхэд өөрөө хөдөлгөх

зэргээр хүүхэдтэйгээ зохицож ажиллана. Оюун ухааны бэрхшээлтэй хүүхэд бол яг цээжлэх гарна. Аутизмтай хүүхэд бол ижил манжингийн үлгэр үзээд миний яриаг анхаарч сонсоно гэж хүүхдийн төвшинтэй таарч нэг сэдвийг, нэг материалаас янз бүр болгож заадаг.

Танд магадгүй хүүхдүүд рүү явж байхын оронд оффис эсвэл цэцэрлэг нээгээд хүүхдүүдийг авч ирээд сургалт явуулъя гэсэн бодол байсан уу?

Ерөөсөө ч тийм бодол байгаагүй. Эхний жил Нийслэлийн боловсролын газар, дүүрэг гэсэн янз бүрийн байгууллагатай хамтраад ажиллая гэж бодоод явж байхад та өөрөө нээхгүй юм уу? гэж надад зөндөө хүмүүс хэлсэн. Бэрхшээлтэй хүүхэд юу сурах юм, юу заах юм? гэсэн нэг зэрэг ийм хоёр асуулт гардаг байсан. Яагаад манай байгууллага цэцэрлэгийн байшин барихгүй байгаа вэ? гэвэл тэр үед буюу 2011 оны үед хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувийн эсвэл төрийн бус байгууллага байгаа ч юм шиг, үгүй ч юм шиг байсан. Хэрвээ би байшин барьвал Кимико багш тэнд байшин бариад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд авч байгаа, тийшээ яв гэсэн яриа гарна. Ямар ч нэмэр байхгүй болно. Энэ бол Монгол улсын хийх ажил гэж би тэр үед бодсон. Би монгол улсын ажилд хамтран ажиллаж, тусалж чадах ч байшин бариад нааш ир гэж чадахгүй, тэр миний ажил биш. Би өөрөө шугам тавиад байшин барихгүй ч гэсэн ингэж чадна гэж саналаа хэлээд, хамтраад ажиллана. Одоо хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг авч



байгаа хувийн байгууллага олон болсон байгаа. Одоо монгол хүмүүс хийж байгаа юм. Хамт ажиллая гээд яривал тэгье гээд хамт ажилладаг.

Би танаас асуусан шалтгаан гэвэл хэрвээ та хүүхдүүдийгээ авч ирээд заавал илүү олон хүүхдийг хамарч болно байх гэж бодсон юм. Та бас айл болгон руу явахаар ганцаараа заадаг болохоор магадгүй их цаг зарцуулаад, өөрөө ч ядардаг байж магадгүй гэж би бодсон.

Тийм ээ, тийм. Хүмүүс яг тийм санаа бас хэлж байсан. Гэхдээ би өөрөө айлд очиж байгаа учраас айлын хүмүүс ямар юм бэ? гэж яг нүдээрээ харсан. Зарим эцэг эхчүүд ерөөсөө инээдэггүй. Надтай ингэж байсан байж магадгүй. Биеийн хэмжээ нь бүр 1 настай хүүхдийнх шиг 3 настай маш хүнд хүүхэд байсан. Их татдаг, хараа байхгүй учраас дандаа ээж нь тэвэрдэг байсан. Тийм хүүхэд 1 биш хэд хэд байсан. Эцэг эхчүүд хүүхэд нь хүнд учраас яасан хэцүү юм бэ? гэж амаар ярихгүй ч гэсэн нүүр царайгаараа харуулж байдаг. Тэгээд би эцэг эхийн санааг өөрчилбөл хүүхэд өөр болдог гэдгийг тэр үед сурсан. Тэгээд хүүхдийг хөгжүүлээд 1, 2 сар явна. Зарим эцэг эхчүүд хүүхдээ шууд надад өгөөд, бид хоёрын тухай тоохгүйгээр зурагт үзээд суудаг. Тэгээд 1 цагийн дараа бид хоёрын ажил дуусаад, бид хоёр дууссан гэвэл над руу хараад аан дуусчихсан уу? гэх эцэг эхчүүд ч бас байсан. Зарим эцэг эхчүүд хүүхэд нь хүнд бэрхшээлтэй учраас надад хүүхдээ өгөхөөс айгаад Кимико багш аа та миний хүүхдийг тэвэрч чадах юм уу? гээд л маш их санаа зовж байгаа царайтай байдаг. Би 5 минутад тэврээд ээжид нь буцаагаад өгнө. Тэгээд бага багаар нэмэгдүүлнэ, эцэг эх нь надад итгээ эхэлнэ. Энэ чинь эцэг эхтэй үүсч байгаа итгэлцэл шүү дээ. Тэр зурагт үздэг эцэг эх ч гэсэн миний тухай ойлгоод зурагт үзэх биш над руу хардаг болсон. Тэгээд хүүхэдтэйгээ харилцах харилцаа нь шал өөр болсон. "Хүүш ээ миний хүүхэд ингэж чаддаг юм уу" гэж гайхна. Хүүхдийнхээ өөрчлөгдсөн байдлыг хараад баярлана. Нүүр царай, сэтгэл, биеийн хөдөлгөөн нь шал өөр болдог. Ийм юмыг би өөрөө гэрт нь очоод биеэр мэдэрсэн учраас бусад хүмүүс, төрийн бус байгууллага, төрийн байгууллагуудад тайлбар өгөөд, жишээ гаргаад, бид нарт ийм зүйл хэрэгтэй байгаа, ингэж ажиллах хэрэгтэй гэж санаа өгч чадсан. Зарим айл бол автобусны буудлаас 20 минут зайтай. Би 20 минут гэр хороололд дээшээ явна. Өглөө нар байсан ч утаатай учраас нарыг хаачихна. Гэр хороолол гэж ийм байдаг байх нь гэж би бас мэдэж авна. Тийм учраас их юм сурсан, их бодсон. Тэгээд өөрөөрөө дамжуулж бусад хүмүүстээ заая гэж шийдээд, байшин барихгүйгээр цаг их авсан ч гэсэн хамаагүй айлд очих нь маш их үр дүнтэй юм байна гэж бодож байсан.

Би бас сайн мэдэхгүй байсан байна. Дан ганц хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд биш, тухайн хүүхдүүдийн эцэг эх, гэр бүл гэдэг чинь аймаар чухал нөлөө үзүүлдэг. Тэр хүмүүст ч гэсэн нөлөөлөх ёстой гэдгийг

би сая ойлголоо. Жишээлбэл өмнө нь зурагт үздэг байсан гээд та хэлсэн зарим эцэг эхчүүдийн өмнө нь хүүхдээ хандаж байсан хандлага өөрчлөгдөж манай хүүхэд ингэдэг байсан юм уу гээд илүү анхаарал тавиад эхэлсэн гэсэн. Зөвхөн хүүхэд гэлтгүй эцэг эхчүүд ч гэсэн өөрчлөгдөж байгааг харах танд ямар санагддаг вэ?

Ёстой баяртай байсан. Хүүхдэд өөрчлөлт гарвал эцэг эхийн нүүр царай өөр болоод ирдэг учраас маш баярласан. Ялангуяа эцэг эхчүүд хүүхдийн ирээдүйд их зүйл хийх хүмүүс учраас эцэг эхчүүд өөр боллоо гэж маш их баярласан. Тэр зурагт харж байсан эцэг эх надад итгэл өгөөд би юу ч хийсэн гайхахгүй болсон. Хүүхэд ч өөрөө олон юм чаддаг болсон. Тэгээд "Кимико багш аа манай хүүхэд бүр хүнд учраас эмнэлэг явах хэрэггүй гэж бодож байсан. Манай хүүхэд эмнэлэгт эмчийн зөвлөгөө авбал ухаантай болох болов уу?" гээд ёстой шал өөр царайтайгаар асуусанд нь би маш их баярласан байгаа.

Энэ олон жил та олон монгол хүүхдүүдэд болон эцэг эхчүүдэд нь туслаад явсанд маш их баярлалаа.

Би энэ коронагийн үеэр жаахан бичиг баримт, сургалтын материал янзалж байгаа. Хэрвээ би сурахгүй бол зааж чадахгүй, хүүхэдтэйгээ харьцаж чадахгүй байсан. Тийм учраас би одоо ч гэсэн сурч яваа. Бичиг хараад, сургалтын материал янзалж байгаа үед ч гэсэн би яагаад ийм санаа гаргасан бэ? Тэгмээр байгаа учраас тийм шинэ санаа гарч байгаа, энэ хүүхдийг яах вэ? гэж бодож байсан учраас янз бүрийн материал гарч байсан. Тэгж бодвол би Монголд ирээд, хүүхдүүдтэй хамт байж өөрөө хөгжиж байгаа гэж бодвод би өөрөө баярлалаа гэж хэлмээр байна.

Баярлалаа танд. Манай подкастын цаг өндөрлөх дөхөж байна. Манай подкастад урилгыг минь хүлээж авч ирсэн танд маш их баярлалаа.

Зөндөө ярих боломж өгсөнд баярлалаа.

Маш гоё хараагүй өнцгүүдийг ч гэсэн гоё ярьж өгөөд, маш сонирхолтой яриа ярьж өгсөнд баярлалаа. Тэгээд таны цаашдын ажил хөдөлмөр, амьдралд нь сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе!

Та нарт ч гэсэн баярлалаа. Одоо корона гээд жаахан хэцүү байна гэхдээ бүгдээрээ илүү сайн байвал их боломж гарна. Тийм учраас зарим нь хөл харна, зарим нь дээшээ харна. Тэгээд бүгдээрээ хамт явцгаая гэж бодож байна.

Баярлалаа.

ИРЭЭДҮЙГЭЭ ӨӨРСДӨӨ БҮТЭЭЦГЭЭЕ!

Г.Самбууданзан



Сайн байцгаана уу, эрхэм хүндэт сонсогчид оо, Антолд подкастын маань ээлжит дугаар эхлэхэд бэлэн болоод байна. Энэхүү дугаарт Архангай аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоодын зөвлөлийн тэргүүн Самбууданзан оролцож байна. Та манай урилгыг хүлээж авсанд баярлалаа. Та сонсогчдодоо өөрийгөө танилцуулахгүй юу?

Та бүхнийг энэ нэвтрүүлэгт урьж оролцуулж байгаад бас баяртай байна. Хөдөө орон нутгаас орж байгаадаа бас баяртай байна.

Намайг Ганзоригийн Самбууданзан гэдэг. Архангай аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоодын зөвлөл (ХБИХЗ)-ийн тэргүүнээр ажилладаг. Тэгээд манай байгууллага маань 6 төрийн бус байгууллагын нэгдэл байдаг ба яг үндсэн Харааны бэрхшээлтэй иргэдийн холбоо, Тэргэнцэртэй иргэдийн холбоо гээд бэрхшээл төрөл бүрээрээ байдаг. Архангай аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоод маань 2012 онд анх энэ холбоодын зөвлөл гэдэг байгууллагыг байгуулаад хамтдаа үйл ажиллагаа явуулаад 9 жил болж байна.

Тухайн үедээ 2012 онд холбоодын зөвлөл гэж байгуулах болсон шалтгаан нь юу вэ?

Манай аймагт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 6 төрийн бус байгууллага байдаг. Тухайн үед ХБИХЗ-ийг байгуулах болсон хамгийн том шалтгаан бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төр засагтайгаа харьцах, нийгэм рүү чиглэсэн үйл ажиллагаагаа идэвхжүүлэх үүднээс байгуулсан. Ер нь бол нийгэм рүү чиглэсэн үйл ажиллагаанаасаа илүү төр засагтай харьцах асуудал хүндрэлтэй байсан. Тэгээд аймгийн Засаг даргын тамгын газар руу 1 хүсэлт тавиад л эсвэл Иргэдийн Хурал руу хүсэлт бичдэг 6 өөр толгой 6 өөр юм бичээд л ордог байсан. Тухайн үед Флом (FLOM) олон улсын байгууллага гэж байсан ба тэр байгууллагыг Пави Орнер гэдэг хүн удирддаг байсан. Тэгээд бид хэд ярилцаад ийм олуулаа тарамдуу байж болохгүй, бөөнөөрөө 1 болох ёстой гэж шийдээд 2012 онд анхныхаа хурлыг хийгээд 2012 оны 10 сарын дундуур ХБИХЗ-ийг байгуулаад ажиллаж байсан түүхтэй.

Та одоо тэргүүнээр нь ажиллаж байгаа, өмнө нь бас ажиллаж байсан гэсэн?

Тийм тийм. Манай ХБИХЗ-ийн дүрмэндээ тэргүүнээ 3 жилийн хугацаагаар сонгодог сонгуульт хугацаатай байдаг. Би 2014-2017 онд тэргүүн хийж байгаад сонгуульт хугацаагаа өгөөд сая 3 жил болсон. Миний өмнө өөр хүн тэргүүн хийж байгаад тэр хүнийхээ ажлыг аваад үйл ажиллагаагаа явуулах гээд л байж байна. Одоо цар тахалтай байгаа учраас ажлаа онлайнаар хийж байна.

Танайх одоогийн байдлаар ямар ажил дээр төвлөрч ажиллаж байгаа вэ?

Ер нь төрийн бус байгууллагын амин чухал сүнс гэдэг бол үйл ажиллагаа нь идэвхтэй, тогтмол явагдах байдаг юм. Яг үүн дээр төрийн бус байгууллагуудын стратеги, төлөвлөгөө байдгийг энэ олон жил энэ зөвлөлд байснаараа мэдэж авсан. Энэ жил ХБИХЗ-ийн 5 жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулаад ажиллаж байна. Энэ жил Архангай аймгийн Флом олон улсын байгууллагын төслийн хугацаа дууссан ч түүний оронд Тэгш тусгал гэдэг байгууллага шинээр гарч ирсэн. Энэ байгууллага Архангай аймагт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр 4 жил төсөл хэрэгжүүлэхтэй уялдуулаад байгууллагынхаа стратеги төлөвлөгөө хийж байна.

Хөдөө орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн маань аж амьдрал, орчин нөхцөл хэр байдаг вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аж амьдрал ер нь хоёр талтай гэж би боддог. Нэг талаасаа хувь хүн өөрөө хичээх юм бол ямар ч орчинд байсан хөгжлийн бэрхшээлийг даван туулаад, хөдөлмөрлөөд, нийгмийн харилцаанд ороод явах боломжтой. Нөгөө тал нь гэвэл нийгмийн харилцаанд орж чадахааргүй хүмүүс бас зөндөө байдаг. Тэд нарыгаа чиглүүлж өгөх нь их чухал байдаг. Улаанбаатар хотыг бодвол хөдөө орон нутаг дэд бүтцийн хүртээмж арай муу ч гэсэн мэдээллийн хүртээмжийг би муу гэж ойлгохгүй байгаа. Яагаад гэвэл Монгол

улсад орон даяараа интернет сүлжээ нэвтэрчихсэн байгаа учраас интернетээс өөрийнхөө хэрэгцээтэй мэдээллийг аваад байх боломжтой. Гэхдээ төр засгаас өгч байгаа мэдээллүүд хязгаарлагдмал, өөрсдөө тэрийгээ дагадаггүй, түүнийг орж үзэж чадахгүй зүйлүүд бас байгаа. Хамгийн их тулгамддаг асуудал бол дэд бүтцийн хүртээмж. Бас хөдөө орон нутагт хөдөлмөр эрхлэх, бизнес хийх боломж нь Улаанбаатар хотыг бодвол арай бага. Зах зээл нь бага байдаг учраас хөдөлмөр эрхлэх боломж бага. Гэхдээ манай Архангай аймгийнхаа төвд хөгжлийн бэрхшээлтэй иргэд бас өөрийнхөө санаачилгаар чамгүй ажил хөдөлмөр эрхлээд яваад байх боломжтой. Төр засгаас хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрт хамрагдаад, бичил зээл аваад, хөдөлмөр эхлээд явах боломжууд байгаа. Ер нь бол шат шатны төрийн байгууллагуудын хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг харах хандлага жоохон дутмаг байгаа. Гэхдээ 10 жилийн өмнөх үеийг бодвол шал өөр болсон.

Гэхдээ магадгүй аймгийн төв дээр байгаа хүмүүс нэг өөр эсвэл бүр хөдөө суман дээр байгаа хүмүүс бас нэг өөр байж магадгүй. Та тэрний ялгааг ярьж өгөхгүй юу?

Бүс нутгийн онцлогоос хамааралтай хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байр байдал шал ондоо байна. Жишээлбэл Архангай аймгийн Эрдэнэбулган суманд байгаа иргэн мэдээлэл авах, дэлгүүр хоршоо орох дээрээ хүний дэмжлэгтэй яваад байх боломжтой. Хөдөө орон нутагт уулын мухарт байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэн яах аргагүй гэр бүлийнхээ хүний эсвэл аав ээжийнхээ асран хамгаалалтад амьдарч байгаа тийм жишээнүүд маш их байдаг. Тэд нарын эрх үнэхээр өдөр болон зөрчигдөж байгаа. Тэгээд хөгжлийн бэрхшээлтэй иргэд хүний эрхийн зөрчил гэдгээ бас ойлгодоггүй юм байна. Бас дээрээс нь хүчирхийлэлд автаад байгаа гэдгээ бол бас ойлгодоггүй. Хөгжлийн бэрхшээлтэй хүн “бид хэд ийм л байх ёстой, ийм л тавилантай юм чинь одоо ингээд л байж байхаас” гээд эвлэрчихсэн байдаг. Монгол улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах хууль гээд л гоё хууль зөндөө байдаг. Гэхдээ бүс нутгийн онцлог, орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлог, хувь хүнийхээ онцлогт нийцсэн хуулийнхаа зохицуулалтыг хийж өгөхгүй бол асуудалтай гэж би боддог. Яагаад гэвэл хөдөлмөр магадлах комиссын хуралдаан хийж байхад ганцхан барааг нь харахын тулд заавал тэр хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөө орон нутгаас авчруулж маш их чирэгдэл учруулдаг. Тиймэрхүү зөрчлүүдээс зайлсхийх, ийм зөрчлүүд гаргахгүй байх, хүний эрх зөрчихгүй байх, хүчирхийлэл хийхгүй байх тал дээр ажиллах хэрэгтэй байх гэж боддог.

Тухайн хүмүүс өөрсдөө хүний эрх нь зөрчигдөөд байгааг мэдэхгүй байна гэхээр манай хөгжлийн бэрхшээлтэй иргэд маань боловсрол сайн авч чаддаг уу, сургуульд явах боломж бололцоо хэр байдаг юм бэ?

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг боловсрол эзэмших, тэгш хамруулах тал дээр хэрэгжилт муу байна. Улаанбаатар хотод байгаа сонсголын, харааны, тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүсийн ээж аав нь суурин газар байгаа учраас хүүхдээ боловсруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүн боловсрол эзэмшихгүй бол болохгүй гэдэг тал дээр анхаарлаа хандуулж мэддэг болчихсон. Сургууль соёлд хамруулаад байх боломжтой байдаг. Аймгийн төв, сумын төвд байгаа хүмүүст боловсрол эзэмшүүлэх боломж бол байгаа. Яг хөдөө орон нутагт байгаа нэг нь хөгжлийн бэрхшээлтэй, нөгөө нь бэрхшээлгүй 2 хүүхэдтэй айл байлаа гэж бодоход "чи бэрхшээлгүй юм чинь сумын төв дээр таньдаг айл байхгүй учраас дотуур байранд суучих, энэ нөхөр гэртээ байж байхаас би малынхаа хажуугаар хараад байж байя" гэдэг тийм хандлага хөдөө орон нутагт зөндөө байгаа. Хөдөө байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ихэнх нь төрөхдөө хөгжлийн бэрхшээлтэй болсон, саажилт голдуу байдаг юм шиг санагддаг. Тэр хүмүүс гадуур хөдөлгөөн хийж явсаар байгаад хөл дээрээ явдаг болсон учраас хонь малд явах ажил хийдэг юм шиг байдаг.

Анхнаас нь сургая гэсэн бодол ч байхгүй. Сургасан ч гэсэн яг тэр сургуулиуд нь тархины саажилттай хүүхдэд заагаад явах нөхцөл бололцоо нь байгаа болов уу?



Эрдэнэбулган сумын хэмжээнд л гэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй харьцах, хамт олонд түшиглэсэн энгийн ангид сургах боломж зааж сургаж байгаа багш нарт нь бараг л байхгүй юм шиг санагддаг. Хөдөө сумдын сургуулиудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурна гэдэг бол хэцүү. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тулаад хамгийн эхэнд яригдах том асуудал гэвэл гадаа байдаг модон ариун цэврийн өрөөний асуудал. Хараагүй эсвэл тэргэнцэртэй хүүхэд шороон зам дээгүүр явж очоод бие засахад хүндрэлтэй байна л гэсэн үг. Тэгэхээр хөдөө орон нутагт бол хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцахад маш хэцүү. Миний өмнө нь ярьсан шиг "энэ нөхөр бол гэр орондоо байг, энэ нөхөр нь бол сургуульдаа яваг" гэдэг эх эцгийн өөрсдийнх нь хандлага бас байгаа юм. Нөгөө талаас нь харахаар, тэр хүүхдийг дагуулаад ээж эсвэл аав нь аймаг, сумын төвд суух зайлшгүй шаардлагатай болдог. Мал идээгээ хэн нэг нь ганцаараа хариулах боломжгүй учраас ингэдэг байх гэсэн бодол бас байдаг.

Зарим нь ч бол бараг мал хариулаад, хөдөлмөр эрхлээд явж байгаа гэсэн үг л юм байна, тийм ээ?

Тийм, хөдөө орон нутагт байгаа хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ихэнхдээ л хонь мал хариулдаг. Байнга малд л явж байдаг, хонь дагаад л явж байдаг жишээнүүд байдаг.

Тэгээд эдгээр иргэдэд маань төрийн үйлчилгээ хэр очдог вэ? Энэ хүмүүс бүгдээрээ нийгмийн халамж хүртэх ёстой хүмүүс. Магадгүй хөдөө орон нутагт байдгаасаа болоод үйлчилгээ, халамжаа муу хүртэх тохиолдол байдаг уу?

Тиймэрхүү тохиолдол байдаг. Группийнхээ хурлаар орж чадахгүй группийнхээ хурлаас хасагдаад төрөөс үзүүлж байгаа дэмжлэг авахгүй байх тохиолдол байна. Группээсээ хасагдаагүй ч гэсэн группийнхээ мөнгийг авч байгаагаа мэддэггүй, ар гэрийнхэн нь аваад хоол хүнсэндээ зарцуулаад байгаа болохоос яг тэр хүний хэрэгцээ шаардлагад нь нийцсэн зүйлийг халамжийнх нь мөнгөөр авч өгч байгаа зүйл бараг л байхгүй. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд төрөөс үзүүлж байгаа дэмжлэг хөгжлийн бэрхшээлтэй хүндээ л зарцуулагдах ёстой. Жишээлбэл миний ээж аав намайг тэжээдэг юм чинь энэ мөнгийг энэ 2 аваад гурил будаандаа зарцуулаг гэдэг бол өөрөө эдийн засгийн хүчирхийллийн хэлбэрт ороод явдаг юм байна. Тэгэхээр хүний эрхийн суурь ойлголт байхгүй, хүчирхийлэл гэдгээ мэдэхгүй, мэдээллээс хол, энэ чиглэлийн мэдээллийг төр засаг нь ч гэсэн хүртээмжтэйгээр хөдөө орон нутагт байгаа иргэддээ хүргэж чаддаггүй учраас энэ бол асуудалтай зүйл. Гэтэл нийгмийн харилцаа, хандлага, төрийн бодлого, төрөөс хэрэгжүүлэх гэж байгаа энэ хэлтэс, агентлагууд нь яг хүндээ яаж хүртээмжтэйгээр мэдээ мэдээллийг ийм учиртай зүйл гэдгийг тайлбарлаж хүргэхээс шалтгаалаад энэ өөрчлөгдөх байх гэж хардаг.

Энэ хүмүүст мэдээ мэдээллийг сайн хүргэх ямар арга байна? Таны бодлоор эрх нь зөрчигдөөд байгааг тухайн хүнд мэдүүлэхийн тулд ямар арга замаар мэдээлэл хүргэх боломж байгаа вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй хүнд мэдээлэл хүргэх гэхээсээ илүү өмнө нь ярьсан шиг хөгжлийн бэрхшээлтэй хүнийг боловсролд тэгш хамруулах л чухал гэж боддог. Яагаад гэвэл хөгжлийн бэрхшээлтэй иргэн өөрөө зөв хандлагатай, хүний эрхийн суурь ойлголттой байвал би хүчирхийлэл, хүний эрхийн зөрчил, асуудлуудад орж байна гэдгээ ойлгодог болж энэ асуудлууд цогцоор шийдэгдэх байх. Тэрнээс хөдөө байгаа, өөрийгөө нийгэмшүүлж чадаагүй хөгжлийн бэрхшээлтэй хүнд очоод "чиний группийн мөнгийг ээж чинь авч байгаа нь өөрөө хүчирхийллийн нэг хэлбэрт орох юм байна" гэж хэлбэл тэрийг бараг л ойлгохгүй "хүчирхийлэл гэж одоо юу яриад байгаа юм" гэнэ. Манай хөдөө орон нутагт ганцхан зодож жанчих, дарамтлахыг хүчирхийлэл гэж ойлгож байгаа байх. Хүчирхийлэл маш олон янзаар үйлдэгддэг юм байна. Төр засгаас үзүүлж байгаа боловсролын систем нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэйгээр боловсрол эзэмшүүлж, тэр хүн өөрөө тэр зүйлээ ойлгодог болж байж энэ зөрчлүүд арилах байх. Тэрнээс энэ зөрчлүүдийг ойлгохгүй бол энэ зөрчил байсаар л байх болно. Өөрөө тэр асуудлаа хөндөж, ар гэрийнхэнтэйгээ ярьж, хэн нэгэнд хандаж асуудлыг шийдэхгүй бол энэ шийдэгдэхгүй байх гэж боддог.

Танай аймагт ажиллаж байгаа төрийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын хүмүүс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дуу хоолойг цаашаагаа Улаанбаатар руу хэр хүргэж чаддаг вэ?

Төр засгаас хөгжлийн бэрхшээлтэй иргэнийхээ асуудлыг анхаарч хандаж байгаа асуудал нь сүүлийн жилүүдэд харьцангуй сайн болсон. Архангай аймгийн хэмжээнд ХБИХЗ дуу хоолойгоо аймгийнхаа анхан шатны байгууллагуудад бодлогын төвшинд, суурь судалгаатай зөв оруулж байж төр засагт хүргэх боломжтой. Тэрнээс бид нар ингэхгүй байна гээд нэг суулт хийгээд, бид нарын асуудал ийм байна гээд цээжээ дэлдээд байвал энэ нь төр засагт онц ач холбогдолтой дуу хоолой хүргэх арга биш. Жишээлбэл, Эрдэнэбулган сумын 5-р баг дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал гарахад, Эрдэнэбулган сумын 5-р багийн иргэдийн нийтийн хурал дээр хөгжлийн бэрхшээлтэй хүн очиж асуудлаа гаргаж тавьдаг. Багийн нийтийн хурлаас гарсан шийдвэр нь сумынхаа иргэдийн хурал руу очиж хөгжлийн бэрхшээлтэй иргэн нь асуудал болдог. Суман дээр гарсан асуудлууд нь аймаг дээр багцлагдаад, улсынхаа их хурал руу явж бодлогын төвшинд ийм ийм асуудлууд байна гэж хүрвэл чухал байх. Гэхдээ тухайн орон нутгийн төр захиргааны байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг авч хэлэлцэхгүй байгаа бол жагсах эсвэл өөр янз бүрийн байдлаар тэр хүмүүстэй ойлголцох, үзэл бодлоо илэрхийлэх нь зөв. Бодлогын төвшинд хүргэе л гэж

байгаа бол анхан шатнаасаа эхлээд улс төрийн мэдлэгтэй баймаар санагддаг.

Төрийн анхан шатны байгууллагад ажиллаж байгаа хүмүүсийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх ойлголт, хандлага хэр байдаг вэ?

Хөдөө орон нутагт хандлага сайжирсан. Миний харж байгаагаар хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон иргэдийн төлөө ажилладаг төрийн бус байгууллагуудад ажиллаж байгаа хүмүүсийн өөрсдийнх нь хандлага, өөрсдөө ажил хөдөлмөрөө сайн хийх, дуу хоолой, өөрт байгаа хэрэгцээ шаардлагыг сайн тодорхойлж гаргаж ирэх нь л чухал гэж би боддог. Гэхдээ энэ төрийн бус байгууллагын нэг онцлог байгаа. Төрийн байгууллагад ажиллаж байгаа хүмүүс цалин хөлстэй, цаг нартай ажилладаг бол сайн дураараа төрийн бус байгууллагад ажиллаж байгаа хүмүүс цалин хөлсгүй, хамтарч дуу хоолойгоо хүргэх зорилгоор ямар ч эдийн засгийн хөшүүрэггүй ажилладаг. Хотын томоохон төрийн бус байгууллагууд л эдийн засгийн бага зэрэг хөшүүрэгтэй байгаа болохоос хөдөө орон нутагт байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоонуудад эдийн засгийн хөшүүрэг бага байдаг. Тухайн орон нутаг нь ямар санхүү төсөвтэй газар юм эсвэл тухайн аймгийг удирдаж байгаа хүнээс шалтгаалж бага хэмжээний төсөв байх магадлалтай. Ер нь төсөл хөтөлбөрөөр амь зогоосон, жижиг ажлууд хийсэн хэмжээнд л ихэнх төрийн бус байгууллагууд явдаг байх гэж боддог.

Танай зөвлөл санхүүгийн асуудлаа яаж шийддэг вэ? Бүгд л сайн дураараа юу?

Манай зөвлөлийн хувьд бүгд сайн дураараа, ямар ч цалин хөлсгүйгээр жижиг төслүүд дээр ажилладаг. Сүүлийн 2-3 жил Засаг даргын тамгын газраас бага хэмжээний санхүүгийн дэмжлэг үзүүлдэг болсон. Тэр дэмжлэгийнхээ хүрээнд зохих хэмжээнийхээ ажил хийнэ. Мөн жижиг төсөл хөтөлбөрүүдэд хамрагдаж ажил хийдэг. Манай Архангай аймагт Тэгш тусгал төрийн бус байгууллагын 4 жилийн хугацаанд хэрэгжүүлэх гэж байгаа төсөл бол манай аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон төрийн бус байгууллагуудад маш чухал ач холбогдолтой төсөл гэж харж байгаа. Одоо төр засагтаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ дуу хоолойг зүгээр яриад суух байх биш бодлогын төвшинд яаж хүргэх вэ гэдэг дээр тэгш тусгалынхаа баг хамт олонтой сайн хамтарч ажиллахыг хичээнэ л гэж зорьж байгаа.

Тэгж дуу хоолойгоо хүргэхдээ та юуг нь анхаардаг вэ? Магадгүй өөр аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зөвлөл сонсож байвал манайхан ингэж хийгээд илүү идэвхтэй байдаг гэсэн зөвлөгөө байгаа юу?

Төрийн бус байгууллагын амьд байх, ажил хөдөлмөрөө сайн хийх нөхцөл нь бол баг хамт олноо сайн бүрдүүлэх байдаг. Чин сэтгэлтэй, нэг зүгт л зорьсон хүмүүс байх хэрэгтэй. Бид өөрсдийгөө сайн хөгжүүлэх хэрэгтэй юм байна. Багаа сайн бүрдүүлээд,

өөрсдийгөө сайн хөгжүүлээд, харилцаа холбоогоо сайжруулаад явах хэрэгтэй. Төр засаг ерөнхийдөө бодлогын төвшинд бол асуудалгүй болчихсон, дэмжихэд бэлэн байгаа. Бид нар ямар нэгэн ажлыг гэрээлэн гүйцэтгэх, ямар нэгэн байдлаар ажлууд хийх боломж их байгаа. Тэгэхээр өөрсдөө л бид боловсроод, сайн хөдөлмөрлөх, хэрэгцээ шаардлагаа зөв тодорхойлж, зөв алхмуудыг хийж, зөв урагшлах нь чухал юм билээ.

Хөдөө орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй иргэд маань ажил хөдөлмөр хийх ямар боломжууд байгаа вэ?

Хөдөө орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажил хөдөлмөр эрхлэх боломж харьцангуй бага. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээр гар урлалын зүйл хийлгэх боломжтой гэж төр засгаас хардаг. Ер нь гар урлалын зүйл гэхэд л аялал жуучлалын бүс нутгаас хамааралтай борлуулалт хийгддэг. Тэгэхээр энэ бол яавч хурдан бүтэж, хүмүүсийн амьжиргааг дэмжих боломжтой шийдэл биш. Миний бодлоор сумын төвд ядаж гар утасны засварын газар хөгжлийн бэрхшээлтэй хүн суугаад засвараа хийж байх боломжтой. Манай Тариат сумын Мөрөн багт нэг хөгжлийн бэрхшээлтэй залуу гар утас засдаг. Тэр бол багийнхаа 40-50 айлын хүмүүсийн гар утасны хэрэгцээнд бол болоод байдаг гэж ярьдаг. Бас паспортын, янз бүрийн зураг авдаг газар бий болгож чадвал тэр бас зүгээр юм шиг санагддаг. Суманд ямар нэгэн байдлаар зураг авах хэрэгцээ шаардлагууд байдаг. Манай Чулуут суманд нэг хөгжлийн бэрхшээлтэй иргэн тийм маягаар зураг авдаг туршлага байгаа. Тухайн сумын хэрэгцээ шаардлага юу байна гэдгээ хөгжлийн бэрхшээлтэй иргэн сайн тодорхойлоод, түүн дээр нь зах зээлийн судалгаа хийгээд ямар нэгэн юм хийвэл боломжтой гэж боддог. Аймгийн төвд амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрөө л хичээж хөдөлмөрлөхийг зоривол ямар нэгэн байдлаар хөдөлмөр эрхлэх боломжтой. Төсөл хөтөлбөр, жижиг дэмжлэг бас төрөөс үзүүлж байна. Ямар нэгэн албан байгууллагад хандаад ажил хийе гэвэл хөнгөн хэлбэрийн бэрхшээлтэй хүмүүст ажил хөдөлмөр эрхлэх боломжууд байгаа. Төр засгаас ч гэсэн дэмжлэг үзүүлж, ажилд зуучлах гэж хичээдэг болсон. Яг бүс нутгийнхаа онцлогоос ямар ажил хийх вэ гэдэг нь хамаарах байх. Бас боловсрол эзэмшсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн төр захиргааны байгууллагууд, сургууль соёлд ажиллаж болох байх. Компьютер программын чиглэлээр их сургууль төгссөн байлаа гэхэд яагаад сумын Засаг даргын тамгын газарт АйТи (IT) хийгээд байж болохгүй гэж? Хөгжлийн бэрхшээлтэй иргэд янз



бүрийн хэцүү ажил хийж байснаас боловсрол эзэмшээд түүнийхээ дагуу хүртээмжтэй, тохиргоотой ажлын байранд ажиллавал гоё байх гэж боддог.

Монгол улсад 25-аас дээш ажилчинтай албан байгууллага 4 хүртэлх хувьд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг авч ажиллуулах ёстой гээд хуульд заачихсан байдаг. Тэр хуулийн хэрэгжилт хэр байдаг вэ?

Хөдөлмөрийн тухай хуулийн 111-р зүйлийн энэ заалт өөрөө хөдөө орон нутагт харьцангуй муу хэрэгждэг. Одоо 25-аас дээш ажиллагсадтай байгууллагад нэг хөгжлийн бэрхшээлтэй хүн авна гэж бодоход хөдөө суманд 25-аас дээш ажилтантай аж ахуйн нэгж бараг л байхгүй. Аймгийнхаа төвд ажиллалаа гэж бодоход яг түүн дээр анхаарч, яг тэр чиглэлээр нь хүнээ ажиллуулдаг байгууллагууд нь бас ховор. Тэгээд ажиллуулахгүй байгаа



байгууллага нь төлбөр төлж байгаа, тэр нь орж ирээд яг ямар юманд зарцуулагдаж байгаа вэ гэдэг нь эргэлзээтэй. Яг тэр хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг энэ байгууллага нь ажиллуулаагүй учраас нөхөн төлбөрөө 1 сая төгрөг төлөх ёстой. Хэрвээ 1 сая төгрөгөө төлсөн бол тэр мөнгө хаана, ямар юманд зарцуулагдсан бэ гэдэг асуудал гарна. Тэр зарцуулагдах мөнгө бол яах аргагүй тухайн орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэнд л зарцуулагдах мөнгө байх. Тэгэхээр тэр мөнгө хаана, юунд зарцуулагдаж байгааг хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон манай байгууллага мэддэггүй. Тэгээд бид нар ч гэсэн бас яг энэ чиглэл лүүгээ бас хөөцөлдөж хайгаагүй учраас энэ мөнгө хаашаа явсныг бас мэддэггүй.

Жишээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилд ороход хамт ажиллаж байгаа хамтран ажиллагсдынх нь хандлага хэр байдаг вэ? Би хүмүүсийн яриаг сонсож байхад хамт ажиллаж байгаа хүмүүсийн хандлагаас болоод нэлээн олон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ажлаасаа гардаг гэж сонсогдож байсан. Магадгүй тухайн хамт ажиллаж байгаа хүмүүс хөгжлийн бэрхшээлтэй хүнийхээ хэрэгцээ, шаардлагыг ойлгохгүй, хэцүү болоод гардаг гэж сонсож байсан юм. Тэгэхээр Архангай аймагт магадгүй аймгийн төвд ажиллаж байгаа хүн байхад тэр хүний эргэн тойрны хамт ажилладаг хүмүүс нь ямар хандлагатай байдаг юм шиг танд санагддаг вэ?

Ер нь бол тухайн байгууллагаасаа л хамаардаг байх. Тэр ер нь хоёр талтай. Яагаад гэвэл хөгжлийн бэрхшээлтэй иргэн тохируулгатай ажлын байранд ажиллавал өөрийнхөө хийх ёстой ямар ч ажлыг, хэнд ч садаа болохгүйгээр хийх боломжтой. Тэгэхдээ тохируулгагүй ажлын байранд ажиллах юм бол хэн нэгнээс дэмжлэг авч, хэн нэгэнд дараа болох шалтгаан болдог. Энийг аваад өгчих, тэрийг аваад өгчих гэхэд дэмжлэг үзүүлж байгаа хүмүүс нь нэг удаа авч өгдөг, хоёр удаа авч өгдөг үүнээсээ болоод хамт ажиллаж байгаа хүмүүсийнх нь дургүйцэл төрөх, ядаргаатай юм ажил хийж чадахгүй, гэртээ сууж байхгүй гэдэг сөрөг хандлагууд бий болдог байх. Тохируулгагүй ажлын байранд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд заавал ямар нэгэн асуудал тулгарна. Тэгэхээр тохируулгатай ажлын байр бий болговол хэн нэгэнд дараа болохгүйгээр ажиллах боломжтой. Архангай аймгийн хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс ажлын байранд зуучилсан хүнээ тэр байгууллагад ажиллуулахын тулд тохируулгатай ажлын байрыг бий болгох тал дээр зөвлөмж өгөх хөтөлбөр хэрэгжүүлэх хэрэгтэй. Хөдөлмөрийн зөвлөл хэрэгжүүлдэг хөтөлбөртөө зөвлөмж өгөх субъект нь янз бүрийнх байдаг юм байна лээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн тохируулгатай ажилтай болоод ажлаа хийж байна. Тэгэхээр тухайн хүний наад захын хэрэгцээ бас байгаа. Ариун цэврийн өрөө орох эсвэл шат, дэд бүтэц муугаас болоод шатаар дээшээ, доошоо явах асуудал хэр байдаг вэ?

Стандартын асуудлууд яригдаад ирэхээр тохируулгатай ажлын байр гэдэг зүйлд тэнд тэргэнцэртэй иргэн ажиллаж л байвал ариун цэврийн өрөө, ажлын байран дээр хөдөлгөөн хийх, гарч ороход зам саадгүй байх зэргийг л хэлээд байгаа юм. Жишээлбэл гарч машиндаа суух, хүний туслалцаагүй явах боломжтой л байвал тэр нь тохируулгатай ажлын байр гэсэн үг юм. Тэгэхээр тэр тохируулгатай ажлын байр бий болговол хэнд ч садаа болохгүй, хувь хүн ажлаа хийж байгаа юм шиг л ажиллах болно. Тохируулгагүй ажлын байр байгаа учраас ямар нэгэн хүндрэл, асуудал гараад хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажлаа хийж чадахгүй байгаа юм.

Тэгвэл одоогийн байдлаар тохируулгатай ажлын байр танай аймгийн хэмжээнд хэр олон байдаг вэ?

Аймгийн хэмжээнд тохируулгатай ажлын байр бараг байхгүй. Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй, тэргэнцэртэй иргэд ХБИХЗ дээрээ л ирнэ гэхээс өөрөөр гадуур ажил хийж байгаа хүн бол байхгүй. Ганц нэг таяг тулдаг, хөл гарын тайралттай, янз бүрийн бэрхшээлтэй хүмүүс бол энгийн хүн шиг орчин нөхцөлтэй газар ажиллаад явдаг. Тэд нарт тохирсон гарч орох шат, зам талбай байхгүй учраас өөрсдөө аргалаад л явчихдаг. Миний мэдэж байгаагаар 2-3 хүн худалдааны төвд лангуу ажиллуулдаг. Тэдний нэг нь нугасны гэмтэлтэй таягтай, нөгөө нь биеийн тамир спортын газар жижүүр хийдэг протезтой, өөр нэг нь хөлний саажилттай оёдол хийдэг хүн байдаг. Эд нарт зориулсан тохируулгатай ажлын байр гэж лав байдаггүй.

Тэгэхээр хөгжлийн бэрхшээлтэй хүн ажил хийж чадахгүй болохоор санхүүгийн эрх чөлөө байхгүй, гэр бүлдээ найдсан хандлага их байдаг уу?

Зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэн ч гэлтгүй ер нь энгийн амьдрал дээр ч гэсэн яг энэ асуудал байдаг байх гэж би хардаг. Яагаад гэвэл гэрт хэн нь ажил хийж, мөнгө олж байна тэр хүн орон гэрт давамгай эрх мэдлийг эдэлдэг санагддаг. Тэр зүйл бол энгийн иргэдэд ч тэр, хөгжлийн бэрхшээлтэй иргэн дээр ч бас байж байгаа. Гэтэл хөгжлийн бэрхшээлтэй иргэний нэг давуу тал бол ядаж сард группийн мөнгө, асран хамгаалагчид нь орох асран хамгаалагчийнх нь мөнгө байгаа. Тэр нь тухайн айлыг хоолтой, шуудай гурилтай байлгахад нь хамгийн том дэмжлэг үзүүлж байгаа юм. Яг группийнхээ мөнгөөр цэвэр амьдарч байгаа айлууд бас байгаа. Ямар ч ажил хийхгүйгээр группийнхээ мөнгөөр хоёулаа амьдраад явж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд бас байж л байгаа.

Группийн мөнгө сард хэдийг авдаг юм бэ?

Нийгмийн даатгал төлөөд, нийгмийн даатгалын сангаас авч байгаа хүмүүс 270,000-аас дээш авч байгаа. Ажил хийж байгаагүй, нийгмийн даатгал төлж байгаагүй халамжийн мөнгө авдаг хүмүүс бол 150,000-аас дээш авдаг байх. Сая цар тахалтай холбогдуулаад бас жоохон

нэмэгдсэн. Хүүхдийн мөнгөтэй ижилхэн 100,000-аар нэмэгдсэн байх. Тэгээд арай гайгүй байгаа байх гэж бодож байна.

Таны бодлоор группийн мөнгөөр амьдрахад хэр хангалттай гэж боддог вэ?

Энэ бол тухайн хөгжлийн бэрхшээлтэй иргэнийхээ хэрэгцээ шаардлагаас хамаараад яригдана. Нуруу нугасны гэмтэлтэй, тэргэнцэртэй хөгжлийн бэрхшээлтэй иргэнд бол хаанаа ч хүрэхгүй. Арай хөнгөн хэлбэрийн бэрхшээлтэй полемилиттой зүгээр явдаг хүнд бол амьжиргаанд нь их том дэм болдог болов уу. Бас хөнгөн хөгжлийн бэрхшээлтэй хүн тохируулгагүй ч гэсэн ажлын байранд ажиллаад байх боломжтой учраас давхар цалинжаад явах боломж байгаа. Тэгэхээр хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хаанаа ч хүрэхээргүй, үгээр л нэг бага зэргийн хэрэгцээг нь хангаж зүйл байх. Яг бэрхшээлийнх нь онцлогоос хамаараад хэрэгцээ шаардлагыг нь тодорхойлж байгаад энэ группийн мөнгөний хэмжээ дээшээ доошоо янз янз тогтоовол зүгээр байх гэж боддог.

Байнга эмчилгээ шаардагддаг хүмүүс бас зөндөө л байгаа. Тэгэхэд группийнхээ хамаг мөнгийг эмчилгээндээ зарцуулаад явчихвал бас л хэцүү юм байна.

Эмчилгээнийх нь сарын төлбөрт хүрэхгүй ч хүн байгаа. Тулах эрхтний бэрхшээлтэй хөгжлийн бэрхшээлтэй хүн, ер нь эрүүл хүн ч байсан хөдөлгөөн л чухал гэж боддог.



Эрүүл байх хамгийн үндэс суурь бол хөдөлгөөн. Манай хөгжлийн бэрхшээлтэй иргэд хөдөлгөөн хийнэ гэхээр заавал спорт зааланд очиж хөдөлгөөн хийх юм шиг боддог. Гэр орондоо өдөрт нэг цагийг ямар нэгэн байдлаар хөдөлгөөн хийгээд өөртөө зарцуулах нь чухал гэж би боддог. Ямар нэгэн аргаар яг өөрт тохирсон янз бүрийн хөдөлгөөн хийж болно. Хөдөлгөөн хийснээр хүний хөлс гадагшилна, хөлсөөр хүний биед байгаа хорт бодис гадагшилна. Хорт бодис гадагшилснаар биеийн бодисын солилцоо сайжирна. Бодисын солилцоо сайжрах юм бол хүний дархлаа сайжирна. Тэгээд өвчин эмгэг тусах магадлал нь багасна. Тэгээд ачаалал даадаг болно гэх мэт их олон давуу тал байдаг.

Цар тахал танай аймагт байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ямар нөлөө үзүүлсэн гэж та бодож байна?

Цар тахлын үеэр аж ахуй эрхэлж байгаа эсвэл хөдөлмөр эрхэлж байгаа байнгын ажил хөдөлмөр эрхэлж орлогоо нэмэгдүүлэх гэж зорьж байгаа хүмүүст л их ач холбогдолтой. Эдийн засаг унасан нь тэр хүмүүст асуудалд болсон байх. Банкныхаа зээлийг яах вэ гэсэн асуудлууд байсан байх. Тэрнээс тэртээ тэргүй халамжийнхаа мөнгийг аваад л байж байгаа учраас цар тахалтай ч, тахалгүй ч гэртээ байж байдаг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд бол тэгж их нөлөөлөөгүй байх. Бага зэргээр нөлөөлсөн нь ар гэрийнх нь орлого буураад ирэхээр гэр бүлийн харилцаанд жоохон өөрчлөлт, асуудлууд гарч, дарамт хүчирхийллийн хэлбэртэй зүйл үүссэн байх магадлал ихтэй. Өмнө нь бид хоёрын ярьж байснаар хүчирхийлэл гэж юу юм, хүний эрхийн зөрчил гэж юу юм гэдгээ хөгжлийн бэрхшээлтэй иргэд маань мэдэхгүй болохоор тэрэнтэй эвлэрчихсэн "за аашилж л байдаг юм, за ингэж л байдаг юм" гээд л тоохгүй л байсан байх гэж бодож байгаа. Яг энэ чиглэлээр манай байгууллага дээр ийм асуудал үүсээд байна гэсэн зүйл яригдаагүй.

Яг хөл хорионы үеэр эмчилгээ хийлгэх шаардлагатай, байнга эмчилгээнд байдаг хөгжлийн бэрхшээлтэй иргэд яаж эмнэлгийн үйлчилгээ авч байсан бэ?

Сая эмчилгээний асуудал жоохон хэцүү байсан. Яагаад гэвэл эмнэлэг хаалттай бас янз бүрийн өвчин эмгэг гарах магадлалтай байсан. Тэгээд бэрхшээлтэй, суурь өвчтэй хүмүүсийг гэр орноосоо битгий гар, эмнэлэг рүү битгий яв, гэрээрээ эмчилгээ хийлгэ гэсэн зөвлөмж өгч байсан. Гэхдээ манай байгууллага дээр бидэнд ийм асуудал гараад байна гэж ярьж бидэнтэй холбогдсон зүйл бол байхгүй.

Сая танаас тэргүүний зүгээс олон асуулт асуулаа. Одоо таны хувь хүнийх нь үүднээс асуулт асуумаар санагдаж байна. Та яагаад Архангай аймгийн ХБИХЗ-д ороод, тэргүүнээр хүртэл маш идэвхтэй ажиллаад явж байгаа вэ?

Би 2002 онд ослын улмаас нуруу нугасны гэмтэл авсан. Одоо бараг 20 жил болж

байна. Түүнээс хойш яг бэлтгэл хийж байгаа тамирчин шиг маш их хөдөлгөөн хийсэн. Гэмтлийн эмнэлэгт Мягмарцогт гээд их эмч ах бий, тухайн үед сувилагч байсан. Тэр хүн нуруу нугасны гэмтэлтэй, Монголчлоод хийчихсэн хөл, гар хөдөлгөдөг аппараттай байсан. Сая шинэчилж сайжруулсан нь одоо ч байгаа. Тэр төхөөрөмж дээр би өдөрт 3 удаа өглөө, өдөр, орой байнга хөдөлгөөн хийдэг байсан. Бүтэн 2 жил гаран хөдөлгөөн хийгээд би таяг тулаад, түгжээтэй явдаг болсон. Тэр үеэс эхлээд би ингээд сууж байж болохгүй юм байна гээд нийгмийн амьдрал руу орж ирсэн. Тухайн үед би аймгийн төв зах дээр таяг тулаад, 2 хөлөндөө түгжээтэй учраас чигээрээ алхахад хэцүү, аймаар удаан алхдаг байсан. Би өөрөө хөдөөний хүүхэд юм чинь өдөр төв шуудангаар орж ирээд л зах дээр явна, гуанз руу орж хоол унд идэх шаардлага гарна гээд л маш их бэрхшээлтэй зүйлийг туулж орж гарч явдаг байсан. Гэхдээ би "энэ гэртээ л хэвтэж байхгүй" гэдэг үг хэзээ ч сонсож байгаагүй. "Энэ яасан сайхан залуу вэ? Яагаад ийм болчихсон юм бол оо? Эвий, зайлуул" гэсэн өрөвдсөн харцаар намайг хүмүүс их хардаг байсан шиг санагддаг. Тухайн үед би өөрөөсөө ичдэггүй аймгийн төв дотор хаа ч хамаагүй л явж л байдаг байсан.

Гэмтэхээсээ өмнө ханьтайгаа танилцсан байсан учраас эхнэртэйгээ хоёулаа цуг амьдраад эхэлчихсэн байсан. Ганцхан эхнэр маань ажиллаад байх хэцүү учраас давхар юм хийх хүсэл тэмүүлэл надад байсан. Би өөрийнхөө чадах чинээгээр хөдөлмөр эрхлэхийг хичээсэн. Тухайн үед таягтай байсан ч гэсэн аймаг дээр гуанз түрээслээд хоолны, цайны газар ажиллуулна. Манай хүн хараа зүйч учраас гоёлын, харааны шилний газар ажиллуулдаг. Би бас өөр мөнгө олох ямар л арга байна тэр болгон дээр ажилладаг байсан. Аймагтай ойролцоо баяр наадам болоход хүртэл тийшээ хуушуур, янз бүрийн юм аваад явж зардаг байсан.

Сүүлд нь таягтай мөртлөө найз нартайгаа нийлж том тэрэг худалдаж аваад Өвөрхангай, Баянхонгор руу найз нартайгаа цуг банз мод зөөж, банзны ченж хийж явсан. Тэгж байгаад сүүлд нь бие жоохон өвдсөн. Тэгсэн чинь 2009 онд олон улсын эрхийг хамгаалах өдрөөр нэг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хурал аймгийн хөгжмийн драмын театрт болсон. Тухайн үед хөгжлийн бэрхшээлтэй иргэд хариуцаж байсан Сандагсүрэн гээд манай нэг ах намайг тэр хуралд суугаарай гэсэн. Тэгсэн чинь нөгөө хүмүүс халамжийн дарга нь ч магтаад л, хөгжлийн бэрхшээлтэй ганц нэгэн хөдөлмөр эрхэлдэг хүмүүс нь ч дарга нараа магтаад салдаггүй. Тэгэхээр нь би "та дандаа статистик тоо ярьж байна. Таны яриад байгаа бодлого яг надад хүрээд байгаа юм бол алга. Та нарын яриа худлаа зүйл л гэж бодож байна" гэж хэлсэн. Тухайн үе бол хэн нэгэн даргыг магтдаг үе л байсан л даа. Тэгээд л би таалагдахгүй болохоор нь гараад явчихсан юм. Гэтэл тэр хурлыг зохион байгуулж байсан газарт Флом олон улсын байгууллагыг удирддаг байсан хүн байсан юм билээ. Тэгээд тэр хүн үзэл бодолдоо үнэнч хүн байна гэж харсан уу намайг дуудаад уулзмаар байна

гэсэн. Тэр хүн "би чамайг дэмжмээр байна, чи надтай хамтарч ажиллаач, би чамд иймдэмжлэг үзүүлье чи ингээд сургалтад суугаач" гэж хэлсэн. Тухайн үед шүр сувдан эдлэл сүлждэг 14 хоногийн гар урлалын сургалт байсан. Тэгээд гэрт хийх ажилгүй байгаа учраас сургалтад сууя гээд 14 хоногийн дотор бүх сүлждэг юмнуудыг нь сурсан.

Тэгсэн чинь Пави Орнер гуай 2012 онд намайг "чи нэг төсөв бичээд ирээрэй тэгвэл би чамд дэмжлэг үзүүлмээр байна" гэсэн. Тэгээд дэвтрийн гол цаасан дээр шугам татаж байгаад сургалт орсон багшаасаа үнийн судалгаа авч хийгээд, 2,300,000 төгрөгийн төсөв гараараа бичээд ороход тухайн үедээ их л мөнгө санагдаж байсан. Тэгээд надад олон бараа материал авч өгсөн. Тэгээд би бүлэг байгуулж 5 хүнийг удирдаж, худалдааны төвд бүр шүрээр хийдэг зүйлийн лангуу нээж зардаг болоод маш идэвхтэй явсан. Тэгээд байж байтал аймагт дандаа нийгэмд үйлчилдэг байгууллага байна, гишүүнчлэлтэй байгууллагатай болмоор байна гэж Пави Орнер санаачлаад, Улаанбаатар хотоос хүмүүс урьж авч ирээд аймагт Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо гэдэг байгууллагын салбар зөвлөлийг байгуулаад, намайг тэргүүнээр нь ажиллаач гэдэг санал тавьсан. Тэгээд би 2010 оноос эхэлж төрийн бус байгууллагын тэргүүн болж ажилласан юм. Тэгээд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн салбарт гүн ороод тэрнээс хойш одоо 11 жил хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн салбарт ажиллаж байна. Тухайн үедээ шинэ залуу, үзэл бодол өөр байсан учраас аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд дундаа реформ, шинэчлэл хийгээд нэлээн дориун ажилладаг байсан. Тухайн үед одоогийн Улсын Их Хурлын гишүүн Баатарбилэг манай аймгийн засаг дарга байлаа. Тэгээд Баатарбилэг даргатай хамтарч зөндөө ажлууд зохион байгуулсан.

Би чинь өөрөө тухайн үед барилддаг байсан учраас энэ байгууллагад орсноороо хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн паралимп гэдэг спортын чиглэл рүү ороод спортынхоо чиглэлээр бас нэлээн өндөр амжилтыг үзүүлсэн. Миний хамгийн том медаль бол Азийн аваргын мөнгөн медаль байдаг. Одоо Монгол Улсынхаа бөөрөнцөг, зээрэнцэг шидэлтийн рекордыг эзэмшдэг. Монгол улсын пара шидэгч нарын анхны олон улсын хэмжээний мастер гэдэг спортоор үзүүлсэн амжилт надад олон байгаа. Спортын буянаар их олон орноор явж, олон орны хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй уулздаг учраас юмыг арай өөрөөр харах гэж хичээдэг гэж би боддог. Тэгээд нийгмийнхээ салбарт реформ өөрчлөлтийг хийхийн төлөө ажиллаж байсан. Яг 2012 онд Флом байгууллагын дэмжлэгтэй ХБИХЗ-ийг байгуулах үед Фломд ажиллаж байсан хүн зөвлөлийн тэргүүнийг хийдэг байж байгаад тэр хүн хийж болохгүй юм байна гэдэг асуудал яригдаж, 2014 онд ХБИХЗ-ийн тэргүүн нь болоод ажилласан. Тэрнээс хойш 3 жил ажиллаад дараагийнхаа тэргүүнд ажлаа хүлээлгэж өгөөд, энэ жил цар

тахал гэж явсаар байгаад сүүлийн 1-2 жил ажил хийлгэсэнгүй. Энэ жил би зөвлөлийнхөө тэргүүний ажлыг аваад арай өвөрмөц, шинэ маягаар олон улс, Улаанбаатар хотын дээвэр болсон томоохон төрийн бус байгууллагуудын хандлага, харилцаанд нийцүүлсэн, тэд нартайгаа уялдсан маягаар ажиллах нь зөв гэж бодсон. Яг манай зөвлөлийн хувьд Түгээмэл Хөгжил төв, Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо гээд 2 том байгууллагатай нэлээн ойрхон ажилладаг. Тэгээд энэ төсөл хэрэгжээд явах хугацаанд бүх байгууллагуудтай ойрхон ажиллах шаардлага гарах юм шиг байгаа юм. Форум гэдэг байгууллагатай бас хамтраад ажиллаад явах байх. Гэхдээ манай аймагт хэрэгжиж байгаа Тэгш тусгал байгууллагын төсөл бол маш чухал төсөл. Яагаад гэвэл өмнө нь олон улсын төслүүд биднийг ингэж ажилла, тэгж ажилла гэдэг заавар зөвлөгөө өгч, манай дотоод ажилд оролцож ажилладаг байсан бол энэ жилээс тэгш тусгал төрийн бус байгууллагатай хамтын ажиллагааны гэрээтэй, тусдаа бие даасан, өөрсдийгөө хөгжүүлсэн байдлаар ажиллах зорилго тавиад байгаа. Энэ төсөл дуусахад Архангай аймгийн ХБИХЗ маш гоё манлайлагч болсон, бодлогын төвшинд зөв ажилладаг болсон байх чиглэл рүү түлхүү ажиллах юм.



Тэгш Тусгал төрийн бус байгууллага нь ямар байгууллага вэ? Олон улсын байгууллага уу эсвэл Монголын төрийн бус байгууллага юм уу?

Монголын төрийн бус байгууллага. Миний өмнө нь ярьж байсан Флом олон улсын байгууллага бол Финландын засгийн газраас санхүүжилттэй байгууллага байсан. Тэд Архангай аймагт 2003 оноос эхлээд үйл ажиллагаагаа явуулаад өнгөрсөн жил төслийнх нь хугацаа дууссан юм. Тэгээд төсөл дээр ажиллаж байсан хүмүүс Финландын засгийн газарт дахиж хандаад шинэ төрийн бус байгууллага байгуулаад, одоо энэ төсөл Архангай аймагт хэрэгжихээр болсон юм.

Та сая спортын амжилт үзүүлсэн гэж ярьсан. Спортоор хичээллэхэд ямар байсан бэ? Таны хувьд одоо ч гэсэн хичээллэдэг байх, тийм ээ?

Спортоор хичээллэх бол хамгийн гоё зүйл гэж боддог. Би ямар ч завгүй байсан ч гэсэн өөртөө өдөрт заавал нэг цаг гаргахыг хичээдэг. Яагаад гэвэл би 10 жил тасралтгүй спортоор хичээллэж байгаа мэргэжлийн тамирчин болчихсон хүн. Спортоор хичээллэнэ гэдэг бол хөгжлийн бэрхшээлтэй хүнд 5 жил амьдраад тэнгэрт дэвших байсан бол ядаж 6 жил амьдраад тэнгэрт дэвших нэг жилийн нас

нэмэхүйц аймаар том боломжийг өгдөг. Яагаад гэвэл хөдөлгөөнтэй, бодисын солилцоо сайтай байна гэдэг бол тэр хүний амьдрах чадвар нэмэгдэнэ, хоёрт хөдөлгөөн ихтэй хүн тэсвэр хатуужилтай, ажлын ачаалал даадаг болдог. Хөгжлийн бэрхшээлтэй хүн хөдөлгөөн хийх нь л хамгийн чухал. Гэр орондоо хоол ундаа хийх, хог шороогоо гөвөх, тоос шороо арчих зэрэг ахуйн хөдөлгөөн байж болно. Ахуй хөдөлгөөнөөс гадна өөрт тохирсон ачаалалтай хөдөлгөөн хийнэ гэдэг бас их чухал зүйл байдаг. Би өөрөө тэргэнцэр дээр сууна, таягтай явна, бас одоо давхар фитнес клубийн захирал хийдэг. Монгол улсын хэмжээнд тэргэнцэртэй фитнессийн багш бараг л надаас өөр байхгүй байх гэж би боддог. Чөлөөт бөхийн гавьяат Энхээ гээд нэг ах байдаг. Энхээ ах бас яг тэргэнцэр дээр суудаг ч чөлөөт бөхийн хүүхдүүд бэлтгэдэг юм байна лээ. Яг тэрэн шиг би фитнесс клубээр эмэгтэйчүүд яаж турах юм, залуучууд яаж масс нэмэх юм, яаж гоё бие хаатай болох юм гэдэг чиглэл лүү бас ажиллана. Дээрээс нь би бас Архалхын домог гээд клубтэй. Манай клубд дандаа эрүүл энгийн 10 жилийн хүүхдүүд байдаг. Тэндээ паур лифтинг (powerlifting) гээд хүчний 3 төрөлд хүүхдүүд бэлдэнэ. Бас олимпын төрлийн хүндийн өргөлт, хөнгөн атлетикийн шидэлтийн төрлөөр хүүхдүүд бэлтгэдэг. Тэгээд дээрээс нь паралимпынхаа өөр шигээ хөгжлийн бэрхшээлтэй тамирчдыг зохион байгуулж, удирдаж, тэмцээн уралдаанд оруулж авч явдаг. Ер нь бол 4 чиглэлээр хүн бэлддэг. Дээрээс нь фитнесс клубээ ажиллуулна, зөвлөлийнхөө ажлыг давхар хийгээд л явж байдаг. Бас хоол хийх дуртай учраас хоолны салбарт жижигхэн хоолны газартай. Би үүнийг бэртэж гэмтсэнээс хойш хөдөлмөрлөөд амьдрахын төлөө зүтгэсэн, ажил хөдөлмөр хийгээд байгаад бурхан надад өгсөн бэлэг байх гэж боддог. Би ямар ч гэсэн өөрт тулгардаг бэрхшээлүүдийг даван туулаад яваад байдаг.

Та анх тэр тэмцээнд оръё гэсэн тэр санаа юунаас үүссэн бэ?

Анх тэмцээнд оръё гэж бодсон, мэдсэн юмгүй байж байлаа. Яг тэргүүнийхээ ажлыг авчхаад байж байтал манай энд Ай Фо байгууллагын суурин төлөөлөгч Буянаа гээд настай эмч эмч байсан. “Самбууданзаан нэг ийм ажил байна. Халамж дээр тэмцээний удирдамж ирж, манай дээр бас ирсэн байна. Хот руу тэмцээнд 4 хүн явуулах хэрэгтэй байна. Чи хүн олоод, явуулах хэрэгтэй. Зардлыг нь шийдье” гэсэн. Надад Хангай гэдэг найз байсан юм. Хангай найз, Гантуяа гээд дүүтэйгээ гурвуулаа болсон. Бид гуравт хэн юм заах вэ гээд бодтол чинь биднийг бодвол арай эрт бэртэлтэй байсан Бадам гэдэг залуу байсан. Бадам өмнө нь тэргэнцэртэй уралдаанд ороод хотын хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй нэлээн харьцаатай яваад байдаг байсан юм байна лээ. Тэгээд Бадамтай уулзаад “ийм хүмүүс бэлдсэн, одоо ийм ийм ажил байна, хот руу тэмцээнд орох уу” гэсэн оръё гэсэн. Тэгээд бид хэдийн хувьд бэлтгэл хийгээд тэмцээнд оролцоод, тэгээд манай Бадам маань ч түрүүлээд л, манай Гантуяа ч

тэргэнцэртэй уралдаанд түрүүллээ. Хангай бид хоёр бас тэргэнцэртэй хуралдаанд уралдлаа. Би ч наадмын талбайг нэг тойроод л "би бол үүнийг хийдэг хүн биш юм байна" гэж бодсон. Аймаар тэсвэр тэвчээр шаардаад больсон.

Тэгээд тэмцээний өдөр байтал одоо бөөрөнцөг шиднэ гэж байна. Бөөрөнцөг шиднэ гэж ямар юм байдаг юм бол гээд очоод үзтэл нэг дөрвөлжин сандал дээр суулгаад нэг бөөрөнхий төмөр шидүүлж байна. Шидээд үзлээ бас боломжийн юм байна шүү. Тухайн үедээ би 4-р байранд ороод л мултарсан. "Би бол тэргэнцрээр уралддаг хүн биш, бөөрөнцөг шиддэг хүн юм байна" гэж бодсон. "Хойтон жил улсын аварга болохоор ирж заавал түрүүлнэ дээ" гэж хэлээд би явсан. Аймагтаа ирээд, аймгийнхаа Биеийн Тамир Спортын Газрын даргатай уулзаад "ийм тэмцээн болдог юм байна, би хүмүүс цуглуулъя, бөөрөнцөг гэдэг зүйл шийдэх юм байна, гүйх юм байна, тэргэнцрээр уралдах юм байна, та зааж өгөөч" гэж хэлсэн.. Энэ нь яг Монголд анх удаагаа олон төрлөөр дөнгөж оролцуулж эхэлж байсан үе л дээ. Тэгээд би 12 хүний бүрэлдэхүүнтэй баг бүрдүүлсэн. Тухайн үеийн Биеийн тамир спортын газрын дарга байсан Нэргүйбаатар гэдэг хүн чинь надад бөөрөнцөг, зээрэнцэг шидэлтийг зааж байсан миний багш. Одоо ч гэсэн миний багш хэвээрээ байгаа. Байгууллагын дарга хүн бид нарыг жоохон үл ойшоосон байдалтай ч гэсэн гүйж ирээд ингээрээ тэгээрэй гээд бид нарт зав чөлөө гаргаад заадаг байсан. Тэгээд бид нар багаараа тэмцээнд явахад, багш ч, халамжийн газрын дарга ч бас хот руу орж таарсан. "Бид нар гайгүй байгаа та 2 ирээд тэмцээнийг үзээрэй" гээд хэлсэн. Тэгээд л манайхан тэмцээнд оролцоод, би бөөрөнцөг шиднэ гэсэн амлалтандаа хүрч бөөрөнцөг шидэлтээр түрүүлсэн.

Манай Архангай аймгаас 2010 онд 12 хүний бүрэлдэхүүнтэй орсон баг нийлбэр дүнгээр хөнгөн атлетикийн улсын аварга болоод, тэгээд л манай аймагт паралимпийн хөнгөн атлетикийн төрөл эрчимтэй хөгжиж эхэлсэн. Анх тиймэрхүү маягаар спортын замналаа эхэлсэн. Багаараа аварга болсон тухайн үед Монголын пара хөнгөн атлетикийн холбооны тэргүүн Батдорж багштай танилцсан. Тэгсэн чинь 2010 оны намар 4 жилд нэг удаа болдог Гуанжугийн Азийн их наадам болно гэж сонслоо. Тэгсэн явах ихэнх хүмүүсийн зардал мөнгө нь төрөөс шийдэгдэж байгаа бололтой. Би тэр чимээг нь хотоос хүмүүсээс сонсоод л байсан. Тэгээд би бас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагынхаа чиглэлээр нэг сургалтад суучхаад хотод байж байхдаа Батдорж багшийг дуудаж уулзаад "би энэ тэмцээнд явж үзмээр байна, бөөрөнцөг шидье та намайг дэмжээд өг, би зардал мөнгөө өөрөө олно, та намайг явуулах арга хэмжээн дээр л бүх юмыг нь янзлаад өг" гэж хэлсэн. Тэгсэн за тэгье гэж хоёулаа тохироод би аймагтаа ирж аймгийнхаа засаг даргын тамгын газартай ярьж зардал мөнгөө шийдүүлсэн. Тэгээд 2010 онд анх олон улсын тэмцээнд орж үзээд тэндээс олон улсын тэмцээн гэж юу байдаг, хөнгөн атлетикийн төрлүүд, паралимпын төрөлд

тэмцээнүүд ямар төрлөөр явагддаг, ямар ангиллууд байдаг гэдгийг анх мэдэж ирээд, тэрнээс хойш олон улсын тэмцээнүүдэд их явсан.

Тэрний дараа 2011 онд анхныхаа медалийг Японоос авч байлаа. Бөөрөнцөг, зээрэнцэг, жад гэсэн 3 төрлөөр ороод 3 хүрэл медаль аваад ирж байсан. Багштайгаа хамт яваад олон улсын тэмцээнээс пара шидэлтийн төрлөөр бараг анхны медалийг авсан. Тэгээд л бөөн баяр, орон нутаг маань ч гэсэн аймаар сайхан хүлээж авсан. Миний хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага дээр ажиллах карьер өсөөд л, намайг харах хандлага хүртэл өөрчлөгдөж байсан. Одоо ч гэсэн пара, хөгжлийн бэрхшээлтэй тамирчин гэж харахаараа манай аймгийнхан дандаа яг надаар төсөөлж хардаг. Би бас давхар фитнесс клуб хичээллүүлж эхлээд 2 жил шахуу болох гэж байна. Тэгэхэд манай фитнесс дээр ирж байгаа хүмүүс өмнө нь тэнд байсан хүмүүс дээр очдоггүй байсан ч намайг очсон гэдэг сургаар над дээр ирж бэлтгэл хийх гэж хүсдэг болчихсон. Тэнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ч, зүгээр нийгэмд амьдраад явж байгаа эрүүл иргэд ирж дасгал хөдөлгөөнөө заалгаж бэлтгэл сургуулилтаа хийдэг байгаа. Спортын амжилт гэвэл би Азийн аваргын мөнгөн медаль авсан байдаг. Манай шавь нар бас их мундаг хүчний 3 төрөлт, повер лифтингийн төрлөөр Азийн аварга, дэд аварга төрчихсөн. Хүүхдийн их наадмаас шидэлтийн төрлөөр бас аваргууд төрсөн. Улсын аваргад манай Архангайгаас миний бэлдсэн хүүхдүүд нэлээн сайн оролцдог. Хүчний 3 төрөлтийн парад Содномпэлжээ гээд манай гавьяат тамирчин ороод, өөрөө шахаад, бүх зүйлийг хийгээд аймаар гоё үлгэр дуурайл үзүүлээд л явж байгаа. Тэгэхэд би хажууд нь тэргэнцэртэй, хөл муутай хүн эрүүл хүүхдүүдийг бэлдээд амжилт үзүүлж болдог гэдгийг давхар харуулж байгаа гэж би боддог. Манай шидэлтийн төрлүүд, ер нь аль ч төрөл дээр очиход тэргэнцэртэй багш хүн байдаггүй. Би Хүүхдийн их наадамд уржнан оролцсон. Хүүхдийн их наадмын хүндийг өргөлтийн төрөлд 2 хүүхэд бэлдэж орсон.

Тэгээд очиход хүндийн өргөлтийн төрөлд Архангайгаас нэг ч тамирчин ирдэггүй байж байгаад, хүн ирнэ гэхээр ямар хүн ирэх нь вэ? гэж гайхаж байсан. Тэгээд гайхаж байсан хүмүүс тэргэнцэртэй хүн 2 сөөсгөр бандитай яваад орохоор бүр гайхаж байсан. Тэр үед гавьяат тамирчин Анхцэцэгийн багш Хосоо багштай анх танилцсан юм. Эхлээд бие биеийгээ хараад л өнгөрсөн ч “чамайг ёстой сайн дэмжинэ, чи ёстой мундаг байна. Архангайгаас ингэж ордоггүй байсан. Одоо бас нэг аймаг ордог болж байна. Бид нар баяртай байна” гээд л надад гоё аяга бэлэглэхэд бүр аймаар гоё санагдаж байсан. “Энэ том шигшээ багийн дасгалжуулагч намайг ингэж хүндэлж байхад би хүүхдүүдээ сайн бэлтгэхгүй бол болохгүй юм байна” гэж би тухайн үед бодож байсан. Би тэнд тэгж аймаар их баярлаж байсан. Хүүхдийнх наадамд зээрэнцэг шидэлт дээр миний бэлдсэн шавь бас түрүүлсэн. Манай биеийн тамир спортын газрын дарга Нэргүйбаатар

багш өөрөө шидэлтийн тамирчин хүн учраас надад бүх юмаа заасан. Би тэрийг нь хүүхдэдээ заасан. Налайхын тэмцээн болдог хөнгөний талбай дээр бэлтгэл хийлгээд байж байхад бусад аймгийн багш нар ирнэ. Тэргэнцэртэй болохоор намайг багш гэж ойлгодоггүй юм шиг байгаа юм. Хаанах вэ? Архангай. Манай хүүхэд аймаар гоё шидэлт хийхийг хараад "аргагүй Нэргүйбаатар шидэлтийн хүн учир шидэлт чинь ийм байхаас яахав" гэсэн юм ярина. Би тухайн үед "багш тэнд байгаа ч би энэ хүүхдийг өөрөө ингэж шидүүлдэг болсон шүү дээ" гэж бодоод гонсгор байгаа юм. Тэмцээнээс гараад хүүхэд маань түрүүлээд, алтан медаль авсан. Манай аймаг хүүхдийн их наадмаас 4 алтан медаль авсны 1 нь миний шидэлт дээр бэлдсэн хүүхэд алтан медаль авсан. Тэгээд би налайхаас хөдлөхдөө л багш руугаа залгаад "багш аа шавь нь чадсан шүү. Таны заасан юмыг сурсан байна, хүүхдийн их наадамд түрүүлсэн" гээд багшдаа хамгийн түрүүнд баярласнаа хэлсэн. Тэр үйл явдлууд бүр сэтгэлээс гардаггүй юм.

Одоо манай клубийн анхны бэлдэж байсан хүүхдүүд ихэнх нь том оюутан болчихсон. Одоо хамгийн бага нь 4-р ангийн хүүхэд байх жишээтэй. Тэгээд л хүүхдүүд над дээр бэлтгэл хийдэг, намайг хөгжлийн бэрхшээлтэй гэж хэзээ ч хардаггүй. Намайг тэргэн дээр суулгаад, түрээд дэмжиж туслаад явдаг. Миний үгнээс гарахгүй аймаар гоё байдаг. Ер нь хөгжлийн бэрхшээлтэй хүн өөрөө өөрийнхөө амьдралыг бүтээх нь чухал гэдэг зүйлийг би олон жил янз бүрийн юм хийж үзсэн туршлагаасаа хардаг. Одоо манлайлж байгаа, идэвхтэй амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бол ямар нэгэн байдлаар өөрсдийгөө олсон, илүү их хөдөлмөрлөсөн, илүү их өөрийнхөө төлөө зүтгэсэн хүмүүс байдаг болов уу гэж би боддог.

Та бүр нүдэнд төсөөлөгдтөл аймар гоё ярилаа. Таны хүсэл мөрөөдөл яг юу вэ? Та цаашдаа юу хийхийг мөрөөдөж байна вэ?

Миний мөрөөдөж байгаа хамгийн ойрын 2 мөрөөдөлтэй байна. Ар гэртээ би охинтойгоо, ханьтайгаа, ээжтэйгээ дөрвүүлээ амьдардаг. Миний ар гэрийн амьдрал бол асуудалгүй гоё, бас бид нар маш сайхан тайван амгалан амьдарч байгаа. Миний ар гэр тогтвортой тайван амьдарч байгаа учраас миний зорьж байгаа 2 зорилтын нэг нь ХБИХЗ-ийг би өмнө нь бас дурдсан бодлогын төвшинд ажилладаг манлайлагч нарыг маш их сайн бэлдсэн байхыг зорьж байна. Яг энэ зөвлөл гэдэг байгууллагаа 4 жилийн дараа аймаар гоё болгохыг хүсэж мөрөөдөж байгаа. Бодлогын төвшинд ажиллаж чаддаг хүлээн зөвшөөрөгдсөн, хөгжлийн бэрхшээлтэй манлайлагч лидер залуучуудыг бэлтгэж гаргахыг зорьж байна. Удаах зорилт нь клубийнхээ хүүхдүүдээс дэлхийн тэмцээнүүдэд маш том амжилт үзүүлэхийг хүсэж байна. Бас паралимпаар хичээллэж байгаа ганц нэг амжилт үзүүлэх боломжтой залуучуудыгаа дэлхийн тавцанд гаргах хүсэл мөрөөдөл

байна. Нийгмийн салбар руу хөгжлийн бэрхшээлийнхээ ажлыг сайн хийхийг хүсэж байна. Бас спортын салбарт бас маш сайн хөдөлмөрлөхийг хүсэж байна.

Таны хүсэл мөрөөдөл чинь удахгүй биелэх байх гэж би бодож байна. Магадгүй 4 жилийн дараа би подкастаа ахиж хийгээд таны хүсэл мөрөөдлийн талаар бид 2 ахиж ярьж байж ч магадгүй л байх. Маш гоё яриа өгсөн танд их баярлалаа. Үнэхээр их урам авч байна. Хүн хөдөлмөрлөөд өөрөө л хичээх юм бол маш их амжилтад хүрч болдог гэдгийг ойлголоо. Та хүнд хэцүү бэрхшээлүүдтэй тулгараад бууж өгье эсвэл больё гээд шантрах үедээ юу бодож урам авдаг байсан бэ?

Шантрах үе маш их байсан, асуудал зөндөө гардаг. Гэхдээ миний аав ээжээс заяасан нэг төрөлхийн онцлог байдаг байх гэж би боддог. Хэзээ ч, хаана ч, хэн байхаасаа би ичдэггүй. Өнөөдөр би сайхан амьдарч байгаа нь надад тийм ач холбогдолтой зүйл биш. Гэхдээ өмнө нь хэзээ нэгэн цагт ядарч зовж үзсэн үе надад зөндөө байгаа. Тэгэхэд би тухайн үеийнхээ байдлаасаа хэзээ ч, хэнээс ч ичдэггүй яг өнөөдрөөрөө л амьдардагт миний мөн чанар байдаг байх гэж боддог. Манай аав яг тийм хүн байсан, яг л байгаа юмыг байгаагаар нь боддог, байгаа юмыг байгаагаар нь сэтгэж хийдэг. Тэгээд сэтгэж хийж байгаа зүйлдээ их ач холбогдол өгч, тэрэндээ сэтгэлээ зориулдаг учраас хийсэн ажлууд маань үр дүнтэй болдог юм шиг санагддаг. Тэгэхээр шантрах үе байсан ч гэсэн би л хийхгүй бол энэ юмыг хэзээ ч, хэн ч хийхгүй гэдэг бодол надад байдаг. “Би л энийг өөрөө л даван туулахгүй бол хэзээ ч хэн нэгэн намайг энэ өндөр уулын орой дээр гаргаж өгч чадахгүй. Тийм учраас би хөдөлмөрлөж байж тэр өндөр уулын орой дээр очих ёстой” гэж бодож хөдөлмөрлөж л явдаг.

Нэг жишээ ярья л даа. Би өөрөө аав ээж хоёртойгоо хөдөө өссөн хөдөөний хүүхэд, бэртээд л суурин газар амьдардаг болсон хүн. Анх би тэргүүн болох гэж байхад намайг хүмүүс гоочлоод “наадах чинь 4-р ангийн боловсролтой хүн, юун тэргүүн болгох, энэ юу хийх юм” гэдэг яриа гарч байсан. Тэгэхээр нь “би тэдэнтэй, тэдэнгүй амьдраад болсон юм, би зөвхөн найз нөхөдтэйгөө хийдэг юмаа хийгээд явахад болно” гээд аймаар гомдоод ажиллахгүй гээд ажлаа орхиод явж байсан. Тэгээд ажил хийхгүй гээд хэвтэж байтал Мерси Корын мэргэжилтэн байсан Ойдов гээд нэг мундаг залуу бий л дээ. Ойдов хотоос ирчихсэн байж таараад манайд давхиж ирээд “чи л ингэж явж байгаа бол бусад нь бас бүгд л явна. Хэн ч энэ ажлыг хийхгүй. Тийм учраас чи хэзээ ч ингэж болохгүй. Чи өөрийнхөө төлөө хөдөлмөрлө, өөрийнхөө төлөө зүтгэ, өөрийнхөө төлөө хөдөлмөрлөсний дараа чи хүний төлөө ажилладаг болно. Хүний төлөө ажиллаад нийгэмд сайн сайхан юм бүтээхийн төлөө ажиллаж сур. Чи энэ бүхнийг даван туулж байж л нийгмийн харилцаанд зөв орж амьдарна шүү” гэдэг зүйлийг ярьсан. Тэгээд л ажил хийе гээд 7 хоногийн дотор хурдан өөрчлөгдөж, хүмүүсийн юу гэх нь

хамаагүй, би л ажлаа сайн хийвэл болно гээд л ажилласан. Тухайн үед намайг хүмүүс 4-р ангийн боловсролтой гэж байсан бол одоо би биеийн тамирын багш, дасгалжуулагч мэргэжилтэй болоод сургуулийг нь төгсөөд, хүүхдүүд бэлтгээд, магистрынхаа зэргийг хамгаалаад явж байна. Хүнд боломжгүй зүйл гэж угаасаа байдаггүй. Хүн юу гэж хэлэх нь чухал биш, өөрөө хөдөлмөрлөх нь их чухал юм байна. Тэгэхээр ямар нэгэн байдлаар өөрийнхөө, хувь хүнийхээ онцлогоос хамааралтай тэр бэрхшээлүүдийг өөрийнхөө чадах чинээгээр даван туулаасай л гэж хүсдэг.

Маш гоё яриа өгсөн танд баярлалаа. Манай подкастын ч гэсэн цаг өндөрлөх дөхөж байна. Таны цаашдын ажил үйлс, амьдрал, хүсэл мөрөөдөл, бүх зүйл нь маш сайхан бүтэх болтугай гэж хүсэн ерөөе!

За баярлалаа. Намайг өнөөдөр энэ подкастандаа урьж оролцуулсан, манай хөдөө орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ямар асуудал тулгардаг тухай хувь хүн талаас нь, байгууллага талаас нь ярилцсан үр дүнтэй ярилцлага боллоо гэж би бодож байна. Тэгэхээр хүмүүс өөрөөр хардаг байж болно, би бол хэтэрхий дэвүүн сэтгэлтэй, өөдрөгөөр хардаг хүн учраас хүн болгоныг өөдрөгөөр харахыг хичээдэг. Тийм учраас би өнөөдөр төр засгийг ийм тийм гэж хэлэхийг хүсэхгүй байна. Төр засаг маань бүх юм нь бүрдчихсэн биднийг дэмжихэд бэлэн байгаа. Тэгэхээр хувь хүний өөрийнх нь хандлага бас их чухал гэдгийг манай хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хөдөө орон нутагт ажиллаж байгаа төрийн бус байгууллагынхан ойлгох хэрэгтэй байх гэж бодож байна. Миний дуу хоолойгоо хүргэсэн энэ нэвтрүүлэг орон даяар цацагдаад хүмүүс сонсох байх. Тэгэхээр манай Архангай аймаг бол нэг иймэрхүү маягаар ажилладаг гэдгийг товч, тодорхой ярьсан байх гэж бодож байна. Урьж оролцуулсан танай баг хамт олонд бас баярлалаа. Би бас чадахаараа л өөрийнхөө мэддэгээр ярихыг хичээлээ. Та бүхнийхээ ажилд, амьдралд сайн сайхан бүхнийг хүсье ээ!

За баярлалаа танд.

ХҮҮХЭД БҮХЭН СУРАХ ЭРХТЭЙ



Д.Мөнхзул

Сайн байцгаана уу, эрхэм хүндэт сонсогчид оо, Антолд подкастын маань ээлжит дугаар эхлэхэд бэлэн болоод байна. Энэхүү дугаарт Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 263 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Мөнхзул оролцож байна. Та манай урилгыг хүлээн авсанд баярлалаа. Та эхлээд өөрийгөө манай сонсогчдод танилцуулахгүй юу?

Миний нэрийг Мөнхзул гэдэг, Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 263 дугаар цэцэрлэгт эрхлэгчээр ажилладаг. Би 2011 онд Монгол Улсын Боловсролын их сургууль (МУБИС)-ийн Сургуулийн өмнөх боловсролын сургуулийг багш, арга зүйч мэргэжлээр суралцаж төгссөн. Мөн 2016 онд МУБИС-ийн боловсролын удирдлагаар магистр, 2018 оноос МУБИС-ийн боловсрол судлалын докторантаар элсэн суралцаж байгаа судлаач оюутан байна.

Би сая статистик тоо баримт хараад сууж байхад 2020 оны байдлаар улсын хэмжээнд нийт 1156 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагддагийн 643 нь Улаанбаатар хотод хамрагддаг мэдээлэл харлаа. Танай цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байдаг уу?

Манай цэцэрлэг Сонгинохайрхан дүүргийн 36 дугаар хороонд байрладаг. Судалгаагаар 2021 онд нийтдээ манай хороонд 25 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна гэсэн тоо гарсан. Манай цэцэрлэг 2019 онд байгуулагдсан шинэ цэцэрлэг.

Байгуулагдсан оныхоо хичээлийн жилд хөгжлийн бэрхшээлтэй нэг хүүхдийг эцэг эх нь хүсэлт гаргасны дагуу цэцэрлэгтээ элсүүлсэн. Багш нар маань хэдийгээр сургуульдаа тусгай хэрэгцээт боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй хэрхэн ажиллах вэ? гэдэг арга зүйн хичээлийг үзсэн боловч яг бодит практик дээр ажиллахад бидэнд бага зэргийн бэрхшээлүүд үүссэн. Тэгээд эцэг эх, багш нар, заах аргын нэгдлээрээ хамтраад энэ хүүхэдтэйгээ хэрхэн ажиллах вэ гэдэг төлөвлөгөө гаргаж ажилласан. Хамгийн эхэнд ээжээс хүүхдээ оношилсон байдлыг нь авсан ба хүүхэд тулгуур эрхтний бэрхшээлтэй гэсэн оноштойгоор манай цэцэрлэгт ирсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдээс төвшнийг нь тогтоох сорил авдаг.

Монголын хүүхдийн хөгжлийг үнэлэх түргэвчилсэн сорилоор оношилж үзэхэд оюун ухаан, дадал хэвшил, том, жижиг булчингийн хөгжил, нийгэм, сэтгэл зүй, хэл ярианд нь бага зэргийн өөрчлөлт байгааг бид анзаарсан. Тэгээд ээжтэй нь ярилцаад энэ бол ганц тулгуур эрхтний талаасаа бэрхшээл биш, хавсарсан бэрхшээл байх магадлалтай учраас хүүхдээ бид цаашид нь яаж хөгжүүлэх вэ гэдэг асуудлыг шийдэхийн тулд олон улсын байгууллагатай хамтарч ажиллаж эхэлсэн. Дэлхийн Зөн олон улсын байгууллагад бид бүхнийг мэргэжлийн хүмүүстэй холбож



өгнө үү гэж хүсэлт гаргасан. Тэд биднийг АШУҮИС-ийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн чиглэлээр ажилладаг эмч, багш нартай холбож өгсөн. Ингээд Наранцэцэг багштай холбогдоод, ганц цэцэрлэгийнхээ хүүхдийг биш 36 дугаар хороотойгоо хамтраад хорооныхоо нийт 25 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үзлэг, оношилгоонд хамруулах 2 өдрийн үйл ажиллагаа зохион байгуулсан. Энэ хүүхдүүдийг эрт, зөв оношилъё. Бид энэ хүүхдийг хэрхэн цаашид хөгжүүлэх вэ гэж бодож байсан. Энэ оношилгооны үр дүнд "Энэ хүүхэд зөвхөн тулгуур эрхтний бэрхшээлтэй биш, хөнгөн хэлбэрийн тархины саажилттай хүүхэд байна" гэдэг зөрүү оноштой гарсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хамгийн чухал зүйл бол эрт бөгөөд зөв оношилгоо байдаг. Эрт, зөв оношилсноор бид энэ хүүхдийг цааш нь яаж хөгжүүлэх вэ? гэдэг төлөвлөгөөгөө гаргана. Ингээд хүүхдийн хувьд тархины саажилтын хэлбэртэй учраас бид нар мэргэжлийн хүмүүстэй дахиад хамтран ажиллах хэрэгцээ, шаардлага үүссэн.

Тэгээд АШУҮИС-тай хамтарч ажилласны дараагаар бид Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв (ХБХСЗХТ)-тэй цаашид хамтарч ажиллахаар болсон. Энэ ХБХСЗХТ-өөс хүүхдэд эрүүл мэндийн зөвлөгөө, эцэг эхэд сэтгэл зүйн зөвлөгөө авч, цэцэрлэгийнхээ ганцаарчлан ажиллах төлөвлөгөөгөө өөрчилсөн. Бид нар өмнө нь тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байсан бол одоо тархины саажилттай хүүхэдтэй хэрхэн ажиллах вэ гэж төлөвлөгөөгөө өөрчилсөн. Цэцэрлэгийнхээ хэмжээнд ганц хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш, туслах багш биш цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, эцэг эх, дээр нь бусад байгууллагуудтай бид нар хамтдаа дэмжлэгийн багийг байгуулсан. Бид энэ хүүхдийнхээ төвшинг нь тогтоож үзэхэд хэл яриа, хөдөлгөөний хувьд 2 нас 2 сартай хүүхдийн хэмжээнд хөгжлийн төвшинтэй байсан.

Тухайн хүүхэд маань хэдэн настайдаа анх цэцэрлэгт орсон бэ?

Анх 3 настай цэцэрлэгт хамрагдсан. Төрийн өмчийн цэцэрлэгт 2 настайд нь өгье гэж ээж нь 2 цэцэрлэгт хүсэлт гаргасан. Гэтэл цэцэрлэг "манайх энгийн сургалт, хүмүүжлийн үйл ажиллагаа явуулдаг цэцэрлэг учраас хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд авах боломжгүй" гэсэн хариу өгсөн. Яагаад гэвэл хүүхэд маань памперс хэрэглэдэг, өөрөө бие даан бие засах, хоол идэх зүйл дээр бэрхшээлтэй байсан учраас авах боломжгүй байна гэдэг асуудал яригдсан. Ингээд 2019 онд манай цэцэрлэг шинээр байгуулагдахад ээж хүсэлт гаргасан. Тэгээд манай цэцэрлэгийн багш нар, эцэг эх, цэцэрлэгийн захиргаа яаж энэ хүүхэдтэй ажиллах вэ гэж ярилцаад, хүүхдийг аваад цаашид үйл ажиллагаа явуулсан.

Тухайн үед 2-3 цэцэрлэгээс татгалзсан хариу аваад танай цэцэрлэгт хандахад та яагаад хүүхдийг хүлээж авах болсон бэ?

Одоо бол бодлогын баримт бичиг, эрх зүйн орчин нь бүрдсэн байгаа. Энгийн цэцэрлэгийн нэг ангид 1-2 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж болно гэсэн Боловсролын яамны сайдын тушаал гарсан. Дээр нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тэгш хамруулан сургах чиглэлээр дүрэм журмууд гарсан. Энэ дүрэм журмынхаа дагуу бид хүүхдийг цэцэрлэгтээ элсүүлэн суралцуулсан.

Анх хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд авахад ямар бэрхшээлүүд тулгарч байсан бэ?

Бэрхшээлүүд гарч эхэлсэн. Нэгдүгээрт хүүхэд ээж, ахтайгаа гурвуулаа амьдардаг, сургуулийн өмнөх боловсролд огт хамрагдаж байгаагүй. Тэгэхээр нийгмийн харилцаанд орох, хүүхдүүдтэй харилцан ярих хэл ярианы хувьд бэрхшээлтэй. Тод ярьж чаддаггүй, бие дааж бие засах дадал хэвшилд суралцаагүй, насанд хүрэгчдийн дэмжлэг туслалцааг аван памперс хэрэглэдэг байсан. Тэгэхээр хамгийн эхэнд ХБХСЗХТ-д эрүүл мэндийнх нь талаас нь хүүхдэд массаж хийх, чангарсан булчингуудыг нь зөөллөх иллэг хийх, хөдөлгөөнийг нь дэмжсэн олон хэлбэрийн





үйл ажиллагаанууд явуулсны дараа хүүхэд маань өөрөө бага зэрэг зогсож, гишгэдэг болсон. Тэгээд бие засъя гээд тархиндаа удирдаж эхлэхээс гадна багшдаа хэлдэг болсон. Эхлээд бол огт ярьдаггүй хүүхэд шууд бие засна гэж хэлэхгүй. Бид нар шиг бие засах процесс явагдаж байна гээд тархинд мэдээлэл ирэхгүй, хүүхэд шууд л бие засчихдаг ийм хүндрэл бэрхшээлүүд байсан. Дээр нь хүүхэд өөрөө 3 нас өнгөрч байхад оюун ухаан, нийгэмшихүй, сэтгэхүйн хувьд 2 нас 2 сартай хэмжээнд хоцрогдолтой байдаг. Тэгэхээр өөрийгөө илэрхийлэх асуудал хэцүү байсан учраас багш нар маань ойлгох, нийгмийн харилцаанд оруулахад бэрхшээлтэй асуудлууд байсан.

Бусад хүүхдүүдтэй хамт нэг ангид явж байсан уу?

Энгийн ангийн хүүхдүүдтэй хамт явж байгаа. Эцэг эхчүүдийн тал дээр ч гэсэн асуудлууд үүсэж эхэлсэн. Яагаад гэвэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд гэдэг чинь өөрөө халдварт өвчин биш. Тэгэхээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бусад хүүхдүүдтэй нэг ангид оруулаад сургахад нөгөө хүүхдүүдийн эцэг эхийн зүгээс “Яагаад манай хүүхдүүд хөгжлийн

бэрхшээлтэй хүүхэдтэй хамт нэг ангид явж байгаа юм бэ" гээд эвэртэй туулай үзчихсэн юм шиг ч гэсэн хандлага гарч эхэлсэн. Ээж аавууд "хүүхдээ бид нар өөр ангид өгөх хүсэлтэй байна, эрхлэгч ээ" гэсэн асуудал яригдсан. Тэгэхээр бид ганц багш, туслах багш, цэцэрлэг хүлээн зөвшөөрөөд хүсэл сонирхлоороо энэ хүүхдийг хүлээж авч байгаа ч гэсэн нийгмийн хандлага гэдэг юмыг өөрчлөхгүй бол болохгүй юм байна гэдэг үүднээс эцэг эхчүүдтэй ч гэсэн хамтарч ажилласан. Энэ хүүхдийн онцлогийн талаар ойлголтыг өгье, эцэг эхэд дүрэм журам, хууль эрх зүйг нь танилцуулъя гээд эцэг эхийн хурлаараа мэдээлэл өгч, эцэг эх болгонтой ганцаарчилж ярилцсаны дараа энэ хүүхдийг ээж аавууд арай өөр нүдээр хардаг болсон. Бусад эцэг эхтэй ч гэсэн аль болох хүндэтгэлгүй харьцахгүй байх, хүүхдийг ойлгодог давуу талууд гарч эхэлсэн.

Тухайн үед ангийнх нь хүүхдүүд яаж хандаж байсан бэ?

Манай хүүхдийн хувьд явж чаддаггүй, мөлхдөг ангид байсан. Тэгээд 3 нас гарантай бусад хүүхдүүд алхаад, гишгээд, гүйгээд, тоглоод байдаг. Гэтэл нөгөө хүүхэд маань элгээрээ мөлхөөд явж байхаар үе тэнгийнх нь хүүхдүүд "яагаад ийм өөр юм бэ" гээд гайхна. Бусдаас өөр онцлогийг нь хараад хүүхэдтэй харилцаа үүсгэх гэхээр хүүхэд маань хэл ярианы бэрхшээлээсээ болоод хүүхдүүдтэй харилцаа үүсгэдэггүй, дуугардаггүй, ярьдаггүй, хамтдаа тоглолтгүй байсан. Нэг буланд сандал дээрээ хөдөлгөөнгүй суугаад байдаг харилцааны асуудлууд гарч эхэлсэн. Хүүхдүүд ч гэсэн ойлгохгүй, "яагаад энэ хүүхэд ингээд байгаа юм бол" гээд ойлгохгүй. Тэгэхэд эрэг хандлагыг бий болгож хүүхдүүддээ энэ хүүхдүүдийг ойлгуулахын тулд, онцлогийг нь мэдүүлэхийн тулд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй бид яаж хамтраад нэг ангид суралцах вэ? гээд хүүхэлдэйн киног үзүүлсэн. Цэцэрлэгийн хүүхдүүд чинь юмыг нүдээрээ хараад, мэдрээд тэр зүйлийг бодитоор ойлгож мэдэрч байдаг. Тэгэхээр хамгийн түрүүнд энэ хүүхдүүддээ ойлгуулах хэлбэр нь юу гэвэл хүүхэлдэйн кино үзүүлье гээд ангийн багш нь хүүхэлдэйн киногоор таниулж байсан. Хүүхэд маань 2019 онд цэцэрлэгт орж ирээд 4 сарын дараа гэхэд хүүхдүүдийн хандлага маш их өөрчлөгдөж эхэлсэн. Ангийнх нь хүүхдүүдийн хувьд найзыгаа ариун цэврийн өрөөнд ороход нь тусалдаг, шүдээ угаахад нь сойз, оог нь авч өгч тусалдаг, хамтдаа тоглодог болсон. Хүүхэд явж чадахгүй учраас ширээн дээр нь тоглоомыг нь авч ирээд, хамтдаа тоглодог. Ингээд харилцаа үүсээд эхэлсэн чинь хүүхдийн хэл ярианд өөрчлөлт гарч эхэлсэн. Өөрийгөө илэрхийлдэг, "надад туслаач ээ, би хүсэхгүй байна аа, би одоо хоолоо идье, би бие засмаар байна" гэх зэргээр харилцаанд бас өөрчлөлт гарч эхэлсэн. Тэгэхээр ганц багш биш тэр ангийн хүүхдүүд хүртэл тэр хүүхдийн хөгжилд дэмжлэг үзүүлсэн байна.



Танай цэцэрлэгийн багш нар хүүхэдтэйгээ яаж ажиллах талаар арга зүйн хувьд нэмэлт боловсролыг хаанаас, яаж авч байсан бэ?

Багшийн мэргэжил дээшлүүлэх институт эсвэл Нийслэлийн боловсролын газраас бид нарт үндсэн сургалтууд ордог. Багшийн боловсролыг дэмжих дээр хүүхдүүдийг тэгш хамруулан сургах, хөгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй хэрхэн ажиллах вэ? гэдэг арга зүйн сургалтуудыг авдаг. Энэ карантин нэг ёсондоо бид нарт нэг маш том боломжийг нээж байна. Тэгэхээр энэ карантины үед бид боловсон хүчнийхээ мэдлэг, мэргэжил, боловсролыг дээшлүүлэх чиглэлээр Кимико гээд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажилладаг багшийн Хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих арга зүй гээд хоёр өдрийн сургалтад цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, бүлгийн багш нар, туслах багш нар бас хамрагдсан.

Багш нар ч гэсэн хамт ажиллаад ирэхээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг харах өнцөг нь өөрчлөгдөөд, тэрийг дагаад хүүхдүүд, эцэг эхчүүдийнх нь хандлага өөрчлөгдөөд ирэхээр тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэр бүлд ч гэсэн эерэг өөрчлөлт гарсан байх?



Манай цэцэрлэгт явж байгаа хүүхдийн ээж нь манай цэцэрлэгт туслах багшаар ажилладаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг харж байгаа эцэг эхийн хувьд хөдөлмөр эрхэлж, нийгэмтэй харилцах боломж нь саадтай, хаалттай болчихдог. Яагаад гэвэл хүүхдээ хараад, ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй байдаг. Тийм болохоор 2019 онд байгуулагдаад л хүүхдийн ээжийг туслах багшаар авч ажиллуулсан. Тэгэхээр бусад багш нартаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх энгийн практик зүйлүүдийг хэлж, яаж энэ хүүхдүүдийг бид нар ойлгох вэ, хөгжилд нь ямар ахиц гарч байна вэ? гээд ангийн багштай нь маш сайн ярилцдаг. Өнөөдөр жишээлбэл багш та ямар хичээл орсон бэ? Энэ хичээлээр дууны нэгээс хоёр үгийг дуулж байна, гараараа энэ дууны хөдөлгөөнүүдийг илэрхийлж чаддаг болж байна. Гурвалжин дүрсийг ялгадаг болж байна, хоёрхон өнгө ялгадаг байсан бол 4-5 өнгийг ялгадаг болж байна гээд хөгжлийн ахицыг нь эцэг эх өөрөө ажиглаад багшдаа хэлж байсан учир энэ хүүхдийн хөгжилд нэмэр болгохын тулд бид нар сургалтаа, арга зүйгээ яаж цаашаа үргэлжлүүлэх вэ, хүүхэдтэй яаж ажиллах вэ? гэдэг төлөвлөгөөндөө өөрчлөлт оруулаад явж байсан. Тэгэхээр эцэг эхийн хувьд багштай ярилцах, ажиглах, хүүхдийнхээ хөгжилд нь гарч байгаа тэр ахицыг багшид маш сайн мэдээлэх хэрэгтэй байдаг. Мэдээлэлтэй байх юм бол багш, туслах багш нар биш эцэг эхтэйгээ хамтраад хүүхдийг цааш нь хөгжүүлэх боломжтой байдаг. Тэгэхээр эцэг эх бол энэ хүүхдийг хөгжүүлэхэд маш чухал үүрэгтэй.

Танай цэцэрлэгт 1 ангид хэдэн хүүхэд байдаг вэ?

Нийтдээ манай цэцэрлэг 235 хүүхэдтэй, 6 бүлэгтэй цэцэрлэг байгаа. Тэгээд 1 ангид хамрагдах хүүхдийн тоо 30-35 хооронд байдаг.

Энэ 30-35 хүүхэд дунд жишээ нь 1-2 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байлаа гэж бодоход, багш нар яаж тэр олон хүүхдүүд дунд тусгайлан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд анхаарлаа хандуулж чадах вэ?

Цэцэрлэгийн багш нарын нэг маш сайхан зан чанар байдаг. Цэцэрлэгийн багш нар хүүхэд болгоноо ажигладаг. Хараа дүүрэн ангидаа энэ хүүхэд юунд дуртай байна, өнөөдөр ямар мэдрэмжтэй орж ирж байна вэ гээд маш сайн ажиглагч байдаг. Цэцэрлэгийн гэлтгүй сургуулийн багш нар ч тэр. Тэгээд хүүхэд болгоныхоо онцлогийг мэдэж, хүүхэд болгонтой ажиллах арга зүйн талаар сургуульдаа бид нар суралцсан. Тойргийн цаг эсвэл төвийн үйл ажиллагаа гээд сургалтын үйл ажиллагааны хэлбэрүүд нь өөр өөр байдаг. Эхний 5 хүүхдийн математикийн төв дээр ажиллаж байхад дараагийн 5 хүүхдийн хэл ярианы төлөв дээр төвлөрч байдаг. Бусад цагуудаа тооцоолно, мөн цэцэрлэгт өдрийн дэглэм гэж байгаа. Тэр өдрийн дэглэмийнхээ дагуу багш 15-20 минут зөвхөн тэр ганцаарчлан ажиллах хүүхэдтэйгээ ажиллаж байдаг. Бусад хүүхдүүд бол туслах багштайгаа хамт дараагийн сургалтынхаа үйл ажиллагаанд

хамрагдаж байдаг. Цагийн хуваарилалт, өдрийн дэглэмийнхээ дагуу ганцаарчлан ажиллах төлөвлөгөөнийхөө хуваарийг гаргадаг. Яаж ажиллах вэ гэдэг чинь цагийн менежмент л явагдаад ирж байгаа юм. Хүүхэдтэй ганцхан бүлгийн багш биш арга зүйч, эмч, туслах багш ажиллана.

Та бүхэн хөнгөн хэлбэрийн тархины саажилттай энэ хүүхэдтэй эхлээд ямар үе шаттайгаар ажиллаж байсан бэ? Олон цэцэрлэгүүд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг авмаар байвч яаж ажиллах, юунаасаа эхлэхээ мэдэхгүй байж магадгүй. Тэгэхээр хүүхдийг хөнгөн хэлбэрийн тархины саажилттай гэдгийг нь тогтоосноос хойш танай цэцэрлэгийн зүгээс ямар ямар арга хэмжээнүүдийг, ямар үе шаттайгаар авч хэрэгжүүлсэн бэ?

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн онцлог болгон өөр. Аутизмтай хүүхэдтэй ингэж ажиллана, дауны хам шинжтэй хүүхдийг ингэж сургана гэдэг нэгдсэн хөтөлбөр байхгүй. Дауны хам шинжтэй хүүхэд байлаа гэхэд хүнд үү, хөнгөн үү гээд онцлог, бэрхшээл болон нь өөр байдаг. Тэгэхээр манай цэцэрлэгийн хувьд тархины хөнгөн хэлбэрийн саажилттай хүүхэдтэй ажиллах төлөвлөгөө гэдэг зүйлийг гаргана. Хүүхэд болгоны онцлог, хөгжлийн бэрхшээл нь өөр учраас зөвхөн тэр хүүхдэд зориулсан төлөвлөгөөг гаргаж, арга зүйгээ боловсруулна. Тэгэхээр том булчингийнх нь хөдөлгөөнийг яаж дэмжих вэ, жижиг булчингийнх нь хөдөлгөөнийг яаж дэмжих вэ, дадал хэвшил нь одоо ямар төвшинд байна вэ, дадал хэвшилд ахиц гаргахын тулд яаж ажиллах вэ, сэтгэл зүй, нийгэмшихүй, харилцаа, хэл ярианы ямар хичээлийг түлхүү оруулж өгөх вэ? Танин мэдэхүйн талаас нь магадгүй хүүхдийн сонирхлын дагуу гадаа тоглоомын талбайд байгаль, нийгмийн орчны хичээлийг орох уу, ангид орох уу. Хаанаас нь хүүхэд танин мэдэх гээд байна тэр сонирхлынх нь дагуу төлөвлөгөөг нь боловсруулна. Түүнээс яг тархины саажилттай хүүхэдтэй ингэж ажиллана гэсэн нэгдсэн арга зүй байхгүй учраас хүүхэд болгонд тохирсон арга зүйгээр сургаж хүмүүжүүлбэл хүүхдийн хөгжилд ахиц гарах юм.

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж чаддаггүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд олон байдаг гэж та боддог уу? Энэ хүүхдүүд яагаад цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа вэ, шалтгаан нь юу байдаг вэ?

Би Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхдүүдийн Эцэг Эхийн Холбоо гээд байгууллагын ярилцлагад сууж байхад эцэг эхчүүд хүүхдүүдээ ихэвчлэн энгийн хүүхдүүдтэй цуг тэгш хамруулан сургах хүсэл сонирхолтой байдаг нь анзаарагдсан. Гэтэл хүүхдүүдийн бэрхшээл болгон өөр болохоор хэчнээн хүнд хүүхдүүдийг хамт сургах хүсэл сонирхолтой байсан ч бэрхшээл нь хүнд байдаг үзэгдлийн талаар ярьж байсан. Нөгөө талаасаа “тусгай сургууль, цэцэрлэгт өгөхөөсөө илүүтэйгээр энгийн цэцэрлэг сургуульд бид нар хүүхдээ өгөх хүсэлтэй байна” гээд эцэг эхүүд ярьж байсан. Бас ерөнхий

боловсролын сургууль, цэцэрлэгт тулгардаг бэрхшээлүүд байна. Ээж аавууд 7, 8 сард амарч зугаалаад явж байгаад яг сургууль, цэцэрлэг эхлэхийн өмнө магадгүй 8 сарын 30-нд би хүүхдээ цэцэрлэгт оруулъя аа, сургуульд оруулъя гээд гүйгээд ирдэг. Манай хүүхэд ийм хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, яг одоо өргөдлөө бичээд өгөх юм бол би хүүхдээ өгөх бүрэн эрхтэй гээд ямар ч гэр бүлийн төлөвлөлтгүйгээр шууд хүрээд ирдэг. Гэтэл нөгөө сургууль, цэцэрлэгийн хувьд бэлтгэл ажил гэдэг зүйл хангах ёстой, хүндрэл бэрхшээлтэй асуудлууд байгаа. Бид нар боловсон хүчнээ бэлтгэх хэрэгтэй, энэ хүүхэдтэй яаж ажиллах вэ гээд хүүхдийн бэрхшээлийн талаар бүрэн ойлголттой болсон байх хэрэгтэй, багш нараараа зөвлөлдөх хэрэгтэй, цаашид суралцах хэрэгтэй байдаг. Мөн дээр нь бид нар орчноо бүрдүүлэх ёстой. Тэргэнцэртэй хүүхэд ороод ирлээ гэхэд бид нарт налуу шат, шатандаа бариул хийх хэрэгтэй зүйлүүд байдаг.

Гэтэл эцэг эх маань ойлгохгүй шууд хүүхдээ дагуулж ирээд бид нар өргөдлийнхөө дагуу хүүхдээ өгөх ёстой гэдэг асуудал тулгардаг. Тэгэхээр эцэг эхчүүдэд би юу гэж зөвлөх вэ гэвэл танай хүүхэд 4 настай байлаа гэж бодъё. Гэр бүлийнхээ төлөвлөлтийг хийгээд, харааны бэрхшээл, сул хараатай, аль эсвэл хэл ярианы бэрхшээлтэй хүүхэд байвал тухайн хамран сургах тойргийнхоо цэцэрлэг, сургууль дээр хавар ирж хүүхдийнхээ талаар мэдээлэл өгөөд, манай хүүхэд бол хамран сургах тойргоороо танай цэцэрлэг, сургуульд хамрагдах юм. Бид нар хороондоо мэдээлэл өгсөн, энд хөгжлийн бэрхшээлтэй, сургуулийн өмнөх боловсролд хамрагдах ёстой 4 настай хүүхэд байгаа. Бид хүүхдээ энгийн цэцэрлэг, сургуульд өгөх хүсэлтэй байна. Танай цэцэрлэг, сургууль бэлэн үү? Манай хүүхэд бол хэл ярианы бэрхшээлтэй, аутизмын хөнгөн хэлбэр эсвэл Дауны хам шинжтэй хүүхэд байгаа гээд эхлээд 5-6 сарын өмнө урьдчилж цэцэрлэг, сургуульдаа мэдээлэх юм бол цэцэрлэг, сургуульд бид нар багаараа ажиллах ёстой байгаа. Нэгдүгээрт сургалтын орчноо сайжруулан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг дэмжих орчноо бүрдүүлж эхэлнэ. Дараа нь бид нар сургалтын арга зүйгээ боловсруулж, багш боловсон хүчнээ бэлтгэнэ. Ингэснээрээ хүүхдийг хөгжүүлэх сургалтын үйл ажиллагаа эхэлдэг. Гэтэл 8 сарын 30-нд эцэг эхчүүд хүсэлтээ гаргаад, бид нар хүүхдээ цэцэрлэгтээ хүлээж авлаа гэхэд хөгжлийг нь дэмжих ажил хойшлоод байдаг. Эхлээд хүүхдээ таних гэсээр байтал 1-2 сар болдог. Шууд орчиндоо өнөөдөр налуу шат хийгээд маргааш нь бариул хийхгүй шүү дээ. Бас хүүхдээ элссэнээс нь хойш 3, 4 сар ойлголцох, нийгэмшүүлэх хугацаа байна, сэтгэл зүйг нь бас бид нар бэлдэх хэрэгтэй байна. Дараа дараагийн хүүхдийнхээ хөгжлийг дэмжих мэргэжлийн, эрүүл мэндийн болон бусад боловсролын байгууллагуудтай холбогдох хугацаа маань хойшлоод байгаа юм. Тийм учраас аль болох эцэг эх, асран хамгаалагчдад хавар гэр бүлийнхээ төлөвлөлтийг хийгээрэй, хороотойгоо хамтарч ажиллаарай магадгүй та хүүхдээ цэцэрлэг, сургуульд өгөхөөр бол хамран

сургах тойргийнхоо сургууль, цэцэрлэгт заавал урьдчилж мэдээлээрэй гэдэг зүйлийг хэлмээр байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд цэцэрлэгт орсноор тухайн хүүхдийн ирээдүйд нь ямар нөлөө үзүүлэх вэ? Ямар давуу талууд байдаг гэж та боддог вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаар би ингэж боддог. Яг өөрийнхөө нүдээр харахад 10, 20, 30 жилийн дараа бид цэцэрлэг, сургуульд байхад нь хүүхдийн хөгжилд бага зэргийн дэмжлэг үзүүлснээрээ хөгжлийн бэрхшээлтэй маш амжилттай яваа хүмүүс бий болгож чадна гэж боддог. Аутизмтай охин Гүчи гээд дэлхийн хэмжээний брэндийн нүүр царай болж байна. Дауны хам шинжтэй 130 дугаар сургуулийн хүүхэд бас Трио гээд богино хэмжээний кинонд тоглосон. Дээр нь харааны бэрхшээлтэй хүмүүсийн төлөөлөл болоод халуун хэмжигч хийж байна. Магадгүй багш бид нарын гарт, боловсролын байгууллагуудад хэн нэгний амьдралыг өөрчлөх маш том тийм боломж байгаа. Тэр хүүхдүүдийг жоохон дэмжээд, хөгжилд нь нэмэр болох юм бол бид нар магадгүй 10, 20, 30 жилийн дараа







Монгол улсдаа 1 үнэт капитал иргэнийг бэлдэж байгааг үгүйсгэх аргагүй. Тийм учраас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн онцлогийг нь танин мэдэж, ойлгож, хүлээн зөвшөөрч, нийгмийн харилцаанд нь дэмжлэг үзүүлснээрээ тэр хүүхдүүдийн хөгжилд, цаашлаад магадгүй 10, 20 жилийн дараах маш ирээдүйтэй инженер, моделийг бэлдэж байгаа гэж би боддог.

Монголын нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тусгай цэцэрлэг, сургуульд тусгаарлаж боловсрол олгодог байсан. Сүүлийн үед хандлага өөрчлөгдөж боловсролд тэгш хамруулах гэдэг зүйлийн талаар ярьж эхэлж байна. Та боловсролын байгууллагын хүний хувьд энэ тэгш хамруулах боловсролын талаар ямар бодолтой байдаг вэ?

Дэлхий нийтийн чиг хандлага өөрчлөгдөж байна. Үүнийг дагаад хүмүүсийн бодол санаа өөрчлөгдөж эхэлж байна. Тусгай сургууль, цэцэрлэгтэй хоёр гуравхан улс байдгийн нэг нь манай Монгол улс. Одоо хүмүүсийн дуу хоолой арай өөрөөр гарч, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүд ч гэсэн дуу хоолойгоо өргөж байна. Манай боловсролын байгууллагын хүмүүс ч гэсэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсрол гэдэг зүйл дээр маш их анхаарч эхэлж байна. Тийм болохоор зөвхөн тусгай цэцэрлэг, сургуульд хүүхдүүдийг сургах биш энгийн хүүхдүүдтэй цуг тэгш хамруулан хөгжүүлснээр тэр хүүхдүүдийн хувьд нийгэмшихүй, бие бялдар, сэтгэхүйн талаасаа хөгжилд нь ахиц гарах боломжтойг хүмүүс одоо арай өөрөөр харж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээс гадна ангийнх нь хүүхдүүд, эргэн тойрных нь хүмүүсийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх ойлголт, хандлагыг өөрчилж байгаа байх гэж бодож байна.

Тархины саажилт, Дауны хам шинжтэй хүүхэд бол тархины жоохон эмгэгтэй л болохоос энэ чинь халдварт өвчин биш. Хүний эрх гэдэг талаасаа тэр хүүхдийн эрх гэдэг зүйл байгаа. Тэгэхээр хүн болгон эрхийнхээ дагуу өөрийнхөө хөгжилд ахиц гарахын тулд боловсролын үйлчилгээг эрх тэгш авч, амьдарч байгаа орчин нь ч гэсэн хөгжлийн бэрхшээлтэй, бэрхшээлгүй иргэдэд ээлтэй, тэгш хүртээмжтэй орчин хэрэгтэй байна.

Таны зүгээс Монголын нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг харах хандлага ямар санагддаг вэ?

Урьд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, хүмүүсийн талаарх ойлголт арай өөр байсан. Тэднийг ойлгох, боловсролын үйлчилгээнд тэгш хамруулах зүйлүүд дутмаг байсан. Орчин үед залуус маань маш их мэдлэг боловсролтой болж, сэтгэлгээний хувьд ч гэсэн хөгжиж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд маань өөрсдөө ч гэсэн дуу хоолойгоо нээлттэйгээр илэрхийлдэг боллоо. Нэг ёсондоо энэ интернет, сошиал орчинд хүмүүст өөрсдийгөө ойлгуулах, таниулах, мэдүүлэх зүйлийг маш нээлттэйгээр ярьж байгаа учраас энэ талаараа хүмүүсийн ойлголт арай өөр болчихлоо гэж би харж байгаа.

Та анх яагаад энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хүлээн авч, арга зүй боловсруулж, ажиллахад хувь нэмрээ оруулах болсон бэ?

Би өмнө нь багш байхдаа аутизм, харааны бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байсан боловч тархины саажилт гэж оноштой хүүхэдтэй ажиллаж үзээгүй, тийм туршлага байгаагүй. Тэгээд би яаж энэ хүүхдийг би хөгжүүлэх ёстой вэ? Гэж бодсон. Хүн өөрийн эрхийнхээ хүрээнд "цэцэрлэгт явмаар байна аа" гэж хүсэлт гаргаж байна. Тэгэхээр надад хууль эрх зүйн талаасаа ч тэр, дүрэм журмаа дагасан ч гэсэн авахгүй байх шалтгаан байхгүй. Би өөрийгөө хүүхдийн ээжийн хувьд, хүүхдийн оронд тавьж үзсэн. Магадгүй би ийм хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ээж байлаа гэхэд ажил хиймээр байсан ч ажил хийх боломжгүй, хүүхдээ сургаж хүмүүжүүлмээр байдаг, гэтэл боловсролын байгууллагуудаас 2 ч удаа татгалзсан хариу сонсчихсон байдаг. Магадгүй хамгийн их итгэл тавиад, сүүлийн удаа ирсэн цэцэрлэг нь манайх байхыг ч гэсэн би үгүйсгэхгүй. Тийм учраас "би хүүхдээ танай цэцэрлэгт өгмөөр байна аа" гээд аймаар итгэлтэй харцтай орж ирэхэд хүүхдийг аваад, сургаад хөгжүүлье гэхэд бид нарт боломжгүй зүйл байхгүй. Бид нар боловсролын сургуульд нь онол, практикийг нь сурсан. Бас хүүхдээ тэврээд " би хүүхдээ цэцэрлэгт өгч, ажил хиймээр байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ харж байхад надад хөдөлмөр эрхлэх боломж байгаагүй. Хүүхдүүдээ өсгөж хүмүүжүүлмээр байна, хүүхдээ би яг хөгжлийн бэрхшээлтэй хэвээр нь гэртээ байлгамааргүй байна аа" гээд ороод ирэхэд ээжид нь би яаж туслах вэ? гэж бодсон. Ээжийн хувьд маш идэвх зүтгэлтэй хүн байсан. Цэцэрлэгийн туслах багшийн сургалтад суугаад үнэмлэхтэй болсон. Хүүхдийн хувьд цэцэрлэгт хамрагдах нас нь болчихсон байсан. Тэгээд ээжийн нийгмийн асуудлыг нь шийдээд, багшаар ажилд аваад дараа нь хүүхдийг цэцэрлэгтээ авсан. Би өдөр болгон ангид нь ороод хүүхдийг харахад ангийн нөгөө буланд хүүхдүүд тоглож байхад дандаа л сандал дээр ганцаараа сууж байдаг байсан. Тэр хүүхэд очиж тогломоор л байгаа шүү дээ. Найзуудтайгаа хамт сандал дээр суугаад, баярлаад, тэврэлдээд хүүхэлдэйн кино үзэж байгаа хүүхдүүдийг хараад хэрвээ би энэ хүүхдийн оронд байсан бол надад ямар мэдрэмж төрөх вэ? Ямар байх бол оо? Би гүймээр, хараймаар, үсэрмээр, тогломоор байдаг гэтэл явж чадахгүй гэж бодсон. Тэгээд яаж энэ хүүхдэд туслах вэ гэж бодоод, багш нартайгаа ярилцаад эрхлэгч болоод авсан анхны цалингаараа хүүхдэд машины хэлбэртэй алхуулагч авч өгсөн. Эхлээд багш нь дэмжээд урагшаа 1 алхаарай, 2 алхаарай, 3 алхаарай гээд хүүхэдтэй ажиллаж байсан. Дараа нь хүүхэд биеэ даагаад нэг хоёр, нэг хоёр гишгэдэг болсон байсан. Долоо хоногтоо 1 удаа хүүхэд дээр орж ирэхэд хөгжилд нь маш их ахиц гарч байсан. Өөр хүний нүдээр харахад энгийн хүүхдүүдийг бодвол жижиг ахиц байх л даа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ойрын зайд 1-2 хоёр алхахад хүртэл бид нар

баярладаг. Хүүхдэд гарч байгаа ахиц гэж хардаг юм. Тэгээд нэг өглөө ажилдаа ирж байхад хүүхэд маань гараа даллачихсан цонхон дээр зогсож байсан. Сэргээн засах эмчилгээнд яваад, жилийн дараа хүүхэд маань цонхон дээр гараа даллаад зогсож байхыг хараад би амьдралдаа аймаар баярлаж байсан. Байнгын суудаг, мөлхдөгөөр харж байсан хүүхэд ингээд цонхон дээр очоод цэцэрлэгийн орчноо харж байна. Энэ хүүхдийг цэцэрлэгт аваад багш нар болон бусад байгууллагуудтай хамтарч ажилласнаараа энэ хүүхдийн хөгжилд маш том ахиц гарч байна гэж бодсон. Хүүхдийг хөгжилд ахиц гарч байгааг харах бол миний амьдралдаа үзэж байсан хамгийн аз жаргалтай мөчүүдийн нэг байсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүд юмыг маш хүндээр хүлээж авдаг, эмзэг байдаг.

Дөнгөж цэцэрлэгт ороод ирэхэд нь бусад эцэг эхчүүд "яагаад манай хүүхдүүд ийм хүүхэдтэй хамт суралцах ёстой юм" гээд их өөр хандлагаар харж байсан. Гэтэл ээж маань бусад эцэг эхчүүдэд харуулахгүйн тулд өглөө хамгийн түрүүнд хүүхдээ үүрээд цэцэрлэгтээ ирдэг мөн бүх хүүхдүүд явсны дараа хамгийн сүүлд хүүхдээ үүрээд гараад явдаг байсан. Яагаад гэвэл миний хүүхдийг "нэг ээж аав ч гэсэн буруугаар ойлгож муухайгаар хэлэх вий, тэр үгийг нь миний



хүүхэд сонсчих вий" гээд ээж хүний хувьд айх, эмээх сэтгэл байна. Тэгэхээр бусад аав ээжүүд маань тэр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хүндэлдэг байх хэрэгтэй. Тэр эцэг эхийн оронд өөрийгөө тавьж үзэж, тэр хүүхдүүдийг маш сайн ойлгодог байх хэрэгтэй. Манай цэцэрлэгийн нэг хүүхдийн аав "Ийм том болчихсон байж яагаад ээждээ үүрүүлээд яваад байгаа юм бэ?" гээд тоншоод авсан байгаа юм. Эрх болоод ээждээ үүрүүлээд явна гэж тэр аав харж байна. Гэтэл хүүхэд маань өөрөө явж, алхаж гишгэж чадахгүй. Тийм учраас ээж нь өглөө болгон хүүхдээ үүрч ирдэг, орой болгон үүрч харьдаг. Хотын төвд ч гэсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан эрүүл, аюулгүй орчин хомс байхад хотын захад мэдээж ямар байх вэ. Тэгэхээр гудамж шороотой, чулуутай, явган хүнд явах зам байгаа боловч хөгжлийн бэрхшээлтэй иргэд зорчих зам байдаггүй. Тийм учраас хүүхдийг ээж нь өглөө оройдоо байнга үүрээд явж байгааг хүмүүс ойлгохгүй хандлага байдаг. Тийм болохоор ерөөсөө л ойлгоё, хүндлэе гэдэг чинь өөрөө маш зөв хандлага. Тэр хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүндэлдэг, ойлгодог ээлтэй орчныг бид нар бий болгох хэрэгтэй байгаа юм. Нийгмээрээ тэр хүмүүсийг хүлээн зөвшөөрдөг нийгэм байгаасай л гэж би хүсдэг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эцэг эхийн асаргаа, халамж маш их шаардлагатай байдаг. Монголд эцэг эх хоёулаа хүүхдээ харах нь 1 хүн харахаас дээр байх гэж боддог. Гэтэл Монголд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ганц бие эцэг эхчүүд их байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэдгээ мэдээд хүлээн зөвшөөрч чадаагүйгээсээ болоод гэр бүлээ орхих зүйл танд ажиглагдсан болов уу?

Миний яг эргэн тойронд байгаа кэйсүүд байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг багш нарын яриа сонсоход ч тэр, ХБХСЗХТ дээр ирж байгаа хүүхдүүдийг ажиглаж байхад ч тэр, манай энэ кэйс дээр дөнгөж хүүхдээ хөгжлийн бэрхшээлтэй гэдгийг мэдээд сэтгэл зүйн хувьд хүнд цохилтод ороод гэр бүл салж, хүүхдээ орхиж явах үзэгдэл гардаг. Үүнээс улбаатайгаар ганц бие, өрх толгойлсон ээжүүд нийгэмд их байдаг. Миний зүгээс харахад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхэд магадгүй юу дутагдаад байна вэ гэвэл сэтгэл зүйн зөвлөгөөнүүд хэрэгтэй байна. Эцэг эхчүүдэд маш зөв ойлголт, сэтгэл зүйн зөвлөгөө өгдөг төвүүд хэрэгтэй байна. "Энэ хүүхэд суралцаад, хөгжөөд энгийн амьдралын хэмнэлээр амьдарч болно" гэдгийг тайлбарлаж таниулдаг байх хэрэгтэй. Би дөнгөж багш болоход надад нэг асуудал тулгарсан. Манай 4 настай ангид хүүхдээ өгсөн залуухан ээж аав байсан. Би хичээл ороод самбар дээр дугуй алимыг зурж үзүүлээд алим бол ногоон, улаан, шар өнгөтэй байж болно гээд зуруулаад явж байхад 1 хүүхэд маань бусад хүүхдүүдээс маш өөр зурдаг байсан. Зурахдаа дугуй дүрсийг өөр хэлбэртэй болгож зураад эсвэл улаан, шар өнгөөр биш хараар будаад байсан. Тэгээд би нэг

биш нэлээн олон хоног бусад хичээл дээр нь ч гэсэн ажиглахад тэр хүүхэд харааны хувьд ямар нэгэн бэрхшээлтэй байсан. Тэр хүүхдийн ээж маш үзэсгэлэнтэй, биеэ гоё авч явдаг, маш боловсролтой гоё эмэгтэй байсан. Тэгээд би ээжид нь "манай энэ хүүхэд бусад хүүхдүүдээс өөр байна. Би 2-3 удаа ажиглалаа. Та зурсан зургуудыг нь хар даа, хийсэн хичээлүүдийг нь та ажиглаарай өөр байгаад байна" гээд хэлсэн юм. Гэтэл эхний удаад ээж сонсоод өнгөрсөн, хоёр дахь удаад муухай хараад, дургүйцсэн. Дараа нь аав нь ирээд "чи яагаад миний хүүхдийг онцлоод, ад үзээд байгаа юм. Яагаад миний хүүхдийг ерөөсөө болохгүй байна гээд байгаа юм. Би хүүхдээ өөр ангид өгнө. Эсвэл эрхлэгч дээр чинь орж хэлнэ. Миний хүүхдийг онцлоод байгаа чинь надад таалагдахгүй байна" гээд бухимдсан. Би бас цэцэрлэгийнхээ эмчид "манай хүүхэд арай өөр байгаад байна эсвэл би буруу хараад байна, та нэг эмч хүний хувьд ажиглаад өгөөч ээ" гээд эмчээсээ тусламж гуйхад эмч хүртэл "Арай өөр байна. Та ээж аавтай нь ярилцах хэрэгтэй" гэж зөвлөж байсан. Тэгээд хамгийн сүүлийн удаа би ээжээс нь "та ээж хүн, танай хүүхэд өөр байгаад байна. Би бүр болохгүй гэвэл та мэргэжлийн хүнээс зөвлөгөө аваад, мэргэжлийн хүнд үзүүлээд өгөөч ээ. Та хүүхдээ үзүүлэх шаардлагатай байна" гээд гуйсан.

Тэгээд мэргэжлийн хүнээс зөвлөгөө авахад хүүхэд харааны бэрхшээлтэй болж таарсан. Дүрс буруу зурж, өнгө сайн ялгахгүй байсан. Тэр гоё боловсролтой, мундаг ээж аавууд аймаар харамсалтай нь тэр хүүхдийг 4 нас хүртэл нь ингээд явуулчихсан байсан. Би энд юу хэлэх гээд байна гэвэл хэрвээ эцэг эх танд цэцэрлэг, сургуулийн багш "таны хүүхэд арай өөр байна, та мэргэжлийн эмчид үзүүлээч ээ" гэдэг ийм зөвлөгөө өгвөл маш эрт хүүхдээ оношлуулах хэрэгтэй. Тэр зөвлөгөөг дагаж мэргэжлийн эмчид үзүүлэх хэрэгтэй байна. Харааны бэрхшээлтэй хүүхдийг 5 настайд нь мэдэхгүй 6 настайд нь сургуульд оруулаад самбараас хол суулгачихвал багшийн самбар дээр бичсэн юмыг тэр хүүхэд харахгүй. Ийм асуудлууд үүсэх учраас ээж аавууд маань үүн дээр анхаарлаа хандуулах хэрэгтэй. Багш нар бол маш сайн ажиглагч байдаг учраас багшийн зөвлөгөөг зарим үед сонсож байгаасай гэж хүсдэг. Тэр хүүхдийг 4 насанд нь бид нар мэдсэнээрээ харааны энгийн шил зүүдэг болсон. Дараа нь хүүхэд цэцэрлэгээ төгсөхөд аав ээж нь багш аа баярлалаа хэлсэн л дээ. Баярлалаа гэдэг үг надад тийм тааламжтай үг биш. Магадгүй тэр ээж аавын хувьд 1 нас, 2 настайд нь мэддэггүй юм гэхэд 3 настайд нь хэрвээ эрт мэдсэн бол магадгүй тэр хүүхдийн хараа нэг жилээр ч гэсэн арай өөр харах байсан болов уу гэж харамсдаг. Бас аутизмтай хүүхэд цэцэрлэгт орж ирэх хүртэл тэр хүүхдүүдийг гэртээ байхад нь аав ээжүүд нь мэддэггүй. Тэд нар нийгмийн харилцаанд цэцэрлэгт ороод ирэхээр багш хүүхдийг ажиллаад мэдэж байгаа юм. Хүүхэд хөнгөн хэлбэрийн аутизмтай байна гээд оношлоод эцэг эхэд хэлэхэд хүлээн

зөвшөөрдөггүй. “Ерөөсөө үгүй, миний хүү тийм биш, миний хүүхэд энгийн” гээд байдаг бас нэг үзэгдэл байдаг. Нэг жил, хоёр жил бүр хүүхдээ эмчлүүлэхгүй яваад байгаа харамсалтай зүйл байна. Тэгэхээр эцэг эхчүүд ийм 2 талтай байдаг. Нэг хэсэг нь хүүхдээ маш их анхаардаг, нөгөө хэсэг нь хүүхдэд нь ямар нэгэн бэрхшээлтэй байна гээд зөвлөхөд тэрийг үгүйсгээд, хүлээн зөвшөөрч чаддаггүй. Тэгээд хүүхэд хохироогоод байгаа ийм асуудал байгаа юм. Хэрвээ таны хүүхэд цэцэрлэг, сургуульд явдаг бол магадгүй багш танд “хараг нь мэргэжлийн эмчид үзүүлээрэй” ч гээд хэлэх юм бол тэр зөвлөгөөг маш сайн дагаарай л гэж хэлмээр байна.

Тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч хамгаалъя гэвэл 1 хүн заавал хажууд нь байх шаардлагатай байдаг. Гэтэл нөгөө хүн маань бас ажил хөдөлмөр хийгээд, мөнгө төгрөг олоод гэр бүлийнхээ санхүүгийн байдлыг сайжруулмаар байдаг. Ер нь маш их асуудлууд эндээс үүдэж гарч ирж байгаа харагдаж байна л даа?

Манай цэцэрлэгийн багшийн кэйс дээр бол хүүхдээ дөнгөж 2 хүрэхэд хөгжлийн бэрхшээлтэй гэдгийг нь мэдээд л орхиод явсан. Тэгээд ээж маань өөрөө 2 хүүхэдтэй байдаг. Ажил хийе гэхээр ажил хийх нөхцөл нь хэцүү. Яагаад гэвэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ харна, хооллоно, ундална. Нөгөө хүүхдийнхээ хажууд байхгүй бол болохгүй учраас ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй. Тэгэхээр бусад байгууллагуудыг ч гэсэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг маш сайн дэмждэг байгаасай гэж хүсдэг. Энэ эцэг эхчүүд хөдөлмөр эрхлэх юм бол хүүхдийнхээ эм тариаг авах зардлаас эхлээд, амьдралын орчин ч гэсэн сайжирна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэйгээ байдаг эцэг эхчүүд сэтгэл зүйн хувьд ч гэсэн ийм хүнд асуудлуудтай байдаг. Яагаад эмзэг байна вэ гэвэл тэр хүмүүс нийгмийн харилцаанд орохгүй, байнга хүүхдээ хараад, асраад байж байдаг. Тэгэхээр ихэнх нь сэтгэл зүйн талаасаа стресс, бухимдалтай болдог. Хэрвээ ажил хийгээд явах юм бол хамт олонтой болж, сэтгэл зүйн тааламжгүй байдал үүслээ гэхэд хамт ярилцаад тайвширна. Нийгмийн харилцаанд ороод ирэхээр тэр хүүхдүүдийн ээж аавуудад сэтгэл зүйн талаасаа ч гэсэн эерэг өөрчлөлтүүд гарах боломжтой байдаг. Санхүүгийн хувьд ч гэсэн хөдөлмөр эрхэлж байгаа учраас амьдралд нь өөрчлөлт гарч эхэлнэ.

Таны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах ирээдүйн төлөвлөгөө ямар байгаа вэ? Танай цэцэрлэг цаашид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг авах уу? Тэр талаар та ярьж өгөхгүй юу?

Одоо бол бид нар нэг хүүхэдтэй ажилласан туршлагаа ярьж байгаа боловч манай хороонд 25 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байдаг. Бид энэ хүүхдүүд дундаас цэцэрлэгийн насны хэдэн хүүхэд байна гэсэн статистик дээр ажиллаад зөвхөн

263 дугаар цэцэрлэгийн нэг хүүхэд биш, Сонгинохайрхан дүүргийн 36 дугаар хорооны үлдсэн 3-4 хүүхдийн хөгжилд дэмжлэг үзүүлэх боломжтой. Тэгэхээр энэ хүүхдүүдийн онцлогийг нь мэдээд, ойлгоод дараа нь харааны бэрхшээлтэй, хэл ярианы бэрхшээлтэй хүүхэд манай цэцэрлэгт элсвэл яах вэ гээд багшлах боловсон хүчнээ сайжруулах хэрэгцээ шаардлага үүсэж байна. Манай багш нар дохионы хэлний 35 үсгийг өөрсдөө бие даан суралцаж байна. Дохионы энгийн "би бие засмаар байна, би хүсэхгүй байна" гэх зэрэг хэлнүүдийг сайн дурааараа багш нар маань суралцаж байгаа сайшаалтай зүйл байна. Дээр нь бид нар орчиндоо бас өөрчлөлтүүдийг хийж эхэлсэн. Цэцэрлэгийнхээ гадаад талбайд ээж аавууд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэйгээ ирээд машинаа тавих зогсоолыг гаргаж, цэцэрлэгийн орох хэсгийн налуу шатандаа тусламжийн хонхыг байрлуулж, хүүхэд хуурайлах тусгай хэсгийг бий болгож, шатан дээрээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг явахад дэмжлэг үзүүлэх шатны бариулууд бий болгосон. Бас бид нар ментор багштай хамтарч ажиллаж байгаа. Цаашлаад бэрхшээл болгоны онцлогт тохирсон хэлбэрээр сургалтын хэрэглэгдэхүүндээ өөрчлөлт хэрхэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн суралцах анги танхимыг сайжруулах тал дээр өөрчлөлт хийж байна. Нийт хамран сургах тойргийн маань ямар ч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүд манай цэцэрлэгт хандаад, хүүхдээ сургах хүсэлт гаргахад манай үүд хаалга нээлттэй байгаа. Эцэг эх, асран хамгаалагчиддаа зөвлөхөд ердийн хүүхэд ч бай, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ч бай хүүхдийнхээ бүх талын хөгжлийг нь ажиглаад, багштайгаа хамтарч ажилласнаараа хүүхдийнхээ хөгжилд та дэмжлэг үзүүлж байгаа учраас багштайгаа маш сайн хамтарч ажиллаарай гэж зөвлөмөөр байна.

Эрт, зөв оношилгоо хийгдээгүй тохиолдолд цаашид үүсэх үр дагаврууд нь юу юу байж болох вэ?

Манай ангийн энэ хүүхдийг ээж нь 1 ой 6 сартайгаас нь эхлээд миний хүүхэд арай өөр байна, алхаж гишгэж чадахгүй байна гээд мэдэрч эхэлсэн байдаг. Тэгээд Эх нялхас, Өрхийн эмнэлэг, Гэмтэл, Шар хадны эмнэлэг гээд бүх эмнэлгүүдэд үзүүлсэн. "Хөдөлгөөний хоцрогдолтой хүүхэд байна, магадгүй танай удамд ийм хүн байсан байж болох юм, эсвэл 2 нас гараад хүүхэд чинь явж чаддаг болно, эсвэл түнхний мултралтай байна" гээд онош нь эхлээд буруу гарчихсан. Хамгийн сүүлдээ гэмтлийн эмнэлэг, Шар хадны эмнэлэг "та хүүхдээ тархины цахилгаан бичлэг хийлгэ, тархины томографид харуул" гээд үзүүлсэн боловч онош нь буруу



тогтоогдоод явсан болохоор нэгдүгээрт хамгийн их хохиролтой зүйл нь цэцэрлэгт орж, зөв оносш гарах хүртэл ээж нь нийгмийн халамж, үйлчилгээнд хамрагдаж чадаагүй. Дээр нь хүүхдийн онош нь буруу гарчихсан учраас эмчилгээ буруу хийгдэнэ. Хүүхэд уналт таталт өгөхөд ээж эм уулгаагүй. Эмнэлэг дээр очихоор хөдөлгөөний хоцрогдол, тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхэд гээд оношлоод явуулаад байдаг. Уналт, таталт өгөх болгонд тархины эд эс үхэж байдаг юм.

Ер нь бол ийм асуудалтай байж байгаад цэцэрлэгт хамрагдаад, АШУҮИС-ийн эмчтэй холбогдоод бид нар хамтарч ажилласнаараа энэ хүүхдэд нэгдүгээрт “тархины хөнгөн хэлбэрээр саажилттай хүүхэд” гээд оношийг нь зөв тогтоосон. Хоёрдугаарт ээж маань өөрөө нийгмийн халамж, үйлчилгээнд хамрагдаж эхэлсэн. Дээр нь хүүхдийн зөв онош нь тогтоогдоод, эмчилгээ нь зөв явагдсан учраас энэ хүүхдийн хөгжилд ахиц гарсан байх гэж харж байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд маань зөвхөн



алхагчийн тусламжтайгаар явж байгаа. Нас ахих тусам өөрийнх нь өндөр, биед нь тохирсон алхагчийг авна. Алхахад нь дэмжлэг үзүүлэх гутал авлаа гэхэд хамгийн хямдхан нь 140,000 төгрөгийн үнэтэй. Томрох тусмаа нөгөө тавхай томорч байгаа учраас гутал, шагайн бэхэлгээг нь шинээр авах хэрэгтэй болно. Тэгэхээр тэр болгоныг ээж өөрөөсөө гаргах биш халамж үйлчилгээнээсээ эм, хүүхдийнхээ гутал, хувцас, хэрэглэлүүдийг нь бэлдэж байгаа учраас хүүхдэд маань алхаж гишгэх өөрчлөлтүүд гарч байгаа юм. Тэгэхээр хамгийн эхлээд хүүхдийг эрт бөгөөд зөв оношлох. "Намайг дэмждэг хүн байсан учраас би ийм том амжилтад хүрсэн юм аа" гэж Путины хэлсэн үг байдаг. Түүн шиг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг жоохон дэмжчих юм бол миний хэлж байгаа шиг магадгүй 10, 20, 30 жилийн дараах Монгол Улсын үнэт капитал иргэдийг бид нар бэлдэж байгаа гэдэгт би ерөөсөө эргэлздэггүй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэхээр нийгмээс тусгаарлагддаг, хөдөлмөр эрхлэх чадваргүй биш шүү дээ. Тэр Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яаманд хүртэл Болороо гээд эмэгтэй байна. Ямар ухаалаг, өндөр мэдлэгтэй, мундаг байна. Тэр хүн өнөөдөр нийгэмд гарч ирснээрээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг харж байгаа өнцөг, хандлага өөрчлөгдөж байгаа гэж би хардаг. Тэгээд бас их гоё сэдвээр ярилцлаа, Сайнаа. Маш их баярлалаа. Би өөрөө хувь хүнийхээ үүднээс нийгмийн сайн сайхны төлөө үйлсийг маш их дэмждэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэхээс гадна хүчирхийллээс өөрийгөө хамгаалах ийм аргуудын талаар олон улсын байгууллагатай хамтраад сургалт явуулж байгаа. Тэгээд нэг арга зүйг боловсруулж байгаа. Энэ арга зүйгээ тусгай хэрэгцээт боловсролын сургууль, цэцэрлэг бүр цаашлаад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүд, хүүхдүүдэд ч гэсэн түгээн дэлгэрүүлье гэсэн хүсэлтэй байгаа.

Би ч гэсэн тантай ярилцсанаараа маш олон зүйлүүдийг мэдэж авлаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэлтгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүдэд сэтгэл зүйн зөвлөгөө гэдэг зүйл ямар чухал вэ, эрт оношилгоо хүүхдийн цаашдын хөгжилд ямар чухал вэ, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүдийн хөдөлмөр эрхлэлт гэдэг асуудлууд бас маш гоё хөндөгдөж гарч ирлээ. Маш гоё яриа боллоо гэж би хувьдаа дүгнэж байна. Ковид цар тахал танай байгууллагын үйл ажиллагаа болон танай цэцэрлэгт явдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хэрхэн нөлөөлж байгаа вэ?

Монгол улс даяар онлайнаар, танхимын бус хэлбэрээр зайнаас ажиллах хэрэгцээ шаардлага үүсэж байна. Боловсролын үйлчилгээ тасралтгүй үргэлжилж байх ёстой байдаг. Тэгэхээр цэцэрлэгийн хувьд бол ковидын нөхцөл байдалд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийнхээ эцэг эхтэйгээ утсаар болон онлайнаар холбогдож байгаа. Бас хүүхдэдээ зориулсан цэцэрлэгийнхээ хүүхдүүдийн нас болгонд тохирсон

дасгал ажлын дэвтрийг боловсруулсан. Тэгээд энэ хүүхэдтэйгээ ажиллах дасгал ажлын дэвтрийг боловсруулаад, эцэг эхэд хүлээлгэж өгөөд, хүүхдээрээ дасгал ажлын дэвтрээ ажиллуулаад, эцэг эхээр тэмдэглэл хөтлүүлдэг. Дасгал ажлыг хийхэд хүүхэд тэдэн минут хийж байна, магадгүй хүрээнээсээ гадуур тойруулаад зураад байна. Хуруу, тохой 2 хөдлөхөд бэрхшээлтэй учраас бүр хэтэрхий жижиг дүрстэй зургийг будаж чадахгүй байгаа болохоор цар хүрээг нь томруулаад том хэмжээтэй зураг өгөхөд будаж чадаж байна гэх мэтээр үүнийг чадаж байна, үүнийг чадахгүй байна гээд багш, эцэг эхийн дунд эргээд холбоо үүсгэдэг. Тэгэхээр багш дараагийн арга зүй, сургалтын үйл ажиллагаагаа өөрчлөөд явж байгаа. Мөн зайнаас теле хичээлээ үзэж байна.

Цаг зав гарган манай подкастад орсон танд маш их баярлалаа. Та болон танай цэцэрлэгийн бүх хүмүүст ажил үйлс, амьдралд нь маш их сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе! Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай!

Антолд подкастад урьж оролцуулсан явдалд танай хамт олонд маш их баярлалаа. Бүгдээрээ хамтдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг, хүүхдүүдийг ойлгож, хүндэтгэж байя. Нийгэмдээ бүгдээрээ гэрэл асаая, хайр түгээе гэдэг уриаг хэлмээр байна.

За баярлалаа танд.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД ХОТОД НУУГДАЖ АМЬДАРДАГ

Анне Тулкин



Энэ удаагийн зочин болох Анне Тулкин маань АНУ-аас холбогдлоо. Тэрээр АНУ-ын хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад зориулсан Нээлттэй Коллеж (Accessible College)-ийг үүсгэн байгуулсан ба одоо захирлаар нь ажиллаж байна.

Хатагтай Тулкин 2007-2008 онд "Сургуульд суралцагч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудалд хандах Монгол багш, сонирхогч бүлгүүдийн хандлага"-ын тухай магистрын ажлын судалгаа хийжээ. Бидэнтэй "Сайн байцгаана уу" хэмээн Монголоор мэндлээд, өөрийгөө манай улстай зүрх сэтгэлээрээ холбоотой нэгэн хэмээн танилцуулсан юм. Тэрээр анх 2003 онд АНУ-ын Энх тайвны корпусын сайн дурын ажилтнаар Дорнод аймгийн

Чойбалсан хотын ерөнхий боловсролын 8-р сургуульд хоёр жил ажиллаж, тус сургуулийн багш нарын заах арга зүйг сайжруулах чиглэлээр Энх тайваны корпусын төсөл хэрэгжүүлжээ. Хожим АНУ-д магистрантурт суралцаж байхдаа Фулбрайтын хөтөлбөрийн тэтгэлэгт хамрагдан, өмнө дурдсан судалгааны ажлаа хийн, дахиад жил гаруй Монгол Улсад амьдарсан байна. Монголд элгэмсэг хатагтай Тулкин хуримынхаа бал сарыг хүртэл манай улсад тэмдэглэжээ.

Хөдөө орон нутагт хөгжлийн бэрхшээл илүү ойр мэдрэгддэг

Энх тайваны корпусын Монгол амьдрал, ахуйтай танилцах сургалтаа Хатагтай Тулкин Сэлэнгэ аймгийн Баруунхараа суманд хийжээ. Хөдөөний айлд гурван сар сууж, Монгол соёл, ёс заншилтай танилцаж, хэлний эрчимтэй сургалтад хамрагдсан тэрээр шууд алс зүүн хязгаарын Чойбалсан хотод ажиллахаар болжээ. Тус хотод ажиллаж байхдаа тэрээр ерөнхий боловсролын сургуульд нь хэд хэдэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байхыг анзаарчээ. Тухайн үед оюуны бэрхшээлтэй хүүхдийг эргэн тойрных нь хүмүүс "тэнэг хүүхэд" гэж дууддаг байсныг тэрээр дурсаад, аливаа хүн хөгжлийн бэрхшээлийг хэрхэн тодорхойлж байгаа нь тэдний хандлагаар илэрхийлэгддэг болохыг онцолсон.

Мөн хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд сургуулийн орчин хүртээмжтэй бус, саад ихтэй байсан хэдий ч үе тэнгийн найзууд нь тэдэнд ихээхэн тусалдаг болохыг тэрээр ажигласан байна. Хоттой харьцуулахад хөдөө, орон нутагт хүн амын тоо бага учраас хүмүүс бие биенээ сайн таньдаг. Иймээс хөгжлийн бэрхшээлтэй нэгнийг нуух боломжгүй.



Ийм нөхцөл байдлын улмаас хөдөө дэх хөгжлийн бэрхшээлтэй иргэд хот суурин газартай харьцуулбал нийгмийн харилцаанд түлхүү ордог. Нутгийн иргэд хөгжлийн бэрхшээлийг Бурхны шашинтай холбон тайлбарладаг. Тухайлбал, өмнөх төрөлдөө муу зүйл үйлдвэл энэ төрөлдөө хөгжлийн бэрхшээлтэй болж төрнө гэх ойлголт Монголчуудын дунд зонхилж байсан нь хатагтай Тулкины гайхлыг төрүүлж байсан аж.

Тэрээр Улаанбаатар хотод судалгааны ажлаа хийх явцдаа хотын амьдралтай танилцаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрал ахуй, тэдэнд хандах хүмүүсийн хандлагын талаарх бодлоо бидэнтэй илэн далангүй хуваалцсан юм. Хөдөөтэй харьцуулахад хотод хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гадуур бараг л харагддаггүй, зөвхөн гуйлга гуйж байгаа юм уу эсвэл гэр оронгүй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс л гудамжинд харагдагддаг. Учир нь Улаанбаатар хотын хувьд дэд бүтэц хүртээмжтэй бус, ээлгүй байгаагаас хөгжлийн бэрхшээлтэй иргэд гадуур чөлөөтэй зорчиж чаддаггүйтэй холбоотой хэмээн тэр тайлбарлав. Мөн



хотод хүмүүс илүү хаалттай төдийгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ бусад хүмүүсээс нуух тохиолдол ч байдгийг хатагтай Тулкин анзаарчээ.

Анне судалгаандаа хэд хэдэн чухал асуудлыг хөндсөн. Жишээлбэл, хөдөө орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй иргэд илүү гадуур гарч, хүмүүстэй харилцдаг ч энэ нь яг тэгш хамруулалт байж чадах уу? Монголчуудын хувьд тэгш хамруулалт гэж яг юуг хэлээд байгааг ойлгохыг оролдсон нь цаашид түүнийг тусгай боловсролын чиглэлээр судалгаа хийхэд нь чухал нөлөө үзүүлжээ.

Алдагдсан боломжууд

АНУ-ын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах хууль эрх зүйн орчин нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах, дэмжихэд чухал нөлөө үзүүлснийг хатагтай Тулкин бидэнд онцолж байв. Ялангуяа, хоёр хуулийг (The Rehabiliation Act 1973, Americans with Disabilities Act 1990) тэрээр тусгайлан дурьдаж, энэ нь АНУ зэрэг хөгжингүй орнуудад дээр үеэс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ эрхийг хамгаалах, тэднийг хөдөлмөр эрхлэлт болон боловсролын салбарт ялгаварлан гадуурхах явдлыг зогсоох, орчны хүртээмжийг сайжруулах зэрэгт анхаарч ирснийг сонсоод атаархаж сууснаа нуух аргагүй. Гэтэл манай улсын хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай хуулийг тавхан жилийн өмнө анх баталсан нь энэ хоёр нийгмийн хооронд асар их ялгаа байгааг түүнтэй ярилцахдаа мэдэрсэн юм. Хэдийгээр орчныг бүх нийтэд хүртээмжтэй болгох тухай хууль, дүрэм журам, стандарт нь батлагдчихсан боловч эдгээрийг хэрэгжүүлэх, хянан шалгах тогтолцоо сул байна. Үүнийг манай зочин онцолж, бид хууль тогтоомжоо хэрэгжүүлэхгүй, хяналтгүй сул орхисноор хөгжлийн бэрхшээлтэй иргэд ээлтэй орчин буй болгох боломжоо энэ их хурдацтай хотжилтын үйл явцад алдсаар л байна. Анхнаас нь чанарын стандартын дагуу барихгүй, налуу зам барьсан гэсэн нэр төдий байх нь эргээд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд учрах орчны саадыг арилгаж чадахгүй юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд гадуур чөлөөтэй, саадгүй явдаг байж л нийгмийн амьдралд тэгш хамрагдаж, өөрсдийн эрхийг хамгаалахаар гарч ирж, дуу хоолойгоо хүргэх болно гэдгийг тэрээр онцолсон юм.

АНУ-ын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхээ хамгаалуулахаар тэмцэж буй баримтат кино (Crip Camp)-г үзэхийг хатагтай Тулкин бидэнд санал болгосон. Энэ нь манайхан ч гэсэн АНУ-ын нэгэн адил хүний эрхийг дээдлэдэг ардчилсан орны хувьд иргэд дуу хоолойгоо чөлөөтэй илэрхийлээсэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэд маань эрхийнхээ төлөө тэмцээсэй гэж хэлэхийг зорьсон мэт. Ярилцлагын явцад зочин маань Монгол хүмүүст байдаг сайхан чанарыг олонтаа дурсаж байв. Тухайлбал, Монголд гудамжинд явж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хараад хэн ч уриалгахан тусалдаг нь нөгөө талаараа тэдэнд өдөр тутамд тулгардаг орчны саадыг нь давахад тусалдаг гэсэн юм.

ХБИ-ийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэхдээ

Хатагтай Тулкин 2008 онд хийсэн судалгааны ажилдаа манайд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх ойлголт, хандлага муу байгаа нь нийгэмд эргээд олон сөрөг асуудал үүсэхэд нөлөөлж байдаг талаар бичсэн байдаг. Хэрхэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх ойлголтыг нэмэгдүүлж, хандлагыг эерэг болгох талаарх бидний асуултад тэрээр ямар ч эргэлзээгүйгээр мэдээллийн хэрэгслүүдээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллийг оруулцуул, олон нийтэд таниулах хэрэгтэй гэж хэлсэн юм. Хэдийгээр нийгэмд энэ асуудлаар бусад хүмүүс ярихгүй байсан ч гэсэн дуу хоолойгоо тасралтгүй хүргэх хэрэгтэй гэж тэрээр үздэг аж. Мөн Монголчуудыг Солонгос олон ангит кино үзэх дуртайг анзаарсан тэрээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх дэлгэцийн контентыг нийтэд хүргэх нь үр дүнтэй аргуудын нэг хэмээн онцолсон юм. Эцэст нь хэлэхэд, зочин маань Монголд байхдаа Шар хадны эмнэлэгт (СЭМҮТ) оюуны хувьд ямар ч бэрхшээлгүй тархины саажилттай хүүхдүүдийг байлгаж байсныг хараад хэрвээ тэр хүүхдүүд АНУ-д төрсөн бол амьдрал нь ямар өөр байх байсан гэсэн бодол төрсөн гэдгээ хуваалцсан нь бид цаашид ямар их зүйл хийх хэрэгтэй, АНУ зэрэг орнуудаас хичнээн хол байгааг ахин нэг удаа ухааруулсан юм.

ЗҮГЭЭР Л НАЙЗ НЬ БАЙ!

А.Хаш



Сайн байцгаана уу, эрхэм хүндэт сонсогчид оо, Антолд подкастын маань ээлжит дугаар эхлэхэд бэлэн болоод байна. Энэхүү дугаарт Эм Жи Эл (MGL) радио буюу дэлхийн монголчуудын радиогийн хөтлөгч Хаш оролцож байна. Та урилгыг минь хүлээн авч манай подкастад орж байгаад маш их баярлалаа. Та манай сонсогчдод өөрийгөө танилцуулахгүй юу?

Бас урьж оруулсанд баярлалаа. Би 2017 оноос хойш Эм Жи Эл (MGL) радиод хөтлөгчөөр ажиллаж байгаа. Фейсбүүкт бас их идэвхтэй байдаг, миний фейсбүүк хаягийг Алимаа Хаш гэдэг. Энэ сошиал талаараа л би танилцуулахгүй бол би нэг их түүхтэй хүн бол биш. Гавьяа шагнал байхгүй, яг зэмлэл байхгүй гэдэг шиг яг л тийм хүн.

Манай подкастын хамгийн анхны оролцогч Баттулга ах таны талаар их ярьсан учраас бид таныг урьсан юм. Баттулга бид хоёр холбоотой байдаг. Тэгээд юу гэж ярьж байна?

Баттулга ах таныг маш их сэтгэл санааны дэмжлэг үзүүлсэн, гэрт нь ирээд гоё сонирхолтой юм ярьдаг байсан гэж хэлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй болж сэтгэл санааны маш их хямралд орсон хүмүүстэй очиж ярилцаад, маш их сэтгэлийн дэм өгөөд, буцаж нийгэмшихэд нь маш их тус болсон гэж ярьсан. Таныг тэр талаар яриулах гэсэн юм. Та анх яагаад хүмүүс дээр очиж

сэтгэл санааны дэмжлэг өгөх болсон бэ?

Би их сэтгэлийн хөдөлгөөнтэй, дэврүүн хүн. Муугаар яривал их тогтворгүй хүн. Нэг харсан чинь миний амьдрал бага зэрэг уйтгартай болчихсон байсан. Яг үнэнийг хэлэхэд ажил гэр, ажил гэр гэсэн уйтгартай амьдралаас салахын тулд архи их уудаг байсан. Архи уувал арай өөр ч юм шиг, гэхдээ архи бол зөв зүйтэй зүйл биш гэдгийг хэлсэн хэлээгүй мэдээж хүн болгон л мэднэ. "Ер нь архинаас өөр таашаал авах зүйл байна уу, өөр юу байдаг юм бол" гээд дотроо боддог байсан. Ах нь саарал амьдралаас гарах гээд байна шүү дээ. Нэг мэдсэн чинь зөвхөн өөрийгөө л боддог хүн болчихсон байсан. Нэг өдрийнхөө хоолыг аргацаасан, юм авбал зөвхөн өөртөө авдаг, өөрөө л болж байвал болдог. Тэгж явах тусам хүн маш өчүүхэн болж ажлаа хийгээд л, гэртээ хариад л, ажлаа хийгээд л, гэртээ хариад л сайн хүн гэж хэлэхэд хэцүү, муу хүн гэж хэлэхэд хэцүү. Зүгээр хэн ч биш юм шиг мэдрэмж надад төрсөн. Мэдэхгүй яагаад ч юм надад нэг тийм муухай мэдрэмж төрсөн. Залуу байсан бол өөр юм бодох байсан байх. Тэгээд би яах ёстой юм бол гэж бодсон. Би өмнө нь эмнэлэгт хэвтэж байхдаа "эмнэлэгт эргэлт ирдэггүй хүмүүс ямар хэцүү байдаг юм бэ" гэж боддог байсан учраас "тийм хүмүүс дээр очвол яасан юм" гэсэн бодол надад төрсөн. Тэгээд би анх долоо хоногт 2 дахь эсвэл 3 дахь өдөр өөртөө нэг хуваарь гаргаад 1 хүнийг эргэж, хоол аваачиж өгнө гэж шийдсэн. Хамгийн анх хуучин Гэмтлийн эмнэлэг дээр лапшаа хийгээд очиход маш хэцүү байсан. Ер нь ямар нэгэн юмыг эхлэх их хэцүү байдаг. Хүн намайг солиотой гэж харах болов уу гэж санаа зовж зовж эмнэлэг дээр очоод сувилагч, асрагч нараас нь "танайд эргэлт огт авдаггүй өвчтөн хэвтдэг үү?" гэсэн чинь, "та яах гэж байгаа юм" гээд л, "би эргэх гэсэн юм" гээд л, тэд нар гайхаж харж байсан. Яагаад гэвэл манайд урд нь тийм тохиолдол гараагүй юм шиг байгаа юм. Танихгүй хүнийг очиж эргэдэг анхных нь хүн би байсан байх. Тэд надаас ямар албан байгууллагаас явж байгаа юм гэж асуугаад эхэлсэн л дээ. Би албан байгууллага биш, хувиараа явж байгаа юм гээд нэг хүн очихоор хүмүүс гайхаад, том том хараад л, эхэндээ аймаар эвгүй байсан.

Тэгээд нэг эргэлт авдаггүй хүн хэвтэж байгааг хэлж өгсөн. Би 2 дахь өдрийн 2 цагт очно гэж өөртөө хуваарь гаргаад яг хуваарийн дагуу очдог байсан. Анх нөгөө хүн дээрээ ороход нөгөө хүн маань бас надаас эвгүйрхээд "хүүе тийм юм байдаг юм уу? би танихгүй шүү дээ, хүн андуураад байна уу?" гэсэн. "Үгүй ээ, үгүй. Би андуураагүй. Би чамайг эргэж баймаар байна, чамд эргэлт байдаггүй гэж сонслоо" гэж хэлсэн. Манайхан юманд үл итгэдэг, хартай хүмүүс. Тэгээд л "аль намынх вэ, ямар байгууллагынх юм" гээд эхэндээ төвөгтэй эхэлсэн түүхтэй. Тэр болгоныг тайлбарлаад, би 6 сар гаруй тэр хүн дээр очсон. Тэр хүн 2 хөлөө тайруулсан, түлэгдэл маш ихтэй, ер нь хэцүү хүн байсан. Тэгээд эхнэр нь хаяад, охинтойгоо үлдсэн байсан. Би яг очих газраа л очсон. Тэр хүн маань сүүлдээ надад их гоё болсон.

Мягмар гараг болох гэж байхад л өмнөх өдөр нь эсвэл бүтэн сайн өдрийн орой над луу утасдаад “Хашаа хэзээ над дээр ирэх гэж байна” гээд гоё байдаг байсан. Заримдаа хоол хийж очдог байсан бол заримдаа печень авч очдог гэхдээ эд юм авч ирж өгөх нь чухал биш. Зүгээр л би очоод тэр хүнтэй сайхан ярьдаг байсан. Хүнтэй ярих чинь гоё шүү дээ. Дараа нь би юу мэдсэн гэвэл ямар нэгэн өөр хүн намайг үгүйлээд байгааг мэдрэхээр их гоё байсан. Би зөвхөн гэр бүлдээ эсвэл зөвхөн өөртөө хэрэгтэй хүн байснаас нэг хүнтэй танилцаад, би тэр хүний ах нь, найз нь болоод явахаар миний амьдрал илүү сонирхолтой болж эхэлсэн.

Яг үнэнээ хэлэхэд би буян хийгээд их ариун гэгээнтэн, сайн хүн болоод тэгж яваагүй. Би өөрөө өөртөө сайн юм хийж, өөрөө өөрийнхөө амьдралыг утгатай болгож, таашаал авах гээд байна. Амьдралын утга учир гээд хүмүүс ярьдаг. Харин би амьдралаас таашаал авах аргаа олчихвол утга учраа олчихлоо гэж би бодох гээд байгаа юм. Тэгэхээр таашаалыг бол юунаас ч авч болно, тэр хүний л амьдралын утга учир. Дараа нь их сонин манай хүн 6 сар болоод эмнэлгээсээ гарах болсон. Бид хоёр найзууд болчихсон юм чинь “би эмнэлэг дээр дахиж очихгүй, за баяртай би эргэж дууссан” гэж хэлж болдоггүй. Би ямар нэг төслийн ажил хийж байгаа биш энэ чинь хүний амьд харилцаа шүү дээ. Тэгээд манай хүн “би эмнэлгээс гарлаа, чи манайд ирж байх юм байгаа биз дээ” гэсэн. Би “яагаад болохгүй гэж” гээд Баянхошуу руу долоо хоног болгон очдог болсон. Тэгээд 1 хүн дээр очих багадаад байгаа юм шиг санагдаад 2, 3 хүн дээр очдог боллоо. Би тэр үед чинь барьдаг байсан. Тэгээд явж байтал 104.5 ФМ радионыхонд нөгөө хүн миний тухай ярьсан гэсэн. “Над дээр нэг хүн ирээд” гэтэл нөгөөдүүл нь “тийм хүн байдаг юм уу, тэр хүнтэй чинь уулзъя” гээд одоо гэр бүлийн радио дээр намайг уриад яриулсан. Ярьж байтал Тулгаагийн ээж аав нь утастаад “манай хүү дээр ирж байж болох уу? Манай хүү саяхан осолд ороод хэвтэж байгаа юм” гэсэн.

Тэгээд би яваад очсон чинь нэг хөөрхөн хүү хэвтэж байсан. Нуруу нугасны их дээгүүр гэмтэлтэй болохоор эдгэрэх магадлал маш бага. Нурууны гэмтэл дээшлэх тусам мэдээ орох нь хол, доогуур гэмтэл байх тусам эдгэх магадлал их байдаг юм байна. Тулгаа маань их дайчин хүү байсан. Анх очиход манай хүн бас гайхаж, эргэлзэж байна. Тэгээд аав чинь ингэж хэлсэн юм гэсэн. Хүн дээр очихдоо хэнд ч зааварчилгаа, зөвлөгөө, удирдамж өгөхгүй гэдгийг би их сайн ойлгосон. Нэг үгээр хэлбэл би багшлахгүй гэсэн үг. Яагаад энэ надад вэ гэвэл би өөрөө тэр зовлонг үзсэн хүн. Үнэнээ хэлье, надад зааж сургадаг багшаас илүү архи хамт уудаг, миний үгийг сонсдог, хамт тэнэг юм ярьдаг найз надад хэрэгтэй байсан. Надад багшилдаг, зөвлөдөг гэгээнтүүд ёстой хэрэггүй, тэд надад дарамт л үүсгэдэг байсан. Би өөрийгөө ийм мундаг хүн би биш шүү дээ гээд л голдог. Тийм болохоор би эхэндээ Тулгаа дээрээ очоод “би өчигдөр ингэсэн, тэгсэн, чи яаж байна гээд зүгээр л энгийн юм яриад цагийг хамт

өнгөрөөдөг байсан. Заримдаа хүн чинь үг хэлэхгүйгээр нэг нэгнийгээ ойлгоно, маш олон тийм юм байсан. Тэгэх тусам нь хүмүүс яг үнэнээ ярьдаг болдог. Надаас нууж хаагаад байх юм байхгүй яагаад гэвэл би нууж хаахгүй шүү дээ. Тэгэхгүй би очоод "чи тэгэх хэрэгтэй, чи босож чадна" гээд би өөрөө итгээгүй байж үлгэрийн юм яриад байдаг худлаа, хиймэл юманд би маш дургүй. Тийм хүмүүстэй харьцвал хүн биеэ бариад "сайн байна, баярлалаа" гэхээс цаашаа юм ярьдаггүй. Тэгэхэд Тулгаа бид хоёр ёстой бүр есөн жорын юм ярьдаг байсан. "Өчигдөр ах нь ингээд явж байгаад ингэчихлээ. Тэгсэн чинь тэглээ. Ёстой би бүр ингэлээ яана аа" гээд л. "Одоо би хурдан гүйгээд явахгүй бол болохгүй" гээд би яг найзтайгаа харьцаж байгаа юм шиг ярьдаг байсан. Гэтэл хүнтэй найз болно гэдэг их том урлаг гэдгийг би ойлгосон. Хүнд заах зөвлөх шиг амархан юм байхгүй.

Хоёрдугаарт анзаарсан зүйл гэвэл би хүмүүс дээр хүмүүстэй хамтарч очиж үзлээ, байгууллагын хүмүүсийн тусламжийг өгч очиж үзлээ. Тэгэхэд яагаад ч юм (ухамсаргүйгээр) би энэ хүнээс илүү гэсэн мэдрэмж төрдөг учраас заах гээд байдаг. Заана гэдэг нь би чамаас илүү юм мэдэж байгаа учраас чамд заагаад байна. Автоматаар би үнийг чамаас илүү мэдэж байгаа болохоор чи тэгэх ёстой гээд байгаа юм. Харин би тэр хүний өвдсөн өвчнөөр өвдөж үзээгүй болохоор чи ингэж биеэ тэнхрүүлээрэй



гээд худлаа яримааргүй байдаг болохоор ийм харилцаан дунд бид хоёр найзалсан. Манай хүний нэг дайчин зан чанар байсан нь “би эдгэрнэ, босно, тийм ээ?” л гээд байдаг байсан. Тэгээд турник, гантель хажуудаа тавьчихсан сургуулилж байдаг. Өөр хүн харах юм бол чи ёстой зөв, босно гээд л хэлэх байсан байх. Манайхан чинь нэг гоё үгтэй шүү дээ “урам өгч сур” гээд л. Тэр урам өгөх чинь өөрөө учиртай юм гэдгийг хүмүүс тэр болгон ойлгодоггүй. Харин би “За Тулгаа минь чи боссон хойноо л амьдрах гээд байгаа юм уу? Одоо амьдрал чинь үргэлжилж байна шүү дээ. Чи босохгүй бол яах юм, чи босно гээд л дахиад хугацаагаа алдаад байх юм уу? Жишээлбэл би хөлгүй хүн, миний хөл ургана, хөл ургасан хойноо гүйнэ гэж би хэзээ ч боддоггүй” гэхэд жоохон харгис сонсогдсон л байх гэхдээ тэр үг манай хүнд нэлээн юм бодогдуулсан байх. Тэгээд манай хүн англи хэл сурмаар байна гэсэн. Гар нь хөдөлж байна, ухаан санаа эрүүл, босож л чадахгүй болохоос биш толгой нь ажиллаж байгаа. Ямарваа нэг юм мирэкл (гайхамшиг) болохгүй 1 жил, 2 жил, 3 жил явна. Дараа нь манай хүн “англи хэл сурах гэсэн чинь аймаар хэцүү, хүн амьтан ч байхгүй, надтай практик хийх хүн олж өгөөч” гэхээр нь “чи ямар давруу амьтан бэ? Чамайг шоронд хийчихвэл чи шоронгийн харгалзагчаас би англи хэл сурах гэсэн юм, нэг англи хэлтэй хүн оруулаад ир гэх үү? Цаана чинь шоронд номны өөдөс аваад 2-3 хэл сурчихсан хүний зөндөө л түүх байгааг уншаагүй юу, мэдэхгүй юу” гээд л инээлдэж байсан. Энэ ч гэсэн жоохон урам болсон байх гэж би боддог. Өөрөө ч итгэхгүй байж “чи чадна аа, чи чадна аа” гэж хүн итгүүлэх хэрэг байхгүй. Зүгээр л “чи чадна аа, битгий бууж өгөөрэй” гээд жижүүрийн үг болсонд заримдаа би харамсмаар санагддаг.

Тийм тийм. Тэгэхээр яг жинхэнэ юм бол бүр их хялбар яг амьдралаас ургаж гардаг. Чи зүрх сэтгэлээсээ харьцаж чадаж байна уу, үгүй юу гэдэг л асуудал байгаа болохоос би өөрөө итгэхгүй юмаа тэр хүнд итгүүлэх шиг худлаа юм байхгүй. Чи өөрөө юу ч мэдэхгүй байж мэддэг юм шиг ярьж болохгүй. Худлаа ярьж байгаа л хэрэг болно. Заримдаа хүмүүс мэдэхгүй юмаа мэдэхгүй, чадахгүй юмаа чадахгүй гэж хэлж байх хэрэгтэй. Тэгвэл миний ч, тэр хүний ч амьдрал хялбар болно. Хүний хоорондын харилцаа ч гэсэн итгэлтэй, их сайхан болно. Нэг өдөр Тулгаагийн ирсэн чинь ээж нь надтай уулзсан. Тулгаа дээр 2 давхартаа амьдардаг, ээж нь нэг давхартаа амьдардаг байсан. Тулгаа өчигдөр уурлаад буу өгөөдөх, би амиа хорлоё гээд байсан. Би буу олоод өгчихдөг ч юм билүү гэж ээж нь надад хэлсэн, тэр чинь цөхөрсөн хүний л үг.

Би юу гэж хэлсэн гэвэл юу ч хэлээгүй. Аан тийм үү л гэсэн. Би ороод өчигдөр яасан дүү хямарсан уу? гэсэн чинь “гурван жил нэг газар обойныхоо хээг харсаар байгаад би ийм болж байна” гэсэн. Ямар хэцүү байдгийг би мэдэх учраас би юу хэлэх юм бэ? “Хашаа ах аа би нээрэн өөрийгөө буудчихмаар байна” гэсэн, би юу ч дуугарч чадаагүй “Битгий өөрийгөө бууд, чиний амьдрал сайхан болно” гэж

хэлэх дэмий. Тэр үед өөрийгөө буудая гэсэн бол хоёр гар нь сул байхад надад хэлсэн хэлээгүй буудчихна, амиа хорлоё гэвэл хорлочихно. Хүн хүнтэй харилцаж байхдаа бодож харилцах хэрэгтэй байдаг. Тэр бол зүгээр бухимдсан хүний үг байсан. Яагаад би Тулгаад тайвшралын үг хэлж чадахгүй байна вэ гээд би гарч яваад өөртөө бухимдсан. Би 6 жил хүн амьтан дээр очсон байж яагаад тэр хүүхдэд бусад хүн шиг тайвшрах ганц гоё үг хэлчхэж чаддаггүй юм бол гэж өөртөө аймаар гутарсан. Би гарч явахдаа Тулгаад " Тулгаа ах нь маргааш ирье дээ, одоо явлаа" гэж хэлээд явсан. Хүн өөрийгөө буудъя гээд байхад нь тэгж болохгүй гээд тэвэрч авч үнэхээр чадаагүй яагаад гэвэл би өөрөө шоконд орчихсон байсан. Харин маргааш нь очъё гэснээрээ очсон. Надад маш олон жил хар тамхичидтай ажилласан Жон Күллэр гэдэг Америк ментор байдаг.

Монголд уу?

Монголд байсан. Хуурай ах дүү нэг америк хүнтэй, тэр хүнээс би маш их юм сурч авсан. Тэгээд би тэр хүн дээр очиж "Жон ах аа би энэ хүнд ёстой юу ч хэлж чадсангүй" гээд бухимдлаа илэрхийлсэн чинь "Хаш аа чи одоо л жоохон юм сурч байна" гэсэн. Юу сурчихсан юм, яасан гэсэн чинь, "зүрх сэтгэлээрээ сонсож сурч байна, хүнийг сонсож сурна гэдэг бол энэ. Чи үг хэлэх ёстой нөхцөл байдал нь байгаад, хувь тавилан чинь чамайг залаад тэр үгийг хэлүүлэх байсан бол ямар нэгэн байдлаар чамд үг орж ирэх байсан. Орж ирээгүй болохоор чи зүгээр чимээгүй байж байгаад л гараад ирсэн. Чи байх ёстой газраа байж байсан. Тэгээд л болоо. Байх ёстой газраа байна гээд заавал юм дуугарна гэсэн үг биш. Чи байх ёстой газраа байж, түшиг болж байсан байж магадгүй, мэдэхгүй. Энэ хорвоод бүх юмыг тайлбарлах аргагүй. Тэгэхээр яагаад ч юм хувь тавилан чинь чамайг яг тэр цаг мөчид тэр хүүхдийн хажууд байлгаж байсан. Чи худлаа юм яриагүй болоо. Нэг үгээр хэлэх юм бол чи өөрөө өөртэйгөө бас шударга байж чадсан. Чи ийм нөхцөл байдалд хувь тавиланг хуурч, өөрийнхөө санааг хэлээгүй, зүгээр л чимээгүй сонсож чадсан" гэж хэлсэн.

Маргааш нь яваад очсон чинь Тулгаа харааД "Хашаа ах аа би өчигдөр танд ёстой аймаар баярласан, ёстой их баярласан" гэж хэлсэн. Юу ч хэлээгүй хүн чинь ёстой мэл гайхсан. Гэхдээ би хажууд нь сонсож байсан. Иймэрхүү юмнууд их бид хоёрын дунд болж байсан. Тэгээд ер нь чи хувиа бодоод өөрийгөө болгох гээд л яваад л байх юм бол чиний хүрээлэл нэгдүгээрт маш жижигхэн болно, чиний сэтгэхүй их жоохон болно. Тэгэх тусмаа чи маш бэртэгчин, өчүүхэн хүн болж л хувирах юм байна гэдгийг л би бүр яс махандаа шингэтэл ойлгосон.

Одоо радиогийн ажилтай болохоор радиогоор дуртай юмаа бураад л, бураад л гоё байна. Хүмүүс намайг гудамжинд хоолойгоор маань танидаг. Би бас радио дээрээ ийм амьд харилцаатай байж, өөрөөрөө байхыг их хүсдэг. Хүн болгонд мэдээж таалагдах албагүй. Миний хийж

чадах юм бол ажлаа таслахгүй, ажлаасаа хожигдохгүй байж чадна гэдгийг би ойлгосон. Би чадах юмаа л хийе, ур чадвар, мэргэжлийн төвшин ахих бол өөр асуудал. Хэзээ ч, хэн ч мундаг байдаггүй, хүн жоохон сахилга баттай болоод өөрийгөө хүмүүжүүлэх бол амьдрал цэцэглэдэг гэдгийг олж хараад, залуучуудад үүнийг л би хэлмээр байна. Хүн хэзээ ч мундаг чадварлаг байж юм хийдэггүй, сахилга баттай, даруухан байж өөрийгөө дэг журамд оруулж байж ямарваа нэгэн юманд хүрдэг юм байна. Амьдралын утга учир гэвэл амьдралаас өөрийнхөө зугаа цэнгэл, өөрийнхөө баяр баясгаланг олж авах хэрэгтэй юм байна. Тэрнээс архи, өөр зугаа цэнгэл ч тэр өчүүхнээс гадна бүр хорт зуршил болж, өөрийг нь сүүлд нь нурааж, хэн ч биш болгоно гэдгийг л ойлгох хэрэгтэй. Тэрнээс нэг их гэгээрээд сайн хүн болсондоо сайн үйлс хийгээд байдаг юм гэж би хэлэхгүй. Зүгээр л би бүтэн амьдралаар амьдармаар, нас барахдаа юманд харамсаж үхмээргүй байна. Би сүүлийн үед үхлийн тухай маш их боддог болсон. Хэзээ нэгэн цагт би үхнэ, энэ муу ёр биш. Харин үхэхдээ би амар тайван, өвдөж зовохгүй, за баяртай, одоо миний нас болж дээ гээд маш гоё амар тайван, инээмсэглэл тодруулаад авсандаа орохыг хүсэж байна. Тэрний тулд би өнөөдөр энэ амьдралаа тултал нь явах хэрэгтэй байгаа юм.

Та одоогийн байдлаар хэдэн хүн дээр очиж байгаа вэ? Одоо ч гэсэн очиж байгаа юу? Ковидоос болоод зогссон уу?

Ковидоос болоод биш, зүгээр тогтмол очихоо больчихсон. Надад одоо хоёр бүсгүй хүн байгаа. Нэг нь хараагүй, нэг нь хөгжлийн бэрхшээлтэй хоёр бүсгүй байгаа. Тэгээд би ганцаараа хийгээд байхгүй хүмүүсийг уриалаад, нэгдэж юм хийе гэсэн бодол надад байгаа. Би ажилдаа дуртай болоод ч тэр үү, хагас, бүтэн сайнд л жоохон завтай байдаг учраас ажлын цаг үнэхээр бага. Би чухалдаа биш шүү, нэг их чухал хүн болоод би завгүй гэдэг чинь худлаа. Гэхдээ яах аргагүй би 9.00 цагт гараад орой 21.00 цагт гэртээ орж ирдэг. Уг нь ажлын 8 цаг гэхдээ би маш тайван ажиллах дуртай болохоор 11.00 цагт ажил дээрээ очих ёстой байтал би 9.00 цагт очоод сууж байдаг. Яагаад гэвэл би ажлаа бэлтгэнэ, ажлаа тайван, өөрийнхөө тааваар хийнэ. Одоо нас яваад байна шүү дээ, энд тэнд очоод тамхи татна. Тийм болохоор би яг нэг тэмпэндээ орсон байдаг.

Та одоо байгаа 2 хүнтэйгээ онлайнаар холбогддог уу?

Утсаар л ярьдаг. Амьдралд яг хүнийг бүрэн халамжилна, амьдралыг нь өөрчилнө гэдэг юм байдаггүй, дэм л болох боломжтой байдаг. Тухайн цагт нь хүнд тус хүргэх боломж нь олдвол тусалдаг. Нэг үгээр хэлвэл надад тэр хүнд мөнгө өгөөрэй гээд дамжуулвал, тухайн цагийнх нь л юмыг би өгдөг. Тэрнээс “энэ хүнд би туслаад байхад амьдрал өөрчлөгдөхгүй ямар арчаагүй хүн юм бэ” гэж бид нарын ихэнх нь ярьдаг. Бид нар бурхад биш!

Та нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх хандлагыг эерэг болгоё, өөрчилье гэж радиогоороо дамжуулж ярьдаг болов уу?

Үгүй ээ. Энэ зөвхөн миний хийх ёстой юм гээд иргэн хүнийхээ хувьд бүх юманд би оролцох ёстой. Зөвхөн нэг юм бариад мэргэшээд явбал мэргэжлийн болох гээд байдаг, тийм мэргэжлийн хүн би биш. Над дээр зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүн биш, зүгээр ядарч, ганцаардаж, учраа олохоо байсан хүмүүс ирвэл би чамтай уулзахгүй гэж хэлэхгүй гэж боддог.

Би таны нүд нь муу настай хүн гудамжинд явж байхад нь очоод юм ярьсан тухай постын харсан. Хэрвээ би ч гэсэн гадаа тааралдвал яг яаж тухайн хүнтэй харьцахаа мэдэхгүй, жоохон бэрхшээгээд айгаад байдаг юм. Тэгэхээр та гудамжинд явж байгаад тийм хүмүүстэй таарсан, яаж харьцах, туслахаа мэдэхгүй миний үеийн залуучуудад юу гэж хэлэх вэ?

Зүгээр ямар ч эргэлзээгүйгээр очоод л тусал. Намайг 8 настай байхад 1970 хэдэн онд Хятадуудтай их муу байсан. Энхтайвны өргөний чөлөөний өргөн гудамжинд нэг хятад эмээ зогсож байсан. Тэр үеийн хятад эмээ нар шувуун хөлтэй, явж чаддаггүй. Явсан ч гэсэн удаан явдаг, жоохон салхи гарахаар уначих гээд байдаг. Тэр үед манайх хятадуудтай байлдаж магадгүй байсан. Би хятад хүн шүү дээ гэж бодоод л, миний хувьд тэр хүн бол дайсан. Гэхдээ тэр эмээг зам гарч чадахгүй байхаар нь би очоод хөтлөөд, намайг хүн битгий хараасай гэж бодон бодон хурдан гаргаж өгсөн. Хэрвээ манай байрны хүүхдүүд харвал “муу хужаад тусалсан, чи хужаа юм уу” гээд шоолуулна гэдгээ би сайн мэдэж байсан. Би ичсэн хэрнээ нөгөө эмээгийн гараас бариад, замын нөгөө талд нь гаргаад өгсөн. Тэгсэн тэр эмээ над руу хараад хи хи, хи хи гэж нэг их гоё инээмсэглээд миний гарыг зөөлхөн атгаад, илсэн. Тэр хүн бол надад анх хүнд туслахын тэр сайн сайхныг мэдрүүлсэн учраас би тэр хүнийг насан туршдаа мартахгүй. Түүний баярласан нүдний харц үнэхээр гайхалтай байсан.

Гэхдээ би залуучууддаа хэлье, хүн болгон бидний энэ сайхан сэтгэлийг ойлгохгүй, зарим нь нулимж ч магадгүй. Битгий санаа зов, чи хийх ёстой юмаа зөв хийсэн, тэгээд л болоо. Хүмүүс чамайг хүнд тусаллаа гээд магтвал чи шагналаа хүмүүсээс тэр дор нь л авчихна. Тэр хүн чамд баярлавал чи тэр хүнээс шаналгаа аваад өөрийнхөө сэтгэлийнхээ таашаалыг авна. Хэн ч харахгүй, хэн ч чамайг тоохгүй, тэр тусалсан хүн чинь хүртэл чамд талархал илэрхийлэхгүй байвал хувь заяа чинь чамд талархлаа илэрхийлэх болно, үүнийг бол ёстой баттай хэлнэ. Би өөрийгөө юунд ч санаа зовохгүй сайхан амьдралтай, жаргалтай хүн гэж хэлнэ. Тэгээд энэ миний өмнө нь ингэж явсны буян байдаг юм болов уу гэсэн нэг бодол орж ирээд их гоё сэтгэлийн ханамж авдаг. Хүн болгон тэр бүр талархал авна гэж байхгүй. Харагдах гэж сайн үйлс хийдэг хүмүүсийг би бас муулахгүй. Бусад хүндээ

сайн үйлс нь очиж байвал ямар хамаатай юм, тэр хүмүүсийг битгий муулаарай, залуус аа. Хийж л байг. Компани хүмүүст тусламж өгөөд өөрийгөө рекламдаж байвал тэр хүмүүст л сайн зүйл очих нь хамгийн чухал зүйл. Ийм сэтгэлээр бид хүмүүст хандах хэрэгтэй. Зүгээр хүнийг хүн гэдэг үүднээс хандах хэрэгтэй юм болов уу л гэж би бодож явдаг. Цэвэр хүнлэг ёс / гуманизм/ маш чухал.

Та сая яриандаа таны хөл гэмтсэн гээд ярьсан. Тухайн үед болж байсан бэ?

Тэр залуу байхад болсон явдал. Би залуу байхдаа осолд ороод хөлөө тайруулж байсан. Тэгэхдээ би өөрийгөө хөгжлийн бэрхшээлтэй, хөлгүй гэдгээ бараг мэддэггүй. Намайг хүмүүс “Хаш ах аа хөл чи яачихсан юм” гээд гайхаж асуудаг. Жоохон доголдог болохоос энэ бол асуудал биш.

Та тухайн үед сэтгэлээр унаж л байсан байх даа?

Үгүй үгүй. Би хөлөө тайруулчихаад орон дээр хэвтэж байхдаа “протезын гутал гэж муухай хар гутал өмсөх байх даа. Гоё гутал өмсөж болох болов уу” гэсэн юм бодоод хэвтэж байсан шүү дээ. Тэнэг байсан л даа. Одоо байсан бол амьдрал дууслаа гээд сэтгэлээр унах байсан байх. Залуу байсан, юм ч тоодоггүй байж. “Ямар ч байсан хиймэл хөл хийлгэх нь хийлгэнэ. Гоё хиймэл хөл хийлгээд, гоё гутал өмсөнө дөө” гэж бодож байсан.

Одоо та гоё гутал өмсөж байгаа биз дээ?

Тэгнэ, би гангалах маш дуртай. Ер нь нэг юм руу туйлшрах ёстой хэрэггүй гэж хэлэх байна. Намайг ингээд хэлэхээр хүмүүс уурлаад л эхэлнэ. Хаяа архи уух дуртай, тамхи татдаг, хэнд ч гай болоогүй. Би архи уугаад хүмүүст агсраад явдаг байсан бол архи уухаа болих л байх.

Зөв болох гээд үү?

Үгүй, үгүй одоо би тийм юм яримааргүй байна. Зүгээр л байгаагаараа л шударга баймаар байна. “Яагаад ингээд шударга ярьчхаж болдоггүй юм” гэж би их гайхдаг. Амьдралыг сүржигнээд байх хэрэггүй, амьдрал өөрөө маш хялбар.

Одоохондоо мэдэхгүй байна, тийм үү?

Тийм, тийм. Би 60 хүрчихээд, 70 хүрчхээд юу яриад сууж байх юм гэдгээ бас мэдэхгүй байна. Чи 20 жилийн дараа надаас дахиад нэг ярилцлага аваарай. Хаш өвөө гээд л ярина шүү дээ.

Би бас өөрөө хөгширчихсөн.

Хоёулаа амьдрал үзчихсэн, амьдралын туршлагатай. Үгүй, үгүй. Хүн тэнэг байсан бол тэнэгээрээ л дуусдаг. Одоо хүртэл залуугийн тэнэг юм надад байдаг. Би маш дэврүүн сэтгэлтэй шүү дээ.

Таныг аймаар романтик хүн гэж бодсон?

Тийм, аймаар аймаар. Уйтгартай

амьдралаас л айдаг хүн дээ.

Та сая яриандаа олон залуучуудыг уриалаад эсвэл хамтраад сэтгэлээр унасан, хэцүү байгаа хүмүүст туслах юмсан гэж боддог гэсэн. Тэгэхээр та энийгээ хэзээнээс хэрэгжүүлж эхлэх вэ? Эсвэл аль хэдийн хэрэгжүүлчихсэн явж байгаа юу?

Надтай яг хамтардаг нэг залуухан бүсгүй байгаа. Бид хоёр корона эхлэхээс өмнө хүмүүс дээр очдог байсан. Бас фэйсбүүкийн найзуудтайгаа ойр дотно болдог. Тэгээд мессенжерээр харилцаад, цөмөөрөө уулзаад тийм газар очих зэргээр цаг үеийн компанит ажил зохион байгуулж байсан. Яг байнгын ажиллагаанд арай ороогүй гэхдээ нэг тиймэрхүү юмаа илүү дагнаж хийнэ гэсэн бодол байгаа. Надад одоо хагас, бүтэн сайн өдөр бол миний өдөр болчихоод байхад яагаад би тэр 2 өдөр хийж болохгүй гэж гэсэн бодолтой байгаа. Гэхдээ бас үүнийг зарлаад байхыг хүсдэггүй. Хүмүүс намайг таньдаг болчихлоо, нөгөө Хаш чинь попорч л байна гэнэ. Гэхдээ надад попорсон гэнэ үү, юу гэнэ ёстой хамаагүй. Хүмүүс юу гэж хэлэх нь тийм чухал биш ч гэсэн жоохон бодолтой байх хэрэгтэй. Бас “уриалах”, гэх мэтийн юм битгий ярьж бай. Одоо бүгдээрээ тэгцгээе гээд уриалахаар би чамайг сонсоод, нээрээ тэгье гээд л гарна гэж байхгүй. Тамхийг жишээ авъя. “Залуусаа тамхинаас бүгдээрээ гарцгаая, тамхи муухай, тамхигүй, цэвэр эрүүл орчинд амьдарцгаая гэж уриалж байна” гэвэл тэр надад зүгээр л өнгөрнө. Тэрний оронд би тамхинаас гарсан чинь уушги маш гоё цэвэршээд, амьсгал гоё болоод гээд даруухан ярьчихвал, нөгөө хүнд аль нь илүү очих вэ?

Хоёр дахь нь.

Тийм байгаа биз дээ? Бид нар тэгж ярьж сурах хэрэгтэй байна. Хүнд хүрэхгүй үг, үг биш. Хэчнээн чанга орилсон ч гэсэн хэрэлдэж байгаа хүмүүс нэг нэгэндээ чанга хэлэх тусам л хүн ойлгохгүй, улам л холдоод байдаг. Яг л тэрэнтэй адилхан уриалга, лоозон бол зүгээр л миний хувьд бол чипуха. Тэрний оронд өөрийнхөө тухай, өөрийнхөө мэдрэмжийг мэдэж байж хүний амьдрал өөрчлөгддөг. Тэгж байж хүний амьдрал сайжирдаг. Миний фокус өөр юман дээр тусаад, өөр дээрээ минь тусахгүй бол би яаж өөрчлөгдөх юм? Заримдаа хэлмээр юм зөндөө байдаг ч цаг нь болоогүй юм бас байна.

Яг өөрийгөө олоогүй, юу хийхээ мэдэхгүй маш олон хүмүүс байгаа л байх даа.

Бас хэтэрхий даруу загнаад ч яахав, онгирох үедээ сайхан онгироод л, алдаа хийнэ гэдэг чинь бид нарын эрх чөлөө гээд байгаа юм шүү дээ. Ер нь амьдрал гоё, аймаар гоё. Хүмүүс амьдрал хэцүү гэж ярьдаг. Амьдрал хэцүү байсан ч гэсэн амьдрал бас өөрөө сайхан. Ерөөсөө тийм хэцүү амьдралын дунд сайхан амьдарна гэдэг чинь өөрөө гоё.

Хүн бол сэтгэлийн амьтан. Ялангуяа

хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст маш их зүйл тулгарч байгаа. Тэр хүмүүсийн сэтгэл зүйд та дэмжлэг өгч, нийгэмд эргээд ороход нь тус болж байгаад тань маш их баярлалаа. Магадгүй нэг ингээд тусалчих юмсан гэж бодож байгаа хүмүүс зөндөө л байгаа. Яг хэрэгжүүлж чадахгүй, юунаас эхлэхээ мэдэхгүй байгаа хүмүүс та юу гэж хэлмээр байна?

Зүгээр зориглоод үзээрэй л гэж хэлэх гэсэн юм. Эхлээд ичмээр байж магадгүй, эвгүй байж магадгүй гэхдээ гоё байдаг. Өөрийгөө ухаантай гэж хэзээ ч битгий бодоорой. Өөрийгөө чухал хүн гэж хэзээ ч битгий тооцоорой. Хүнд тэнэг, мангар, буруу харагдсан ч байж болно, чи зөв гэсэн юмаа л хийх хэрэгтэй. Яагаад бид нар өөрийнхөө хүнд туслах эрх чөлөөгөө яагаад эдэлж болдоггүй юм? Өөрийнхөө бодоод л, яриад байдаг юмаа яагаад хэрэгжүүлж болдоггүй юм? Чамайг хэн боль гээд байгаа юм. Хэн ч чамайг сайн үйлс хийхийг боль гээгүй. Тийм болохоор өөрийн санаачилга хэрэгтэй. Одоо бүгдэд нь сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

За баярлалаа, баяртай.

САНАА ЗОВОХ ЗҮЙЛГҮЙ ЧӨЛӨӨТЭЙ ХАРИЛЦАЦГААЯ

А.Лхамсүрэн



Сайн байцгаана уу, эрхэм хүндэт сонсогчид оо, Антолд подкастаар дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэднийг тойрсон асуудлын талаар ний нуугүй ярилцах болно. Сайн байцгаана уу, эрхэм хүндэт сонсогчид оо! Антолд подкастын маань ээлжит дугаар эхлэхэд бэлэн болоод байна. Энэхүү дугаарт Лхамсүрэн оролцож байна. Лхамсүрэндээ манай подкастад орохоор болсонд маш их баярлалаа.

Сайн байцгаана уу? Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Намайг оролцооч хэмээн урьсан танай подкастын хамт олонд баярлалаа.

Лхамсүрэн маань өөрийнхөө талаар товч танилцуулахгүй юу?

Намайг Алтангэрэлийн Лхамсүрэн гэдэг. Яг одоогоор ЭмАйЮ (MIU) дээд сургуулийн 3-р дамжааны оюутан, 2018 онд харааны бэрхшээлтэй хүүхдийн тусгай 116 дугаар сургуулийг төгссөн.

Баянхонгор аймагт сурч байгаад 116 дугаар сургуульд ороход ямар санагдсан бэ?

Ер нь 10-р анги төгстлөө Баянхонгор аймаг буюу төрсөн нутагтаа сурч байгаад сүүлийн 2 жил 116 дугаар сургуульд суралцсан. Огт гэрээсээ хол байж үзээгүй хүн шууд шилжээд, дотуур байранд амьдраад, брайль үсэг анх сурч эхэлж байсан болохоор эхний нэг сар бол их хэцүү байсан. Гэхдээ маш хурдан дассан. Хүүхдүүд болон багш нарынхаа

тусламжтайгаар сурах юмаа сураад, хамгийн дотны найзуудаа тэндээс олж авсан. Оюутан болох хамгийн том алхам 116-аас эхэлсэн.

Анх брайль үсэг сурахад ямар байсан бэ?

Брайль үсэг ашигладаггүй хүнд хурууны мэдрэмж ерөөсөө хөгжөөгүй байдаг юм байна. Үсэгнүүдээ 1 өдрийн дотор нэгдүгээр цэг бол А үсэг, Б үсэг хоёрдугаар цэг байдаг юм байна гээд цээжилсэн мөртлөө яг тэмтрээд уншихаар ерөөсөө болдоггүй, хоорондоо үсэгнүүд нь нийлчихсэн юм шиг санагдаад их хүндрэлтэй байсан. Төрөл бүрийн хурууны мэдрэмж сайжруулах дасгал гүйцэтгэх, унших даслагуудыг хийж байсан болохоор 1 сарын дараа гэхэд харьцангуй дээрдсэн.

Анх 116-р сургууль дотуур байрандаа ганцаараа амьдарсан уу?

Дотуур байрандаа өрөөнийхөнтэйгөө танилцаад амьдарч эхэлсэн.

Гэрээсээ хол байхад гэрийнхнийгээ их санасан уу?

Дотуур байранд орсны дараа 7 хоног болгон аав маань бүр 800 километрийн цаанаас зорьж ирээд уулздаг байсан. Анх чамайг дотуур байранд орсны дараа аав чинь 7 хоног болгон ирдэг байсан чинь одоо ингээд харахад сүүлийн бараг нэг жил авч ирж өгчихөөд ирэхээ больчихсон байна гэж хоёр жилийн дараа манай асрагч эгч хэлж байсан. Эхэндээ эцэг эхэд маань ч гэсэн хүүхдээ хол явуулах хүнд байсан байх гэхдээ их хурдан дассан.

Өмнө нь Баянхонгорт 10 жилийн энгийн сургуульд явж байсан уу?

Сумандаа ерөнхий боловсролын сургуульд сурч байсан.

Тэнд сургуульд явахад ямар байсан бэ? Хараа нь сүүлийн жилүүдэд их муудаж эхэлсэн гэсэн, тийм ээ?

Эхлээд гайгүй байж байгаад 8-р анги төгссөнөөс хойш нэлээн хүнд болж эхэлсэн. Тэгээд 10 ангид уншдаггүй, бичдэггүй зөвхөн сонсоод, ойлгосон зүйлээ амаар асуугдаад дүнгээ гаргах байдлаар сурч байсан. Тэр сургуулийнхаа багш нарт бас баярлалаа гэж чин сэтгэлээсээ хэлье. Яагаад гэвэл Монгол Улсын хэмжээнд бүтэн харааны бэрхшээлтэй хүүхдийг суралцуулаад, багш нар бүх хичээлээ нүдэнд нь бараг харагдтал тайлбарлаж өгөөд, эргүүлээд асуух маягаар үйл ажиллагаа албан ёсоор явуулдаг газар байхгүй. Манай сургуулийн багш нар намайг сүүлийн 2 жил буюу 9-р ангийн сүүлийн улирал, 10-р ангид тэгж дэмжиж ажиллаж байсан.

Хэрвээ татгалзахгүй бол хараа нь юунаас болж муудсан талаар асууж болох уу?

Би нүдний даралт гэдэг оноштой. Багаасаа л бага багаар муудсаар яваад яг 10-р ангид нэлээн муу болсон.

Хотод ирж амьдраад, биеэ даагаад сурсан байна. Хот, хөдөөгийн хүмүүсийн хандлагын ялгаа чамд ямар санагдсан бэ?

Миний хувьд хот, хөдөөгийн ялгаа хүмүүсийн хандлага дээр төдийлөн илэрдэггүй гэж боддог. Яагаад гэвэл хөдөө ч бай, хотод ч бай хэрвээ тэр хүний мэдээлэл хүлээн авах сувгууд нь өргөн байвал олон талын мэдээлэл хүлээж авч чаддаг. Ийм байвал хот, хөдөөний ялгаа байдаггүй. Хамгийн том ялгаа гэвэл бол орчны хүртээмж. Улаанбаатар бол хэчнээн стандартын бус замтай, явган хүний зам дээр машин тавьж, шон ургуулсан байна гээд асуудлууд яригддаг ч гэсэн өөрийгөө аваад явах боломж байдаг. Хөдөө орон нутгийн энгийн сумуудад зарим аймгийн төвүүдэд бүр явган хүний зам ч байдаггүй. Тийм болохоор биеэ дааж явах боломж арай бага байдаг.

Хөдөө орон нутагт ихэвчлэн гэр бүлийнхээ гишүүдтэйгээ эсвэл таньдаг хүмүүстэйгээ л хамт явдаг гэсэн үг үү? Тийм, хөдөө орон нутагт байхдаа тэгдэг. Улаанбаатар хотод бол өөрөө биеэ даагаад явж чадаж байгаа юу?

Тийм. Явж байхад жишээлбэл гэрлэн дохио хэр санагддаг вэ? Чимээ гаргахгүй, ихэнх нь зүгээр гэрэл нь асдаг.

Дуугардаг гэрлэн дохио их цөөхөн. Хүн ихтэй газруудад хажуу дах хүмүүсээ харж байгаад, тэд нар явахаар нь дагаж явдаг. Зам гарахад хүмүүс их тусалдаг. Өөрөө тэр замаар гарахгүй байсан ч гэсэн намайг хараад “миний дүү ногоон гэрэл асчихлаа” гээд хэлж өгдөг.

Хүмүүсийн тусламж дэмжлэг авахад чамд өөрт чинь хэр санагддаг вэ?

Тэр тал дээр хүнд юм бол байдаггүй. Төдийлөн харааны бэрхшээлтэй хүнтэй харьцаж мэдэхгүй болохоор тусалж байгаа хүмүүс маань илүү сандраад байх шиг санагддаг. Намайг зам дээр явж байхад



миний өмнө олон машин байгааг хараад тэр хүмүүс өөрсдөө илүү сандарчихдаг. Бид нар тэрийг таягаараа тэмтрээд л, тойрох газруудыг нь тойроод явчихна. Тусалж байгаа хүмүүсийг анзаарахад илүү сандарч, санаа зовсон байдлууд ажиглагддаг.

Жишээлбэл би гадуур явж байхдаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хараад яаж туслахаа сайн мэдэхгүй үе гардаг.

Хүмүүст хандаад ингэж тусалбал зүгээр эсвэл битгий сандраарай гэсэн чиний хувийн зүгээс өгөх зөвлөгөө байгаа болов уу?

Зам гарч байгаа эсвэл ганцаараа явж байгаа харааны бэрхшээлтэй гэлтгүй магадгүй тэргэнцэртэй хүн явж байхад үнэхээр туслах гэж байгаа бол нэгдүгээрт тэр хүн яг өөртэй чинь ижилхэн хүн гэдгийг ойлгож харьцаарай. Өөрийгөө аваад явж байгаа арга нь л жаахан өөр. Бидний хувьд таягтай явж байгаа, өөр бусад хүн тэргэнцэртэй явж байгаа. Ингэж хэлбэл гомдох болов эсвэл юу ярих учраа олохгүй сандрах, санаа зовох зүйл байхгүй шүү. Бид нар жишээлбэл автобусанд эсвэл өөр газар огт танихгүй хүнтэй энгийн яриа өрнүүлэх тохиолдлууд байдаг шиг яг тийм байдлаар хүлээж авч байгаарай гэж хэлмээр байна. Магадгүй миний баруун талд нэг зүйл байхад тэр зүйлийг өнгөрөөх гээд цаашаа гээд бүр баруун тийш нь болгох зэргээр сандарсан үедээ буруу зааж өгөх тохиолдол ч бас байдаг. Би болон миний найзууд нэг их эмзэглэж хүлээж авдаггүй.

Лхамсүрэн маань анх Эм Ай Ю дээд сургуульд англи хэл дээр сурах болсон шалтгаан нь юу вэ? Яагаад англи хэлээр суръя гэж бодсон бэ?

Ерөнхийдөө бол миний өөрийн сонирхол. Анх 4-р ангид байхдаа англи хэлний хичээлийг үзэж эхэлснээс хойш бүх хичээлдээ сонирхолтой байсан ч гэсэн англи хэлний хичээлд илүү сонирхолтой байсан. Бас гадаад хэл гэдэг утгаараа цоо шинэ зүйл, дээрээс нь хэлтэй бол хөлтэй гэж ярьдаг учраас миний хувьд англи хэлийг яадаг ч байсан сайн сурах хэрэгтэй гэсэн бодолтой байсан. Тэгээд 12-р ангид ороод боловсрол хүний амьдрал их чухал юм байна гэдгийг ойлгосон. Ялангуяа боловсролыг түгээж байгаа энэ багшийн мэргэжил маш чухал мэргэжил юм байна гээд өөрөө ч гэсэн багш болохоор шийдсэн. Ямар ч салбарын, ямар ч мэргэжлийн, ямар ч албан тушаалын бүх хүмүүс багшаас төрсөн байгаа. Тийм болохоор ямар ямар ч цэцэрлэг, арван жил, хувийн их, дээд сургуульд багшилдаг байсан хамаагүй багш гэдэг хүний үүрэг оролцоо маш чухал учраас миний хувьд энэ мэргэжлийг сонгож ЭмАйЮ дээд сургуульд орсон.

Сургуулиа төгсөөд хаана багшилна гэж боддог вэ?

Төгсөөд хөдөө орон нутагт 10 жилийн сургуульд багшилж үзэхийг хүсдэг. Яг өөрийнхөө төгссөн 116-р сургууль гэхээсээ илүү энгийн 10 жилийн сургуульд багшлахыг хүсдэг.

Лхамсүрэн англи хэлний хажуугаар мэдээллийн технологийн чиглэлээр тэмцээнүүдэд орж байсан. Мэдээллийн технологийн чиглэлээр өөрөө сурсан уу? Яаж тийм тэмцээнүүдэд орох болсон бэ?

Тэр чиглэлээр яг сурч байсан зүйл байхгүй. Одоо санаж байхад Сэргээн Засах Үндэсний Төвөөс Монгол Улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн дунд мэдээллийн технологийн тэмцээн зохион байгуулаад, тэр тэмцээнээс шалгарсан хүүхдийг гадаадад буюу Ази, Номхон Далайн бүсийн орнуудын дунд болох тэмцээнд бэлдэж авч явна гэсэн зар сургууль дээр ирсэн байсан. Тэр зарын дагуу мэдээлэл зүйн багштайгаа хамт нэг хэсэг бэлдсэн, тусгайлан сурсан зүйл бол байхгүй. Тэмцээн хэрэглээний программууд дээр суурилсан байсан. Жишээлбэл тулгуур, хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхэд повер пойнт (power point) дээр өрсөлдсөн, харааны бэрхшээлтэй хүүхдүүд эксел (excel) зэрэг хэрэглээний программууд дээр өрсөлдсөн болохоор илүү амар байсан.

Тэндээс 4 хүүхэдтэй хамт нэг баг болоод Ази, Номхон Далайн бүсийн орнуудын дунд болдог тэмцээнд орсон тийм ээ?

Тэр тэмцээнд 4 өөр төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нэг баг болоод оролцдог юм.

Чиний бодлоор Монголд хөгжлийн бэрхшээлтэй залуучуудыг сурч боловсрох, сургуулиа төгсөөд ажил хөдөлмөр эрхлэхэд нь ямар бодлогоор дэмжвэл зүгээр гэж боддог вэ?

Миний хувьд 2 зүйл яг одоо санаанд орж ирж байна. Эхнийх нь мэдээлэл маш сайн түгээх. Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэйхүүхэд, залуучуудадзориулсан ийм тусгай сургуулиуд, ийм төрийн бус байгууллагууд, ийм төрийн байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна гэж мэдээлж болно. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудын төлөөлөл ингэж сурч боловсорч, ажиллаж хөдөлмөрлөж байна гэдэг зүйлийг бүр тасралтгүй мэдээлдэг байгаасай гэж хүсдэг. Мэдээлэлгүйгээсээ болоод хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ гэртээ байлгаж байгаа аав ээж, айл өрхүүд олон байгаа. Цэцэрлэгийн насны, 10 жилийн, бүр их дээд сургуулийн насны гэртээ байдаг залуучууд олон байгаа. Тэр хүмүүсийн эцэг эхчүүдэд зориулсан, тухайн хүмүүст өөрт нь чиглэсэн мэдлэг, мэдээллийг хангалттай хүргэж байгаасай гэж би боддог.

Нөгөө нь хууль эрх зүйн орчноо сайжруулахаас гадна, эргээд хяналт сайн тавьж байгаасай гэж хүсдэг. Жишээлбэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар үйл ажиллагаагаа явуулдаг төрийн бус байгууллага байна гэж бодъё. Энэ байгууллага ямар ямар үйл ажиллагаа явуулж, хэчнээн хүнд хүрч ажиллаж байна гээд тэр болгоныг эргээд хянадаг, тоо баримттайгаар дүгнэдэг тогтолцоотой болбол зүгээр гэж боддог.

Тэргэнцэртэй иргэдийн ариун цэврийн өрөөний асуудлыг шийдсэн түгээмэл загвар бий болгох судалгааны ажлыг 4 найзтайгаа хамтарч хийсэн. Энэ судалгааны ажлынхаа талаар танилцуулахгүй юу?

Өнгөрсөн 2020 оны сүүлээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн агентлагаас Засгийн Газрын дэмжлэгтэйгээр зохион байгуулагдсан эрдэм шинжилгээний хуралд өөрийнхөө судалгааны материалыг явуулсан. "Тэргэнцэртэй хүмүүсийг олон нийтийн байгууллагаар үйлчлүүлэхэд ариун цэврийн өрөөний асуудлыг хэр шийдэж өгсөн байна вэ?" гэдэг талаар судалгаа хийсэн юм. И-март гэх зэрэг томоохон ганц хоёр газрууд буюу маш бага хувь нь хүртээмжтэй ариун цэврийн өрөөг тохижуулсан байсан. Ихэнх газруудад тэргэнцэртэй хүн битгий хэл энгийн хүн ороод эргээд хаалгаа хаахад багтахгүй жижиг ариун цэвэр өртэй газрууд ч байсан. Зам нь болохгүй байна, налуу зам дутагдаад байна эсвэл ариун цэврийн өрөө нь болохгүй байна гээд их ярьдаг. Хууль дүрэм байгаад боловч яг энэ хууль дүрмээ танай байгууллага хэрэгжүүлж байна уу гэдгийг хянадаг тогтолцоо нь сул байна. Тийм учраас тухайн газрууд тэр



тал дээр анхаарахгүй орхигдуулаад байна гэсэн дүгнэлтэд бид хүрсэн. Ямар ч хүн ороод үйлчлүүлэхэд тохирсон, ашиглах боломжтой түгээмэл загварыг бид бий болгож хэрэгжүүлэх хэрэгтэй юм байна гэсэн санааг судалгаагаараа дамжуулж гаргасан юм.

Тэгвэл чиний бодлоор яагаад энэ байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг орхигдуулаад байна гэж боддог вэ? Хууль дүрэм нь сулаас болоод уу, юунаас болдог гэж боддог вэ?

Олон зүйл нөлөөлж байгаа байх. Хууль журмууд нь байдаг ч 100% хангалттай гэж хэлэхгүй, гэхдээ тодорхой хэмжээнд орон сууцны угаалгын өрөө ийм байх ёстой, барилгуудын угаалгын өрөөний талбай ийм байх ёстой гээд олон стандартууд байдаг. Жишээлбэл явган хүний зам картелин замтай байх ёстой байдаг. Гэхдээ сая хэлсэнчлэн эргээд энэ шаардлагуудаа биелж байна уу гэдгийг хянаад, хариуцлага тооцох тогтолцоо сул байна. Нөгөө талаар тухайн барилга, зам, дэд бүтцийг бий болгож байгаа хүмүүс мэдээлэл дутуугаас тухайн барилга, замыг хэнд зориулж барьж байгаа вэ гэдгээ хангалттай бодож үзэхгүй байна. Зам дээр хүн болгон алхаад явах юм шиг, хүн болгон урдах замаа хараад алхах юм шиг бодож хийснээс болоод алдаатай, стандартын бус дэд бүтцүүд олноороо бий болсон байх. Гадаадын улс орнуудад бол энд харааны бэрхшээлтэй хүн явна, тэргэнцэртэй хүн явна гээд бүгдийг нь тооцоолж байж хийж байгаа учраас стандартын дагуу болдог гэсэн үг.

Монголд тэр нь дутмаг, тооцохгүй л байна гэсэн үг юм байна, тийм үү?

Тийм, миний хувьд бол яг тэгж л харж байгаа.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд маань ч, жирийн иргэд ч гэсэн мэдлэг мэдээллээр дутмаг байгаа гэж сая хэллээ. Тэгэхээр яг яаж хүмүүст мэдээллийг түгээж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ийм тусгай хэрэгцээ шаардлага байдаг, хөгжлийн бэрхшээлтэй ч гэсэн биднийг хамгаалж байгаа хууль дүрэм байдаг гэдгийг хүмүүст таниулах ёстой гэж боддог вэ?

Миний бодлоор бүх зүйл цахимжсан энэ үед магадгүй цахим хуудас байх ёстой. Ямар ч хөгжлийн бэрхшээлтэй хүн эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар мэдээлэл хайж байгаа хүн хандах боломжтой цахим хуудсыг хөгжүүлэх хэрэгтэй. Тэндээ төрөл бүрийн мэдээллүүдийг тасралтгүй оруулдаг, хөгжүүлдэг байх хэрэгтэй. Дээрээс нь тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын эцэг эхчүүдэд зориулсан сургалтууд сайн зохион байгуулдаг байгаасай. Бас 10 жилийн хүүхдүүдэд зориулж хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар сургалт зохион байгуулдаг байгаасай гэж бодож байна. Монголд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад зориулсан төрийн болон төрийн бус байгууллагууд олон байдаг.

Тэгэхдээ үйл ажиллагаа нь хэр том цар хүрээг хамарч байна вэ гэдэг нь их чухал асуудал байдаг. Тийм болохоор хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай сургалт гэхээр л хөгжлийн бэрхшээлтэй хүнд, хөгжлийн бэрхшээлтэй хүний эцэг эхэд хийх ёстой биш, тэр сургалтыг нийгэм даяар нь хүн болгонд зориулж хийх хэрэгтэй. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар контент хийх гэж байгаа бол түүнийг нийгэмдээ, хүн болгонд зориулсан байдлаар хийвэл дээр байх. Цэцэрлэгийн хүүхдүүдэд зориулсан контент яагаад байж болохгүй гэж? Тэгвэл мэдээлэл илүү нээлттэй, хүртээмжтэй, нийгэм даяараа тэгш олж авах боломжтой.

Ямар контент байвал хүмүүст их хүрнэ гэж боддог вэ?

Төрөл бүрийн зүйл байж болно. Хамгийн энгийн жишээ бол хүүхэлдэйн кино байна. Хүүхэлдэйн кинонд яагаад нэг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дүр оруулж болохгүй гэж? Тэгвэл ийм хүн байдаг юм байна гээд цэцэрлэгийн насны хүүхдүүд нь мэдээд эхэлнэ. Магадгүй 5 найзын тухай хүүхэлдэйн кино хийлээ гэхэд тэдний 1 болох харааны бэрхшээлтэй хүүхэд брайлаар бусаддаа ном уншиж өгч болно. Хийж байгаа бүх зүйлдээ хөгжлийн бэрхшээлтэй, бэрхшээлгүй бүгдийг тэгш хамруулсан, аль болох зөв өнцгөөс харуулсан байх хэрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэхээр л халамж шаардлагатай, асаргаа хэрэгтэй хүн гэдэг талаас нь биш, харааны бэрхшээлтэй хүн ном уншиж чаддаг, тэргэнцэртэй хүн бүжиглэж чадна гээд төрөл бүрийн зүйл хийх боломж байгаа гэж бодож байгаа.

Маш гоё санаа гаргаж ирж байгаад баярлалаа. Лхамсүрэн маань сургуулиа төгсөхөд ажлын байр хэр хангалттай байгаа гэж бодож байгаа вэ?

Ажлын байрны хувьд болох байх гэж бодож байгаа. Миний хувьд 10 жилийн сургууль биш бол сургалтын төвд ажиллах байх. Ямартай ч багш болчихоод мэргэжлээрээ ажиллана, харааны бэрхшээлтэй багш болчихоод зөвхөн харааны бэрхшээлтэй хүүхдүүдэд багшлах биш, нийгэмд ажиллаж хөдөлмөрлөөд бид нарт сураад явах боломж бий шүү гэдгийг харуулахын тулд илүү нийгэм рүүгээ чиглэж ажиллахыг хичээж байгаа.

Цаашдын хүсэл мөрөөдөл нь юу вэ?

Цаашдын хүсэл мөрөөдөл гэвэл мэдээж боловсролын салбартаа ажиллана. Маш олон хүүхэд залууст чанартай боловсрол олгосон, дээрээс нь нийгмийг бүх л хүрээ, бүх л талаас нь зөв харж ойлгодог бие хүнийг бэлтгэхэд өөрийнхөө чадах чинээгээр хөрөнгө оруулалт хийхийг хүсдэг. Магадгүй би 10 жилд энгийн хүүхдүүдэд багшлахад надаас төгссөн шавь нар маань харааны бэрхшээлтэй хүн, харааны бэрхшээл гэдэг зүйлийн талаар эерэг ойлголттой болж цаашдаа над шиг хүмүүстэй хамтраад ажиллах, үйл ажиллагаа хэрэгжүүлэхдээ харааны бэрхшээлтэй хүмүүсийн талаар мартдаггүй хүмүүсийг бэлтгэх хүсэлтэй байдаг. Төсөл

хэрэгжүүллээ гэхэд тэнд заавал хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар тусгадаг, зөвхөн би, бид гээд хүн болгон алхаад, хараад явна гэдэг өнцгөөр хардаг биш. Энд тэргэнцэртэй, харааны бэрхшээлтэй, таягтай, таяггүй хүн амьдарна, энгийн хүн ч амьдарна гэдэг зүүлийг бодож чаддаг тийм сэтгэлтэй хүмүүсийг бэлтгэхэд өөрийнхөө зүгээс бага ч гэсэн хувь нэмэрээ оруулахыг хүсэж байна. Энэ бол миний амьдралын хамгийн энгийн бөгөөд том мөрөөдөл юм.

Аймар гоё мөрөөдөл байна. Би ч гэсэн тийм зүйл мөрөөдөж байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэхээр зарим хүмүүс халамж хүссэн гэдэг байдлаар сөрөг хандлага, ялгаварлан гадуурхалт ажиглагддаг. Чиний хувьд ямар санагддаг вэ?

Миний бодлоор дээрдэж байгаа гэж боддог. Хүмүүсийн хандлага маш их өөрчлөгдөж байгаа. Өчигдөрхөн би нэг эгчтэйгээ ярьж байхад би фэйсбүүк ашиглаж эхлээд 4 жил өнгөрсөн байна. Тэгэхэд та нар ашиглаж эхлээд хоёрхон жил өнгөрсөн. Хэрэглэж байгаа төвшинг нь харахаар та нар бараг надаас илүү ашиглаж байна гэж хэлж байсан. Утас байгаа ч гэсэн фэйсбүүк орохгүй бол бараг утас чинь хэрэггүй болчихсон байгаа биз дээ? гээд асуусан чинь, харин тийм байна, фэйсбүүк их хэрэгтэй байдаг болчихож. Төрөл бүрийн ажлаа амжуулж, амарч суухдаа хүртэл фэйсбүүкийнхээ мэдэгдлийг шалгадаг гэсэн. Ер нь хүн болгоны амьдрал ийм болчихсон байгаа. Зөвхөн залуу хүмүүс гэлтгүй бүр 50-иас дээш насныхан эрчимтэйгээр цахим сүлжээг ашиглаж байна. Үүний үр дүнд зөв контент орж уздэг, зөв мэдээлэл хүлээж авдаг хүмүүс бас их байгаа. Мэдээж хэрэг эсрэг хүмүүс байгаа л даа. Гэхдээ хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон бусад нийгмийн цөөнхүүдийн талаар харьцангуй эерэг үзэл хандлагатай болоод байгаа гэж би харж байгаа. Тодорхой хэмжээнд жижиг сажиг үл ойлголцол, зайгаа барих асуудлууд байна. Гэхдээ тэр маань яг гадуурхаж байя, энэ хөгжлийн бэрхшээлтэй хүн юу хийж чаддаг юм гэсэн өнцгөөс илүүтэйгээр яаж харьцах учраа олохгүй байдаг байж магадгүй юм. Магадгүй намайг сууж байхад над дээр ирээд хөөе сайн уу гээд мэндлэхэд яах билээ гээд санаа зовсон, биеэ барьсан тохиолдлуудаасаа болоод зайгаа барих зүйлүүд хааяа ажиглагддаг. Бусад нүүрэмгий хүмүүс бол сайн уу гээд хүрч ирээд л мэндлээд л, намайг таньж байна уу, миний хоолойг таньчихсан уу ч гэдэг байдлаар харьцаад явчихдаг.

Чамд нүүрэмгий хүмүүс шиг харьцаад явах нь гоё байдаг уу?

Ер нь тийм. Ганцаараа байж байхад хааяа хүмүүс орж ирээд яах учраа олдохгүй байгаа юм шиг дуугарахгүй уддаг. Би аймаар гайхдаг. Намайг яриад эхлэх юм бол зүгээр ярьдаг. Тэгэхээр тэр бол аймаар том асуудал бол биш, жижигхэн хаалт байдаг. Тэгээд аль нэгийг нь эхлээд л сайн уу, юу байна гээд л яриад эхлэхэд нөгөөх нь тэр хэрээр чөлөөтэй мэдрэмж аваад хооронд нь харилцан яриа үүсэж байдаг.

Монголын өнөөгийн нийгэмд амьдрахад харааны бэрхшээлтэй хүмүүст тулгардаг ямар саад бэрхшээл байдаг вэ?

Мэдээж хэрэг маш олон асуудал байгаа. Яг үнэнийг хэлэхэд зөвхөн харааны бэрхшээлтэй ч гэлтгүй Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хатуу ширүүн уур амьсгал гэдэг шиг энэ орчин нөхцөлдөө бараг дасчихсан байдаг. Хэчнээн зам чинь болохгүй байна, шон байна, тэргэнцэртэй хүн орох налуу замгүй автобус байна гээд яригддаг ч гэсэн тэр орчиндоо өөрийгөө авч яваад дасчихсан байдаг. Гэхдээ, ийм байлаа гээд орхиж болно гэсэн үг биш. Аль болох хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хангах, тэр хүмүүст боломжийг нь нээж өгөх талаас нь олон зүйлийг хийгээсэй хүсдэг. Мэдээж хэрэг маш олон асуудлууд байгаа ч гэсэн, миний хувьд хөгжлийн бэрхшээлтэй гэдэг нэр томьёоноос болоод мэдээлэл авч чадахгүй, сургуульд сурч чадахгүй байгаа хүүхэд багачуудад л илүү анхааараасай гэж хүсдэг.

Тухайн хүүхдүүд маань яагаад сургуульд сурч чадахгүй байгаа гэж боддог вэ? Энэ хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй юм чинь сургаад яах юм гэсэн эцэг эхийн хандлагын нөлөө байна уу эсвэл тухайн хүүхдийг сургах тохиргоотой орчин нь бүрдээгүй байна уу?

Хүн болгонд өөр өөр шалтгаанууд байгаа байх. Миний бодлоор хүүхдээ сургуульд сургахгүй байгаа тохиолдол хөдөө орон нутагт илүү олон байгаа гэж бодож байна. Яагаад гэвэл Монголд харааны бэрхшээлтэй хүүхдэд зориулсан тусгай сургууль Улаанбаатар хотод ганцхан байдаг. Тэгэхэд харааны бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүдийн хэд нь хүүхдээ тийш нь шууд явуулаад, дотуур байранд байлгах хэмжээний зориг гаргах вэ? Бас хотод байнга байрлаад хүүхдээ зөөнө гэвэл хэцүү. Нөгөө талаасаа эцэг эхчүүдийн хандлагын асуудал бас байдаг. Би гаргасан юм, би хүүхдээ мэдэж байна. Би л хүүхдээ харж байхад болно. Миний хүүхэд өвдөлгүй, эрүүл гэртээ байж байвал болно гэдэг өнцгөөс ханддаг эцэг эхчүүд бас байгаа. Тийм хүмүүс байгаа бол таны хүүхэд шиг зуу зуун хүүхдүүд сураад, их сургуульд ороод, ажил дээр гараад бусдын адил амьдарч байгаа жишээнүүд олон байгаа гэж хэлмээр байна. Өөр нэг зүйл бол өмнө нь хэлж байсан мэдээллийн хомсдол. Үнэхээр болно шүү, ийм ийм боломжууд байна гэдэг мэдээлэл хүрэхгүй болохоор тэр хүмүүс мэдэхгүй байна. Хүн хэзээ ч сонсож, харж байгаагүй зүйлээ мөрөөддөггүй, тийм зүйлд хүсэж тэмүүлдэггүй. Тийм учраас аль болох тэр хүмүүст сонсгож мэдүүлэх ажлыг нийгмийн зүгээс их хэмжээгээр зохион байгуулах шаардлагатай гэж боддог.

Нийгмийн зүгээс тийм ажлуудыг зохион байгуулъя гэвэл хэн зохион байгуулах ёстой вэ?

Олон дагагчидтай инфлүэнсэр хүмүүст байгаа. Тэр хүмүүс яагаад энэ тухай ямар нэгэн зүйл ярьж, энэ тухай дуугарч

болохгүй гэж? Тэгэх юм бол хүмүүс мэдээд, дуулаад, сонсоод эхэлнэ. Инфлүэнсэр хүмүүсийг дагадаг хүмүүс тэр хүний хийж, хэлж, постолж байгаа бүхнийг их чухалчилж хүлээж авдаг учраас тийм хүмүүс оролцох нь зүйтэй байх.

Манай Лхамсүрэн шинэ залуу үеийн төлөөлөл, чамтай ижилхэн маш олон залуучууд байгаа. Нийлж байгаад өөрийнхөө үеийнхэндээ зориулаад нэг тийм юм хийх юмсан гэж хүсдэг зүйл бий юу?

Яг залуучуудад гэхээсээ илүү миний хувьд хүүхдүүдэд чиглэсэн зүйл хийхийг хүсдэг. Тэр тусмаа хөгжлийн бэрхшээлтэй гэж онцлолгүйгээр, хичээлийн хоцрогдол эсвэл ямар нэг шалтгаанаас болоод сургуульд сурч чадахгүй байгаа хүүхдүүдэд хүрч ажиллах юмсан гэсэн мөрөөдөлтэй байдаг. Одоогоор бол хэзээ, яаж, юу хийх вэ гэсэн бодол байхгүй байна. Магадгүй тийм хүүхдүүдэд зориулсан гоё сургуультай болох эсвэл ямар нэгэн байдлаар хүүхдүүдэд чиглэсэн л үйл ажиллагаа аль болох хэрэгжүүлэх юмсан гэж боддог.

Өмнө нь хардаг байж байгаад, дараа нь аравдугаар ангиасаа хараа нь бүр муудаад ирэхэд магадгүй сэтгэл санааны цохилтод ч юм уу, хямралд орсон ч байж магадгүй л байх. Анх сэтгэл зүйн хувьд ер нь ямархуу байсан бэ? Тухайн үеийн сэтгэл зүйл хямралтай байдлаа хэрхэн яаж давж гарч байсан бэ?



Сэтгэл зүйн хувьд харааны бэрхшээлээс болоод эсвэл бага багаар хараа муудаж байгаагаас болоод сэтгэл зүйн хямралд орж байсан үе бараг байхгүй. Би өөрөө тэгж асуудлыг хүндрүүлээд бодоод байх дургүй. Хамгийн их хямарч байсан үе бол 9-р ангид байхдаа сургуулиас гарах шийдвэр гаргаж байсан. Яагаад гэвэл би 8-р ангиа төгсөхөд миний хараа нэлээн муудчихсан байсан. Бичих, унших боломжгүй, өөрийнхөө тэмдэглэлийг ч эргүүлээд уншиж чадахгүй болсон. Тэнд миний нууцууд их байдаг. Магадгүй миний тэмдэглэлийн дэвтрийг хэн нэгэн аваад унших юм бол би харахгүй учраас нууцаа алдаж магадгүй гэж айгаад тэмдэглэлийнхээ дэвтрийг шатааж байх үед жаахан эмзэг тусаж байсан. Тэрний дараа сургуулиас гарах шийдвэр гаргаад нэлээн хэдэн сар хөдөө ээжтэйгээ, хаяа аавтайгаа байдаг байсан. Одоо бодоход тэр үед л их хямарч байжээ. Гол хямарч байсан асуудал бол харааны бэрхшээл гэдэг асуудал байгаагүй. Би сургуульд явж чадахгүй байна гэдгээсээ болоод их хямарч байсан юм шиг байна. Дүү нараа амралтын өдрүүдээр ирэхэд багш нарынх нь тухай яриаг сонсоно, бүр өмнөөс нь догдолно. Тэгээд явахад нь аймаар гунигладаг. Энэ тал дээр би ээж аавдаа маш их баярладаг. Би өөрөө сургуулиас гарна гэж хэлж байсан боловч манай ээж аав 2 намайг гаргаагүй зүгээр чөлөө аваад ирсэн байсан. Магадгүй тэр үед миний хуваарийг авчихсан бол өнөөдөр би хаана байж байхыг мэдэхгүй байна. Надад дахиад нэг сонголтыг гаргаж, сургуульд үлдээсэн хүмүүс бол яах аргагүй миний ээж аав хоёр. Тэгээд хэсэг хугацаа өнгөрсний дараа би үнэхээр сургуульд явахгүй байж чадахгүй юм байна гээд буцаад сургуульд орж байсан.

Хотод 116 дугаар сургууль руу шилжих санааг нь хэн гаргасан бэ?

Би ч, манай гэрийнхэн ч 116-р сургуулийн талаар нэлээн эртнээс мэддэг байсан. Манай ээж аав хоёр надтай ярилцаж байгаад л гаргасан байх. Яг чи ингээд яваарай эсвэл би ингээд явъя гэж хэлж байснаа бол сайн санахгүй байна. Ямартай ч та 2 судлаад үзээрэй гээд ээж аав хоёрт 1 удаа хэлж байсан. Дараа нь гурвуулаа ярилцаж байгаад аав бид хоёр очиж үзээд, албан ёсоор бүртгүүлээд орсон.

Чамайг 116-р сургуульд сурч байхад сургалтын чанар хэр санагдсан бэ? Тусгай хэрэгцээт хүүхдүүдэд шаардлагатай тоног төхөөрөмж, ном материал нь бүгд байсан уу, багш нар ч гэсэн чадвартай байсан уу?

Тоног төхөөрөмжийн хувьд гэвэл жилээс жилд нэмэгдээд, сайжраад явж байгаа. Брайль принтертэй ч болсон. Хүүхдүүддээ номоо файлаар хувиргаж өгөөд түүнийг нь хүүхдүүд уншдаг, дейзи тоглуулагчтай болсон. Техник технологийн хувьд ахиц гарч байгаа. Багш нарын чанарын хувьд гэвэл сайн багш нар байгаа. Тодорхой хэмжээгээр шинэ, залуу хүмүүс бас байгаа. Надад энэ тал дээр боддог юм гэвэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд боловсрол олгох багш нарыг илүү сайн

мэргэшүүлдэг болвол зүгээр санагддаг. Хэдий залуу хүмүүс ч гэсэн тэр хүмүүст ямар хүмүүстэй ажиллах, ямар хүүхдүүдэд мэдлэг олгох гэж байгаа талаар нь илүү гүнзгий ойлголт өгвөл зүгээр гэж боддог.

Сурч байхад үед нь ямар нэгэн хүндрэл гарч байсан уу?

Залуу багш нартай үе үе хүндрэл гардаг байсан. Брайлуудаа багш нар хоорондоо хольдог эсвэл мэдээлэл зүйн хичээл дээр хүндрэлтэй байх, математикийн брайль стандарт яг тогтоогүй зэрэг асуудлууд гардаг байсан. Манай ангийн нэг хүүхэд хуучин стандартаар бичдэг байхад, би шинэ стандартаа бичдэг. Нэг ёсондоо бид хоёр нэгнийхээ дэвтрийг уншихад ойлгохооргүй иймэрхүү асуудлууд байсан. Тийм болохоор яах аргагүй үнэлэлтээр стандарт тогтоох хэрэгтэй. Дээрээс нь шинэ багш нарт зориулсан илүү үр дүнтэй мэргэшүүлэх сургалт, дамжаа зохион байгуулах нь зөв байх. Ажиллаж байгаа залуу багш нарын ихэнх нь мэдлэггүй хүрч ирээд 2-3 жил өнгөрөхөд амьдрал дээрээс сурч, дадлагажиж байгаа гэсэн үг. Тэгэхээр тэр хугацаанд бас хүүхдүүдийг бодож үзэх хэрэгтэй.

Багш нар нь дандаа сургууль төгсөөд ирсэн шинэ багш нар байгаа юу?

Тийм, ихэнх нь шинэ багш нар байдаг. Монгол Улсын Боловсролын их сургуулийг эсвэл өөр ямар нэгэн их сургуулиас яг багшийн мэргэжлээр бакалавр зэрэгтэй төгсөөд ирсэн шинэ хүмүүс ирэх тохиолдол их байдаг.

Өөрсдийгөө тусгай хэрэгцээт хүүхдүүдэд хичээл заана гэдгээ ухамсарлаад бэлтгэлтэй ирвэл зүгээр тийм ээ?

Би харааны бэрхшээлтэй хүүхдүүдэд хичээл заана гээд тодорхой хэмжээнд хувь хүнийхээ талаас бодож үздэг байх. Гэхдээ тэрний өмнө дор хаяж ядаж 1 жилийн туршлагатай магадгүй брайлаа мэдчихсэн, таягны талаар мэдлэгтэй, өөр харааны бэрхшээлтэй хүмүүсийн ашиглаж болдог, сургалтад хэрэглэгддэг техник технологийн талаар мэдлэгтэй болсон байвал зүгээр байх. Хамгийн гол нь би энэ хүүхдүүдтэй яг ажиллана гэдэг сэтгэл зүйтэй болчихоод орж ирвэл их чухал.

Тийм сэтгэл зүйгүй байна гэдэг нь чамд яг юун дээр ажиглагдсан бэ?

Зарим тохиолдолд тухайн багш нарын зүгээс юу гэж хэлдэг вэ гэвэл ямар ч туршлага байхгүй, сайн мэдэхгүй, хичээж байгаа, сурч байгаа л гэдэг. Тэр нь үнэн ч гэсэн бид нарын зүгээс тодорхой хэмжээнд юм сурахгүй цаг хугацаа өнгөрч байвал энэ бол хохирол байдаг. Тийм учраас аль болох болгоё, бүтээе, би мэдэхгүй байгаа бол суръя гэдэг хүмүүс байх хэрэгтэй гэж санагддаг.

Ерөнхийдөө подкастын маань цаг өндөрлөх дөхөж байна. Ковид цар тахлын нөлөө чамд болон танай гэр бүлд хэрхэн тусаж байгаа вэ?

Ер нь бол нэлээн хүнд тусаж байгаа. Вакцин хийлгэсэн. Манай ээж аав хоёр

малчин хүмүүс учраас отор хийгээд хөдөө явчихсан, би төв дээр гэртээ ээж ааваасаа хол байгаа. Ковид цар тахлын хөл хорио, тохиолдлууд нэмэгдээд байхаар наашаа цаашаа байнга яваад ээж аавтайгаа уулзаад байх боломжгүй болсон. Дээрээс нь дүү нарын маань хичээл сургууль нь нэлээн хоцрогдчихсон асуудлууд байгаа. Ерөнхийдөө бусад хүмүүст нөлөөлж байгаа хэмжээгээр л нөлөөлж байна.

Хүнсээ цуглуулах эсвэл гадуур гарах үедээ хэн нь гардаг вэ?

Одоогийн байдлаар би дүүтэйгээ хамт байгаа болохоор манай дүү шаардлагатай үед гараад хэрэгтэй зүйлээ цуглуулж байгаа.

Цар тахлын нөлөөгөөр нэлээн олон хүн санхүүгийн хүндрэлтэй учирч байна. Чамд тийм зүйл мэдрэгдэж байгаа болов уу?

Хотод байхад бол мэдрэгдэж байсан. Би өвөл дотуур байрандаа карантины үеэр байж байхад яах аргагүй санхүүгийн хүндрэл тулгарч байсан. Хоол хүнсний тусламжийг оюутнуудад тарааж тодорхой хэмжээнд дэмжсэн. Гэртээ ирснээс хойш бол харьцангуй гайгүй болсон. Гэртээ байгаа хүнд их зарлага гарахгүй, ер нь бол гайгүй байгаа.

Манай подкастад орсон Лхамсүрэндээ маш их баярлалаа. Тэгээд зөндөө гоё гоё ярианууд ярьсан. Бас цаашид хүмүүс бид нарт ч юм уу, бид нар цаашид юун дээр анхаарах талаар контент ч юм уу, хүмүүст хүргэх гоё санаануудыг гаргаж ирсэн Лхамсүрэндээ маш их баярлалаа. Цаашдын сурлага, хөдөлмөр, мөрөөдөлд нь томоос том амжилтыг хүсье ээ!

За баярлалаа. Ахиад танай подкастын хамт олонд баярлалаа гэж хэлье. Та нарт ч гэсэн маш том амжилт, эрүүл энхийг хүсэж байна.

СУРАГЧИД МААНЬ ӨӨРИЙН ЭРХГҮЙ ХАЙР ТАТСАН



Э.Энхзул

Сайн байцгаана уу, эрхэм хүндэт сонсогчид оо, Антолд подкастын маань ээлжит дугаар эхлэхэд бэлэн болоод байна. Энэхүү дугаарт Нийслэлийн 116 дугаар сургуулийн бага ангийн багш Энхзул оролцож байна. Та урилгыг минь хүлээн авч манай подкастад орохоор болсонд маш их баярлалаа.

Та манай сонсогчдод өөрийгөө товч танилцуулахгүй юу?

За баярлалаа. Танай урилгаар энэхүү ярилцлагад орох гэж байгаадаа би ч бас маш их баяртай байна. Би 1987 онд Багшийн сургууль төгсөөд бага ангийн багш мэргэжил эзэмшээд анх 25 дугаар тусгай сургуульд багшаар очиж байсан. Тэр цагаас хойш би ерөнхий боловсролын сургуульд багшлаагүй дандаа тусгай сургуульд оюуны бэрхшээлтэй, харааны бэрхшээлтэй хүүхдүүдтэй 34 жил ажилласан байна. Ирэх жил 35 дахь жилдээ ажиллаад тэтгэвэртээ гарах хүсэлтэй байгаа.

Та анх их сургуулиа төгсөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд багшлахад ямар санагдаж байсан бэ?

Мэдээж 1987 онд социализмын үед би өөрөө 20 настай байсан. Би Улаанбаатар хотын тавдугаар 10 жилийг төгссөн. Намайг бүр хүүхэд байхад л хотод сурлага тааруу эсвэл сахилга батаар доголдолтой хүүхдүүдийг мэдрэлийн 25-д шилжүүлнэ гэж айлгадаг, шилжүүлж суралцуулдаг байсан. Тэгээд би тусгай сургууль гэж юу вэ гэдгийг мэддэггүй байж байгаад 25-р

сургуульд хуваарилагдсан. Тухайн үедээ би яаж ажиллах юм бол гээд маш их айдастай байсан. Тэнд дандаа мэдрэлийн өвчтэй хүүхдүүд байгаа, би ажиллаж чадахгүй гээд л үнэндээ томилолтоо аваад уйлж байсан. Гэхдээ Улаанбаатар хотод хуваарилагдаж үлдэнэ гэдэг тэр үед бараг байдаггүй, дандаа хөдөө хуваарилагддаг байсан. Ямар ч байсан хотод хуваарилагдсан юм чинь түр ажиллаад өөр сургууль руу шилжинэ гэсэн бодолтой очиж байлаа. Очоод 2-р анги дааж аваад ажилласан. Тэгсэн юун миний төсөөлж байсан шүлсээ гоожуулсан, мэдрэлийн өвчтэй хүүхдүүд биш, хэчнээн хөөрхөн, үнэнч хүүхдүүд байсан гээч. Мэдээж ахуй, сурлагаар нэлээн хоцрогдчихсон байсан. Зарим хүүхдүүд эмчийн оноштой нэлээн хүнд, өөрөөсөө атгачихсан ийм өвчтэй байсан. Тэрнээсээ болоод юмыг хүлээж авах хугацаа нь удаан л болохоос тэгж хүн айгаад, сүрдээд байхаар хүүхдүүд байгаагүй. Мэдээж би дөнгөж багш болоод очсон болохоор надад ажлын туршлага гэдэг зүйл байхгүй. Тэгээд ямар ч байсан ахмад багш нараараа заалгадаг байсан. Намайг багш болоод очиж байхад манай хичээлийн эрхлэгч Магвандорж гээд нэлээн чанга багш хүн байсан. Тэр багшийн удирдлага дор би ажиллаад л, айх, шантрах ч үе зөндөө байлаа. Ер нь болъё доо, өөр сургуульд ажиллая, болохгүй бол хөдөө очиж ажилласан ч яахав гэсэн бодолтой ч байлаа. Гэхдээ



үнэхээр энэ хүүхдийн гоё энерги, хүүхэдтэй ажиллах сайхан ажил өөрийн эрхгүй намайг багш болгож нэг мэдэхэд л би 25-р сургуульд он удаан жил ажилласан, маш олон хүүхдүүдийг сургаж хөгжүүлээд амьдралын замд нь гаргасан, нэлээн туршлага хуримтлуулсан багш болчихсон байна. Яагаад би энэ сургуулийг орхиод явчихаагүй юм гээд өмнөх үеэ эргээд дурсахад маш их баярладаг. Үнэнхээр би энэ тусгай сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй 34 жил ажилласандаа өөрөөрөө бахархмаар ч юм шиг санагдаж байна.

Тухайн үед танд юу нөлөөлөөд сургуульдаа үлдэхээр болов?

Ерөөсөө л хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн өөрсдийнх нь хүний сайхан хайр татсан байдал. Би энэ хүүхдүүдтэй ажиллаж, энэ хүүхдүүдийг амьдралын замд нь хүргэхийн тулд ажлынхаа хажуугаар өөрийгөө маш их хөгжүүлж, өөрөө маш их хичээж ажиллах хэрэгтэй байсан. Маш завгүй ч ажилладаг байлаа. Тэгээд энэ хөөрхөн хүүхдүүдийн хүчинд л ёстой шантраагүй ажиллаж ирсэн.

Тухайн үед таныг их сургуульд сурч байхад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд ингэж заах ёстой гэсэн тусгай хичээл орж байсан уу?

Орж байгаагүй. Ерөөсөө л би бага ангийн багшаар анх төгссөн. Тухайн үед бага ангийн багш бүх хичээлүүдийг заадаг байсан. Тэр хичээлүүдийг л заах арга зүй, сэтгэл судлал сурган гэж орж байснаас хэрвээ танай ангид хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байвал энэ аргаар ажиллана гэсэн арга зүй тухайн үед өгдөггүй байсан. Тэгээд ажил дээр гараад, хүүхдүүдтэй ажиллаад, ажлын явцад согог зүй, тусгай сурган гэдэг зүйлээр суралцаад, өөрийн сургах арга барилаа олж авсан. Ажлын туршлага надад маш их нөлөөлсөн.

Одоо Монгол Улсын Их Сургуульд эсвэл багш бэлтгэдэг сургуулиудад тусгай хэрэгцээт сургалт шаардлагатай хүүхдүүдэд ингэж хичээлээ заах ёстой гэсэн арга зүй, нэмэлт хичээл ордог болов уу?

Одоо орж байгаа гэж бодож байна. Ерөнхий эрдмийн чиглэлийн хичээлүүдийг багш нарт тодорхой хэмжээний кредит цаг байгаа байх. Ялангуяа сэтгэл судлал сурганыг дагаад согог судлал, тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр хичээлүүд орж байгаа байх. Тэгэхдээ бол МУБИС дээр одоо бүр тусгай хэрэгцээт боловсролын багш бэлтгэх тусгай анги нээгдээд, хоёр ч төгсөлт болсон.

Одоо тэр ангийг төгссөн төгсөгч нар тусгай сургуулиудад багшилж байгаа байх, тийм үү? Өмнө нь таны үед бол улсаас хуваарилагдаад явдаг байсан бол одоо хүмүүс тэр сургуулийг төгсөөд сайн дурааараа ирж багшилж байгаа байх, тийм ээ?

Тийм. Намайг анх багш болоод очиж байхад бүх тусгай сургуулиудад Оросын

Холбооны улсад төгссөн согог зүйч, дептологичид байсан. Нэг сургуульд 7-8 согог зүйч, дептологичид байж бусад багш нартаа зааж сургаад явдаг байсан. Дээрээс нь Оросоос мэргэжилтэн ирж бид нарт сар болгон лекц сургалт явуулдаг байсан. Одоо ч тийм юм байхгүй, согог зүйчид маань бүгд тэтгэвэртээ суугаад явсан. Тэдний оронд ажиллах хойно бэлтгэгдсэн согог зүйчид бараг байхгүй болсон. Одоо ажиллаж байгаа цөөхөн хэдхэн согог зүйчид л байгаа байх. Тийм учраас манайх Монголдоо бэлтгээд эхэлсэн. Эхлээд Багшийн дээд сургуульд анги нээхээс өмнө тусгай сургуульд ажиллаж байгаа залуу багш нарыг 1 жилийн хугацаатай тусгай хэрэгцээт боловсролын багш гэсэн мэргэшсэнээр төгсгөж, диплом болгож байсан. Үүгээр ажиллаж байгаа нэлээн олон багш нар мэргэшиж авсан. Одоо бол бүр тусгай хэрэгцээт боловсролын багш бэлтгэх ангитай болчихсон учраас яваандаа манай тусгай сургуулиуд мэргэжлийн боловсон хүчнээр нэлээн сайн хангагдах байх гэж бодож байна. Ер нь гадаад харилцаа ч бас нэлээн сайжирч Эрхүү рүү 2 жилийн өмнө 2, 2 багш шалгаруулж аваад дээд сургуульд нь суралцуулж байгаа. Одоо эргээд энэ мэргэжлийнхээ багш нарыг бэлтгэх асуудалд нэлээн сайн анхаарал хандуулдаг болсон.

Сургалтын төвшин нь тусгай сургуулиудад ямар байгаа вэ? Тэд өмнө нь ямар байсан бэ?

Анх төгсөөд би оюуны бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллаж байсан. Намайг очиход ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, программ гэж тусдаа оюуны бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургуулиудынх тусдаа байдаг байсан. Тэр нь бүр боловсролын яамаар батлагдчихсан. Нэг ёсондоо үзэж байгаа хичээлийн агуулга, программаараа нэлээн хөнгөвчилсөн маягаар явдаг байсан. Одоо ч гэсэн тусгай сургуулиуд өөрийн гэсэн хөтөлбөр, төлөвлөгөөтэй явдаг. Мэдээж оюуны бэрхшээлтэй хүүхдийн сургууль бол нэлээн хөнгөвчилсөн хэлбэрээр явна. Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29-р сургууль, манай 116-р сургууль хоёрын ерөнхий эрдмийн хичээлүүдийн агуулга ерөнхий боловсролын сургуулийнхтай ойролцоо явдаг. Яагаад гэвэл эдгээр хүүхдүүд 12-р анги төгсөөд ерөнхий эрдмийн шалгалт өгөөд, их, дээд сургуульд элсэх бүрэн бололцоотой байдаг учраас ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөр төлөвлөгөөг нэлээн дагаж явдаг.

Сүүлийн жилүүдэд таны бодлоор тусгай боловсролын хувьд ямар ахиц дэвшил гарсан бэ?

Ер нь бол нэлээн ахиц гарч байна. Ялангуяа энэ хүүхдүүдийн сурах хөтөлбөр, төлөвлөгөөн дээр нэлээн шинэчлэлүүдийг хийж өгсөн. Жишээлбэл харааны бэрхшээлтэй хүүхэд гэхэд зөвхөн харааны нэ бэрхшээлтэй хүүхэд сурахгүй байгаа. Сүүлийн үед манай сургуулийн бага ангид харааны бэрхшээл дээр бусад бэрхшээл хавсарчихсан хүүхдүүд нэлээн олон



байна. Жишээлбэл манай анги 7 хүүхэдтэй. Энэ 7 хүүхдийн 6 нь давхар бэрхшээлтэй хүүхдүүд байна. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл харааны бэрхшээлтэй, давхар аутизм гэсэн оноштой эсвэл харааны бэрхшээлтэй, тархины саажилттай гэсэн оноштой хүүхэд байж байна. Мөн харааны бэрхшээл, оюуны хөнгөн хэлбэрийн бэрхшээлтэй ийм хүүхдүүд байж байна Гэх мэтчилэн давхар оношлогдоод ирж байгаа хүүхдүүд байна. Эдгээр хүүхдүүд ерөнхий боловсролын хөтөлбөрийг дагаж хичээллэх боломж байхгүй. Энэ хүүхдүүдэд тохирсон сургалтын төлөвлөгөө гаргаж өгөөд ажиллаж байгаа, хүүхдээ ойлгож сургалтынхаа агуулгаа бэлтгэдэг, сургалтаа явуулдаг ийм сайхан дэвшлүүд гараад байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нийгмээс айхтар тусгаарлахаа больсон. Манай төр засаг, боловсролын яам тусгай сургуулиудаа их сайн дэмжиж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдээ сургаж хүмүүжүүлэх тал дээр маш их анхаарал тавьж ажилладаг болсон байна. Багш

нар бид мэдэгдэхүйц ахиц, өөрчлөлт гарч байгаад их баяртай байдаг. Цаашид ч гэсэн нэлээн ахиц өөрчлөлтүүд гарах байх гэж бодож байгаа. Бас дутагдаж, гачигдаж байгаа бэрхшээлтэй зүйлүүд ч бас байгаа. Гэхдээ дандаа хуучнаараа байгаад байхгүй ямар ч байсан ахиц өөрчлөлт сайн гарч байгаа.

Таныг хичээл зааж байх хугацаанд ямар хүндрэл бэрхшээлтэй талууд гарч байсан бэ?

Бид нар нэгдүгээрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байхад хүүхдээ ийм өвчтэй байна, ийм бэрхшээлтэй байна гэж дурааараа эмчийн оношноос гадуур хамаагүй ярьж болохгүй. Энэ хүүхдүүдтэй ажиллахад хүүхэд болгон нэг төвшинд суралцаж ерөөсөө чаддаггүй юм. Тэгэхээр бид нар хүүхдээ маш сайн мэдрэх хэрэгтэй. Жишээлбэл энэ хүүхэд багаасаа ямар өвчнөөр өвдөж ирсэн бэ. Энэ хүүхэд ийм бэрхшээлтэй байгаа учраас би өөр хүүхдийн төвшинд авч үзэж ажиллаж болохгүй. Тэгэхээр энэ хүүхдэдээ яг тохирсон арга барилаар ажиллана гэсэн чиглэл бариад ажиллана. Гэтэл зарим хүүхдүүдийн онош буруу тавигдсан эсвэл тодорхой бус оноштой хүүхдүүд ирэхэд бид нарт их хэцүү байдаг. Өнөөдөр тооны хичээл дээр бид нар 100 доторх арифметик үйлдлийг үзэхэд зарим хүүхдүүд өөрийнхөө бэрхшээлээс болоод маш удаан хугацаанд ойлгох явдал гардаг. Тэр хүүхэдтэй маш өөр арга барилаар ажиллах ийм шаардлагатай болдог. Тэгээд хүүхдийн оношилгоо, сурах арга барилд нь зөв л хандаж явахгүй бол хүүхэд хохироох асуудал гарах гээд байдаг юм. Тийм учраас бид нарт мэдэхгүй, чадахгүй зүйлүүд бас нэлээн гардаг л даа. Гэхдээ ямар ч байсан орчин нөхцөлдөө тохируулаад, олон жилийн ажлын туршлага байгаа учраас хүүхдээ сайн судалж үзээд, өвчнийх нь онош, багаасаа хөтөлж явсан карт, өвчний түүхтэй танилцаж байж хүүхэдтэй ажиллах арга барилаа гаргадаг. Энэ бол бидэнд шууд сургалт руугаа ороход нэлээн бэрхшээл үүсгэдэг.

Хүүхдийг багаас нь оношийг нь зөв тавиад, энэ хүүхдийг яаж сайжруулах вэ, яаж сургуульд ороход нь бэлтгэх вэ гэдэг зүйлүүдийг анхнаас нь сайн хийгээд явчихвал сургуульд ороход хүүхдэд ч зовлон бага болно. Багш нарт ч гэсэн хүүхэдтэйгээ зөв ажиллаад ирэхэд нэлээн дөхөмтэй болдог. Энэ байдал нэлээн сайжирч байгаа байх л гэж бодож байна. Жишээлбэл манай сургуульд зарим хүүхдүүд оюуны хөнгөн хэлбэрийн оноштой байхад зарим нь хүнд хэлбэрийн оноштой хүүхдүүд байдаг. Хэдий хүнд хэлбэрийг оноштой ч гэсэн багш тэр хүүхэдтэй ганцаарчлаад ажиллаад байхад тодорхой хэмжээнд ахиц мэдрэгдэхгүй байгаа үед багш нар маш хэцүү болдог. Манай зарим эцэг эхчүүд их мундаг, ёстой хүүхдийнхээ төлөө ухтлээ л явдаг эцэг эхчүүд байдаг. Зарим нь бид нар бүр Америкт очоод хүүхдээ үзүүлээд оношийг нь тогтоолгоод үзлээ, Германд очоод ирлээ гэсэн эцэг эхчүүд байдаг. Тэгээд үзэхээр 10 настай хүүхдийн оюуны хэмжээ 2-3 настай хүүхдийн хэмжээнд байж байх

жишээтэй. Тийм оюуны төвшинтэй байгаа хүүхдийг бид нар эмчийн тавьсан онош мэдэхгүйгээс болоод маш их ачаалалтай сургах гээд хүүхдээ ядраагаад байдаг ийм зүйлүүд нэлээн байдаг. Тэгэхээр одоо манай Сэтгэцийн эрүүл мэндийн эмнэлэг судалгаа оношилгоогоо сайн тавиад байгаа ололттой талууд нэлээн байгаа. Ерөнхийдөө хүүхдийг л их сайн мэдэрч ажиллах багш бид нарт маш чухал байгаа юм. Тэрнээс ерөнхий боловсролын сургуулийн нэг ангид өнөөдөр 35 хүүхэд ороод ирлээ гэхэд 35-уулаа эрүүл саруул, дуу нь хангинаад л, ямар хөөрхөн цогтой хүүхдүүд орж ирж байна. Бүгдэд нь багш Б үсэг заагаад, үгнүүдийг уншуулахад бүгд сайхан жигдхэн суралцаад гарах бололцоо байхад манай тусгай сургуульд бол тийм бололцоо их хүнд байдаг. Нэг ангид хуульд заасны дагуу цөөхөн буюу 7, 8 хүүхэд байна, тэр байтугай 4, 5 хүүхэдтэй ч ангиуд байна гэж бусад хүмүүс сонсохоор гайхдаг. Хэдий тийм ч гэсэн яг энэ хүүхдүүдтэйгээ тулаад ажиллахад бид нарын ачаалал маш их, заавал туслах багш хэрэгтэй байдаг. Ганцаараа ажиллахад ажлын ачаалалтай их, хүүхдээ хүрэлцэх байдал хүндрэлтэй байдаг даа.

Та эцэг эхчүүдэд анхнаасаа бэлтгэлээ сайн хийгээд сургуульд орж ирэх хэрэгтэй гэж байна. Та хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдэд өөр ямар зөвлөгөө өгөх вэ?

Хотод бол эцэг эхчүүд хүүхдүүдээ янз бүрийн сургалт, сэргээн засах төвүүдээр багаас нь авч яваад хөгжүүлдэг. Бүр хөдөө орон нутагт байгаа, тэрнээс хол сумдад байгаа эцэг эхчүүд хүүхдүүдээ сэргээн засах, эмчилгээ сувилгаанд авч явах нь бас их ховор байдаг. Хүүхдээ байнга эмнэлэгт үзүүлж зөвлөгөө авах, эмчилгээ хийлгэх асуудлууд нь нэлээн хоцрогдонгуй байна. Үүнээсээ болоод хүүхэд өөрөө өөртөө үйлчлэх ахуйн хоцрогдол гэдэг юманд орчихдог. Хүүхдүүд 6 настай сургуульд ордог гэтэл хөдөө байгаа зарим хүүхдүүд 6 настай орж ирж чадахгүй байна. Эцэг эх нь энэ хүүхэд маань 6 настай, арай биеэ дааж хотод очоод сурч чадахгүй гэсэн айдастай байдаг. Түүнээсээ болоод хүүхдийг наснаас нь хэтрүүлж сургуульд оруулдаг. Жишээлбэл манай сургуульд 3 жилийн өмнө 14 настай, огт сургуульд сууж байгаагүй хүүхэд ирж байсан. Хүүхэд аль 7-8 жилийн өмнө сургуульд ороод, тодорхой хэмжээгээр боловсрол эзэмшээд явж байх ёстой байхад ахуйн хоцрогдлоос болоод тэр олон жил хохироод одоо ирж байгаа тохиолдлууд их байдаг. Тийм учраас эцэг эхчүүд хүүхдээ багаас нь сайн анхаар.

Анхаарал сайн тавина гэдэг чинь хүүхдээ байнга ажиглаж миний хүүхдийн хэл ярианы хөгжил нь ямар байна, хэдэн настайдаа бүрэн ярьж сурч байна, биеэ даагаад өөртөө үйлчилж байгаа байдал нь хэр байна, одоо 4 нас хүрч байхад оймсоо ч өмсөж чадахгүй, өмд, гутлаа эвхэж чадахгүй байна гэх мэт зүйл дээр дээр ажиглаж байгаач гэдгийг л би эцэг эхчүүддээ зөвлөдөг юм. Хүүхэд өөрөө өөртөө үйлчилж чадахгүй байвал сургуульд ороод маш их айдастай байдаг.

Тэрнээсээ болоод л уйлна, гэрээ санана. Манай сургууль чинь улсын хэмжээний сургууль учраас дотуур байртай, хүүхдүүд хөдөөнөөс ирээд дотуур байранд ордог. Тэгээд ирэхээр л хүүхэд их хэцүү болдог учраас хүүхдүүдээ бага наснаас нь эхлээд сайн юманд сурга, ялангуяа тэр ахуйн орчин нөхцөлд сайн сургаж л байх хэрэгтэй гэж бодож байна.

Хөдөө орон нутгаас ирж байгаа хүүхдүүд хэр их байдаг вэ?

Байлгүй яахав. Нэгэнт хүүхэд харааны бэрхшээлтэй, брайль үсгээр суралцах хэрэгтэй, ерөнхий боловсролын сургуульд суралцаж чадахгүй гэсэн эмчийн оноштой л бол ирнэ. Харин сүүлийн үед 6 настай хүүхдүүд нэлээн ирлээ. Тэрнээс өмнө дандаа нас хоцорч ирж байсан. Тэр их харамсалтай байдаг. Хүүхэд 10 настай 1-р ангид орж ирэх тохиолдлууд байна.

Магадгүй эцэг эхчүүд өөрсдөө хүүхдээ хол явуулахаар санаа нь зовдог эсвэл манай хүүхэд ингээд юм сураад, цаашид юу ч хийхэв гэсэн бодолтой хүмүүс зөндөө л байдаг байх. Та хэр их тулгарч байсан бэ?

Мэдээж хэрэг энэ олон жил янз бүрийн л ааш араншинтай, үзэл бодолтой эцэг эхчүүдтэй харьцаж байсан. Үнэхээр манай хүүхэд сургуульд сураад ямар цаашаа олигтой байх юм биш, эрдэмтэн болох гэж байгаа биш гэсэн хандлага байсан. Ялангуяа зах зээлийн ерэн хэдэн оны үед нийтээрээ л ард түмний амьдрал хүнд байсан. Тийм үед хүүхдүүдийг эцэг эх нь дур мэдээд хичээлд нь явуулахгүй хэдэн хоногоор алга болчихно. Нөгөө хүүхэд хичээлдээ ирсэнгүй яав гээд л бид нар гэр орноор нь явахад, нөгөө муу хүүхдүүдийг зах дээр юм заруулаад суулгачихдаг эсвэл ажил хийлгээд явуулчихдаг. Гэр хороололд байдаг бол айл амьтны ус авч, түлээ модыг нь хагалж өгч хэдэн төгрөгөө олуулдаг байсан. Боловсрол олгох гэхээсээ илүү хүүхдүүдийг гэр орны хар бор ажилд эсвэл насанд хүрээгүй хүүхдийг хэтэрхий хүнд хөдөлмөр эрхлүүлсэн байдалд маш их оруулдаг байсан. Энэ байдал сүүлийн үед байхгүй болсон.

Гэхдээ бас буруу үзэл бодолтой эцэг эхчүүд одоо ч гэсэн байдаг. Тэгээд “хүүхэд ингээд байна, та нар хүүхдэдээ анхаарал тавиарай, багш ингээд ажиллаж байна, энэ хичээл ийм хөтөлбөр үзэж байгаа шүү, одоо хүүхэд дээр ингэж анхаармаар байна” гээд санал тавихад “өө яахав яахав, наад хүүхэд чинь өөрөө ингээд байдаг юм, яршиг” гээд хайхрахдаггүй эцэг эхчүүд байдаг. Хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй, өвчтэй байлаа гээд эцсийн эцэст тэр хүүхдийн ч, эцэг эхчүүдийн ч буруу биш. Тэгэхээр хүүхдээ ойлгож, “миний хүүхэд хэнээс ч дутахгүй суралцаж, хэнээс ч дутахгүй амьдрах ёстой” гэдэг үзэл бодлоор хүүхдээ хайрлаж, хүүхдэдээ анхаарал халамжаа тавьж, хүүхдийнхээ асаргааг сайн хийж явах юм бол энэ хүүхдүүд ямар хөөрхөн гэж бодно. Өнөөдөр би гучин хэдэн жил ажлаасаа хөндийрч халшраагүй ажилдаа дуртай болсон энэ зүйл маань цэвэр хүүхдүүдийн



л ач гавьяа. Хүүхдүүд намайг өнөөдөр ийм болгосон. Тэрэн шиг өнөөдөр хүүхэд болгон эцэг эхээ баярлуулж, хүүхэд болгон сайн хүн болж явах ёстой. Энийг л эцэг эхчүүд сайн хараасай гэж би боддог. Тэрнээс хөгжлийн бэрхшээлтэй бол цаашаа олиггүй явна гэсэн тийм бурангуй ойлголттой эцэг эхчүүд байвал одоо алдаагаа засаарай. Таны хүүхэд бол бусдаас содон мундаг хүүхэд шүү гэж би хэлмээр байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд таны бодлоор боловсрол хэр чухал вэ?

Маш их чухал. Ялангуяа хүүхэд өөрөө өөртөө тохирсон боловсролыг зөв авна гэдэг л бол их чухал. Тэрнээс нийтийн дунд суулгаад "энэ өнөөдөр чадаж байхад, чи чадахгүй байна" гэсэн үзлээр хандаж болохгүй. Хэдийгээр одоо бусад хүүхдүүдтэй хамт суралцаж байсан ч тэр хүүхэд яг өөртөө тохирсон боловсролоо л зөв авсан байх ёстой. Тэгэхэд л тэр хүүхэд том болоод өөрөө өөрийгөө аваад явах, ажил хөдөлмөр эрхлэхэд нь маш том хувь нэмэр болно. Хүүхдийг багад нь үл тоомсорлож, хаяж болохгүй.

Тэр эцэг эхчүүдэд яаж нөлөөлвөл эерэгээр хүлээж авч, миний хүүхэд ч гэсэн цаашаа сурч хөгжих боломжтой юм байна гэсэн гарц гаргалгаа танд байдаг уу?

Намайг залуу байхад манай улсын гурван яамны хамтарсан судалгааны баг гэж байдаг байсан. Эрүүл мэндийн яам, Нийгмийн хамгааллын яам, Боловсролын яамнаас хамтраад жилд 1 удаа Монгол улсынхаа бүх аймаг, сумуудаар явж хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн судалгаа хийдэг байсан. Тэр судалгаанд ямар бэрхшээлтэй, хэдэн хүүхэд байна, эдгээр хүүхдүүд сургуульд орох хугацаа болсон уу, сургуульд хамрагдсан уу, сургуульд ороход бэлэн үү, цэцэрлэгт явж байна уу? гээд бүх талаас нь судалгаа хийгээд жил болгон тоон дүн гаргаж, түүндээ тулгуурлаад хүүхдүүдийг боловсрол эзэмшүүлэх, эмчилгээнд явуулах бүх асуудлыг шийддэг байсан. Тэгээд 90-ээд оны үед тэр комисс дахиж ажиллахаа больчихсон. Хэрвээ одоо яг энэ судалгаа оношилгооны баг яг өмнөх шигээ гурван яамныхан явбал тэнд эмч, багш, нийгмийн халамжийнхан явж байна.





Тэгэхээр эдгээр хүмүүс явж байхдаа л хүүхдүүдийг судлаад, аймаг сумуудын нийгмийн халамжийн байгууллага, боловсролын байгууллагуудтай уулзаж ярилцах, эцэг эхчүүдийг дуудаж сургалт, зөвлөгөө өгөх ажлуудыг сайн хийгээд байвал эцэг эхчүүд ойлгоно. Тэр хөдөө алслагдмал байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхчүүд ялангуяа малаа маллаад наашаа хот орж ирэх завгүй, хүүхдээ анхаарал тавих цаг хомс хүмүүс бол үнэхээр хэцүү байдаг. Тийм учраас нийгмээс эцэг эхчүүд, хүүхдүүд рүүгээ хандсан зөв үйл ажиллагаа нэлээн хийгдээсэй гэж би боддог. Тэгээд эцэг эхчүүддээ энэ ажлыг сайн ойлгуулах, ер нь дээд дээд шатандаа ч гэсэн боловсрол, нийгмийн хамгаалал хариуцаж байгаа хүмүүс, ялангуяа тэр хүүхдийг үзэж байгаа эмч бүр сайн ойлгуулж хэлж байх ёстой л гэж боддог.

Та магадгүй маш олон сурагчтай, олон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг төгсгөөд гаргасан байх. Таныг багшилж байх хугацаанд шантрах, за би ер нь чадахгүй юм байна гэсэн үе тулгарч байсан уу?



Дөнгөж багш болсны дараа тийм юм нэлээн байсан. Би чинь бүр хүүхдүүдээсээ хүртэл айдаг, уйлдаг байсан. Ялангуяа ахлах ангийн хүмүүжлийн жаахан доголдолтой эрэгтэй хүүхдүүд байдаг байсан. Дөнгөж хорьхон настай байсан болохоор тийм хүүхдүүдээсээ айдаг байсан. Ялангуяа оюуны бэрхшээл, хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар ерөөсөө ойлголтгүй байсан учраас шантрах зүйлүүд маш их байсан. Гэхдээ би эхний хоёр жилд л шантардаг байсан тэрнээс хойш тэгж шантарсан зүйл бол байхгүй. Тэгээд зах зээлийн үед их олон багш нар ажлаа орхиод, бизнес хөөгөөд явахад хэдхэн багш л үлдсэн. Ялангуяа манай тусгай сургуулиудад цөөхөн багш нар үлдсэн. Тэгээд бид нар өглөө нэг ангид хичээл ороод, үдээс хойш өөр нэг ангид хичээл заагаад явдаг байсан. Зарим үед ч бас орхиод бизнес хийгээд явдаг ч юм уу гэсэн бодол төрж байсан. Цалин маш багатай, ажиллаж байгаа орчин нөхцөл маань хүнд, ажил маань ачаалал ихтэй байсан. Манай нөхөр бас тусгай сургуульд багш хийж байгаад 1990 онд бизнес хөөгөөд явахад нөхрийгөө дагаад багшийн ажлыг орхих уу гэж бодож байсан уе байсан. Бид 2 ярьж байгаад 1 нь ядаж багшийн ажлаа хийгээд үлдсэн нь дээр гээд би үлдэж байсан. Одоо эргээд бодоход надтай хамт ажиллаж байсан багш нар маань их мундаг хүмүүс байсан. Ахмад багш нар Ялангуяа ахмад багш нар залуу багш нарыг маш сайхан сургадаг. Бид нар хэзээ ч ажлаа муу муухайгаар боддоггүй. Хэрвээ бодох тохиолдол гарвал ахмад багш нар бидэнд маш их юм ухуулж хэлдэг байсан. Тэгээд нэгэнт энэ ажлыг хийгээд, цалин хөлс авч байж энэ хэдэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээс ядарлаа зүдэрлээ гээд арчаагүй байдалтай байж болохгүй гээд ажлаа хийдэг байсан. Тэгээд нэг мэдсэн чинь би 34 жил ажилласан байна. Тийм муухай хүн айж шантраад, хаяж яваад байхаар ажил биш, би л лав ажилдаа дуртай. Харин би дахиад хэлэхэд намайг ажилдаа дуртай болоход энэ хүүхдүүд л тусалсан.

Танд энэ хугацаанд аймаар баярлаж байсан уе байгаа юу?

Байгаа шүү дээ, зөндөө л байгаа. Мэдээж бид нарын хамгийн их санаа зовоодог зүйл бол тусгай сургууль төгсөөд гарч байгаа хүүхдүүдийн ажил эрхлэлт, амьдрал. Одоо хүртэл бид нар тэр маань хаана, юу хийж яваа бол, тэр ажилд орсон болов уу, тэрний бие яагаа бол гээд байнга л төгсгөсөн хүүхдүүдээ боддог. Манай ангид 2000-аад онд төгссөн амьдрал нэлээн хүнд охин байсан юм. Тэр охин маань одоо нас нь



бараг 30 хүрлээ. Тэгээд уг нь бол айхтар хүнд оюуны бэрхшээлтэй тийм хүүхэд биш. Ахуй бол их хүнд, олон хүүхэдтэй, аав нь ажилгүй. Гэр нь 32-ын тийшээ гэр хороололд байдаг айл байсан. Аав нь архи их уудаг, ээж нь оёдлын үйлдвэрт ажилладаг, тэр гэрийг авч явах гэж эх нь их зовно. Нөгөө муу охин чинь өөрөө түнхний мултралттай, хөл муутай охин ээж нь шөнийн ээлжинд ажиллахад өдөржин шөнөжин ээжийнхээ хажууд суугаад л, ээжийнхээ ажилд туслаад л, маргааш нь хичээлдээ ирнэ. Заримдаа ч үнэндээ амьдралын бололцооноос болоод хичээлдээ ирэхгүй тохиолдол байдаг. Би тэр хүүхдэд их санаа зовж явдаг байж билээ. Тэгээд 9-р анги төгсөх улсын шалгалт өгөх болоход нөгөө хүүхэд маань хичээлдээ ирдэггүй. Тэгээд шалгалтын өмнө би бараг гэрийнх нь гадаа хонож байж маргааш нь хүүхдээ авч яваад шалгалтанд нь оруулаад ямар ч байсан энэ хүүхдүүдийг суурь боловсролын гэрчилгээтэй болгочихъё гээд явж байсан. Тэгээд л ямар ч байсан хүүхдээ би төгсгөөд, суурь боловсролын гэрчилгээтэй болгосон.

Нөгөө хүүхэд маань 11 дүгээр хороололд байдаг Сэргээн засах төвд оюутан анги төгсөөд, оёдолчин болоод Солонгост ажил хийж байгаа. Тэр багадаа амьдралын хүнд нугачаанд үйлдвэр дотор хонож ээждээ тусалж ажилладаг байсан хүүхэд ажлыг мундаг сурсан юм байна. Тэр охин одоо Солонгост маш мундаг ажиллаад, өөр шигээ маш ажилсаг залуутай суучихсан 2 хүүхэдтэйгээ их мундаг амьдарч байна. Солонгосоос ирээд багшаа байртай болсон, гэр орон маань ийм болсон гээд л гэртээ намайг оруулахад би ёстой нэг магнай хагартлаа баярлаж байлаа. Төгсгөсөн хүүхэд маань өнөөдөр ийм сайхан амьдралын замналд ороод явчихсан байхаар бид нар өөр юунд баярлах юм бэ. Санаа зовж байсан зүйлд маань ийм сайхан хариу ирэхэд баярлахаас өөр яах вэ. Заримдаа ч санаа зовоод одоо хүртэл толгойноос гарахгүй зүйлүүд байна. Маш хүнд өвчтэй байсан хүүхдүүд маань бие нь тааруу хэцүү, ажилгүй, амьдрал нь хүнд байгаа асуудал байна. Тэгээд л нөгөө жаргал зовлон ээлжилдэг гэдэг шиг бид нарын баярлах, санаа зовох, сэтгэл өвдөх асуудлууд ээлжилж байдаг.

Одоо ковид цар тахлын нөлөө энэ хүүхдүүдэд болон та хэдэд хэрхэн нөлөөлж байгаа вэ?

Ер нь манай сургуулийн хувьд их хүнд нөлөөлж байна. Яагаад гэвэл хүүхдүүдийн маань ихэнх нь хөдөө орон нутагт байдаг. Тэгээд бүр суманд байдаг болохоор бид нар гүүгл мэйтээр (google mate) хичээл заахад хүүхдүүд маань тэр болгон бүрэн хамрагдаж чадахгүй байна. Харааны бэрхшээлтэй хүүхэд гэдэг гүүгл мэйтээр багшийн оруулж байгаа хичээлийг үзээд, тийм амархан ойлгоод суух асуудал биш. Дээр нь энэ хүүхдүүд брайль үсгээр бичиж, уншдаг. Бодит зүйлийг харж чадахгүй, голдуу барьж тэмтрэх мэдрэмжээрээ мэдэрдэг хүүхдүүдийг зүгээр компьютер харуулаад сургалт явуулна гэдэг маш хэцүү асуудал. Тэгээд хөдөө бас их

хэцүү. Жишээлбэл Эх Орон телевизээр 3-р ангийн хичээл явж байхад зарим орон нутагт эх орон телевиз нь гарахгүй. Тэгээд өдөр 14.00 цагаас давталтыг нь арай хийж үздэг. Ухраагаад үзнэ гэсэн ойлголт ерөөсөө байхгүй. Манай ангийн хүүхдүүдээс гэртээ компьютертой хүүхэд байхгүй, зурагттай. Тэгэхээр миний гүүгл мэйтээр өгч байгаа сургалт дандаа сонсох хэлбэрээр явна. Сонсох хэлбэрээр явахад хүүхдүүд маань гар утас барина. Гар утас барихаар дата байхгүй их хэцүү юм билээ. Тэгээд ний нуугүй хэлэхэд сая хичээлээс нэлээн хоцрогдчихсон, маш хэцүү байгаа. Хэзээ танхимаар хичээллэж эхэлнэ тэр үед нэлээн нухаж байж хоцрогдлыг арилгахад бид нарт асар их хугацаа, ачаалал хэрэгтэй л болно доо.

Тэгвэл оюуны болон харааны бэрхшээлтэй хүүхдүүдийн онцлог нь юу байдаг вэ?

Мэдээж ерөнхий боловсролын сургуулийг бодвол шууд харьцах харьцаа манай хүүхдүүдэд маш хэцүү байдаг. Манай ангийн 7 хүүхэд гэхэд 7 өөр төвшний хүүхдүүд байдаг. Тэгэхээр би яг 20 минутад шинэ хичээлээ заачихаад, яг хүүхэд болгонд тохируулж сургалт, арга зүйгээ гаргаж хүүхэд болгонтой ажиллаж ойлгуулах ажилтай байдаг учраас ганцааарчилсан үйл ажиллагаа маш их хэрэгтэй.

Таны бодлоор одоогийн Монголын тусгай хэрэгцээт боловсролын төвшин хэр байгаа гэж боддог вэ?

Манай тусгай боловсрол гэдэг чинь тавин хэдэн жилийн түүхтэй. Социализмын үед анх тусгай хэрэгцээт боловсрол байгуулагдсан цагаасаа эхлээд Оросын сургалтаар явсан. Сүүлийн үед бол Ази талаасаа Япон, Солонгос улсуудын сургалтаас нэлээн олон арга зүй нэвтэрч орж ирж байгаа. Тэгэхээр бид нар янз янзын л туршлага авч хэрэглэж байгаа хэдий ч дэвшилт бол байгаа. Хэрвээ хууль эрх зүйдээ өөрчлөлт оруулаад, тэгш хамран сургах гэдэг зүйлийг баталчихвал мөрдөгдөж эхлэх байх. Энэ бол нэлээн ололттой зүйл гэж би бодож байгаа. Ерөнхий боловсролын сургуулиар суралцаад явах шаардлагатай хүүхдүүдийг заавал тусгай сургуульд тусгаарлах шаардлага байхгүй. Бололцоотой хүүхдүүдийг жирийн хүүхдүүдтэй ерөнхий боловсролын сургуульд нь сураад, үнэхээр тусгай сургуульдаа сурах шаардлагатай хүүхдүүд нь тусгай сургуульдаа, сэргээн засах төвүүд дээрээ суралцах хэрэгтэй байна. Хэрвээ ингэвэл манай тусгай боловсролын салбарт нэлээн ахиц гарна байх. Заавал орчин нөхцөлөө бүрдүүлж байж мөрдөнө гэхгүй мөрдөөд эхэлчихсэн байхад орчин нөхцөлөө бүрдүүлээд л ирэх байх. Ер нь сургалтын орчин бүрдэх тал дээрээ хэцүү. Жишээлбэл манай 6 тусгай сургууль гээд бодоход хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан цахилгаан лифттэй сургууль хоёрхон байна. Тэгэхэд бусад 5 давхар, 4 давхар, 3 давхар сургууль байж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд өнөөдөр тэнд очоод өөрийнхөө хүслээр суралцъя гэхэд орчин нөхцөл бүрдээгүй хэцүү зүйлүүд бол бий.

Хийгдэх ажлууд, анхаарах зүйлүүд нэлээн л их байгаа. Гэхдээ бид нар тийм байна гээд ярихаасаа илүү хийж хэрэгжүүлэх хэрэгтэй гэж бодож байна.

Одоо манай подкастын маань цаг өндөрлөх дөхөж байна. Танаас сүүлийн асуултаа асууя. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орчин нөхцөлийн талаар таны бодож явдаг зүйл юу байдаг вэ?

Би нийгэм рүүгээ хандаж их зүйлийг хэлмээр санагддаг. Яагаад гэвэл нэгэнтээ бид нарын дунд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байгаа тохиолдолд эдгээр хүмүүсийгээ хүүхэд багачууд, хөгшид залуучуудгүй бүгд л ойлгож, хайрлаж, дандаа тусалж дэмжиж байгаасай гэж би их хүсдэг. Ойлгож дэмжих асуудал хэдийгээр бас гайгүй ч гэсэн хүндрэлтэй асуудлууд их байдаг. Дээрээс нь манай байгууллагууд, үйлчилгээний газруудын



орчин бүрдүүлэлт муу байдаг. Жишээлбэл тэргэнцэртэй хүний шат гээд л маш гоё ярина. Нэг дэлгүүр рүү яваад ороход налуу зам хийчихсэн байгаа юм. Гэтэл тэр налуу замаар өнөөдөр тэргэнцэртэй хүн битгий хэл явган явж байгаа бид нар доошоо уруудаад л, гүйгээд л хэцүү баймаар маш огцом хийчихсэн байдаг. Налуу шат л хийгээд байгаа болохоос ерөөсөө дүрэм журмаар нь хийдэггүй. Гэтэл тэргэнцэртэй хүний зам гэдэг чинь налуу 15 билүү градусын налуутай гээд явдаг. Тэгээд бараг налуу зам дээр явж байгаа, үгүй нь мэдэгдэхгүй шахуу байдлаар хийдэг. Тэгж аюулгүй байдлыг хангаж хийх ёстой байтал хүний нүд хуурсан юмнууд маш их хийгдчихсэн байгаад нь маш их сэтгэл зовдог. Тэгээд тэр автобус унаанд ороход ямар хэцүү байна. Зарим хүмүүс үнэндээ л айж зугтдаг ийм байдлуудыг манайхан яваандаа ойлгож сайжрах байлгүй дээ. Монгол улсад ялангуяа энэ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулагдсан тусгай хэрэглэгдэхүүн маш ховор байдаг. Жишээлбэл харааны бэрхшээлтэй хүүхдүүдийн суралцах орчин гэхэд брайль цаас гэдэг зүйл Монголд бараг байдаггүй, гадаадаас ихэвчлэн хандиваар орж ирдэг. Тэрийгээ гамтай хэрэглэж байгаад дуусгахгүй бол дараагийн нөөц гэдэг юм их хэцүү болдог. Тэгэхээр төр засаг маань энэ тал дээр анхаарлаа хандуулж, улам сайжруулж явах байх гэж найдаж байна. Ард иргэд маань энэ хөгжлийн бэрхшээлтэй гээд нэгэнтээ өөрөөсөө ахадсан өвчин үүрээд, зовж ядарч байгаа хүүхдүүдээ ойлгож, маш их тусалж дэмжиж яваасай л гэж би боддог.

Цаг гарган манай подкастад орсон Энхзул багшдаа маш их баярлалаа. Таны цаашдын ажилд нь томоос том амжилт, эрүүл энх, аз жаргал хүсье ээ!

Бас надтай илэн далангүй ярилцсан чамд их баярлалаа. Энэ ярилцлагыг сонссон зарим хүмүүс авах гээх ухаанаар хандаж, зөв ойлгож хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдээ сайхан хайрлаж, бүгдээрээ тэднийгээ хамтдаа хөгжүүлье гэж хэлмээр байна.

БОЛОВСРОЛ БОЛ ӨРСӨЛДӨХ ЧАДВАР

В.Ойдов



Сайн байцгаана уу, эрхэм хүндэт сонсогчид оо, Антолд подкастын маань ээлжит дугаар эхлэхэд бэлэн болоод байна. Энэхүү дугаарт Рехтус компанийн үүсгэн байгуулагч, захирал Ойдов оролцож байна. Та урилгыг маань хүлээн авч подкастад маань орсонд маш их баярлалаа. Манай сонсогчдод өөрийгөө танилцуулахгүй юу?

За баярлалаа. Подкастыг сонсогч та бүхэнд бас өдрийн мэндийг хүргэе ээ! Хүн өөрийгөө танилцуулна гэдэг төрсөн он сараасаа эхлэх үү, юугаа ярих вэ гээд хамгийн хэцүү зүйлүүдийн нэг байдаг юм гэсэн. Би өөрийгөө хамгийн товчоор танилцуулах гээд үзье. Намайг Ванчин овогтой Ойдов гэдэг. Би 3 хүүхдийн аав, сайхан бүсгүйн нөхөр. Бизнесийн салбарт 10 жил ажиллаж байгаа, олон улсын салбарт бас 10 жил ажиллаж байгаа. Одоо өөрийн гэсэн Ректус гэдэг асаргаа сувилгаанд зориулагдсан бүтээгдэхүүн санал болгодог компаниа үүсгэн байгуулсан хүн байна.

Та компанийнхаа үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй ярьж өгөхгүй юу?

Компанийн үйл ажиллагаа үндсэндээ 1 гэр бүлд, 1 хүнд зориулж байгуулсан компани. Аль ч гэр бүл, аль ч хамт олонд ямар нэгэн хэмжээгээр бусдаасаа асаргаа шаардах тохиолдол үүсдэг. Тэмцээнд ороод өөрийгөө гэмтээх эсвэл харвалтаас эсвэл зүгээр өндөр настны улмаас аливаа гэр

бүлд хэн нэгнийгээ асрах цаг үе ирдэг. Тэр тохиолдолд гэр бүл тэр хүнийг асрахын тулд бусад гэр бүлийн гишүүд нь ажлаасаа гарах эсвэл бусад нөхцөлөө өөрчлөх шаардлага гардаг нь өөрөө маш их стресс дагуулдаг. Мөн эдийн засаг, сэтгэл зүйн их дарамтыг үүсгэдэг. Манай компанийн хувьд тухайн хүнийг асарч байхдаа аль болохоор шинэ технологийг хэрэглэж, асаргааг хөнгөвчлөх зориулалттай үйлчилгээ үзүүлдэг. Энэ нь ямар учиртай гэвэл хүнд асруулна гэдэг асруулж байгаа хүндээ хэцүү байдаг. Хэн нэгнийг асарна гэдэг асарч байгаа хүний хувьд тийм амар биш үе байдаг. Тэгэхээр аль алинд нь тусалж байгаа гэсэн үг. Ингээд нэг гэр бүлд бид тусалснаараа улс орноо хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулж байгаа юм. Яагаад гэвэл 3 сая хүн амтай улсын тодорхой хувь нь бусдаас асаргаа шаардахаар Монгол Улсын төлөө хөдөлмөрлөх боловсон хүчин багасаж, улсаа хөгжүүлэх хүн маань хайртай нэгнийгээ асрах хэрэгтэй болдог. Энэ хоёрын дунд технологи, зөвлөгөө, нэн шаардлагатай бүтээгдэхүүнүүдийг санал болгосноор тухайн хүн ажлаа хийх боломжтой болно. Асруулж байгаа хүн ч гэсэн сэтгэл санааны хувьд өөдрөг байх бололцоотой. Тиймээс манай компанийн уриа үндсэндээ "асарч байгаа болон асруулж байгаа хүн бүрд" гэсэн байдаг. Түүнээс гадна манай компани орчныг хүртээмжтэй болгох ажлыг хийж өгдөг. Өөрөөр хэлбэл хүмүүс хүртээмжтэй орчинд байх ёстой. Хүртээмж гэж яг юу вэ, хүртээмжтэй орчныг яаж бүрдүүлэх вэ гэдгийг хүмүүс заримдаа ойлгодоггүй. Хүсэл бөгөөд санхүү нь байгаа тохиолдолд бид тэрийг нь биелүүлж өгдөг. Одоо үндсэн салбараасаа хазайхгүйгээр өөр салбар луу цаашаа улам дэлгэрээд хөгжүүлэхээр явж байна.

Танд анх компани байгуулъя гэсэн санаа яаж орж ирсэн бэ?

Сэдэл нь юунаас үүдэлтэй вэ гэвэл бусдад туслахын тулд би өөрөө хүчтэй байх ёстой. Өөрөө хүчтэй байхын тулд хамгийн түрүүний хийх ёстой зүйлсийн нэг болохоор санхүүгийн эрх чөлөөнд хүрэх. Санхүүгийн тодорхой хэмжээний эрх чөлөөнд хүрнэ гэдэг маань одоогийн нийгэмд бол ерөөсөө бизнес хийхээс өөр бололцоо байхгүй. Тэгэхээр бизнесээ хийгээд, тэгсэн хэрнээ бусдад туслах тэр үйл ажиллагаагаа хийхийн тулд би гарцаагүй бизнес хийх шаардлагатай болсон. Бизнес хийхэд мэдээж суурь зүйлсийн нэг бол чиний өөрийн чинь тодорхой хэмжээгээр чаддаг, салбараа мэддэг зүйл байх ёстой. Би 17 наснаасаа хойш Монголын бүх аймгуудаар явж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн анхны тоног төхөөрөмж, хэрэгслүүдийг Америкаас авч ирж, үнэгүй тарааж байсан. Тэр маань нэг туршлага болсон. Хоёрт би өөрөө олон улсын харилцааны чиглэлээр мөн тэр дундаа олон улсын бизнесийн чиглэлээр боловсрол эзэмшсэн учраас яаж энэ бизнесийг Монголд хийж болох вэ? гэдэг хоёр урсгалыг нэгтгэхийг зорьсон. Энэ үүднээсээ Монголд ирснийхээ дараагаар Рехтус гэдэг компанийг байгуулсан. Эхний ээлжинд мэдээж тодорхой хэмжээний бэрхшээлүүд байсан. Яагаад гэвэл хүмүүс

миний хийх гээд байгаа, хийгээд байгаа зүйлийг тэр бүр ойлгохгүй, үзээгүй, хараагүй байсан. Тийм учраас нэн түрүүний хийх ажил бол үйлчлүүлэгчиддээ хийх гээд байгаа зүйлийнхээ талаар мэдээлэл өгөх, боловсруулах, боловсролыг нь олгох ажлыг их хийх шаардлагатай болж байсан.

Тухайн үедээ яаж үйлчлүүлэгчиддээ боловсрол өгч байсан бэ?

Өөрийн биеэр үлгэрлэн үзүүлэх. Ингэж болдог ингэдэг юм гээд холбоотой мэдээлэл өгөх, текст орчуулж өгөх. Хамгийн гол нь дэлгүүрээ байгуулсны дараа ирж байгаа үйлчлүүлэгч бүртэйгээ тулж харьцах. Эхлээд надад ийм бүтээгдэхүүн байна гэж ярихаасаа илүү танд ямар асуудал байна, ямар нөхцөлөөс яагаад над дээр ирэх болов, би танд юугаар тусалж чадах вэ, надад ямар бололцоо байна? гэдэг асуултуудыг аль болохоор аль аль талдаа ашигтай байдлаар тайлбарлахыг хичээдэг байсан. Жишээ нь тэргэнцэр авъя гээд хүн хүрээд ирвэл "яагаад та тэргэнцэр авахаар болов?" гэж асууна. Нөгөө хүмүүс бол зүгээр л нэг сайхан тэргэнцэр авъя гэдэг. Гэтэл тэргэнцэр нь зарим тохиолдолд лифтэнд нь багтахгүй байдаг. Тэргэнцэр гэдгийг өөрөө гүйцэд ойлгоогүй зөвхөн "тэргэнцэр том бөгөөд дотор нь суугаад л явж л байвал болно" гэж боддог. Гэтэл тэргэнцэр чинь өөрөө хэтэрхий том байгаа тохиолдолд тухайн хүний нуруунд гэмтэл учруулах, хүн тэргэнцэр дээрээ аюултай байдалд орох зэрэг аюулууд байдаг. Түүний оронд жишээлбэл та ийм тэргэнцэр авбал гэр дотроо усанд орж болно, аюулгүй, авсаархан, аваад явахад эвтэйхэн гэх мэт зөвлөгөөнүүд өөрийнхөө зүгээс маш их өгнө. Тухайн үедээ юм зарахгүй байж болно, ямар ч борлуулалт хийхгүй байж болно. Тэр хүний оронд өөрийгөө тавьж үзээд аль болох түүнд туслах арга хэмжээ авна. Гэхдээ хамгийн гол нь тэр хүний асуудлыг шийдвэрлэж өгөх нь нэн чухал асуудал.

Та тухайн үедээ магадгүй үйлчлүүлэгч нар нь ойлголт муутайгаас саад бэрхшээл үүсэж байсан юм байна. Тэрнээс өөр ямар саад бэрхшээл үүсэж байсан бэ?

Хамгийн том бэрхшээл бол үйлчлүүлэгчиддээ үзүүлэх гэж байгаа үйлчилгээгээ ойлгуулах асуудал байсан. Өөр саад бэрхшээл гэвэл бусдаас илүү хэмжээний саад бэрхшээл байгаагүй. Мэдээж дөнгөж эхэлж байсан старт ап (start-up) компанийн хувьд санхүүгийн хязгаарлагдмал нөхцөлд орж байсан. Тухайн үед компаниа арван хэдэн сая төгрөгөөр эхлүүлээд компанийн маань мөнгө дэлгүүрийн эхний түрээс, эхний барааны татан авалт дээр л ерөнхийдөө дуусаж байсан. Тэрний дараа яах вэ гэдэг асуудал тулгарахад сурсан сургуульд маань заасан нь кроудфандинг (crowd-funding) буюу олон нийтээс хөрөнгө босгох ажил байсан. Тэрийг би 3 сарын хугацаанд кроудфандинг хийгээд анхны хорин хэдэн сая төгрөгөө босгож байсан. Өөрөөр хэлбэл кроудфандинг гэдэг маань олон нийтэд өөрийнхөө төслийн санаагаа аль болохоор товч, тодорхой тайлбарлаад

та нар сонирхвол үүн дээр хандив өгч болно гэсэн санаа юм. Тэрийгээ олон улсад гаргаад найзууд, таньдаг, таньдаггүй, Монголд, гадаадад хүмүүсийн харилцаанд түшиглээд хөрөнгө босгож байсан. Энэ хөрөнгө маань өнөөг хүртэл 7 жил явуулж байгаа энэ компанийн үндсэн суурь хөрөнгө болж чадсан. Одоо компани маань өргөжөөд, хөгжөөд явж байгаа байдал маань энэ.

Тань шиг ийм амжилттай старт ап байгуулаад явж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд хэр олон байдаг вэ?

Байдаг байх гэж итгэж байна. Гэхдээ яг бизнес салбар руу ороод явж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бол бас их олон биш. Шударгаар хэлэхэд төрийн бус байгууллагын салбарт нэлээн амжилттай явцгааж байгаа залуучууд бий. Бизнесийнхээ салбарт бол их цөөхөн байх.

Ингээд цөөхөн байгаагийн шалтгаан нь таны бодлоор юу байдаг вэ?

Цөөхөн байгаа хамгийн гол шалтгаануудын нэг бол харамсалтай нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд тэр болгон цэцэрлэг, яслид боловсрол эзэмших бололцоо маш багатай холбоотой. Боловсрол эзэмшээгүй байгаа тохиолдолд хүүхдүүд хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөх чадвар бага. Өрсөлдөх чадвар бага байна гэдэг нь бизнес хийх суурь байхгүй байна гэсэн үг. Бодоод үзье. Би Өмнөговь аймагт нэгдүгээр 10 жилийг төгссөн. Тухайн үед 2,000 гаруй хүүхэд сургууль төгсөж байхад над шиг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нэг л байсан. Хөгжлийн бэрхшээлтэй миний үеийн, надтай нас чацуу хүүхдүүд бол олон байсан. Яг сургуулиа төгссөн нь бол ганц байсан. Би 2001 онд Монгол Улсын Их Сургууль (МУИС)-ийг дүүргэж байхад бүхэл бүтэн МУИС-ийн хэмжээнд гуравхан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байсны 1 нь би байсан. Нийгмийн ухааны факультетэд 1, биологийн факультетээс 1 төгссөн. Гэтэл тэнд чинь нэлээн хэдэн мянган хүүхэд байгаа шүү дээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тооны харьцаа одоогийн байдлаар 12,000 байгаа. Энэ 12,000 хүн гэдэг нь нэлээд мэдэгдэхүйц тоо л доо. Тэр хүүхдүүд маань сургууль гэхээсээ илүү эхлээд цэцэрлэгт боловсрол эзэмших бололцоо багатай. Цэцэрлэгт боловсрол эзэмшээгүй хүүхэд сургуульд орох магадлал их багатай. Дунд сургууль хүртээмжгүй байдгийн улмаас сургуульд орсон ч сургуулиа төгсгөж чаддаггүй. Боловсрол шинжлэх ухааны яамны гаргаж байгаа янз бүрийн статистик тоогоор бол зарим талдаа их өөдрөг харагдаад байдаг. Хөөх ийм олон хүүхэд сургуульд элсжээ гэж харагддаг. Элсэж болно. Гэтэл 4-р анги, 5-р анги хүрээд тэр хүүхдүүд сургуулиа хаядаг. Тэр шалтгааныг нь судалж байсан тохиолдол их цөөхөн. Би олон улсын байгууллагад ажиллаж байхдаа хөгжлийн бэрхшээлтэй 13 хүүхдүүдийг сургуульд элсүүлэхэд, 5-р ангид очиход гуравхан хүүхэд үлдэж, 10 хүүхэд нь 4, 5-р ангидаа гарчихаж байсан. Үүнд нэгдүгээр шалтгаан нь сургууль өөрөө хүртээмжгүй, хүүхэд өөрөө жинтэй

болж эхэлсэн. Дээр нь нэмээд хүйсийн мэдрэмжүүд эхэлдэг, эрэгтэй эмэгтэйгээ мэдэрч эхэлдэг зэрэг олон шалтгаанаас болоод сургуулиа дүүргэж чаддаггүй. Яагаад бизнест хөгжлийн бэрхшээлтэй залуучууд цөөхөн байна гэвэл иймэрхүү үндсэн гол шалтгаанууд байна.

Боловсрол авч чадаагүйгээс болоод бизнес эрхлэлтэд нөлөөлж байна гэж та харж байгаа юм байна. Таныг Швейцар Улсад сургуульд сурч, магистраа төгссөнийг нь мэднэ. Аймагт 10 жилээ төгсөөд, МУИС-д ороод, Швейцар яваад энэ олон сургуулиудыг яаж төгссөн бэ? Та тэр талаараа жаахан ярьж өгөхгүй юу?

Нэг зүйл засаж хэлэхэд би Швейцарт магистр төгсөөгүй. Миний хоёр дахь бакалавр байсан. Өмнөх асуулттай холбогдуулаад хэлэхэд боловсрол гэж юу вэ гэж хүмүүсээс асуувал, хүмүүс юу гэж хариулахыг мэдэхгүй. Миний хувьд



боловсрол гэдэг өөрөө өрсөлдөх чадвар. Өрсөлдөх чадвар нь түлхүүр л гэж би боддог. Хүн хэдий чинээ боловсролтой, дээр нь нэмээд зоригтой байна төдий чинээ хийж бүтээх магадлал их өндөр байдаг. Боловсрол бага байх тусам бизнес хийх хэцүү. Бизнес бол мэдээж дэлхий дээр хийх ёстой хамгийн мундаг зүйл бол биш л дээ. Гэхдээ л бизнес хийгээд явна гэдэг чинь өөрөө өөрийгөө сорих бас нэг үндэс байдаг. Тийм учраас боловсрол бол юм болгоны үндэс болчихоод байгаа юм. Боловсрол ядуурлаас гарах маш том түлхүүр болчихоод байгаа юм. Би яаж энэ боловсролд хүрэх боломжтой байсан гэвэл би бага наснаасаа бие махбодийн шаардлагын улмаас эмнэлэгт маш их эмчлүүлдэг байсан. Бага байхдаа Орост 6 жил эмчилгээ хийлгэж явсан. Тэгэхдээ би Орост бага сургуулиа төгсөөд Монголд ирээд дунд сургуулиа төгсөж байхдаа би МУИС-ийн Олон Улсын Харилцааны Сургуульд элсэлтгүй орох эрх олж авсан. Төгссөнийхөө дараа би 10 жил хөдөлмөр эрхэлсэн. Тэгэхдээ 5 жил бизнесийн салбарт, 5 жил олон улсын байгууллагад ажилласан. Ингэж ажилласныхаа дараагаар миний сурсан мэдсэн зүйл цаг хугацаанаасаа хоцорч байна гэдгийг нэгдүгээрт ойлгосон. Хоёрдугаарт миний цаашдын бодож явсан төлөвлөгөөнд гарцаагүй 1 зүйл дутагдаад байсан. Би бизнес хийх сонирхолтой байсан боловч бизнесийн талаар



мэдлэг багатай, суурь ухагдахуун багатай, бизнес гэдгийг мэддэггүй байсан. Тийм учраас би бизнесийн ухаанд суралцах шаардлагатай юм байна гээд тэтгэлэгт хөтөлбөрийн дагуу Швейцарт олон улсын бизнес удирдлагаар суралцаж ирсэн. Зэвсгээ үндсэндээ бэлдчихэж байна гэсэн үг. Одоо миний бүтээх цаг гэж бодоод би аль нэгэн компанид ажилд ороогүй. Тухайн үед би гучин хэдтэй байсан тэгээд "би одоо л зориглоод өөрөө юм бүтээе, зөвхөн цалин мөнгөний төлөө явбал би хүссэн зүйлээ хэзээ нэгэн цагт зориглож чадахгүй юм байна аа" гэж бодсон. Тэгээд би бизнесийн салбар руу орж байсан.

Та яагаад Швейцарийг сонгосон бэ?

Швейцарийг сонгох хэд хэдэн том шалтгаан байсан юм. Нэгдүгээрт би 17 настай байхдаа Америкчуудтай хамтран ажиллаж байгаад Монгол, Америкийн хамтарсан төрийн бус байгууллага байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настай хүмүүст зориулсан янз бүрийн тоног төхөөрөмжийг үнэгүй тараагаад зүүн тийшээ Дорнод, хойшоо Хөвсгөл, урагшаа Өмнөговь, баруун тийшээ Баян-Өлгий хүртэл бүх аймгуудаар явж байхад олон улсын янз янзын мэргэжлийн хүмүүстэй танилцаж явсан. Тэр дундаа Швейцараас ирсэн мэргэжилтнүүдтэй танилцаад явж байхдаа Монголд хөдөлмөр засалч (occupational therapist) гэдэг мэргэжил байдаггүй гэдгийн ойлгосон. Тэгээд энэ мэргэжлийг Монголд үүсгэе, энэ мэргэжлийн хүн байхгүй бол маш олон хүн хохирч үлдэх юм байна гээд Швейцарийн их сургуультай хамтарч 2004 оноос хойш төсөл хэрэгжүүлж явсан. Би төслөө нэлээн амжилттай хэрэгжүүлснийхээ дараа бизнесийн чиглэлээр суралцах хэрэгцээ надад байна, санхүүгийн хувьд мэдээж би Швейцар шиг өртөг өндөртэй газар өөрийнхөө санхүүг дийлэхгүй. Тэгэхээр тэтгэлэгт хөтөлбөр хаж үзтэл, манай хамтрагч сургууль дээр тэтгэлэгт хөтөлбөр зарлагдаад, би тэнцсэн юм. Тодорхой хэмжээгээр маш том азтай л байсан гэсэн үг.

Та бас Америк явж байсан. Өндөр хөгжилтэй орнуудад байж байгаад Монголд ирэхэд Монголд ийм юм ингээд хөгжчихөөсэй гэсэн зүйл байдаг уу?

Юу юугүй айлын хоёр хүүхдийг харьцуулах нь одоо бас хаашаа ч юм. Америк, Швейцар ч юм уу миний амьдарч байсан бусад европын улсууд анхнаасаа сүүлийн 100, 200 жилд манайхаас огт өөр хөгжлийн замыг сонгосон байсан. Манай Монголыг бол хэдэн жил, ямар дэглэмтэй байсан, хэзээнээс ардчилал, гадаад паспортыг эзэмшиж эхэлсэн гэдгийг та өөрөө мэдэж байгаа. Тэгэхээр шууд харьцуулвал өрөөсгөл болох байх. Заавал хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэхгүй 1 зүйлийг тодруулаад хэлэхэд бид 2 хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэж яриад байгаа боловч сонсож байгаа залуучууд хэзээ нэгэн цагт тодорхой хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй болно. Муу ёрлож байгаадаа биш, хүн өндөр настай болох үед чадвар алддаг. Хараа сулардаг, чихний

сонсгол мууддаг, гар, хөлийн хөдөлгөөн удааширдаг. Хүн дөнгөж төрсөн нялх нярай байх үедээ бас хөдөлмөрийн чадваргүй байдаг. Ээж аав нь хооллодог, хувцасладаг бүх юмыг хийдэг. Хүн идэр насандаа бас тодорхой хэмжээгээр гэмтэл аван хөгжлийн бэрхшээлтэй болдог тал бий. Зүгээр жирэмсэн эмэгтэй хүн хүртэл жишээ нь гутлаа өмсчхөөд, өмдөө өмсөж чадахгүй тохиолдол байдаг. Хөгжлийн бэрхшээл нэг ёсны бидний амьдралд маш их ойрхон байдаг зүйл. Бусдаар бол та нар нэг гарагаас, бид нар өөр гарагаас гээд өөр өөр гарагаас ирсэн хүмүүс биш. Тэрийг нэгдүгээрт тодотгож өгье. Тийм учраас бэрхшээлгүй хүн байдаггүй гээд ойлгочих. Тухайн улс орнуудаас авмаар зүйл юу байсан гэвэл маш их зүйл байсан. Тэдний мөнгөний бодлого гэж нэг мундаг зүйл бий. Төрөөс олгогдож байгаа мөнгө нь төрөөс гүйцэтгэж байгаа аливаа төсөл хөтөлбөрүүдийг бүгдийг нь дэмждэг байх ёстой. Монголд жишээ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй нийгэм байгуулна гээд өчнөөн олон жил зарлаж байна. Гэтэл цаана нь тендерээр олгож байгаа мөнгө нь энэ хөтөлбөр төсөлтэйгөө ямар ч уялдаагүй байдаг. Уялдаатай байлгана гэвэл барилгын компанид тендерээр мөнгө өгч байгаа бол тухайн компани байшин барилга барихдаа хүртээмжтэй орчныг байгуулах ёстой. Арай байгуулж чадаагүй бол дараагийн удаа тендер өгөхгүй. Барилгын компани нэг мөнгөөр үндсэндээ 2-3 зорилгыг биелүүлчхэж байгаа юм. Тэгэхгүй одоо манайд баруун гар нь тендерээ болгоод, зүүн гар нь янз бүрийн гоё хөтөлбөрүүд яриад явдаг. Хоёр гар хоорондоо холбогдохгүй байна гэсэн үг. Энэ систем Америк, Швейцар, европын улс орнуудыг нийтэд хүртээмжтэй нийгмийг маш хурдан хугацаанд бий болгох үндсийг тавьж өгсөн. Бид болохоор энэ хоорондын уялдааг олж харж чадахгүй байгаа. Баруунаараа баахан мөнгө тараачхаад л, зүүнээрээ дахиж мөнгө тараана гээд зүтгээд байна. Тэгэхээр нэг зүйл дээр хоёр дахин мөнгө төлөөд байгаа юм.

Тэгвэл таны хувьд Монголд хүртээмжтэй нийгмийг байгуулахад хамгийн түрүүнд хийх ёстой юм нь хариуцлагын системийг бий болгох ёстой юу?

Олон юм байна л даа. Яг аль өнцгөөс хөврөх үү гэдэг л асуудал. Мэдээж хамгийн эхэнд боловсрол. Хоёулаа эргээд бөөсний үлгэр шиг боловсролоо л ярья. Залуучууд, хүүхдүүд маань боловсрол эзэмших юм бол магадгүй 20, 30 жилийн дараа Ойдов шиг залуучууд 20, 30-аараа бий болно. Эдгээр Ойдов шиг залуучууд ганцхан одоо цагт байгаа Ойдвоос 20, 30 дахин илүү дуугараад, 20, 30 дахин өөрсдийнхөө юмыг өөрчлөөд явна гэдэг чинь хүнээс хамаарал их багатай байна гэсэн үг. Одоо Ойдов шиг залуучууд цөөхөн байгаа учраас усаар ярих юм бол давалгаа үүсгэж чадахгүй байна гэсэн үг. Давлагаа үүсгэж чадах юм бол энийгээ өөрчилж чадна. Тэгээд үүнийг бий болгох үндэс бол мэдээж сургууль, цэцэрлэг, яслийн боловсролын асуудал. Энэ цаг үе бидний асуудал юм аа гэхэд, ирээдүй цагийн хүүхдүүд энэ асуудлыг шийдвэрлэх ёстой гэж хардаг.

Тэгээд нэг сургуульд, нэг ангид хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байж байхад тэр анги, сургуульд байгаа бэрхшээлгүй хүүхдүүд тэдний асуудлыг маш сайн ойлгодог. Өмнөговь аймагт байгаа миний үеийнхэн, ангийнхан бүгдээрээ намайг мэднэ. Надаас дээш, доош 5 үеийнхэн намайг сайн мэднэ. Зарим нэг нь үүрээд гүйцгээж байсан, зарим нэгэнтэй нь тоглож байсан. Тэрнээс Ойдов шиг хүнтэй уулзахад жишээдбэл ямар байдаг вэ гэдэг бидний хувьд зүгээр гар бариад явах бол энгийн асуудал. Гэтэл чи өөрөө төсөөлөөд үз дээ. Амьдралдаа уулзаж үзээгүй заан гэдэг амьтантай уулзчихвал яах вэ? айна шүү дээ. Хүний хүнтэйгээ харилцаж чаддаггүй хамгийн том шалтгаан нь тэр хүнийхээ тухай мэддэггүй учмаас тэр хүнтэйгээ харилцаж чаддаггүй. Түүнтэй адилхан хэрвээ чи амьдралдаа заантай уулзаж үзээгүй бол, зааныг хэзээ ч очиж юу юугүй хошуунаас нь тэврээд авахгүй.

Сүүлийн жилүүдэд тэгш хамруулах боловсролын тухай их ярьж, одоо хэрэгжүүлж эхэлж байгаа. Хэчнээн тэгш хамруулна гэж ярьж байгаа ч гэсэн таны бодлоор хэрэгжилт нь одоогийн байдлаар хэр байгаа вэ?

Одоо хэрэгтэй юу? хэрэгтэй. Гэхдээ хэт туйлширч байна уу гэвэл туйлшрал бас явж байгаа. Жишээлбэл бүх хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулах ёстой гэж боддог. Эцсийн үр дүнд боловсролын хамгийн том зорилго бол тэр хүүхэд өөрөө өөртөө үйлчлээд, өөрөө өөрийгөө санхүүжүүлэх чадварыг л олгох асуудал шүү дээ. Гэтэл оюун ухааны хувьд магадгүй хэзээ ч 4 оронтой тооноос дээш бодож чадахгүй хүүхдийг зайлшгүй тэгш хамруулна гээд жигдхэн зүтгүүлээд байх нь нөгөө талаас асуудал. Ийм тохиолдолд магадгүй тэр хүүхдийг тодорхой хэмжээгээр үйлдвэрт ажиллах чадвар эзэмшүүлээд, үйлдвэрээс гарч байгаа орлогоор хүүхэд өөрийнхөө амьжиргааг авч явах бололцоо үүсгэх хэрэгтэй гэсэн их ялгаа байгаа шүү. Тийм учраас тэр хүүхдүүдэд тусгай сургууль гэж байгаа. Заримд нь боловсролын оронд арай өөр зүйл заах шаардлага байгаа гэх мэт ойлголтууд байна. Зарчмын хувьд тэгш хамруулах боловсрол Монголд зайлшгүй хөгжих ёстой маш их чухал зүйл. Хэрэгжилтийн хувьд тэгш хамруулах, боловсруулах гэхээр хэдэн багш нарыг л балбаад, байнга сургалтад хамруулаад яваад байгаа. Болно оо, болно. Багш нар бэлтгэгдсэн байж болно, эцэг эхчүүд бэлтгэгдсэн байж болно. Гэтэл тэр сургуулийг хэн өөрчилж байгаа вэ. Сургуульд тэргэнцэртэй очъё гээд сургууль руугаа орж чадахгүй. Сургуульд 5, 6-р ангиас дээш бүх ангиуд дандаа 2, 3 давхартаа хичээл орж байгаа. Коридорт нь саадтай, даваа шиг юмнууд байдаг, хичээлдээ ороод бие засах боломж байхгүй, ариун цэврийн өрөөний асуудалтай. Тэгэхээр боловсрол эзэмшихэд миний хувьд хөгжлийн бэрхшээлийн 4 хүчин зүйл байдаг. Зөөлөн 2 хүчин зүйлийн 1 нь багш нар, 2 дахь нь эцэг эхчүүд. Хатуу 2 хүчин зүйлийн 1 нь сургуулийн гаднах дэд бүтэц , 2 дахь нь сургууль доторх дэд бүтэц. Сургуулийн гаднах дэд бүтэц гэдэг нь сургууль руугаа

хүрэх, нийтийн тээврийн асуудлыг, гаднах зогсоолыг ярьж байгаа. Сургууль доторх дэд бүтэц гэдэг нь сургуулийн дотоод орчны хүртээмжийг яриад байгаа юм. Одоо бид яагаад мянга гоё лоозон яриад байгаа хэрнээ бүтэхгүй яваад байна гэвэл бид зөөлөнтэйгөө ноцолдоод, хатуу нь ерөөсөө өөрчлөгдөхгүй байна. Хатуугаа өөрчилж чадаагүй тохиолдолд бид мянга зүлгээд зүүлгээд мяндас шиг болгосон ч тэр маань хэзээ ч утсаа зүү нь дагадаггүй шиг өөрчлөгдөхгүй. Зүү нь утсаа дагуулж явдаг шүү дээ. Эсрэгээр нь атуу зүйлийгээ дагуулж явах ёстой нөхцөл үүсчхээд байгаа юм. Гэтэл үүнийг ойлгохгүй байна.

Уг нь барилга байгууламжийн хүртээмжтэй байдлын стандарт гэж Монголд байдаг. Стандарт байдаг хэрнээ яагаад энэ баригдаж байгаа барилга байгууламжийн хүртээмжтэй байдал сайжрахгүй байгаа юм бэ?

Би наад асуултыг чинь өөрөөсөө өдөр болгон асуудаг юм. Яагаад гэвэл хүмүүс нэгдүгээрт энийг хамгийн гол нь хүнд хэрэгцээтэй гэдгийг ойлгохгүй байна. Бизнесүүдг том том моол, супер маркетууд бариад л байдаг ч тэд хэзээ ч Монголд байгаа 120,000 хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үйлчилнэ гэж боддоггүй. Тэр ч байтугай хүүхэд түрсэн ээжүүдэд ч үйлчилнэ гэж тооцдоггүй. Бизнесийн хувьд үүн дээр бол билгийн нүд нь аньчихсан байна. Төрийнхний хувьд өөрсдөө үлгэр дуурайл үзүүлэх ёстой. Одоо байгаа бүх барилга байгууламж үндсэндээ соц үеэс барьсан л барилга байгууламж. Тэр үед хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай ойлголт огт яригдаж байгаагүй. Та ямар дунд сургууль төгссөнийг мэдэхгүй. Тэгэхдээ бүх л аймгуудад нэг адилхан шар дунд сургууль байгаа, 10 жил гээд ямар хүртээмжтэй байдаг билээ бүгд мэдэж байгаа. Сургууль барихдаа хэзээ ч тэрийгээ тооцдоггүй. Цэцэрлэг барихад стандарт гэж ярьдаг боловч цэцэрлэгүүд нь дандаа 2, 3 давхар байшингууд, хөдөө орон нутагт ч ялгаагүй. Гэтэл хөгжингүй орнуудад цэцэрлэгийг хэзээ ч 1 давхраас дээш барьдаггүй. Шалтгаан нь маш энгийн, гал гарлаа эсвэл газар хөдлөлт боллоо гэхэд нялх нойтон, жижигхэн хүүхдүүд хэзээ ч 2 давхраас буугаад гарч амжихгүй. Тэгэхээр бидэнд мэдлэг л дутаад байна. Мэддэг нь хэлээд өгөхөөр тоохгүй. Би үндсэндээ олж харсан, мэдсэн зүйлсээ хэлэх юм бол өөдөөс нэг гоё инээмсэглээд бодолцоно оо, бодно оо, судална аа л гэж хэлэх байх. Тэгээд тэрийгээ хэрэгжүүлнэ гэж байхгүй. Энэ нийгэмд байгаа зөндөө олон өөр шалтгаан байгаа байх л даа.

Та бизнес хийхийн хажуугаар нийгэмд чиглэсэн ямар үйл ажиллагаа явуулдаг вэ?

Яг шударгаар хэлэхэд нийгэмд чиглэсэн ажил руу би цөөхөн оролцож байгаа. Яагаад гэвэл аль аль талдаа цэвэрхэн байхыг боддог. Бизнес сонгосон бол бизнесээ хийнэ, олон улсын байгууллага сонгосон бол нийгэмд чиглэсэн ажлаа хийнэ гээд. Би арван хэдэн жил нийгэмд чиглэсэн ажил хийж явсан, одоо цэвэр бизнес рүү орно гээд сонголтоо хийсэн.



Тэгээд цэвэр бизнесээ л хийгээд явж байгаа юм. Тэгэхээр хооронд нь холихгүй байхыг боддог. Миний өөрийн нийгэм рүү чиглэн хийж байгаа ажил бол хөдөлмөр засалч гэдэг мэргэжлийг монголд хөгжүүлэх, анхны төгсөгчдийг дэмжих. Тэр мэргэжлийг Монголд хөгжүүлэх ажлыг эхнээсээ явсан учраас би дуустал нь хөгжүүлж явна гэж боддог. Тэгээд төгссөн хүүхдүүдээс жишээ нь магистрт сурах шаардлага гаргавал би тэтгэлэг байдлаар санхүүгийн дэмжлэг үзүүлдэг.

Хөдөлмөр засалч гэж яг юу юм бэ?

Хөдөлмөр засалч гэдэг маань маш энгийн жишээгээр тайлбарлавал цус харвалт өгөхөд хүн тодорхой чадварууд алдагддаг. Хамгийн энгийн өмдөө татахаас эхлээд, үдээс үдэх, өмднийхөө товчийг тайлах, тэлээ цахилгаанаа тайлах чадваруудаа алддаг. Харвасны дараа нэгдүгээрт амийг нь аварна. Амийг нь аварсны дараа хөл гар нь жоохон татанги болсон тохиолдолд хөдөлгөөн засалчид хөл гарынх нь үйл ажиллагааг хэвийн болгож өгөөд эмнэлгээс гаргадаг. Гэхдээ тэр хүнд эргээд өмдөө яаж өмсөх вэ, гутлаа яаж өмсөх вэ? Хэрвээ бичгийн хүн байсан бол

бичих чадваруудыг нь эргээд олгож өгдөг. Тэгэхгүй бол тэр хүн амьд байсан ч урьд нь чаддаг байсан чадваруудаа нөхөж авч чаддаггүй. Хөдөлмөр засалч болохоор яг тэр чадварыг нь эргэж олгодог хүн байдаг. Харин эргэж олгох боломжгүй бол өөр чадварыг суулгаж өгдөг гэсэн үг юм. Тэгээд тэр хүнийг хэрвээ дайны фронт байлаа гэхэд эргээд эгнээнд нь оруулдаг, хөдөлмөрийн зах зээл дээр эргэж гаргаж өгдөг хүмүүс байдаг юм. Манай Монголд бол амийг нь аварлаа, гар хөлийг нь хэр зэрэгтэй ажиллагаатай болгож өглөө, тэгээд л эмнэлгээсээ гаргачихдаг. Нөгөө хүн маань амьд л байгаа болохоос бусдаар яг хийж байсан чадвараа эргээд олж авч чадаагүй байдаг. Би энэ мэргэжлийг үүсгэх гээд 2003 оноос хойш явж байгаа бөгөөд энэ жил 3 дахь төгсөлт болсон. Тэгэхээр миний нийгэмдээ зориулж хийж байгаа хамгийн том ажлын маань нэг бол энэ хөдөлмөр заслын ангийг Анагаахын Шинжлэх Ухаан Үндэсний Сургууль дээр байгуулж өгсөн. Хэрвээ энэ чиглэлээр суралцах хүсэлтэй залуучууд сонсож байгаа бол сонголт бол байгаа. Энэ бол XXI зууны хамгийн эрэлттэй мэргэжлийн тоонд ордог мэргэжил байгаа юм. Хөдөлмөр заслын мэргэжилтэн цалин хөлсний хувьд маш бололцоотой байдаг. Хамгийн гол нь зах зээл маш томтой, хаана ч хөдөлмөр заслыг хэрэглэдэг. Бүх анагаахын салбарт хэрэглэхээс гадна бизнесийн салбарт хэрэглэдэг, маш их өргөн цар хүрээг хамардаг мэргэжил. Энийг сонсож байгаа залуучууд байвал гуравдугаар эмнэлгийн хажууд байдаг сувилахуйн сургууль дээр хөдөлмөр заслын бакалавр чиглэлээр 4 жилээр бэлтгэдэг байгаа. Энийг сонсож, сонирхож байгаа залуучууд орж үзэж болно шүү.

Яг үнэнийг хэлэхэд энэ талаар анх удаа сонсож байна. Таныг анх энэ талаар ярихад хүмүүс яаж хүлээж авч байсан бэ?

Би өөрт чинь гэнэтхэн марс гараг дээр алмаз байдаг гээд яриад байдагтай л адилхан. Таны хувьд хэр ойлгомжтой сонсогдож байна? Марс гаригаа мэдэхгүй, алмаз нь ямар байдгийг нь мэдэхгүй. Тэгэхээр таны хувьд ойлгоход хол байгаа ухагдахуун, олон залуучуудын хувьд ч гэсэн их хол байдаг ухагдахуун. Гэхдээ ойлгож болдог зүйл. Миний хувьд хүний ойлгож чадаагүй зүйлийг ойлгуулна гэдэг өөрөө том сорилт байдаг ч, их сонирхолтой сорилт санагддаг. Хүний ойлгочихсон юмыг дахин дахин хэлж өгөх нь надад их уйтгартай санагддаг. Тэгэхээр би тэр хүний бодол санаа өөрчлөгдтөл гоё шинэ зүйл хийх юмсан гэж хүсдэг. Миний хувийн амбиц бол тэр.

Таны цаашдын хүсэл мөрөөдөл, хэтийн төлөвлөгөө юу байгаа вэ?

Өмнөхөөсөө учиргүй өөр юм бол байхгүй. Яг энэ чиглэлээр өмнө нь хийж байсан ажлуудаа аль болох өргөсгөх, аль болох олонд хүргэх ажлуудыг л хийх бодолтой байгаа. Би одоо хүртээмжтэй амины орон сууц, эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц гэсэн хоёр концепцыг нийлүүлсэн байшинг барьж

байгаа. Энэ байшингаа би загвар байшин болгож монголчуудад аль болохоор өргөн хэмжээнд ойлгуулах бодолтой байгаа. Яагаад гэвэл нэг байшин авчхаад гэмтсэн тохиолдолд тэрийгээ өөрчлөх хэрэг гарна. Үгүй бол хөгширсөн хойноо тэр байшингаа өөрчлөх хэрэгтэй болно. Тэгэхгүй эхнээсээ зөв дизайнтай байшин барьчихвал тэр байшинд 20 настай гэр бүлүүд ч хамтдаа амьдарч болно, 50, 60-тай өндөр настнууд ч амьдарч болно. Нөгөө талын концепц нь эрчим хүчний хэмнэлт. Би яагаад эрчим хүчний хэмнэлттэй байшин барьж байгаа вэ гэвэл хүмүүс "хүндээ ээлтэй нийгэм байя аа" гэж ярьдаг, би бол тэрний эсрэг байдаг. Хүн өөрөө тийм чухал биш харин байгальдаа ээлтэй нийгэм байя аа. Яагаад гэвэл байгалийн 1 бүрэлдэхүүн нь тэртээ тэргүй хүн. Ёстой хүнийг тахин шүтэх нь өөрөө энэ байгалиа устгаж байгаа нэг үзэгдэл. Байнга л хүний бүтээсэн том том зүйлүүд байгаад бид хүрээлэн буй орчныгоо устгаад байгаа. Үүний нэг том шалтгаан нь мэдээж нүүрс хүчлийн хийн асуудал байдаг. Тэгээд эрчим хүчний асуудал яригдаж байна. Гадуур байшингууд өвлийн халаалтдаа 300,000-500,000 төгрөг төлж байхад, би сардаа 20,000-30,000 төгрөг төлдөг байшин босгохыг зорьж байгаа.



Нууц биш бол та яаж тэгж барих юм бэ?

Яг одоо би байшингаа барьж байгаа, тун удахгүй байшингийнхаа талаар танилцуулгуудыг гаргана. Тэр үед намайг дахиж подкастандаа уриарай. Тэр үед цэвэр байшингийнхаа тухай ярья.

Амласан шүү та.

Би ч яахав амласан, та бас амлах хэрэгтэй байна.

Манай подкаст цаашдаа влог хийх төлөвлөгөөтэй байгаа. Тэгээд влогтоо таныг урьж оролцуулж болох уу?

Болно. Надад юу л байна ярих л зүйл байна. Тэгэхдээ зөвхөн яриад суух биш ярьсныгаа хийдэг байх хэрэгтэй л дээ. Хийгээгүй ярьдаг хүмүүс одоо бас их л байна.

Манай подкастын цаг өндөрлөх дөхөж байна. Ковид цар тахал та болон таны



бизнест хэрхэн нөлөөлж байна вэ?

Бусадтай адил хэмжээнд л нөлөөлж байна. Үйлчлүүлэгчдийн тоо хязгаарлагдмал болж, татан авалт, нийлүүлэлт хийх, бизнесийн процессыг гүйцэтгэхэд их хүндрэлтэй болж байна. Үйлчлүүлэгчид ирээд үйлчлүүлэхэд эрсдэл нь давамгайлаад байгаа учраас хүргэлтээр үйлчилгээ авах сонирхол нь илүү байна. Миний бизнест онцгой нөлөөлөөд эсвэл бага нөлөөлж байгаа зүйл бол байхгүй.



Надтай адилхан ямар старт ап, бизнес байна түүний л адил хэмжээнд нөлөө үзүүлж байна.

Та болон таны гэр бүлд хэн нөлөөлж байгаа вэ?

Хүүхдүүдийг маань найзуудтайгаа гарч уулзах бололцоог нь багасгаж, хязгаарлаж байна. Би ч гэсэн хүн амьтантай уулзах тоо толгойгоо багасгасан. Ерөөсөө л контрактуудыг аль болох онлайнаар хийгээд л явж байна. Онлайнаар хийсээр байгаад сүүлдээ онлайн хийхээс, дэлгэц харахаас залхаж эхэлж байна. Амьд хүнтэй уулзмаар байна шүү дээ. Тиймэрхүү л нөлөөтэй байна. Ер нь бол бусдаас илүү юм алга, дутуу ч юм алга, яг бусдын жишгээр явж байна.

Цаг зав гарган манай подкастад орсон Ойдов ахдаа маш их баярлалаа. Цаашдынх нь ажил хөдөлмөрт амжилт, эрүүл энхийг хүсье ээ!

За подкастын хөтлөгч болон подкастыг сонсож байгаа залуучууд бүгдэд нь амжилт чинь өөрөө бас төлбөртэй байдаг учраас амжилт гэхээсээ илүү зүгээр өөрт оногдсон өмнөх зүйлээ л амжилттай хийгээсэй л гэж хүсэж байна. Амжилтын төлөө хэтэрхий их битгий зүтгээрэй л гэж хэлмээр байна.

ӨӨРИЙГӨӨ БИТГИЙ НУУ, НИЙГЭМДЭЭ ИЛ ГАРЦГААЯ!

Н.Лигдэн



Энэ дугаарт "Жонон" бөгөөд "Grooving High" хамтлагийн төгөлдөр хуурч, даралтат хөгжимчин оролцож байна. Та урилгыг минь хүлээн авч подкастад маань оролцсонд маш их баярлалаа. Та манай подкаст сонсогчдод өөрийгөө танилцуулахгүй юу?

Баярлалаа. Сонсож байгаа бүх хүмүүст энэ өдрийн мэнд хүргэе. Орой өглөө, өдрийн мэнд!

Намайг Лигдэн гэдэг. Одоогийн байдлаар ардын хөгжмийн "Жонон" хамтлаг, жаз хөгжмийн "Grooving High" хамтлагт төгөлдөр хуурчаар тоглож байна. Энэ хоёр хамтлагт харьяалагддаг хөгжимчин залуу байна.

Та анх урлагийн ертөнцөд хэрхэн хөл тавьсан бэ?

Ер нь багаасаа хөл тавьсан. Яагаад гэвэл манай эмээ өвөө урлагийн хүн байсан. Манай аав ээж бас урлагийн хүмүүс. Тэр чиглэлээр хөгжмийн сургууль төгссөн. Миний санаж байгаагаар би таван настайгаасаа урлагтай холбогдсон. Бусад хүүхдийн жишгээр сонирхож суралцаж байгаад 16 жилийн өмнө 2005 онд "Свич он" амьд хөгжмийн хамтлагт даралтат хөгжимчнөөр орсноор миний хөгжимчний карьер, хөдөлмөрийн гараа эхэлсэн. "Свич он" хамтлаг маань 2005 онд байгуулагдаж тус хамтлагт 2006-2009 он гээд би тухайн хамтлагаас нэг



жил завсарлаад 2019 оны 9-р сарын 23-нд эргэж ороод тэгээд манай хамтлаг болонгуут дахиад ремэйк рэстарт хийх шаардлагатай байсан. Тухайн үед "Адр" хамтлагийг, одоо "Свич он"хамтлагийн мэдээж одоо амьд хөгжмийн хамтлагаас ар гэрийн шалтгаанаар, эсвэл үзэл бодол нийлэхгүй гэдэг шалтгаанаар яг амьд хөгжмийн хамтлагийн гишүүд ингээд холигдож солигдох, гарч орох асуудал аягүй их байдаг. Явж байгаад "Адр" хамтлаг гэдгийг байгуулаад тус хамтлагт би 2014 оны 12-р сар хүртэл хөгжимчнөөр ажиллаж байгаад тэгээд манай танилууд бас хөгжимчин найзуудаас бас нөгөө филармонид ажилладаг найзууд, дуучин найзууд, эгч ахлагч нараас Хөгжим бүжиг дээр жаз хөгжмийн сургалт явагдаад байгаа юм байна. Чи тэнд нэг ороод суралцаад үзэхэд яадаг юм бэ, чи одоо ингээд төгөлдөр хуурч хүн хүн юм байна, мэдээж бас тэгээд залуу хүн бас апдэйт хийх хэрэгтэй байх гээд тэгсний үндсэн дээр яг 2015 оны 6 сард билүү дээ яг шалгалт өгсөн. За тэгээд яг тэр шалгалт өгөөд яг хариу өгнө өө гээд хэлсэн. Тэгэнгүүт тэрийг хүлээгээд байж байсан. Тэгэнгүүт хоёр хоногийн дараа одоо энэ "Бөртэ" хамтлагийг үүсгэн байгуулагч, одоо "Алтай" хамтлагийн продюсер Ганпүрэв ах маань тухайн үед яг нөгөө төслийн удирдагчаар ажиллаж байсан. Тэгэхэд над

руу яриад за миний дүү ингээд төгөлдөр хуурчаар ингээд шалгалт өгөөд "Жи Эм юби" буюу "Геоди мюзик Улаанбаатар лайбер" гээд жааз хөгжмийн сургалтад тэнцсэн шүү. Баяр хүргэе. Тэгээд тухайн үед одоо хэрхэн хичээлдээ хамрагдах талаар одоо удирдамж өгнө гээд тэгж хэлж байхад маш их баярласан. Би бол хувьдаа яг ингэж боддог юм. Одоо жишээ нь яг энэ "Жи Эм юби" буюу "Геоди мюзик Улаанбаатар лайбер" гээд яг энэ Хөгжим бүжгийн дэргэдэх жааз хөгжмийн тэнхим болонгуут яг энэ амьд хөгжмийн одоо би нар одоо жишээ нь юу байхыг нь мэддэг тэгэнгүүт яг номоор нь сурах тийм ээ, яг яавал зөв суралцаж болох вэ, яавал энэ амьд хөгжим тоглож байгаа, энэ сонирхож байгаа хүүхдүүдэд илүү үр өгөөжтэй талаас нь байх уу гэдэг юмыг яг стандартын дагуу анхан шатнаас нь бий болгосон Монголд хамгийн анхны сургалт байхгүй юу. За товчхондоо тайлбар хэлэхэд бол ийм байна

Энэ сургалтад ингээд тэнцсэнээрээ одоо хүртэл маш их баярлаж явдаг. Яагаад гэхээр хэчнээн тоглодог байсан ч гэсэн ийшээгээ орсноор одоо маш сайжралыг олсон. Нөгөө талаар одоо гадаад дотоодын багш нараас маш их зүйлийг сурсан, одоо хүртэл тэгээд зарим нэгтэй нь холбоотой байдаг. Яг тэр тухайн үед орсон ангийнхантайгаа ч гэдэг юм уу, бид нарт зааж байсан манай бас дээр бас нэг анги байсан. Тэд нартайгаа асар их зүйлээр холбогдож яавал зөв хийж байна, яавал буруу юу хийж байна, яавал одоо энэ яг орчин үе шигээ ингэж дуугарах гээд байна, онол практикийг нь яг юун дээр суурилаад байна гэдэг юмыг яг энэ сургалтаас одоо анхан шатнаас нь гэх юм уу зөв сурч авсан гэж бодож байдаг. Тэгээд тэр тухайн үед очоод бид нар яг хоёр дахь нь юм билээ. Одоо хамгийн анхных нь гэх юм бол одоо яг энэ манай амьд хөгжим сонирхогчид их сайн мэдэх байх даа. Манай одоо сол гитарист Атка ах маань байна, Отгонбаяр ах байна. "Э саунд" (A sound) хамтлагийн даралтат хөгжимчин, төгөлдөр хуурч Пүрэвсүх ах маань байна, "Пауз" хамтлагийн дуучин Хишгээ эгч байна. Тэгээд манай Цэргийн дуу бүжгийн чуулгын бөмбөрчин Батцоож ах байна. Анхандаа бас багш байсан, тэгээд сүүлдээ манай "Grooving High" хамтлагийн аргил гитарчин Мөнхбаяр гэх мэтчилэн маш авьяаслаг хөгжимчид болонгуут яг энэ анхны жилд нь орж суралцсан байдаг юм. Аа тэгэнгүүт яг манай тэр 2015 онд орсон элсэгчид бол яг хоёрдугаар элсэгчид байхгүй юу. Тэгэнгүүт дээд талынхаа ангийнхаа ах эгч нараас асууна, найзуудаасаа асууна, багш нараасаа асууна. Гадаад дотоодын багш нараас зөндөө юм сурч байгаа байхгүй юу. Дашрамд хэлэхэд энэ төслийг оруулж ирсэн тухайн үеийн Хөгжим бүжгийн удирдлага, шалгалт авч одоо яг итгэл үзүүлсэн, энэ сурч чадна гээд ингээд тэнцүүлээд цаашаагаа ингээд өдий хүртэл ингээд тордоод ирж байгаа Мортен Сенкер багшдаа болон Ганпүрэв ахдаа маш их баярлаж талархаж явдгаа илэрхийлье гэж хэлэхийг хүсэж байна. За миний бол урлагтай холбогдсон түүх бол товчхондоо бол энэ.

Та анх төгөлдөр хуур ингээд сурч байхад болохоор танд ямар байсан юм бэ?

Би өөрөө их сул хараатай хүн байхгүй юу. Тэгэнгүүт янз бүрийн нөгөө нэг яг урдах тийм цаас нь одоо хараад яг энэ төгөлдөр хуурын нотны парт дээр ингээд тавигдаад пулт дээр тавигдаад тоглож байгаа нотыг харахад аймаар төвөгтэй байсан. Тэрнээс биш одоо юу гэдэг ч юм хараагүй хүн, хараа сул хүн ч гэдэг юм уу, нэг талаараа чих нь маш сайн хөгждөг. Яагаад гэхээр энэ яг хүртэхүйгээрээ аль нэг эрхтнээ нэг тийм нэг орлодог гэсэн нэг тийм шинжлэх ухаан л яваад байх шиг байгаад байгаа юм. Би бас хожим нь нэлээн уншсан. Одоо жишээ нь Монголд ч байдаг байх. Дэлхийд одоо жишээ нь Рей Чанс, Би Вондер гээд ингээд мундаг мундаг, тийм нэг хараагүй, хараагаа алдчихсан, тэгсэн мөртөө дэлхийн бараг од болчихсон хүмүүс байдаг. Эд нар ингээд хараагүй мөртөө чихээрээ хараад байгаа гэж ойлгодог байхгүй юу. Одоо түрүүний хэлээд байгаа тийм шинжлэх ухаан шиг байгаад байгаа байхгүй юу. Аль нэг төрлийн, одоо бид нар чинь одоо нэг таван мэдрэхүй яваад байгаа шүү дээ. Харах, сонсох, хүртэх, амтлах ийм таван мэдрэхүй яваад байгаа. Тэгэнгүүт аль нэг нь алдчихсан байлаа гэхэд аль нэг мэдрэхүй нь тэрийгээ ингээд нөхөж байдаг. Бид нар нэг тийм мэдээлэл авах ийм хоёр эрхтэнтэй байгаа шиг байгаа юм. Тэр юу вэ гэхээр сонсох, харах. Тэгэнгүүт харах чадвараа алдчихсан хүний сонсгол нөгөөтээгүүр илүү хөгждөг байж магадгүй гэж ойлгосон. Тэр утгаараа өөрийнх нь асуудгаар яг юу хэцүү байсан бэ гэдгийг нэг бодлын харах хэцүү. Гэхдээ нөгөө талаараа яг тэр тухайн үед сонсож байгаа юмыг яг хөгжим дээрээ яавал илүү дөхүү тоглож болох вэ, яавал илүү үнэнд ойрхон оруулж болох вэ бид оруулаад чаддаг байсан. Нөгөө талаар харахад хэцүү байсан. Энэ бол асуудалгүй. Тэгэхээр бараг надад юу гэдэг ч юм харах дээр асуудал байсан уу гэхээс биш яг сонсоод суралцах тал дээр бол нэг тийм асуудал байгаагүй гэж боддог.

Та тэгвэл тухайн үед ихэвчлэн ер нь сонсоод л сурчихдаг байсан уу?

За тийм. Тэгэхдээ сонсоод суралцана. Тэрнээс гадна манай гэр бүлийнхэн намайг дэмждэг байсан учраас одоо миний яг тоглохыг хүссэн бүх ноотнуудыг миний харах бололцоог нь хүртэл томруулж ирдэг байсан. Тэрнээсээ заримдаа ингээд хараад тоглоно, аль нэг буруу юм уу, худлаа тулгаж байгаа зүйлүүдээ тэрнээс залруулж авдаг. Тэгэнгүүтээ байнга харж өөртөө төвөг учруулах биш сонсоод магадгүй би энэ дээр алдчихсан байна гэдэг зүйлээ эргүүлээд тэр ноотноосоо нөхөөд харчихдаг байсан учраас асуудал байхын хувьд байсан. Тэгэхдээ тэрийг өөрийнхөөрөө даваад туулаад шийдээд явж байсан учраас бас харьцангуй гайгүй гэж ойлгож болно.

Ер нь ингээд урлагийн хүн болоод урлагийн ертөнцөд ингээд явахад танд ер нь ямар байдаг вэ?

Мэдээж гоё шүү дээ. Тийм мэдээж гоё. Яагаад гэхээр одоо жишээ нь ингэдэг

байхгүй юу. Тухайн хөгжим чинь хөгжимчин, урлагийн хүн, тамирчин, тамирчин хоёр бол яг адилхан байхгүй юу. Тамирчид жишээ нь хөнгөн атлетын тамирчид байлаа гэж үзэхэд 100 метр тодорхой секунд долинд гүйж байсан бол тэрийгээ нэг секунд, нэг долиор ахиулахын тулд асар их бэлтгэл хийдэг. Тэрийг нь үзэгчид хараад алга ташаад тэр тамирчин илүү урам шагнаад. Яг түүнтэй адилхан урлагийн хүмүүс жишээ нь нэг шинэ гаргаад үзэгчдийн өмнө ингээд тоглохоор тэр алга ташилт бидэнд өгдөг аймаар том урам. Энэ утгаараа маш их гоё. Тэгэхдээ энэ явцад шантрах тохиолдол их байна. Тэгэхдээ тэрийг нэг талаараа бид яг өөрийнхөө таалагддаг зүйлээр өөрийнхөө хийхийг хүсдэг зүйлээр даван туулж байгаа, нөгөө талаар одоо жишээ нь ярьдаг шүү дээ. Өөрийнхөө чаддаг мэддэг юмнуудыг хүмүүс гайхуулаад ингээд явж байх нь аймаар гоё байхгүй юу. Тэгээд надад тэр утгаар нь бол аягүй гоё. Яагаад гэхээр хүнд яг хүнд бэлэн мөнгө өгөхөөсөө, бодит боломжоор нь туслахаасаа илүүтэйгээр урлагийн салбарт нэг бодлын нүдэнд харагдахгүй хэрнээ чихээр дамжиж тэр хүнд аймаар гоё аз жаргал хүрдэг байхгүй юу. Чихээр дамжиж ч гэдэг нь бас нэг өрөөсгөл ойлголт юм. Одоо жишээ нь их гоё зураг зурчихсан байлаа гээд одоо тэр зургийг хараад нүд амрах байдаг юм уу, эсвэл бүжигчин хүн байлаа гэж бодоход ямар гоё уран тансаг гоё хөдөлдөг юм бэ гээд ингээд харах урлагаар таашаал өгчихөж байна. Яг тэрэнтэй адилхан. Энэ ямар гоё аяыг энэ хөгжим шиг ямар гоёор илэрхийлэх вэ гэдэг юмыг хүн сонсоод дотоод ертөнцөө баясгах гэх юм уу, иймэрхүү зүйлийг өгч байгаа. Энийг бол мөнгө санхүү, аливаа юмаар илэрхийлэх боломжгүй. Бид нар энийг үзэгчдэдээ өгч байгаа нь бол бид нарт бол аймаар гоё урлагийн хүн болсны нэг аз жаргал нь гэх юм уу даа.

Та сая шантрах үе байсан гээд ярилаа. Тэгээд яг ямар одоо саад бэрхшээлүүд тулгараад тухайн үед ингээд шантарч байсан бэ?

Хөгжлийн бэрхшээл гэдэг зүйл бол энд бас нэг шантрах юм өгөөд байгаа. Яагаад гэхээр хэрвээ би одоо цоо эрүүл ч байдаг юм уу, цоо эрүүл хүмүүс шиг хардаг, явдаг, сонсдог байсан бол би яг хийгээд явж чадна. Яг надаас шалтгаалах зүйл биш зүгээр нэгэнтээ л ийм болчихсон юм чинь. Яг энэ хөгжлийн бэрхшээл гэдэг зүйлээс шалтгаалж байгаа зүйл аймаар хүндээр тусаж байгаа тохиолдолд энэ бол тодорхой хэмжээний шантрал өгч байгаа. Яагаад гэхээр би ингээд тэрийг хараад ингээд тоглочихмоор байдаг. Адаглаад ингээд нэг ном сэтгүүлээс урлагийн холбогдолтой ч байдаг юм уу ямарваа нэгэн мэдээллийг уншаад өгмөөр байдаг. Гэхдээ яг тэр хүсэж байсан шигээ илэрхийлж чадахгүй байхад л энд л аймаар том шантрал яваад байгаа юм. Тэгэхдээ энэ шантралыг техник технологийн үсрэнгүй хөгжлийн ачаар хамаагүй хөнгөвчлөх, зууны ерээс ерэн таван хувь давж туулах боломжтой болчихсон гэдэг утгаараа миний шантрал гэдэг юм бол энэтэй холбоотой. Нэг талаар техник технологи хөгжөөгүй байхад энэ

бүр илүү илэрхийлэгдэж гардаг байсан шантрал гэдэг зүйл. Одоогоос сүүлийн нэг тав зургаан жил бид энийг давж туулж байгаа юм.

Та тэгээд шантарсан үедээ, магадгүй бас сэтгэлийн дарамт ч юм уу, сэтгэлээр унах ч юм уу тийм үе байдаг байх. Тухайн үеийг яаж, юу бодож ч юм уу давж байсан бэ?

Яг тухайн үед ер нь мэдээж ямарваа нэгэн юм давтах гээд ч гэдэг юм уу, бэлтгэл дээр л ер нь ихэнх юм болдог л доо. Тэгэхээр заримдаа зүгээр тэр асуудлыг хаячихсан зөв юм шиг байгаам. Яг тухайн үедээ хаяад, жишээ нь маргааш ч юм уу, нөгөөдөр ч байдаг юм уу нэгээс хоёр хоногийн дараа давтлаа гэж үзэхэд сэтгэл санаа бас шал өөр болчихсон байдаг. Яг тухайн үедээ бол хаяад өөрийгөө стресс депресс гэдэг юмнаас тухайн үед өөрийгөө 100 хувь чөлөөлөх ёстой. Энэ бид нарт аймаар чухал. Ер нь хөгжимчин хүнд. Тухайн моментод болж байгаа тийм нэг шантрал ч байдаг юм уу, тэр хүн юунаас ч болж шантарч болно. Яг тэр мөчид яг тэр юунаас болоод шантраад байгаа вэ гэдэг асуудлаасаа гараад хийж байгаа юмаа ор тас 100 хувь орхих хэрэгтэй байхгүй юу. Тэрийг маргааш, нөгөөдөр дахиад хийж болно. Тэр болтлоо болохгүй байгаа юмыг дахин дахин болгох гээд байх албагүй. Зүгээр тэр үед нь тэгээд л хаячих, тэгээд ойлгомжтой. Зүгээр өөрийнхөө хоббигоо ч гэдэг юм уу, өөрийнхөө хийх дуртай юмаараа өөрийгөө сатааруулах хэрэгтэй. Нэгэнт болохгүй байгаад байгаа юмыг заавал тэгж явах албагүй, тэгээд л хаячих тэгээд л болоо.

Одоо ингээд тантай ижилхэн урлагийн ертөнцөд ингээд хүч сорьж байгаа тийм залуу уран бүтээлчид ер нь хэр их байдаг вэ?

Тийм ерөнхийдөө байна аа байна. Одоо жишээ нь энэ “Верс персон” гээд энэ наадмын 2009-2010 оны оролцогч Гантөмөр гээд залуу байна. “Андар”-т тоглодог, бас бараг хараагүй шахуу дуучин, гитар тоглодог дуучин залуу байна. Тэгээд миний мэдэж байгаа нь бол тэр байгаа. Тэгэхдээ Соёл урлагийн их сургуульд бас хэд хэд байдаг юм шиг байгаа юм. Би бас яг тэр тэр гээд хэлж чадахгүй юм байна л даа.

Магадгүй манай подкастыг сонсож байгаа, бас тэгээд урлагт дуртай, урлагийн хүн болохыг хүсдэг тийм хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бас байж магадгүй. Тэгээд та тухайн хүмүүст ямар зөвлөгөө өгөх вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй байтугай хөгжлийн бэрхшээлгүй яг энэ урлагийн хүн болъё гээд зорьж байгаа, хөдөлмөрлөж байгаа, одоо яг бэлтгэгдэж байгаа залуучуудад миний хамгийн түрүүнд өгөх зөвлөгөө бол битгий залхуур. Одоо чадахаасаа чадахгүй хүртэл хөдөлмөрлөх хэрэгтэй. Хөгжих хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нь хандаж хэлэхэд жишээ нь та нар ямар ч хөгжлийн бэрхшээлтэй байсан хамаагүй ямарваа нэгэн түрүүний миний

дээр дурдсан шиг одоо чамд ямар нэгэн дутуу юм байж болно. Тэгэхдээ чамд хөгжлийн бэрхшээлгүй хүмүүсээс илүү боломжууд байгаа. Чиний хийж чаддаг зүйлийг, магадгүй тэр хүн чадахгүй ч байдаг юм уу, эс үгүй бол нөгөө талаасаа харахад хөгжлийн бэрхшээлгүй хүмүүсийн чаддаггүй олон зүйлийг чи чаддаг. Тийм байгаа. Гол нь өөр өөртөө итгэ, чи чадна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хандаж хэлэхэд чи, та чадна. Хөгжлийн бэрхшээлгүй хүмүүст хандаж хэлэхэд одоо бид нар юмыг сурахад бол хамаагүй хялбар болчихсон. Адаглаад бид нар ютүбээс хүссэн мэдээллээ авч ашиглаж болж байна. Хүссэн дууныхаа аккордыг хараад тоглож болж байна. Одоо энэ дууг хэрхэн тоглох вэ гээд бичихэд бид өчнөөн олон хандалтууд бичлэгүүд байна. Эд нараас бид нар ашиглах ёстой. Техник технологи гэдэг зүйлийн ачаар бид нарын амьдрал хамаагүй хөнгөн болж байгаатай адилхан. Энийг та дагаад ашиглах хэрэгтэй, болохоосоо болохгүй хүртэл явах хэрэгтэй, гол нь хөдөлмөрлөх ёстой. Битгий залхуур л гэж хэлье.

Таны ер нь цаашдын хүсэл мөрөөдөл яг юу вэ?



Миний цаашдын хүсэл мөрөөдөл гэх юм бол сайн хөгжимчин болох гэж боддог шүү дээ.

Та тэгэхдээ одоо ч гэсэн аймаар сайн хөгжимчин.

Баярлалаа. Ер нь хавь ойрныхоо хавь ойрынхныхоо магтаал гэхээсээ илүү шүүмжлэлийг л хүлээж авдаг шүү дээ. Яагаад гэхээр магтаал гэдэг үг бол тухайн үед аа чи лаг шүү, шинэ сайн шүү гээд чихний хажуугаар нисээд өнгөрч болно. Тухайн үед тэр хүн яг тэр таван минутад ч байдаг юм уу, яг тодорхой хэмжээний минутад омогшоод л өнгөрнө. Шүүмжлэл гэдэг зүйл илүү үлддэг юм болов уу гэж би ойлгодог шүү дээ.

Таны ер нь хүүхэд нас ер нь хэрхэн өнгөрсөн бэ?

Миний хүүхэд нас тэгээд хавар, намар, өвлийн цагтаа бол хичээл сургуульдаа явна. Хөгжмөө давтана. Илүү их бэлтгэл хийнэ. Зуны сайхан цагт бол тэгээд л эмээ өвөө дээрээ үхэр тугалтай л ноцолдож өнгөрсөн шүү дээ.

Аанхан. Та аль сургуульд арван жилдээ аль сургуульд явдаг байсан бэ?

Энэ тухай ярих юм бол жаахан ээдрээтэй. Хөгжим бүжигт явж байгаад дундаас нь 84-р дунд сургуульд орж суралцаад ингээд Хөгжим бүжигтээ ороод төгсөөд тэгээд дараа нь Соёл урлагийн их сургуульд магистр хамгаалаад Чи энд юу би-д суралцаад. Ерөнхийдөө ер нь хүн аливаа нэг цэгт очоод ханах биш, бололцооныхоо хэрээр цаашаагаа сурч л байх хэрэгтэй юм болов уу гэж ойлгодог шүү дээ.

Ер нь бол одоо ингээд Монголд зарим хүмүүс хөгжлийн бэрхшээлтэй гэхээр ингээд жаахан тийм сөрөг хандлагатай хүмүүс байдаг шүү дээ. Таны бодлоор ерөнхийдөө одоо өнөөгийн нийгмийн хандлага ер нь хэр байгаа юм шиг санагддаг вэ?

Нийгмийн хандлага гээд ингээд ярих юм бол аа би бол ингэж хардаг юм. Ингээд гадуур ингээд гудамж талбайгаар алхаад явж байхад хөгжлийн бэрхшээлтэй гэдэг ойлголт чинь өөрөө асар одоо олон зүйлийг хамарч байгаа байхгүй юу. Яагаад гэхээр тэнд одоо саажилтай хүмүүс орж болж байна. Тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс орж байна, харааны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс орж байна, аль нэг мөч нь дутуу хүн орж байна. Яг нийгмийн тал дээр эд нарын амьдрах боломжийг хангачихсан тийм нийгмийн хариуцлагыг биелүүлсэн тийм байгууллага нөгөө талаасаа одоо төрийн ч бай хувийн ч бай байна уу гэхээр байхгүй. Тэгээд дээрээс нь хараад байхад эрүүл хүмүүсийн хөгжлийн бэрхшээлгүй хүмүүсийн хажууд энэ хүмүүс илүү гадуурхагддаг. Одоо жишээ нь юу гэдэг юм, таягтай цагаан таяг тулсан хараагүй хүн хараад л ингээд л их тийм гайхсан нүдээр хардаг. Тэргэнцэртэй хүн яваад өнгийгөөд бас нэг тийм гайхсан нүдээр хардаг. Эвэртэй туулай үзчихсэн юм шиг гэх юм уу даа. Би болохоор энийг

бол асар буруу гэж хардаг. Яагаад гэхээр энэ хүмүүс бол адилхан эрүүл, яг бидний юу сэтгэж байгааг л адилхан тэд сэтгэнэ, бид нарын юу хийж байгааг адилхан тэд хийж чадна. Тэгэхэд бид тэр хүмүүст илүү тийм дэмжлэг туслалцаа өгөх ёстой, аль юу чадахаараа туслах ёстой. Тэгээд би болохоор тэгж хардаг.

Өнөөдөр автобусны буудал дээр ингээд ямарваа нэгэн тохиолдлоор тодорхой хэмжээний минут зарцуулаад зогсоход тэргэнцэртэй хүнийг авдаг автобус байхгүй шүү дээ. Тэгэнгүүт сүүлийн тав зургаан жил болонгуут яах вэ, тэр хүний хараад харааны бэрхшээлтэй хүмүүс хаана яаж буух вэ гэдэг хүмүүс одоо талаар бас нэг мэдээлэл өгөөд байх шиг байгаа юм. Энэ бол авууштай тал нь. Тэгээд нөгөө талаар дүлий хүн ороод төрийн одоо тэр чинь тодорхой хэмжээний нийгмийн харилцаанд л ороод яваад байгаа юм байна шүү дээ. Тэгэнгүүт яг одоо яг Монгол улсад дохионы хэлмэрч гэдэг юм асар цөөхөн байгаа. Тэрийг яг миний дээр дурдсан асуудлыг тодорхой хэмжээгээр хөгжүүлээд явбал манайх нийгэм талаасаа тэгээд нийгэмд оролцож байгаа энэ хувь хүмүүсийн талаарх энэ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ойлгох ухамсар нь тодорхой хэмжээнд дээшилчих юм бол эдгээр хүмүүс эргээд бид нартай зэрэгцээд энэ хөгжилд оролцох оролцоо нэмэгдэнэ. Тэгээд дээрээс нь энд гүйцэтгэх үүрэг роль нь нэмэгдэнэ. Би бас тэгж сонсож байсан юм. 1960-аад оны дундуур билүү дээ, одоо Их Британий Сангийн сайд бил үү дээ бас нэг хараагүй хүн байсан гэж сонсож байсан. Тэгэхээр эдгээр хүмүүсийг бид нар наад захын оролцоогоор нь ингээд дэмжээд өгөх юм бол магадгүй маш том инновацийг бий болгож болно, маш том үүрэг ролийг бий болгож болно. Энүүгээр бас тодорхой хэмжээний манай улсын хөгжил хэмжигдэх юм болов уу гэж л ойлгодог шүү дээ.

Одоо энэ хандлага, тэгээд эдгээр таны ярьсан зүйлийг өөрчлөхийн тулд ерөнхийдөө бид нар өнөөдөр яг юу хийх ёстой вэ?

Эдгээр хандлагуудыг ер нь өөрчлөхийн тулд гэх юм бол ер нь ийм л юм ярих гээд байна. Аливаа нэг шийдвэртэй алхам хийхийн тулд бид нар зүгээр төр засаг, төр засаг гэж ярьсаар байгаад өнгөрдөг. Төр засаг гэж ярихаасаа тэгж томруулахаасаа илүүтэйгээр одоо жишээ нь би юу хийж чадах вэ? Та юу хийж чадах вэ? Адаглаад тэр асууж байгаа тэр газрыг нь чиглүүлээд өгөх, магадгүй тэр хүн такси бариад зогсож байгаа тохиолдолд өмнөөс нь такси бариад туслах, зам гарах гээд, магадгүй тэр хараагүй хүмүүсээ ингээд гарцгүй газраар гарчихаж болно шүү дээ. Тэгэнгүүт тэр гарцтай газраар нь чиглүүлж өгөх, магадгүй зам гаргаад өгөх энэ бол асар жижигхэн юмнаас эхэлнэ. Гол нь төр гэж ярихаасаа илүүтэйгээр бид нар өөрсдөө л тусалчихвал болоо. Энэ магадгүй жижигхэн юм шиг санагдаж болно. Тэгэхдээ энэ жижигхэн юмыг бид нар чин сэтгэлээ сэргээсэн тохиолдолд аливаа нэг зүйл, агуу зүйл энгийн зүйлээс бий болдог гэдэг шиг бий болох юм болов

уу гэж ойлгодог шүү дээ. Бид нар зүгээр наад зах нь зөв хийгээд л туслаад өгөхөд болоо.

Магадгүй би ингээд гудамжинд явж байгаад тэгээд нэг харааны бэрхшээлтэй хүн хажууд зам гарах гэж байгаа гэвэл би ер нь түрүүлээд ер нь яаж тэр хүнд хандвал болох вэ?

Яаж хандах тал дээр гэх юм бол Сайн байна уу? Зам гаргах гэж байгаа юм шиг байна. Танд тус болж болох болов уу? Хоёулаа энэ талаар нь ингээд гаръя, наад чинь гарцгүй газар байна. Бид хоёр зам гаргаад өгье өө гэхэд л болчихож байгаа байхгүй юу. Тэгэхээр тэр хүн чинь мэдээж үгүй гэж хэлэхгүй. Тэгэхэд л баярлаад л өнгөрнө.

Аанхан биед нь хүрч болох уу?

Одоо тэрийг тэгээд л асууж байж болох байх даа. Хоёулаа хөтлөөд явах уу? Танд яавал эвтэйхэн байна? Магадгүй тэр хүн чинь хөөрхий харахгүй ч юм уу сул хараатай хүмүүс чинь тодорхой хэмжээнд тохойноос нь барьж байж эс үгүй бол хөтөлж байж л яг чигээ олох учраас одоо тэр зүг дээр хоёулаа би эхлээд гарцтай



газар олоод өгье. Та намайг дагаад явах уу? За би таныг хөтлөөд явчихсан дээр юм шиг байна аа гэдэг ч юм уу. Тиймэрхүү хандлагаар явах бол илүү дээр байхаа. За зогсож байхад нь ингээд таныг ч гэсэн тийм шүү дээ. Одоо жишээ нь гэнэт нэг хүн ингээд л зам гарах гээд. Магадгүй та ингээд осолтой алхам гарцаар хийж байгаа тохиолдолд хүүе гээд бариад авахад тэр хүн чинь яг тэр хүртэхүй мэдрэмжээрээ аймаар цочрол авах байхгүй юу. Тийм учраас хүүе ч гэдэг ч юм уу, эс үгүй бол хэл ярианыхаа техникийг ашиглаад хамгийн түрүүн тэр хүнд дохио өгөх ёстой. Та ингэх гэж байсан байна аа, чи ийм байна. Хоёулаа энэ талаар нь ингэж явъя, би таныг хөтлөөд явъя гэх юм бол тэгээд ямар ч асуудалгүй байх аа.

Одоо сонсож байгаа хүмүүс маань бас сайн сонсоод аваарай. Тэгээд цаашдаа гудамжинд харааны бэрхшээлтэй юм уу, эсвэл сул хараатай хүмүүст тааралдвал манайхан туслаарай. Одоо ерөнхийдөө ковид цар тахал дэлхий нийтээр тархаж байна. Тэгээд манай Монголд ч гэсэн ихсэж байгаа. Тэгээд ковид цар тахлын нөлөө танд болон таны ажилд хэрхэн нөлөөлж байгаа вэ?

Ерөнхийдөө айдастай байна. Яагаад гэхээр би түрүүн хэлсэн шүү дээ. "Жонон", "Grooving high" гээд хоёр хамтлагт би төгөлдөр хуурч даралтат хөгжимчний үүрэг хашдаг. Тэгэнгүүт нөгөө "Grooving high" хамтлаг маань сэшн бэнд учраас ерөнхийдөө үзэгчид одоо цугларч болохгүй, олныг хамарсан одоо үйл ажиллагаа хийхгүй гэдэг утгаараа завсарласан байна. Нөгөө талаараа "Жонон" хамтлаг маань сонирхуулж хэлэхэд одоо бид нар Битлзийн ковер цомог гэх юм уу даа. Энийг одоо Монголдоо анх удаа ардын хөгжим дээр үзэгчдийн хүртээл болгох гэж байна. Энэ дээрээс юу ярих гээд байна гэхээр бичлэгээ эхэлчихмээр ч юм шиг, эхэлчихмээргүй ч юм шиг, эсвэл бидний ойр дотны хүмүүс ковид ингээд тусаад байхаар бид нарт эргээд ирэх үедэ одоо яах бол? ийх бол гэсэн нэг тийм нэг айдастай байгаад байна. Ер нь бол яг олныг хамарсан үйл ажиллагаанууд мэдээж зохион байгуулагдахаа болиод удаж байна гэдэг талаараа бол нөлөөлж байна. Тэгэхдээ бас ч нэг тийм айхтар нөлөөлсөн юм бас алга аа. Жаахан айдастай байна үнэнийг хэлэхэд. Монгол хүн амны билгээс ашдын билэг гэдэг. Бид нар ковидыг хээгээ нэгэн цагт давж туулж л тааараа. Эргээд урлагийн тоглолтоо мэдээж үзнэ, хаа нэгэн ямарваа нэгэн арга хэмжээ зохион байгуулагдаж байна гэвэл мэдээж үзэгчид цугларах байх. Тэр цаг удахгүй ирэх байх гэдэгт итгэлтэй байгаа.

Та ер нь одоо хэр олон фентэй вэ?

Байдаг юм уу даа. Фэнтэй байна гэж боддоггүй шүү дээ. Тийм надад юу гэдэг ч яах вэ сонсдог хүмүүс байна гэвэл мэдээж баярлана. Тэгэхдээ нэг их тийм олон биш байх аа.

За та цаашдаа ер нь нийгэмдээ хандаж юу хиймээр байгаа вэ?

Нийгэмдээ хандаж тодорхой хэмжээнд

уран бүтээл туурвимаар байна. Яг тэр тухайн хүний бие биш ч гэсэн нэр нь үлддэг гэж ярьдаг. Ардын урлаг ч бай, орчин үеийн хөгжим ч бай энэ хоёр салбарт тодорхой хэмжээнд даацтай яг өөрийнхөө нэрийг үлдээсэн, нэг талаараа хойч үед маань өв болсон тийм уран бүтээлийг хийхийг л мөрөөддөг дөө. Товчхондоо хэлэхэд ийм байна.

За дэлгэрүүлээд хэлж өгөхгүй юу?

Тийм. Одоо миний харьяалагдаж байгаа хоёр хамтлаг хоёулаа л мундаг нэртэй хамтлаг болоосой, мундаг чадамжтай хамтлаг болоосой, эргээд "Жонон" хамтлаг ч бай, "Grooving High" хамтлагч бай сонсоход тухайн үеийн залуучууд одоо залуучуудын хийгээд байгаа ч гэдэг юм уу, хийхийг хүсэж байгаа юмыг бид нар магадгүй тэр хүнд хэцүү байсан бол манай хоёр хамтлагийг сонсонгуутаа миний хоёр хамтлагийг сонсоод өө эд нар чинь аль дээр хийчихсэн юм байна, ингээд л хийчих юм байна, өө энэ ийм юм байна шүү дээ гээд тийм одоо дөтөлсөн юмыг үлдээх, нэг ёсондоо энэ чинь тодорхой хэмжээнд өв болж үлдэнэ гэсэн үг. Аа ийм л юм хийхийг хүсдэг л дээ урлагтаа бол. Энэ дээр бол илүү тодорхой болох байх.

За ингээд ерөнхийдөө манай подкастын цаг өндөрлөх дөхөж байна. Тэгээд та хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж, тэд нарт ер нь нийгэмтэйгээ харьцахад нь зөвлөгөө өгөхгүй юу?

Ер нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд маань нэгэнт л одоо ийм болчихсон гэж хэлэх юм уу, та нэгэнт л хөгжлийн бэрхшээлтэй байгаа чинь үнэн, энэнээс та өөрөөсөө ичих хэрэггүй. Яг тэр өөрийгөө нуух хэрэггүй. Нөгөө талаар өөрийгөө яг үнэн зөвөөр, үнэн бодитойгоор илэрхийлэх ёстой. Энд бид нар зүгээр л одоо жишээ нь би нэг хүнтэй тааралдаад, та нэг хүнтэй тааралдлаа энэ дээр асар нээлттэй байх хэрэгтэй. Зүгээр л яг нийгэм дээрээ л өөр өөрийгөө нээгээд өг. Одоо жишээ нь яг юу гэж харагддаг вэ гэхээр ийм байхгүй юу. Тэргэнцэртэй хүн ч байдаг юм уу, аливаа нэг хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэг ч юм уу тухайн тэр өрх гэр бүлийн тэжээвэр амьтан шиг байдаг. Нэг тэгж их тэгж тэргэнцэртэй хүмүүс нэг салхилаад яваад байдаггүй. Харааны бэрхшээлтэй хүн салхилаад яваад байдаггүй. Ерөнхийдөө нэг тийм нэг жаахан сүүдрийн байдалтай амьдардаг энэнээсээ гарах ёстой. Яагаад гэхээр ийм байгаагаа нийгэмдээ бид нар өөрсдөө илэрхийлэх ёстой. Ийм зүйлийг харж байж нөгөө нэг хэсэг хүмүүс ойлгох байхгүй юу. Нөгөө хөгжлийн бэрхшээлгүй хүмүүст ийм хүмүүс байдаг юм байна, ийм хүмүүс тааралдвал бид нар ингэх ёстой юм байна, ийм сэтгэл зүйтэй харьцах ёстой юм. Гэхдээ нэгэнтээ л амьдраад явж байгаа юм чинь түрүүний хэлсэнчлэн нийгэм дээр өөрийгөө илэрхийл, тэгэхдээ болж өгвөл одоо жаахан мэдээж энэ хүмүүс илүү сэтгэлийн тэнхээ гаргаад амьдарч байгаа. Яг тэр сэтгэлийн тэнхээ дээрээ жаахан л зүйл нэмчих. Нийгмийн харилцаа гэдэг юман дээрээ. Тэр хүмүүс ойлгох ёстой байхгүй юу. Таныг хөгжлийн бэрхшээлтэй хүнийг та өөрийнхөө амьдралыг авч

явахад төчнөөн хэмжээний сэтгэл зүйн тэнхээ зарцуулж байгаа. Хөгжлийн бэрхшээлгүй хүнээс гурав дөрөв тав дахин их зарцуулж байгаа. Энийгээ ойлгуул, энийгээ мэдрүүл. Гэхдээ нөгөө тал энэ болохоор хоёр талтай. Өрөвдүүлж байгаа гэдэг ухаандаа биш. Зүгээр бид нар ингэж амьдарч чадаж байна гэдэг мессежийг өгөх ёстой. Тэрнээс би өрөвдүүл гэж хэлээгүй, өрөвдүүлэх ч ёсгүй. Яагаад гэхээр төдийгөөс өдий хүртэл яг энэ амьдралаар амьдраад ирчихсэн. Магадгүй та зарим нэг хүнээс илүү амьдарч байгаа. Магадгүй та зарим нэг хүнээс илүү зүйлийг хийж чаддаг байгаа магадгүй та тэр хүмүүсээс түрүүний миний хэлсэнчлэн гурав, дөрөв, тав дахин илүү сэтгэлийн тэнхээг гаргаж, өчнөөн олон иргэний зориг шаардсан алхмуудыг хийж байгаа. Энэ дээр та өөртөө л итгэлтэй бай. Тэгээд болоо.

Маш гоё зөвлөгөө өгсөн танд баярлалаа. Тэгээд бас нэг зүйл зүйлийг нэмж асуухаа мартчихсан байна. Одоо ингээд хэрвээ цар тахал дуусах юм бол таны тоглолтыг ер нь хаанаас үзэх вэ?

Манай “Жонон” хамтлаг ч байдаг юм уу, энэ тэнд тоглож байна гэдэг одоо тухайн тэр зан түгээгдэх л байх л даа. Тэндээс үзэж болно гэдгээс илүүтэйгээр манай “Grooving High” хамтлаг чинь одоо яг сешн бэнд болохоор бид нар хаана ч тоглож байж магадгүй. Ихэвчлэн одоо энэ хуримын ордны баруун талд Чойжин ламын музейн бас баруун талд нь “Миранда” гэдэг ресторан доод тал “Фат” гээд жаз клаб байгаа. Ихэвчлэн бид нар тэнд тоглодог, уран бүтээлчидтэйгээ уулздаг. Тэндээс үзэх боломжтой байх.

За тэгвэл цар тахал дуусахаар таны тоглолтыг очиж үзнэ ээ.

Тэгээрэй баярлалаа.

За цаг зав гаргаж манай подкастад орсон танд маш их баярлалаа. Тэгээд таны цаашдын уран бүтээлд тань арвин их амжилтыг хүсээд, тэгээд короно цар тахлын үед эрүүл энх байгаарай гэж хүсэн ерөөе.

Баярлалаа. Намайг бас ингэж тоож урьж оролцуулсанд Антолд подкастын хамт олон болоод өөрт тань маш их баярлалаа. Тэгээд та хэдийн ажилд нь өндрөөс өндөр амжилтыг хүсье. Энэ чинь бас тодорхой хэмжээнд уран бүтээл гэж тооцогдоно л доо. Яг энэ та нарын хийж байгаа уран бүтээл энэ гоё подкастад нь өндрөөс өндөр амжилтыг хүсье. Өөр зөндөө олон гоё сонирхолтой зочдыг урьж оролцуулаарай.

За тэгнэ ээ.

За баярлалаа танд эрүүл энхийг хүсье.

За баярлалаа. Танд ч гэсэн!

АЖИЛДАА ЯМАР Ч САДГҮЙ ЗАМААР ХҮРЭЭД ОЧИХЫГ МӨРӨӨДДӨГ

Б.Бат-Эрдэнэ



Сайн байцгаана уу, эрхэм хүндэт сонсогчид оо, Антолд подкастын маань ээлжит дугаар эхлэхэд бэлэн болоод байна. За энэхүү дугаарт Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооны дэргэдэх "Бэст массаж нэг" төвийн бариа засалч, мөн "Ахиллис монгол клуб"-ын роль модель тамирчин залуу оролцож байна. За та ийнхүү манай подкастын урилгыг хүлээн авч манай подкастад орохоор болсонд маш их баярлалаа. Та манай сонсогчдод өөрийгөө дэлгэрэнгүй танилцуулахгүй юу?

Намайг Баатарсүрэнгийн Бат-Эрдэнэ гэдэг. Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоонд 2012 оноос гишүүнээр элсэж ороод 2014 оноос "Бэст массаж нэг" төвд бариа засалч мэргэжлээр тогтмол өдийг хүртэл ажиллаж байна.

Та яагаад бариа засалч мэргэжлийг сонгоод "Бэст массаж нэг" төвд ажиллах болсон бэ?

За миний хувьд яагаад энэ мэргэжлийг сонгосон бэ гэвэл харааны бэрхшээлтэй иргэдэд түгээмэл, бас хийж чадах тийм мэргэжил бол бариа заслын мэргэжил. За тэгээд нөгөө хүн хараагаа алдахаар мэдрэмж нь гартаа орчихдог энэ тэр гээд ярьдаг, бас гарын мэдрэмж тодорхой хэмжээгээр хөгждөг. За тэгээд урьд нь хүүхэд байхад ч гэсэн бас их баривал их гоё гартай хүүхэд энэ тэр гээд л ярьдаг. Өвөө маань ч бас их барьдаг байсан. Тэгээд ер нь энэ мэргэжилд хүүхэд байхдаа дургүй л байсан л даа. Тэгээд 2007 оноос хараагаа алдчихаад. Тэгээд

2012 оноос Монголын хараагүйчүүдийн хөгжлийн үндэсний холбоонд гишүүнээр элсэж ороод 2013-2014 онд алжаал тайлах бариа засал мэргэжлээр 6 сарын курсэд сурч төгсөөд тэгээд 2014 оноос хойш Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооны дэргэдэх "Бэст массаж" төвдөө тогтмол ажиллаж байна даа.

Та тухайн үед яг анх хараагаа алдчихаад сэтгэл санаа ер нь ямархуу байсан бэ?

Мэдээж тэр үед 16-17 настай яг өгсүүр ид хөдөлгөөнтэй тийм үе байсан. Мэдээж хардаг байж байгаад хараа алдчихаар ямар олиг байх вэ? Тэгээд 4 жил орчим гэртээ байсан даа. За тэгээд бас ээж аавыг бас нэлээд их зовоосон. Хүний эцэг эх л илүү их зовдог шүү дээ. Тийм болохоор эцэг эхээ одоо хэчнээн их зовоох вэ гэж, өөрөө би эцэг эхээ маш их зовоож байна даа гэж боддог л байсан л даа. Тэгээд радио, зурагт л их сонсоно. Тэгээд радиогаар Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо гэж ийм холбоо байдаг гээд яригдаж байсан. Тэр үед нэвтрүүлгийн нэвтрүүлэг энэ тэр бас гараад л тэгж байсан шиг санаж байна. Тэгээд Батноов гуай гээд одоо манай Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооны тэргүүлэгч ерөнхийлөгчөөр ажиллаж байсан хүний яриаг сонсоод за энэ холбоондоо ер нь бас элсэж оръё, энүүнд ороод үнэхээрийн би бас нийгэмшээд нэг ажлын байртай болоод өөрийн гэсэн мэргэжлээ олоод авах юм болбол эцэг эхээ бас зовоох маань багасах юм болов уу гэж бодсоны үндсэн дээрээс 2010-2012 онд яг холбоонд гишүүнээр элсэж ороод тэр цагаас хойш тэгээд өдийг хүртэл ажил мэргэжил эзэмшээд тэрүүгээрээ ажил хийгээд ингээд явж байна даа.

Тухайн үед та холбоондоо нэгдээд хүмүүстэй нийгэмшээд нийгмийн харилцаанд ороод явахад ер нь ямар байсан юм бэ?

За 2012 онд анх Монголын хараагүйчүүдийн үндэсний хороонд элсэж орчихоод урлагийн наадам болно гээд тэр үед чинь дөрвөн жил болдог юм болдог байсан юм шиг байгаа юм. Тэр бол би наадамд нь бэлдэж байх хугацаандаа нэг зургаан цэг хатгаж сурах гээд л тэр зургаан цэгээ хатгаж сураад л ерөнхийдөө зун нь өнгөрчихсөн. За тэгээд хавар нь 4 сарын компьютерын сургалтад урьд нь нөхөн сэргээх сургалтын төв байсан. Нөхөн сэргээх сургалтын төвд компьютерийн сургалтад 4 сар сурч төгсөөд тэгээд ер нь компьютерынхоо чиглэлээр бас ажлын байр тухайн үед бага байсан л даа. 2013 онд онд бол би анхлан суралцаж байсан болохоор компьютер бас төдийлөн сайн сураагүй байх гэж боддог юм. Тэгээд энэ өөрийнхөө хэмжээнд л жаахан сурсан. Тэрнээс одоо ажлын байран дээр гарах хэмжээнд бол сураагүй. За тэгээд ер нь бодож байгаад за илүү ер нь бас надад хэрэгтэй, цаашдаа бас ажиллаад зорилгоо болгоод явчихаар юм юу байна гээд сургалтуудыг нь харж байгаад бариа засал их зүгээр юм байна аа гээд

алжаал тайлах бариа заслаар 6 сар сурч төгсчихөөд 2014 оноос Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооны “Бэст массаж нэг” төвдөө бариа засалчаар орсон байгаа. Бариа засал мэргэжил бол нөгөө хараагүй хүмүүст илүү их хүртээмжтэй, хараагүй хүмүүсийн хамгийн их хийж болох ажлуудын нэг байсан л даа. За тэр үеийн 2013-2014 онд бол яг энэ бариа засал гэдэг зүйл дээр л ер нь манайхан сурч төгсөж энүүгээрээ яг мэргэжил эзэмшээд ажиллаж байсан. Энэ нь илүү их эрт хэрэгцээтэй байсан гэх юм уу. Одоо бол урьд нь нөгөө Нөхөн сэргээх сургалтын төв байсан сургалтын төв маань Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв болж өргөжөөд 2 жилээр морин хуур, хөөмий, даралтат хөгжим, компьютер, нөгөө оператор тэгээд гар урлал гэдэг юм уу ийм чиглэлүүдээр өргөжсөн. Одоо бол бас аль ч талаар нь төгссөн бас ажлын байрууд нэлээн их нэмэгдсэн байгаа. Тэр дундаасаа бол тухайн онуудад хамгийн их эрэлт хэрэгцээтэй нь бариа заслын мэргэжил байсан гэх юм уу даа.

Анх тэгээд та ингээд бариа заслаараа ингээд ажил эрхлээд явж байхад хүмүүстэй харьцахад ер нь ямар байсан бэ?

Мэдээж нөгөө урьд нь хардаг байж байгаад л хараагаа алдчихсан хараагаа алдаж гэртээ байж байгаад л яг нийгэмд гараад өөртэйгөө ижил хүмүүстэйгээ харилцаад явахад бас хүндрэлүүд байсан л даа. Биеэ барих, өөрийгөө зөв талаасаа ойлгуулаад ярилцаж чадах болов уу ч гэдэг юм уу. Ядаж л гараад таягаа бариад явахад хэцүү шүү дээ манай Монголын зам. Тэр зам дээр явахад би ер нь бараг таяг бариад ганцаараа явж чадах юм болов уу энэ тэр гэсэн айдсууд маш их байсан. Тэгээд хүн өөрөө хүсээд зориод зорилго тавиад тэрнийхээ төлөө тууштай явж чадах юм болбол тэр бэрхшээлүүд бол юу ч биш байдаг юм байна лээ. Тэгээд мэдээж тэр зүйлүүддээ багш нарынхаа заавар зөвлөж, зөвлөгөө, тэр бүх зүйлээр ингээд өдийг хүртэл суралцаад явж байна даа.

Та “Ахиллис Монгол” клубийн роль модель тамирчин гэж явдаг. Тэгээд та яагаад анх энэ “Ахиллис Монгол” клубт элсэхээр болсон бэ? Тэгээд бүр цаашлаад ингээд тамирчин болоод олон улсын одоо марафонуудад оролцоод явсан байгаа. Тэгээд энэ талаасаа энэ талаараа бас бид нарт хуваалцахгүй юу?

“Ахиллис Монгол” клубт би 2019 оны 1 сард анх элсэж орсон. Үүнд ороход нөлөөлсөн хүн маань гэвэл одоо параийн хөнгөн атлетикийн Монгол улсын гавьяат тамирчин Лхагважав гуай гэж хөнгөний багш хүн байгаа. Тэр хүн маань анх “Ахиллис Монгол” клубт бас гүйчихээр гүйлтэд сонирхолтой тийм хүн хайж байсан. Тэгээд надад энэ саналыг тавиад миний хүү ингээд энэ “Ахилис Монгол” клубт гүйвэл ер нь яаж байна вэ? Бас ингээд цаашдаа зорилгоо болгоод явах тийм сонирхол байна уу гэж асууж байсан. Тэгээд би өөрөө ч бас гүйх сонирхолтой. За ер нь нэг яваад үзье, ороод үзье,

өөрийгөө бас ажлынхаа хажуугаар бас нэг өөр юманд дайчилж үзье гээд 2019 оноос хойш ороод одоо 2021 он хүртэл 3 жил хичээллэсэн байна.

Анх та ингээд гүйлтээр хичээллэж байх үед ер нь ямар байсан бэ?

Анх гүйж хичээллэж байгаа үе бол анх эхэлж байхад бол гайгүй. Мэдээж дунд нь бэлтгэл хийгээд бэлтгэлдээ ороод ирсэн. Ер нь бол бараг ингэж явах хэрэг байна уу, үгүй юу гээд бас шантрах үе байсан л даа. Тэр үед нөгөө оруулсан багш маань, "Ахиллис Монгол" клубийнхэн маань, гэр бүлийнхэн маань мөн ажлынхан маань ч гэдэг юм уу, маш олон хүн намайг чи чадна аа, чи яв, зорилго тавьчихсан бол тэрүүндээ хүрэхийн төлөө явах ёстой гээд их зоригжуулж байсан. Тэгээд тэр олон хүний итгэлийг мэдээж дааж байгаа учраас хүн шантарч байсан ч гэсэн за би энийг даван туулах ёстой гэдэг зорилгоо бүр улам батжуулж аваад 2019 онд Нью-йоркийн марафонд 42 км 196 м байдаг билүү? За тийм, тэр замаа дуусгаад Виничийн медалиа авсан. Тэгээд анхныхаа 42 км гүйж байгаа юм маань тэр. Ер нь бол 42 гүйнэ гэдэг болбол тэвчээр тэсвэрийг л шалгасан зүйл. Тэгээд би 42-ийг туулах замд бол ер нь л их юм бодогдоно доо. Тэгээд тэрийг ингээд дуусгасны дараах мэдрэмж гэдэг бол нөгөө үгээр илэрхийлэхийн аргагүй тийм сайхан мэдрэмж байсан. Тэгээд тэр цагаас хойш улам их гүйлтэд дурлаж сонирхож улам их дуртай болсон доо.

Тэмцээнд, олон улсын тийм тэмцээнд орохын тулд маш их бэлтгэл сургуулилт хэрэгтэй шүү дээ. Тэгээд та тухайн одоо бэлтгэлээ ерөнхийдөө яаж хийдэг байсан юм бэ?

Манайх мэргэжлийн дасгалжуулагч багштай. Тэгээд мэргэжлийнхээ дасгалжуулагч багшийн заавар зөвлөгөөний дагуу долоо хоногийн хөтөлбөр гаргана. Одоо юу гэдэг юм? Нэг дэх өдөр одоо дөчин минутын кросст, хоёр дахь өдөр нь жаахан темптэй хурдан гүйлттэй, гурав дахь өдөр нь амралтын байдалтай. За дөрөв дэх өдөр нь давтана ч гэдэг юм уу. Тэгээд долоо хоногийнхоо нэг өдөр нь холын кросстой ч гэдэг юм уу. За тэгээд иймэрхүү маягаар ингээд багшийнхаа яг заавар зөвлөгөөний дагуу явдаг. Яг холын кросстой үедээ бол бөөнөөрөө гүйнэ. Бусад үедээ болбол ажил төрөлтэй хүмүүс учраас өөрсдийнхөө зав зай тэр бүх юмыг тааруулаад тохируулаад байгаа байгаа байгаа газраа бусдыг үзэхээр гүйчихээр аюулгүй ямар зам байна тэрэн дээрээ хийнэ. За миний хувьд бол заавал хөтөчтэйгээ хамт хийнэ. Тэгээд хөтчийнхээ ажлыг харна. Өөрийнхөө ажлыг зохицуулна. Тэгээд хоёулаа яриад голцуу цэцэрлэгт хүрээлэн дээрээ, мөн Маршалын дугуйн зам дээр түлхүү хийж байна даа.

Хөтөч тамирчин гээд та сая ярилаа. Энэ хөтөч тамирчингийнхаа талаар та жаахан дэлгэрүүлж ярьж өгөхгүй юу?

Хөтөч тамирчин маань гэдэг болохоороо миний хувьд бол 100 хувь харааны бэрхшээлтэй учраас намайг чиглүүлэх хүн хэрэгтэй. За тэгээд 42 километрийг даван туулахад тэр хүн нэгдүгээр дүрэм бол би өөрийнхөө хувьд тэгж бодож байгаа байхгүй юу. Нэгдүгээр дүрэм нь намайг чиглүүлнэ, хоёрт гэх юм бол мэдээж одоо би гүйж байгаа. За тэгээд нөгөө усаа ядаж гүйгээд зогслоо гэхэд би авч чадахгүй шүү дээ. Тэгэхээр усаа авч өгөх, за тэгээд сэтгэл санаагаар дэмжих. За одоо тэдэн километр гүйж байна, тиймэрхүү зай үлдлээ гээд. Мэдээж би шантарч байгаа юм чинь. Тэгэхээр одоо тиймэрхүү зай үлдсэн байна, одоо жаахан тэвчээрэй, бие нь ер нь ямархуу байна ч гэдэг юм уу, иймэрхүү байдлаар ер нь үүрэг гүйцэтгэдэг. Тамирчдын талаас ч гэсэн тухайн хүний хамт гүйж байгаа юм чинь бас тухайн хүнээ маш их ядраахгүй байх ёстой. Өөрөө бас маш хөнгөн гүйх ёстой. Бас өөрийнхөө темпийг тухайн хүнийхээ темптэй тааруулах ёстой. Бас тэгж гараа тааруулах ёстой. Гар хөлөө зэрэг одоо нэг хүн шиг байж л тэр 42 километрийг даван туулна шүү дээ. Тийм болохоор тэр зүйлүүдийг ингэж хийж нэг хүн шиг бэлтгэл хийхийн тулд бараг бүтэн жил гаруй бэлдэж байж марафоныхоо тэмцээнд явдаг гэсэн үг.

Тэгэхээр бараг тэр хөтөч тамирчин маань тантай яг ижилхэн 42 километрийг хамт даван туулна гэсэн үг үү?

Тэгнэ гэсэн үг. Ер нь бол одоо тийм 42 км-т нэг хүн шиг гүйж даван туулахын тулд



бид хоёр бүтэн жил бэлтгэл хийдэг байх нь байна шүү дээ. Нэг долоогоос найман сарын бэлтгэлийг бол хоёулаа байнга хамт хийнэ. Тэгээд хамт гүйж байх хугацаандаа анх танилцаж байгаа хүмүүс бол бие биеийнхээ занг мэдэх ёстой. За энэ хүн ядраад ирэхээрээ нэг жаахан иймэрхүү зан ааш гаргадаг ч гэдэг юм уу, энэ хүнд одоо иймэрхүү заавар зөвлөгөө өгвөл сэтгэл зүйд нь ингэж нөлөөлнө ч гэдэг юм уу. Аль аль талыг нь ингээд бүрэн мэдэрдэг болчихдог л доо. Одоо бол би хөтөч тамирчинтайгаа гүйхэд ямар ч асуудал байхгүй, хэн хэнийхээ занг мэддэг, хэн хэнийхээ гарын хөдөлгөөн, хөлийн тавилт ч гэдэг юм уу тэр зүйл маань жигдэрчихсэн учраас ер нь нэг хөтөгчтэй байвал бас их зүгээр санагддаг.

“Ахиллис Монгол” клуб гээд та ярьж байгаа шүү дээ. Энэ ер нь ямар учиртай клуб билээ? Та энэ талаар дэлгэрүүлж ярьж өгөхгүй юу?

“Ахиллис” гээд олон улсын байгууллага байдаг. Тэр олон улсын байгууллагын Монгол дахь салбар нь “Ахиллис Монгол” клуб юм. Энэ клуб маань ямар утга учиртай вэ гэвэл хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэмшүүлэх, спортод уриалах, спортоор хичээллүүлэх эрүүл мэнд, за тэгээд олон улсын тэмцээнд бэлтгэж оруулах ч гэдэг юм уу. Иймэрхүү зорилготой үйл ажиллагаа явуулдаг ийм байгууллага байгаа. Мөн “Ахиллис Монгол” бас олон улсын хүүхдийн хөтөлбөр явуулдаг. Энэ нь болохоор ганцхан харааны бэрхшээлтэй биш тэргэнцэртэй, гар нь тайранхай ч гэдэг юм уу. Бүх төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нь хамааруулдаг олон улсын байгууллага байгаа.

Одоогийн байдлаар “Ахиллис Монгол” клуб нь хэдэн тамирчинтай вэ? Хэдэн хүний бүрэлдэхүүнтэй вэ? Тэгээд зөвхөн спортоос гадна өөр төрлийн үйл ажиллагаа явуулдаг уу?

Энэ клуб маань хүүхдэд чиглэсэн хөтөлбөрүүдтэй. Хүүхдэд чиглэсэн үйл ажиллагаанууд явуулна. За мөн насанд хүрэгчид гэхээрээ бид ороод явчихна л даа. Ер нь бид ингээд мэргэжлийн багштай ингээд гүйлтэд бэлдээд олон улсын тэмцээнд авч явдаг. Тэгээд “Гайхамшигт бямба гараг” ч гэдэг юм уу, хагас долоо хоног болгоны нэг өдөр нь сайхан амардаг. Иймэрхүү үйл ажиллагаа явуулдаг. 2019 оноос хойш хийсэн бас хамгийн нэг том зүйл нь болбол манайх цэцэрлэгт хүрээлэнд байртай болсон. Ганцхан “Ахиллис Монгол” клуб биш, бүх гүйгч нарт зориулсан тийм сайхан байртай болсон. Ингээд бас олон үйл ажиллагаа явуулдаг. Ер нь дандаа сайн дурын үндсэн дээрээс дандаа сайн дурын үйл ажиллагаа явуулдаг ийм байгууллага байгаа. Тамирчдын хувьд гэх юм бол одоо ер нь 20 гаруй тамирчин байна. Тэгээд хөтөч бүгдээрээ нийлээд 60 гаруй хүн байна. Би чинь бас шинэхэн ороод, одоо 3 жил болж байгаа, тэрнээс өмнө бас байсан тамирчид энэ тэр гээд би яг тодорхой тоог нь бол сайн мэдэхгүй байна. Гэхдээ миний мэдэж байгаагаар болбол ер нь 20 гаруй тамирчин хөтөч нийлээд 60 гаруй хүн байна.

Таныг болохоор роль модель тамирчин гэсэн. Энэ нь яг ямар учиртай юм бол?

“Ахиллис Монгол” клубээ төлөөлж клубын нүүр царай болж, бүх бэлтгэл сургуулилт хийгээд гадаадын тэмцээн уралдаанд Монгол улсаа төлөөлөх “Ахиллис Монгол” клубээс орох ч гэдэг юм уу тэр зүйлийг л төлөөлсөн үг юм шиг байгаа юм.

Та тэгээд 2019 онд Нью-йорк марафонд очоод оролцсон. Тэгээд 2020 онд бас марафон онлайнаар болсон. Түүнд яг яаж ордог юм бэ? Онлайн марафон гэж ер нь яаж явагддаг вэ?

Онлайн марафон гэхээр бид цаанаа бүртгэлээ өгнө. За тэгээд страбо гээд аппликэйшн ашиглаад страбо аппликэйшн маань яадаг вэ гэхээр ажиллуулаад гүйнэ. Түүн дээр туулж байгаа километр маань цаанаа бүртгэлтэй тэр аппликэйшнийг нь бүртгээд авчихдаг гэсэн үг. Түүн дээрээ цаг минут хэдэн цагт энэ хүн 42 километрийг туулж байна гэдэг юм уу тэрүүгээрээ бүртгэгдээд олон улсдаа ингээд орчихдог. Нью-йоркийнхоо тэр цаанаа ингээд цаг маань бүх юм нь гарчихдаг. Тэгээд тэндээсээ медаль өргөмжлөл тэр бүх юм нь хүрээд ирдэг гэсэн үг л дээ. Онлайнаар гүйж байгаа нь ер нь бол тэр шүү дээ. Дандаа вай фай(wi-fi)-аар орно дататай онлайн байгаа учраас цаанаа страбо-оор холбогдчихож байгаа учраас бидний гүйж байгаа километрийг хянаад явчихдаг гэсэн үг.

Тэрийг болохоор бүх хүмүүс, дэлхийн өнцөг булан бүрт байгаа бүх хүмүүс нэг цагт гүйх гүйнэ гэж байхгүй байх тийм, тэгэхээр бас яах вэ?

Ер нь бүх орноосоо л оролцож байгаа шүү дээ. Нөгөө цагийн зөрүүнээсээ болоод л бүх орноос л оролцож байгаа, тэгээд бүгд гүйх эрхгтэй. Тэгээд тэндээ бүртгүүлчихсэн бол тухайн нэг өдрөө сонгоод өөрийнхөө орон орныхоо боломжтой өдрийг сонгоод гүйдэг гэсэн үг. Одоо жишээлбэл 2020 оны марафон маань болохоор 24-өөс 11 сарын 3-нд болдог. Тэгээд тийм челленж маягаар зарлаад тухайн өдрөө, бид бол 24-эд гүйсэн, тэгээд тухайн өдрөө ингээд сонгоод сонгоод л явчихдаг гэсэн үг. 24-нд өдөр болж байна шүү дээ. Тэгэхээр бид 24-эд өдөртөө гүйчихэж байна аа гэсэн үг.

2021 оны Берлиний марафон нь онлайн уу? Эсвэл та явах уу?

2021 оны Берлиний марафонд бид явна. Бэлтгэл сургуулилтаа базаагаад байж байна. 9 сарын 21-нд бид эндээс ниснэ. 26-нд тэмцээнтэй. Тэгээд энэ жил коронатай үе байсан учраас бэлтгэл сургуулилтаа 4 сараас эхлээд бага багаар гүйгээд, 7 сараас яг эрчимтэй бэлтгэлдээ ороод одоо бэлтгэл сургуулилтаа базаагаад явж байна даа.

Ер нь бэлтгэлтэй үедээ хэр эрчимтэй бэлтгэл хийдэг вэ? Удахгүй та явах гэж байгаа юм байна. Тэгэхээр одоо хэр эрчимтэй бэлдэж байна, бэлтгэл ер нь хэр байна?

За бидний хувьд эрчимтэй бэлтгэл гэдэг нь бол 7 сараас сар сарын хөтөлбөр гаргачихдаг. Ер нь 8 сар бол долоо хоногийн нэг зургаан өдөр нь бэлтгэлтэй. За тэгээд 9 сарын 10-аас хойш бол бэлтгэл сургуулилт маань арай нэг биеэ амраагаад хөнгөн дасгалууд хийж эхэлнэ. Явахаасаа өмнө заавал 28, 32 гүйсэн байх ёстой гээд тийм шаардлага тавьдаг. Тэгээд тэр нь норм нормативаа биелүүлчих юм бол 9 сарын 10-аас хойш дандаа хөнгөн бэлтгэлтэй, биеэ сэргээх зорилготойгоор биеэ амраагаад дасгалаа хийгээд явдаг аа гэсэн үг.

Ингээд та бэлтгэлээ хийх, мөн гадаадын тэмцээнд гадагшаа явах гээд маш их зардлууд гарна шүү дээ. Энэ санхүүгийн асуудлаа яаж шийдэж явдаг вэ?



Санхүүгийн асуудлыг бол энэ жил хөтөч тамирчин хоёр буюу бид хоёрын хувьд бол 16 сая төгрөг болж байгаа. Тэрнээс “Ахиллис Монгол” байгууллага маань 1-2 саяыг гаргаад үлдсэнийг нь бид хоёр зардал мөнгөө хандив босгох, энд тэнд албан газруудаас хандив гуйгаад тэрийг нь сурталчлаад ч гэдэг юм уу, тийм маягаар ер нь явдаг гэх юм уу даа.



Одоогийн байдлаар таны хандив хэд цугларсан байгаа вэ?

Миний хувьд бол яг тэгж ингээд айхтар хандив энэ тэр гэж явсангүй. За энэ коронагийн үед клабхаус гэж нэг юм гарлаа. За тэр платформ дээр ерөнхийдөө яах вэ дуулах сонирхолтой, тэгээд морин хуур хөөмийгөөр сурч төгссөн болохоороо тэр зүйлээ ашиглаад бас урлагийнхантайгаа ч гэсэн холбогдоод. Ингээд сайхан сайн хүмүүстэй танилцчихсан байлаа. Тэгээд клабхаус-таа нэг тийм хандивын сайхан аян өрнүүлчихээд бас хандив өргөсөн хүмүүстээ тайлан тоглолт маягийн юм зориулаад ингээд хандиваа цуглуулаад явж байна даа. Ер нь болбол клабхауст арай л нэг амьд харилцаа үүсдэг. Яагаад гэхээр одоо хоёулаа холбогдоод ярьж байна шүү дээ, яг энүүнтэй адилхан. Ингээд олон хүн ороод ирж болдог ороод ингээд хүнтэй ярьж бодол санаагаа илэрхийлж болдог. Тэгээд энэ зүйлийг ашиглаад явж байна. Анх эхлээд явж байхад жаахан замбараагүй байсан. Одоо бол бас гоё цэгцтэй болоод арай нэг эрэг, нийгэмд зөв хандлага түгээх тийм өрөөнүүд нь ч олон болоод, арай нэг боловсронгуй тэр платформд нэгэн хүн ороод ирэхэд зөв зүйтэй мэдээлэл авчихдаг болсон байх. Тэгээд гоё хөгжөөд явж байгаа.

Та сая корона гээд дурдлаа. Тэд ер нь энэ корона цар тахлын нөлөө, тэгээд таны ажил, та бол бариад засалч хүн байгаа шүү дээ. Тэгээд энэ ажил болон таны спортод ер нь хэрхэн нөлөөлж байна вэ?

За миний хувьд бол бусдын жишгийн дагуу хорих үед нь хоригдоод л, хорио тавих үед нь ажлаа хийгээд л, за хорио тавигдвал ажлынхаа хажуугаар бэлтгэл сургуулилтаа давхар хийгээд ч юм уу ингээд л явж байна. Ер нь л бусдын нэгэн адил мэдээж тэгээд л ажиллахгүй үед бол мэдээж тодорхой хэмжээний санхүүгийн асуудал энэ тэр багасна. Мэдээж ажлаа хийгээд ирэхээр нэг хэвийн нэг горимдоо ороод жигдрээд явна ч гэдэг юм уу. Нэг иймэрхүү байдлаар бас л бусдын жишгээр л яваад өнгөрч байна даа.

Ингээд спортоор хичээллэхээр бие сэтгэл зүйн хувьд би чадахгүй юм байна гэх юм уу нэг бууж өгмөөр үе гардаг гээд ярьсан. Тэгээд о та энэ спортоор хичээллэснийхээ дараа таны бие болон сэтгэл зүйд ямар өөрчлөлт гарсан бэ?

Тийм энэ бол маш гоё асуулт л даа. Миний хувьд болбол урьд нь ер нь тийм сэтгэл зүйгээ удирдах ч гэдэг юм уу, өөрийгөө чи энэ зүйлийг ялж чадна гэсэн итгэл, би өөрөө ялчихсан, харааны бэрхшээлтэй байж байгаад нийгэмшиж чадсан байна, чиний өмнө юу ч тулгарсан даваад гарч чадна гэсэн тийм итгэлтэй байсан бол дахиад би энэ марафоноор хичээллээд 42 километрийг гүйгээд дуусгасны дараа бол чи ёстой болоогүй байсан юм байнаа гэж энэ зүйлээ улам бататгаж авах цаашдаа дахиад аливаа нэгэн бэрхшээл таарвал тэрийгээ улам сэтгэлийн хатаар даван туулах ч гэдэг юм уу тиймэрхүү зүйлүүд их сууж өгсөн. Тэгээд ер нь гүйгээд ирэхэд их юм бодогдоно. Бас их ухаажна л даа. Хүн спортоор хичээллэсэн хүн бол бас их ухааждаг гэж ярьдаг. Тийм болохоор маш их ухаан сууна. Маш их тэсвэр тэвчээртэй болно. Олон юмыг үнэлээд сурдаг болно ч гэдэг юм уу. Ингээд тийм зүйлүүд бас хүнд нөлөөлнө. Ялангуяа эрүүл мэнд тал дээр болбол бас маш сайн өөрчлөлтүүд гарна. Одоо миний хувьд 2-3 жил гүйлтээр хичээллээд хөлс их гарна. Уураг, өөрт байгаа тэр бодисын солилцооны зүйлүүд бага байгаа байх гэж би их боддог байсан. Их алдаж байгаа гэж харж байсан. Тэгэхэд одоо үзүүлэхэд тэр бүх зүйл маань эрүүл гарч байна, тийм болохоор спортоор хичээлсэний ач тус бол нэг тал нь эрүүл мэнд талаасаа бас их сайн байдаг. Тэр тусам одоо гүйлтийг спортын хаан гэж ярьдаг шүү дээ. Тийм болохоор маш их хэрэгтэй зүйл юм гэж ойлгож авсан. Хэрвээ гүйлтээр хичээллэх хүмүүс байвал хамгийн түрүүнд пүүзээ бэлдэх хэрэгтэй. Тэгээд мэргэжлийн багштай, тэгээд зөв заавар зөвлөгөөтэй бэлдэх юм бол танд маш их ач тустай зүйл гэж хэлмээр байна.

Бас та бас дуулдаг тэгээд морин морин хуур хөөмийг бас давхар суралцаж байсан. Тэгээд энэ талаараа ярьж өгөхгүй юу? Багаасаа дуулах дуртай хүн байсан уу? Эсвэл та сүүлд дуулдаг болов уу?

За багын мөрөөдөл маань бол би хөөмийнд их сонирхолтой байсан. Тэгээд сонирхлоороо бас дуулна. Тэгж явж байгаад 2012 онд анх нөгөө холбоондоо гишүүнээр элсэж зарж байхдаа урлагийн наадам болоод тэрүүнд анх оролцоод

хасагдаж байлаа. Тэгээд би өөрөө ч тийм шартай хүн юм уу? Яагаад би дуулж чадахгүй гэж? Ер нь яагаад энэ зүйлээр ингээд амжилт гаргаж чадахгүй нь ч гэдэг юм уу жаахан тийм шартай ч юм уу яагаад ч тэгж бодсон юм. Тэгээд тийм зорилго тавиад тэгээд ерөнхийдөө дуугаа ер нь мэргэжлээ болтол нь сайхан хөгжүүлье, өөрийнхөө хэмжээнд бүр чадах хэмжээндээ хүртэл хөгжүүлье гээд сайхан хоббигоо хөгжүүлээд явж байна. За хөөмий бол багын сонирхол байсан. Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооны дэргэдэх Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд маань морин хуурын сургалт, хөөмийний дагуул хичээлтэй орж хөөмий бас сураад төгсөөд тэгээд одоо хүртэл ингээд хичээллээд явж байна даа. Бас нэг мэргэжлийн тал руу нь болгочих гээд сайхан хичээллэж байна.

Та бас нөгөө хамтлагт байдаг гээд тэгсэн?

Тэр хамтлаг маань болохоороо хараагүйчүүдийн сургалт, хөдөлмөр, сургалт хөдөлмөрийн үйлдвэрийн төв гэж байдаг. Тэнд нэг төслийн хүрээнд хөөмийн дөрвөл, хуурын дөрвөл гээд нийлээд нэг хамтлаг болох зорилготойгоор явж байна. Тэгээд энэ төсөл маань бас сайн хэрэгжээд цаашаа өргөжөөд явах юм бол бид бүр нэг тийм цогц хамтлаг болъё гэсэн зорилготой. Тэгээд тэр хамтлагтаа орчихсон явж байна даа.

Та урлагт авьяастай, тэгээд мөн спортын хувьд хүртэл амжилт гаргаад явж байгаа нь надад их мундаг санагдаж байна. Тэгээд танаас ингээд эрч хүч аваад явж байна. Тэгээд таны хувьд цаашид ер нь юу хийхийг хүсдэг вэ? Таны хүсэл мөрөөдөл юу вэ?

Ер нь бол би ингэж боддог. Хүн залуу байгаа үедээ л хөдөлмөрлөх ёстой гэж боддог. Хүн залуу байгаа үедээ хийж чадна гээд тэр зүйлийг бариад авсан бол эцсийг нь үзэх хэрэгтэй гэж боддог. За ер нь би тавин нас хүрлээ гэж бодъё. Аа тавин наснаас хойш бас эрх чөлөөтэй дурараа баймаар байна шүү дээ. Тийм ээ, залуу насандаа сайхан хөдөлмөрлөөд сайхан гоё амьдралыг төслөө босгочихоод өтөл насандаа хүн чинь бас тийм биз дээ. Энэ сайхан уужим дэлхий байна. Энэ сайхан дэлхийгээ бас нэг тойрч аялах хэрэгтэй шүү дээ. Хүн чинь бас юм үзэх хэрэгтэй. Тийм болохын тулд хүн залуу насандаа хөдөлмөрлөж ер нь залуу насандаа бас хөдөлмөрлөснөөрөө хүн тэр амьдралаа эргээд нэг харахад за би ч бас нэг ийм юм хийчихсэн шүү дээ гээд харамсахгүй шүү дээ. Тэгж их боддог. Тийм болохоор би одоо хүсэл мөрөөдлийнхөө нэг жаахан хэсэгт л явж байна гэж харж байгаа. Мэдээж яах вэ, тодорхой хэмжээний амжилт гаргаад ингээд явж байгаа ч гэсэн одоо болоогүй байна. Мэдээж 100 хувь амжилт гаргана гэж бол байдаггүй. Аливаа нэг зүйлд ядаж 70-80 хувийн амжилт гаргачихсан байх юм бол би тавин нас хүрээд дэлхийгээр аялж байхдаа эргээд бодохдоо бас нэг сэтгэл хангалуун байх юм гэж боддог. Тийм болохоор ер нь залуу хүмүүс бол залуу насандаа л яг

юу хийж чадахаар байна тэр зүйлдээ л хөдөлмөрлөж сурах хэрэгтэй юм шиг санагддаг.

Тэгээд бас хараад байхаар одоо хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зарим нь болохоор нийгмээс нуугддаг ч юм уу, эсвэл гэрийнхэн нь одоо гараад яах юм, миний хүү ч юм уу, миний охин гэртээ байж бай ч гэх юм уу нэг тиймэрхүү хандлагаас болоод нийгэмтэйгээ нэгдэж чадахгүй нийгэмшихээс айдаг ч юм уу, бэрхшээдэг тийм хүмүүс бас нэлээн ажиглагдсан. Та тийм хүмүүст ер нь юу гэж хэлэх вэ?

За ер нь тийм хүмүүс болбол нэлээн байгаа байгаа. Ялангуяа хөдөө орон нутаг руу болбол нэлээн байгаа байх. За энэ тал дээр өнөө холбоо маань ч гэсэн бас нэлээд түлхүү анхаарч ажиллаад хөдөө орон нутагт байгаа залуучуудыг сургадаг. Тэднийг нийгэмшүүлэх тал дээр нэлээн ажилладаг байх. Мэдээж нөгөө давхар бэрхшээлтэй ч гэдэг юм уу, бас нийгэмшиж чадахгүй тийм залуучуудыг авчраад нөхөн сэргээх сургах зорилготойгоор, бас бүх зүйлийг нь зааж өгөөд явж байна. Мэдээж 100 хувь тэр хүмүүст хүрч ажиллаж байна гэвэл бас худлаа. 30-40 хувьтай бол ажиллаж байгаа байх. Мэдээж тэр үлдсэн хувийг нь бол зарим гайгүй нь өөрөө би нээрээ ингэж байх ч гэж дээ гээд өөрөө зориод ирдэг хүмүүс ч байна. Бүүр ирж чадахгүй байгаа хүмүүс ч байгаа. Хэрвээ одоо үүгээр дамжуулаад тийм хүмүүс намайг сонсож байгаа бол та бүхэн өөрийгөө дайчил, Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо гэж байдаг юм байна гээд энэ зүйлүүдийг хэрвээ сонсож байгаад энэ зүйл рүү хандаад ир. Тэгэх юм бол танд маш их өөрчлөлт гарна. За мөн хажууд нь байгаа эцэг эх нь ч юм уу, ах дүү нь ч юм уу сонсож байгаа бол Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо гэж байдаг. За энэ зүйлтэй ирээд уулзаад ер нь манай нэг хүүхэд ийм байгаа юм аа гээд. Тэрэнд ичиж зовох юм байхгүй. Бид бүгдээрээ л адилхан хүмүүс учраас сайхан чөлөөтэй ярилцаад тэгж бодол санаагаа илэрхийлснээрээ тэр үр хүүхдээ ч гэдэг юм уу, хамаатан саднаа ч гэдэг юм уу, бас нийгэмд хөтлөх, нийгэмшүүлэх тэр хүний амьдралд нь цаашид өөрийгөө аваад явах тэр зүйлийг нь нээж өгч байгаа гэсэн үг шүү гэж бас хэлмээр байна.

Таны бодлоор ерөнхийдөө өнөөгийн Монголын нийгэм хөгжлийн бэрхшээлтэй хүн амьдрахад ер нь хэр таатай вэ?

За одоо амьдарч байгаа 2021 он, анх Монголын хараагүйчүүдийн холбоонд гишүүнээр элсээд орж байсан нийгэм хоёр бас харьцангуй ондоо л болсон байна л даа. Одоо бол арай илүү нээлттэй, бас арай бодол санаагаа чөлөөтэй илэрхийлдэг болчихсон тийм цаг үе болж байгаа юм байна. Урьд нь бол бүрэг байсан. Тэрнээс ч урьдны жилүүдэд бол бүр л бүрэг байсан байх. Би анх 2012 оноос хойш 2021 он хүртэлх хугацаагаа л мэдэх юм байна. За тэгэхэд бол нэлээн нийгэм нь арай гайгүй болж байгаа юм уу

гэж харж байгаа. Яахав болохгүй юмнууд бол байгаа. Замын ослын асуудлууд байна. Одоо чөлөөтэй, хараагүй хүн таягаараа явахад замын голд шон зоогоод хаячихсан. Одоо тийм гэрлийн шонгууд маш их байна шүү дээ. Тэрийг чинь урд талдаа л нэг таяг барьж явж байгаа тулдаа л тойрч явж байгаа юм биш. Одоо таяггүй явдаг бол очоод л мөргөөд л тэр хүний толгой тархинд ямар олиг байх вэ. Тийм тийм зүйлүүдээ бас анхааралд засаад нэг үеэ бодоход бас гэрлэн дохионууд дээр дуу дохио тавигдаад эхэлчихсэн байна. Нэг үеэ бодоход бас арай л янз болж байна. Автобусны буудал дээр байхад хүмүүс хаана суух гэж байгаа юм? яах гэж байгаа юм бэ? гээд бас залуучууд маань тийм ийм хандлагатай болчихсон байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд хаана ч хамаагүй явж байхад бас нэг туслаад өгье ингээд тэгье гэдэг нь арай л нэг нээлттэй болж байгаа юм уу гэж хардаг. Урьд нь бол мэдээж явж байхад за ингээд явж л байг гээд хаяад явдаг хүмүүс байгаа л байх л даа. Гэхдээ арай л нэг илүү нээлттэй болчихсон, арай л нэг чөлөөтэй болчихсон юм болов уу гэж бодож байна. Нийгэм бас арай өөрчлөгдөж байгаа. Мэдээж гаднын орнуудтай харьцуулахад бол манайх арай болоогүй байна. Монголдоо хараагүйчүүдийн үндэсний холбоо маань үйл ажиллагаа явуулж байгаагийн хүчинд бас энэ залуучуудыг сургаад, ганцхан бариа гэлтгүй бас өөр зөндөө олон газруудад ийм ажлын байртай болгоод явж байна. Тэгээд бас сайхан сайхан залуучууд араас мэргэжил боловсрол эзэмшээд гарч ирээд ажилладаг. Ер нь бол хараатай хүмүүсийнхээ дунд ороод ингээд чөлөөтэй ажиллаад л явж байна. Тэгээд нэг үеэ бодоход болбол харьцангуй бас сайхан нийгэм ирж байгаа гэж залуу хүний хувьд харж байна.

Хандлагын хувьд ер нь сайжирсан гэж ярьж байна. Тэгээд энэ нь зөвхөн залуучуудын хандлага байна уу? Нийгэм бүхлээрээ тийм хандлагатай байна уу?

За яах вэ, ер нь нийгмийг бол бүхлээр нь харах юм болбол бас бага л даа. Мэдээж шинэ залуу үе маань арай илүү юу гэдэг юм бодсон, санаж байгаа ч гэдэг юм уу, нээлттэй болчихно ч гэдэг юм уу арай гайгүй байх шиг санагдаад байгаа юм. Ер нь мэдээж одоо бүгдийг харлуулдаг л болчихлоо л доо. Одоо ер нь нөгөө сайхан талыг нь ярихаасаа илүүтэйгээр фэйсбүүкийн виртуал ертөнцөд хар зүйл нь илүү их хандалт авдаг болчихсон байна. Тэгэхээр би нэг их тийм, хар зүйлийг л бас харлуулж ярих аягүй дургүй. Тийм болохоор нийгэм маань ер нь л ихэнх нь л бас сайхан болж байгаа гэж өөрийнхөө хувьд бас харж байгаа. Тийм болохоор тэрнээс илүү гурав дөрвөн жил өнгөрөхөд илүү сайхан болох байх гэж бас бодож байна.

Танд ямар нэгэн байдлаар нийгэмд гомдсон ч юм уу, эсвэл ялгаварлан гадуурхал өгчихсөн ч юм уу тэрнээсээ болоод ингээд сэтгэлийн шарх авч байсан ч юм уу тиймэрхүү үеүд байсан уу?

Үгүй ээ, одоо миний хувьд бол нэг тийм айхтар юм бол байгаагүй. Ер нь хэлэхэд мэдээж харж байгаад харахаа болчихсон гэртээ би дөрвөн жил байсан. Тэр үе болбол жаахан хүнд байсан. Тэр үед миний хамгийн нэг бодож явдаг л юм байдаг юм. Ер нь харахаа болиод эцэг эхээ нэлээн их зовоосон байх гэж боддог. Тэгээд тэр зүйлээ л ер нь нэг жаахан ойлгоогүй ч байсан байх. Жаахан эцэг эхээ зовоосон байх. Тэр зүйлээ эргээд засах юмсан гэж бодож явдаг нэг тийм л юм байна. Тэрнээс нийгэмд мэдээж гараад хүн байгаа орчиндоо зохицоод байгаа юмандаа нийцэж амьдрах ёстой. Би л хараагүй юм чинь хараагүй хүн нийгмээс надад ийм шахалт дарамт ирлээ, нийгэмд намайг хүмүүс автобусны буудал дээр зогсож байхад эд нараас чинь суулгаад өгчихгүй, энэ хүмүүсийн буруу ч гэдэг юм уу, бусад хүмүүс рүү бас юм чихээд байх нь. Миний хувьд сүүлийн үед бол ингээд харж байхад хүн өөр өөрөө бас ямар байхаас шалтгаалж нийгэм нь хүлээж авдаг юм уу гэж бас сүүлийн үед их боддог болсон. Өөрөө бас зөв бодолтой зөв сэтгэлтэй. За мэдээж одоо хараагүй хүн автобусны буудал дээр зогсоод нэг автобус ингээд асуухад хэлэхгүй хүмүүс байна л даа. Зарим нь сайхан хэлээд өгнө энэ гэдэг яах вэ, зовлон бол байна тэр бүгдийг ингээд тооцоод байх юм бол маш их зовлон байна. Гэхдээ тэр болгоныг бас тэгээд л одоо юу гэдэг юм, би л хараагүй учраас л тэр болгоныг өөр дээрээ ингээд л тусгаж хүлээж аваад л энэ нийгмийг буруутгаад энд амьдарч байгаа бүх хүнийг буруутгаад байвал би өөрийнхөө төлөө, өөрийнхөө зорилгын төлөө л зорьж амьдарч байгаа болохоос хүний төлөө ч юм уу, бусдын төлөө амьдраагүй шүү дээ. Тийм болохоор хүн өөр өөртөө бас дайчилгаатай өөр өөрийгөө хурцалсан тийм байх юм бол илүү энэ нийгэмд амьдарч чадах, илүү энэ нийгэмд нийгэмшиж чадах юм болов уу гэж миний хувьд боддог. Тийм учраас одоо би бас өөрийгөө дайчлаад энэ өдүүдэд ингээд өөрийгөө хурцлаад явж байна. Гомдоллоод байвал зөндөө л юм байгаа. Тэр түрүүний ярьсан гэрлийн шонгоос авахуулаад л, ядаж л автобусны буудал руу явахад тэр зам ингээд дундаа тасраад хаашаагаа явж байгаагаа мэдэхгүй ч гэдэг юм уу. Ингээд ийм ийм зүйлүүд бас зөндөө л байгаа. Энэ бүгдийг ингээд тооцоод л тоочоод байх юм бол одоо хэцүү зүйлүүд маш их байгаа. Тийм болохоор бас энэ талаас нь их яримааргүй байна ингээд засрах байх. Би яагаад ийм сэтгэхүйтэй болж ирсэн бэ гэвэл бүр нэг зүйл дээр аймаар жаахан эмзэглэх ч юу байх вэ дээ, зүгээр боддог юм. Сэтгэл дутдаг юм уу даа л гэж боддог. Ер нь монголчуудын хийж байгаа байдал нь, зам засаж байгаа нь ч тэр, ер нь нийгэмд хандаж байгаа хандлага нь ч тэр зүгээр хүмүүсийн сэтгэл нэг жаахан дутчихсан, жаахан энийг ингэсгээд хийчихье дээ л гэсэн, энийг хийгээд хэдэн төгрөг авчихъя даа ч гэдэг юм уу, эсвэл мөнгө их боддог болчихсон ч юм уу, одоо яагаад ч юм мэдэхгүй би тэрийг ерөөсөө яг ойлгохгүй байгаа, жаахан сэтгэл дутаад байгаа юм уу даа л гэж ойлгодог. Ер нь тэрнээс хөгжлөөрөө бол ингээд харж байхад дэлхийд, гадаадад ч гэдэг юм уу шинэ юм гарч байна. Манай

Монголд орж ирж чадаж байна. Бүх юм ингээд нээлттэй болчихсон, бүх юмыг нэвтрүүлээд оруулаад ирж чадаж байна. Ер нь бол хөрөнгө нь байна уу? Бас байх шиг байгаа юм. Ер нь ингээд ажиглаж байхад.

Гэхдээ нөгөө сэтгэл дутаад байгаа учраас тэр хөгжил бүх зүйл нэг жаахан алдаатай яваад байгаа юм уу даа гэж миний хувьд зүгээр хардаг. Тэгээд энэ зүйл маань бас явцын дунд гайгүй болох юм болов уу даа гээд л сайхан гэгээлгээр бодож явах дуртай. Тэгээд бүх зүйлийг харлуулаад л, яриад байвал яриад л байх юмнууд зөндөө л байгаа. Гэхдээ сайхан гэгээлгээр эргээр бас амьдарч байх юм болохоор хүмүүст илүү эерэг зүйлийг олонд түгээх юм болов уу гэж боддог шүү дээ. Жишээлбэл би “Ахиллис Монгол” клубт ороод л гүйж байна. Одоо намайг хараад зуун хэдэн кг-тай хүн ч юм уу, 100 кг-тай хүн ч юм уу ингээд л хараад л нээрээ энэ залуу бас ингээд гүйгээд бэлтгэл сургуулилалт хийгээд харахгүй ч гэсэн энэ амьдралын төлөө ингээд тэмцээд явж байхад би яагаад хэдхэн кг хаяхын тулд жаахан тэвчээр гаргаад хийчихэд болохгүй гэж гээд хүмүүс сайхан жингээ хаяж байна, нэг хүнд нөлөөлж байна гэдэг чинь тэр хүн цаашид дахиад хэдэн хүн нөлөөлөхийг хэн ч мэдэхгүй. Тэгэхээр ийм бага зүйлүүдээр бас энэ нийгэмдээ бас нөлөөлөөд сайн зүйлд нь нөлөөлөөд л явахыг боддог. Тийм болохоор тэгж сайн зүйлд нөлөөлж байгаа учраас муу зүйлийг нь нэг их тэгж харж яриад байхыг хүсдэггүй. Ер нь тийм ч бодолтой болчихсон гэх юм уу даа. Ер нь яг өдий хугацаанд өөртөө зорилго тавиад л өөрийнхөө төлөө явж



байгаа. Бид нар чинь мэдээж өөрийнхөө төлөө л явж байгаа шүү дээ. Манай холбоонд ажиллаж байгаа хүмүүс бол бас энэ хараагүй хүмүүсийг нийгэмд ажлын байртай болгочих юм сан. Олон нийттэй зөв харилцдаг болгох юмсан ч гэдэг юм уу, хүний төлөө бас явж л байна. Тэгэхээр ер нь яг ингээд сурч байгаа бүх нийтээр хөгжлийн бэрхшээлтэй иргэд маань ч тэр энд амьдарч байгаа залуучууд маань, энэ нийгэмд байгаа бүх хүн маань бас эергээр бүх юмыг хардаг, харлуулж биш гэгээлгээр л хардаг байгаасай гэж миний хувьд бодож байна даа. Тийм байх юм бол тэгээд болно доо.

Ерөнхийдөө манай подкастын цаг өндөрлөх дөхөж байна. Тэгээд танаас сүүлийн асуултаа асууя. Та ер нь Монголыг ирээдүйн магадгүй тав арван жилд ер нь ямар болоосой гээд боддог вэ?

За миний хувьд бол их байшин барилга баригдаад ч юм уу, одоо лаг лаг машин орж ирэхдээ гол нь биш л дээ. Одоо бол маш их байшин баригдаж байна. Одоо маш их машинтай болчихлоо. Тийм байхаасаа илүүтэйгээр энэ хотынхоо түгжрэлийг нэг гайгүй болгочихдог. Одоо ядаж л хүн ажилдаа очиход саадгүй оччихдог тийм сайхан замтай, хараагүй хүмүүс, ер нь бусад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс явахад нэг сайхан тийм явдаг замтай болчихдог. Тийм байхад л ер нь бас болж байгаа байхгүй юу. Одоо тэгэхгүй энэ замын түгжрээнээс чинь болоод л маш их хүмүүс стресстэж байна. Энэ зүйлээс болоод осол аваар ч гэдэг юм уу янз бүрийн иймм юмнууд бас их гарч байна. Тэгэхээр ер нь хотдоо хамгийн эхэнд шийдээд таван жилийн дараа ямар ч хүн гараад явсан ажилдаа саадгүй оччихдог, ямар ч ажил хөөцөлдөөд явсан нь тэнд түгжрэхгүйгээр оччихдог, тухайн дүүрэг, хороо, за нийслэлд юу байдаг юм, ямар ч газар очсон бас нэг оочер багатай, тэр бүх зүйлийг нь ингээд нэг аятайхан, нэг цэгцтэй, хурдан шуурхай явуулчихдаг л болчих юм бол их сайхан байна даа. Тэрнээс одоо хэт олон юм яриад яах вэ дээ. Мэдээж дэлхий чинь хөгжиж байгаа юм чинь хөгжлийнхөө дагуу явах л байлгүй. Тэгэхээр ийм зүйлүүд нь л илүү бас хүртээмжтэй, хурдан шуурхай түргэн байдаг болчихвол нэг ч гэсэн хөгжлөөр дээшлэх юм болов уу л гэж бодож байна шүү дээ. Ийм л байгаасай гэж хүсэж байна даа.

За ийнхүү цаг зав гарган манай подкастад орсон танд маш их баярлалаа. Тэгээд таны удахгүй болох марафоны тэмцээнд нь амжилт хүсье. Тэгээд та маш олон хүнд үлгэр дуурайл болж, маш их олон хүнд урам өгч байгаа шүү гэж хэлмээр байна.

За тэгээд энэхүү подкастад урьж оролцуулсан та бүхэндээ маш их баярлалаа. Тэгээд та бүгдийн ажилд амьдралд нь аз жаргал, хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе!

ХҮРТЭЭМЖТЭЙ НИЙГМИЙГ БИЙ БОЛГОХЫН ТУЛД ОЛОН НИЙТИЙГ ОРОЛЦУУЛАХ ХЭРЭГТЭЙ

В.Ганзориг



Сайн байцгаана уу, эрхэм хүндэт сонсогчид оо, Антолд подкастын маань ээлжит дугаар эхлэхэд бэлэн болоод байна. Энэхүү дугаарт Монголын дауны холбооны тэргүүн Ганзориг оролцож байна. За та манай урилгыг хүлээн авч, манай подкастад орохоор ирсэнд маш их баярлалаа. Та эхлээд манай сонсогчдод өөрийгөө танилцуулна уу.

За урьж оролцуулж байгаад баярлалаа.

Намайг Ванчигийн Ганзориг гэдэг. Би хувийн хэвшилд ажилладаг. Монголын дауны холбоог анх үүсгэн байгуулагчдын нэг, одоо тэргүүнээр нь ажилладаг. Бас нэлээн олон төрийн бус байгууллагад сайн дурааараа ажиллаж нийгмийн идэвхтэй байхыг хичээдэг хүн байна.

Та дауны холбооны талаар дэлгэрэнгүй мэдээллийг сонсогчдод өгөхгүй юу?

Манай холбоо 10 гаруй жилийн өмнө анх байгуулагдсан. Тэр үед одоогийнх шиг мэдлэг мэдээлэл хомс байв. Дауны синдром гэдэг үгийг анх удаа сонсож байгаа хүмүүс олон, яг юу гэдгийг нь мэдэхгүй байсан. Арван жилийн өмнө одоогийнх шиг хаа сайгүй бас оношилдог, тусгай сургууль, ганцаарчилсан хөтөлбөр, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ гээд юмнууд шал өөр байсан. Одоо харьцангуй гайгүй болж байна. Тэр үед эцэг эхчүүд нийлээд өөрсдийнхөө санаачилгаар энэ төрийн бус байгууллага байгуулаад өнөөдрийг хүртэл амжилттай явж байна.Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага. Холбогдсон түүх нь юу

вэ? гэхээр би өөрөө даунтай хүүхэдтэй. Манай хүүг Орхон гэдэг. Одоо насанд хүрсэн. Арван найман настай. Тэр үед жаахан байсан. Анх тийм хүүхэдтэй болсноо мэдээд мэдээж амар байгаагүй. Тэгээд би өөрөө судалж эхэлсэн. Тэр үед интернэт ашиглаад гаднын нэлээн олон тийм байгууллагуудтай холбогдож мэдээлэл авсан. Өөрөө өөрийгөө бас нэлээн цэнэглэсэн. Тэгээд эргээд харахад над шиг бас ийм эцэг эхчүүд зөндөө олон байдаг юм байна. Тэд нартай цугтаа нэгдээд энэ хүүхдүүдийнхээ амьдрах орчин, сурах, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ авах, ажил эрхлэх боломжийг нь олгож, хүний эрхийг нь утгаар нь эдлүүлэх нийгмийн идэвхтэй байх ёстой юм байна гэж ойлгоод, санал нэгтэйгээр эцэг эхчүүд маань хоорондоо нэгдээд энэ холбоог үүсгэн байгуулж байсан. Монголын дауны холбооны зорилго бол их энгийн. Даунтай хүүхэд, хүн болгоныг Монгол улсад нь татвар төлөгч болгоно гэдэг зорилготой. Тэр нь юу гэсэн үг вэ гэхээр татвар төлнө гэдэг чинь орлоготой, ажил эрхэлнэ гэсэн үг. Ажил эрхлэхийн тулд тухайн хүн маань тодорхой хэмжээний боловсрол, мэргэжилтэй байх ёстой. За мэдээж сурч боловсрохын тулд хамгийн гол нь эрүүл байх ёстой. Товчхондоо яг энэ эрүүл мэнд, боловсрол, ажил эрхлэлт гэдэг бол манай холбооны тулгын гурван чулуу гэж хэлж болно. Тэгээд чадлаараа л ажиллаж байна даа.

Тухайн үед таныг анх ингэж энэ талаар ярьж эхлэхэд Монголд дауны хам шинж гэдэг хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт хэр байсан бэ?

За бараг байгаагүй гэж хэлж болно. Мэдлэг мэдээлэл байхгүйгээс болоод эцэг эхчүүд хүүхдээ нуудаг, хамаатан саднаасаа нуудаг, хүлээн зөвшөөрдөггүй. Түүнээсээ болоод одоо ялангуяа залуу гэр бүлийн хувьд салж сарних асуудал, бие биеэ элдвээр хэлэх асуудлууд нэлээн байдаг. Одоо ч гэсэн хаяа надаас бас шинэ эцэг эхчүүд зөвлөгөө авдаг. Яг энэ эхний сэтгэл зүйн процесс тийм амар байдаггүй л дээ. Тэр үед бол ёстой ойлголт, мэдээлэл байгаагүй. Нэг сонины сэтгүүлч надаас ярилцлага авсан. Тэгээд дараа нь гаргахдаа жишээ нь даун гэж бичихийг ор дэрний даавуу шиг “даавууны синдром” гэж бичээд хэвлэж байсан юм. Одоо тэр үетэй харьцуулахад харьцангуй ойлголт мэдээ мэдээлэл гайгүй болж байна. Гайгүй болохын хэрээр эцэг эхчүүд нь бас хүүхдээсээ ичих биш хүлээн зөвшөөрөөд бүр бардам байдаг болоод. Жишээ нь өнгөрсөн оны 9 сараас бүх энгийн сургуулиуд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг(одоо хөгжлийн бэрхшээл гэж бас нэрлэхгүй байгаа. ялгаатай хөгжилтэй хүүхэд гэж нэрлээд байгаа) ялгаатай хөгжилтэй хүүхдүүдийг тэгш боловсролоор хангах хууль гаргаад хувийн, хувьсгалын бүх сургуулиуд, оюуны ялгаатай өвчтэй хүүхдүүдийг сургуульдаа авах тийм хууль журам гараад хэрэгжээд явж байна. Энэ бол асар том ахиц дэвшил. Дэлхий даяар бол “дизабилити” гэдэг үг хэрэглэхээс зайлсхийгээд эхэлчихсэн. “Хөгжлийн бэрхшээл” гэхээр нөгөө юмыг дандаа нөгөө өөр өнцгөөс буруу өнцгөөс нь харж байгаа учраас эргээд түүнийгээ

тайлбарлахад болохгүй байна. Тэгээд хүртээмжтэй нийгэм гээд дэлхий даяар нэлээн эрчтэй ярьж байна. Бид бие биеэсээ ямар нэгэн байдлаар ялгаатай. Тэр ялгааг бид одоо хүлээн зөвшөөрч одоо хамтдаа амьдрах ёстой. Тэр утгаараа "дизэйбл"(-disability) англиар "хөгжлийн бэрхшээл" гэж бичдэг, тэрийг нь "дифферентли эйбилити"(differently ability) гэж ярьдаг болчихоод байгаа юм. "Ялгаатай хөгжил" гээд. Хөгжилгүй биш. Хөгжлийн бэрхшээл бол бий. Би таныг бодвол миний хөгжил одоо жаахан л нэг юмаараа ялгаатай, тэрнээё биш би хөгжилгүй биш. Хуучин хууль дээр бүр аймаар нэр томьёо байдаг байсан. Та нар мэдэж байна уу, үгүй юу? Тахир дутуу иргэд гэж ярьдаг байсан. Аймаар байгаа биз, саяхан хүртэл бид нар хоорондоо тэгж ярьж хэлж хууль нь хүртэл тийм байсан. Тэгээд одоо "хөгжлийн бэрхшээл" гэж яриад, тэрний дараагийн хэлбэр нь "ялгаатай хөгжил" гэж ярьж байгаа юм.

Зарим хүмүүс дауны хам шинж гэж юу юм, эсвэл аутизм гэж юу юм гээд одоо хүртэл бас мэдэхгүй хүмүүс зөндөө байдаг. Та яг дауны синдром гэж яг ямар өөр ямар бэрхшээл байдгийг нь хүмүүст тайлбарлаад өгөхгүй юу?

За тэгье. Дауны синдром гээд синдромын хам шинж гэж орчуулаад байгаа. Энэ бол өвчин биш. Өвчин гэдэг нь тодорхойлолт нь өөр байдаг. Халддаг, халдварладаг, бие эрхтнийг гэмтээдэг гээд. Харин үүнийг өвчин гэдэггүй хам шинж буюу синдром гэж ярьдаг. Тэгээд сонирхолтой нь одоо хүртэл яагаад ийм даунтай хүн төрдөг вэ гэдгийг нээж чадаагүй байна. Шинж тэмдэг нь бол маш энгийн. Хүн хорин гурван хос хромсом, нийт дөчин зургаан хромосомтой байдаг. Энэ бүр генетикийн түвшинд хүн бүтэх үр тогтохоос авахуулаад л ингээд бүр үлддэг зүйл гэсэн үг. Тэгэхэд ямар нэгэн байдлаар нэг хос хромсом нь хос биш гурвалчихдаг. Голцуу дауны хам шинжтэй хүмүүсийн бараг 95 хувь нь хорин нэг дэх хос хромсом нь хос биш гурвуул байдаг. Тэгээд энгийн хүмүүсийг бодвол илүү хромсомтой гэсэн үг. Ийм шинж тэмдэг генетикийн түвшинд байдаг. Тэгээд тэр нь харагдах байдал гаднах төрхөөрөө ямар байх вэ гэхлээр арьс өнгө хамаарахгүй царайныхаа нийтлэг төрхөөрөө хоорондоо маш адилхан байдаг. Жартгардуу нүд, хамар нь бас аягүй хөөрхөн хэлбэртэй. Ямар ч хүмүүсийг хараад за яг энэ даунтай байна даа гээд хэлж болохоор тийм шинж тэмдгүүд байдаг. Даун нь дотроо бас гурав дөрвөн төрөл бий. Хорин нэг дэх хос нь гурвалсан байдаг гэдэг нь болохоороо трисом гээд нэрлэж байгаа юм. Тэр нь болохоор хамгийн түгээмэл байдаг хэлбэр. Тэгээд мозайк хэлбэртэй гэж байна. Мөн хорин нэг дэх нь биш өөр өөр хромсомын хослол дээр очиж илүү хромсом үүсдэг тийм шалтгаан байна. Тэгээд үүнээсээ хамааражаад дөрвөн төрөл байдаг. Гэхдээ бусад нь ховор. Голцуу байдаг нь болохоор хорин нэг дэх хоромсом нь гурвалсан байдаг. Тэгээд үүнээсээ хамааражаад нөгөө удамшдаг удамшдаггүй гэж бас байдаг.Жишээ нь хорин нэг дэх хромсом нь гурвалсан байлаа гэхэд.

Жишээ нь гэр бүлээрээ гэр бүл ахуйн шинжилгээ өгөөд тухайн үедээ ялангуяа залуу эцэг эхчүүдийн анхны хүүхэд нь даунтай гарчихвал маш их айдастай болдог. Дараагийн хүүхдүүд нь яах бол гээд. Тэгэхээр барууны улсуудад жирэмсэн эх болгоноос төрөхөөс нь өмнө нөгөө ДОХ-ын шинжилгээ авдаг шиг яг энэ дауны шинжилгээ авдаг. Монголд ч гэсэн одоо авдаг болчихсон байгаа байх. Тэрнээсээ хамаараад удамшдаг удамшдаггүй хэлбэр нь бас янз бүр байж болно. Дээрээс нь нэг ижил хэлбэр дотор түвшнээсээ хамаараад бас өөр байдаг. Ер нь нийтлэг нэг шинж нь гэх юм болбол энгийн хүнтэй харьцуулбал оюуны итгэлцүүр буюу ай кю(IQ)-ийн түвшин арай бага гэсэн үг. Дотроо тэгээд түвшинтэй. Бараг энгийн хүүхэдтэй адилхан тийм хөгжилтэй хүүхэд байна. Дунд зэргийн хөгжилтэй байна. За нэлээн хүнд хэлбэрийн гэж байна. Тэр нь болохоор хромсомын тооноосоо үл хамаараад дотроо яг тэр хүүхдийнхээ хөгжилтэй холбоотойгоор энэ нь ялгаатай байдаг. Тэгээд нэлээн тийм сэргэлэн хүүхдүүд бол бараг энгийн хүүхдээс чинь ялгарахгүй. Англи хэл сураад кинонд тоглоод, гадны жишээнүүдийг харж байхад зөндөө олон тийм мундаг хүмүүс байдаг. Өөрийгөө илэрхийлээд хүний эрхийн хувьд, хэдэн жилийн өмнө НҮБ-ын нэг хурал дээр гаднын нэг даунтай хүн илтгэл тавьсан байсан. Монгол хүн бас илтгэл тавьсан. Өөрийнхөө эрхийг хамгаалаад Нью-йорк хотод НҮБ-ын индэр дээр. Жил бүрийн 3 сарын 21-нд Дэлхийн дауны өдөр гэж болдог. 3 сарын 21 гэдэг нь 21 дэх хромсом гурвалсан гэдгээс Нэгдсэн үндэсний байгууллагаас зарлаад дэлхийн даавууны өдөр World down syndrom ворлд даун синдром гээд. Бид сүүлийн арав гаруй жил тэмдэглээд явж байна. Яагаад ийм илүү хромсом төрөөд байна вэ гэдгээ учрыг нь одоогоор хэн ч олж чадаагүй байна. Илүү хромсомоос үүдэлтэй юм байна шүү гэдгийг өнгөрсөн зуунд гаднын эрдэмтэн нээгээд түүний нэрээр даун гэж нэрлэгдсэн. Одоо хүртэл шалтгааныг нь олоогүй. Магадгүй олсон хүн нь бараг Нобелийн шагнал авах байх гэж би боддог. Одоогийн байдлаар эрдэмтдийн мэдэж байгаа зүйл юу вэ гэхээр энэ зүйл санаандгүй тохиолдол. Анх эр эм бэлгийн эс нийлээд л яг үр хөврөл бүрэлдэж байхад ийм алдаа гараад илүү хромсом үүсээд байгаа. Юунаас болоод байгаа юм, арьс өнгө, цаг агаар, хоол унд гэдэг ямар ч тийм баталсан юм байхгүй байгаа. Дэлхий даяар дундаж статистик нь 800 төрөлт тутам 1 даунтай хүүхэд төрдөг. Монголд яг тэр багцаагаар тоолоод үзэхээр хэдэн мянгараа даунтай хүүхэд байх ёстой. Одоо манай Монголд жилд ойролцоо 70-80 мянган шинэ хүүхэд төрдөг гэж бодоход 1990-ээд оноос хойш ч юм уу тооцож үзэхэд хэдэн зуугараа хэдэн мянгараа байх ёстой. Гэхдээ харамсалтай зүйл нь юу вэ гэхээр би лав амьдралдаа насанд хүрсэн даунтай хүнийг бараг хоёр гуравхан удаа л харсан. Тэгээд тэр нь юу гэсэн үг вэ гэхээр хоёр шалтгаан байж болох юм болов уу л гэж би дотроо таамаглаад байгаа. Нэгд нь болохоороо одоо хүртэл хүмүүс хүүхдээ нуугаад гэрээсээ гаргахгүй байна. Угаасаа гарлаас ч гэсэн барууныхан шиг тэр сайхан орчин

байхгүй учраас гэртээ нуугаад гадуур явахгүй байна. Хоёр дахь шалтгаан нь магадгүй эрүүл мэндийн шалтгааны улмаас энгийн хүнтэй харьцуулбал дундаж наслалт нь бага байж магадгүй. Даунтай хүүхдүүд хавсарсан эмгэгтэй төрөх тохиолдол түгээмэл байдаг. Тухайлбал зүрхний цоорхой, нүдний хөгжил гээд зүйлүүд байдаг. Түүнээсээ хамаараад багадаа зохих ёстой эрүүл мэндийн үйлчилгээгээ авч чадахгүйгээсээ болоод үндсэн наслалт бага байхыг үгүйсгэхгүй. Тэгээд ийм хүүхэдтэй боллоо гээд тийм гэр бүл, танил нөхөд, найз нөхөд байлаа гэхэд энэ бол ерөөсөө айж ичих зүйл биш. Ялангуяа эцэг эхчүүд аав ээжүүд, хадам аав ээжид нь хэлэхэд энэ бол хэн нэгнийг буруутгах тийм шалтгаан ерөөсөө биш, хэний ч буруу байхгүй, зүгээр санаандгүй тийм тохиолдол гэж ойлгоорой.

Таныг 2018 онд танилцуулсан илтгэлийг би үзэж байсан. Өөр хөгжилтэй хүүхдүүдэд ойр тойрных нь хүмүүсээс муухай хандаж байгаа ч юм уу, ёс зүйгүй ханддаг хүмүүс байгаа тухай судалгааг харсан. Тэгэхэд тэр дунд эмч нар эмнэлгийн байгууллагын ажилчид гэж өндөр гарсан байсан.

Манай холбооны эцэг эхчүүдийн дунд хийсэн судалгаа байгаа. Бид нэлээн олон хүмүүс хамруулаад, хамгийн их гомдоосон хүмүүс гэсэн чинь яг эмч нарыг нэрлэж байсан. Хэд хэдэн шалтгаан байгаа байх. Эхнийх нь бол мэдээж мэдлэг мэдээлэл дутуугаасаа болоод мэдээж тэгж ярьж байгаа байх. Дээрээс нь даунтай хүнтэй



харьцаж үзээгүй, анх удаа харьцаж байгаа учраас мэргэжлийн хүмүүс нь заримдаа хүлээн зөвшөөрч чадахгүй байх шиг байналээ. Гурав дахь зүйл нь болохоор яг тухайн хувь хүний соёл хүмүүжилтэй холбоотой гэж би хэлнэ. Олон ээжүүд бүр уйлаад л надад хэлж байсан л даа. Жишээ нь хүүхэд нь ингэж гарангуут нь даунтай гэдгийг нь эмч хэлэнгүүт мэддэг юм шиг хүүхэд чинь их удахгүй, бараг ажил явдлыг нь бэлдээрэй гээд л дөнгөж хөхүүл хүүхэдтэй ээжид хэлээд л. Худлаа юм хэлээд ээжийг нь сэтгэл санаагаар унагаагаад уйлуулаад явж байсан түүхүүд байна. Одоо тэр хүүхэд нь насанд хүрчихсэн, бүр дэлхийн тусгай олимпд оролцоод медаль аваад ээжийнхээ хамгийн хайртай хүүхэд болчихсон явж байгаа тохиолдлууд зөндөө. Тэгээд мэдлэг мэдээлэл дутуугаас л үүдсэн асуудал бол байгаа. Тийм учраас бид нар анх холбоогоо байгуулаад, монгол хэл дээр материал ховор учраас бүгдийг нь бид англиас орчуулж байсан. Астралийн дауны холбоо, солонгос, япон, израйлуудтай бид хамтарч ажилласан.

Гадны улсуудын туршлага судлаад хэрэгтэй материалын копирайт эрхийг нь авч орчуулаад түгээгээд. Бид 10 гаруй жилийн өмнө анх бараг бүх өрхийн эмч нарт сургалт хийж явдаг байсан. Тэгээд өөрсдөө сайн дураараа номоо хэвлээд үнэгүй тараагаад тараагаад эмч нар сургалт хийгээд эхэлж байсан. Тэгээд түүнээс харахад тэр хүний буруу байгаа ч нөгөө талдаа мэргэжлийн боловсон хүчнийг эмх цэгцтэй зөв мэдлэг, шинжлэх ухааны мэдлэг мэдээллээр хангадаг тэр бааз суурь нь бас хангалтгүй л байсан юм шиг байгаа юм. Одоо болбол цаг өөр болчихсон байх. Тэгэхдээ мэр сэр ийм хүмүүс байгаа. Тэгэхдээ тэр нь мэдлэг мэдээлэл гэхээсээ илүүтэйгээр одоо бол тэгж дүгнэж болохгүй. Энэ бол цэвэр хувь хүний хүмүүжилтэй соёлтой холбоотой. Бас эмч хүний тангараг гэж мундаг зүйл байдаг. Тийм тохиолдлууд одоо ч гэсэн үе үе гардаг. Нийтээрээ л соён гэгээрүүлж байж л энэ хандлага арилах байх гэж боддог.

Дауны синдромтой иргэд Монголд өнөөгийн нөхцөлд амьдрахад хэр юм шиг танд бодогддог вэ?

Амар биш. Эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ, хувийн эмнэлгүүд нэг үеэ бодвол харьцангуй гайгүй болж байна. Бид Гялс төвтэй хамтын ажиллагаатай ажилладаг. Манай Гялс төвийнхэн эмнэлгийнхэн маань манай хүүхдүүдэд бүртгэл нээгээд хромсомыг нь тоолоод, хөнгөлөлттэй үнээр үйлчлээд, магадгүй цаанаа эрдэм судалгааны ажил явж байгаа байх. Одоо хромсомыг Монголд тоолдог, үздэг, оношилдог болсон. Боловсролын тал дээр бид хуучин тусгай сургууль гэж ярьдаг байсан. Одоо тэр хандлага маань бас өөрчлөгдөөд энгийн сургуульд тусгай ангийг нээх, энгийн хүүхдүүдтэйгээ ажиллах гэдэг хандлага нь гараад хууль нь батлагдаад боловсрол нэг үеэ бодвол орчин нь бүрдэж байна. Тэгэхдээ боловсрол, эрүүл мэндийн аль аль тал дээр нь хамгийн том асуудал бол одоо боловсон хүчин буюу хүний нөөцийн асуудал байгаа. Яг энэ даунаар мэргэшсэн тусгай хэрэгцээт боловсролын техник технологийг эзэмшсэн тийм туршлагатай багш нар, эмч нар Монголд ховор хэвээрээ байна. Тэгээд хэдийгээр хууль нь боловсролын тухай хуульд ингээд гарсан ч гэсэн анги танхим нь байгаад байдаг. Тэгсэн ганц хоёр эцэг эхчүүдээс гомдол ирсэн. Манай хүүхдийг энэ сургууль авахгүй байна гээд. Тэгээд яагаад ингэж байна гэхээр багш нь өөрөө амьдралдаа анх удаа даунтай хүүхэд харж байгаа. Тэгээд би яг энэ хүүхдэд ямар аргачлалаар юу зааж өгөхөө би үнэхээр мэдэхгүй байна гээд багш нар нь өөрсдөө бэлэн биш байдаг. Тэгэхээр боловсрол, эрүүл мэндийн салбарт мэддэггүйгээ мэддэггүй зарим хүмүүс янз бүрийн үнэн худлаа юм яриад нөгөө хүмүүсийг гомдоогоод буруу мэдээлэл өгөөд байдаг тийм эрсдэл байгаад байна. Тэгэхээр боловсон хүчний асуудал нэлээн тулгамдаж байгаа. Хамгийн том асуудал минийхээр бол ажил эрхлэлт байна. Хүүхэд жаахан байхдаа асуудлууд нь тэр болгон тодордоггүй юм байна. Хүүхэд цэцэрлэг сургууль гээд

цагаа өнгөрөөх газартай, хамт олонтой байдаг. Тэгсэн хамгийн аймаар юм нь хүүхэд насанд хүрэхээр л эхэлдэг юм байна л даа. Насанд хүрнэ гэж сургуулиа төгсчихнө гэсэн үг. Сургууль төгсөөд даунтай хүүхдүүдийн дийлэнх нь их дээд сургуульд орох боломжгүй. Тэгээд энгийн хүүхэд шиг сураад нарийн мэргэжил эзэмших боломжгүй. Иймд ерөнхий боловсролоо эзэмшээд үндсэндээ очих газаргүй болдог. Буцаад л гэрийн хорионд орохоос өөр аргагүй. Ажил эрхлэх боломж нь байхгүй. Гаднын улсуудад байдаг шиг нийгмийн янз бүрийн төвүүд байхгүй. Тэгээд хамгийн сэтгэл өвдөж явдаг зүйл нь юу вэ гэхээр хүүхэд нь насанд хүрэхийнхээ хэрээр эцэг эхчүүд дагаад нас нь явж байгаа. Тэгээд олон ээж аав надад ярьдаг л даа. За хүүхдээсээ л өмнө үхэх эрхгүй шүү гээд. Яагаад гэвэл хүн бүл цөөтэй, магадгүй айлын ганц хүүхэд байвал аав ээж нь өнхрөөд өгвөл тэр хүүхэд очих газар Монголд байхгүй. Тэр хүүхэд ганцаараа амьдарч чадахгүй заавал асран хамгаалагчтай байна. Тэгээд манайд Батсүмбэрэлийн асрамжийн газар гэж ахмадуудад зориулсан нэг төв байдаг. Шар хаданд бол асрах газар гэхээсээ илүү эмнэлэг юм. Хамгийн дээд талдаа сар орчим эмчлээд гаргадаг юм байна лээ. Өөрөөр хэлбэл тийм өнчин, амьдралын боломжгүй бие даан амьдрах чадваргүй даунтай хүүхэд бол Монголд удаан амьдрах яг үнэнийг хэлэхэд боломжгүй байгаа. Тэр нь одоо бүхэл бүтэн улс гэж бодоход энэ нь байж болшгүй зүйл л дээ. Тэгээд гадны улсуудад болохоороо улсаас нь нийгмийн хамгааллын яаманд ч юм уу хариуцаад ажилладаг олон асрамжийн төвүүд байдаг. Тэнд бүтэн цагаар хүмүүс ажиллаад нийгэмшүүлэх, ажил эрхлэх, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээг хүмүүст хүргээд тэр хүмүүс тэнд амьдраад тодорхой хэмжээний орлого олоод, тэр орлогоороо байрныхаа түрээсээ төлөөд бүр хоорондоо гэр бүл болоод ингээд ажилладаг зөндөө олон кэйсүүд байдаг. Монголд тийм дэд бүтэц ерөөсөө байхгүй. Тэгээд тэр нь одоо хамгийн аймшигтай зүйл байгаад байгаа юм. Энэ нь магадгүй ганцхан даун ч биш, бусад бүхий л төрлийн ялгаатай хөгжилтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ялангуяа өндөр настай хүн, бүл цөөнтэй гэр бүлд тохиолддог хамгийн эмгэнэлтэй асуудал байх гэж бодож байна. Тэгэхээр ойрын үед энийг л ямар нэгэн аргаар манай төрийн ба төрийн бус байгууллагууд хамтраад шийдэх ёстой гэж бодож явдаг. Энэ бол аль нэг төрийн бус байгууллагын хийх ажил биш юм байналээ. Хамаагүй том. Улс нь л өөрөө хийхээс хэдэн эцэг эхчүүд нийлээд хийхэд аягүй хүнд юм байна. Тиймэрхүү л нөхцөл байдалтай байна даа.

Таны бодлоор даунтай иргэдийн эрхийг хамгаалахын тулд бид юу хийх ёстой вэ?

Бид хамгийн түрүүнд хандлагаа өөрчлөх ёстой. Хандлагаа өөрчилж чадаагүй хүн бол ямар ч юм хийж чадахгүй. Бид нараас ийм ялгаатай хүмүүс байдаг. Надад ч гэсэн бас сул тал байгаа. Энэ даунтай хүмүүс дунд биднээс илүү авьяастай, бидэнд байхгүй давуу талтай олон шинж тэмдгүүд байдаг. Бид өөрсдийнхөө ялгаатай

байдгийг л хүлээн зөвшөөрөх хэрэгтэй байгаад байгаа юм. Энэ нь ганцхан давуун дээр яригдахгүй л дээ. Бид улс төр гээд харахад туйлшраад л маргалдаад л. Дэлхийн түүхийг аваад үзэхлээр ерөнхийдөө бие биеэсээ ялгаатай, хөгжилтэй, ямар нэгэн үнэт зүйлээрээ бие биеэсээ өөр хүмүүс гээд эрхийнхээ төлөө тэмцсээр байгаад л амжилтад хүрсэн олон кэйс байдаг. Хамгийн анх өнгөт арьстнууд өөрсдийнхөө эрхийнхээ төлөө тэмцээд тэр Нельсон Мандела гээд өмнөд Африкийг яаж өөрчлөв. Мартин Лютер Кинг тэр эрх чөлөөнийхөө хувьсгалыг хийсэн алдарт үгээ хэлж Америкийн нийгмийг өөрчилсөн. Дараа нь ижил хүйстнүүд болон бэлгийн ялгаатай чиг баримжаатай хүмүүсээс өөрсдийнхөө эрхийг хамгаалаад нийгэмд ингээд хүлээн зөвшөөрөгдөөд танигдаад хүний эрхээ хамгаалаад явж байна. Сүүлийн үед хүйсийн тэгш эрх гэж их ярьдаг болсон. Ялангуяа эмэгтэйчүүд маань өөрсдөө ижил тэнцүү эрхтэй байх шаардлага тавиад нэлээн амжилттай болоод явж байна. Яг үүнтэй зэрэгцээд хөгжлийн бэрхшээлтэй иргэд маань бас өөрсдийн эрхийг хамгаалаад гарч ирж байна л даа. Тэгэхдээ манай энэ ялангуяа энэ даун аутизм гэдэг юм уу, энэ оюуны ялгаатай хөгжилтэй хүмүүсийн хувьд нэг эрсдэлтэй зүйл нь юу вэ гэхээр нийгмийн харилцаанд бусад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бодвол бүрэн орж өөрийгөө илэрхийлж чаддаггүй. За тухайлбал хараа юм уу, сонсголын бэрхшээлтэй, тулгуур эрхтний ялгаатай хөгжилтэй хүмүүс болохоороо оюун ухаан нь зүв зүгээр учраас тэр эрхээ хамгаалаад яриад, бичээд хүмүүстэй уулзаад хурал хийгээд нийгмийн харилцаанд маш идэвхтэй ороод явах боломжтой байдаг, тэгж ч явж байгаа. Манай оюуны ялгаатай хөгжилтэй иргэдийн хувьд бол нэгт өөрийгөө бүрэн илэрхийлж чадахгүй, хоёрт нийгмийн олон харилцаан дунд бүрэн дүүрэн орж ойлголцож чадахгүй учраас эрхээ хамгаалж чаддаггүй. Дуугарч чадахгүй юм чинь. Тэгэхээр хэн нэгэн буюу аав ээж нь, асран хамгаалагч нь, гэр бүлийн хүмүүс нь л тэдний өмнөөс эрхийг нь хамгаалж хөдлөхөөс өөр аргагүй тийм зүйл байгаад байгаа юм. Тийм учраас магадгүй тэр идэвх нь сул учраас өөрийн чинь түрүүн асуусан олон нийтийг соён гэгээрүүлэх, мэдээ мэдээллээр хангах гэдэг ажил нь удаашралтай байгаа болов уу гэж боддог. Тулаад ирэхээрээ яг үнэхээр өөрөө ийм гэр бүлийн гишүүдтэй, эсвэл ойр дотнын хэн нэг нь ийм ялгаатай хөгжилтэй хүн байвал энэ асуудлыг ойлгодог л доо. Огт тийм хүрээлэл байхгүй бол шууд ойлгоод ухаараад явна гэдэг тийм амар биш. Тийм учраас л энэ соён гэгээрүүлэх ажил маш чухал байгаа тэгж байж л хандлага өөрчлөгдөнө.

Оюуны ялгаатай хөгжилтэй хүмүүс маань өөрсдийнхөө дуу хоолойг хүргэж чадахгүйгээс болоод нийгмээс ялгаварлан гадуурхалтыг хэр их авдаг гэж та боддог вэ?

Оюуны ялгаатай хөгжил гэхээр хүмүүс хоёр хандлага гаргадгийн эхнийх нь болохоороо ялгаварлан гадуурхдаг. Хэд хэдэн сургууль дээр гарч байсан. Манай



хүүхдийг жишээ нь тийм хүүхэдтэй нэг ширээнд суулгалаа гээд эцэг эх нь багшдаа, сургуулийн захиргаандаа гомдол гаргаад явж байсан хачин хачин түүхүүд байгаа л даа. Хоёрт нь болохоор хэт өрөвдөх гээд байдаг. Зайлуул ийм гэсэн ийм гэсэн гээд. Тэгээд энэ манай Монголын дауны холбоо нь Дэлхийн дауны холбооны гишүүн, мөн Ази-Номхон далайн дауны холбооны удирдах зөвлөлд нь сонгогдоод ажиллаж байна. Ази-Номхон далайн гэхээр бараг 30-40 улс байдаг. Австрали, Шинэ Зеланд, Япон, Хятадаас авахуулаад. Тэр дунд нь бид бүр удирдах зөвлөлд нь хүндтэй ажилладаг. Манай Эрдэнээ гээд эгч гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан. Тэр олон улсуудын түүхийг нь хараад хөгжлийн процессыг харахаар "Битгий ялгаварлан гадуурхаач ээ" гэж хэлэх нь бол мэдээж боловч "Хэнийг ч ялгаварлан гадуурхах ёсгүй, битгий өрөвдөөч ээ" гэж их ярьдаг болчихсон байна. Миний анзаарснаар 10-аад жил ингэж ялгаварлан яг үнэндээ хэтэрхий бөөцийлж өрөвдөх нь үр дүнгийн хувьд ялгаварлан гадуурхахаас илүү хортой. Яагаад гэвэл өрөвдөж байна

гээд өмнөөс нь бүх юмыг нь хийж өгөөд бие даан амьдрах чадварыг нь сулруулах ч юм уу, нийгмийн харилцааг нь тасалж байгаа процесс гэж үздэг юм байна. Тэгэхлээр одоо бол "Битгий ялгаварлан гадуурх, биднийг битгий өрөвдөөд бай, харин бидний онцлогт тааруулсан орчинг бүрдүүлж өгөөд эрүүл мэнд, боловсрол, ажил эрхлэлт дээр бид өөрсдөө оролцоотойгоор нийгэмдээ чадлаараа бие даагаад амьдармаар байна" гэдэг хандлагууд дэлхийд одоо явж байна. Монголд болохоороо энэ харамсалтай нь жаахан эсрэгээрээ байгаад байгаа. Боломжийг нь олгохгүй байж ялгаварлан гадуурхах бол өрөвдөх байдлаар яваад байгаа. Одоо болохлоороо нийгмийн бүх суурь дэд бүтцүүдийг ялгаатай хөгжилтэй иргэддээ ээлтэй болгочихвол тэр хүмүүс ч гэсэн өөрсдөө амьдралаас таашаал аваад ажил хөдөлмөр хийгээд найз нөхөдтэй болоод гудамжаараа гоё чөлөөтэй алхахыг хүн болгон л хүсэж байгаа шүү дээ. 12 сард хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдөр гэж болдог билүү дээ. Би "Синдикат ток" гэж нэвтрүүлэг хөтөлдөг. Тэр өдрийг тохиолдуулаад би харааны бэрхшээлтэй, сонсголын бэрхшээлтэй, тэргэнцэртэй тэгээд нэг нь оюуны ялгаатай хөгжилтэй хүүхдийн ээжийг нь оролцуулаад нэвтрүүлэг хийсэн. Тэгэхэд тэргэнцэртэй бүсгүй хэлж байсан. Тэр "Бид ямар нэгэн бэрхшээлтэй ч гэсэн бусдын л адил хүн шүү дээ. Би жишээ нь хааяа гоё ресторанд ормоор байдаг, гоё хоол идмээр байдаг, гоё шөнийн клубт орж дэргэд тэргэнцэртэйгээ ч гэсэн гоё бүжиглэж, пиво ууж, вино шимж суумаар байдаг. Монголд тийм үйлчилгээтэй газар байхгүй. Магадгүй орох юм бол нүд нь орой дээрээ гараад гайхаад хараад байдаг. Тэгэхээр бид яг та нарын хүсэж байгаа зүйлтэй л адилхан зүйлийг хүсдэг шүү дээ. Тэгээд тэр орчныг нь бүрдүүлээгүйгээс болоод бид хүний эрхээ, суурь язгуурын эрхээ эдэлж чадахгүй байна" гэж асуудлыг хөндөж байсан. Тэгэхээр бид нар яг энэ "бэрхшээл" гэдэг үгийг ашиглахыг татгалзаад "ялгаатай хөгжил" гэдэг тал руугаа хандлагаа өөрчлөөд энэ өнцгөөр энийг харвал бидний өмнө хийх зүйл асар их байна.

Ерөнхийдөө Монголд хэзээнээс "хөгжлийн бэрхшээл" гэдэг үгийг хэрэглэж эхэлсэн юм бол?

Анх нэлээн хэдэн жилийн өмнө хууль нь гарсан юм. "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах тухай хууль" гэж гарсан санаж байна. Тэгээд тэр үеэс л юм болов уу. Тэрний өмнө миний санахаар намайг жаахан хүүхэд байхад тахир дутуу иргэд л гэж ярьдаг байсан. Бүр "Тахир дутуу иргэдийн үнэмлэх" гээд бүр тийм аймаар байсан. Сүүлийн арав гаруй жил л гэж би бодож байна.

Хүний илэрхийлж байгаа үгээр дамжаад нөгөө хүнд бодол нь суудаг. Тэгэхээр хөгжлийн бэрхшээлтэй гэхээр тэр хүн хөгжихөд нь бэрхшээл үүсээд байгаа гээд ойлгогдоод энэ хүмүүс чинь ингээд хөгжихөд хөгжиж чаддаггүй юм байна гэсэн тийм ойлголт төрөөд байдаг. Тэгэхээр таны ярьж байгаа энэ

ялгаатай хөгжил болохоор надад их гоё санагдаж байна.

Тийм. Одоо яг ингэж ярьж хэрэглэж занших ёстой байна. Магадгүй бараг хуулинд ч гэсэн энэ нэр томьёог оруулах ёстой гэж би боддог.

Та сая хэлж байсан, танай Дауны холбооны зорилго нь болохоор татвар төлөгч иргэн бий болгох гээд. Тэгээд танай Дауны холбооноос ч гэсэн нэлээн хэдэн тийм ажил хөдөлмөр эрхэлтийг дэмжсэн ажлуудыг хийж байсан юм байна лээ. Нэлээн хэдэн дауны синдромтой хүмүүс маань Шангрилад ажиллаж байсан. Азийн хөгжлийн санд бас ажиллаж байсан. Тэгээд аа та хэдийн одоо энэ ажил хөдөлмөр эрхлэлтийн тал дээр яаж дауны синдромтой хүмүүсээ бэлтгээд ажил дээр гаргаж байгаа вэ?

Маш чухал асуулт байна. Эхлээд түрүүний бие биеэсээ ялгаатай гэдэг дээр бас нэг жишээ хэлмээр санагдлаа. Би нөгөө тэргэнцэртэй бүсгүйн жишээг хэлсэн. "Би ч гэсэн ресторанд ороод дарс шимж уугаад хөгжилдөж гоё зугаацмаар байна" гээд. Түүнтэй адилхан, ялангуяа оюуны ялгаатай хөгжилтэй иргэдийн хувьд нас биед хүрээд ирэхлээр энэ бэлгийн бойжилт нь эхэлдэг. Шилжилтийн нас гэдэг шиг мэдээж хүн л юм чинь тэр бүхнийг туулаад л өнгөрнө. Тэгээд олон эцэг эхчүүдийн, ялангуяа насанд хүрсэн эмэгтэй, эрэгтэй хүүхэдтэй оюуны ялгаатай хөгжилтэй, ер нь хөгжлийн бэрхшээлтэй ч юм уу, ялгаатай хөгжилтэй хүүхэдтэй гэр бүлүүдэд тохиолддог асуудал энэ бэлгийн амьдрал нь л даа. Энэ сэдэв нь өөрөө тийм хаалттай ч юм уу, эсвэл нийтэд ярихад таатай сэдэв биш учраас олон хүн ярьж чаддаггүй, асуудлаа гаргаж чаддаггүй, асуудлаа гаргахгүй болохоороо шийдлээ олж чаддаггүй. Ингээд байгаад байдаг. Жишээ нь, гадны өндөр хөгжилтэй улсуудад энэ бэлгийн амьдралыг нь зохицуулдаг тийм үйлчилгээ хүртэл байдаг. Тэгээд энийг жишээ нь манай нэг сэтгүүлч хөндөж нийтлэл бичсэн байсан. Тэгээд маш чухал асуудлыг хөндөж байна даа гээд харж байсан. Тэгээд олон эцэг эхчүүдийн хувьд энэ маш том асуудал нь байдаг. Харамсалтай нь ил гаргаж чаддаггүй. Тэгээд бид иймэрхүү асуудлуудыг одоо хүртэл шийдэж чадаагүй гэхээр манай нийгэмд ямар том ажил хийх ёстой байна вэ, тэр ажлыг хийхийн тулд бид хандлагаа яаж эрс өөрчлөх ёстой болсон бэ гэдэг ийм л жишээ байгаад байна. Ажил эрхлэлтийн хувьд бидний гол зорилт болоод байна. Ялангуяа насанд хүрсэн хүмүүсийн хувьд бие дааж амьдрах шаардлага үүснэ. Тэгээд аав ээж нь байхгүй боллоо гэж бодоход тэр хүүхэд цаашаа амьдраад явах ёстой. Түүний тулд санхүүгийн хувьд хэн нэгнээс хамааралтай байх ёсгүй болж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд өгдөг халамжийн мөнгө байдаг. Тэдэнд халамж гэхээсээ илүү ажил хийх гэдэг, даунтай хүмүүсийн хувьд мөнгө бол биш, цалин орлого биш зүгээр л хамт олонтой болж нийгмийн нэг эд эс болж, өглөө гараад алхдаг, уулздаг хүнтэй, тэр нь өөрөө хамгийн том зорилго байдаг. Тэгээд ажил хийж байгаа даунтай

хүүхдүүдээсээ асуухад "Мөнгө төгрөгтөө гол нь биш ээ. Ажил өөрөө миний одоо аз жаргал юм аа","Би ажилдаа их дуртай, яагаад гэвэл хүмүүстэй харилцаж, гудамжаар явж хүнд үйлчилж энэ нь өөрөө миний хувьд хамгийн том аз жаргал" гэж хэлж байсан. Иймд ажил эрхлэлтийн хувьд бид энэ зүй ёсны шаардлага хэрэгцээг нь урьдчилж харвал эхлээд бид хөдөлмөр сургалтын төв байгуулах ёстой юм байна. Гадны жишээнүүдийг харахаар даунтай хүмүүс ихэвчлэн үйлчилгээний салбарт түлхүү ажилладаг. Жишээлбэл, дэлгүүрт бараа бүтээгдэхүүнийг нь уут саванд хийх, шуудан нэлээн их ялгадаг. Үйлчилгээний газар зөөгч хийдэг, кофе шопт олноор ажилладаг. Тэгээд иймэрхүү хөнгөн хэлбэрийн ажлуудын дадалд сургах төв байгуулсан. Манай хөдөлмөр сургалтын төв Зориг сангийн ард байдаг. Бид хүүхдүүдийг бэлэн мөнгөтэй харьцаж сургадаг. Жишээ нь 5000 төгрөг хүн өгөөд 1000 төгрөгийн юм авлаа гэхэд зөрүүлээд 4000 төгрөг хариулж өгнө. Түүний тулд бүх арга техник заахаас авхуулаад хүнтэй харьцахыг заана. Манай даунтай хүмүүс чинь тийм хар буруу санаа гэж ер нь байдаггүй. Худлаа ярьчихад мэддэггүй, муу юм боддоггүй. Тэгээд л бараг хүн болгоныг л "аав аа, ээж ээ" гэж бодоод л очиж тэвэрч аваад л, үнсээд л хамаагүй байдаг. тэгээд мэдээж нөгөө нас биед хүрсэн хүмүүсийн хувьд болохоо. Тэгээд жишээ нь эмэгтэй хүний биеийн хаана нь хүрч болох юм, хаана хүрч болохгүй юм гэдэг зүйлийг нийгэмших хичээл байдаг. Тиймэрхүү арга техникийг нь зааж өгөөд ажлын байран дээр гаргах гол зорилготой ажилладаг. Сүүлийн нэг жил гаруй ковидын улмаас эрсдэлтэй бүлэгт ордог учраас бид үйл ажиллагаагаа явуулахгүй байгаа. Дархлаа нь энгийн хүнийг бодвол арай сул учраас нөгөө өвчинд нэрвэгдэх магадлал өндөртэй. Иймд бид хаалтын байдалтай байгаад байгаа. Бид хэд хэдэн хүнийг ажилд амжилттай зуучилж оруулсан. Манай хамгийн анхны албан ёсоор ажилтай болж цалин авсан хүн бол Шангрила зочид буудалд ажилладаг Номулин гээд охин байгаа. Азийн санд Энхбаяр гээд залуу маань орсон байгаа. Офисын ажил хийгээд Азийн сангийнхан маш сайхан хүлээж авсан. Би өөрөө очиж анхных нь сургалтыг хийгээд манай холбооны хүмүүс маань хүүхдээдээ тусалж дэмжээд ажилд нь оруулаад эцэг эх нь нэлээн аз жаргалтай сэтгэл хангалуун байгаа. Тэгээд хамгийн чухал зүйл нь Азийн сангийн хамт олны өөрчлөгдөж байгаа байдал. Тэгээд захирал нь Марк гээд америк хүн байдаг. Тэгээд Марк өөрөө маш сэтгэл хангалуун байгаа. Нэмж бас хүүхэд авах тухай ярьж байна, бүтэн цагаар ажилд авдаггүй юм аа гэхэд цалинтай, цалингүй дадлага хийх боломжуудыг бас бид ярилцаад эхэлчихсэн байгаа. Бид нарын холбоог олон хүүхдүүдийг ажилд авч маш том үлгэр жишээ үзүүлсэн Оюу толгойн ханган нийлүүлэгч компани байгаа. Тэр компани маань бараг 7-8 хүүхдэд цалин өгдөг. Манай хүүхдүүд оёдол хийдэг. Бэлэг дурсгалын зүйлийг хийгээд захиалгынх нь дагуу нийлүүлээд нийгмийн даатгалаа төлөөд яг утгаараа татвар төлөгч болж байгаа олон жишээнүүд байгаа. Энээ

мэтээр байгууллагууд бага багаар өөрчлөгдөж байна. Гэхдээ харамсалтай нь сүүлийн үед ковид гээд бизнесүүд нэлээн хумигдаад эдийн засаг тааруу байгаатай холбоотойгоор энэ үйл явц маань жаахан сулрах хандлагатай болчихсон байгаа. Тэгээд өвчин нь арилсны дараа буцаад нэлээн эрчтэйгээр энэ ажил руугаа орно гэсэн бодолтой байна. Хамгийн сүүлд Соёлын яам над руу ярьсан. Соёлын яамны нэг газрын дарга нь даунтай хүүхэд ажилд авмаар байна, холбож өгч туслаач гээд. Төрийн байгууллагууд маань бас эхнээсээ ингээд гоё өөрчлөгдөөд эхэлж байгаад би маш их баяртай байна.

Бас кофе шоп байдаг билүү?

Тийм. Тэр нь манай хөдөлмөр сургалтын төвийн. Бид тэндээ хүүхдүүдээ үйлчилгээний ажилчид яаж сургах вэ гэдэг зүйлийг туршилтын маягаар бид олон нийтэд үйлчилдэг байсан юм. Тэрийг кофе шоп гэж бас давхар нэрлээд байгаа. Тэгэхдээ яг албан ёсны кофе шоп биш. Бидэнд өөрсдийн албан ёсны кофе шоп нээж үзэх, ажиллуулах бодол мөрөөдөл байдаг. Гэхдээ буяны ч юм уу эсвэл дахиад нэг төрийн бус байгууллагын статустай ч юм уу юм нээмээргүй байгаа юм. Хүнд өрөвдүүлж, үйлчилгээний ажил хийнэ гэдэг нь өөрөө урт хугацаандаа явахгүй зүйл л дээ. Тэгэхээр кофе шоп нээвэл өрсөлдөхүйц хэмжээний өндөр хэмжээний, нийтийн хоолны бизнес гэдэг чинь өөрөө бас маш чухал. Хүний эрүүл мэндэд шууд нөлөөлдөг учраас мэргэжлийн хяналтын газраас зөвшөөрөл авч таарах байх. Үйлчилгээний өндөр стандарт, үнэ, чанар гээд. Тэгэхлээр энэ бол ингээд зүгээр хэдэн эцэг эхчүүдийн сайхан санааны үзүүрээр бүтдэг ажил биш гэж би харсан л даа. Яг мэргэжлийн түвшинд байх ёстой. Бусад кофе шоп нээлээ гэхэд бусад байгууллагуудтай яг л мөн чанараараа өрсөлддөг шиг өрсөлдөх ёстой, тэгж байж амжилттай урт хугацаанд оршин тогтнох юм байна. Тийм учраас төрийн бус байгууллага, сайхан сэтгэл гэхгүйгээр яг л тийм бизнесийн зарчмаараа эхлэх ёстой юм байна гээд бид нар тэгээд нэг бас нэг жижигхэн бичил төсөл бичээд хэд хэдэн олон улсын байгууллагууд, дотоодын байгууллагуудад хамтарч ажиллах хүсэлт өгөөд явж байгаа. Одоогоор яг гарсан том ахиц байхгүй байна. Хүн хүч бэлдэх хөрөнгө оруулалт, тооцоолол гээд амар зүйл биш байгаад байна. Яаж ийж байгаад нэг кофе шоп хийчихэж болох байх. Хамгийн гол нь тэр нь өөрөө тасралтгүй, жигд ажиллах нь хамгийн том асуудал юм. Манай эцэг эхчүүдэд ялгаварлан гадуурхах өрөвдөх гэдэг зүйл их байгаагийн нэг илрэл нь манай зарим эцэг эхчүүд хүүхдээрээ ажил хийлгэх сонирхолгүй байдаг. За өдөржин яаж тэнд зогсох юм минь хөөрхий минь гээд хүүхдээ хэт өрөвдөх, нөгөө талаасаа бас нэг ичихдээ тийм хүүхэдтэй гэдгээ хүн амьтан мэдрүүлэхгүй байх ийм хүсэлтэй таньдаг хүн бий. Одоо хүртэл бас хүүхдээ бүрэн хүлээн зөвшөөрч чадаагүй нэлээн хэдэн жил болоод. Тэгэхээр эцэг эхчүүд нь өөрсдөө тийм байхад энгийн хүн бас ойлгохгүй байх нь нэг бодлын аргагүй л дээ. Тийм учраас хандлагаа л бид нар

өөрчилж сурахгүй болбол ямар ч асуудлыг шийдэж чадахгүй.

Энэ хандлагыг яаж өөрчлөх вэ? Ер нь хүмүүсийн хандлага яаж өөрчлөгддөг юм бол, таны бодлоор?

Нийгмийн л оролцоотой байх ёстой юм шиг надад санагддаг. Тэгээд өөртөө хэрэгцээтэй шаардлагатай мэдээж ажлаа хийгээд үйлчилгээгээ аваад амьдраад байж болно. Тэгэхдээ нийгэмдээ ямар нэгэн байдлаар оролцоотой, нийгмийн болохгүй бүтэхгүй байгаа асуудлыг хөндлөнгөөс мэдээж шүүмжлэх нь зөв. Гэхдээ шүүмжилж байгаа зүйл дээрээ шийдэл гаргах, шийдэхэд нь оролцох шийдэл гаргахад нь оролцдог тийм оролцооны соёл гэх юм уу даа. Сахилга бат арай бас бусад улсуудтай харьцуулахад төлөвшиж амжаагүй байгаа юм болов уу гэж хардаг. Тэгээд тийм учраас цөөхөн хэдэн хүмүүсийн нуруун дээр асар их ачаалал ирээд байдаг. Ер нь компанийн нийгмийн хариуцлага гэж ярьдаг шиг хувь хүний нийгмийн хариуцлага гэж бас байна. Хуулиар хүлээгээгүй ч гэсэн бие биедээ туслах, хайрлах, хүндлэх, ялгаатай хөгжилтэй нэгнээ ойлгох гээд ийм суурь ухамсар магадгүй тэгээд боловсролын системээсээ авхуулаад бид заах л ёстой юм шиг байгаа юм. Барууны сургуулиудад бол боловсролын системээс нь эхлээд л ялгаатай хөгжлийн тухай маш сайн цэгцтэй ойлголт өгчихдөг. Тэгээд тийм суурь боловсрол авч эзэмшсэн хүүхэд бол амьдрал дээр гараад яг л тийм ёстой утгаараа хүмүүнлэг ардчилсан иргэний нийгэм гэдэг шиг нийгмийн эд эс нь болоод ингээд л хүмүүжээд явчихдаг юм шиг байгаа юм. Тэгэхээр бид нар бас энэ боловсролын системийг бас ингэж хянах шаардлагатай л юм шиг байгаа юм.

Та сая ковид цар тахал гээд дурдаж байсан. Одоо ер нь энэ ковид цар тахал дауны синдромтой хүмүүст хэрхэн нөлөөлж байна вэ?

За саяхан Харвардын их сургуульд судалгаа гарчихсан байсан. Тэнд нэг том эмнэлэг байдаг. Яг дауны талаар мэргэшсэн. Тэднийхэн болохлоор зөвлөмж гаргасан байсан нь ковидод өртөх магадлал нь мэдээж нөгөө хүмүүстэй яг адилхан. Тэгэхдээ энгийн хүнийг бодвол магадгүй жаахан дархлаа сул учраас яг энэ халдвар хамгааллын дэглэмээ аягүй сайн барьж яваарай. Тэгээд вакцинууд хийлгэж болно шүү. Тэгээд Америкт бол жишээ нь пайзерийг санал болгож байгаа юм билээ. Вакцинаа хийлгэхэд асуудалгүй. Аль болох эртхэн вакцинаа хийлгээрэй гэж захиж байсан. Эдийн засгийн хувьд нэлээн хүндээр нөлөөлж байгаа. Ялангуяа даунтай хүн ч гэлтгүй даунтай гэр бүлийн гишүүдтэй гэр бүлд нэлээн хүндээр нөлөөлж байгаа. Цаанаа бас ийм гэр бүлийн хувьд аягүй тийм асуудал байдаг юм. Ер нь ийм асран хамгаалагчтай хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлд байдаг нэг зовлон юу вэ гэхээр гэр бүлийн аль нэг гишүүн нь, аав, ээжийнх нь аль нэг нь ажил амьдралаа золиослоод өнөө гэртээ хүүхдээ хардаг гэсэн үг. Тэгээд хэн нэг нь ажил хийх нь байна шүү дээ. Тэгээд ажил

хийж байгаа нэгнийх нь нуруун дээр бол асар том санхүүгийн тийм дарамт үүсдэг. Тэр хүн одоо өвдөж болохгүй, үхэж болохгүй. Яагаад гэвэл орлогогүй болно. Тэгээд Монголд бас энэ асуудал их байдаг. Ингээд л эргэн тойрноо харахаар аль нэг нь гэртээ үлдчихсэн голцуу, ээж нар нь гэртээ үлддэг. Тэгээд аав нь ажлаа хийгээд л, санхүүгийн нэлээн тийм дарамттай байдаг. Тэгээд сая энэ ковидын улмаас цөөнгүй байгууллагууд үүдээ бариад цалин мөнгөө багасгаад бизнес нь хумигдаад. Түүнээсээ шалтгаалаад өрхийн энэ орлогод нь нэлээн сөргөөр нөлөөлж байгаа. Маш хэцүү байдлыг туулаад явж байгаа гэж би хэлмээр байна. Энэ ганцхан би даун гэж хэлээгүй шүү дээ. Ер нь хөгжлийн бэрхшээл гэж ярьж байгаа. Ялгаатай хөгжилтэй бүхий л хүмүүсийн гэр бүлд нь тохиолдож байгаа нэлээн тийм хүнд цаг үе л байна даа.

Таны хүү дауны синдромтой гэж ярьж байсан. Та хүүгийнхээ ирээдүйг ер нь ямар байгаасай гэж төсөөлдөг вэ?

Би асран хамгаалагч буюу аав ээжгүйгээрээ бие дааж амьдардаг тэр орчныг л Монголд хурдан бүрдээсэй, тэрийг бүрдүүлэхийн төлөө бүхий л нөөц боломжоо ашиглаж ажиллана гэж бодож явдаг. Бие даан амьдрах гэдэг үгийг л хэлмээр байна. Бие даан амьдрах орчин нөхцөл нь Монгол улс яг улс шиг улс юм бол тэрийг нь бүрдүүлж тийм цогцолбор төвийг зайлшгүй байгуулах шаардлагатай.

Ерөнхийдөө ингээд манай подкастын цаг өндөрлөх дөхөж байна. Танаас сүүлчийн асуултаа асууя. Бие даан амьдрах боломжтой нийгмийг байгуулахын тулд танай холбоо болон та юу хийхийг зорьж байгаа вэ?

Холбоо маань байгуулагдаад 10 гаруй жил болжээ. Одоо эргээд харахаар байгуулагдсан эхний хэдэн жилдээ бид соён гэгээрүүлэх тал дээрээ нэлээн анхаарсан байдаг. Угаасаа дотооддоо бидэнд монгол хэлээр хангалттай мэдлэг мэдээлэл нь байгаагүй. Гаднын байгууллагуудаас дауны холбоодууд хамтарч ажиллах замаар номуудыг орчуулж монгол хэлээр буулгах, мэдлэг мэдээлэл түгээх, соён гэгээрүүлэх ажлуудыг нэлээн хийсэн. Хоёр дахь гол хийсэн ажил маань олон улсын байгууллагуудтай холбогдож ажиллаж эхэлсэн. Жишээ нь бид Израйлийн генетикийн төвтэй хамтраад Монголд шинжилгээ хийдэггүй байхад 2000 оны эхээр хамгийн анх хүүхдүүдийнхээ цусны шинжилгээг аваад Израйл руу онгоцоор явуулж тэнд генетикийн шинжилгээ хийлгэж байлаа. Тэгээд Япон улстай нэлээн удаан хугацаанд хамтарч ажиллаж байна. Бид 2-3 тэтгэвэртээ гарсан япон багшийг авчраад Монголдоо 2 жил гаруй ажиллуулсан. 25-р тусгай сургууль дээр дауны ангийг нээгээд багш нарыг сургаад орчныг нь бүрдүүлээд эцэг эхчүүдэд мэдээлэл өгөх замаар лекц семинар уншаад ингээд ажиллаад олон улсын харилцаа холбоогоо нэлээн хөгжүүлэхийг хичээсэн. Тэгээд Дэлхийн дауны холбооны гишүүн болсон. Ази-Номхон далайн дауны холбоо гэж байдаг. Тэр холбоонд

нь бид нэлээн идэвхтэй гишүүдийн тоонд ордог төдийгүй удирдах зөвлөлд нь сонгогдоод үүрэг хүлээгээд ажиллаж байгаа. Жишээ нь ирэх долоо хоногт надад манай бүсийн холбооны тэргүүн даалгавар өгөөд Бангкокд болж байгаа "Ялгаатай хөгжилтэй хүмүүсийн ажил эрхлэлт" гэдэг сэдвээр НҮБ-ын олон улсын хуралд илтгэл тавих болж байна. Би одоо ингээд юмаа бэлдээд сууж байна. Тэгээд иймэрхүү байдлаар гаднаас сурахын сацуу бид бас Монголдоо амжилттай, үр бүтээлтэй хийж байгаа тэргүүн туршлагаа хуваалцах, мэдлэг мэдээллээ хуваалцах гадаад сүлжээн дээрээ нэлээн анхаарсан. Сүүлийн хэдэн жил бол мэдээж бид нар эрүүл мэнд, боловсрол гээд хууль нь гараад байна. Одоо тулгамдаж байгаа, хийх гэж байгаа хоёр том ажил бий. Эхнийх нь бол ажил эрхлэлт, хоёрт нь бол миний түрүүний хэлдэг "Бие даан амьдрах төв" гэдэг зүйлийг засаг төртэйгөө нийлээд байгуулахын төлөө бүх зүйлээ зориулна гэж бодож байгаа. Бас энэ хоёрыг шийдэхгүйгээр бид цаашид өөр олон зүйл ярихад бэрхшээлтэй л болж байна л даа. Яагаад гэвэл одоо байгаа жаахан хүүхдүүд тав, арван жилийн дараа бүгдээрээ насанд хүрнэ. Бүгдээрээ насанд хүрээд сургуулийн наснаасаа гараад явчихаар би түрүү хэлдэг тэр хүүхдүүд, хүмүүс, насанд хүрсэн хүмүүс, очих газар хийх зүйл энэ улсад байхгүй байна яг одоогийн байдлаар. Ийм байж болохгүй, тэгэхлээр тэгш хүртээмжтэй ажлын байраар хангах тийм ажил олгогчдыг бэлдэх жоб коучин гээд бас тусгай мэргэжил байдаг л даа. Тэгээд бие даан амьдрах төвийг нь байгуулах. Ийм хоёр ажлыг заавал хийх ёстой гэж бодож явдаг. Тэгээд түүний төлөө өөрийнхөө зүгээс холбооныхоо зүгээс чаддаг мэддэг зүйлээ чадлаараа зориулаад л явж байгаа. Гэхдээ бас бүх зүйл бас санаснаар болохгүй байгааг нуухгүй. Тэгэхдээ хийх ажил зөндөө байгаа.

Танаас ахиад асуух юм гараад ирсэн. Ерөнхийдөө эцэг эхчүүд нуудаг гэж та ярьсан шүү дээ. Тэгэхээр тийм та одоо дауны синдромтой хүүхэдтэй, тэгсэн хэрнээ ингээд нуугаад байгаа, тэгээд тийм зориг нь хүрэхгүй байгаа эцэг эхчүүдэд ямар зөвлөгөө өгмөөр байгаа вэ?

Тийм. Бараг улиралдаа нэг удаа шинэ эцэг эхчүүд надтай фэйсбүүк энэ тэрээр холбогдоод зөвлөгөө авдаг л даа. Би тэгээд захидаг нэг зүйл гэвэл хэн нэгнийгээ буруутгаж ерөөсөө болохгүй. Манай Монголд чиний буруу, миний буруу, танай удмынхан гээд тиймэрхүү юм нэлээд түгээмэл байдаг юм биш үү? Энэ бол хэн нэгний буруу ерөөсөө биш. Барууны улсуудад бүр тийм үг байдаг. Азийн улсууд ч гэсэн байгаа л даа. Яг энэ даунтай хүүхэд гэдэг болбол зүүний үзүүр дээр тогтож ирсэн будаа гэсэн зүйрлэл байдаг л даа. Өөрөөр хэлбэл бараг боломжгүй гэсэн үг шүү дээ, зүүний үзүүр дээр будаа тогтоно гэдэг. Тийм болдоггүй зүйлийг болгож ирсэн англиар энжил(angel) гэж ярьдаг л даа "Нарны хүүхдүүд, сахиулсан тэнгэр" гээд тийм хүүхэд шүү гээд. Тэгээд бүр хэлц байдаг л даа. За эцэг эхчүүдэд би

бас энийг их хэлдэг. Би хаанаас сонслоо доо. Бас манай нэг холбооны л нэгэн хэлж байсан байх. Хэрвээ даунтай хүүхэдтэй болох юм бол бурхан танай хүүхдийг бэлэг болгож танд илгээсэн байна. Яагаад гэвэл та хоёрыг л яг энэ хүүхдэд жинхэнэ утгаараа аав ээж болж чадна гэж бурхан найдаад ийм том хариуцлага хүлээлгэж байна шүү гэсэн утгатай үг байдаг л даа. Би тэрийг л залуу ч эцэг эхчүүддээ захиж хэлмээр байна. Хэн хэнийгээ буруутгаж болохгүй. Тэгээд хүүхдээ яг ойлгоод хүлээн зөвшөөрснөөс хойш яг тэр хүүхдийнхээ, тэр хүүхэд нь ямар үнэ цэнтэй, ямар тийм үнэтэй бэлэг вэ гэдгийг аав ээжүүд мэдэрч эхэлдэг. Хүлээн зөвшөөрөхгүй байх тусмаа л тэр болж бүтэхгүй бүх харилцаа үүсдэг л дээ. Тэгээд бурхнаас заяасан бэлэг, яг танай гэр бүл л энэ хүүхдийг хүн болгож хүмүүжүүлж өсгөж чадна гэж явуулсан тийм хариуцлага шүү гэж хэлсэн тэр үг л миний санаанд их тогтсон байдаг. Тэгээд би энийг л аав ээжүүдээ дандаа хэлдэг юм. Тэгээд би бас дахиад нэг жишээ хэлмээр санагдчихлаа. Хөгжихийн хэрээр жирэмсэн ээжүүдээс ургийн уснаас цусаар нь нөгөө хромосомын тоо тоолоод даунтай хүүхэд төрөх магадлал байна уу үгүй юу гэдгийг нь үздэг болчихсон байгаа. Монголд бас нэлээн хийдэг болсон асуудалгүй. Тэгээд ийм шинжилгээ хийлгээд даунтай хүүхэдтэйгээ бичсэн гэр бүлийн дийлэнх нь нөгөө дэлхийн статистик ярьж байгаа шүү, дийлэнх нь болохоороо абортонд



ордог байсан. Хүүхдээ авахуулдаг байсан, ийм хүүхэд гаргахгүй ээ гээд. Гэтэл сүүлийн жилүүдэд эсрэгээрээ яг жирэмсэн байхдаа, одоо би Англид болсон хамгийн сүүлийн жишээг санаж байна. Ээж нь даунтай гэдгээ мэдчихээд ёстой бурхнаас илгээсэн билүү энэ хүүхдээ заавал гаргана гээд хүүхдээ гаргаж байгаа. Тэрийгээ ингээд олон нийтэд зарлаад тэрүүгээрээ бардам байгаад хандлага нь өөрчлөгдөж байгаа тийм олон кэйсүүд байдаг л даа. Тэгэхлээр магадгүй мэдээж эцэг эхийн шийдвэр, гэр бүлийн шийдвэр. Гэхдээ би хэрвээ дахиад ийм хүүхэдтэй боллоо гэхэд ерөөсөө харамсах зүйл байхгүй, тэрийгээ хүн болоход нь саад болох ямар ч тийм үйлдэл бол хийхгүй байх байсан.

За таны нөгөө илтгэлд бас нэг амжилт хүсье. Тэгээд илтгэлд нь амжилтыг хүсээд танай Дауны холбоо болон танд ажлын өндөр амжилтыг хүсье!

За маш их баярлалаа. Тэгээд подкастандаа урьж оролцуулсанд. Тэгээд та бүхний ажилд бас маш өндөр амжилтыг хүсье!

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ЗОРИУЛСАН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ



Б.Алтмаа

Сайн байцгаана уу, эрхэм хүндэт сонсогчид оо, Антолд подкастын маань ээлжит дугаар эхлэхэд бэлэн болоод байна. Энэхүү дугаарт Монголын сэргээн засалт, сургалт үйлдвэрлэлийн төвийн дэргэдэх Мэргэжлийн боловсрол, ур чадвар олгох сургуулийн захирал Алтмаа оролцож байна. Цаг зав гарган манай подкастад орохоор болсонд маш их баярлалаа.

Та юуны түрүүнд өөрийгөө манай сонсогчдод танилцуулахгүй юу?

Намайг Алтмаа гэдэг. Би Сэргээн засах сургалт үйлдвэрлэлийн төвийн дэргэдэх Мэргэжлийн боловсрол, ур чадвар олгох сургууль гээд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэргэжлийн боловсрол олгодог сургуулийн захирлаар ажилладаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүний ерөнхий газрын харьяа Сэргээн засал, сургалт үйлдвэрлэлийн төв гэж байдаг. Энэ сургалт үйлдвэрлэлийн төв маань мэргэжлийн боловсрол, ур чадвар олгох сургууль. Энэ нь 15-45 насны иргэдэд мэргэжил олгодог. Мөн сэргээн засах эмнэлэг, протез ортопедийн үйлдвэр гэсэн гурван үйлчилгээг үзүүлдэг байгууллага байна. Үүний мэргэжлийн боловсрол олгодог сургуулийг төлөөлж оролцож байна.

Одоогийн байдлаар ерөнхийдөө танай сургуульд хэдэн оюутан, сурагч суралцаж байгаа вэ?

Сургууль бол зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэргэжлийн боловсрол олгодог учраас манай

хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг суралцуулах стандарт гэж байдаг. Одоо нэг анги дүүргэлт нь 8-12 байдаг. Манайх жилдээ арван мэргэжлээр 130-140 хүүхдэд мэргэжил олгодог.

Ихэвчлэн ямар төрлийн мэргэжлийг олгодог вэ?

За яг өнөөдрийн байдлаар бол манайд хоёр жилийн хугацаатай талх нарийн боовны технологийн ажилтан, тогооч, оёдол, гар утас засвар, мужаан, сийлбэр, хэвлэлийн график дизайн гэх мэт үйлчилгээний чиглэлийн ийм мэргэжил олгож байгаа.

Ерөнхийдөө ямар төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ихэвчлэн танай сургуульд сурдаг вэ?

Бэрхшээлийн хувьд бол бүх төрлийн бэрхшээлтэй хүүхдүүд суралцах боломжтой. Өнөөдрийн байдлаар бүрэн хараагүй хүүхдүүд суралцаагүй байна. Манайд хараагүйчүүдийн дэргэдэх МСҮТ(Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв) гэж байдаг. Тэнд бол манай хараагүй хүүхдүүд бол суралцдаг. Манай сургуулийн хувьд бол бүрэн хараагүй биш арай сул хараатай хүүхдүүд бас суралцах боломжтой. Тэгээд бусад бүх бэрхшээлтэй хүүхдүүд манай сургууль дээр суралцаж байна. За энд тулгуур эрхтний сонсголын, уналт таталттай хүүхдүүд, оюун ухааны бэрхшээлтэй, аутизм, даунтай гэсэн бүх л хүүхдүүд суралцдаг даа.

Ер нь Монгол улсын хэмжээнд ерөнхийдөө хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн ур чадвар олгох сургууль хэдэн оноос байгуулагдаж эхэлсэн бэ?

Манай сургуулийн хувьд бол одоо бараг 43 дахь, 45 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна. Өмнө нь бол манайх зөвхөн түр сургалтын үйлчилгээ үзүүлдэг сургалтын төв байсан. Ингээд үйл ажиллагаагаа өргөжүүлээд өнөөдрийн байдлаар бараг МСҮТ-ийн хэмжээнд хүртэл хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэргэжил олгож байна. Өмнө нь байсан сургалтын төвөөсөө юугаараа ялгаатай вэ гэхээр сургалтын төвүүд бол түр буюу богино хугацааны 21-45 хоногийн сургалтуудыг явуулдаг байсан бол өнөөдөр мэргэжил олгохоор талаар бусад сургуулиудтай адилхан болсон. Одоо 1-2 жилийн хугацаатайгаар одоо сургалтынхаа үйл ажиллагааг явуулж байна.

Танай сургуулиас ингээд үйл ажиллагаагаа явуулах хугацаанд гардаг хүндрэл бэрхшээлүүд ерөнхийдөө юу байдаг вэ?

Хүндрэл бэрхшээлийн хувьд манай багш нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй иргэдтэй ажиллах арга зүйд суралцсан. Олон жилийн туршлагатай. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй бол жирийн хүүхдүүдээс маш өөр байдаг. Наад зах нь дохионы хэлтэй

байх ёстой гэх мэтчилэн нэмэлт ийм арга зүйг эзэмшиж байж багш болдог. Тэгээд манай багш нар харьцангуй олон жилийн туршлагатай, ийм хүүхдүүдтэй ажиллах боломжтой, мундаг чадвартай багш нар байдаг. Бэрхшээлийн хувьд бол өнөөдөр манай хөгжлийн бэрхшээлтэй иргэд бол ихэвчлэн ерөнхий боловсрол эзэмшээгүй орж ирээд байдаг. Сургуулийн хувьд бол бүр 25-аас дээш 30-40 гарчихсан ийм хүмүүс ирдэг. Яг өнөөдөр амьдрал дээр яаж байна вэ гэхээр ингээд л хөгжлийн бэрхшээлтэй юм чинь хөөрхий гээд л арван жилийн сургуульд нь сургахгүй байж явсаар байгаад аав ээж нь настай болоод юм ирэхээрээ энэ хүүхдийг ерөөсөө амьдралд нь хөл залгуулъя, сургууль соёл, ядаж нэг мэргэжил эзэмшүүлье, ядаж хоол хийлгэдэг болгоё гээд аргаа барсан үедээ манай дээр авчирч өгөөд байгаа юм. Тэгэхээр өмнө нь ямар нэгэн боловсрол эзэмшээгүй ийм хүүхдүүдэд бид одоо байгаа хугацаандаа мэргэжил эзэмшүүлэх бас үнэхээр хүндрэлтэй байгаад байдаг. Яагаад гэвэл эд бичиг үсэг мэдэхгүй орж ирж байна. Бэрхшээлийнхээ хэлбэрээс болоод янз бүрийн шинэ нэмэлт бэрхшээлүүдтэй орж ирж байна, өнгө ялгадаггүй ч байдаг юм уу, дохио, сонсголын бэрхшээлтэй хүн гэхэд ямар ч дохиогүйгээр орж ирдэг гэх мэтчилэн бид мэргэжил олгохоосоо гадна нөгөө хүнийг хөгжүүлэх, энэ мэргэжлийг эзэмшихэд ямар ямар ур чадвар хэрэгтэй байна тэрнийх нь өмнөх суурийг бараг ерөнхий боловсролынх нь суурь дайны тийм нэмэлт ур чадварыг заавал өгч байж нөгөө хүүхдүүдээ мэргэжил рүү нь дөхүү болгож илүү их ачаалалтай байдаг гэсэн үг сургуулийн хувьд бол. Тусгай сургуулиа төгсөөд ирсэн хүүхдүүдэд бол бас харьцангуй гайгүй байдаг. Одоо бас тодорхой хэмжээний боловсрол эзэмшчихсэн суурь боловсролоо бүрэн дунд боловсролоо эзэмшээд ирчихсэн бичиг үсэгтэй ийм хүүхдүүд байдаг. Бэрхшээлийнхээ хэлбэрээс болоод хүндрэлтэй асуудлууд байна. Мэдээж манай сургуульд ийм хүүхдүүд суралцаж байгааг бид айхтар хүндрэл бэрхшээл гэж авч үздэггүй. Гол нь бид мэргэжил олгохын тулд эцэг эхчүүд хүүхдээ аль болох эрт сургуулийн өмнөх боловсрол, бага, дунд боловсролд нь хамруулж байж дараа нь тэр хүүхдийг тодорхой хэмжээнд амьдралд ойртуулан нийгэмшүүлэх харилцаанд орох ёстой. Манай эцэг эхчүүд хүүхдээ ерөнхий боловсролын сургуульд хамруулах нь харьцангуй муу байсан л даа. Тэгээд одоо дийлэнх нь 30 нас хүрсэн хүмүүс сурах гэж ирдэг.

Ерөнхийдөө ерөнхий боловсрол эзэмшээгүй шууд ирсэн энэ оюутнуудад суурь боловсролыг нь олгоно, давхар бас мэргэжил боловсрол, ур чадварыг нь олгох нь гээд. Тэгэхээр ерөнхийдөө энэ сургалтынхаа хоёр жилдээ багтаж амждаг болов уу?

Сургууль бол ер нь нэг жилийн хугацаатай байсан юм. Одоо мэргэжлийн ур чадвар бол. Жишээлбэл тогооч гэхэд зөвхөн махыг ингэж хэрчих ёстой, ногоог ингэж

арилгах ёстой, ингэж бэлтгэх ёстой, ажлын байр ингэж бэлтгэх ёстой гэдэг маань өөрөө нэг жилийн хугацаатай мэргэжил олгодог. Ийм ур чадвар олгоход нэг жилийн хугацаа шаардлагатай байдаг. Бид нэг жилийн хугацаанд жирийн хүүхдүүдтэй адилханаар яавч энэ ур чадварыг олох боломжгүй юм байна гээд хугацаагаа нэмсэн юм. Хоёр жил болсон. Энэ хоёр жил нь ерөөсөө хоёр жилийн маань нэг жил нь бараг бүтэн тэр хүүхдийг одоо харилцаанд оролцоход нийгэмшихэд тэгээд өөрийнх нь одоо яг юу чадахгүй байгаа вэ гэдэг хөгжүүлэх хөтөлбөрийг явуулах зорилгоор нэг жилийн хөтөлбөрийг нэмэлтээр оруулж байж бид нар энэ хугацаагаа хоёр жил болгосон.

Тэгвэл ерөнхийдөө өмнө нь бас сургуульд хамрагдчихаад ирсэн хүүхдүүд маань болохоор тэр жилүүддээ ерөнхийдөө юу хийдэг вэ?

Бид сургуульд элсэхэд суралцах чадварын үнэлгээ хийдэг юм. За энэ үнэлгээ нь ямар учиртай байна вэ гэхээр энэ хүүхэд зөвхөн энэ мэргэжлийг эзэмшихэд ямар ямар чадвар, өөрийнх нь ямар ямар чадвар байна, өөрийнх нь бэрхшээл нь юу байна, яг энэ мэргэжлийг эзэмших боломжтой юу, боломжгүй юу гээд бид суралцах чадварын үнэлгээ хийдэг. За энэ үнэлгээ нь яадаг вэ гэхээр манай эмч нар, мэргэжлийн багш нарын хамтарсан баг бүрдэж байгаад оюутан бүр дээр үнэлгээ хийж байгаа юм. За ингээд энэ хүүхдэд нэмэлт хөтөлбөр шаардлагатай байна уу, эсвэл шууд мэргэжлийнхээ ур чадварыг эзэмшээд явах боломжтой байна уу гэдгийг нь тодорхойлж байгаа юм. За ингээд л нөгөө хүүхдүүдийн суралцах чадвар, эрүүл мэнд зэргийг нь ингэж тодорхойлсны дараа бид хүүхэд болгонд зориулсан, нэмэлт хөтөлбөрүүдийг гаргах ёстой. Жишээлбэл бичиг үсэг байхгүй бол ядаж энэ хүүхдэд бичиг үсгийг нь өгье. Ядаж л талах гээд биччихсэн байвал талх гэдэг үгийг л энэ хүн ойлгож байх ёстой шүү гэх мэтчилэн. Оюун ухааны бэрхшээлтэй юм уу бас хүнд бэрхшээлтэй хүмүүс байна. Яаж бичиг үсэг заагаад ч сурахгүй хүүхэд ч байна. Ийм хүүхдүүд яадаг вэ гэхээр ийм давталттай ямар ур чадвар эзэмшүүлж болох вэ гээд энэ дээр манай жинхэнэ одоо мэргэжлийн багш нар ажилладаг гэх мэтчилэн бэрхшээлд нь тааруулаад бид нар суралцах чадварын үнэлгээ хийж байгаад тэгээд энэ хүүхдийг өөрөөр хэлбэл хоёр жил хүртэл хугацаатай сургадаг гэсэн үг. Шаардлагагүй бол бид шууд нэг жилийн хугацаанд ур чадварыг нь олгоод тухайн мэргэжлийг нь эзэмшүүлээд төгсгөнө.

Тэгвэл ерөнхийдөө оюутнууд маань анх хэлэхдээ би ийм мэргэжлээр ормоор байна гээд өөрсдөө мэргэжлээ сонгочихсон орж ирдэг үү, эсвэл саяын үнэлгээнээс ингээд шалтгаалаад энэ энэ мэргэжлээрээ боломжтой юм байнаа гээд санал болгодог уу?

Оюутнууд суралцагчид маань, эцэг эхчүүд маань бол голцуу мэргэжлээ сонгочихсон энэ ангид суръя гээд л ороод ирдэг. Ингээд яах вэ, мэдээж би ийм мэргэжлээр сурмаар

байна, ийм гоё ажил хиймээр байна гэдэг хүсэл эрмэлзэл тэр хүнд байгааг харгалзаж үзнэ. Гэхдээ бид заавал тухайн мэргэжлийг эзэмшээд төгсөөд гарахад энэ хүүхдийн бэрхшээл нь тэрэнд бэрхшээл болох уу үгүй юу гэдгийг гол нь тодорхойлж өгдөг. Үнэхээр уналт таталттай хүүхэд халуун нөхцөлд тогоочийн мэргэжлийг эзэмшээд гараад ажиллах хэр байх вэ? Өөрөөр хэлбэл, бид яг энэ мэргэжил чинь одоо за болох юм байна гэдгийг нь, хэрэв энэ бэрхшээл чинь ийм ийм учраас энэ мэргэжлийг эзэмшиж болохгүй байна, таны бэрхшээлийн онцлог нь ийм ийм мэргэжил эзэмших, манай сургуулийн ийм ийм ангид элсэн суралцах боломжтой шүү гэдгийг нь бид бас дахиад давхар зөвлөгөө өгөөд явчихдаг.

Үнэлгээ хийхдээ ерөнхийдөө тэгвэл танай суралцагчид болон одоо оюутнууд маань төгсөөд ер нь ажлын байрны олдоц ер нь хэр байдаг вэ?

Өнөөдөр бас харьцангуй ажил олгогчид маань бас арай хандлага нь өөрчлөгдсөн байна. Төр засгаас авч байгаа бас олон арга хэмжээнүүдээс шалтгаалаад ажил олгогчдыг хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулахад тодорхой хэмжээний дэмжлэг туслалцаа үзүүлдэг учраас хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулчихъя гэсэн захиалгууд ирдэг. Бид мэргэжил эзэмшүүлчхээд л орхихгүй аль болох ажлын байранд нь зуучилж өгдөг. Ажил олгогчдоос ажлын байрны захиалгууд бол яг өнөөдөр байгаа манай мэргэжлүүдийн хувьд бол тогооч, мужаан



дээр маш их эрэлттэй байдаг. Талх, нарийн боов дээр ч гэсэн. Одоо нарийн боовны олон цехүүд бий болчихсон. Ингээд ажилтан гаръя кофе шопууд байна, энэ дээр бас авъя гэсэн ийм захиалгууд бол ирдэг. За энэнээс гадна бас манай энэ том том газрууд нь дандаа үйлчилгээний ажилтан авъя гэсэн захиалгууд ирүүлээд байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүн байна уу? Үйлчилгээний ажилтан авъя гэдэг. Тэгэхээр өнөөдөр манай мэргэжлүүдэд маань үйлчилгээний ажилтан, мэргэжил бэлтгэж байгаа мэргэжилтнүүд бас байдаггүй л дээ. Ер нь бол ийм мэргэжил бол байдаг уу гэвэл байдаг. Сургуулын хувьд өнөөдрийн хувьд бол байхгүй байгаад байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй, өмнө нь өгсөн ажил олдохгүй байгаа, ажилд ороод одоо тэнцэхгүй байгаа тийм хүүхдүүддээ үйлчилгээний ажил дээр зуучлаад өгч байна. Хөдөлмөр эрхлэлтийн хувьд ажил олгогчоосоо гадна манай мэргэжилтнүүд жишээлбэл гар утас засвар юм уу, сийлбэр гар урлалын ангиуд маань өөрсдөө ажлын байр бий болгодог. Бас ийм мэргэжлүүд байгаад байгаа юм. За бас нэг эрэлттэй, мэргэжил маань бас оёдол байдаг. Оёдлын цехүүд дээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс авъя аа гээд манай ажил олгогчид голцуу өөрсдөө бас хөгжлийн бэрхшээлтэй иргэд маань ажил олгогч болчихсон, ийм хүмүүстэйгээ ажиллахад илүү ойр байдаг юм болов уу. Ажлын байрныг захиалгад маань бас тийм хүмүүс буюу өөрсдөө хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бас их ажилд авдаг.

Ерөнхийдөө ингээд тогооч, мужаан, нарийн боовны чиглэлээр сурч байгаа оюутнуудад маань ерөнхийдөө ямар төрлийн бэрхшээлтэй хүмүүс илүү голлон зонхилж байгаа вэ?

Мужаан дээр бол дийлэнх нь сонсголын бэрхшээлтэй хүүхдүүд байна. За бас нэг бага зэргийн жаахан оюун ухааны бэрхшээлтэй хүүхдүүд байдаг. Яг одоо сул хараатай хүүхдүүд бас ирж л байдаг. Ер нь мужаан дээр дийлэнх нь сонсголын бэрхшээлтэй хүүхдүүд ирж байгаа. Яагаад гэвэл өөрийнх нь мэргэжлийн онцлог байна. Бусад талх, нарийн боов, тогоочийн мэргэжил дээр бас бүх л төрлийн бэрхшээлтэй хүүхдүүд ирдэг. Тулгуур эрхтний бэрхшээлтэй, оюун ухаан, сэтгэц аль аль нь л ирдэг л дээ.

Үйлчилгээний ажилтны хувьд бол бас ямар хүмүүсийг ихэвчлэн та зуучилж байсан бэ?

Өмнө нь манай сургууль бас үйлчилгээний ажилтан байшин арчлагч гэдэг нэртэй мэргэжилтэн бэлтгэж байсан. Энэ маань гараад яг үйлчилгээний ажилтан болдог. Тэгэхээр энэ дээр манай өмнө нь төгссөн төгсөгчид аягүй удаан байгууллагатай ажиллаж байгаа хүүхдүүд бол байгаад байгаа. Эд нар ингээд харахаар оюун ухааны бэрхшээлтэй, тэгэхдээ хүнд хэлбэрийн биш жаахан уналт таталттай ийм хүмүүс байгаад байгаа юм. Саяхан бид нэг уулзалт хийсэн байгаа. Ажил олгогч төрийн бус байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төлөөлсөн төрийн бус байгууллагууд байна. За

ингээд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулдаг ажил олгогчид яг ажлын байран дээр ажиллаж байгаа иргэдтэйгээ уулзсан. За энэ дээр манай Эм Си Эс дээр ажиллаж байгаа хоёр үйлчилгээний ажилтан, маш удаан ажиллаж байгаа, хоорондоо гэр бүл болчихсон, ажилдаа маш үнэнч ажиллаж байгаа ийм хүүхдүүд байгаад байгаа. Энэ тэр нь болохоор ихэвчлэн оюун ухааны хөнгөн хэлбэрийн бэрхшээлтэй хүүхдүүд ажиллаж байна. За яг энэ яг ажлыг ингээд ингээд хийгээрэй гээд зааварчилгаа өгөөд явчихвал энэ хүүхдүүд маань маш сайн ажиллах чадвартай байдаг.

Ерөнхийдөө хараад байхаар оюуны бэрхшээлтэй хүүхдүүд маань ажил дээр гарсан ч гэсэн өөрийгөө илэрхийлж чадахгүй ч юм уу, тэгээд тэрнээсээ болоод жаахан тийм хүнд байдал үүсэх ч юм уу, нэг тиймэрхүү юмнууд бас байгаа юм шиг санагддаг. Тэгэхээр танай төв дээр хичээл зааж байхад ч гэсэн тэр, тэндээсээ гараад ажл дээр гарсан ч гэсэн тэр оюуны бэрхшээлтэй, оюуны ялгаатай суралцагч нар маань ерөнхийдөө ямархуу байдаг вэ?

Оюуны бэрхшээлтэй хүүхдүүд маань бол нэгэнт л хүн юм чинь бид мэргэжил эзэмшүүлэх ёстой, тэд ч бас мэргэжил эзэмшээд амьдрах ёстой шүү дээ. Тийм учраас бид аль болох манай энэ тусгай сургуулиудаас ирж байгаа хүүхдүүдийн дийлэнх нь, ер нь тийм бэрхшээлтэй хүүхдүүд ирдэг л дээ оюуны бэрхшээлтэй. Энэ хүүхдүүдэд яг одоо практик дээр гараад олон нийттэй харьцах тийм ажил биш, ганцаарчилсан ажлын байрыг санал болгооч гэдэг. Оюуны бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүдийн холбоо, төрийн бус байгууллагууд байдаг. Эд нар бас тийм санал хэлдэг. Ганцаарчилсан ажлын байр, бусад хүмүүстэй нэг их харьцаад байхгүй, ийм ажлын байруудад санал болго гэдэг. Жишээлбэл зочид буудлын үйлчилгээн дээр гэхэд зөвхөн өрөөний үйлчилгээг ганцаараа яваад цэвэрлэдэг, өөрөөр хэлбэл бусад хүмүүстэй харьцахгүй ийм үйлчилгээн дээр манай оюуны бэрхшээлтэй хүүхдүүд яаж заагаад л өгчихвөл, ингэх ёстой, тэгэх ёстой гээд хэлээд заагаад л, зааварлаад л өгчихвөл тэрийгээ гүйцэтгээд байдаг. Тэгэхээр ийм ажлын байрнууд илүү зүгээр байдаг юм аа гэдэг тийм саналыг хэлдэг. Тэгээд бид ч бас нэг ажлын байранд зуучлахдаа тийм чиглэл рүү нь зуучилж өгдөг.

Зарим хүмүүс маань бас хэлдэг л дээ. Ажилд орохын хувьд орчихдог, тэгээд тэрэн дээрээ удаан байх гэхээр бас хэцүү байдаг. Ингээд бас дэд бүтэц нь нэгт тухайн газарт нь бүрдээгүй, хоёрт гэвэл хүмүүсийн хандлагаас болоод ерөнхийдөө ажилд удаан ажиллахад хэцүү байдаг гээд ярьдаг л даа. Тэгээд танай сургуулийг төгссөн төгсөгч нар ерөнхийдөө ажлын байран дээрээ доод тал нь хэдэн жил, дээд тал нь хэдэн жил ажиллаж байгаа вэ?

Сургууль төгсөлт хийгээд яг төгсөх үед нь тэгээд төгссөний дараах зургаан сар, нэг жил гээд бид үе үе мөшгих судалгаа

хийдэг. Төгсөгчдөө ажлын байран дээрээ ажиллаж байна уу үгүй юу гээд үзэхээр ер нь яг ажлын байранд зуучлаад өгөөд тогтвортой ажиллаж байгаа юу, ажиллаж байгаа нь цөөхөн байгаад байдаг. Ингээд л орж гараад орж гараад ажлын байран дээрээ тогтохгүй байх асуудал маш их байдаг. За энэ нь болохоороо аль аль талдаа байгаад байгаа юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн талдаа ч байгаад байгаа. Харилцааны хувьд бусадтайгаа харьцахдаа, одоо хамт ажиллаж байгаа байгууллагынх нь аль нэг эвгүй харьцвал шууд гараад яваад өгдөг гэх мэт ийм асуудал байдаг, нэгдүгээрт. Хоёрдугаарт ажил олгогч нарт бид уг нь аль болох хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ийм шүү, энэ хүмүүстэй ажиллахад ингээрэй гэдэг бас нэг тийм арга зүйн зөвлөгөө өгөхгүй бол ажил олгогчид бас энэ хүн чинь ийм хэцүү юм байна гээд л ажлаас нь халах тохиолдол бас байдаг. Сая таны хэлдгээр нөгөө тохируулга байгаа. Ажлын байрны тохируулга орц гарц хэцүү бол үнэхээр боломжгүй байгаад байдаг. Одоо бас харьцангуй гайгүй болоод сүүлийн үеийн барилгууд маань орц гарцтай болж байна. Тэрнээс бас тэр болгон ажил олгогчид ийм хүмүүс ажилд авах гэж байна гээд ийм тохируулгыг бэлдэж өгөөд нөгөө хүнд бүхэл бүтэн ажлын байр бэлдээд байх ийм чадвар ямар билээ? Ихэвчлэн одоо жижиг болон дунд түвшний ажил олгогчид манай иргэдийг авахад дандаа



ийм бэрхшээлүүд аягүй их гарч ирээд байдаг. Бас сүүлийн үед гайгүй болж байна. Тэрнээс маш их ийм хөдөлгөөн ордог, ингээд л ажил зуучлаад л уг нь харилцааны хувьд болохгүй байна, нөгөө ажил олгогч талдаа болохгүй байна, энэ ингээд байна тэгээд байна гээд ийм асуудлууд бол эргээд байнга холбогдож байдаг ийм асуудал байгаа юм. Бас эцэг эхчүүд ажилд оруулаад зуучлаад ажилд оруулаад хүүхдээ явж байхад ажлаас нь гаргаад тэр одоо эмээг нь асруулна, тэр эгч нь төрчихсөн байна, хүүхэд харуулна гээд яг тэр хүнийг ар гэрийнхээ юманд дандаа нөгөө хүүхдийг ажлаас нь гаргаж авдаг олон тохиолдол байдаг байсан. Ингээд сайхан ажлын байранд оруулах гэсэн чинь тэрийг нь харах хүн байхгүй болчихлоо гээд. Одоо нөгөө хүнийг ерөөсөө бодохгүй байгаа байхгүй юу. Тэр дүүгээ харахгүй бол болохгүй, ингэчихлээ тэгчихлээ гээд нөгөө эцэг эх талаасаа ч гэсэн ажлын байранд зуучилчихаад байхад гаргачихдаг. Харилцааны хувьд бол яг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдөө маш эмзэг байдаг. Одоо нэг эвгүй харахад энэ намайг муухай харлаа гээд л жишээлбэл сонсголын бэрхшээлтэй хүмүүс дээр энэ маш их тохиолддог. Өөрөөр хэлбэл биеийн хэлэмжээр хүнийг ингээд л дүгнээд л энэ надад ерөөсөө дургүй юм байна гээд л бодчихдог. Нөгөө хэлж л ойлголцохгүй болохоор. Ийм тохиолдлууд ч гэсэн манай ажил олгогчид гарч байгаа. Яг ийм тохиолдол гараад байна, яах вэ гээд л асуудлууд аягүй их ирээд байдаг. Тэгэхээр бид нөгөө ажил олгогчдоо ч, хүүхдүүдээ ч гэсэн аль аль талд нь сургалт явуулж байж тэдний хандлагыг өөрчлөхгүй аль нэг нь жишээлбэл би зөвхөн хүүхдээ зөвхөн харилцаа ийм байдаг, нийгэмшихэд ийм байдаг гээд ингэж заагаад гаргалаа гэхэд ажил олгогчдодоо давхар өгөхгүй энэ ажлын байран дээр ажиллахад бас тодорхой хэмжээний хүндрэлүүд гаргадаг. Ер нь харилцаандаа байдаг юм байна гэдэгт үндэслээд бид нар харилцаа, амьдрах ухааны ур чадвар хичээлүүдийн цагийн агуулгыг тодорхой хэмжээгээр нэмж өгсөн. Ерөөсөө энэ талынх нь хандлагыг өгөхгүй бол ажлын байран дээр яг энүүгээрээ л гологдоод байгаа юм байна, чадвараараа биш харилцаагаараа гологдоод байгаа юм байна гэдгийг бид бас тодорхой хэмжээний судалгаа, ажил олгогчдын дунд судалгаа хийж үзээд энэ чадварыг нь нэмэгдүүлье гээд цагуудыг нь бас тодорхой хэмжээгээр нэмж өгсөн байгаа. Өөрөөр хэлбэл илүү том агуулгаар орж өгч байгаа гэсэн үг юм.

Та сая нөлөөллийн ажлууд чухал гэлээ. Тэгээд энэ компаниуд одоо ажил олгогч нарт очоод нөлөөллийн ажил хийгээд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар ийм хүмүүс маань ийм байдаг шүү гээд тайлбарлаад явах гэхээр ерөнхийдөө тэрийг дэмжсэн тийм санхүүгийн дэмжлэг ер нь байдаг уу?

За манай сэргээн засах сургалт үйлдвэрлэлийн төв маань одоо яг ийм арга зүйн үйлчилгээг бас давхар үзүүлдэг. Одоо ажил олгогчдод юм уу, төрийн байгууллагуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажиллах арга зүй, хөгжлийн

бэрхшээлийн талаар манай төв маань үйлчилгээ үзүүлдэг үндсэн ганц том байгууллага байгаа юм. Өнөөдрийн байдлаар манайх байгууллагуудын захиалгын дагуу сургалтаа бол явуулж байна. Яг энэ төрлийг дэмжсэн үйлчилгээ гэвэл тухайн ажил олгогчид өөрсдөө хүсэж байна. За нөгөө талдаа төрийн үйлчилгээ үзүүлэх манай байгууллагын зорилгын маань нэг учраас бид тодорхой хэмжээний үйлчилгээг яг өөрийнхөө түвшинд үзүүлдэг. Өнөөдөр улсын хэмжээнд ерөөсөө манайхаас өөр газар байхгүй шүү дээ.

Ийм үйлчилгээг үзүүлээд явж байгаа танай сургуулийн хувьд ер нь сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг ер нь яаж гаргадаг вэ? Жишээлбэл, аль нэг орны жишгийг аваад Монголд суурьшуулах ч юм уу, эсвэл Монголын өнөөгийн нөхцөл байдал дээрээ тулгуурлаад сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө гаргадаг уу?

За сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг манайх Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр манай мэргэжлийн боловсоролын газар байгаа, өөрөөр хэлбэл манай яамнаас мэргэжлийн боловсролын чиглэлээр мэргэжил бүрээр тухайн мэргэжлийн стандартууд гаргадаг. Одоогоор зарим нэгэн мэргэжлүүд нь гараагүй байна. Энэ стандартынх нь дагуу бид нар хөтөлбөр, төлөвлөгөөгөө боловсруулдаг. Тэгэхээр энэ стандартыг боловсруулахдаа бид яг ажил олгогчтойгоо ажлын байран дээр өнөөдөр энэ мэргэжлийн ажлын байран дээр ямар ур чадвар хэрэгтэй байна вэ гэдгийг нь тодорхойлж байж мэргэжлийн стандарт нь гардаг. За энэ мэргэжлийн стандартын дагуу бид нар хөтөлбөрөө боловсруулж байгаа. Сургууль болгон энэ боловсруулсан хөтөлбөрөө мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл арга зүйн төв өөрөө баталгаажуулаад ингээд сургалтдаа ашигладаг. Өмнө нь бол ерөөсөө 1990-ээд он 2000 оны эхээр сургууль болгон өөрсдөө тухайн мэргэжлээр ингээд хөтөлбөр боловсруулаад л ингээд төгсгөдөг байсан. Өнөөдөр стандарт нь боловсруулагдаад үүний дагуу бид хөтөлбөр төлөвлөгөөгөө сургууль болгон боловсруулаад баталгаажуулаад ашиглаж байна. Өнөөдөр яг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тухайн мэргэжлийн стандарт хөтөлбөр гэж байхгүй. Харин хуулиндаа хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан хөтөлбөр стандартууд нь одоо тусдаа байна аа, ялгаатай байна гээд заасан байдаг. За өнөөдөр яг одоо манай сургуулийн хувьд шинэ гурван мэргэжлийг туршиж үзэх гээд стандартыг нь боловсруулаад түүний дагуу хөтөлбөр төлөвлөгөөг нь боловсруулаад гурван шинэ мэргэжлийг нээх гээд одоо яг боловсруулагдаад төслийн хэмжээнд явж байна л даа. Энэ ямар гурван мэргэжил вэ гэхээр бид, ажил олгогч, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл, маш олон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагууд, хөдөлмөр зуучлалын олон байгууллагуудтай маш олон судалгаа хийсэн байгаа. За тэгээд дээрээс нь олон хэлэлцүүлэг, ярилцлага хийж

байгаад гурван мэргэжил сонгож авсан. Өнөөдрийн хувьд Европын холбооны төслөөр бид үйлчилгээний ажилтан, цахим үйлчилгээний ажилтан, нарийн бичгийн туслах ажилтан, бичиг хэргийн туслах ажилтан ийм гурван мэргэжлээр хөгжлийн бэрхшээлтэй иргэд бас ажиллах боломжтой юм байна, ажлын байрууд нь байна, энэ гурван мэргэжлийн хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан стандартыг нь боловсруулаад хөтөлбөр, төлөвлөгөөг нь гаргаад энүүгээр мэргэжилтэн бэлтгэж үзье гээд яг энэ жил одоо хийгдээд явж байна. Одоо стандарт нь хийгдэж байна. За үүний дагуу хөтөлбөр нь гарна. Ингээд хөтөлбөр нь боловсруулагдсаны дараа бид тодорхой хэмжээгээр элсэлт явуулаад энэ мэргэжлүүдээрээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг суралцуулаад яг энэ ажлын байран дээр ийм үйлчилгээний ажил хийх хэрэгтэй байна гэдэг захиалгаар бэлдэж байгаа учраас бас ажлын байр харьцангуй гайгүй байгаа байх гэж бодож байгаа. Тэгээд одоо туршилтын үйл ажиллагаа бол 9 сарын 1-ээс яваад эхлэх байх гэж бодож байна. Ер нь төлөвлөлтөөр тодорхой хэмжээгээр 1-2 жилийн хугацаанд элсэгчдийг аваад бас мэргэжилтэн бэлтгэх гээд туршиж үзэх гээд л байж байна. Ер нь бол яг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан гэсэн тийм тодорхой хөтөлбөр стандартууд өмнө нь байгаагүй.

Олон улсын жишиг ер нь ямархуу байдаг вэ?

Олон улсад бол хүүхдүүдээ тодорхой хэмжээгээр жирийн сургуулиудад хамруулаад явж байна. За энэ нь тодорхой хэмжээгээр өөрийгөө аваад явах чадвартай тийм хүүхдүүд жирийн сургуульд хамрагдчихаж байгаа юм. Хамрагдаж чадахгүй хүнд хэлбэрийн бэрхшээлтэй хүмүүсийг тусдаа, жишээлбэл манайх Солонгосын нэг сургуультай одоо хамтын ажиллагааны гэрээтэй ажилладаг. За энэ сургууль дээр бол яаж байна гэхээр үйлдвэрлэл хөгжсөн орон болохоор яг нэг дамжлагыг зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй тухайн иргэнд зориулаад бэлтгэж байгаа юм. За тэр нь яг суралцах чадварын үнэлгээ хийж байгаад хүүхдэд зориулсан зарим нь ганцаарчилсан хөтөлбөр байгаад байгаа юм, зарим нь тодорхой хэмжээний нөгөө үйлдвэрийн ажил олгогчийнхоо, бас ийм захиалгын дагуу яг ийм чадвартай хүн бэлтгээд өгөөч гэдэг тийм захиалгаар бас бэлдээд байгаа юм л даа. Ер нь яг манайх шиг түвшний ийм мэргэжилтэй ажилтан бэлтгээд гаргаж байгаа нь мэдээж өндөр хөгжилтэй оронд үйлдвэрлэл хөгжчихсөн болохоор ажлын байрандаа яг бэлтгэгдэж гарч байгаа бас тийм давуу талууд бас байгаа юм. Тэгэхээр тэр бол яг иргэнд зориулсан хөтөлбөр байна. Тэгэхдээ тэр хүнийг бэлтгэхэд маш олон багш нар байна. Дор хаяж удаа нэг хүнд найман багш байна. Одоо эмчтэйгээ. Мэргэжлийн багштайгаа сэтгэл зүйчтэйгээ нийлээд. Гэтэл манайд нэг багш дээр найман хүүхдийн ийм стандарт байхгүй. Одоо бараг 8-аас илүү, бид 10-12 гээд л илүү ороод л ирдэг. 15 хүүхэд хүртэл ороод ирдэг. Энэ хүүхдүүдийг бид өнөөдөр манайх 8-хан хүүхэд авна гээд бусад

хүүхдүүдийг нь яв гэж хэлж чадахгүй шүү дээ. Тэгээд хамгийн дээд талдаа 15 хүртэл авч байна. За нөгөө 8 хүүхэд, 15 хүүхэд маань бүгд нэг нэг бэрхшээлтэй. Тэгэхээр нөгөө хүн болгонтой тулж ажиллах ийм шаардлага гарч байдаг. Тэгэхээр хөтөлбөр маань жирийн сургуулийн жишээлбэл, тогооч, мужааны ангийн хөтөлбөр шиг биш, арай өөр ялгаатай. Яг ур чадварын хувьд ялгаатай биш ч гэсэн нөгөө хүүхэдтэй ажиллах арга зүйн хувьд болохоор ийм ялгаатай байгаад байгаа юм. Тэр маягаар хөтөлбөр маань ялгаатай байдаг юм. Гадаадад бол ерөөсөө яг иргэнд нь зориулчихсан. Тэгээд л энэ хүний чадамж ямар байна гээд л маш олон талаас нь олон багш нар ингээд давхар ажиллаж байгаа гэсэн үг.

Тэгвэл ер нь манай одоо манай орны хувьд гэх юм бол хүний нөөц нь ер нь дутмаг гэж ойлгож болох уу?

За хүний нөөц бол үнэхээр дутмаг. Манай одоо яг энэ тусгай хэрэгцээт боловсролоор мэргэжилтэн бараг байхгүй гэхэд болно. Өмнө нь тусгай сургуулиудад Орост төгссөн хүмүүс ажиллаж байсан. Одоо ерөнхий боловсролын сургуульд гэсэн үг. Одоо тэр хүмүүс маань тэтгэвэрт гараад ажиллахаа болисон. За ингээд нэг хэсэг завсарлаад одоо тусгай хэрэгцээт боловсролоор Багшийн дээд дээр нэг мастерын хөтөлбөрөөр бэлтгэж байна. Одоо бас харьцангуй боловсролын яам энэ багш бэлтгэж байгаа хөтөлбөрт заавал хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй ажиллах арга зүйг оруулах талаар оруулах тийм хөтөлбөр бас боловсруулсан байгаа. Тэгээд яг ч хэрэгжиж эхэлж байгаа үгүйг мэдэхгүй байна. Одоо тодорхой хэмжээний кредитийг бас ийм хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажиллах арга зүйн тийм сургалт бас явуулж байгаа. Яг хүний нөөцийн хувьд өнөөдөр мэргэжлийн боловсролд бас байхгүй.

Танай сургуулийн хувьд ер нь багш нар нь ихэвчлэн аль сургуулийг төгсөж ирсэн хүмүүс байдаг вэ?

За манай яг энэ мэргэжлийн боловсролын салбарт тухайн мэргэжлээрээ бакалаврын мэргэжил эзэмшсэн байх ёстой. Жишээлбэл би цахилгаанчин гэдэг мэргэжил бэлдэхийн тулд би цахилгааны инженер байх ёстой, дээрээс нь багшлах эрхтэй байх ёстой гэсэн үг. Тэгвэл манай дээр мужааны чиглэлээрээ ч юм уу, тогооч маань тогоочийн мэргэжлээрээ бакалавр буюу түүнээс дээш мэргэжлийн зэрэгтэй гэсэн тийм шаардлага тавигддаг. Яг тэр шаардлагынхаа дагуу багш нар маань сонгогдож ажиллаж байгаа. Багшлах хүсэлтэй иргэд маань нэмэлт тусгай хэрэгцээт боловсролын чиглэлийн арга зүй дээрээс нь дохионы хэлний боловсролыг манай сургууль дээр ирээд давхар сурдаг гэсэн үг.

Хүмүүст боловсрол олгохын тулд бас нэлээн цаг шаардагдах юм байна?

Дадлагажих шаардлагатай. Хүн дор хаяж нэг, хоёр жил дадлагажиж байж багш болно л гэсэн үг дээ.

Танайд тэгээд багшлах гээд ирэх тийм хүсэлт ерөнхийдөө хэр их гардаг вэ? Ер нь ажлын байрны орон тоон дээр хүмүүс хэр их материалаа өгдөг вэ?

За багш нарын хувьд бол ажилд оръё гэсэн хүсэлтүүд ирнэ. Оёдол, тогооч, гар урлал байна. Тодорхой хэмжээний багш нар ирдэг. Сургуулийн хувьд манайх чинь төсвийн байгууллага болохоор төсөвтөө баригдаад хүний нөөцийн маань ч гэсэн бас тодорхой тоотой болохоор одоо байгаа нөөц бололцоогоороо ажиллаж байна. Ер нь цаашид юу шаардлагатай вэ гэхээр манайх мэргэжлийн багшаасаа илүү тусгай хэрэгцээт боловсрол нь бас илүү их шаардлагатай, нэмэлт сэтгэл зүйч шаардлагатай гэх мэтчилэн бас нэг ийм шаардлагатай цаг үеэ дагаад ийм хэрэгцээтэй, ийм орон тоонууд байгаад байна л даа.

Та яагаад сэтгэл зүйч хэрэгтэй гэж бодож байгаа вэ?

За сэтгэл зүйн хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд бүр илүү их шаардлагатай байдаг. Яг тухайн мэргэжил эзэмшээд байгаа хүүхдүүдтэйгээ харьцахад ч шаардлагатай. Дээрээс нь нөгөө өвчний хөдлөх үе гэж байна. За тэгээд янз бүрийн, зарим хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн маань ар гэр бол үнэхээр бас хүнд хэцүү байдаг. За тэгээд тэд нар сургуулиа хаях, орох, гарах ийм тохиолдлууд байдаг. Ер нь алхам тутамд сэтгэл зүйч шаардлагатай байгаад байгаа юм.

Ерөнхийдөө ковид цар тахал болж байгаа шүү дээ. Тэгээд ковид цар тахлын нөлөө танай сургуульд хэрхэн нөлөөлж байгаа вэ? Мөн танай сургуульд суралцагч нарт хэрхэн нөлөөлж байгаа вэ?

За манайд бол ёстой маш хүндээр нөлөөллөө. Манайх цахимаар хичээлүүдээ явуулаад байх үнэхээр боломж байхгүй. Манай нэг онцлог байгаа юм. Дийлэнхдээ онолын хичээл нь маш бага, дандаа дадлага дээр илүү их суурилж явдаг. Мэргэжлийн боловсрол салбар ер нь тийм дээ, гучин хувь нь онол, далан хувь нь дадлага гэж явдаг. Манайх бараг тэр гучин хувийг чинь дахиад бараг тэр гучин хувь нь тэр чигээрээ дадлага явж байж тэр хүүхдүүдэд тухайн ур чадварыг өгөхөд онолоосоо заавал нэмэлт дадлага, ур чадварыг нь өгөхийн тулд дадлагаа илүү их явдаг. Дээрээс нь тэд нарт ингээд л онолдоод л ингээд л хууль томьёо заагаад манай хүүхдүүдийн ойлгоц бол ойлгомжтой шүү дээ. Тэгэхээр дийлэнх хичээл маань дадлагын хичээл болохоор хэчнээн бичлэг үзүүлээд тэр хүүхдүүд бол дадлагауихгүй байхгүй юу. Тэгэхээр манай хүүхдүүдийн хувьд бол сая хоёр жилийн хугацаанд бол үнэхээр их хоцрогдсон. Бусад сургуулиуд ингээд онлайнаар цахимаар яваад төгсөлтөө хийгээд байна. Манай сургуулийн хувьд бол тэгж хийх боломж байхгүй. Ямар ч байсан танхимаар хичээллэх үед л дадлагажуулаад хичээлүүдээ хуваарийн дагуу орж байж бид төгсөлтөө хийхээр явж байгаа.

Тэгвэл одоо жишээлэх юм бол хоёр жилийн өмнө ковид эхлэхээс өмнө танай сургуульд орсон хүүхдүүд одоо ковид ингээд дуусаад танхимаар хичээллэнэ гэхэд дахиж хоёр жил сураад төгсөнө гэсэн үг үү ?

Ер нь ороод нэг жил болчихсон хүүхдүүд байсан. Одоо яг нэг жилийн хугацаа шаардлагатай байх. Одоо орсон хүүхдүүд ирэх хавар бид төгсөлт хийнэ гэсэн үг.

Ерөнхийдөө манай подкастын цаг өндөрлөх дөхөж байна. Тэгээд танаас сүүлийн асуултаа асуя. Та цаашдаа мэргэжлийн боловсрол, ур чадвар олгох сургуулиа ерөнхийдөө ямар болоосой гэж хүсдэг вэ? Тэгээд таны цаашдын төлөвлөгөө юу байгаа вэ?

За цаашдаа бид хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллах боломжтой ямар ажлын байр байна тэр болгоныг л бид нар бэлдэх ёстой. Манайх л бэлдэх ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг бэрхшээлийнх нь хэлбэр гайгүй бол аль болох жирийн сургуульдаа жирийн хүүхдүүдтэйгээ хамрагдаад төгсвөл тэр хүүхдийн хөгжилд нь л хэрэгтэй байдаг. Сургуульд суралцах боломжгүй, жаахан хүндхэн бэрхшээлтэй, жишээлбэл бэрхшээлийнх нь хувьд нэлээн хүнд, дээрээс нь ямар ч өмнөх боловсрол эзэмшээгүй ийм хүүхдүүд манайд ирээд байдаг. Тэгэхээр сургуулийн хувьд бол цаашид юу гэж төсөөлж байна вэ гэхээр манай сургууль өнөөдөр байшин барилгынхаа хувьд шаардлага хангахгүй байгаа л даа. Улсын хэмжээнд ганцхан хүртээмжтэй сургууль манайх ч гэсэн багтаамжийн хувьд харьцангуй бага байгаад байгаа юм. Дахиад олон хүүхэд суралцах хүсэлтэй хүүхдүүд зөндөө байгаад байдаг. За энэ хүүхдүүдэд энэ мэргэжил боловсрол олгохоосоо гадна нэмэлт сэргээн засах хөтөлбөрүүдийг нь маш их явуулах хэрэгтэй байгаа юм. Өөрөөр хэлбэл, тулгуур эрхтний бэрхшээлтэй гэвэл тэр бэрхшээлийнх нь хэлбэрт сэргээн засах, ахуй засал, хөдөлмөр засал, хөдөлгөөн засал гэсэн нэмэлт сэргээн засах хөтөлбөрүүдийг илүү түлхүү давхар оруулж байж энэ хүүхдүүдэд нөгөө бэрхшээл нь бэрхшээл болохгүйгээр аль болох энэ хүнийг бас тодорхой хэмжээнд илүү хөгжүүлээд гарах ийм боломж байгаа юм. Сургуулийн хувьд өнөөдөр олон улсын тэмцээнд тодорхой хэмжээгээр мэргэжлийнхээ чиглэлүүдээр амжилттай оролцож байна. Тэгэхээр бид бас өнөөдөр олон улсын түвшинд, жишээлбэл манай хэвлэлийн график дизайн хоёр гурван жил дараалаад манай суралцагчид яваад алт мөнгөн медалийг авч ирсэн. Тэгэхээр өнөөдрийн манай олгож байгаа мэргэжлийн чиглэл бас энэ мэргэжлийн боловсрол маань олон улсын түвшинд байна гэж үзэж байгаа. Яг энэ шиг бусад бүх мэргэжлүүд маань ч гэсэн бас энэ түвшинд байгаасай. Тийм учраас сургалтын орчин, оюутны дотуур байр, дээрээс нь хөгжих боломжтой тэр орчин талбай, ийм юм нь илүү байвал хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст илүү илүү их үйлчилгээ үзүүлж, бид илүү их боломж олгох боломжтой л гэж үзэж байгаа.

Сая нэг асуулт гараад ирсэн. Ерөнхийдөө танай сургуулийг төгсөөд тэгээд тухайн чиглэлээрээ ингээд удаан ажиллах чинь тогтвортой удаан ажиллаж байгаа ч юм уу, эсвэл тухайн чиглэлээрээ амжилт гаргасан ч юм уу тийм оюутны жишээ байгаа болов уу?

Шууд нэр орж ирэхгүй байна. Ер нь манай оюутнууд их мундаг яваа. Одоо Дуламсүрэн гээд манай компьютерын ангийг төгссөн сонсголын бэрхшээлтэй төгсөгч байгаа. Тэгэхээр өнөөдөр хүртэл багштайгаа хамт энэ жилийн олон улсын тэмцээнд цахимаар явагдсан манай компьютерын. Тэрийг хүртэл ингээд хамт зохион байгуулаад явж байна. Дээрээс нь өөрөө олон улсад төлөөлсөн сонсголын бэрхшээлтэй иргэдийг төлөөлж манай Монголын бас том төлөөлөл болж байгаа гэх мэтчилэн ер нь бас амжилттай яваа суралцагчид олон байгаа.

За ийнхүү цаг зав гарган манай подкастад орж ингээд Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн дэргэд мэргэжлийн боловсрол, ур чадварыг хэрхэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд олгож байгаа талаар ярьсан танд маш их баярлалаа.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ИДЭВХИТЭЙ ОРОЛЦОО НИЙГМЭЭС ХАМААРАЛТАЙ...



Чиба Хисао

Энэ удаагийн зочин Чиба Хисао маань Япон улсаас холбогдож байна. Тэрээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих, тэдэнд учрах саад бэрхшээлийг арилгахын төлөө ажил, амьдралынхаа 20 гаруй жилийг зориулсан эрхэм нэгэн билээ. Бангкок хотноо НҮБ-ийн Ази номхон далайн бүс нутгийн Эдийн засаг, нийгмийн комисст томилогдсоноор энэ чиглэлээрх ажлын гаргаагаа эхлүүлж байжээ.

Чиба Хисао 2016-2020 онд Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-аас Монголд хэрэгжүүлсэн Улаанбаатар хотын хөгжлийн бэрхшээлтэй иргэд (ХБИ)-ийн нийгмийн оролцоог дэмжих төсөл дээр ажиллаж байсан. Төслийн үр дүнд ХБИ-ийн асуудлаарх мэдээлэл, судалгааны нэгдсэн статистиктай болж “Цагаан ном”-ыг 2018, 2019, 2020 онуудад боловсруулан гаргаж нэгдмэл бодлого боловсруулахад хувь нэмрээ оруулсан байна. Харин өнөөдөр Тэрээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажил эрхлэлтийг дэмжихээр ЖАЙКА-аас Монголд 2021-2024 онд хэрэгжүүлэх төсөл дээр идэвхийлэн ажиллаж буй.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд учирдаг түгээмэл саад, бэрхшээлүүд

Чиба Хисао хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь биеийн, харилцаа мэдээллийн болон ухамсарын гэсэн 3 төрлийн бэрхшээлээс үүдэн хүрээлэн буй орчинтойгоо харьцахад хүндрэлтэй байдаг, харин эдгээр саад бэрхшээлийг давчихвал тэдгээр иргэд нийгэмд илүү оролцоотой, идэвхтэй

байж чадна гэдгийг онцоллоо. Монголд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд биетээр учирдаг саад бэрхшээл маш түгээмэл байдаг. Наад зах нь тэдэнд зориулсан зам, шат гэж бараг байдаггүй. Байгаа цөөхөн нь стандартад нийцээгүй, хэтэрхий огцом өгсүүр байх жишээтэй. Мөн, харилцаа, мэдээллийн саад их учраас тэд нийгмээс тусгаарлагддаг. Сүүлийн үед Монголын үндсэний телевиз болон өөр бусад сувгууд дохионы хэлмэрчээр дамжуулан мэдээллээ дамжуулж байгаа нь сайшаалтай. Ухамсарын түвшинд авч үзвэл хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэмд идэвхтэй, оролцоотой байхад саад болж буй гол зүйл нь "тухайн хүн өөрөө биш, харин нийгэм нь юм" гэдэг ойлголтыг Монголчуудад хүргэж, ойлгуулах нь Чибагийн гол хүсэл, эрмэлзэл юм.

Харилцан ажиллагаа, хамтын хүчин чармайлтын үр дүн

Тэрээр 2016 оныг одоо үетэй харьцуулахад ахиц дэвшил, өөрчлөлт гарсан эсэх талаар сэтгэгдэлээ хуваалцахдаа харилцан уялдаа холбоо, хамтын ажиллагаа хичнээн чухал болохыг онцолсон юм. Монгол улсын Засгийн газраас ХБИ-ээ дэмжих, нийгэмд идэвхтэй, оролцоотой байлгах талаар анхаарлаа хандуулан тодорхой төсөл хөтөлбөр, үйл ажиллагааг хэрэгжүүлэн, олон бодлого шийдвэрүүдийг гаргасан. Гэхдээ тухайн оролцоог яаж нэмэгдүүлэх арга замыг тодорхойлоход олон улсын байгууллага, төслүүдийн дэмжлэг хэрэгтэй байсан. Чиба ЖАЙКА-д ажиллахдаа дараах 3 түвшинд харилцан ажиллагаа, хамтын хүчин чармайлт үгүйлэгдэж байгааг олж харсан байна. Нэгдүгээрт, Монгол дахь ХБИ-ийн байгууллагууд өөр хоорондын; хоёрдугаарт, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага ба засгийн газар хоорондын; гуравдугаарт, яамд, төрийн байгууллагууд хоорондын уялдаа холбоо байдаггүй нь маш том сул тал гэж үзсэн. Төрийн байгууллага, яамд өөрсдийн судалгаа, мэдээллүүдтэй боловч нэгдсэн системгүй байв. Тийм учраас нэгдмэл хүч, нэгэн дуу хоолойгоор төр засагтаа санал бодлоо зөв хүргэхэд нь эдгээр иргэдэд дэмжлэг үзүүлэхээр зорьсон байна. Япон улсад зохион байгуулагдсан олон тооны сургалтад хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон төрийн байгууллагын албан хаагчдын аль алиных нь төлөөллийг хамтад нь оролцуулж, харилцан ойлголцолыг дэмжиж иржээ.

Түүний бодлоор, өнгөрсөн 4 жилийн хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд олон чухал төсөл, хөтөлбөрүүдэд өөрсдөө биечлэн оролцож, төрийн байгууллагуудтай хамтран ажиллах тал дээр томоохон ахиц гаргасан. Тэд төр засагтайгаа асуудлыг хэлэлцэн тохирч, зарим үед шахан шаардсаар тодорхой шийдэлд хүрч чадсан.

Монгол Улсыг Азийн зарим улс орнуудтай харьцуулсан түүний бодол, дүгнэлт

Бангкокт 7 жил, Камбож, Филиппин зэрэг Зүүн өмнөд Азийн орнуудад нэлээдгүй



олон жил ажиллахдаа тэрээр Монгол улсын нийгмийн хамгаалал, аюулгүй байдлын тогтолцоо нь арай өөр болохыг анзаарчээ. Түүхэндээ Монгол улс нь социалист системтэй орон байсан. Хэдийгээр ардчилсан хувьсгал ялсан ч гэсэн тэтгэвэр тэтгэмж, нийгмийн даатгал гэх мэт хуучин системийн бодлого хэвээр хадгалагдаж байдаг. Харин Тайланд, Филиппин зэрэг улсууд эдийн засгийн хөгжлийг нэгдүгээрт тавьдаг. Тийм ч учраас эрүүл мэнд, нийгмийн даатгалын тогтолцоо нь Монголтой харьцуулахад арай сул, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудалд өөрөөр ханддаг санагджээ. Гэхдээ, хүний эрхийн хандлага талаас нь авч үзвэл Тайланд улс сайн хөгжсөн бөгөөд Монголчууд тэднээс сурах зүйл их байдаг.

Бидний суралцах зүйл: Нэгдүгээрт, түрүүн дурдсанчлан Монголд хамтын буюу харилцан ажиллагаа сул. Тайландад бол хөгжлийн бэрхшээлтэй иргэд нэгэн дээвэр дор нэгдэж ажилладаг. Ингэх нь засгийн газартайгаа яриа хэлцэл хийх, хамтран ажиллаж хүсэл сонирхолоо илэрхийлэхэд том боломжийг олгодог. Түүний хувьд энэ бол орхигдох ёсгүй чухал сэдэв юм. Хоёрдугаарт ажил эрхлэлтийг дэмжих асуудал. Тайландад төрийн болон хувийн байгууллагууд квотын систем буюу 100 хүн тутамд 1 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах шаадлагатай байдаг. Харин Монголын квот 100 хүн тутамд 4 байдаг. Хэдийгээр Монгол улс квотын тоогоор илүү боловч, Тайландын хариуцлага тооцох систем нь илүү сайн. Квотдоо хүрч ажиллуулж чадахгүй бол өндөр хэмжээний татварыг засгийн газартаа төлнө, тэр орлого нь эргээд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжихэд зориулагддаг. Энэ

нь тухайн иргэдийг ажлаар хангах том хөшүүрэг болж өгдөг байна. Энэ бол өнөөдөр түүний ажиллаж буй төслийн гол зорилго юм.

2021-2024 онд хэрэгжүүлэх төслийн тухай

ЖАЙКА-аас Монголд 4 жил хэрэгжүүлэх хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажил эрхлэлтийг дэмжих төсөл нь 2 ажлыг хандлагыг голчилж байна. Нэгдүгээрт, Ажилд дадлагажуулагч буюу Job coach. Япончууд АНУ-ын туршлагад үндэслэн ХБИ болон ажил олгогч компаниудыг хооронд нь холбох энэ аргад суралцсан. Тэд төрийн оролцоо багатайгаар өөрсдөө ажил олох боломжтой болно гэсэн үг. Нөгөө талаар ХБИ-ийг ажиллуулах хүсэлтэй ч тэдэнтэй яаж холбогдохоо мэдэхгүй байгаа компаниудад бас тусалдаг юм. Ажилд дадлагжуулагчид зөвхөн гүүр болоод зогсохгүй, компаниудад ХБИ-тэй хэрхэн хамтран ажиллах тухай тусгай сургалт явуулж биеийн, харилцааны болоод сэтгэл зүйн хувьд тулгарч болох саад бэрхшээлүүдийг аль болох багасгахад дэмжлэг үзүүлдэг. Хоёрдугаарт, компаний удирдах бүрэлдэхүүний оролцоог



нэмэгдүүлэх. Хэрэв тухайн компаний удирдлага чухам яагаад ХБИ-тэй хамтран ажиллаж байгаа учир шалтгаан, ач холбогдлыг ул суурьтай ойлгохгүй бол тэд зөв шийдвэр гаргаж чадахгүй. Асуудлыг шийдвэрлэх гарц, гаргалгааг бий болгоход хүмүүсийн ухамсар, сэтгэлгээ маш чухал юм. Хараагүй, сонсголгүй зэрэг хөгжлийн биет бэрхшээлтэй хүмүүсийн хувьд ажиллах орчин орчинг бүрдүүлсэн байхад болох мэт санагддаг. Гэтэл оюуны болон сэтгэлгээний бэрхшээлтэй хүмүүсийн хувьд байдал өөр. Тэдэнд тохирсон ажил олгоход ажилд зуучлагчдийн үүрэг оролцоо өндөр байдаг.

Энэ бүхний эцэст бусдад өгөхийг хүссэн түүний зөвлөгөө бол "биет бус нийгмээс үүдэлтэй саад бэрхшээл"-ийг аль аль тал нь ойлгох хэрэгтэй гэв. Хүмүүс ХБИ-д зүгээр л туслах биш, тэднийг нийгмийн идэвхитэй, оролцоотой бүлэг гэж хүлээн зөвшөөрөөсэй гэж тэр боддог. Хэрэв ХБИ нь нийгэмдээ оролцоотой байж чадаж байвал, тэр нийгэм бусад бүх хүмүүсээ оролцоотой, идэвхитэй байлгаж чаднаа гэсэн үг. Энэ консептийг хүн бүхэн ойлгоосой.

Бие даан амьдрах төв

Япон улс 1980-аад оны үеэс ХБИ-ээ Америк явуулж "Бие даан амьдрах чадвар"-т сургаж, энэ аргыг хэрэгжүүлж эхэлсэн. Тэд мэдээж шууд хуулбарлаад ирээгүй, Японы онцлогт тохируулан сайжруулж ирсэн. Одоогоор Японд 140 гаруй "Бие даан амьдрах төв" байдаг. Монголд байгуулсан "Түгээмэл хөгжил бие даан амьдрах төв"-ийн тэргүүн Ч.Ундрахбаяр,



Чиба нар анх 2008 онд Японд, дараа нь Монголд уулзаж байж. Бие даан амьдарна гэдэг нь зөвхөн эдийн засаг, санхүүгийн хувьд хязгаардагдах асуудал биш юм. ХБИ шийдвэр гаргахад сэтгэлзүйн хувьд маш хүнд байдаг. Яагаад гэвэд тэд үргэлж орчин тойрны болон гэр бүлийн хүмүүстээ ямар нэг байдлаар нөлөөлчихвий гэж боддог. Тийм ч учраас өөрсдийн жинхэнэ хэрэгцээ, шаардлагыг бүрэн дүүрэн илэрхийлж чаддаггүй. Тэгэхээр "Бие даан амьдах төв"-ийг ажиллуулна гэдэг өргөн агуулгатай гээд Монголын засгийн газар үүнд анхаарлаа хандуулахыг хүсэж байдагаа илэрхийлэв. Америк, Япон зэрэг улсуудтай харьцуулахад Монголд энэ төрлийн төвүүдийн санхүүжилт илүү хүндрэлтэй санагдсан. Японы хувьд 1990-ээд оны үед ХБИ засгийн газартаа хүчтэй шаардлага тавьсны үр дүнд "Бие даан амьдрах төв"-үүдийг төрөөс санхүүжүүлж эхэлсэн бөгөөд ажилчдийн цалингийн хэмжээ боломжийн түвшинд хүрсэн тухай туршлагаас хуваалцав.

Ярилцлагын явцад Чиба Монгол хүмүүс их найрсаг, тусархуу юм хэмээгээд нэгэн тохиодлыг дурсав."Би хөгжлийн бэрхшээлтэй найзынхаа хамтаар автобусанд суух гэж байв. Мэдээж, зориулалтын хэрэгсэл байгаагүй. Найз минь яах бол гээд ажиж байтал түүний ойр орчимд байсан хүмүүс огтхон ч эргэлзэх зүйлгүйгээр маш хурдан түүнд тусалсан. Японд бол нөхцөл байдал арай өөр. Тэд шууд туслахгүй, эхлээд жоохон анзаарч, эргэлзэнэ. Магадгүй Японд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан дэд бүтцээ сайн хөгжүүлсэн, бас тэднийг сургалтад хамруулж бэлддэгтэй холбоотой байх. Японд миний найз хараагүй боловч олон нийтийн газраар ганцаараа явж, нийгмийн оролцоотой байж чаддаг. Харин Улаанбаатарт тийм бэрхшээлтэй хүн ганцаараа явна гэдэг маш хэцүү. Миний найз ийм сорилттой орчинд өөрөө явах гээд оролдоод үзье гэж хэлсэн, тэр чадсан. Гэнэт л бөөн хүмүүс түүнийг хүрээлээд, тусалсан. Зарим нь чи яагаад ганцаараа явж байгаа юм бэ, болохгүй, ... ямар нэг болбол яана гээд л...энэ бүхэн нь Монгол хүмүүсийн сайхан хандлагыг илэрхийлж байсан. Мэдээж их сайхан зүйл. Гэхдээ тэд үргэлж хүмүүст найдаж амьдрах хэцүү. Тийм учраас тулд DET / disability equality training/ буюу "Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт"-ыг явуулж байх шаардлагатай" гэснээр яриагаа өдөрлөв.

АНГЛИ ХЭЛ СУРСНААР ФУЛБРАЙТЫН ТЭТГЭЛЭГ АВЧ АНУ-Д СУРСАН



Д.Гэрэл

Сайн байцгаана уу, эрхэм хүндэт сонсогчид оо, Антолд подкастын маань ээлжит дугаар эхлэхэд бэлэн болоод байна. Энэхүү дугаарт Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооны ерөнхийлөгч Гэрэл оролцож байнаа. За та ийнхүү цаг зав гарган манай подкастад орж байгаад маш их баярлалаа. Та эхлээд өөрийнхөө талаар болон холбооныхоо талаар танилцуулахгүй юу?

Манай хараагүйчүүдийн үндэсний холбоо бүр 1978 онд байгуулагдаж байсан. Ер нь Монголд анх байгуулагдсан ууган байгууллагуудын нэг гэж хэлж болно. Тэгээд сая бид нар 2018 онд 40 жилийн ойгоо хийсэн. Тэгээд хөгжлийн бэрхшээлтэй гэж ярихаар нэг зүйлийг боддог. Одоо хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй, хүртээмжтэй, тэгш боломжийг олгоно гээд л ярьдаг. Тэгэхлээр яг тийм, одоо хүртээмжтэй, тэгш боломж олгочихсон орчинг бүрдүүлье гэвэл юуны өмнө хөгжлийн бэрхшээл гэсэн ангилалд хамрагдаад байгаа эдгээр хүмүүсийнхээ өөр хоорондын ялгаатай хэрэгцээг нь таньж мэдэх ёстой гэж боддог. Тэгэхлээр яах аргагүй жишээлэх юм бол хараагүй харааны бэрхшээлтэй хүний хувьд нийгэмд оролцоход орчин хүртээмжтэй байхын тулд бид өөр юм ярьдаг. Гэтэл сонсголын бэрхшээлтэй хүнд бол өөр тохируулах нөхцөл хэрэгтэй ч гэдэг юм уу, тийм байгаа болохоор хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй хүртээмжтэй нийгмийг бий болгоё гэх юм бол яг дотор нь байгаа тэр өөр хоорондоо ялгаатай, иргэдийнхээ яг тус бүрийн онцлогийг маш сайн анхаарч мэддэг байх ёстой гэж боддог. Тэгэхлээр яах

аргагүй ингээд жишээлэх юм бол харааны бэрхшээлтэй иргэд бид ний нуугүй хэлэхэд бусад хөгжлийн бэрхшээлтэй би хувьдаа сонсголын бэрхшээлтэй хүмүүсийг мэднэ. Мэдээж хэрэг гэхдээ яг ямар ямар асуудлууд ихэвчлэн тулгамддаг вэ, яаж тэдгээрийг нь шийддэг вэ гэх юм бол би сайн мэдэхгүй, тийм байгаа болохоор яг нөгөө хөгжлийн бэрхшээлтэй иргэд, төрөл төрлөөрөө одоо хэлбэрээрээ ингээд үйл ажиллагааг яг чиглүүлж явдаг үйл ажиллагаа явуулдаг, тэр нь ч бол зүй ёсны зүйл. Яг үүний адилаар хараагүйчүүдийн үндэсний холбоо бол зөвхөн одоо харааны бэрхшээлтэй тэр иргэдийнхээ эрхийг хамгаалах, нийгмийн харилцаанд бусдын адил оролцоход нь ямар дэмжлэг, орчин бий болгох ёстой юм бэ гэдэг дээр илүү анхаарч, хөгжилд нь дэмжлэг үзүүлж явдаг. Тэгээд манай холбоо дэргэдээ бол яг хараагүй хүн тойрсон асуудлуудыг шийдэхэд чиглэдэг болохоор манай холбооны бүтцэд өнөөдөр хараагүй хүмүүст зориулсан барель болон ярьдаг ном хэвлэдэг төв, харааны бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн өмнөх боловсрол олгодог цэцэрлэг, насанд хүрэгчдэд нь мэргэжлийн боловсрол олгодог сургалтын төв, тэгээд дээрээс нь хараагүй хүмүүс, нөгөө МСҮТ-д төгсөөд гарсан бариа заслын чиглэлээр төгссөн хүмүүсийг ажлын байртай болгоход нь зориулсан анхны нэг гуравдугаар төв ч гэдэг юм уу, бас сүүлд байгуулагдсан кофе шоп гэж байдаг. Ингээд одоо эф эм (FM) радио станц манайд байдаг. Энэ бол яг л бас нөгөө хараа бүхий бэрхшээлтэй хүмүүстэй нөгөө мэдээлэл авах боломж нь хязгаарлагдмал байдаг болохоор яг тэр чиглэлийнх нь алдагдсан боломжийг нь арай жаахан нэмэгдүүлэх ч гэдэг юм уу. Тэгэхээр манай FM радио бол уран зохиолын цагтай ч гэдэг юм уу, мэдээ мэдээллийн цаг түлхүү байдаг гэдэг юм уу. Ингээд ерөнхийдөө ингээд л хүн тойрсон асуудлыг шийдэх зорилгоор үйл ажиллагаагаа чиглүүлээд явдаг. За тэгээд энэ хүрээндээ яг бүтцийн байгууллагууд нь бол ийм. Үүнийхээ зэрэгцээ бид нар одоо яг харааны бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, боловсрол, боловсрол дотроо дээд боловсролд эзэн суралцахад их дээд сургуульд суралцахад ямар асуудал байна, ерөнхий боловсролын сургуульд суралцахад боломж нь байна уу? тусгай сургууль, тэгвэл ердийн сургуульд сурахад ямар асуудал байдаг юм бэ? хүртээмж, замаар явахад бие даагаад нөгөө цагаан таягаа бариад явахад аюулгүй орчин бүрдэж чадаж уу? цагаан таягаа зөв авч явах, сурах тэр сургалтын систем, гэрлэн дохио, зам талбайн тээврийн хэрэгслийн хүртээмж, барилга байгууламжийн хүртээмж, тэгээд бас мэдээллийн хүртээмж, нөгөө мэдээллийг авахад гээд л ерөөсөө хүн тойрсон ямар асуудал байна тэр бүх асуудал дээр анхаарал хандуулаад ингээд ажиллаад явж байгаа байгууллага байдаг.

Тэгээд өнөөдөр манай холбоо чинь 9000 орчим гишүүдтэй. Ерөнхийдөө нөгөө ууган байгууллага гэдэг утгаараа ч гэдэг юм уу, хөдөө орон нутгийн бүх хорин нэгэн аймаг, алслагдсан хоёр дүүрэгт өөрийн гэсэн салбартай. За тэгээд салбараараа дамжуулаад л 9000 гаруй гишүүддээ хүрч ажиллахыг хичээдэг. За тэгээд манай

хөдөөд байдаг салбарууд бол бас л зарим нь дэргэдээ FM-тэй мэдээллийн танхимтай, массажийн төвтэй ч гэдэг юм уу, хотод хийж байгаа үйл ажиллагааг хөдөө орон нутгийн харааны бэрхшээлтэй иргэдэд хүргэхэд чиглэдэг. Дээрээс нь мэдээж хэрэг гол юм нь нөлөөлөл эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн тохиолдолд ямар арга хэмжээ авах вэ, шийдвэр гаргах түвшинд ямар нөлөөллийг үзүүлж, энэ хүмүүст хэрэгтэй бодлого шийдвэрийг гаргах вэ гэдэг дээр илүү түлхүү ажиллаж байдаг. Өнөөдөр манай холбоонд бол ерөнхийдөө 86 өөрийн гэсэн ажилчидтай, тэгээд л үйл ажиллагаагаа явуулж байгаа ийм байгууллага байна даа. За тэгээд би 2006 онд хараагүйчүүдийн үндэсний холбоонд ажилд орж байсан. За тэгээд өөрөө бол би тухайн үед гүйцэтгэх захирлаар нь ажилд ороод за тэгээд манай холбоо чинь дөрвөн жил тутамд нөгөө их хурлаа хийдэг, бүр хөдөө орон нутгийн төлөөлөл, за тэгээд хотын төлөөлөл оруулаад тэгээд 2013 оны их хурлаар холбооны ерөнхийлөгч, тэгээд 2017 оны их хурлаар нэг удаа улиран сонгогдоод ингээд холбоогоо тэргүүлээд л ажиллаж байгаа. Тэгээд манайх чинь 15 удирдах зөвлөлийн гишүүдтэй, их өнөр олуулаа л хамт олон л доо. Тэгээд л бусад алба нэгжүүдийнхээ удирдлагуудтай, удирдах зөвлөлийнхөнтэйгээ, ажилтан гишүүдтэйгээ тэгээд л хамтдаа Монгол улсад харааны бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй, ээлтэй орчин бүрдүүлэхийн төлөө л зорьж яваа ийм хүмүүс байна.

Ийнхүү та ингээд холбооныхоо үйл ажиллагааг ингээд үргэлжлүүлээд явж байхад ерөнхийдөө ямар нийтлэг саад бэрхшээлүүд тулгарч байдаг вэ?

Тийм эхлээд бол ер нь хамгийн том саад бэрхшээлийг бол мэдээж ингээд нөгөө юм хийгээд ингээд үүсгээд явж байхад бол яг тухайн тухай бүрдээ олон саад бэрхшээлүүд их учирна. Гэхдээ ерөнхийдөө өнөөдөр ингээд бид нар нэг ерөнхийд нь хэлдэг шүү дээ. Монгол улсад ганц хараагүй гэхгүй ер нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бий болж чадаж уу? Хөгжлийн бэрхшээлтэй иргэд маань нөгөө хүний эрх гэдэг үндсэн эрхээ бусдын адил бүрэн дүүрэн эдэлж чадаж байна уу гээд л ингээд л яриад явах юм бол би бол хангалтгүй гэж хэлдэг. Яагаад гэх юм бол? Өнөөдөр бусдын адил одоо бид нар яг энэ нийгэмд бүрэн дүүрэн оролцоотой байж чадахгүй байна шүү дээ. Яг ингээд л одоо сургуульд суръя гээд одоо өнөөдөр ингээд л нөгөө тоо баримтаас харах юм бол мянга хоёр зуугаад харааны бэрхшээлтэй хүүхэд байна аа гэсэн тоог өгдөг. За тэгээд энэ мянга хоёр зуугаа нолиос арван долоон насны хүүхдүүд гэж байгаа. Тэгээд эдгээрийн хэдэн хувь нь өнөөдөр боловсролд хамрагдаж байна гээд аваад үзэх юм бол хоёр зуу хүрэхгүй хүүхэд л өнөөдөр цэцэрлэг тэгээд сургуульд явж байна шүү дээ. Ихэнх нь нөгөө хараагүй хүүхдийн тусгай сургууль 116-д явж байна. Цөөн тооны хүүхдүүд болбол тэгэхдээ яг бүрэн хараагүй нь биш, ер нь цөөн тооны сул хараатай хүүхдүүд нь болбол ердийн сургуульд явж байна. Тэгэхдээ маш цөөхөн. За тэгээд

бусад хүүхдүүд нь ингээд сургуульд суръя нөгөө хуульдаа заасан би одоо хамран хамрагдаж байгаа тойргийнхоо сургуульд оръё гэхэд л өнөөдөр тэр сургуульд орох боломж нь байхгүй шүү дээ. Олон хараагүй хүүхэд нөгөө хүртээмжтэй сургалтын орчин бүрдээгүйгээс гэртээ байна, ажил хөдөлмөр эрхэлье гээд бид нар чинь дуртай ажилдаа орчихъё гэхэд бас хязгаарлагдмал. Гэхдээ л бид нарын бас хийж чаддаг тохирсон ажлууд бол маш их байдаг. Гэтэл бас л нөгөө орчин бүрдээгүйгээс. Одоо өнөөдөр хөдөлмөрийн насны 7000 гаруй харааны бэрхшээлтэй иргэдээ дөнгөж 5 гаруй хувь нь л хөдөлмөр эрхэлж байгаа. Одоо ихэнх нь бол энэ бариа заслын чиглэлээр манай хараагүйчүүдийн үйлдвэрт хараагүйчүүдийн үндэсний холбоонд гэтэл одоо тавиад хүн ажиллаж байх жишээтэй. Ингээд хөдөлмөр эрхлэлт, боловсрол гээд л бусад нөгөө хүний үндсэн эрхүүдээ бусдын адил эдэлье ээ, хэрэгжүүлье гэхээр нөгөө аягүй их саадтай, орчин нь бүрдээгүй. Тэгээд энийг мэдээж хэрэг олон асуудлыг бид нар хэлж болно шүү дээ. Гэхдээ хамгийн гол үндсэн саад нь юу вэ гэдгийг бид нар юу гэж дүгнэж үзэж байна вэ гэхээр өнөөдрийн өндөрлөгөөс хүмүүсийн одоо нөгөө тухайн асуудлын талаарх нөгөө мэдлэг ойлголт хангалтгүй байгаа байдал гэж ерөнхий бид бид нар дүгнээд байгаа юм.



Ер нь ингээд бид нар ингээд олон улсын түвшинд бусад улс орнуудтай одоо ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай хамтардаг Монголдоо ч гэсэн бусад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ байгууллагуудтай хамтардаг. За тэгээд мэдээж тус бүрд нь ингээд л нэг асуудлууд бол байгаа, тэгээд гол бэрхшээл нь бол нөгөө хүн мэдэхгүй юмандаа жаахан хайхрамжгүй ханддаг, эсвэл мэдэхгүй болохоороо ингээд юу гэдэг юм, тэр хүмүүсийнхээ асуудлыг ингээд яг өөрийнхөө үйл ажиллагаан дээр бүрэн тусгадаггүй ч гэдэг юм уу, тэр нь гол бэрхшээл гэж боддог. Монголчуудын хувьд бол мэдээд ирэх юм бол өө ингэдэг байсан юм уу? тэгвэл ингэчихье гэдэг дээр бас арай гайгүй гэж хэлж болно. Зүгээр бид нар ингээд нөгөө бусад улс орнуудын байгууллагуудтай хамтарч байхад одоо нэг ялгаварлан гадуурхалт гээд л нэг ярьдаг шүү дээ. Одоо хүнийг хөгжлийн бэрхшээлийнх нь үндсэн дээр ялгаварлах, арьс өнгөөр нь ялгаварлах, жендерээр нь ялгаруулах гээд л ялгаварлан гадуурхах олон хэлбэрүүд байдаг. Тэгээд анх бид нар ингээд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхах гээд зүгээр нэр томьёо.



Ингээд нөгөө Монголд орж ирээд мэдээж хэрэг гол үндэслэл нь бол 2006 онд Нэгдсэн үндэстний байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц баталсан. За тэгээд Монгол улс 2009 онд нэгдэж орсон. Тэгээд тэр конвенц дээр байдаг нэг гол үзэл санаа нь бол хүнийг хөгжлийн бэрхшээлийнх нь үндсэн дээрээс нь ялгаварлаж болохгүй, тэр хүний үндсэн эрх, эрх чөлөөг бусдын адил эдлэх боломжийг нь олгоно гээд л заачихсан. Тэгээд ерөнхийдөө нөгөө хөгжлийн бэрхшээлийнх нь үүднээс ялгаварлан гадуурхан гэж юу юм бэ гэдгээ нарийн сайн ингээд ухаж яг конвенцын үзэл санаа зарчимд нийцүүлээд тайлбарлахгүй бол зүгээр ялгаварлан гадуурхана гэхээр монголчууд анх тэгж ярьж байсан юм, бид нар чинь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхана гэж юу байх вэ дээ, харин ч одоо ингээд ядарсан зүдэрснийгээ, бид нар чинь наашаа л гэдэг, болж өгвөл дэмжиж бай л гэдэг шүү дээ гээд ерөнхийдөө бол тийм гэр дотор ч гэсэн ер нь монголчуудын нэг тийм юм харагддаг гэж боддог л доо, одоо хамгийн ядарсныгаа л гээд л тэгдэг шүү дээ. Ер нь бол гэр дотор ингээд л таван хүүхэд, би бол өөрөө таван дүүтэй тэгээд л ингээд

л байлаа гэхэд чинь бүхний анхаарал болбол бүх дүү нар одоо гэр бүл дотроо би нэгдүгээрт нь эхлээд л миний асуудлыг ярина. Миний асуудлыг зохицуулахын тулд за чи яах вэ, ийх вэ гэдгээ ярина. Одоо жишээлэх юм болбол намайг л ингээд л ая тухтай өөрсдийнхөө хэмжээнд байлгах гээд л ингээд л бүх зүйлийг надад зориулдаг гэх жишээтэй. Ер нь иймэрхүү юм бол гэр бүлүүдэд мэдээж хэрэг их түгээмэл байдаг. Яг энэ зарчмаараа ч гэсэн ер нь хүмүүс жаахан тиймэрхүү хүмүүсээ харахаар дэмжчих юм сан, аль болох тусалчих юм сан гэсэн бодолтой байдаг. Гэхдээ яг нөгөө зөв эрхэд суурилсан хандлагаар гол нь нөгөө дэмжлэг нь явдаггүй байхгүй юу. Хөөрхий чааваас, зайлуул за тэгээд нөгөө нэг одоо юу гэдэг юм, зүгээр нэг санхүүгийн талаар нь ч юм уу тэр талаар нь дэмжих гээд байхаас биш ерөнхийдөө нөгөө сурахад нь, ажиллахад нь энэ хүн нийгэмд ороход нь гэдэг талын ойлголт нь байдаггүй болохоор яг тэр талынхаа дэмжлэгийг бүрэн үзүүлж чаддаггүй байсан. Би гэхэд л ингээд анх хараагүй болчихоод оюутан байхдаа би хараагүй болсон л доо.

Тэгээд гэртээ сууж байхад би өөрөө хараагүй хүн яаж сурдаг юм, яаж ажилладаг юм, гадуур явахдаа яаж явдаг юм, одоо хараагүй хүн ямар ном уншдаг юм гэсэн ямар ч мэдээлэлгүй, ойлголтгүй байсан. Манай гэр бүлийнхэн ч гэсэн тийм ойлголт байхгүй. Тийм байгаа болохоор одоо надад яг тэр нөгөө хөгжил талын дэмжлэг гэхээсээ илүү зүгээр л намайг гэр дотор минь ая тухтай юугаар ч дутаахгүй байлгах нөгөө бөөцийлөх тэр хандлага руугаа илүү яваад өгчихөж байсан. Тэгээд дараа нь ингээд бүх зүйлээ мэдээд ирэхээр өө тэгье сургая, ажил хийлгэе, тийм дэлгэц унших программтай компьютер үзвэл тэрийг нь авааД өгье, номтой болгоё гэж тэр талаас нь ингээд мэдлэг ойлголт авсны дараа тэр талын дэмжлэгүүд маань хийгдэж эхэлж байгаа байхгүй юу. Тэгэхлээр гол бэрхшээл маань бид нарын онцлог хэрэгцээ яавал энэ хүмүүст хүртээмжтэй орчин бий болгох вэ, яавал энэ хүмүүст бусдын адил ажилд амьдрах тэр боломжийг бий болгох вэ гэдэг ойлголт маань одоо аль ч түвшинд гэж би бол ярих, одоо бид нар ярьдаг л даа. Одоо нийгэмд маань ч ерөнхий талын ойлголт хангалтгүй, за тэгээд нөгөө хууль тогтоомжийг хэрэгжүүлээд сууж байгаа хүмүүс маань хангалтгүй, шийдвэр гаргаж байгаа хүмүүсийн маань түвшинд хангалтгүй байгаа болохоор бид нарын асуудал ингээд жаахан орхигдох тал л илүү байдаг юм байна аа гэж зүгээр сүүлийн үед ажиглах болсон. Тийм болохоор хамгийн гол зүйл нь бол ойлголтыг нэмэгдүүлэх гэдэг асуудал маш чухал. За мэдээж хэрэг хоёрдугаар гол бэрхшээл нь бол ойлгоод байгаа мөртлөө бас нэг сэтгэлгүй гэдэг юм уу нөгөө хүсэл зориг байхгүй энэ хүмүүсийг дэмжчихье гэдгийг ойлгохгүй ирэх гэдэг үүднээс нь харахгүй. За бараг нөгөө тиймэрхүү юмнууд гарч байсан шүү дээ. За ингээд хараагүй хүмүүс ажил хийнэ гэж юу байдаг юм бэ? Тэгээд л гэртээ л байж байхгүй юу гэж хэлдэг хүмүүс байдаг юм. Та нар одоо энд юу хийж байгаа юм бэ ч гэдэг юм уу. Бараг л ингээд л гэртээ ингээд

л амар тайван гээд л байж байсан дээр шүү дээ. Таягаа бариад л гадуур ингээд л аюултай нөхцөлд явж байхаар гэдэг ч юм уу. Тэгэхлээр нөгөө дэмжих хүсэл сонирхолгүй тиймэрхүү сөрөг хандлагатай хүмүүс болбол ний нуугүй хэлэхэд байдаг. Тэгэхлээр гол бэрхшээлүүд нь бол энэ хоёр ойлголтгүй, ойлголттой байгаа ч гэсэн дэмжчихье гэсэн эрхийн үүднээс асуудлыг ойлгодоггүй хүмүүс хамгийн гол бэрхшээл нь гэж боддог. Яагаад тэгж байгаа гэхээр мэдээд байгаа мөртлөө төсөв зохиохдоо бид нарын асуудлыг суулгадаггүй, мэдээд байгаа мөртлөө ажлын байрыг энэ хүмүүст зориулаад хүртээмжтэй болгоё гэдэг дээр үйл ажиллагаа хийдэггүй энэ хүмүүсийг бол яах аргагүй сөрөг хандлагатай хүмүүс гэж бодож байгаа байхгүй юу. Тэгэхлээр хамгийн гол бэрхшээлүүд нь болбол одоо эдгээр гэж ер нь ойлгодог. Тэрнээс тус тусдаа ингээд л яриад л явах юм бол одоо сургуульд сурахад яагаад болохгүй байна гэх юм бол, ном дэвтэр нь байхгүй байна, багш нь ойлголт байхгүй байна, нөгөө туслах багш нь байхгүй байна гээд л тэ ээж аа мэдэхгүй байна гээд л жижиг жижиг асуудал дотор нь байгаа бэрхшээлийг бол ярьж болно. Гэхдээ том хоёрыг нь бол бид нар тэгж хардаг.

Тэгвэл энэ том хоёр асуудлыг одоо ер нь шийдэхийн тулд ер нь яаж шийдэх ёстой вэ? Гарц гаргалгаа таны бодлоор юу байна?

Гарц гаргалгаа нь одоо жишээлэх юм бол би танай ингээд подкастад оролцоод ингээд яриад явж байна тэ. Энэ бол жишээлэх юм бол нэг хэлбэр нь. Тэгээд бид нар бас нэг олон улсын ингээд хуралд сууж байхад, бид нар Данийн хараагүйдийн холбоотой нэлээн хамтардаг. Тэгээд тэр байгууллагатай ярьж байхад нөлөөлөл хий, ийм хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгмийн дунд байдаг юм аа, та нартай адилхан эрхтэй юм аа гэдгийг байнга энэ хүмүүст хэлж бай ойлгуулж бай гэж хэлж байсан. Тэгээд хамгийн одоо наад жишээ нь хараагүй хүмүүс таягаа бариад та нар өөрсдөө нийгэмдээ оролцоод яв. Гудамжаар яв, хүмүүсийн нүдэнд харагд, энд тэнд сур, ажилла. Яг та нар өөрсдөө ингээд асуудлаа яриад, та нар өөрсдөө хүмүүсийн дунд ороод ирэх эхлэх юм бол хүмүүс та нарын тухай ярьдаг болно. Ингэх юм бол нөгөө бие биеэсээ ингээд уламжлаад дамжаад мэддэг болдог юм аа. Тэгэхгүй зүгээр та нар ингээд гудамжиндаа байхгүй гэр гэртээ суучихаад л, зүгээр хараагүй ингэж хамт олны дунд нэг байхгүй байхад нэг гучин хүний дунд оччихоод л та нар хараагүй хүнтэй уулзлаа гээд л яах вэ? Ярина л даа.

Гэхдээ тэр маань ерөнхийдөө жаахан хол хөндийдүү ч гэдэг юм уу, яг ингээд хажууд нь ойрхон жишээ баримттайгаар өөрсдөө өөрсдийнхөө асуудлыг ярьдаг ч юм уу, эс үгүй бол өөрсдөө дунд нь ордог ч юм уу энэ тэр гээд явах юм болбол одоо ойлголтыг нэмэгдүүлэх маш бас чухал гэж харж байгаа. Тэгэхлээр энэ подкастыг яг ингээд хөгжлийн бэрхшээлийн чиглэлээр бас та нарыг эхлүүлж байгаад их талархаж байгаа. Энэ бас яг энэ нийгмийн ойлголтыг нэмэгдүүлэхэд их чухал юм болов уу л гэж

ойлгож байгаа. Тэгээд зүгээр нөгөө энэ дээр нэг жишээ хэлэхэд бол мэдээж хэрэг нөгөө ойлголтыг нэмэгдүүлэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өөрсдийнх нь оролцоо маш чухал. Жишээлэх юм бол би их сургуульд сурч байгаад хараагүй болсон. Тэгээд тодорхой хугацаанд завсарласны дараа би сургуульдаа үргэжлүүлж сурсан. Тэгээд мэдээж хэрэг манай ангид бол хараагүй хүүхэд байхгүй, манай сургуульд байхгүй, хуулийн сургуульд намайг ингээд сургуульдаа үргэжлүүлээд сурахад мэдээж хэрэг ороход надад ч мэдээж хэрэг яг нөгөө шинэ хамт олны дунд орж байгаа, тэгээд нөгөө манай ангийнхан ч гэсэн эхлээд мэдээж хэрэг за энэ хүн сурч чадах болов уу? багш нар ингээд янз бүрийн л асуудал байгаа шүү дээ. Тэгээд тодорхой хугацаанд хамт олныхоо дунд явахаар яг манайхан юу гэдэг вэ гэхээр хараагүй хүнтэй яаж харилцах вэ, онцлог нь юу байдаг юм тэ гэдгийг бүгдийг нь мэдчихэж байгаа юм. Тэгээд бүр хэсэг хугацааны дараа манай найз нөхдүүд нь юу гэж ярьдаг вэ гэхээр за ингээд хараагүй гэдгийг чинь заримдаа мартдаг шүү дээ. Ингээд л нөгөө яг адилхан дунд нь ороод л ярилцаад л, тэд нар маань намайг ингээд л хөтлөөд л явчихдаг. Бид нар чинь бүр нийлээд одоо заримдаа ангийнхантайгаа эд ангийнхаа хүүхдэд хүүхдээ нийлээд уран зураг, музей эд нарыг үзээд л явдаг л даа. Тэгээд л тэд нартайгаа явж байхдаа одоо уран зургийг хүртэл надад маш сайхан нөгөө тайлбарлаад л музей эд нарыг ингээд бүр яаж тайлбарлах вэ, яаж хөтлөх вэ, ингээд бид нар жишээлэх юм бол одоо ууланд гардаг, тэгэхээр яаж авч явахыг нь мэддэг болчихсон, тэгэхээр тэр хүмүүс маань ингээд дундаа ороод явахаар хараагүй хүний л талаараа маш сайн мэддэг болчихоосоо гадна ерөөсөө бид нарыг тэгж бид нараас дутуу юм байна, энэ нь надад хэцүү юм байна гэсэн ойлголт байхгүй болбол бараг л адилхан хандаад л явчихдаг болдог. Тэгэхлээр одоо манай залуучууд ч гэсэн ингээд одоо ердийн ажлын байранд нээлттэй ажлын байранд ажиллаад эхэлж байгаа. Тэгээд тэр хүмүүсийг анх ингээд ажилд ингээд оруулаад явахад бол эхлээд ингээд ажлын хамт олны хандлага одоо яах бол, энэ чадах болов уу энэ тэр гэсэн ажигласан болгоомжилсон, за хөөрхий одоо яана даа энэ тэр гэсэн байдалтай ханддаг бол тодорхой хугацааны дараа ажиллаад ирэхээр өө бид нартай адилхан юм байна гэдгийг нь мэдээд бүр сүүлдээ бахархах, өө та нар чинь ёстой мундаг юм байна шүү дээ, өө ёстой хийчихдэг юм байна шүү дээ, за тэгвэл дараагийн хүнийг авч болох юм уу ч гэдэг юм уу.

Тэгэхээр яг өөрөө өөрсдөө дунд нь орно гэдэг бол хамгийн том нөлөөллийн ажил, ойлголт нэмэгдүүлэх. Үүнтэй уялдуулаад хэлэхэд энэ хүмүүсийг нийгэмд ингэж гаргах, сургуульд сургах, ажилд оруулах тал дээр нь нөгөө нийгэм их бэлэн биш, тэгээд хамгийн том саад нь бас би юу гэж хардаг вэ гэхээр нөгөө өрх бүл, гэр бүлийн гишүүд гэж хардаг байхгүй юу. Одоо жишээлэх юм бол хараагүй хүүхдээ байлаа гэхэд бөөцийлчихнэ одоо бүх юмыг нь урдуур нь орж хийгээд л. За тэгээд л одоо сургаад яах вэ, одоо тийм хүмүүс байдаг юм,

манай дээр ингээд л бүр хорь гарчихсан сургуульд сураагүй хүмүүс ирчихээд л манайх чинь дэргэддээ нөгөө МСҮТ-тэй. МСҮТ-д чинь бид нар нас харгалзахгүй авна л даа. Тэгэхээр сургуульд сураагүй хүмүүс ирнэ. Зарим нь баруун зүг чигээ ч мэдэхгүй зүгээр гэртээ ингээд л одоо хоолоо идээд л, FM-ээ сонсоод л, телевизороо үзээд л сууж байдаг. Тэгээд л ингээд л тиймэрхүү тохиолдлууд маш их байдаг л даа. Гэрт нь хадгалчихсан, маш их хайрладаг, бөөцийлчихсөн. Тэр нь маань эргээд нөгөө хүмүүс чинь нийгэмд орж чадахгүй, тэгээд нөгөө хүмүүс маань нөгөө нийгмийн ойлголтыг нэмэгдүүлэх ёстой хүн гэртээ байгаад байгаа болохоор тэгээд л хүмүүс байдаггүй юм байна гэсэн ойлголттой. Тэгээд үүнтэй нэг жишээ хэлж байсан юм. Нэг Австрали яваад ирсэн нэг хүн өө Австрали явсан чинь гудамжаар нь маш их хөгжлийн бэрхшээлтэй хүн явдаг юм байна лээ шүү дээ. Тэргэнцэртэй хүмүүс нохойгоо дагуулсан таягаа барьчихсан хараагүй хүмүүс тэгээд л ингээд л нөгөө дохионы орчуулга хийгээд л утсаа бариад л. Ингээд л замдаа дохиод л. Үгүй ээ тэгээд л энэ тэнд нөгөө даунтай хүмүүс маш их явдаг юм байна лээ шүү дээ. Харин манай Монголд чинь хөгжлийн бэрхшээлтэй хүн цөөхөн байдаг юм биш үү? Нэг их харагддаггүй шүү дээ гэж байгаа байхгүй юу.

Тэнд нөгөө нийгмийн хүртээмжтэй болчихсон хүмүүсийнх нь хандлага нь зөв болчихсон болохоор хүн болгон нийгэмдээ оролцоод яваад байгаа байхгүй юу. Бид нар нөгөө хүртээмжгүй гэдгээсээ ч юм уу, өөрсдөө нөгөө гарах зориггүй ч гэдэг юм уу гэрийнх нь хэт бөөцийлдөг болохоор нийгэмд нэг их маш ховор гардаг. Тэгэхлээр бид нарыг чинь маш цөөхүүлхнээ гэж хараад байдаг. Гэтэл бол үгүй байхгүй юу. Ерөөсөө Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас нийт хүн амын чинь 15 хувь нь бол тодорхой хэмжээний бэрхшээлтэй хүмүүс байна аа гэж ерөнхийдөө үзэж байгаа. Манайд бол яах вэ 4 орчим хувь гэдэг л дээ. Гэхдээ л одоо харааны бэрхшээлтэй 11900 шүү дээ, манай Монголд. Тэгэхээр энэ бүх хүмүүс ингээд гараад одоо дөнгөж л 300-400 нь л ажил хийж байна гэсэн үг шүү дээ. 200 нь сургуульд сурч байна. Тэгэхээр бусад нь хаана байгаа юм. Бусад нь бол



тэгээд л гэр гэртээ л байж байгаа байхгүй юу. Тэгэхлээр л одоо энэ ээж аавуудын ойлголтыг сайжруулахын тулд бас яг ийм нэвтрүүлэг, одоо энэ сайн жишээ, хаана ямар боломж байгаа тухай ингээд сайн ээж аавд нь хүргэх юм бол өө сурч болдог гэж байна шүү дээ гээд л ээж аавууд нь хүүхдээ дагуулаад ирэх жишээтэй. Тийм ном байдаг гэж байна шүү дээ гээд л тэрний хойноос гүйгээд ирэх жишээтэй гээд л. Тэгээд л дамжаад л явдаг гэж ойлгодог шүү дээ.

Тэгвэл танай нөгөө МСҮТ дээр ер нь ямар төрлийн мэргэжлээр боловсрол олгодог вэ?

Тийм манай МСҮТ-д бол ерөнхийдөө Монгол улсад бол 80 орчим мэргэжлийн сургалтүйлдвэрлэлийн төв байдаг гэсэн тоо баримт байдаг. Тэгээд яагаад бид нар энэ МСҮТ-ийг байгуулахаар болсон бэ гэхлээр мэдээж хэрэг ерөөсөө дэлхий нийтийн чиг хандлага өөрөө ингээд тусгаарлах, тусгай МСҮТ, тусгай сургууль энэ тэр гэдгийг бол дэмждэггүй. Гэтэл Монголын нөхцөл маань юу болсон бэ гэхээр эдгээр МСҮТ-д харааны бэрхшээлтэй хүмүүст мэргэжлийн боловсрол олгох нэгдүгээрт орчин байгаагүй, хоёрдугаарт энэ хүмүүст бас нэг мэргэжил мэргэжлийн дундаас нэг бас нөгөө онцлог чадвар, чадавхид нь нийцсэн нэг мэргэжил гэж байгаа шүү дээ. Яг тэрийг нь эхний ээлжинд бий болгож дэмжиж ажлын байртай бий болгох, дэмжих шаардлага байдаг. Гэтэл яг бусад ердийн МСҮТ-д яг хараагүй хүмүүс сураад амжилттай сурчихаар тийм анги, мэргэжлийн чиглэл байгаагүй. Тийм байгаа болохоор манай холбоо 2015 онд Мэргэжлийн боловсролын сургалтын төв байгуулж байсан. Тэгээд өнөөдөр төвд маань хараагүй хүмүүст зориулаад бариа заслын мэргэжил олгодог. Тэгэхээр бариа заслаа дотор нь хоёр авч үздэг. Нэгдүгээрт нь эмчилгээний бариа заслын үйлчилгээ үзүүлэх бариа засалч, хоёрдугаарт алжаал тайлах гээд. Эмчилгээ гэдэг нь бол яг одоо эмчийн удирдлага доор хүмүүст цэг суваг дээр нь бариа заслын үйлчилгээ хийх, эмчлэх чиглэлээр илүү мэргэшсэн хүмүүс гэж ойлгож болно. Одоо эмнэлэг, эрүүл мэнд, сувиллын газар дээр эмчийн удирдлага дээр ажиллах боломжтой хүмүүсийг бэлдэж байгаа гэсэн үг. Нөгөө алжаал тайлах гэдэг нь бол одоо гадуур байгаа нөгөө төвүүдэд ихэвчлэн байдаг. Одоо янз бүрийн зангирсан булчин шөрмөс эд нарыг нь тайвшруулж алжаалыг нь тайлдаг. За гурав дахь чиглэл нь бол хүртээмжит технологийн мэргэжилтэн бэлтгэдэг ангитай. За хүртээмжит технологийн мэргэжил гэхээр өнөөдөр маш олон зүйл нөгөө мэдээллийн технологи дээр үндэслээд явагдаж байдаг. За нэгдүгээрт тэр нь, хоёрдугаарт хараагүй хүмүүс өөрсдөө нийгмийн харилцаанд ингээд бүрэн дүүрэн орохын тулд бид нар маш их туслах хэрэгсэл, технологи ашигладаг. Өөрөөр хэлэх юм бол миний компьютер дэлгэц уншигч программтай. Одоо миний гар утас айфон хэрэглэдэг, энэ болбол дэлгэц унших программтай ч гэдэг юм уу, би дэсиг тоглуулагч гэж хэрэглэдэг. Энэ бол ном уншдаг, бичлэг хийдэг төхөөрөмж гэсэн үг. Бүх функц

бүх одоо ямар л товч дарна тэрийгээ ярьж өгдөг, одоо ном уншлаа гэхэд ярьдаг ном унших юм бол одоо хэдэн минутын бичлэг байна, тэр хаана зогссон байна тэр газраасаа үргэлжлүүлдэг ном уншингаа одоо хэрэгтэй зүйл дээр нь тэмдэглэл хийдэг ч гэдэг юм уу, яг хараагүй хүмүүст зориулаад бүтээчихсэн. За тэгээд нөгөө барель хэрэгслүүд байна, брайль компьютер, брайль дэлгэц гээд энэ олон туслах хэрэгслүүдийг ашигладаг. Дээрээс нь энэ мэдээллийн технологийн чиглэлээр гарч байгаа бүх бараа бүтээгдэхүүнийг яаж хүртээмжтэй болгох вэ гэдгийг одоо ур чадварыг олгодог ийм анги гэсэн үг. Одоо вэб сайтыг хүртэл хүртээмжтэй болгоход ямар стандартын дагуу хийх вэ гэдгийг манай оюутан сурдаг гэсэн үг. За тэгээд дөрөвдүгээрт нь бол нөгөө урлагийн чиглэлээр морин хуур, хөөмийний чиглэлээр, тэгээд даралтат хөгжмийн чиглэлээр хараагүй хүмүүс бол урлагийн чиглэлээрээ маш их авьяастай. За дараагийн анги нь кофе бариста бэлтгэгч ангидаа аа энэ нь болбол нөгөө сул хараатай иргэдэд баристагийн мэргэжил олгодог.

Хараагүй хүмүүс гэхээр дотроо бас бүрэн хараагүй байхаас гадна нөгөө сул хардаг хүмүүс хамрагдаж байдаг. Сул хардаг хүмүүс харахад ингээд ганцаараа яваад байгаа юм шиг мөртөө бас нөгөө захын хараа, одоо голын хараа нь байхгүй ч гэдэг юм уу, эс үгүй бол бүдэг хардаг энэ тэр гээд л маш олон төрлийн юм байдаг л даа. Тэгэхлээр тэр хүмүүсийг яг бариста чиглэлээр бэлтгэдэг. Тэгэхээр тухайн кофе, халуун хүйтэн ундааг одоо ямар дэс дараалалтай, яаж аюулгүйгээр бэлтгэх вэ гэдгийг одоо маш олон давтамжтайгаар сургаж бэлтгэдэг. За дараагийн сүүлийн анги нь бол эсгий гар урлал, бэлэг дурсгалын зүйл гэдэг ийм анги байгаа. Тэгээд 2015 оноос хойш МСҮТ гэдэг статустайгаар үйл ажиллагаа явуулж байгаа. Тэгээд хот хөдөөний хаанаас ч харааны бэрхшээлтэй хүн бол ирж суралцах боломжтой. Бид мэргэжил, нас, хүйс ялгахгүй, суръя гэсэн хүсэл эрмэлзэлтэй хэнийг ч сургадаг. Одоо манай туршлагаас харахад 73 настай нэг харааны бэрхшээлтэй хүн төгсөөд одоо маш амжилттай нутагтаа бол ингээд бариа заслын ажил хийгээд явж байгаа кэйс байдаг. Тэгээд сая өнгөрсөн онд манай МСҮТ-ийн үйл ажиллагааг яамнаас үнэлсэн л дээ. Ер нь 2015 оноос хойш хэчнээн хүн сургачихав, хэдэн хувийн хөдөлмөр эрхлэлтэй байна энэ тэр гээд тэгсэн. Ерөнхийдөө бас маш амжилттай. Ялангуяа нөгөө бариа заслын чиглэлээр сурч байгаа хүмүүс бол ер нь 100 хувь гэхэд бол болно. Тодорхой л шалтгааны улмаас тэр мэргэжлээрээ ажиллаж чадахгүйгээс бусад тохиолдолд ажиллая гэсэн хүн болгонд л боломж нь нээгдчихсэн. За тэгээд энэ хүртээмжит технологийн анги ч гэдэг юм уу, энэ бариста эд нар бол ер нь ажлын байртай болох боломж нь өндөр. Урлагийн чиглэлээр бол бас нөгөө тодорхой хэмжээнд өөрсдийгөө энэ чиглэлээр ингээд хувиараа хөдөлмөр эрхлээд явж байгаа. Тэгэхээр ер нь маш дажгүй байна гэсэн үнэлэлтийг өгсөн байгаа манай МСҮТ-д. Тэгээд нэг зүйлийг хэлэхэд МСҮТ-ийн маань нэг онцлогийг хэлэх юм бол зөвхөн харааны бэрхшээлтэй

хүмүүс мэргэжлийн боловсрол олгоод зогсохгүй энэ хүмүүсийг нийгэмших хараагүйн улмаас алдагдсан болон чадварыг нь буцааж сэргээх, тодорхой хэмжээнд нөхөн сэргээхэд бол бас яг гол хувь нэмэр оруулдаг. Өөрөөр хэлэх юм бол манай дээр ирээд хүмүүс таягны сургалтад хамрагддаг, брайль бичгийн сургалтад хамрагддаг, туслах технологи яаж ашиглах вэ гэдэг сургалтад хамрагддаг. Тэгээд одоо хүмүүстэй яаж харьцах вэ энэ тэр гэдгийг хүртэл хамруулдаг. Яагаад гэвэл манай сургалтын төвд сургуульд сураагүй, гэрээсээ ч өөр газар явж үзээгүй хүмүүс бас ирэх нь нэлээн түгээмэл байдаг. Тэгээд л манай сургалтыг төгсөөд л одоо нийгэмдээ бүрэн дүүрэн оролцоод л явчихдаг.

Ер нь 2015 оноос хойш үйл ажиллагаагаа явуулахдаа одоогийн байдлаар нийт хэдэн төгсөгч гаргачихсан байгаа вэ?

За байз 380 гаруй хүнийг сургаж төгсгөсөн. Энэ дээр зүгээр хэлэхэд түрүүн хэлсэн тусгайлсан юмыг бол нэг их дэмждэггүй гээд. Бас хүмүүс сонсоод гайхаж магадгүй. Яагаад тусгай МСҮТ гэж байгаа юм бэ гээд. Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа 80 гаруй МСҮТ-үүд маань харааны бэрхшээлтэй хүнд нэгдүгээрт тохирсон мэргэжлээр анги нь хязгаарлагдмал, хоёрдугаарт хүртээмж муутай. Одоо бид нарт зориулсан брайль ном байна уу, багш нь бид нарт заах арга зөв мэдэж байна уу гэхээр нэг их тийм орчин байдаггүй. Тийм байгаа болохоор бид





нар энэ тусгай мэргэжлийн боловсрол сургалтын төвийг зөвхөн хараагүй иргэдэд гээд байгуулсан. Магадгүй энэ 80 МСҮТ-д маань хүртээмжтэй болоод бас тэгээд хараагүй хүмүүст зориулсан бас анги энэ тэр нээчих юм бол яг ингэж тусгаарласан байгаад байх шаардлага бол байхгүй гэж үзэж байгаа. Хэрэгцээгээ дагаад л ингээд байгуулсан гэсэн үг.

Ерөнхийдөө танай холбоо маш олон чиглэлд үйл ажиллагаа явуулдаг гэж сая ярьж байна. Тэгээд энэхүү үйл ажиллагаа явуулахад санхүүжилтээ ерөнхийдөө та хэд хаанаас босгодог вэ? Санхүүгийн хүндрэл хэр их учирдаг вэ?

Тийм. Мэдээж хэрэг санхүү бол маш чухал, төрийн бус байгууллага болохоор нэгдүгээрт яг тийм тогтмол орлого, одоо төсөв суулгаад гэсэн юм байдаггүй. Яг нөгөө бизнесийн чиглэлийн биш болохоор бас тогтмол орлого бол байхгүй. Гэхдээ манай дэргэд "Бэст массаж" нэг, гурав гэсэн хоёр төв ажилладаг. Хоёр төв маань нийлээд гучаад ажилчидтай. Хориод нь бол яг бариач нар байдаг. За анхны төвүүдийг 2007 онд байгуулж байсан юм. Тэгэхдээ зүгээр нөгөө МСҮТ маань 2015 онд байгуулагдсан ч гэсэн суурь нь болбол бид бариа заслын сургалтыг бол бүр 2005 оноос эхэлж байсан л даа. Анх зургаан хүнд сургалт эхлүүлж байсан япончуудтай хамтраад. Тэгээд бид нар сургалтаа амжилттай дүүргэсэн хүмүүс 2007 онд анхны массажийн төвийг холбооноос байгуулж байсан. За анх мэдээж байгууллагад монголчууд бол хараагүй хүмүүсээр бариа заслын үйлчилгээ, бариа хийлгэнэ гэсэн ойлголт тун хомс, байгуулагдаад их алдагдалтай байсан. Эхний гурван жил бол бид нөгөө бусад улс орны туршлагыг хараад энэ амжилтад хүрнэ гэж итгэж байсан учраас тэгээд алдагдлаа нөхөөд аваад явж байсан. Тэгээд дараагийн хэдэн жил нэг балансалдаг болсон. Одоо бол төвүүд маань тодорхой хэмжээнд бас ашиг олоод холбоогоо дэмжинэ.За хоёрдугаарт нь манайх эф эм-тэй. Эф эм маань ч гэсэн бас тодорхой зарим үйлчилгээг дэмжлэг болгодог. За манай дэргэд цэцэрлэг байдаг, МСҮТ байдаг гэсэн. За эд нар маань бол бага хэмжээгээр зарим зардлаа төрөөс авдаг. Тэгээд төрийн зарим чиг үүргийг бид нар гүйцэтгэж байна гэж ойлгодог. Өөрөөр хэлэх юм бол хараагүй хүнд мэргэжлийн боловсрол олгож байна гэдэг. Тэгэхээр хараагүй оюутнуудынхаа тоон дээр үндэслээд хувьсах зардал авдаг. Цэцэрлэг дээр ч гэсэн тэнд суралцаж байгаа хүүхдүүдийнхээ тоон дээр үндэслээд авдаг. Гэхдээ энэ бол хаанаа ч хүрэлцдэггүй. Энэ хоёр байгууллага одоо хувьсах зардал гэдэг маань өөрөө 2013 онд батлагдаж байсан жишиг үнийн дагуу хувьсах зардлаа авдаг. За хаанаа ч хүрдэггүй.

Тэгээд өнөөдөр 2021 он. Одоо энэ хооронд чинь нөгөө бараа бүтээгдэхүүний үнэ юу боллоо, цалин хэчнээн хувь нэмэгдлээ, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ одоо хэд болчихсон байгаа билээ гээд бодох юм болбол яг тэр 2013оныхоо тэр жишиг үнийг хөдөлгөхгүй байгаа л даа. Тэгэхээр

энэ ер нь хаанаа ч хүрэхгүй. Гэхдээ бид мөнгө байхгүй гээд зогсох эрхгүй. Энэ бол яг тогтмол орлогууд нь гэсэн үг. Үүн дээрээс нь нэмэгдээд бид мэдээж хэрэг нөгөө төсөл хөтөлбөр, хандив тусламж дээр нэлээн үндэслэж үйл ажиллагаагаа явуулдаг. Одоо ингээд л түрүүн ярисан шүү дээ. Нөгөө баристагийн ангитай гээд л. Анх баристагийнхаа ангийг нээхлээ жишээлэх юм бол Солонгосын хараагүйчүүдийн "Шилам" гээд байгууллагатай хамтраад л КОЙКО-оос дэмжлэг авааД л тэгээд л яг анги танхим бүх зүйл, багш эд нарыгаа бэлтгээд сургаад баазаа бэлдэж байсан жишээтэй. Одоо цэцэрлэг гэхэд чинь яг цэцэрлэг байгуулъя гэж төсвөөс улсаас дэмжихгүй шүү дээ. Бид өөрсдөө төслөө бичиж байгаад тэгээд Тайваниас бас ингээд сайн санаатай хүмүүсээс цэцэрлэг байгуулах үндсэн дэмжлэгийг минь өгөөд тэгээд бид нар төрийнхөнд за харж байна уу, МСҮТ ингээд ажиллаад болж байна. За ингээд цэцэрлэг байгуулаад ингээд ажиллаад болж байна, одоо тэгвэл та нар ингээд хувьсах зардлаа өгөөч ээ гэдэг. Ерөнхийдөө Монголын нөхцөлд бол эхлээд хэлээд бол ойлгохгүй, харуулж байгаад энэ болж байна, одоо та нар эхлэлийг тавьчихсан, та нар одоо цаашаа аваад явахад гээд л ингээд явдаг. Тэгээд л санхүүжилтээ бол шийдэж байгаа ихэнх нь болбол ерөнхийдөө төсөл хөтөлбөрөөр л явж байна даа.

Ийнхүү төсөл хөрөг хөтөлбөрт ингээд одоо төсөл бичээд ингээд явуулахад мэдээж хүний нөөц шаардлагатай юм байх. Танай холбооны хувьд ер нь хүний нөөцөө яаж бэлдэж байна? Тэгээд бусад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоодуудаас танайхаас үлгэр дуурайл авбал. Танайх бол яагаад гэх юм бол маш олон чиглэлд үйл ажиллагаа явуулдаг юм байна. Тэгээд ерөнхийдөө та хэд энэ нөү хау(know how)-аа бас хуваалцахгүй юу?

Ер нь манай хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөө үйл ажиллагаа явуулдаг статистикаар бол 500-600 гэж ярьдаг юм гэсэн. Зарим нь 300 гэсэн. Гэхдээ одоо янз бүрийн хурал цуглаан дээр ирсэн байгууллагуудын төлөөлөл хэлэхээр 80-аад байгууллагууд ирлээ л гэдэг юм. Тэгэхдээ бид нарын мэдэхээр бол 20-30 яг нүдэнд харагдахуйцаар үйл ажиллагаа явуулдаг байгууллага байдаг гэж боддог. Яг ингээд тогтмол гэсэн үг шүү дээ. Тэгээд тэд нар маань ч гэсэн яг л бид нарын жишгээр өөрсдийнхөө үйл ажиллагааг төсөл хөтөлбөрүүдээ л янз бүрийн эх үүсвэрүүдээр санхүүжүүлдэг. Бид нарын хувьд бол мэдээж хэрэг төсөл бичнэ гэдэг амархан зүйл биш. Дотооддоо ч, гадааддаа ч өгнө. За тэгээд төсөл бичнэ гэдэг чинь өөрөө хөрөнгө босгох үйл ажиллагааны нэг хэлбэр шүү дээ. Тэгэхээр нөгөө ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлнэ. Олон улсын арга хэмжээнд явж байхдаа бас нөгөө зөв хүмүүсээ олж хамтын ажиллагааг өрнүүлнэ. За тэгээд хамтын ажиллагаа амжилттай өрнүүлэхийн нэг нууц нь юу вэ гэхээр бид нар анхны удаа бага хэмжээний санхүүжилт авлаа гэхэд маш их хариуцлагатай, үнэнч

шударга байх ёстой. Тэгээд яг нөгөө анхны хийсэн санхүүжилтээрээ бид нар бодитой ажил болгочихсон гэдгээ ингээд нөгөө доноруудтай нөгөө хүмүүстээ мэдэгдэхээр хийсэн ажлыг маань хараад урамшаад ингээд үргэлжлүүлээд дэмжээд явах нь олонтаа байдаг. Тийм байгаа болохоор мэдээж хэрэг төсөл бичихэд тухайн тухайн байгууллагаас гаргасан шалгуур, шаардлагын дагуу төслөө бичнэ, монголоор ч бичнэ, англиар бичнэ. За тэгээд нөгөө хэрэгжүүлэх гэдэг бол маш чухал.

Ерөнхийдөө манай холбоо болбол өөрөө маш хатуу, одоо хяналттай нэг гишүүддээ үйлчилдэг болохоор тийм байгаа болохоор яг л одоо зориулалтын гол зориулалтаар л зарцуулагдаад, хамгийн гол нь нөгөө тухайн хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүдээс хараагүй хүмүүс үр шимийг хүртэж, тэдний амьдрал, тэд нарын хөгжилд одоо тодорхой хувь нэмэр орсон байх ёстой байдаг. Тэгэхлээр нөгөө донорууд ирэхэд яах аргагүй энэ МСҮТ-д ингээд сурч байна, энэ хүүхэд цэцэрлэгт ингээд явж байна, энэ ном хэвлээд, ингээд энэ хүн уншиж байна, энэ дээд сургуульд сурч байгаа хүнд энэ компьютер ингээд зээлээр үйлчилгээ үзүүлж байна гээд л ингээд ингээд хараад тэрний үр дүнд одоо энэ хүүхэд ингээд ердийн сургуульд орчихлоо, энэ хүүхэд ингээд ажилтай болчихлоо гэхээр тэгээд тэрэн дээрээ үндэслээд хамтарч байгаа байгууллагууд маань нэг ажил эхэлсэн бол ингээд үргэлжлүүлээд явах нь их байдаг. Тийм болохоор жишээлэх юм бол одоо бид нар дээд боловсролын төсөл хэрэгжүүлдэг 2017 онд эхэлж байсан. Одоо бид өргөжүүлээд явж байгаа. Яагаад гэвэл үр дүн нь харагдаж байна. Тийм болохоор нөгөө донор нь ингээд дэмжээд явдаг ч гэдэг юм уу. Одоо жишээлэх юм бол бид нар нэг байгууллагатай хамтраад л хоёр удаа төсөл хэрэгжүүлсэн. Одоо бид бас гурав дахь удаагийнхаа төслийг хэрэгжүүлье гээд л ярьж байх жишээтэй. Тэгэхлээр хоёр асуудал яригдана. Мэдээж хүний нөөц, хүний нөөц гэх юм болбол аа яг энэ төсөл бичих, хөрөнгө босгох, энэ талаар жаахан мэдлэгтэй хүн байх ёстой. Бид нар бол ер нь манай холбооны нөгөө 87 ажилчидтай гэдгийн бараг 63 нь харааны бэрхшээлтэй хүмүүс байгаа. Тэгээд мэдээж хэрэг бид нар чинь дан өөрсдөө ажиллахгүй, бид нарыг бас тусалж дэмждэг. Одоо бид нар хийж чадахгүй юмыг бас хийдэг, барьдаг тийм хараатай хамт олон, ажилчид байдаг. Тэгэхлээр тэр хүмүүстээ нөгөө төсөл бичих талаар цаг үргэлж одоо хөгжүүлэх, эхлээд алдсан бол алдаан дээрээсээ суралцах, тэгээд л ер нь байгууллага авч явна гэдэг бол маш олон талын цогц үйл ажиллагаа амжилттай хэрэгжсэний үр дүн гэж боддог. Төсөл авна, тэрийгээ амжилттай хэрэгжүүлнэ, нөгөө коммуникэйшнтэй тэр хүмүүстэй яаж хамтран ажиллах вэ? яаж харилцах вэ? гэдэг чинь бас нэг дараагийн хүмүүс байх шаардлагатай, одоо чадвар болоод л явчихдаг ч гэдэг юм уу, багаар ажиллах ч гэдэг юм уу тэр хариуцлага гээд л янз бүрийн юмнууд дээр чинь хамт олон л болсон хойно. Тэгэхээр тэр эд нарыгаа бол бид нар

ингээд ажилчдаа гишүүдээ ерөнхийдөө сургалтуудад нэлээн хамруулахыг хичээдэг. За тэгээд ерөнхийдөө бол сүүлийн үед хараагүй хүмүүс маань ч гэсэн ийшээ тийшээ сургуульд явах мэргэжил эд нар эзэмших боломжууд нэлээн гарчихсан байгаа болохоор тэр хүмүүсээ бусад хамт олныхоо дунд авах, за тэгээд гурав дахь нь бол нөгөө сайн дурынхантай бусад хүмүүстэй хамтрах. Сайн дурын ажил хийдэг хүмүүс бас нэлээн байгаа шүү дээ. Ер нь бол тэр хүмүүстэй хамтрах, за тэгээд өнөөдөр донор биш байж болно, гэхдээ өнөөдөр ингээд тусалчихъя гэсэн тийм хүмүүстэй ингээд сайхан хамтраад манай байгууллагыг мэддэг болчихвол магадгүй нэг хоёр жилийн дараа үгүй ээ тийм тийм боломж байна лээ шүү дээ танайх чинь ингэдэг биз дээ, танайх ийшээ явбал яасан юм тэр гээд өөрсдөө санал тавиад л хүрээд ирдэг байхгүй юу. Тэгэхлээр хамгийн гол нь маш шударгаар өөрсдийнхөө үйл ажиллагааг хүмүүст таниулах үр дүнг нь ойлгуулаад явж байтал тэгээд л ерөнхийдөө болдог. Гэхдээ мэдээж хэрэг бид нар дахиад олон үйл ажиллагааг хиймээр байгаа юм. Гэхдээ нөгөө хөрөнгө мөнгө санхүүгийн дутагдалтай байдлаас болоод одоо жишээлэх юм бол хийж чадахгүй тийм ажлууд бол бас нэлээн байгаа л даа. Тэгэхлээр тэгээд л ямар ч байсан зогсолтгүй л явж байна.

Танай холбооны дэргэд одоо үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд байдаг. Тэгээд одоо ер нь цар тахал нь



одоо ковид цар тахал одоо эдийн засагт маш хүндээр нөлөөлж байгаа шүү дээ. Тэгэхээр танай байгууллагууд болон танай холбоонд, хараагүй иргэдэд ер нь энэ ковид цар тахлын нөлөө хэр их хүнд тусаж байна?

Ер нь маш хүнд тусаж байгаа. Жишээлэх юм бол анх ингээд л нөгөө ковид гараад л аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа яагаад одоо манай массажийн төвүүд хаагдсан. За манай холбооны дэргэд гэхгүй манай хараагүй хүмүүс ажилладаг 30-аад төв Монгол улсад ажилладаг л даа. Нэг төвд доод тал нь хоёр дээд тал нь арваад хүн ажилладаг. Гэтэл тэр төвүүдийн маань ихэнх нь байр түрээсэлж ажилладаг байгаа. Гэтэл одоо шууд ингээд л зогсоосон шүү дээ, үсчин, маасажны төв гээд л. Тэгэхэд тэд нар орлогогүй болохын зэрэгцээгээр түрээсийн дарамтад ордог ч гэдэг юм уу. Нөгөө орлогогүй хүмүүс чинь түрээсээ төлөхөд хэцүү ч гэдэг юм уу. За тэгээд нөгөө хүүхдүүд ингээд нөгөө хичээл хаагдаад эхэлсэн онлайнаар сургалтууд явж эхэлсэн. Гэтэл нөгөө онлайн цахим маань өөрсдөө хүртээмжгүй болоод эхэлсэн чинь нөгөө хүүхдүүд маань оюутнууд маань хичээлээ бүрэн дүүрэн авч чадахгүй хоцрох, за тэгээд бүр нөгөө сургуулийн хүүхдүүд бол бүр нэг хэсэг бүр маш өндөр хоцрогдолтой явж байгаа шүү дээ. За тэгээд нөгөө хөдөө орон нутаг руугаа буцаад явчихдаг, тэгээд багш нар нь бас төдийлөн холбогдож чадахгүй байдаг ч гэдэг юм уу. За тэгээд бас нэг асуудал



нь нөгөө ковидийн тэр нөхцөл байдал гээд гэртээ байлаа. За хардаг хүмүүс чинь номоо уншаад л телевизээ үзээд гээд бодъё л доо. Гэтэл нөгөө хараагүй бас бид нарт ямар тохиолдол гарч байсан бэ гэхээр хараагүй хүмүүст зориулсан хүртээмжтэй ном Монголд маань маш хязгаарлагдмал цөөхөн байдаг. Ингээд бүр маш зүрх өвтгөсөн юм нь хоёрхон номтой хүүхэд нөгөө номоо л ээлжилж уншдаг. Тэгээд л ингээд л ерөөсөө нөгөө брайль номоо ингээд л элэгдтэл нөгөө номоо л уншаад бүр цээжилчихсэн. Ингээд энийг сонсоход ч гэсэн надад харамсалтай санагдаж байсан. Гэтэл ингээд хардаг хүмүүс дуртай номоо аваад л уншиж байгаа шүү дээ. Тэгтэл тэр хүүхэд жишээлэх юм бол тэгээд л нөгөө хичээл нь телевизороор явж байхад телевизийн хичээл маань өөрсдөө нөгөө хараагүй хүүхдэд хүртээмжгүй за энийг харж байна уу хүүхдүүдээ гэчихдэг гээд л. Юу яриад байгааг нь мэдэхгүй, зарим одоо хүмүүс гэртээ телевизоргүй ч үгүй хүмүүс явж байгаа байхгүй юу. Тэгээд мэдээлэл маш их ковидийн талаар мэдээллийг ард нийтэд зарлаж байсан шүү дээ эхлээд. Гэтэл тэр мэдээллээ авч чадахгүй. Гар утсанд та нарт ингээд л мессеж явуулчихдаг. Бид нар тэрнийг, би нөгөө ярьдаг программтай утастай гэж байгаа боловч одоо ийм айфон ашигладаг хүн бол хараагүйчүүдийн дунд цөөхөн байна л даа. Дөнгөж нэвтэрч орж ирж байгаа. Гэтэл ихэнх хүмүүс зүгээр одоо утас ашиглах гээд тэр мессежийг нь уншиж чадахгүй ч гэдэг юм уу маш олон товхимол юугаар тэрийг нь ашиглаж чадахгүй ч гэдэг юм уу телевизийнхээ юмыг л нэг алдаг оног барьдаг гээд л ерөнхийдөө ингээд асуудлууд бол гаргаж байсан. Бүр ингээд л дараагийн нэг ярихад ганц биеэрээ амьдардаг хараагүй хүмүүс, нөгөө орчин тойрны хүмүүс нь ирээд тусалдаг, дэлгүүр эд нэрээс юм авахад нь эмнэлэг явахад нь тусалдаг байсан бол ковидийн үеэр хөдөлгөөн хязгаарлагдсан шүү дээ. Тэгэхээр дэлгүүр лүүгээ орж чадахгүй тохиолдлууд гардаг ч гэдэг юм уу, эмнэлэг эрүүл мэндийн үйлчилгээ авч чадахгүй байх, хаашаа хандах нь ер нь ингээд л яг бодоод үзэх юм бол маш их бэрхшээлүүд гарсан. Одоо ч гэсэн бүрэн шийдэгдээгүй байгаа шүү дээ. Тэд нар маань тэгээд зүгээр бусад улс орнуудыг харахад ерөөсөө одоо ийм онцгой байдал, гамшиг нөхцөл байдал үүссэн үед хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудалд яаж хүний эрхэд суурилсан хандлагаар хариу үйлчилгээ үзүүлэх вэ гэдгийг бүр харуулсан тийм хөтөлбөртэй төлөвлөгөөтэй байгаа байхгүй юу. Шууд нөгөө гэрээр одоо юманд хүргэе.

За хөгжлийн бэрхшээлтэй иргэд янз бүрийн асуудал гарах юм бол ийм ийм утас руу, ингээд нөгөө тусгай дугаарын утас руу хэлээрэй, за худалдаж авах юм болбол гэрээр нь хүргээд өгчихье, тэр хүмүүст нь жишээлэх юм бол нөгөө дуут мессежийг явуулчихъя. Шууд тэр одоо янз бүрийн мэдээллүүдийг утсанд нь өгөхөөс гадна нөгөө нэг брайль ч гэдэг юм уу, ярьдгаар нь ч юм уу хийгээд хүргээд өгчихье энэ тэр гээд. Одоо сургалтын завсар хоцрохгүй байхын тулд одоо нөгөө видео хичээл хүргэе. Одоо гэрээр нөгөө ганцаарчилсан

байдлаар явуулын сургалтыг хийе ч гэдэг юм уу. Ингээд шийдчихсэн газрууд бол байгаа юм. Тэгээд Монголд бол тэр маань арай л төлөвшөөгүй л байна л даа, ярьж л байна. Тэгэхлээр энэ бол хувь хүнд ингэж нөлөөлсөн. Мэдээж байгууллагын хувьд болбол массажийн төв маань зогссон орлого маань багассан, цэцэрлэг маань бас зогссон. Гэхдээ зогссон ч гэсэн манай багш нар хүүхдүүдтэйгээ холбогдож бас утсаар нь ингээд ээжид нь зөвлөгөө өгч байсан. Төрөөс үзүүлэх дэмжлэг бол зогсоогүй МСҮТ-үүдийг бол бид нар нөгөө онлайнаар сургалт явуулж байсан. Бид нарын хувьд гол асуудал маань юу байсан бэ гэхлээр, нөгөө гишүүддээ бид нар чинь маш их биечилсэн сургалт, үйл ажиллагаа, цуглаан уулзалтуудыг зохион байгуулдаг байсан. Одоо ч сар болгоны сүүлийн долоо хоногийн тав дахь өдрийн хоёр цаг гэхэд бид нар манай гишүүд уулзаж бид нар тухайн сарынхаа үйл ажиллагааг тайлагнадаг гэдэг ч юм уу, одоо ингээд л манай зөвлөлүүд ингээд л уулздаг. Ер нь манай байраар ингээд маш олон хараагүй хүмүүс бужигнаж байдаг л даа. Гэтэл тэр үйл ажиллагаа нь нөгөө хязгаарлагдсан. Тэгэхлээр манай хараагүй хүмүүс чинь нөгөө мэдээллийн бүр хомсдолд ороод л уулзмаар байна, бие биетэйгээ яримаар байдаг, тэгсэн чинь тэр боломж нь байдаггүй ч гэдэг юм уу. Тиймэрхүү асуудлууд бол нэлээн гарч байсан. Бусдаар бол тэгээд л бусдын жишгээр цахимаар гэрээсээ ажиллаад л, ээлжилж ажиллаад л явж байна даа.

Ерөнхийдөө та сая боловсрол гээд бас дунд нь нэг цэцэрлэг сургууль гээд ярьсан. Тэгээд харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан ч юм уу, цэцэрлэг эс үгүй бол одоо энэ сургууль гэхэд ер нь улсын хэмжээнд Улаанбаатарт л байдаг шүү дээ. Тэгээд энэ хангамж хүртээмжтэй бус байдлыг байдлаас болоод ингээд олон хүмүүс ингээд боловсрол хүртэх эрх нь бас хязгаарлагдаж байна. Ингэж тэгээд боловсролгүй болохоор чинь тухайн хүн маань бас цаашид хөдөлмөр эрхлэх боломжгүй. Тэгээд энэ асуудлыг ер нь яаж шийдвэрлэх вэ? Одоо хөдөө орон нутгаас бас зарим харааны бэрхшээлтэй иргэд маань ирээд хотод байх боломжгүй хүмүүс бас зөндөө байдаг шүү дээ?

Тийм. Наадах чинь хамгийн чухал, ер нь бол тэгдэг шүү дээ. Боловсролыг яг авах цагт нь эзэмшээгүй аваагүй юм болбол буцаад хөдөлмөр эрхлэх гэдэг ярихад бол нэлээн хэцүү. Тэгээд л ер нь боловсролыг олгохгүй байна аа гэдэг нь л нөгөө цаашид халамжийг л дулдуйдаж амьдарсан хүмүүсийн тоо нэмэгдэнэ гэсэн үг шүү дээ. Тийм болохоор боловсрол маш чухал. Монгол улсад ганцхан тусгай сургууль байдаг хараагүй хүүхдийн. Тэгээд түрүүн би хэлсэн 1200 хүүхдээс 200 орчим нь л боловсролд хамрагдаж байна гээд. Маш олон хүүхэд сургуулийг нь гадна байна. Тэгээд энэ асуудлыг шийдэх зорилгоор манай холбоо бидний зүгээс сүүлийн хоёр жил нөгөө хараагүй хүүхдүүдийг ердийн сургуульд сургах Засгийн газрын хууль, дүрэм журам хөтөлбөрөөр бол одоо маш мундаг заалттай шүү дээ. Хөгжлийн

бэрхшээлтэй хүүхэд тэгш хамруулах боловсрол хамрагдана, сургуулиуд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хүлээж авч хүртээмжтэй орчин бүрдүүлнэ, ганцаарчилсан төлөвлөгөө боловсруулна, тохирох хэрэглэгслээр хангана, багшид нь тэдэн хувийн цалин нэмэлт болгоно энэ тэр гээд одоо хууль тогтоомжийг харах юм бол маш сайхан заалттай бараг болчихсон. Гэтэл тэр хуулиуд нь яг хэрэгжилт маш хангалтгүй. Тийм байгаа болохоор өнөөдөр хүүхдүүдийг ингээд сургуульд сургая аа гээд ингээд аваад очиход сургууль нь авахгүй гэдэг байсан. Саяхныг болтол өө одоо манайд хараагүй хүүхэдтэй ажилладаг багш байхгүй ээ. Наад хараагүй хүүхдийн чинь брайль бичихийг мэдэхгүй ээ гэдэг ч юм уу. Тэгж хэлээд авдаггүй байсан. Тэгээд яах вэ, нөгөө манайх чинь конвенцид сүүлийн үед, бас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын зүгээс бас нэлээн нөлөөлөл хийсний үр дүнд ямар ч байсан ав гэдэг асуудлыг тавьдаг болсон.

Гэхдээ их инээдтэй нь ав гээд байгаа мөртлөө нөгөө багш нартаа ямар ч сургалт явуулдаггүй нөгөө сургуульд нь хараагүй хүүхдийг очиход ямар ч орчин байхгүй байгаа шүү дээ. Ерөнхийдөө бол хүн зүгээр л ав гээд байгаа юм. За яах вэ тэгээд ав гэдэг дээр нь бид нар дөрөөлөөд тэгээд манай зарим эцэг эхчүүд бас юу гаргасан л даа. Өөрсдөө санал гаргаад одоо жишээлэх юм бол манай цэцэрлэгийг төгссөн одоо уржнангийн төгсөлтөөс гурван хүүхдийн нэг нь би ер нь хүүхдээ ердийн сургуульд өгмөөр байна. Миний хүүхэд бол бүрэн хараагүй, гэхдээ би тусгай сургуульд өгмөөргүй байна, одоо хууль нь байгаа юм чинь гээд. Тэгээд бид нар тэр хүүхдийгээ ердийн сургуульд оруулж байлаа. Тэгээд анх очиход нь бол бас л авахгүй гэсэн. Тэгэхдээ яах вэ одоо Боловсролын яам руу хууль дүрмээ ярьж байгаад л авсан. За тэгээд тэр хүүхэд чинь бол юу ч байхгүй байгаа шүү дээ. Сургалтын ном дэвтэр ч үгүй. Нөгөө брайлиар бичдэг самбар шивэр, нөгөө хатуу гадаргуутай брайль цаасан нь ч юм байдаг юм уу. Туслах багш юу ч байхгүй. Тэгээд холбоо бол тэр анхныхаа хүүхдийн туслах багшийг нь гаргаад бүх номыг нь хэвлэж өгөөд тэр самбар, шивүүр цаас, хараагүй хүүхдүүд юу л хэрэгтэй байдгийг бүгдийг нь бол бэлдэж өгч байсан. Тэгээд эхний жил манай хүүхэд амжилттай сурсан. Тэгээд тэр кэйс мэт жаахан бас хүмүүст хүрээд тэгээд дараа жил нь гэдэг чинь одоо ноднин нөгөө нэг хүүхэд маань найм болж нэмэгдсэн. Тэгсэн чинь бас их инээдтэй нь бид нар ингээд анхныхаа хүүхдийг нэгдүгээр ангид оруулчихлаа гэсэн чинь яг түүнтэй зэрэгцээд долоодугаар ангид хоёр нэг бүр хараагүй, нэг сул хараатай хүүхэд ердийн сургуульд 116-р сургуулиас шилжээд суралцаж байсан юм байна лээ. Тухайн үед бид нар мэдээгүй тэгэхдээ бид нар ингээд анхаарал тавиад эхэлсэн чинь яг хэрэгцээтэй хүмүүс маань бас бид нар дээр хүрч ирээд тэгээд одоогийн байдлаар найман хараагүй болон өндөр хэмжээний сул хараатай хүүхдүүд ердийн сургуульд сурч байгаа, сурсан. Өнгөрсөн хичээлийн жилд яг бид манай холбооны зүгээс таван хүүхдэд нь туслах багш гаргаж

өгөөд зарим хүүхдүүд нь одоо компьютер зээлдүүлэх ч гэдэг юм уу, ном сурах бичгийг нь тодорхой хэмжээгээр хэвлэж өгөх, багш нарт нь бас хараагүй хүүхэдтэй ажиллах арга зүйн талаар ингээд ярьж өгсөн ч гэдэг юм уу, хэлж ойлгуулсан энэ тэр гэсэн бас тийм зарим арга хэмжээнүүдийг авч ажилласан. Тэгээд ямар ч байсан найман хүүхэд маань ингээд л дэвшээд л суралцаад явж байгаа. Тэгэхлээр дандаа мэдээж хэрэг энэ туслах шиг бол бид нар гаргаж чадахгүй шүү дээ. Тэгээд дандаа бид нар брайль номыг хэвлэнэ гэж бол байхгүй.

Гэтэл манай Боловсролын яам одоо ингээд л хэлчихээд байгаа үнэн юм чинь. Одоо энэ хүүхдүүдийн номыг яагаад өгөхгүй байгаа юм? Тэр самбар шивүүр гэдэг чинь хараагүй хүүхдийн үзэг дэвтэр л байхгүй юу. Самбар гэдэг нь нөгөө брайль цаасаа хавчуулдаг хавтсанд шивүүр гэдэг нь үзэг нь гэсэн үг. Нөгөө цаасан дээрээ одоо нөгөө үсгээ товойлгож бичнэ гэсэн үг шүү дээ. Ийм юмыг нь бэлдэж өгөхгүйгээр одоо яаж сургана гээд байгаа юм бэ. Тэгээд одооноос бид нар Боловсролын яамандаа бас хэлээд л байгаа. Тэгээд энэ жилээс болбол бас дэмжинэ гэсэн юу бол хэлж байгаа. Тэрнээс биш одоо тэгээд л төрийн бус байгууллага яг иймэрхүү төрийн их үүргийг ингээд л нуруундаа үүрээд л явж байгаа. Тэгээд цаашаа гарч байгаа нэг зүйл нь юу вэ гэхээр одоо ингээд найман хүүхэдтэй явж байсан чинь одоо бас ахиад гурав дөрвөн хүүхэд бид



нарт хүсэлт тавиад бид нар одоо ингээд Өвөрхангайдаа орох нь, Баян-Өлгийдөө орох хүсэлтэй байна. Өмнөговьдоо ингээд яах вэ гэдэг асуудал яриад эхэлж байгаа байхгүй юу. Тэгээд энэ бол сайны жишээ. Энд тэнд ингээд хүн суръя аа гээд олноороо гараад ирэх юм бол одоо яах аргагүй энэ хүүхдүүдийн асуудлыг ярих хэрэг гарна шүү дээ. Тэгээд юм хийгээд эхлэхээр нь нөгөө ар араасаа ургаад гарчихдаг. Бид нар ингээд хүүхдүүдээ сургуульд оруулаад ингээд явсан чинь хараагүй хүүхдүүд нь математикийн хичээл яаж заах вэ, хэн физик яаж заах вэ гээд л асуудал гараад ирж байгаа байхгүй юу. Ерөөсөө нөгөө нэг сургуульд сурч байсан хүүхдүүдийн багш нар маань хараагүй хүүхдүүд математик заана гэдэг ойлголт байхгүй. За бараг зарим нь математик сурч чадах юм уу, заах хэрэгтэй юм уу гэдэг асуудал ярьж байгаа байхгүй юу. Тэгээд бид нар ингээд олон улсад судалсан чинь хараагүй хүүхдэд математикийг заадаг арга зүй нь аль хэдийн бий болчихсон. За тэр хичээлийг яаж заах вэ гэдэг ном нь байна. Бүр одоо тодорхой сэдвүүдийг яаж заах вэ гэдэг арга зүйг харуулсан видео хичээлүүд байх жишээтэй. Тэгээд бид нар тэгвэл одоо энэ математик заах талын юмыг бас багш нар хэлэх ёстой юм байна, энэ номыг орчуулах ёстой юм байна, энэ видеог орчуулж хүмүүст хүргэх ёстой юм байна гээд л явж байгаа. Боловсролын яам маань тэр нөгөө математикийн номын хэлэхэд бага хэмжээний дэмжлэг өгсөн. Одоо бид нар тэр номоо болбол орчуулж байгаа видеогоо ч гэсэн одоо 180 видео байгаа л даа. Тэгээд л энэ чинь англи хэлээр шүү дээ. Тэрийг орчуулах ёстой, видеон дээр нь нөгөө орчуулсан юмаа наах ёстой, дууг нь оруулах ёстой. Тэгээд үүнээс бол бид одоо нэг гучаадыг хийчихээд явж байгаа. Тэгээд ингээд л бие биеэсээ ургаад л гардаг юм байна лээ. Тэгээд энэ зүйлийг хэлэхэд бол бид нар бас нөгөө нэг Нээлттэй нийгэм форумтай хамтраад яг хараагүй хүүхдүүдэд хичээл заахад ямар арга зүйгээр явдаг юм, брайль бичиг яаж заадаг юм, за тэгээд сургуулийн орчинг яаж бүрдүүлэх юм энэ тэр гээд бас жижиг хэмжээний төсөл хэрэгжүүлээд явж байгаа. Тэгэхлээр гэх мэтээр ингээд нөгөө тал талаасаа хамтраад ажиллахаар бас ингээд нөгөө хийе гэж бодох юм бол арга мундахгүй гэдэг шиг ингээд бас боломжууд гарч байгаа. Тэгээд хэрэгцээ ч байна. Бага багаас нь тэгээд л явуулж байгаа л даа. Тэгээд ерөнхийдөө бол саяын жишгээр эцэг эхчүүд нь өөрсдөө миний хүүхэд ердийн сургуульд сурч болдог юм байна гэдгийг ойлгож аваад өөрсдөө нөгөө эрхээ мэддэг эрхээ нэхдэг эрхээ шаарддаг. За энэ дээр нь бид нар дэмжлэг үзүүлээд ингээд хаа хаанаа дор бүрнээ өөрсдөө ингээд хүчээ нэгтгээд явах юм бол өөрчлөлт хийхэд бас боломжийн гэж харж байгаа юм. Тэгэхгүй тэгвэл нээлттэй юу гэдэг юм, тэгш хамруулах сургалт Монгол улс хүлээн зөвшөөрчихсөн гээд байдаг. Нөгөө ямар ч хүүхэд одоо хараагүй хүүхэд би сургуульд суръя гээд очихгүй бол тэр сургууль хээ ч хараагүй хүүхдэд хүртээмжтэй болохгүй л байхгүй юу. Тэгэхлээр л одоо ингээд л хэвлэл мэдээллийн хэрэгслээр хараагүй хүүхэд сурч болж байгаа юм байна гэдэг мэдээллийг авсан ээж аав магадгүй

Хараагүйчүүдийн үндэсний холбоо руу хандах ч юм уу, сургууль руугаа хандах ч юм уу, сурдаг гэж байна шүү дээ гээд л явах юм бол бид нар энд бас мэдээлэл өгөөд байгаагийн нэг ач холбогдол байна аа гэж харж байгаа.

Таны болон танай холбооны цаашдын хэтийн зорилго ер нь юу вэ?

Хэтийн зорилго бол за ингээд бид нар 2017-2021 онд манай холбоо дөрвөн жилийнхээ үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулаад ажилласан. За тэгээд тэрийгээ дүгнэсэн. Мэдээж бас хийж чадаагүй ажлууд нэлээн гарсан. Жишээлэх юм бол бид нар ингээд л түрүүний яриад байсан нөхөн сэргээх гэдэг зүйлийг бусад улс орны жишгийн дагуу яг одоо зүгээр нэг гоё жишээ ярьчихъя л даа. Ингээд бусад улс оронд яадаг вэ гэхээр хүн хараагүй боллоо, хэдийд ч хараагүй болж болох байхгүй юу. Тэгэхэд хараагүй боллоо л бол шууд нөхөн сэргээлт ч гэж нэрлэдэг, тийшээ аваачаад л тэнд нь бүр жил зургаан сар байрлуулаад нөгөө хүнээ үнэлдэг шүү дээ. Тэгээд л хараагүй хүн нийгэмд оролцоход ямар мэдлэгтэй, ямар ур чадвартай байх ёстой юм бэ гэдгийг нь бүгдийг нь заагаад дадлага хийлгээд нөгөө биеийг нь даалгаад амьдраад байгаа байхгүй юу. Би бүр тийм хүмүүстэй холбогдож байсан. Ингээд одоо аппартментад амьдруулаад л, тэгээд л бүх одоо ахуйн хэрэглээний зүйлс тэр гал тогооны хэрэгсэл, бүх юмыг нь багш нар нь хүрч ирээд л заагаад л өгчихдөг. За таягийг нь заагаад өгчихдөг тэгээд л тэр хүн таягаа бариад л одоо юу гэдэг юм, хажуу талын дэлгүүр ороод л юмаа авч байдаг. Нөгөө сургалтынхаа төвд очоод л бусад юмнуудаа сурч байдаг. Тэгээд л нэг жил сураад гарахад тэр хүн бол хараагүй байхын талаар ямар ч айдасгүй бүх асуудлаа шийдэх арга ур чадвараа сурчихсан. Тэгээд ингээд цаашдынхаа ажлыг цаашдынхаа их сургуульд сурах вэ гэдэг асуудлаа шийдээд явчихаж байгаа байхгүй юу. Тэгэхээр Монголд бол тийм юм байхгүй. Тэгэхээр бид нар жишээлэх юм болбол тийм нөхөн сэргээх том төвтэй болох юм сан гэсэн. Одоо нэг амбицтай ийм зорилго тавьчихсан байсан. Жишээлэх юм бол тэр маань биелээгүй ч гэдэг юм уу, одоо ингээд л орон сууц гээд бид нар бас аягүй том зорилго тавьсан байсан юм. Өнөөдөр маш олон хараагүй хүмүүс нөгөө орон сууцанд ая тухтай нөхцөлд амьдарч чадахгүй байна. Тэрнээсээ болоод одоо гал алдах, гэртээ амь насаа алдах, ингээд нөгөө явж байгаад нүх сүв шуудуу руу унаж нас барах гээд аягүй тийм эмгэнэлтэй юмнууд гардаг л даа. Тэгээд орон сууцаар хангана энэ тэр гэсэн бас нэлээн зорилтуудыг тавьсан. Гэхдээ яах вэ бид нар хууль эрх зүйн хүрээнд тодорхой хөтөлбөрийн хүрээнд анхны сууриудыг бас тавьсан гэх мэт том том асуудлуудыг тавьсан байсан. Тодорхой хэмжээнд хүрээгүй. Тэгээд сая энэ онд бид нар бас нөгөө нөлөөллийн стратеги, хөрөнгө босголтын стратеги гээд хоёр стратегиа боловсруулсан. За тэгээд энэ дээр болбол мэдээж хэрэг бид нарын гол бас нөгөө ерөнхий гол зорилго нь одоо ирэх дөрвөн жилдээ манай холбооны гол зорилго нь яг

ингээд бид нар одоо хараагүй хүмүүс энэ нийгэмд айдас хүйдэсгүй аюулгүй амьдрах тэр боломжийг бүрдүүлэх гэсэн ерөнхий тийм том алсын хараа тавьчхаад тэр дотроо бол хүртээмж, хөдөлмөр эрхлэлт, боловсрол гэсэн бас тодорхой сэдвүүдийг аваад бүр детальчлан аваад явж байгаа юм. Тэгэхлээр мэдээж хэрэг нөгөө ганцхан юмыг аваад явах юм бол болохгүй, ганц боловсрол гээд аваад явах юм бол нөгөө боловсрол одоо сургуульдаа очихын тулд чиний зам чинь хүртээмжтэй байх ёстой, тээврийн хэрэгсэл хүртээмжтэй байх ёстой, чамд ном байх ёстой, чамд нийгмийн хамгаалал баталгаа байх ёстой. Чи ажилтай байхын тулд бас л нөгөө нэг хүртээмж, мэдээллийн хүртээмж энэ тэр гэдэг.

Нөхөн сэргээлт гэдэг нь нөгөө өөр хоорондоо эд нар чинь бүгдээрээ уялдаатай тэгэхлээр за нэгийг нь хийчихье ээ гээд л орхичхож болохгүй. Тэгэхлээр ингээд бүгдийг нь ингээд цогцоор нь аваад явах ийм стратеги төлөвлөгөөнүүдээ баталсан байгаа л даа. Тэгээд л эцсийн зорилго нь бол Монгол улсад хүн хараагүй болж төрсөндөө гомдоод байхааргүй л ингээд гоё бахархалтай амьдармаар л байгаа байхгүй юу. Тэгээд зүгээр энэ



дээр нэг хэлэхэд тэгдэг шүү дээ. Манай Америкт сурч байсан нэг эмэгтэй тэгж байсан. Америкт очихоороо хараагүй гэдгээ мартчихдаг гээд. Яагаад гэвэл бүх юманд хүртээмжтэй, одоо чи хараагүй шүү дээ гэдгийг сануулаад байх тийм орчин байхгүй байхгүй юу. Би ч гэсэн өөрөө Америкт сурч байсан, тэгэхэд тэр их сургууль дээр очиход бол маш одоо тэр тохирох хэрэглэгдэхүүн буюу хүртээмжтэй орчин нь бол гайхалтай. Намайг очлоо, надтай уулзлаа, намайг үнэллээ, компьютер ашигладаг уу? брайль ашигладаг уу? ямар дэмжлэг хэрэгтэй гээд л миний бүх одоо хэрэглэдэг номуудыг тэр сургууль дээр нөгөө дисиби департмент гээд байдаг тэнийхнээс ингээд урьдчилаад бэлдээд өгчхөж байгаа юм. Электроноор нь ярьдгаар нь за тэгээд дөнгөж гарсан шинэ ном байлаа гэж бодъё. Тэгвэл тэр номыг надад яаж бэлдэж байсан бэ гэхлээр би номоо худалдаад авна. Худалдаж авсан тасалбараа баримтаар нөгөө департмент хэлтэстээ өгнө тэгэнгүүт нөгөө ном авсан хэвлэлийн компани нь одоо нөгөө сургуулиас ингээд тодорхойлолт явуулчихаж байгаа юм. Ингээд хараагүй оюутан сурдаг ийм ном үзэх гэж байна, танайх хэвлэсэн байна гээд л тэгэнгүүт нөгөө хэвлэлийн компаниас нь миний худалдаж авсан баримтыг хараад л электроныг нь явуулчихаж байгаа байхгүй юу. Тэгэнгүүт нөгөө хөгжлийн бэрхшээлийн асуудал хариуцсан хэлтэс маань миний тэр электрон номыг нөгөө хүртээмжтэй болгоод хөрвүүлээд өгчихдөг компьютер дээр гэсэн үг шүү дээ. Тэгээд л миний ном болбол ерөөсөө ном дутагдах нь байхгүй. За багш нар хичээл заахдаа намайг мэддэг болчихсон болохоор маш хүртээмжтэй ойлгомжтойгоор заана. Ажлыг ашиглах гэж байгаа слайдаа над руу нэг хоёр хоногийн өмнө явуулчихдаг. За тэгээд янз бүрийн байдлаар ингээд шалгалт авахдаа надад илүү цаг өгдөг. За бүр тэгээд гайхалтай нь надад юу байсан нөгөө бичигч гээд тютер гээд нэг туслах оюутантай байсан. Би тэгээд тэр манай англий нэг америк оюутан миний тэр хичээлийг бичдэг, тэгээд багшийн тэр лекцийг надад бичиж өгөөд тухайн өдрийнхөө орой нь явуулдаг. Эхлээд надад ийм үйлчилгээ авах уу гэхээр нь надад нэг их эвгүй санагдаад өө яах юм яах юм, би өөрөө биччихнэ гэсэн чинь үгүй ээ ингээд авах хэрэгтэй, хүн болгон нөгөө хэлсэн юмыг товчилдог, тийм одоо эргэж санах зориулсан ийм юм хэрэгтэй. Энэ бол чиний эрхийн асуудал ээд би чинь эхлээд аягүй санаа зовж байснаа сүүлдээ ингээд яг эхэлсэн чинь үнэхээр хэрэгтэй. Би чинь нөгөө нэг цаг гучин минутын хичээл биччихээд буцаад цаг гучин минут сонсохоор чинь надад бас хэцүү шүү дээ. Нөгөө ахиад л цаг гучин минут алдаж байгаа. Шаардлагатай үед бичлэгээ эргэж сонсоно уу гэхээс биш яг тэр оюутны бичсэн гол тэмдэглэл байхад надад бол маш дөхөмтэй ойлгомжтой болчихдог юм байна лээ. Тэгээд хамгийн сайхан нь тэгж надад тусалж байгаа тэр оюутан маань өөрөө цагийн цаг нь ингээд нөгөө цагийн ажлын хөлс нь болоод дэмжлэг аваад явчихдаг. Тэгэхээр оюутныхаа ажил эрхэлтийг ч гэсэн нэгдүгээр дэмжсэн, хоёрдугаарт хараагүй

хүмүүсээ бүрэн дүүрэн суралцах орчныг нь бүрдүүлсэн. За тэгээд хамгийн бас гайхалтай нь төгсөлтийн янз бүрийн олон нийтийг хамарсан арга хэмжээ болохоор одоо хаана ямар зааланд болох гэж байна гэдгээс одоо төгсөлт дээрээ жишээлэх юм бол надад ингээд за ингээд төгсгөлт ийм газар болно гээд очиж үзье гээд намайг дагуулаад ингээд та нар энэ заал руу ороод ингэж суугаад за нэрийг нь дуудахаар диплом гардуулахаар энэ шатаар яваад ингэж аваад гээд надад бүх юмыг нь ингээд биечлээд үзүүлчихэж байгаа байхгүй юу. Ингээд заагаад өгчихсөн тэгэнгүүт би яг маргааш нь очиход ямар ч нөгөө айдас хүйдэсгүй. Тэгэхгүй бол хүн чинь олны өмнө бүдэрчих вий юм яачих вэ гээд л санаа зовно шүү дээ. Тэгэхгүй яг ингээд явна, ингэж байна гэдэг болохоор би бол тэгээд л яг л асуудалгүй, ингээд орчихож байгаа. Тэгэхлээр тэнд би юу харсан бэ гэхлээр нөгөө хүний төлөө нийгэм хүнээ боддог. Энэ хүн одоо ямар нэгэн саад бэрхшээлгүйгээр яг л бусадтай адилхан энэ үйл ажиллагаанд оролцох ёстой гэж харсан газар болбол бүгдийг нь тооцоолоод, бүх юмыг нь ингээд хангаад өгчихдөг.

Бүх юмыг нь хангаад өгчихсөн тохиолдолд би бол хараагүйгээрээ түрий барих гээд л, өө багш аа, ёстой нээрээ ном байхгүйгээс хичээл хийгээгүй гэж хэлж чадахгүй болчихож байгаа юм. Бүх юм надад байгаа болохоор би бүх шаардлагын дагуу хичээлдээ сурах ёстой. Тэгээд л яг өөрийнхөө чадвараа л үнэлүүлэх ёстой. Хийж чадаагүй бол чиний тэр хараагүй байх чинь хамаагүй, яагаад вэ гэвэл надад бүх юм байсан гээд. Тэгэхлээр ийм яг хүний эрхэд үндэслэсэн харилцаа үүсгээд аль алинд нь амар, би ч ингээд хүнээс дутуу юм шиг санагдахгүй, багш нар ч намайг хөөрхий л энээ тэрээ гэсэн юм байхгүй, бүх юм ингээд гоё харилцаа үүсчихдэг юм байна лээ. Тэгэхлээр яг ингээд нөгөө нэг иймэрхүү орчныг ингээд Монгол улсад бий болгох, одоо хүнээ боддог энэ нийгэм болгох, тэгээд энийг чинь маш гоё, ер нь бид нарын нэг зорьж байгаа нэг зүйлийг ингээд гурав хуваагаад хэлэх юм бол бүх бодлого шийдвэр маань юу байгаасай гэж зорьж байгаа юм инклюзив гэж ярьдаг шүү дээ. Одоо бүх хүний асуудлыг харж үздэг, одоо олон улсад энийг бол нөгөө хос замын хандлага ч гэж нэрлээд байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол та нийтэд хандсан бодлого гаргах юм бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг заавал тусга. Хоёрдугаарт нь мэдээж бид нарт ингээд нөгөө арай нэмэлт ийм хэрэгтэй шүү дээ. Одоо ингээд брайлв ном сурах бичиг байх ёстой ч гэдэг юм уу. Тэгэхлээр ерөнхий хууль дээр нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг авч сурах боломжтой гэчихээд туслах бичиг баримт дээр ч гэдэг юм уу, дүрэм журам дээр нь яг орчинг нь бүрдүүлэхэд юу юу байх ёстой вэ гэдгийг нь ингээд заагаад өгчихдөг ч гэдэг юм уу. Тэгэхээр ийм инклюзив бүхний асуудлыг ганц хөгжлийн бэрхшээлтэй гэхгүй одоо нийгмийн цөөнх юу байдаг юм, бүгдийн асуудлыг нь анхнаас нь тусгачихдаг. Хоёрдугаарх нь бид нарын зорьж байгаа юм болбол шийдвэр гаргах түвшин дэх оролцоо аягүй сайн байх

шаардлагатай гэж боддог. Өөрөөр хэлэх юм болбол шийдвэр гаргахад асуудлаа мэддэг хүмүүс маань өөрөө дотор нь суугаад энийг ингээд тусгачихъя аа гэдэг зүйлээ хэлээд анхнаас нь бодлогынх нь түвшинд зөв суурийг нь тавьчих юм бол доошоо хэрэгжихэд бол асуудалгүй гэж бодож байгаа юм. Гэтэл дээрээ бид нарын асуудлыг мэдэхгүй хүмүүс жишээлэх юм бол дутуу дулимаг тусгачихдаг. Тэр нь доошоо очоод хэрэгжих болохоороо болдоггүй. Тэгээд би энэ дээр юу гэж боддог вэ гэхээр бид ямарваа нэгэн юм хийхдээ мэргэжилтнүүдийн саналыг сонсъё, мэргэжилтнүүдийг урья аа гээд гадна, дотноос мэргэжилтэн авчирдаг шүү дээ. Ер нь гэтэл яг хөгжлийн бэрхшээлийн асуудал дээр мэргэжилтнүүд нь хэн юм бэ? Бид нар байхгүй юу.

Би жишээлэх юм бол хараагүй хүмүүс өөрсдийнхөө асуудлыг мэднэ шүү дээ. Би жишээлбэл сонсголын бэрхшээлтэй, тэр даунтай хүний асуудлыг мэдэхгүй, тэд нар өөрсдөө асуудлаа ярих ёстой гэсэн үг. Тэгэхлээр яг энэ шийдвэр гаргах бүхий л түвшинд, одоо дээрээ тэгээд энэ орон нутагтаа ч гэдэг юм уу, тэгээд үнэлгээ мониторинг хийх түвшиндээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг бүрэн дүүрэн оролцуулдаг байгаасай гэж хичээдэг. За тэгээд гуравдугаарт нь бол өөрсдийнхөө талаар мэдлэг олгодог, энэ бүгдийг бий болгохын тулд нийгмийн бүхий л түвшинд ойлголт мэдлэгийг маш өргөн хүрээнд бий болгох нь аягүй чухал гэсэн. Ерөнхийдөө бол энэ манай нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын гол зорьж байгаа болохыг хүсэж байгаа л асуудал. Түүний тулд анхнаасаа сургуульд нь ингээд нэг хичээл заачихдаг шүү дээ. Одоо хүний эрхийн тухай хичээл заахад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэж байдаг юм аа гэдгийг, сургуульд сурч байхад нь заагаад их сургуульд нь заагаад, төрийн албанд ажилд ороход нь жендерийн талаар сургалт явуулдаг гэдэг шиг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар ингээд ингэж эд нартай хамтардаг шүү гэдгийг дор бүрд нь шалгалт авдаг ч юм уу, тест авдаг ч юм уу, ойлголт өгдөг байх юм бол би зүгээр ингээд л бусад улс орны хууль тогтоомж практикийг судлахад гайхалтай гайхалтай аваад явчихаар маш олон санаанууд байдаг. Тэгээд л тэр бүгдийг л Монголдоо нэвтрүүлэхийн төлөө л ажиллаж байгаа даа.

Одоог хүртэл Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооны ерөнхийлөгч гэдэг үүднээс ингээд танаас асуулт асуусан байх. Одоо би танаас яг хувь хүнийх нь хувьд дахин асуулт асууя. Ер нь анх англи хэлийг яаж сурч байсан бэ? Тэгээд тэрнээс гадна Америк сая сурсан гэж ярилаа. Тэгээд Америкт яаж сурсан бэ? Ямар чиглэлээр сурсан бэ? Тэгээд бас магадгүй харааны бэрхшээлтэй иргэдийн маань дотор бас гадаадад сурахыг мөрөөддөг, хүсдэг хүмүүс байгаа байх. Тэгээд тэр талаар та өөрийнхөө туршлагаас хуваалцахгүй юу?

Мэдээж Монгол улсын их сургуулийн Хуулийн сургуульд гуравдугаар курст сурч байхдаа хараагүй болсон. Хөгжлийн нөгөө хүн асуудлыг яаж харж байна

вэ гэдэг өнцгөөс л болоод цаашдын амьдралын зорилго, зорилт, мөрөөдөл гэдэг юм уу, тийм юмнууд нь тодорхой болдог болов уу гэж бодож байна. Эхлээд мэдээж хэрэг хараагүй болоход бол түрүүн ярьсан шүү дээ. Анх хараагүйн талаар ямар ч ойлголт байгаагүй болохоор ерөөсөө хараагүй болсон, бүх юм хэцүүдлээ, ингээд амьдрал маань маш хязгаарлагдмал боллоо гэдэг маш тийм хүндээр хүлээж авч байсан. Тэгээд сайн найз нөхөд, гэр бүлийн тусламжтайгаар их сургуульдаа үргэлжлүүлж сураад 2004 онд хуулийн ангиа төгсөж байсан л даа. Ингээд хараатай үеийн амьдрал хараагүй болсны дараах үеийнхээ хоёр зүйлийг харьцуулахад бол мэдээж хэрэг нөгөө амьдралыг харах, одоо цаг хугацааг үнэлэх, мөч бүрийг үнэлэх, хүн болж амьдарч байгаагийн зорилго нь юу юм, юуны төлөө юм, бид нар чинь гэдэг энэ бүх нөгөө ойлголт харалт одоо юу гэдэг юм, эд нар маань үндсээрээ өөрчлөгдсөн л дөө. Юманд хандах хандлага, эд нар маань одоо жишээлэх юм бол би урьд нь хардаг байхдаа оюутан байхад бол англи хэл манайд орж байсан, тэгээд л одоо их сургууль төгсөөд л тэгээд л ажилладаг шүү дээ. Хуулийн анги юм чинь тэгээд л ингээд л ажилтай гэж бодоод л за англи хэл одоо бараг хэрэгтэй ч юм хэрэггүй ч юм уу ухааны юм бодоод л явдаг үе байсан. Дараа нь хараагүй болчихоод би сурч байхад тэгээд үнэхээр одоо яах гэж сураад байгаа юм, тэгээд миний нөгөө зорилго тодорхой болчихсон байсан болохоор ерөнхийдөө зааж байгаа хичээлийн нэг цаг бүхэн надад үнэтэй, нэг мэдлэгийг ч гэсэн өөртөө авчих юм сан, яагаад юм гэвэл сурч байгаа хугацаанд авсан мэдлэг маань буцаад намайг нийгэм дээр ажил дээр гарахад нэмэр болох тэр зүйлүүд маань гэж байсан болохоор тэр зүйлд маш их үнэ цэнтэй хандаж байсан. Тийм байгаа болохоор илүү хариуцлагатайгаар сурч байсан гэж болно. Тэгээд яг ингээд хараагүй болчихоод сурч байхдаа нэг зүйлийг ойлгосон нь хэл бол маш чухал юм байна. За нэгдүгээрт орчин цагт хэлтэй бол хөлтэй гээд англи хэл бол түгээмэл болчихсон. Тэгээд хоёрдугаарт за хараагүй хүний хувьд бол хэлтэй байх нь маш чухал юм байна гэсэн ойлголтыг бол авч байсан. Харамсалтай нь 2000 оны эхээр намайг сурч байхад энэ англи хэл сурчих боломж маань маш хязгаарлагдмал, одоо ном ч байхгүй, яг ингээд англи хэл сурчихъя гэж бодохоор ном дэвтэр ч байхгүй. Би чинь анх 2007 онд компьютертэй болсон шүү дээ. Тэрнээс өмнө би чинь нөгөө диктафоноо ашигладаг кассеттай. Тэгээд л нөгөө диктафоноор, радиогоор англи хэлний хичээл явахаар бичиж авна. Тэр үед бүр Өвөр Монголын сувгаар нэг англи хэлний хичээл заадаг байсан. Тэрийг нь бичиж авна. Тэгээд л тэр мэрийгээ нэг сонсмоор байна, тэгээд л ямар ч байсан англи хэл сурах нь зүйтэй гэсэн тийм нэг зорилготой болчихсон. Тэгээд 2004 онд төгсөөд ажилд ороод тэгээд би чинь бүр 2007 онд нөгөө компьютертой болоод эхэлсэн чинь өөрөө ингээд нөгөө англиар бичдэг нөгөө текст уншдаг болоод эхэлчихэж байгаа байхгүй юу нөгөө компьютерын электрон хэлбэрээр байгаа номоо. Тэгэнгүүт л би тэгээд л

зорилго тавьж байсан. За тэгээд л нөгөө нэг өдөр болгон юу яах ёстой юм байна өглөө эрт босох ёстой зургаан цагт бос. Бас одоо би тэгээд нөгөө "Эсэншл Инглиш Граммар" (Essential English Grammar) билүү нэг тийм сургалтын хөтөлбөр олоод авчихсан. За тэр чинь 130-160 хичээлтэй. Тэгээд л нэг өдөр нэг хичээлийг ойлгож одоо бүгдийг нь эхнээс нь дуустал хуулна. Тэгээд ойлгоно цээжилнэ гэсэн зорилго тавьсан. Тэгээд л өглөө зургаад босно тэрийгээ хийнэ. Орой унтахаасаа өмнө нөгөө бүгдийг нь хуулаад л ингээд бичээд л уншина шүү дээ. Тэгээд л орой дасгалаа хийнэ, орой тэрийгээ ахиж сэргээж харна. Тэгээд л унтана. Дараагийн өглөө ахиад л нэг хичээл ч гэдэг юм уу. Тэгээд л ингээд л яг хэл сурах тийм зорилгоо бол яг өмнөө тавиад л тэгээд л эхэлж байсан. Тэгээд л яах вэ, нөгөө нэг санаж явбал бүтнэ гээд л нөгөө хийх хүнд арга олдоно гэдэг шиг. Тэгээд л ингээд л сураад л янз бүрийн юм сонсох гээд л орчуулах гээд л ингээд л хичээгээд ирэхээр аяндаа хүн сайжирдаг. Тэгээд бас нэг боломж нь бол 2011 онд би 10 сар Энэтхэг рүү явсан. Тэгээд мэдээж хэрэг Энэтхэг рүү явахын тулд бас нэг төрийн бусын чиглэлээр л явж байсан л даа. Нөгөө бас яг хөгжлийн бэрхшээлийн чиглэлээр. Тэгээд тийшээ явахын тулд мэдээж хэлтэй хүн явах ёстой шүү дээ. Тэгэхэд чинь бас ярилцлага ингээд надтай хийхэд бас хөөрхөн өөрийгөө ярьчихдаг, ойлгочихдог, нөгөө юм юмаа бичээд явуулчихдаг тийм түвшинд оччихсон байсан. Тэгээд л буцаж ирээд л би айлтс өгсөн дөө. За тэгээд айлтс (IELTS) өгөөд л тэгээд Фулбрайтын хөтөлбөрөөр Америкт олон улсын хүний эрх гэдэг сэдвээр магистрын зэрэг хамгаалсан. Тэгээд л буцаж ирсэн. Одоо бол ямар ч байсан англиар уншиж, бичих, одоо бүх авах мэдээлэл маань асуудалгүй. Тэгээд л юу яаж явчихдаг. Тэгэхлээр одоо би бол хардаг шүү дээ. Одооны, зарим залуучууд бол маш мундаг болсон зорилготой. Одоо ингээд клабхаус гээд л сонсож байхад залуучууд маань яасан мундаг болчихсон, ер нь хүмүүс маань их мундаг байна. За мундгуудын зэрэгцээ бас ингэчихээсэй тэгчихээсэй гэж бодож байгаа хүмүүс ч гэсэн цөөнгүй л харагддаг.

Тэгэхлээр ер нь бол эцсийн эцэст хэлэхэд хүн болж яах гэж төрсөн билээ тэ? Одоо хараагүй болсныг би хэрвээ маш том зовлон байна аа, маш бэрхшээл байна аа гэдэг харсаар байсан бол магадгүй ингэж бас өөрчлөлт хийх боломжгүй л байсан байх. Тэгээд зүгээр эргээд харахад хараагүй болсон хэцүү. Одоо ч гэсэн надад зарим хязгаарлагдмал юм байдаг. Өсвөр үедээ шууд гараад явчихаж чадахгүй ч гэдэг юм уу. Гэхдээ миний амьдрал илүү утга учиртай, зорилготой, би юуны төлөө амьдраад байгаа юм, яах гэж хүн бол төрлөө гэдэг маань бол илүү тодорхой болсон, илүү зорилготой болсон, илүү завгүй болсон, тийм байгаа болохоор нөгөө би нэг олон улсын бас юм сурч байхад нөгөө дисибилти-гээ посибилити хөгжлийн бэрхшээлээ боломж олгож харъя аа энэ тэр гэсэн бас нэг ярьж байсан. Нээрээ л туулаад ирсэн бэрхшээлийг тэгээд л боломж олгоод л юм болгон нөгөө юу билээ? Нөгөө цагаан өнгийг харъя л гэвэл

цагаан байж дээ гэдэг шиг. Тэгээд л нөгөө ямар ч юман дотор нөгөө боломжууд, ямар ч юман дотор бас цагаан гэгээлэг талууд байдаг шүү дээ. Тийм болохоор тэгээд л одоо завгүй энэ Монголынхоо нийгмийг хөгжлийн бэрхшээлтэй гэлтгүй бүх хүнд гоё ээлтэй тийм сайхан нийгэм болгоход жаахан ч гэсэн хувь нэмрээ оруулна гээд л зориод л явж байгаа. Ер нь манай хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гол зорилго бол бид нар бол тэгж л байдаг. Монгол хүн бол төрнө гэдэг маань өөрөө маш бахархалтай азтай зүйл гэж боддог шүү дээ. Энэ дотроо зарим хүмүүс Монголд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тэгсэн билээ. Нөгөө Японд нэг монгол хараагүй охин байдаг юм байна лээ. Бүр багаасаа тэнд сураад ба тэгээд нөгөө амралтаараа Монголд ирсэн гэнээ. Тэгж явж байгаад нөгөө яах вэ Япон чинь бол маш хүртээмжтэй болохоор тэгээд л таягаа бариад л явдаг юм байна л даа зайлуул. Тэгээд нөгөөдөх чинь яах вэ таньдаг газраараа явж байгаад нөгөө траншей руу унаад эрүүгээ хугалчихсан юм байна л даа. Тэгээд шүдэндээ нөгөө аппарат зүүгээд ахиж л хэзээ ч Монголд ирэхгүй ёстой ийм муухай газар гээд л. Тэгээд л гаслаад л явсан гэж байгаа байхгүй юу. Гэтэл тийм байлгамааргүй байна шүү дээ Монголд төрсөндөө, тэгэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүн болсондоо ингээд гуниглаад, ингээд гомдоод баймааргүй, харин ч бахархаад явахаар тийм гоё хүртээмжтэй орчин байх ёстой. Тэгээд би зүгээр сүүлд нэг зүйлийг хэлэх гэсэн юм. Хүртээмжтэй орчин гээд би нэлээн хэд ярьсан. Хүн болгонд одоо энэрэнгүй нигүүлсэнгүй тийм сайхан нийгэм байгаасай гэж ярьсан. Гэхдээ энийг бол ганцхан хөгжлийн бэрхшээлтэй иргэд бид нар бол хийж чадахгүй шүү дээ.

Бид нар бол асуудлаа ярина. Та нарт ойлгуулна. Та нар хийж байгаа юм болгондоо одоо жишээлэх юм болбол миний энэ хийж байгаа ажлын чинь нэг үр шимийг хүртэгч нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд юмаа гээд. За энэ иргэдэд миний хийж байгаа юм яг хүрч байна уу, үгүй юу? Өөрөө мэдэхгүй бол яг тэр хүмүүсээс нь асуучихдаг, одоо ийм юм хийж байна, танайх болж байна уу? Ингээд болж байна уугэдэг ийм маш сайхан хамтын ажиллагаа. Ийм хүн төвтэй одоо сүүлийн үед нөгөө хүн төвтэй гэж яриад байгаа байхгүй юу. Хийж байгаа юм болгон чинь хүнд хүрч байгаа юм чинь энэ хүн төвтэй ийм одоо хандлага бий болгох ёстой гэж үзэж байгаа юм. Тэгэхлээр ингэж хамтаараа бид нар энэ нийгмийг бол хүн болгонд хүртээмжтэй болгоно. Тэгээд тэгж байсан манай дэлхийн харагүйчүүдийн холбооноос нэг ярьдаг байхгүй юу. Одоо өнөөдөр ингээд л хараагүй хүмүүст ингээд бид нар брайль ном хийж байна, энэ хөтөч зам, дуут гэрлэн дохио байна, туслах технологи гээд л ярьж байна. Гэтэл зарим хүмүүс ингээд л за за надад ямар хамаатай юм тэ? Ямар манай гэр оронд хараагүй хүн байдаг биш гээд зөрөөд өнгөрөх магадлал маш өндөр. Гэхдээ тэр хүмүүст хандаж юу хэлэх вэ гэхлээр магадгүй маргааш та бид нарын хийсэн энэ ажилд баярлалаа гэж хэлэх цаг ирэх ч юм бил үү. Та тэрийгээ бодоорой. Тийм

байхгүй юу. Би чинь тэгээд л хорьхон настай байхдаа л хараагүй болчихсон шүү дээ, Гэтэл бид нарын хийж байгаа юмыг харахаар зарим хүмүүс өө ийм сайхан ном байдаг юм уу, ёстой нэг уншмаар байна шүү дээ. Өө ингээд цэцэрлэг байгаад ингээд бас ингээд хөөрхөн дэмжчихдэг юм байна шүү дээ гээд хүүхдээ аваад ирж байгаа байхгүй юу. Гэтэл маргааш амьдрал юу болохыг хэн ч мэдэхгүй байхгүй юу. Тэгэхлээр ингээд хараагүй болчихлоо гээд гуниглаад суухгүй, хараагүй болчихсон ч гэсэн амьдрал үргэлжилнэ. Амьдрал үргэлжлэхэд та тухайн хэрэгцээтэй юмыг эхнээс нь ч хийх биш юм чинь байвал таны амьдралыг илүү хөнгөн болгочих боломжтой. Тэгэхлээр л одоо нийгэмд байгаа бүх хүмүүс хажуудаа байгаа хүмүүст ингээд жоохон ч гэсэн анхаарал тавьчихдаг. Нөгөө гоё хүнлэг энэрэнгүй, тэгээд маргааш баярлах цаг ирэх ч юм бий дээ гэж бодоод бас бие биедээ бас жаахан ингээд нөгөө өөрсдийнхөө чаддаг мэддэгээр ингээд дэмжээд явчихдаг болбол их гоё. Тэгэхээр нөгөө дэмжээд явъя гээд та нар хувь нэмрээ оруулаач гэхээр өө бид нар ингээд та нарт өгчихөөр тийм мөнгө төгрөг байхгүй бид нар одоо тийм, одоо арай боломжгүй энэ тэр гээд л хүмүүс ирдэг байхгүй юу. Үгүй ээ, заавал ч үгүй бид нарын үйл ажиллагааг дэмж гэдэг маань санхүүгээр дэмжих гэсэн үг биш шүү дээ. Зүгээр л танай хамт олон байгаа бол одоо хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар хамт олныхоо дунд яриа өрнүүл, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг авчирч санал бодлыг нь сонс, хийж байгаа үйл ажиллагаа маань хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүрч байна уу, үгүй юу гэдгээр нэг анхаарал тавиад үзчих дүгнээд. Манайд хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилд орох гээд ирэхэд манайх ээлтэй байна уу үгүй гэдгээ мэдчих. Тэрэн дээр жаахан анхааралд тавьчих, та гэр орондоо юу вэ гэхээр та үр хүүхэдтэй, магадгүй ингээд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс таарах юм бол үр хүүхэд дээр маш сайхан эерэг ойлголтыг багаас нь өгчих. Тэр хүмүүст ингээд одоо маш сайхан тийм туршлага, гоё хүмүүсийн талаар, мундаг хүмүүсийн талаар яриад өгчихдөг. Багаас нь тэр хүүхдүүдтэй ингээд хөгжлийн бэрхшээлтэй байна гэдэг чинь хэцүү зүйл биш ээ, энэ хүмүүстэй ингээд хамтраад байх боломжтой юм байна гэдэг зүгээр ойлголтыг нь өгчих ч гэдэг юм уу. Тэгээд илүү зав зайтай бол та ингээд нөгөө цагаа бид нарт зарцуулж болно. Жишээлэх юм бол манай холбоо хараагүй хүмүүст зориулаад нөгөө ярьдаг номууд хийдэг электрон номууд хийдэг. Энийг хүртээмжтэй болгохын тулд нөгөө бас тодорхой хэмжээний цаг зав хэрэгтэй л дээ. Юм болгоныг бид нар мөнгөө хийж чадахгүй байгаа шүү дээ. Тэгэхлээр сайн дурын ажил хийж өгч болно энэ оюутнуудыг. Магадгүй та бүр боломжтой болбол тэр мөнгө санхүүгээрээ дэмждэг юм байгаа биз. Тэрнээс наана дэмжиж хувь нэмрээ оруулчих маш олон боломжууд байгаа байхгүй юу. Тэгэхлээр оюутнууд ч гэсэн одоо сайн дурын ажил хийгээд заавал ч үгүй одоо нөгөө гадаад явах тодорхойлолт авахын тулд гэдэг үүднээс биш зүгээр энэ хүмүүс ингээд цаг гаргаад ингээд яачих юм бол ер нь нөгөө амьдрал өгөөтэй аваатай байдаг

бол үнэн шүү дээ. Өнөөдөр нь та юугаа хийнэ, маргааш тэр үрээ хурааж авна гэдэг бол яг үнэн байхгүй юу. Тэгэхлээр яг ингээд бас тэр сэтгэлээр энэ хүмүүст жаахан ч гэсэн тус нэмэр болчих юмсан. Хүн дандаа амьдралдаа авахын төлөө явдаг биз дээ. Жаахан ч гэсэн ер нь нөгөө нэг юу билээ гарсан хэрээрээ ордог гэдэг бол яг үнэн. Гаралтын сувгаа л бас сайн ажиллуулах хэрэгтэй. Дандаа оруулах гээд байхгүй. Тэгэхлээр энэ хүмүүст ингээд өнөөдөр бол асуудал их байгаа болохоор энэ чиглэлээр хийх, дэмжих маш олон боломжууд байгаа. Тэгэхлээр энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд руу очоод танилцаад ямар хэрэгцээ байна өөрийнхөө чадлынхаа хэмжээгээр цаг заваа зарцуулчих, бид нарын талаар эерэг ойлголт өгчих ямар боломжууд байна, ингээд судлаад явах юм болбол хүн болгоны хүчээр Монголын нийгэм удахгүй маш сайхан хүртээмжтэй болгох боломжтой гэж хардаг даа.

За ерөнхийдөө манай подкастын цаг өндөрлөх дөхөж байна. Тэгээд танаас сүүлийн асуултаа асуя. Та өнгөрсөн жил НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах хорооны гишүүнээр сонгогдсон байсан. Тэгээд таныг харахаар ингээд маш их амбицтай амжилттай яваа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл шүү дээ. Тэгээд таныг ингэж цааш нь хөдөлгөх хүч ер нь яг юу байдаг вэ?

Одоо нэг нь юм хийсэн л бол нэг оройд нь хүртэл явах хэрэгтэй. Би одоо хөгжлийн бэрхшээл зүгээр мэдэхгүй ээ. Одоо хараагүй болсонтой ч холбоотой юм уу, ерөөсөө надад тийм л бодол зорилго байдаг. Анх ингээд холбоондоо ажилд орчихоод за Монголын хараагүй иргэдийн төлөө ингээд л ямар ч байсан бид нар яагаад ингээд гадуурхагдах ёстой юм, яагаад бид ингэж хөөрхийлтэй явах ёстой юм, би тэгж харагдмааргүй байна шүү дээ, тэгэхээр энийг өөрчлөх хэрэгтэй гээд л хараагүйчүүдийн гүйцэтгэх холбоонд орж байсан. Дараа нь би нөгөө олон улсын хуралд очоод л олон улсыг хараагүй иргэд ингээд бүгдээрээ цуглараад л асуудлаа ярина шүү дээ улс болгон. Бид нар дэлхийд ийм олуулаа юм чинь Монголыг өөрчлөх болбол асуудалгүй юм байна аа гээд л ингээд л явж байсан. Тэгээд л ингээд л явахын тулд нөгөө дэлхийтэй харьцахын тулд надад хэл хэрэгтэй байх гэдгийг ойлгосон байсан. Хэлээ сурсан. Илүү хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөө юм хийе гэхээр нийгэмд би өөрөө хүлээн зөвшөөрөгдөх хэрэгтэй болж байгаа байхгүй юу. Би энэ хүмүүсийн ярьдгийг ярих хэрэгтэй болно. Тиймийн тулд би заавал тэр одоо хүмүүсийн одоо юу гэдэг юм гадаадад сурчихсан. Одоо би нэгдүгээрт мэргэжлээ дээшлүүлнэ. Хоёрдугаарт миний бодол юу вэ гэхээр магадгүй Монголын нийгэм чинь тийм шүү дээ. Эхлээд гадаадад сурсан гэх юм бол нэг хүнтэй юм ярихад арай нэг алхам дээшээ болж байсан. Тэгдэг шүү дээ хүмүүс. Ерөөсөө тийм тэгдэг нийгэм байхгүй юу. Тийм байгаа болохоор энэ хүмүүстэй би мөр зэрэгцэж явахын тулд би энэ хүмүүсийн сурсан мэдсэнийг цуг мэдэх

ёстой юм байна гээд явсан. Сурсан, буцаж ирсэн. Гэтэл дэлхийд нөгөө одоо ганц Монголын асуудал биш, дэлхийн одоо хөгжлийн бэрхшээлтэй асуудлыг ярьдаг хороо цаана чинь байна шүү дээ. Улс орнуудын тайлан илтгэлийг хэлэлцээд л танай улс энэ нь болохгүй байна, энийгээ сайжруул гээд л хэлдэг тийм том хороо цаана чинь байхад чинь яагаад энд монгол хүн байж болохгүй гэж. Би тэгвэл ингээд л зүгээр нэг юм бодогддог шүү дээ, бид нар ингээд монголчууд аягүй их ингээд хандив тусламж төсөл хэрэгжүүлдэг, тэгээд надад заримдаа өрөвдмөөр санагддаг. Хэзээ Монгол ядарсан буурай бусад оронд төсөл өгдөг болох юм бол, бас ингээд л хүмүүс ингээд л төсөл авах гээд ёстой манайд ийм хэцүү, одоо ингээд л хүүхдүүд нь сургуульд сурахгүй байна гээд л ярихад чинь ичгэвэртэй байхгүй юу. Заримдаа тэрийгээ бодохоор ингээд ичдэг шүү дээ.

Ингээд Монголын төр гуравхан сая хүнтэй ийм том баялагтай улс байж тэ? Яагаад биднийг ингээд ядуу амьдруулаад бусдын өмнөөс ингээд бдор барихад хүргээд байгаа юм бол тэ? Яах вэ, мөнгө олж байгаа асуудлаар шийдэж байгаа юм болж байгаа ч гэсэн хүний өмнө тэгж ярина гэж би нэг хүсээд байх зүйл биш байхгүй юу. Тэгэхлээр ингээд тэрнээс ингээд жаахан хор шар байдаг ч юм уу, ерөнхийдөө ингээд л тэр хүмүүсийн хүрдэг хийдэг юманд нь л хүрэх юмсан гэсэн зүгээр л тийм бодолтой. Тийм байгаа болохоор одоо ингээд энэ хороонд явж байгаа. Тэгээд одоо хороондоо дөнгөж ороод л ингээд л ажиллаад л эхэлж байна. Тэгээд одоо манай хороо сая 3 сард хуралдсан. Бид нар бол Женевт жилд хоёр удаа биечилж уулздаг юм. Тэгээд коронагаас болоод чадахгүй байгаа юм. Ингээд сая 3 сарын хурал маань онлайнаар явсан. Одоо 8 сарын 15-аас 9 сарын 15 хүртэл 25-р хорооны хурлууд болно. Тэгээд нөгөө Франц Жибути гээд хоёр улсын тайлан илтгэлийг авч хэлэлцсэн л дээ. Тэгээд л тэд нарын ирсэн тайлан эд нарыг ингээд л уншаад сууж байхад чинь бас авахаар суралцахаар, одоо би энэ хороонд орсноороо бусад улс оронд зөвлөгөө өгөхөөс гадна надад ямар боломж нээгдэж байгаа вэ гэхээр би мэдээллийн дунд орж чадаж байгаа байхгүй юу. Би бусад улс оронд ямар бодлого шийдвэр хэрэгждэг юм байна, ямар сайн туршлагууд байгаа юм байна гэдэг нь би гуйгаад биш надад өөрсдөө бүгдээрээ хүрээд ирж байгаа байхгүй юу. Одоо манай Франц улсад хөгжлийн бэрхшээлийн асуудал ингэж ингэж байдаг, бид нар ийм бодлого хэрэгжүүлдэг гэсэн бүх мэдээллийн дунд би орчихож байгаа болохоор надад эргээд ямар боломжтой байна гэхээр тэр бүх бусад улс оронтойгоо сайн сайхан зүйлийг, тэр жишгийг Монголдоо буцааж энэ асуудлыг чинь ингэж шийддэг юм байна шүү дээ. Энэ улс ингээд маш амжилттай явчихсан байна. Одоо би ингээд л өнөөдөр илтгэл уншаад сууж байгаа байхгүй юу. Тэгтэл ингээд л маш олон ингээд л санаанууд, энэ улс чинь ингэдэг юм байна, ийм хуультай юм байна, энэ асуудлаа ингэж шийддэг юм байна гээд гэсэн маш олон санаанууд орж ирж байгаа. Тэгэхлээр эргээд тэр

олон сурсан мэдсэн сонссон зүйлээ одоо Монголдоо баримттай нотолгоотойгоор зүгээр ингээд өгөөч гэхгүйгээр ингэж цаг конвенцыг чинь ингэж хэрэгжүүлж байна, ийм жишиг байна гэдгийг ингээд хэлэх илүү боломж гарах гэж байгаа бол доо, миний нөгөө эцсийн зорилго Монголын нийгмийг хүртээмжтэй болгох юмсан гэдэг зорилгодоо хүрэхэд энэ надад бас нэг шат ахиж тус олж байгаа зүйл болж байгаа байхгүй юу. Тэгэхлээр ингээд л нөгөө яг эцсийн зорилгодоо хүрэхэд надад юу хэрэгтэй байна тэр бүгдийг нь ингээд л бариад явахад энэ конвенцын хороо болбол бас нэг дамжих ёстой дамжлага юм байна гэж харагдсан. Тэгээд л түүний төлөө зорьсон, Монголын төр засаг бол дэмжсэн. Тийм, тэгээд л баярлаж байгаа.

Таны цаашдын ажил хөдөлмөрт нь томоос том амжилтыг хүсье. Ийнхүү цаг зав гарган манай подкастад орж ингээд маш үнэтэй яриа өгч ийм ийм зүйлүүд байдаг юм байна шүү гэдгийг ойлгуулж ухааруулж өгсөн танд маш их баярлалаа. Тэгээд таны ажилд сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе!

За та нар ч гэсэн баярлалаа. За би бол яах вэ зүгээр өнөөдөр өөрийнхөө тухай, холбооны тухай ярилаа. Гэтэл манай хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд амьдралын төлөө гэсэн зорилготой маш мундаг хүмүүс их байдаг. Тэгэхлээр манай энэ подкастаар ч гэсэн дараа дараагийн олон одоо бусдад үлгэр дуурайл болсон хүн байхын утга учрыг харуулсан тийм хүмүүс бас орж нийгэмд сайхан мэдээлэл ойлголтуудыг өгөх байх аа гэж итгэж байнаа.За баярлалаа та бүхэнд.

За баярлалаа танд.

СОГОГЗҮЙГЭЭС ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛ РУУ

Д.Одгэрэл



Сайн байцгаана уу, эрхэм хүндэт сонсогчид оо, Антолд подкастын маань ээлжит дугаар эхлэхэд бэлэн болоод байна. Энэхүү дугаарт Монгол улсын боловсролын их сургууль, Нагоя их сургуулийн хамтарсан Хүүхдийн хөгжлийг дэмжих төвийн эрхлэгч, доктор, дэд профессор Одгэрэл оролцож байна. Танд ийнхүү цаг зав гарган манай подкастад орсонд маш их баярлалаа. Та өөрийгөө эхлээд сонсогчиддоо танилцуулахгүй юу?

За дэлгэрэнгүй танилцуулбал их цаг хугацаа орох байх. Би боловсролын салбарт ажиллаад бараг 33-34 жил болж байна. 1984 онд хуучнаар Зөвлөлт Холбоот Улсын Ленинград хотын багшийн дээд сургуулийг төгссөн. Сургуулиа төгсөж ирээд тухайн үед 29-р сургууль гэж хараагүй, сонсголгүй хүүхдийн нэг сургууль байсан. Дараа нь энэ сургууль маань хоёр хэсэг болж хуваагдсан. 29-р сургуульд согог зүйч багшаар ажиллаж байсан. Дараа нь 1993 онд Боловсролын яаманд тусгай боловсрол хариуцсан дэс түшмэлээр ажилласан. Боловсролын хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтнаар ажиллаж байгаад Япон, Монгол улсын Боловсролын яамны гэрээний дагуу Япон улсад судлаач оюутнаар очоод тэндээ магистрын болон докторын зэрэг хамгаалж тэндээ ажиллаж байгаад 2009-2010 онд Монголдоо эргэж ирсэн. Эргэж ирээд төслүүд дээр ажиллаж байсан. Дараа нь Боловсролын их сургуульд багшаар ажиллаж байгаад 2016 оноос хойш МУБИС, Нагоя их сургуулийн хамтарсан Хүүхдийн хөгжлийг дэмжих төвийн эрхлэгчээр ажиллаж байгаа.

Та анх Зөвлөлт Холбоот Улсад сурч төгсөөд ирсэн. Тэгээд дараа Японд сурахад хэр ялгаа танд мэдрэгдсэн бэ?

Тийм. Энэ бол маш их ялгаатай. Ялгаатай гэдэг дээр бол зөвхөн Орос, Монголын хоорондын ялгаа биш, ер нь нийгмийн хөгжил дэвшилтэй уялдуулаад Орост ч гэсэн маш их өөрчлөлтүүд гарсан. Одоо Зөвлөлт Холбоот Улс нь ч байхгүй, Ленинград гэдэг нэртэй хот ч байхгүй, Багшийн дээд сургууль гэдэг нэртэй ийм сургууль байхгүй. Яаж өөрчлөгдсөн бэ гэхээр Оросын Санкт-Петербургийн боловсролын их сургууль гэж өөрчлөгдсөн. За согог зүйч гэж мэргэжил бас байхгүй болсон. Өмнө нь согог гэдэг ухагдахуун, чиглэл рүү их анхаарлаа төвлөрүүлж судалдаг байсан бол одоо яг тухайн хүн рүү анхаарлаа төвлөрүүлэхээс гадна орчин нөхцөл байдал нь ямар байна вэ гэдэгтэй уялдуулаад хүүхдэд ямар хэрэгцээ байна вэ, орчин нөхцөл байдалд нь ямар өөрчлөлт хийх шаардлагатай вэ гэх мэт нэр томьёонууд бүгд өөрчлөгдсөн. Тэгэхээр энэ бүгдийг Японд очоод яг тухайн үед нэг их өөрчлөлт мэдэгдэхгүй байсан. Японд очоод их өөр өнцгөөс хардаг юм байна гэдгийг маш сайн ойлгож авсан. За тэгээд надаас "Таны суурь мэргэжил юу вэ?" гэж асуусан л даа. Миний "дефектоложи" гэсэн хариултыг тэд гайхаад манайхаар бол тусгай боловсрол юм байна гэж тайлбарласан. Тэгээд өөр өнцгөөс хардаг юм байна, согог гэдэг өнцгөөс бол ерөөсөө хардаггүй юм байна аа гэдгийг тэр үеэс л эхэлж ойлгож ирсэн дээ. Үзэл баримтлал, концепц энэ тэр нь бол огт өөр байсан. Энэ хоёр өөр зүйлийг харьцуулаад сураад Монголд ямар орчин нөхцөлд яаж буулгаж болох вэ гэдгийг бодож тунгааж ирж энэ ажлаа эхлүүлээд цол хамгаалснаасаа хойш 20 гаруй жил болж байна.

Монголд өмнө нь Орост төгссөн мэргэжилтнүүд ирээд тусгай боловсрол олгодог сургуулиудад ажилладаг байсан. Одоо манай Монгол улсын боловсролын их сургуульд тусгай боловсролын зэрэг хамгаалдаг болсон. Тэгэхээр энэ хоёрын ялгаанд хэр өөрчлөлт орсон бэ?

Яг энэ дээр бол барууны орнууд ч гэдэг юм уу, хуучин Зөвлөлт Холбоот Улс, одоо Оросын Холбооны Улс. Энэ бүгдэд өөрчлөлтүүд орж байгаа. Манайд ч гэсэн өөрчлөлтүүд орж байгаа. Гэсэн хэдий ч яг одоо барууны түвшинд хүрсэн гэж хэлэхэд хэцүү байгаа юм. Энэ дээр ямар жишээ баримт дурдаж болох вэ гэхээр Боловсролын яамнаас мэдээлэл гардаг. Гадныхаар бол тусгай боловсрол шаардлагатай хүүхдүүд гэдэгт хэнийг хамруулж байна вэ гэхээр манайхан бол хараа, сонсгол, сэтгэц, хэл яриа, тулгуур эрхтэн, хавсарсан гээд ийм зургаан ангиллаар л хүүхдүүдийн статистик мэдээлэл гарч байгаа юм. Тэгэхээр гадны орнуудад бол энэ ангилал бол маш олон болсон. Энэ ангилалд танин мэдэхүйн өөрчлөлттэй хүүхдүүд, суралцахуйн бэрхшээлтэй хүүхдүүд, зан төлвийн өөрчлөлттэй хүүхдүүд, анхаарлын дутмагшил хэт хөдөлгөөнтэй эмгэг,



аутизмын хүрээний өндөр чадавхитай хүүхдүүд ч гэдэг юм уу. Ингээд жишээлбэл Америкт 13 ангилал, Японд 10 ангилал, Англид 11 ангилал байх жишээтэй. Манайх бол бие эрхтний согогтой гэдэг 6 ангилалдаа л баригдсан байдалтай байгаа учраас энэ чиглэлээр бол нэлээн хоцорч байна гэж хэлж болно.

Яамдууд тус тусдаа статистиктай байдаг тийм үү?

Яамдууд тус тусдаа статистиктай байж болно. Тухайлбал, боловсролын үнэлгээ, эрүүл мэндийн үнэлгээ, нийгмийн хамгаалал, халамжийн үнэлгээ ч гэдэг юм уу. Энэ бол бас өөр өөр байна. Тэгэхээр нуруу нугасны гэмтэлтэй гээд эрүүл мэнд талаасаа оношилсон хүүхэд бол боловсрол дээр тэр материаллаг орчин нь л бүрдчихсэн байхад нарийн тэр арга зүй нь ч байдаг юм уу, хөтөлбөрийн ч байдаг юм уу энэ тал дээр тухайн хүүхэд боловсролын үйлчилгээн дээр тийм нарийвчилсан тусгай дэмжлэг, үйлчилгээ аваад байх шаардлага байхгүй. Оюун ухаан нь хэвийн, хөгжилтэй хүүхэд бол. Одоо энэ тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхдүүд ч байна, тийм үү? Одоо протезтой гартай, протезтой хөлтэй ч гэдэг юм уу? Ийм хүүхдүүдийн тухайд бол оюун санаа нь эрүүл саруул байгаа

тохиолдолд бол хөтөлбөрийн тохиргоо ч гэдэг юм уу, тусгай арга зүй ч гэдэг юм уу, тийм юм төдийлөн шаардлагагүй. Тэд нарт юу хэрэгтэй вэ гэхээр тэр халамжийн үйлчилгээнээс тэр протез нь хэрэгтэй байдаг юм уу, эрүүл мэнд талаасаа ямар үйлчилгээ хэрэгтэй байдаг юм бэ? Энийг бол ингэж ялгаж салгаж ойлгох хэрэгтэй.

Монголд хөгжлийн бэрхшээлтэй гэхээр бүх хүмүүсийг нэг категорид оруулаад л явчихдаг. Тэгэхэд яг үнэн байдал дээр яг тухайн хүн маань оюуны одоо хөгжил нь янз бүр байхад ингээд орчихоор тухайн нийгмээс ирж байгаа бас хандлага нь тухайн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд өөрөөр нөлөөлөөд байх шиг?

Манайд ямар өнцгөөс хараад байна вэ гэхээр яг бие эрхтний тогтолцоон дээр нь өөрчлөлт орчихсон, хараагүй, сонсголгүй, хөлгүй, гаргүй ч гэдэг юм уу, ийм өнцгөөс хараад байдаг. Тэгэхэд тэр хэдийгээр хараагүй ч гэсэн тэр хүн мундаг оюуны потенциалтай байна. Хэдийгээр сонсгол ч сонсож чадахгүй ч гэсэн дохионыхоо хэлээр яриад, оюуны потенциал нь маш өндөр. Жишээлбэл, надтай хамт энэ "Тусгай боловсрол" сурах бичиг, ном бичсэн зохиогч, багш эмэгтэй байна. Тийм учраас энэ боловсролын салбарт бол ямар өнцгөөс харах ёстой вэ гэхээр яг тухайн хүнд ямар чадвар байна вэ, ямар чадвар нь алдагдчихсан юм бэ, хэрхэн нөхөн сэргээж болох вэ, боловсролын салбарт, ер нь чадвар гэдэг өнцгөөс нь л тэр хүнийг харж үнэлгээ хийж, тэгээд цааш нь хөгжүүлэх гэсэн ийм хандлага байдаг. Тэгэхээр энэ боловсролын салбарт хэрхэн яаж харах вэ, яаж авч үзэх вэ, ямар байдлаар үнэлгээ хийх вэ гэдгийг нарийвчлаад заагаад өгчихсөн байдаг. Энэ талаар бол Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан зөвлөмж байдаг юм. Тэгээд хөгжлийн бэрхшээл гэдгийг бол яаж авч үзэх вэ? Эрүүл мэндийн салбарт бол өвчин согог гэдэг байдлаар авч үзнэ. Тэгэхээр өвчин согог гэдэгтэй хэн ажиллах вэ гэхээр эмч нар ажиллана. Хэн оношлох вэ гэхээр эмч нар оношилно. Эрүүл мэндийн үйлчилгээг хэн үзүүлэх вэ гэхээр эрүүл мэндийн салбарын ажилтнууд үзүүлнэ. Боловсролын салбарт ямар өнцгөөс тэдгээр хүмүүсийг авч үзэх вэ гэхээр яг ямар чадвар нь алдагдаад, ямар чадвар нь одоо давуу байгаад, ямар ч чадвар нь сул байгаад энэ чадвар гэдэг талаас нь хүүхдүүдийг хэрхэн яаж хөгжүүлэх вэ, оюун ухааны чадвар ба нийгэмших чадвар байна, зан төлөв бусад чадваруудыг хэрхэн яаж хөгжүүлэх вэ гэдэг дээр бол энэ боловсролын салбарын ажилтнууд ажиллана. Энэ дээр гадны орнуудад маш тодорхой заачихсан хууль байдаг. Жишээлбэл, Америкт энэ чадварын өөрчлөлттэй, чадварын алдалттай хүмүүст зориулсан тусгай боловсролын хууль байх жишээтэй. За энэ дээр нь яг хэнийг энэ тусгай хэрэгцээтэй хүүхдүүд гэдэгт хамруулах вэ? Хэнд үйлчилгээ үзүүлэх юм бэ? Хэрхэн яаж үзүүлэх юм бэ, ямар аргачлалаар үзүүлэх юм бэ? Ямар нөхцөл байдалд ямар хугацаанд үзүүлэх вэ? гэдгийг тодорхой заагаад өгчихсөн хууль, хуульчилсан бичиг баримтууд байдаг. Манайд хөгжлийн бэрхшээлтэй хүний

эрхийн тухай хууль гэж байгаад маш ерөнхий хөгжлийн бэрхшээлтэй хүн гэж нэг тодорхойлоод тэр хуулийнхаа заалтыг боловсролын салбартаа ч авдаг, эрүүл мэндийн салбартаа ч авдаг, нийгмийн хамгааллын салбартаа ч авдаг. Ийм хэт ерөнхий байдлаар авч үзсэний үндсэн дээр яг онцлог хэрэгцээг нь тодорхойлж мэдэхгүй, ялангуяа боловсролын салбарт. Тэгээд дэмжлэг үзүүлэх нь бас төдийлөн тодорхой биш байна. Яг энэ хуулийн дагуу бол үйлчилгээ авч байгаа хүмүүс тэгэхээр нэлээн хүнд хэлбэрийн эмгэг согогтой хүмүүс бол яг бие эрхний тогтолцоонд нь өөрчлөлт гарсан тийм хүмүүс л аваад байна уу гэхээс биш сүүлийн үед маш их олшроод байгаа танин мэдэхүйн суралцахуйн өөрчлөлттэй, тусгай хэрэгцээтэй хүмүүс энэ хуулийн тодорхойлолтын дагуу хамрагдах боломж одоогоор байхгүй байна. Тийм учраас хуулийнхаа заалтыг салбар, салбартаа өөр, өөрөөр залруулах арга хэмжээ авах хэрэгтэй.

Хүүхдийн оюуны хөгжлийг тодорхойлох, оношилгоо, үнэлгээ хийхэд Монгол улс ямархуу байр суурьтай байдаг вэ? Өмнө нь ямар байсан бэ?

Өмнө нь ямар байр суурьтай байсан бэ гэхээр оюун ухааны бэрхшээлтэй хүүхдийн сургуульд хамруулахын тулд тухайн сургуулийн дэргэд комисс байгуулагдаад, тухайн хүүхэд оюун ухааны бэрхшээлтэй юм байна гэдгийг сэтгэцийн эмч тодорхойлоод тэр хүүхдийн талаарх бусад мэдээллийг согог зүйч багш нар судалж үзээд судалж үзэхдээ өөр өөрийн арга барилаар янз бүрийн асуулт асуудаг. Тухайн хүүхдийн гэр бүлийн талаар асуугаад "Жилд хэдэн улирал байдаг вэ, чи хэнтэйгээ амьдардаг вэ?" гээд яг тухайн багш өөртөө ямар арга барил эзэмшсэн, өөрт нь хэрэглэгдэхүүн байна тийм байдлаар л авч үзээд дүгнэлтээ гаргаад



энэ хүүхэд бол оюун ухааны бэрхшээлтэй, тусгай сургуульд сурах юм байна гэсэн байдлаар ханддаг байсан. Тэгэхээр энэ бол яагаад ийм байдлаар хандаж байсан өөрөөр хэлбэл ерөнхийдөө чанарын судалгаа хийдэг байсан. 1905 оноос хойш барууны орнуудад ай кю-г тодорхойлох тест боловсруулаад маш олон хувилбар гарч, олон дахин шинэчлэгдсэн. Ай кю-г тодорхойлох нь хэрэгтэй юм байна, хүүхдийн хөгжлийн, ялангуяа оюуны хөгжлийн талаарх маш чухал үзүүлэлтүүдийг ай-кю-аар бол гаргаж болох юм байна гэсэн ийм байр суурьтай8 энэ чиглэлийн судалгаанууд их байдаг. Энэ чиглэлээр бид сүүлийн 5-6 жил Нагоя их сургуультай хамтраад Монгол танака оюун ухааны сорил гэдгийг бол боловсруулсан байгаа. За энэ судалгааны ажлыг нарийвчилсан төлөвлөгөөгөөр хийсэн. 1118 хүүхдийг хамруулсан гурван удаагийн судалгаа хийсэн. Урьдчилсан судалгаа, туршилт судалгаа, үндсэн судалгаа гэдгийн гурван удаагийн судалгаагаар яг монгол хүүхдийн дундаж стандартыг гаргасан. 2-10 настай хүүхдийн ай-кю дундаж насыг гаргаж ирээд энэ сорилоор бол монгол хүүхдийн оюуны ухааны хөгжлийн насыг тодорхойлох боломжтой, ай кю-г тодорхойлох боломжтой болсон. Хуучин бол Оросын школоор, энэ тоон үзүүлэлтийг, хүүхдийн оюун ухааны сорил



ай-кю-г тодорхойлох нь учир дутагдалтай гэдэг шүүмж, хандлага байсан учраас энэ чиглэлээр нарийвчилсан судалгаа байдаггүй. Энэ судалгаа бол албан ёсны зохиогчийн эрхийн зөвшөөрөлтэй Японы Танакагийн хүрээлэнгээс бид ашиглах эрхийн зөвшөөрлийг авааД өөрсдөө энэ хувилбарыг боловсруулсан. Энэ хувилбар 60 орчим хувь нь цоо шинээр шинэчлэгдсэн, олон асуултуудыг монгол хүүхдийнхээ монголын соёл ахуй, хэл, онцлогт тохируулан өөрчилж, монгол хүүхдүүдийн дундаж стандартыг гаргасан аргачлалтай болсон. Энэ аргачлалынхаа дагуу бид Танака Бинегийн сорил авагч нарыг бэлтгэх сургалтуудыг зохион байгуулаад явж байна. Эхний сургалтаа амжилттай зохион байгуулсан. Одоо дараагийн сургалтаа энэ намар зохион байгуулах гэж байгаа.

Танака Бенигийн сорил гэдэг нь ерөнхийдөө ямархуу асуултууд байдаг вэ? Та нэг жишээ дурдвал?



2-12 насны хүүхдийн ай кю-г аа тодорхойлох ийм боломжтой. Яг нас насных нь онцлогт нь тохируулсан асуулт даалгаврууд байгаа. Бага насны хүүхдүүд дээр бол маш их тоглоом байна. Жишээлбэл, зураг үзүүлээд л энэ юу вэ, энэ юу вэ гээд л асуугаад л. Хүүхдээр заавал бөмбөг гэж хэлүүлэх албагүй, ойлгож л байвал, энэ юу вэ гээд. Ингээд хоол руу заахад хоол гэж хэлэхгүй л дээ. Жаахан хүүхэдтэй ням ням ч гэдэг юм уу, машин байвал ууд нь уудна ч гэдэг юм уу, нэг иймэрхүү байдлаар хариулж байвал энэ хүүхэд ойлгож байна гэдэг байдлаар нэг хоёр настай хүүхдийн асуулт бол иймэрхүү байх жишээтэй. 9 настай хүүхэд дээр бол за энэ зурган дээр ямар үйл явдал болж байгааг тайлбарлана уу гээд. Тэгээд 9 настай хүүхдийн тайлбар яг нэг зургийг бол 7 настай хүүхэд, 9 настай хүүхэд, 10 настай хүүхэд гэдэг дээр бол асуудаг. Тэгэхдээ шалгах шалгуур үзүүлэлтүүд нь арай өөр байна. Өөрөөр хэлбэл, бага насны хүүхдүүд бол зүгээр дурдаад явчихаж болно. Ахлах насны хүүхдэд бол зөвхөн дурдах биш яг тэр үйл явдлын цаад логик учир шалтгааныг хэлээд энэ хүмүүсийн эмоци, байдал нь ямар байна вэ гэдгийг бас хэлэх шаардлагатай байдаг. Үүний дагуу тэдгээр хүүхдүүдийн шалгуур оноог нь тавиад явдаг. Тэгэхээр маш олон хэл яриа шалгасан байна, орон зайн баримжаа байна, логик сэтгэлгээг шалгасан байна гэвд оюун ухааны олон чадамжийг агуулсан янз янзын асуултууд

байна. Ерэн асуулттай ийм сорил байгаа. **Ингээд 1300 гаруй хүүхдээс сорил авахад үр дүн нь ямархуу гарсан бэ? Монголд тухайн оюуны ялгаатай хөгжил ерөнхийдөө хэр байгаа нь гарч ямар үр дүн гарсан бол?**

Тийм. Бид эхлээд 68 хүүхдээс судалгаа авсан. Тэгэхээр энэ асуултууд нь болж байна уу, болохгүй байна уу, юуг нь өөрчлөх шаардлагатай вэ гэдэг дээр хүүхдүүдээ шалгаж үзээд асуултуудыг өөрчлөх шаардлагатай юм байна гээд өөрчилсөн шинэчилсэн. Дараагийн удаад 300-аад хүүхдээс хот, хөдөөгийн ялгаа гарах нь уу, үгүй юу гэдгийг шалгаж үзсэн. Мэдээж насны үзүүлэлтүүдийг хамгийн нэгдүгээр шалгууруар авсан. Энэ асуулт яг 4 настай хүүхэд дээр тааруй байна уу, 5 настай байна уу, 3 настай байна ч гэдэг юм уу? Тэгэхээр 4 настай хүүхдээс бол доошоо 3, дээшээ 3 гэдэг чинь 1-7 нас хүртэлх даалгаврууд бүгдийг нь туршиж үзсэн. Яг нас насных нь онцлогт нь тохирох даалгаврууд нь сонгож авч статистикийн боловсруулалт хийгээд үлдээсэн. Энэ дээр зарим нэг цөөхөн тохиолдолд бол хот, хөдөөгийн ялгаатай байдал ажиглагдах ч гэдэг юм уу, асуулт нь нөгөө япон агуулгаар орсон асуулт бол таарахгүй ч гэдэг юм уу, ийм зүйлүүд бол гарч байсан. Энийг бол бид бүгдийг нь өөрчилсөн. За тэгээд хамгийн сүүлд энэ туршилт судалгаагаар асуултууд нь хүүхдэд тохирч байна, хот, хөдөөгийн ялгаа бол төдийлөн байхгүй байна гэсэн дүгнэлтэд хүрээд үүнийхээ боловсруулалтыгхийгээд хамгийн сүүлийн хувилбараар 90 асуултыг боловсруулж гаргасан. Хот, хөдөөгийн ялгаа дээр янз янзын сонин сонин зүйл бол ажиглагдаж байсан. Алдартай гэдэг яг юу гэж тайлбарлах вэ гэхээр хөдөөний хүүхдүүд уяач хүн бол алдартай байна аа ч гэдэг юм уу. Хөгжил гэж юу гэж ойлгож байна аа гэхээр хөгжил гэдэг маань одоо хот суурин газрыг хэлнэ ч гэдэг юм уу, нэг иймэрхүү цөөхөн кэйсүүд бол гарч байсан л даа. Монгол хүүхдүүдийн тухайд бол юмыг ингээд ерөнхийлөөд хараад ерөнхийлөн дүгнэх чадвар бол маш сайн. Япон хүүхдүүд яаж байна вэ гэхээр деталиас эхэлдэг зүйл ажиглагдаж байсан. Зарим нэг даалгаврууд бид хассан. Ерөөсөө монгол хүүхдийн онцлогт бол таарахгүй ч гэдэг юм уу, ийм байдлаар яг тэр статистик боловсруулалт хийхэд статистикийн үзүүлэлтүүд нь насаар ахих гэдэг дээр таарахгүй асуултууд байсан. Энэ ийм асуултуудыг бид нар бол хассан. Жишээлбэл, өдөр, сар, гараг гэдгийг юу гэж нэрлэх, юу гэж нэрлэх вэ гэдэг шууд асуулт биш. Арай өөрөөр асуусан, тэд дэх өдөр, тэр хүүхэд ингэж байсан, нөгөө дэх өдөр нь ингэсэн гээд нэг энэ өдөр сарыг хэлэх энэ асуулт дээр зарим хүүхдүүд болохоор даваа, ням, лхагва ч гэдэг юм уу, зарим хүүхдүүд болохоор нэг дэх өдөр, хоёр дахь удаагаа гурав дахь өдөр ч гэдэг юм уу ийм ялгаатай хариултууд байсан учраас яг эцсийн үр дүн дээр ингээд боловсруулалт хийхээр нөгөө нас ахих тусам оноо ахина гэдэг ийм зүйл ажиглагдаагүй учраас тухайн сургалтын орчин, нөхцлөөс хамаарсан ийм үзүүлэлтүүд гарч байсан. Энэ нь статистик боловсруулалт хийхэд яг аваад хэрэглэчих ийм дата болохгүй

байсан учраас зарим асуултуудыг хассан.

Одоо Танака Бинег Монголын нөхцөлд ингээд нутагшуулаад Монгол Бине гээд гаргачихсан байгаа шүү дээ. Тэгээд ерөнхийдөө энэ сорилыг маань ерөнхий боловсролын сургуулиудад хэр их ашиглаж байгаа вэ?

Бид сорил авагч нарыг бэлтгэж байгаа. Тийм учраас цаашид ашиглаад явах байх. Тэгэхээр ер нь хэвийн хөгжилтэй хүүхдүүд дээр энэ сорилыг ашиглаад байх тийм онцын шаардлага байхгүй. Хэвийн гэдэг үзүүлэлтүүдийг бид нар бол гаргачихсан байгаа. Тэгэхээр хэвийнээс доош юм уу, хэвийнээс дээш юм уу? Гоц авьяастай хүүхдүүд, эсвэл оюуны хоцрогдолтой хүүхдүүд байж болно. Тэгэхээр эдгээр хүүхдүүдийг ялгаж салгаад эдгээр хүүхдүүдэд ямар дэмжлэг үзүүлэх вэ гэдэг зорилготойгоор анх Францын эрдэмтэн Альфред Бине энэ тест сорилыг боловсруулсан байдаг. Тэгэхээр бидний баримталж байгаа зарчим ч ялгаагүй. Хүүхдэд ялгаатай байдлыг нь харгалзсан оновчтой. Энэ боловсролын агуулгыг тогтоохын тулд бид хүүхдийн ай кю-г мэдэж байх ёстой. Эцсийн зорилго бол хүүхдийн хөгжлийг дэмжих зорилготой л энэ тест боловсруулагдсан гэж ойлгож болно.

Ерөнхийдөө одоо Монголын хэмжээнд тусгай хэрэгцээт боловсрол боловсрол болохоор таны бодлоор ямар түвшинд явж байгаа гэж боддог вэ?

Тийм. Бид Монголын хэмжээнд ямар байна вэ гэдгийг хэлэхийн тулд бусад орны тусгай боловсрол гэдгийг хэрхэн яаж авч үзэж байна вэ? Түүнтэй харьцуулахад ер нь ямар байна вэ? гэдгийг судлах хэрэгтэй. Зарим нь их сайхан сайхан шийдвэр, бичиг баримт, эрх зүйн орчин бүрдээд болж байна гэж байх жишээтэй. Би өөрөө ч Японд энэ чиглэлээр сурсан. Тэнд бас ажиллаж байсан. Ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургуульд, судалгааны байгууллагад ажиллаж байсан. Энэ чиглэлээр гаднын орнуудад явж энэ туршлага судалж байсан, үзэж байсан хүнийхээ хувьд бол яг тэр өнцгөөс харахад арай л доогуур байна аа гэж хэлмээр байна. Яагаад гэдэг дээр бол ер нь бол гаднын орнуудад, жишээлбэл Америкт тусгай боловсролын үйлчилгээ авч байгаа хүүхдүүдийн 70-80 орчим хувь нь ямар хүүхдүүд байна вэ гэхээр танин мэдэхүйн өөрчлөлттэй, суралцахуйн бэрхшээлтэй, зан үйлийн өөрчлөлттэй хүүхдүүд байдаг. Зөвхөн 15-20 хувь нь оюун ухааны, харааны, сонсголын гээд эрхтэн тогтолцооны өөрчлөлттэй хүүхдүүд. Тэгэхээр энэ бол их өөр тоо баримт байгаа биз. Манайд бол ямар зорилтот бүлэг ямар байна вэ гэхээр тусгай боловсролын зорилтот бол зөвхөн бие эрхтний тогтолцоонд нь өөрчлөлт орчихсон, эрүүл мэндийн хандлагаар хандаад оношлогдчихсон ийм хүүхдүүдийг л тусгай боловсролын үйлчилгээнд хамруулна гэсэн ойлголт байгааг харьцуулахад бусад 70-80 хувийн хүүхдүүд ерөөсөө хамрагдахгүй байна гэдэг бол доогуур үзүүлэлт гэж хэлмээр байна.

Одоо тэр 70-80 хувийг эзэлж байгаа хүүхдүүд маань Монголд яг юу хийгээд яваад байгаа юм бэ? Өөрсдийгөө тийм гэдгээ мэдэхгүй л яваад байгаа гэсэн үг үү?

Тэр хүүхдүүд өөрсдийгөө тийм гэж мэдэхгүй. Эцэг эх нь ч бас төдийлөн сайн мэдэхгүй. Яг ингээд хичээл ороод тайлбарласны үндсэн дээр ойлгоно. Энэ чиглэлээр манай Монгол улсын боловсролын их сургууль дээр бол хичээл орж байна, оюутнууд дадлагад гарч байна. Дадлагад гарч байгаа оюутнууд юу гэж хэлж байна вэ гэхээр "Багш аа, яг ийм ийм ийм хүүхдүүд байна аа, одоо яах вэ? Заримдаа эцэг эх нь хүлээн зөвшөөрөхгүй байна. Багш нар нь хүлээн зөвшөөрөөд байна. Энэ хүүхэд суралцахуйн бэрхшээлтэй юм байна. Энэ хүүхэд бол аутизмын хүрээний эмгэгтэй юм байна" гэдэг юм уу. Ийм асуудлууд гардаг. Зарим ойлгосон багш нар зөвлөгөө аваад, энэ чиглэлээр гарсан ном, эх сурвалж, уншаад тэдгээр хүүхдүүдтэйгээ ажиллаад явж байгаа. Зарим багш нар энэ залхуу, зожиг, хичээл хийдэггүй гэсэн ийм хандлагатай л байдаг. Тэгэхээр бид нэг судалгаа хийсэн л дээ. 380 гаруй багш нараас судалгаа авсан. Танайд ямар ямар асуудалтай хүүхдүүд байна вэ гэхэд "анхаарлаа төвлөрүүлж чаддаггүй, хэт хөдөлгөөнтэй, бусадтай нийцэмжгүй ууртай уцаартай хүүхдүүд бол байдаг" гээд яг нөгөө 70-80 хувьд хамаарагдах шинж тэмдэг бүхий хүүхдүүдийг нэрлээд байгаа. Гэсэн хэдий ч тэдгээр хүүхдүүдтэйгээ яаж ажилладаг вэ гэхээр "даалгавар өгдөг, ганцаарчилж ажилладаг, уншуулдаг, бичүүлдэг, тоо бодуулдаг" гэсэн иймэрхүү хариултуудыг өгсөн байдаг. За ингээд ганцаарчилж ажиллаад давтлага өгөөд ажилласны үр дүнд хүүхдүүдэд өөрчлөлт гарсан байна уу, үгүй юу гэдэг ийм асуултад бол өөрчлөлт гараагүй гэдэг нь 50 гаруй хувь, өөрчлөлт гарсан гэдэг нь 10 орчим хувь, ерөөсөө ямар ч ахиц байхгүй байна аа гэдэг бас 20 орчим хувь, нэг иймэрхүү л хариултуудыг өгч байсан л даа. Тэгэхээр энэ дээр ямар дүгнэлт хийсэн бэ гэхээр багш нар яг тэдгээр хүүхдүүдтэй хэрхэн яаж ажиллах нь төдийлөн тодорхой биш байна. Энэ тал дээр арга зүйн дэмжлэг хэрэгтэй юм байна гэсэн дүгнэлтүүдийг хийгээд бид Нагоя их сургуулийн багш нартайгаа хамтраад сургалтуудыг зохион байгуулж байсан. Сүүлийн үед ковидоос болоод энэ сургалтууд завсардчихсан байгаа.

Анх яагаад Нагояагийн их сургуультай хамтраад Хүүхдийн хөгжлийг дэмжих төвийг байгуулах болсон бэ?

55-р сургуульд нэг аутизмтай хүүхэд сурдаг байсан. Яг аутизмын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Аутизмын холбооны захирал эмэгтэй биднийг Нагоя их сургуулийн багштай уулзуулсан. Тэр үед би Японоос ирээд удаагүй байсан. Монголд ийм ийм ийм асуудлууд байна, тусгай боловсрол гэдгийг ийм л хүрээнд ойлгоод байна. Яг аутизмын талаар бас төдийлөн ойлголт байхгүй байна. Энэ тал дээр бол бидэнд бол маш их дэмжлэг туслалцаа хэрэгтэй байна гэсэн саналуудыг тавьсан. Үүнийг Нагоя их сургуулийн багш нар

маш их нааштайгаар хүлээж аваад за энэ чиглэлээр хамтран ажиллах болж, гэрээ хэлэлцээр хийгээд би өөрөө Нагоя их сургуульд зочин профессороор ажиллаад тэгээд бидний хамтын ажиллагаа эхэлсэн. Ингээд төслүүд, судалгааны ажлууд хэрэгжээд явж байгаа. Одоо ч гэсэн Танака бенийг түгээн дэлгэрүүлэх сургалтыг хамтран зохион байгуулж байгаа. Бусад ажлууд, бас судалгааны ажлуудыг төлөвлөөд хийж байна.

Ерөнхийдөө тусгай хэрэг, дээд боловсрол гэж ярихаар ихэвчлэн Японы сургалт ч юм уу, Японд төгссөн хүмүүс байдаг. Тэгээд бас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гээд ярихаар бас Японд тийм юм байсан гээд ч юм уу, тийм загвар туршлага ч юм уу тийм зүйлийг ерөнхийдөө ярьдаг. Монголд тийм хүмүүс маш их байдаг. Тэгэхээр яагаад хөгжлийн бэрхшээл гэж ярихаар Япон гэдэг улс давхар гарч ирдэг юм бол?

Зөвхөн энэ салбарт ч гэлтгүй боловсролын гэдэг юм уу нийгмийн хамгааллын, эрүүл мэндийн гэлтгүй. Ер нь Японы ард түмэн бол зах зээлийн эдийн засаг руу шилжих үед л манай Монголд тусалж эхэлсэн. Түүнээс хойш эдийн засгийн салбар болон бусад салбарт маш их хөрөнгө оруулалт хийж байсан. Сүүлийн үед ялангуяа боловсролын салбарт маш их хөрөнгө оруулалт хийж байна. Энэ тал дээр миний хувьд Японд сурч төгссөн учраас япон хүмүүстэй ойлголцоход илүү дөхөм юм болов уу гэж бодож байгаа. Нагоя их сургууль бол Япондоо тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийг, аутизмын хүрээний эмгэг, анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэг, суралцахуйн бэрхшээлийг манайд төдийлөн оношлогдоогүй чиглэлээр ажиллах бол маш их туршлагатай. Бидний хамтарч ажиллаж байгаа төв маань одоо 60-70 жилийн түүхтэй, яг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулаад ирсэн, хүүхдийн хөгжлийн үнэлгээ оношилгоо хийдэг, зөвлөгөө өгдөг. Ийм төвтэй бид хамтарч ажиллаад би бас саналаа хэлээд энэ төвийг бол Монголд байгуулмаар байна гэдэг санал хэлсний үндсэн дээр энэ хоёр сургуулийн удирдлага энэ чиглэлээр маш сайн ойлгож дэмжиж энэ төвийг байгуулсан түүхтэй. Одоо төв маань байгуулагдаад 4-5 жил болж байна.

Та Японд төгсөж ирээд яагаад боловсролын салбарт ажиллаад энэ салбараа хөгжүүлье гээд сэтгэл шулуудаад явсан бэ?

Би Зөвлөлт Холбоот Улсад Багшийн дээд сургууль төгссөн. Энэ чиглэлээр ажилласан. Эхлээд хараа, сонсголын бэрхшээлтэй хүүхдийн сургуульд ажиллаж байсан. Дараа нь оюун ухааны бэрхшээлтэй хүүхдүүдийн чиглэлээр өөрийн судалгаагаа хийсэн. Тэгэхээр яагаад оюун ухааны бэрхшээлтэй хүүхдүүдийн талаар судалгаа хийсэн бэ гэдэг дээр бол Боловсролын яаманд 1993-1995 онд ажиллаж байхад оюун ухааны бэрхшээлтэй хүүхдүүдийг оношлох оношилгооны аргачлал дутмаг юм байна, оюун ухааны бэрхшээлтэй хүүхдүүдийг

хамруулдаг тусгай сургуульд зөвхөн оюун ухааны бэрхшээлтэй хүүхдүүд биш өөр бусад хүүхдүүд байсныг ажигласан. Яаж оношилдог, хүүхдүүд маань яг үнэхээр оюун ухааны бэрхшээлтэй юм уу, үгүй юу гэдгийг тодруулах шаардлагатай юм байна гэдэг судалгааны асуудлыг дэвшүүлээд энэ чиглэлээр судалгааныхаа ажлыг хийгээд ямар үр дүнд хүрсэн бэ? гэхээр 1998 онд би докторын хөтөлбөрт хамрагдаад судалгаа хийж эхэлсэн. 2002 онд судалгаа хийгаад дууссан. Энэ хооронд хийсэн ажлын маань үр дүн юу гэж гарсан бэ гэхээр тусгай сургуульд хамрагдаж байгаа хүүхдүүдийн 60 хувь нь хөнгөн хэлбэрийн ухааны бэрхшээлтэй юм байна. 40 хувь нь бол ерөөсөө оюун ухааны бэрхшээлгүй юм байна. Оюун ухааны ай кю нь дундаж үзүүлэлттэй, зарим хүүхдүүдийнх бүр өндөр үзүүлэлттэй. Ийм хүүхдүүд тусгай сургуульд хамрагдаж байна. Тэгэхээр энэ оношилгооны аргачлалыг маш нарийвчилж гаргаж ирэх шаардлагатай гэдэг дүгнэлтүүдийг өөрийнхөө диссертацийн дүгнэлтэд бичиж байсан л даа. Дараа нь ийм боломж гараад Нагоя их сургуультай хамтраад энэ аргачлалыг боловсруулаад одоо харьцуулаад бас тусгай сургуульд яг ямар хүүхдүүд байна гээд энэ аргачлалаараа шалгаад үзэх юм бол бас өөр үр дүн гарах байх л даа.

Сүүлийн жилүүдэд тэгш хамруулан сургах гээд их ярьж байгаа шүү дээ. Тэгээд тусгай сургуульд оюун ухааны хувьд яг дундаж ч юм уу тэднээс дээшээ хүмүүс зөндөө хүмүүс хамрагдсан байгаа шүү дээ. Тэгэхээр тэгш хамруулахыг ер нь таны өнцгөөс юу гэж хардаг вэ?

Тийм. Тэгш хамруулан сургах боловсролын бодлогыг одоо дэлхий нийтээр боловсролын хөгжлийн чиг хандлага болгон баримталж байна. Тэгэхээр тэгш хамруулах боловсролын талаар бас л ялгаагүй тусгай боловсролыг юу гэж ойлгох юм, тусгай хэрэгцээтэй хүүхдүүд гэж хэнийг хэлэх юм гэдгийг улс орнуудад өөр өөрсдийн тодорхойлолтоо гаргачихсан байдаг. Олон улсын ч тодорхойлолтууд байдаг. Ямарваа нэгэн ялгаварлан гадуурхалтаас ангид хүүхэд бүрт хүртээмжтэй, чанартай боловсролыг эзэмшүүлэх үйл явц гэсэн байдаг. Энэ бол бас нэлээн ерөнхий тодорхойлолт. Үүнийг манай багш нар хэрхэн ойлгоод байна вэ гэхээр яг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг л ерөнхий боловсролын сургуульд сургачих юм бол энэ бол тэгш хамруулалт болно гэсэн нэг ийм ойлголт яваад байдаг. Энэ дээр бол яг тэгш хамруулан сургах, боловсролыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд энэ 4 орчин нөхцөл бүрдсэн байх ёстой гэсэн ийм судалгааны үр дүн, чиг хандлага бас байгаад байсан. Тэр дөрвөн орчинд нь юу орох вэ гэхээр эрх зүйн орчин, тэгэхээр эрх зүйн орчин гэдэгт яг ингэж хамруулах боловсролыг юу гэж ойлгох юм, хэрхэн яаж хэрэгжүүлэх вэ гэдэг ийм бодлогын бичиг баримт байх ёстой. Сэтгэл зүйн орчин. Эдгээр хүүхдүүдийг ямар ч хүүхэд байсан сурах боломжийг нь хангаж өгсөн байх ёстой гэсэн ийм сэтгэл зүйн орчныг бол бүрдүүлэх ёстой. Энэ дээр ялангуяа багш нар, сургуулийн удирдлага маш их чухал үүрэг оролцоотой.

Материаллаг орчин зайлшгүй байх ёстой. Боловсролын орчин, эрх зүйн орчин, материаллаг орчин, сэтгэл зүйн орчин гэсэн энэ дөрвөн орчин зайлшгүй байж байж тэгш хамруулах боловсрол амжилттай хэрэгжих нөхцөл боломж, бололцоо нь бүрдэнэ гэсэн ийм зүйл байна. Тэгэхээр манайд бол яг хаана энэ хүүхдүүдийг сургах вэ гэдгийг нь хамгийн нэгдүгээрт тавьчихаад байна. Яаж сургах вэ, ямар орчин нөхцөл байх вэ гэдгийг нь бол хоёрдугаарт тавьдаг ч гэдэг юм уу. Эсвэл зарим тохиолдолд бүр орхигдуулчихсан байдалтай байна. Тэгэхээр тийм тохиолдолд хэрэгжихэд бол хүндрэлтэй л дээ. Тэгэхээр яг хэн энэ хүүхдийг хариуцаад цааш нь хөгжүүлээд явах юм, яаж хөгжүүлэх юм, ямар орчин нөхцөлд байх юм гэдэг энэ орчин нөхцлийг нь маш сайн бий болгож байж энэ тэгш хамруулах боловсролын үйл ажиллагаа амжилттай хэрэгжинэ. Энэ тал дээр багш нарын арга зүй, орчин, нөхцөл байдал гэдэг дээр анги дүүргэлт, гаднын орнуудад бол туслах



багш ч гэдэг юм уу, дэмжлэг үзүүлдэг багш ч гэдэг юм уу гэж байгаад энэ багш нар нь хамтраад энэ хүүхдэд ямар агуулгаар, ямар арга зүйгээр, ямар хэрэглэгдэхүүн ашиглаад сургалт явуулах вэ гэдэг зүйлийг бол хамтраад хийгээд хэрэгжүүлээд явдаг. Яг энэ нөхцөл байдал одоогоор манай Монголд хараахан бүрдээгүй байна. Гэсэн хэдий ч сайн туршлага хуримтлуулаад хэрэгжүүлээд явж байгаа зарим нэг сайн сургуулиуд байна. Би сүүлийн 2-3 жил "Хүүхдийг ивээх сан"-тай хүүхэд нэг бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих төсөл дээр хамтарч ажилласан. Энэ төсөлд хамрагдсан сургуулийн багш нар энэ талын ойлголттой болж, арга зүйдээ өөрчлөлт оруулж орчин, нөхцөл байдлаа бий болгосон. Ганцхан орчин нөхцөл гэдэг дээр одоо нэг ангид 40 гаруй хүүхэд байх ч гэдэг юм уу, тусгайлсан бэлтгэсэн хэрэглэгдэхүүн байхгүй ч гэдэг юм уу асуудал бэрхшээлүүд тулгараад байгаа.

Таны бодлоор 4 орчин нөхцөл бүрдэхгүй байгаа шалтгаан нь юу вэ? Хууль тогтоомждоо байна уу, мөнгө санхүүдээ байна уу?

Энэ тал дээр мэдээж мөнгө санхүүгийн асуудал байна. Мөнгө санхүүгийн асуудлыг нэг дор шийдэх боломж байхгүй. Тиймээс эрх зүйн орчныг маш сайн бүрдүүлэх хэрэгтэй. Эрх зүйн орчин гэдэгт төр засгаас гаргаж байгаа, шат шатандаа гаргаж байгаа бичиг баримтууд байна. Түүнийг маш сайн судалж байж яг бодит байдалд нийцсэн байдлаар эрх зүйн орчныг зөв бүрдүүлээд явбал хэрэгжээд явах боломжтой. Тэгэхээр эрх зүйн орчин гэдэгт маш их асуудал байна.

Эрх зүйн орчноо бүрдүүлэхийн тулд энэ чиглэлийн мэргэжлийн экспертүүдийг хэр оруулж, бодлогоо тодорхойлж, бичиг баримтуудаа гаргадаг вэ?

Биднээс санал авдаг. Ийм ийм журам гаргах гэж байна, саналаа өгөөч гэдэг. Санал гаргадаг. Зөвхөн би ч гэлтгүй бусад мэргэжлийн хүмүүс хэлж байгаа. Бүр бичгээр явуулдаг. Гарсан бичиг баримтад бидний нарын саналыг бол төдийлөн тусгаагүй байдаг. Тусгаагүйн улмаас сургууль дээр зөрчлүүд гардаг. Одоо яг ямар зөрчил гарч байна вэ гэхээр сургууль дээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байдаг. Энэ хөгжлийн бэрхшээлтэй, энэ тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхэдтэй гээд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс гээд салбар комиссууд энэ хөгжлийн бэрхшээлтэйг тодорхойлдог. Энэ дээр нэг жишээ авъя л даа. Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй гээд тодорхойлчихдог. Тэр хүүхдэд дэмжлэг үзүүлэх орчин нөхцөл нь ерөнхийдөө бүрдчихсэн гэж үзэж болно. Гэсэн хэдий ч тэр хүүхдийн энэ оношилгоо, үнэлгээ яаж явагдсан бэ гэхээр эрүүл мэндийн хандлагаар явагдсан байдаг. Яг боловсролын тусгай хэрэгцээ нь юу юм бэ гэдэг нь төдийлөн ойлгомжтой биш. Боловсрол талаасаа тэр хүүхдэд яаж дэмжлэг үзүүлэх вэ гэдэг нь бас төдийлөн тодорхой биш. Ийм асуудал тулгараад байдаг. Нөгөө талаас анхаарлаа

төвлөрүүлж чаддаггүй, хэт хөдөлгөөнтэй ийм хүүхэд ерөнхий боловсролын сургуульд сүүлийн үед бол маш их олширч байна. Тэдгээр хүүхдүүдтэй ингээд ганцаарчилж ажиллая, дэмжлэг үзүүлье гэхээр яг албан ёсоор тэр хүүхдүүдийг хөгжлийн бэрхшээлтэй гэж тодорхойлоогүй. Тийм учраас тэр хүүхдэд бол дэмжлэг үзүүлэх орчин нөхцөл байдал нь бүрдээгүй байх жишээтэй. Яагаад гэвэл Боловсролын яамнаас гаргасан 292-р тушаал байгаа. Тэр болохоор зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулах гэсэн журам гаргасан байдаг. Тэгэхээр хөгжлийн бэрхшээлтэй гэдэгтээ нөгөө 6 ангиллаа л оруулчихдаг. Тэр 6 ангилалд нь багтаагүй хүүхдүүд бол дийлэнх хувийг эзлээд байдаг. Тэгэхээр энэ хүүхдийн талаар асуудлыг хөндөх боломжгүй болчихоод байгаа юм. Энэ тал дээр ерөнхий боловсролын сургуулийн багш нар "ийм, ийм асуудалтай хүүхдүүд их байна аа, багш аа яах вэ" гээд. Тэгэхээр энэ оноштой оношгүй, хөгжлийн бэрхшээлтэй гэдэг тодотголтой тодотголгүй хүүхдээ дэмжээд явахаас өөр арга байхгүй. Дэмжих арга зүй нь бол ийм юм байна аа гэдэг талаар бол бид нар зөвлөгөө өгөөд явж байгаа л даа.

Сүүлийн үед нэг ангид бараг гуч, дөч, дөчөөс дээш хүүхдүүд байгаа шүү дээ. Нэг л багштэй. Тэгээд тэр дунд одоо жишээлбэл, анхаарал нь удаан, анхаарал нь тогтворгүй хүүхэд байлаа гэхэд багш маань ганцаараа хүүхэдтэй тулж ажиллахад хүндрэлтэй байдаг. Тэгэхээр энэ асуудал ерөнхийдөө яаж шийдэгдвэл зүгээр юм бол?

Тийм. Тэгэхээр энэ бас л нөгөө орчин бүрдээгүй байна гэсэн үг. Тэгэхээр энэ орчныг яаж бүрдүүлж ирж байна вэ? Ямар туршлага байна вэ гэхээр Японд ерөнхий боловсролын сургууль бүрт тусгай боловсролын координатор гэж мэргэжлийн хүн байдаг. Энэ мэргэжлийн хүмүүс энэ хүүхэдтэй яаж ажиллах вэ, хэрхэн ажил болох вэ? зэрэг асуудлуудыг хариуцаад зохицуулаад явдаг. Түүнээс гадна хүүхдийнхээ онцлогоос хамаараад тухайн хүүхдэд тухайн ангид туслах багш гэж ажилладаг. Нэг ангид ерөнхий эрдмийнхээ хичээлийг заагаад явдаг нэг багш байх жишээтэй. Хажууд нь туслах багш гээд багаар хамтарч ажиллаад хүүхдийг дэмжээд явдаг туршлагууд бол байдаг. Тэгэхээр энэ орчин нөхцлийг бүрдүүлэх тал дээр судалгаа хийж, ямар хүмүүсийг ерөнхий боловсролын сургуульд ажиллуулах вэ гэдэг дээр арга шийдэл гаргавал их ахиц дэвшил гарах болов уу гэж бодож байна. Ер нь бол энэ тэгш хамруулах боловсрол хөгжсөн улс орнуудад энэ хамтарч ажиллах, багаар ажиллах, нэг ангид хоёр багш буюу туслах багштай байх гэдэг асуудлыг шийдээд хэрэгжүүлээд, ялангуяа сургууль болгонд тусгай боловсролын координатор ажиллаад явдаг.

Та сая сэтгэл зүйн орчин гээд дурдсан. Тэгэхээр энэ сэтгэл зүйн орчин гэдэг нь тухайн багш болон сургуулийн удирдлагууд тухайн хүүхдээдээ хандах

хандлага юм уу? Яг юу байдаг юм бол?

Тэр нь тийм дээ. Сэтгэл зүйн орчин гэдгийг бол хамгийн нэгдүгээрт тавих ёстой. Сургуулийн удирдлага, сургуулийн бусад ажилтнууд орно. Мэдээж хамгийн нэгдүгээрт бол анги удирдсан багш байна. Тэгээд сургуулийн хүүхдүүд тухайн тусгай хэрэгцээтэй хүүхдийг бас зөв ойлгож хүлээж авах ёстой, ялгаатай байдлыг нь хүндлэх ёстой. Зөвхөн хүүхдүүд гэлтгүй хүүхдүүдийн эцэг эхчүүд бас зөвөөр ойлгож хүлээж авах ёстой. Тэгэхээр хэрхэн яаж ойлголт өгөх вэ гэдэг дээр нарийн заавар, зааварчилгааг бид сургалтын үеэр өгөөд явдаг. Энэ ажлыг хийж байж л сургуулийн бүрэлдэхүүн, нэг хэсэг би мөн байна аа гэдэг ойлголт авч байж тэр хүүхэд таатай орчин, нөхцөл байдалд сурна уу гэхээс биш хэрвээ ямар нэгэн байдлаар ялгаварлан гадуурхах юм бол суралцах таатай орчин, нөхцөл байдал бүрдэхгүй тохиолдолд бол энэ нь хэн хэндээ эрсдэлтэй. Тэр тусгай хэрэгцээтэй хүүхдүүдэд ч эрсдэлтэй, нөгөө бусад хүүхдүүдэд ч гэсэн эрсдэлтэй. Ийм суралцах таатай, аюулгүй орчин нөхцлийг бий болгосон тохиолдолд хүүхэд цаашид хөгжих боломж нь бүрдэнэ.

Одоо Монгол улсын хэмжээнд тусгай хэрэгцээт боловсролыг олгох хүний нөөц хэр хангалттай гэж боддог вэ? Би бусад МСҮТ-ийн удирдлагатай ярилцаад үзэхээр хүний нөөц дутмаг байна гэж ярисан.

Монгол улсын хэмжээнд тусгай хэрэгцээт боловсрол олгох гээд ярьдаг. Яг ямар хүмүүс энэ тусгай хэрэгцээтэй хүүхдүүдтэй ажиллах юм бэ гэдэг дээр багшийн суурь мэргэжлийн хичээлүүдийг үзсэн мэргэжилтнүүд эдгээр хүүхдүүдтэй ажиллах боломжтой. Жишээлбэл, аутизмтай, аутизмын хүрээний эмэгтэй хүүхдүүдтэй ажиллана гэвэл аутизмын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн байгууллагууд гаднын орнуудад байдаг. Энэ чиглэлээр ер нь нэг сарын сургалтад хамрагддаг ч гэдэг юм уу, гаднын орнуудад бол эдгээр хүмүүсийгээ давтан бэлтгээд сургаад явдаг. Тийм учраас энэ давтан бэлтгэх ажлыг манай Боловсролын их сургууль хийж болно, энэ чиглэлээрээ хийгээд ч ирсэн. Багш нарын мэргэжил дээшлүүлэх ажлыг хийгээд явахад тийм хүндрэлтэй асуудал биш. Тэгээд энэ чиглэлээр сүүлийн үед "Хүүхдийг ивээх сан"-тай хамтарсан төслөөр маш олон багш нарыг бэлтгэж гаргасан. Эдгээр багш нар хүүхдүүдтэйгээ маш амжилттай ажиллаад арга зүйн өөрчлөлт шинэчлэлтүүдээ хийгээд хөтөлбөртөө тохиргоо хийгээд хүүхдүүдийг амжилттай сургаад хөгжүүлж байгаа сайн туршлага бас байна. Тэгэхээр энэ хандах хандлага, үзэл баримтлалд л маш сайн өөрчлөлт оруулах хэрэгтэй.

Монголд хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэхээр хандлага нь сөрөг байдаг шүү дээ. Энэ хандлагыг нь өөрчлөхийн тулд юу хийх шаардлагатай вэ?

Тийм. Ер нь "хөгжлийн бэрхшээл" гэдэг үг өөрөө энэ сөрөг хандлагыг бий болгоод

байгаа гэж би хардаг юм. Тэгэхээр энэ англиар бол “дизабилити” гэж үг байгаа л даа. Түгээмэл хэрэглэгддэг яг энэ чиглэл энэ салбарт хэрэглэгддэг үг. Тэгэхээр өөрөө бас англи хэл мэдэх байх. Бусад англи хэл мэдэж байгаа хүмүүс бол энийг яг зөв орчуулъя гэх юм бол “абилити” гэдэг үг нь болохоор “чадвар” гэсэн үг. “Диз” гэдэг энэ угтварыг бол “өөрчлөлт, алдагдал” ч гэдэг юм уу. Ийм байдлаар ойлгож болно. Тэгэхээр “чадварын өөрчлөлттэй”, “чадварын алдагдалтай”, “үйлдлийн өөрчлөлттэй”, “үйлдлийн чадварын өөрчлөлттэй” ч гэдэг юм уу. Ингэж ойлгож монгол хэлнээ буулгах байтал шууд “хөгжлийн бэрхшээл”, “хөгжлийн бэрхшээлтэй хүн” гээд буулгачихсан. Тэгэхээр “хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэсэн сөрөг хандлагаар орчуулаад үг, үйлдлийг бий болгодог гэдэг шиг сөрөг хандлагатай учраас энэ ер нь хөгжиж чадахгүй юм болов уу гэсэн хандлагаар л хүлээж авдаг. Тэгэхээр энэ чадварын өөрчлөлттэй хүмүүс чинь жишээлбэл, сонсголгүй



байлаа гэхэд дохионы хэлээрээ ярьчихаж байна, өөрчлөлттэй. Тэгэхээр бид нар дохионы хэлээр ярьж чадахгүй, тэгвэл бид нарыг дохионы хэлний бэрхшээлтэй гэвэл яаж байна вэ гэхээр бас л бид нарыгаа ялгаварлан гадуурхсан юм шиг болчихож байна. Тэгэхээр сүүлийн үед бол энэ сөрөг хандлагатай үгнээс татгалзах хэрэгтэй гэдэг ийм зөвлөмж олон улсын байгууллагуудаас гаргаад өөрчлөөд явж байгаа. Тэгэхээр манайх ч гэсэн энэ сөрөг хандлагатай "хөгжлийн бэрхшээл" гэдэг нэр томьёо, үг хэллэгээ өөрчлөх шаардлага гарч байна. Би ямар санал дэвшүүлээд байна вэ гэхээр яг боловсролын салбартаа энэ боловсролын "тусгай хэрэгцээ" шаардлагатай хүүхдүүд, эрүүл мэндийн салбарт бол яг тэр өвчин согогоор нь нэрлээд явахад болохгүй юм байхгүй. Эсвэл бүр эрэг үг хэллэг хэрэглэнэ ээ гэвэл "эрүүл мэндийн дэмжлэг шаардлагатай" ч гэдэг юм уу. Эрүүл мэндийн салбарынхан нь өөрсдөө нэрлээд явах байх л даа. Бүр болохгүй бол "хөгжлийн ялгаатай", "хөгжлийн онцлогтой" ч гэдэг юм уу. Ийм байдлаар энэ үг хэллэгээ өөрчлөх юм бол хүмүүсийн хандлага бол бас өөрчлөгдөх байх. Тэгэхээр багш нараас танайд ямар ямар бэрхшээлтэй хүүхэд байна вэ гэхээр л яг ийм бэрхшээлтэй гээд л баахан бэрхшээлд дурдчихдаг. Танайд ямар онцлогтой хүүхэд байна вэ гэхээр ийм дуулах авьяастай ч гэдэг юм уу, энэ хөдөөнөөс ирсэн ч гэдэг юм уу ийм гээд онцлогуудыг нэрлээд явдаг. Асуулт яаж тавихаас хамаараад хариулт нь бас арай өөр байна. Тэгэхээр "хөгжлийн онцлогтой" гээд нэрлэх юм бол бас хандах хандлага нь ч гэсэн өөрчлөгдөх болов уу гэж бодож байна.

Манай подкастын цаг өндөрлөх дөхөж байна. Тэгээд танаас сүүлийн асуултаа асууя? Ковид цар тахлын нөлөө тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдүүдэд болон Монгол улсын боловсролын их сургуульд, таны ажилд хэрхэн нөлөөлж байна вэ?

Дэлхий даяар цар тахал одоо хамрагдаад эрэг нөлөө ч байна, сөрөг нөлөө нь мэдээж давамгайлчихсан байна. Ялангуяа энэ тусгай хэрэгцээтэй хүүхдүүдтэй ажиллах орчин, нөхцөл байдал гэдэг бол яг нэг тусгайлсан бэлдсэн ийм орчин нөхцөл байх ёстой. Багш нар нь хүүхдүүдтэйгээ тулж ажиллах ёстой байдаг. Тэгэхээр энэ тал дээр бол энэ хүүхдүүд маань маш их хүнд байдалд орсон байдалтай байна. Тэгэхээр энэ тал дээр бол асуудал хүүхдүүдэд байна гэдэг өнцгөөс харах биш, асуудал бол одоо эргэн тойронд бид нарт байна, бид энэ асуудлыг хэрхэн яаж шийдвэрлэх вэ гэдэг дээр бол хүн бүр дор дороо ажиллаж өөрсдийн санал бодлоо дэвшүүлж, хамтран ажиллаад олон асуудлуудыг даван туулахад бол хувь нэмрээ оруулах байх аа гэж бодож байна. Дахин хэлэхэд, сэтгэл зүйн орчин гэдэг бол маш их чухал л даа. Саяын "хөгжлийн бэрхшээл" гэдэг үг ч байна. "Хоцрогдолтой хүүхдүүд", "хоцрогдолд орсон хүүхдүүд " гэж сүүлийн үед бас их яриад байна л даа. Тэгэхээр "хоцрогдолд орсон хүүхдүүд" гэхээсээ илүү энэ хоцрогдлыг бий болгосон учир шалтгаан, энэ хоцрогдлыг

даван туулахын тулд бид юу хийх ёстой юм бэ гэдэг өнцгөөс харж энэ ажлууддаа эхлүүлээд хийгээд явах шаардлагатай юм болов уу. Тэгэхээр энэ дээр бол энэ нэр томьёо үг хэллэг, асуудалд хандах хандлага, эерэгээр хандах хандлага гэдгийг бол бас их чухалчилж авч үзмээр байна. Амьдралд байдаг хамгийн том бэрхшээл бол сөрөг хандлага байдаг гэж ярьдаг. Тэрнээс биш яг энэ хүүхдүүд асуудалтай байгаа юм биш. Бидний хандлага гэдгийг л их чухалчилж авч үзмээр байна л даа. Тэгээд энэ эерэг хандлагыг бий болгохын тулд бид өөрсдөө яаж өөрчлөгдөх ёстой юм бэ, энэ орчин нөхцлөө яаж сайжруулах ёстой юм бэ гэдэг дээр л хамтарч ажиллаж өөрчлөлт шинэчлэлтийг хийх шаардлага үүсэж байна. Тэгэхээр энэ тал дээр хүүхдүүдтэй ажиллах арга зүй, мэдээлэл технологийн хэрэгслийг ашиглаад тусгай хэрэгцээтэй хүүхдүүдтэй яаж ажиллах вэ гэдэг цоо шинэ салбар гарч ирж байна. Энэ тал дээр зарим эцэг эхчүүд, зарим энэ мэдээлэл технологийн салбарын ажилтнууд маш их хувь нэмрээ оруулаад аппликэйшн гаргаад түүгээрээ дамжуулаад багш нартай, эцэг эхчүүдтэй, хүүхдүүдтэй харьцах боломжийг бүрдүүлж байна. Үүнийг олон нийтэд түгээн дэлгэрүүлээд, энэ чиглэлийн туршлагыг судлаад, суралцаад, сургалтынхаа үйл ажиллагаанд нэвтрүүлээд явбал энэ ковидын үеийн хүндрэлүүдийг давах боломж гарах болов уу гэж бодож байна.

За цаг зав гарган манай подкастад орсон танд маш их баярлалаа. Таны цаашдын ажил үйлсэд амжилтыг хүсье!

ХБИ-Д ЗОРИУЛСАН ХӨГЖЛИЙН АСАРГААНЫ ТӨВ БИЙ БОЛООСОЙ ГЭЖ ХҮСДЭГ

Ш.Мөнхцэрэн



Энэхүү дугаарт Монголын дауны холбооны удирдах зөвлөлийн гишүүн Мөнхцэрэн оролцож байна. За та манай урилгыг хүлээн авч манай подкастад оролцсонд маш их баярлалаа.

Та юуны түрүүн манай сонсогчдод яагаад анх Дауны холбоонд элсэх болсон тэгээд цаашлаад удирдах зөвлөлд нь орох болсон талаар, өөрийнхөө талаар товч танилцуулахгүй юу?

За баярлалаа. Бүх сонсогчиддоо, бас сонсож байгаа ээж аавуудаа энэ өдрийн мэндийг хүргэе.

Би 2005 онд хүүгээ төрүүлсэн. Тэгээд хүү маань бол Дауны синдром гэсэн оноштой төрсөн. Тэгээд 2005 онд төрөөд, тэгээд эхний 1-3 жил хүүгээ хүлээн зөвшөөрөх, хүүтэйгээ яаж ажиллах вэ гэдэг учраа олох гэж нэлээн цаг хугацааг өнгөрөөсөн. Тэгээд энэ хооронд бол мэдээж төрсөн цагаасаа эхлээд л дауны синдром гэж юу вэ, ер нь цаашид ирээдүй нь ямар байх юм бэ гэдэг талаар олон эрэл сурлыг хийгээд явсаар байгаад 2006 оны үеэс Оюун гишүүн ба хэсэг эцэг эхчүүдийн холбоо байгуулж байгаа гэдгийг сонсоод л байсан. Тэгээд 2008 онд бол албан ёсоор Дауны холбоог сураглаж очоод уулзсан. Тэгээд уулзахад холбоонд даунтай хүүхэдтэй эцэг эхчүүд бүртгүүлж байгаа юм, танай хүүхэд бол гуч дахь хүүхэд байна гэж бүртгэж авч байсан юм. Тэрнээс хойш бол энэ Дауны холбоотой байнга хамтарч ажиллаж байгаа. Тэгээд мэдээж Дауны холбооны гишүүн байхаасаа гадна бол ерөөсөө

л идэвхтэй гишүүн байхыг зорилгоо болгоод 2010 он хүртэл гишүүн байж байгаад 2011-2012 оны үеэс холбоондоо нэлээн идэвхтэйгээр ажиллая гээд, тэгээд Уянга гишүүн ч гэсэн нэлээн дэмжээд холбоондоо удирдах зөвлөлдөө орох саналыг тавьсан. Тэгээд л өдий хүртэл явж байна даа.

Та анх хүүгээ төрүүлчихээд байж байх үед Монгол улсад дауны синдромын талаарх ойлголт хандлага хэр байсан бэ? Хүмүүс хэр их мэддэг байсан бэ?

За ер нь 2005 онд хүүхдээ төрүүлэхэд би өөрөө ч дауны синдромын талаар ямар ч ойлголтгүй байсан. Ер нь тэр үеийн миний уулзаж учирч байсан хүмүүсийн хувьд ч гэсэн мэдээлэл маш бага байсан л даа. Зүгээр яах вэ, даун гэдэг үгийг сонсож байсан боловч тэр яг юу юм бэ гэдгийг бол огт мэддэггүй. Хүүхдээ яг төрүүлээд би баасан гарагт төрсөн. Тэгээд төрөхөд хагас, бүтэн сайн, маргааш нь амралтын өдөр таарчихсан учраас нярайн эмч маань бол хүүхдийг маань бол үзээгүй. Тэгээд нэг дэх өдрийн өглөө эцэг эхүүд хүүхдээ үзүүлээд эмнэлгээс гарах болоход нярайн эмч орж ирж үзсэн. Тэгээд бүтэн ингээд амралтын хоёр өдөр ингээд өнгөрчихсөн байсан учраас нярайн эмч орж ирээд үзээд та хоёр гарахгүй гээд л тэгээд л тасагтаа дөрөв тавуулаа байсан. Бүгдээрээ л за одоо гар гэж байна, гар гэж байна гээд өглөө гарна гэсэн. Нярайн эмч үзээд л хүүхдүүдийг эмнэлгээс гаргана гэчихсэн учраас манай гэр бүлийнхэн эмнэлгийн гадаа цэцэг бариад л ирчихсэн хүлээж байсан. Яг гарах тэр агшинд эмч харангуутаа та хоёр гарахгүй гээд өөр юм хэлэхгүй, тэгээд энэ үзлэгийн дараа манай өрөөнд яваад очоорой гээд л ингэж хэлээд л явчихсан. Тэр эмч бүх хүүхдүүдээ үзэж дуусах хүртэлх хугацаанд бол ингээд л яачихсан юм бол гэдэг л айдастайгаар хүлээж байсан. Тэр хугацаа чинь надад бол аймаар урт санагдаж байгаа юм чинь. Ингээд л маш удаан л хүүхдүүд үзээд байгаа юм шиг. Яараад л эмчийн өрөөнд яваад очсон чинь та хоёр дауны синдромтой гээд л. Тэгэхээр нь дауны синдром гэж юу юм бэ эмчээ гэсэн чинь энэ удамшлын өвчин, оюуны бэрхшээлтэй хүүхэд гарсан байна шүү дээ гээд л. Ингээд л тэгээд л тэр оюуны бэрхшээл гэдэг үг бол өөрөө ерөөсөө маш хэцүү. Тэгээд л гайхаад л, тэгээд ер нь үндсэндээ бол шокт л орчихож байгаа юм л даа. Эмч баахан юм ярисан хүлээж авч чадахгүй байгаа учраас би манай нөхөр гадаа байгаа юм уу, та манай нөхөрт хэлээд өгөөч гээд нөхрийгөө дуудаж оруулаад л эмчтэй уулзуулсан. Тэгэхээр бол ерөөсөө яг манай гэр бүлийн хувьд бол үнэхээр энэ дауны синдромын талаар ямар ч ойлголтгүй, тэгээд тэр чинь одоо хагас бүтэн сайнд хүүхдээ эмчид үзүүлээгүй өнгөрөөчихсөн байсан хооронд хүүхдэд маань шарлалт гэдэг юм явагдчихсан байсан юм байна. Тэгээд хүчтэй шарлалт явагдчихсан учраас бид хоёр дахиад тав хоног болоод шарлалтын эмчилгээ хийлгэхээр тэндээ үлдэж байгаа юм л даа. Үндсэндээ эмнэлэгт хэвтсэн долоо хоног маань бол ер нь маш хүнд.

Дөнгөж төрчихсөн гэхэд хажууд ирээд тайвшруулах эмч, сувилагч байсангүй. Тэр хэдэн шөнүүд бол миний амьдралын хамгийн хар дарсан өдрүүд байсан. Уйлаад л, хүүхдээ тэврээд л, уйлаад л яахаа мэдэхгүй өнжиж байсан өдрүүд. Тэгэхэд нөхөр маань мэдээж бас л ингээд л ингэдэг юм байна, ийм юм байна гээд л бас л янз бүрийн хүн рүү утасдаад л хайгаад л. Тэгээд л намайг тайвшруулаад л ингээд л өнгөрсөн. Одоо хүүхэд маань арван тавтай, удахгүй арван зургаа хүрэх гэж байгаа. Хэдий арван зургаан жил өнгөрсөн ч гэсэн энэ бол миний амьдралын хар өдрүүд байлаа. Хүүгээ өлгийдөж авсан дауны синдромтой хүүхдийг хүн дауны синдромтой юм байна, хэдий ийм бэрхшээлтэй ч болон аягүй хөөрхөн хүүхдүүд төрдөг юм аа гэдгийг эмч хэлээд өгсөн бол тэр өдрүүд ийм хүнд өнгөрөхгүй байсан байх гэж би одоо ч ер нь боддог, тэрэндээ ч бат итгэлтэй байдаг. Тэгээд л өнгөрсөн тийм өдрүүд байсан. Эхний нэг жил хоёр жил хүүхдээ хүлээн зөвшөөрч чаддаггүй юм байна лээ. Манай хүүхэд харахаар хэвийн санагддаг учраас ерөөсөө хүлээн зөвшөөрч чадахгүй явсаар байгаад Эх нялхасын төв дээр нэг эмч, та хоёр эргэлзээд байгаа бол хромсомыг нь тоолуулчих гэсэн. Бид хоёр судалж хамгийн сүүлд нь Бээжинд очоод хүүхдийнхээ хромсомыг тоолуулаад



яах аргагүй дөчин зургаа дээр нэмэх нэг буюу дөчин долоон хромсомтой юм байна гэж тоологдсон. Ингээд энэ цаг үеэс бол хүүхдээ хүлээн зөвшөөрсөн учраас хүүхдээ цааш нь яаж хөгжүүлэх вэ гэдэг судалгаа маш сайн хийж эхэлсэн гэсэн үг л дээ.

Тэр цаг үед ер нь олон эцэг эхчүүд яг л ийм л бэрхшээлтэй тулгарч байсан. Яг үүний зөвлөгөөг сайн өгдөг газар байгаагүй. Эх нялхсын төвд бол хэмжилтийн тасгийн нэг эмч, удамшлын тасгийн эмч Оюунчимэг гэж эмч зөвлөгөө өгдөг гэсэн. Ер нь эмч нар бол мэддэг л юм байсан юм байна лээ. Ингээд хүүхдээ тэврээд л очихоор эмч нь нар та хоёр нэг удамшилд үзүүлнэ байгаа гэдэг юмыг бол хэлдэг, энэ нь юу гэсэн үг вэ гэхээр энэ хүүхэд дауны оноштой юм байна аа гэдгийг бол эмч нар хараад л мэддэг. Ер нь даунтай хүүхдийг бол харахад ялгараад байдаг. Одоо би бол одоо хэдийгээр зүгээр ээж ч гэсэн гудамжинд ингээд явахад даунтай хүүхдийг хараад л шууд таньдаг. Гол нь манай эмч нарын талаар надад бодогддог бодол бол даунтай хүүхэд ямар зан үйлтэй юм, ямар хөгжилтэй, ямар хөгжлийн асуудалтай байдаг юм бэ гэдгийг хүмүүст зөв ойлгуулах тэр хандлага маш учир дутагдалтай байсан юм байна гэж бодсон. Яг л энэ бэрхшээлийг даваад яагаад энийг бид нарт сэтгэл зүйн хувьд сайхан дэмжээд ойлгуулчихаж болоогүй юм бэ гэдэг бодол маш их хүчтэй байсан учраас энэ хандлагыг өөрчлөхийн тулд манай холбоо маш идэвхтэй ажилласан л гэж боддог. Өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд ер нь холбооны энэ чиглэлээр хийсэн үйл ажиллагаа маш үр дүнгээ өгсөн юм болов уу. Өнөөдөр нийгэмд дауны талаарх ойлголт харьцангуй дээшилсэн гэж би өөрөө бол үнэлж явдаг.

Анх таныг тэгээд яахад удамшил яагаад үзүүл гэж? Тухайн үед бол удамшил гэж ярьдаг байсан уу?

Одоо ч гэсэн тэгж ярьж байгаа юм аа гэж байдаг юм байна лээ л дээ. Тэгээд удамшлын зүйл гэж үздэг л юм байна лээ. Гэхдээ би өөрөө энэ чиглэлээр дауны хам шинжтэй хүүхдүүдтэй, олон улсын янз бүрийн группүүдэд нэгдээд орчихсон, мэдээллүүдийг аваад л харж байна л даа. Даунтай мөртлөө гэр бүл болчихсон хүүхэд төрүүлчихсэн олон хүмүүс байна. Тэр хүүхдүүд нь эрүүл саруул байна. Тэгээд мэдээж нийгмийн хандлагад нөлөөлөхийн төлөө аавыгаа даунтай аавыгаа, эрүүл хүүхэд нь нийгэмд нөлөөлөх маш сайхан бичлэгүүдийг хийгээд нийгэмд үзүүлж байна. Бодвол тэгээд удамшдаг гэж үздэг юм байлгүй. Миний хувьд бол даун бол тэр болгон удамшдаг өвчин биш, удамшдаггүй байх л гэж бодож байна. Мэдээж тэрийг удамшлын гээд нэрлэчихсэн энэ буруу хандлагаас болоод анх ийм хүүхдээ гар дээрээ хүлээж авсан эцэг эхүүдийн хувьд танай удам уу, манай удам уу гэдэг эрэл хайгуул маш их явагддаг юм байна л даа. Ялангуяа шинэ залуу эцэг эхүүдэд бол энэ маш хүнд тусна. За манай нөхөр бид хоёр бол одоо бас урьд нь хоёр хүүхэдтэй ах эгч хоёр нь зүгээр байсан учраас бид хоёрын хувьд бол тэр хүүхдийг хүлээн хүндээр

хүлээж авааД гэр бүлийн харилцаанд өөрчлөлт орохоосоо илүү бол бид хоёр бол одоо ер нь манай гэр бүлийн хандлагыг улам илүү ойртуулж өгсөн. Одоо бүх бэрхшээлд энэ хүүхдийнхээ хөгжлийг яаж даван туулах вэ гэдэгт чиглэж байгаа учраас илүү нэгдэж өгсөн тийм л асуудал болсон л доо. Мэдээж яг бид хоёрын хувьд ч гэсэн танай удамд ийм хүн байдаг уу, манай удамд ийм хүн байдаг уу гээд л бас л хайлт явагдсан. Гэхдээ бол хэнд нь ч тийм юм байгаагүй. Яагаад ийм хүүхэд гарчихав, юунаас болов гэдэг мэдээж учир шалтгааныг нь хайж олох гэсэн цаг хугацаа бол нэлээн байсан л даа.

Тухайн үед ч гэсэн Монголд яг тийм хромсон тоолдог эмнэлэг ч гэсэн байгаагүй байх тийм үү?

Раднаа эмч бол олон жил Эх нялхсын төв дээр энэ талаар судалгаа хийгээд нэлээн мэргэшчихсэн байсан юм байна лээ. Тэгээд ийм хромсомыг тоолох гэхээр миний одоо санаж байгаагаар нэг шинжилгээ хийхэд бодис нь дутуу, тэгээд тэр бодис нь Монголд ирдэггүй, тэгээд хээээ ирэх вэ? ирэхээр нь тоглуулъя гэхээр хээээ ирэх нь мэдэгдэхгүй. Ингээд л хромсомыг нь тоолж чадахгүй. Эмч нар бол хараад л, мэдээд л байсан юм юм байна лээ. Гэхдээ бид нар бол итгэхгүй байгаа шүү дээ. Энэ эмч нь мэдэж байгаа юм уу, үгүй юу гээд гээд. Яагаад гэхээр дауны хам шинжтэй хүүхдүүдийн олонхид бас бусад хам шинжүүд дагачихсан байдаг. Одоо хам өвчлөл, зүрхний ч гэдэг юм уу, хэл ярианы ч гэдэг юм уу, тэгээд манай хүүхдийн хувьд гурав хүртэлх насанд ер нь нэг их бэрхшээл ажиглагдаагүй. Тэгээд царай зүсийг нь харахаар гайгүй ч юм шиг. Мэдээж жаахан хоцрогдлууд, хөдөлгөөний хоцрогдлууд бол байсан. Тэглээ ч гэсэн ер нь гайгүй юм шиг санагдаад байдаг учраас тэрийг чинь хүлээн зөвшөөрч чадахгүй. Тэгээд бид хоёр Бээжинд очиж тоглуулсан л даа. Бас нэг гомдолтой санагддаг юм байдаг. Одоо ч гэсэн эмч нар ийм байгаа юм. Хүүхэд төрөнгүүт нь амлуулдаг шүү дээ. Тэгээд амлуулах гэхэд манай хүүхэд сайн амлаж чадаагүй. Дараагийн хоёр хоног би ингээд хүүхдээ хөхүүлэх гэхээр ерөөсөө хөхөхгүй. Нэг хэдэн сорчихоод л унтаад л байсан. Бусад айлын хүүхэд болохоор ингээд уйлаад л, хөхөө өгөхөөр хөхөөд л, тэгэхэд манай хүүхэд болохоор унтаад байсан. Бид нар чинь тасаг дотроо яриад байгаа шүү дээ. Ямар тайван хүүхэд төрчихсөн юм бэ? Манай энэ ааштай гээд л нөгөө ээж нар. Би нөгөө тайван унтаж байгаа хүүхдээ хараад л, тэгээд л ёстой унтуулж байгаа юм чинь ингээд л суугаад байсан. Тэгтэл тэр хооронд хүүхэд маань шингэний дутагдалд ороод шарлалт явагдчихсан байсан.

Шарлалт гэдэг маань ерөөсөө хүүхэд төрсөн цаанаасаа л шингэний дутагдал юм байна лээ шүү дээ. Тэгээд тэрийг бид нарт хэлээгүй би ч гэсэн гуч гараад төрж байгаа хэрнээ тэрийг бас мэддэггүй. Миний өөрийн бас мэдлэг дутуу. Бид ер нь эрүүл мэндийн боловсрол олон юман дээр дутуу юм байна лээ. Гэхдээ тэнд байгаа эх нялхсын эмч нар тэрийг аягүй сайн зөвлөдөг, тэр талын мэдээллийг ядаж

ханан дээр нь наачихдаг бол уншина шүү дээ. Хүүхдээ хөхүүлээрэй л гэж ганц нэг хэлж байсан байх. Тэрийг анзаарахгүй хөхүүлэхээр нөгөөдөх маань хөхөхгүй унтаад байдаг. Тэгээд тэрний шалтгааныг дараа нь хайсан чинь ерөөсөө даунтай хүүхдүүд бүх талын булчингийн сулралтай төрдөг юм байна. Толгойгоо даахад хүзүүний булчин ч байдаг юм уу, хөлд ороход хөлний булчин ч байдаг юм уу, бүх талын булчин сул байгаа учраас арай удаан хугацаанд. Дөрвөн сартай суудаг бол манай хүүхэд зургаан сартай найман сартай суугаад, найман сартай хүүхэд мөлхдөг бол манай хүүхэд чинь бүр ой гарч байж мөлхөөд л. Ингээд бүх булчингуудын сулрал явагддаг. Тэрэнтэй адилхан залгиурын булчингийн сулрал бас байдаг юм байна л даа. Тийм учраас хөхөө өгөхөөр зөв хөхөж залгиж чадахгүй, тэгээд тэрнээсээ болоод л ингээд унтаад байгаа хүүхдэд, тэр тайлбарыг бид нар өгч чадаагүй л байгаа байхгүй юу. Тэгэхээр бол хүүхэд бага багаар залгих гэхээр амьсгаа нь давхцаад нэг сонин залгидаг. Ер нь дараа нь хэдэн сартай болчихсон байхдаа ч гэсэн. Тэр мэрийг зөв хуваарилж, хүүхдээдээ сүүг нь тасралтгүй өгөх ёстой гэдэг ойлголт ч байхгүй л хоёр хоноод л шингэний дутлаас болж шарлалт явагдсан байгаа. Тэгэхээр энэ чинь бол заавал даунтай хүүхдэд ч биш шинээр төрсөн хүүхэд болгонд л байх ёстой асуудал учраас зөвлөгөө өгөх ёстой юм байна лээ. Эрүүл



хүүхэд бол арай илүү хүчтэй өлсөнгүүтээ өөрөө хүчтэй сороод булчингууд нь сайн ажиллаж байгаа юм чинь. Одоо ч гэсэн ердийн эрүүл хүүхдүүдийн дунд ч гэсэн шарлалт их явагддаг шүү дээ. Бид нар энэ талын зөвлөгөө мэдээллээ бас л сайн өгөх ёстой л юм байна лээ.

Эцэг эхчүүдэд бас дөнгөж хүүхэд нь төрөнгүүт танай хүүхэд чинь урт наслахгүй ээ гэж хэлсэн гэсэн тохиолдлыг нэлээн сонсож байсан л даа. Таны хувьд ямар байсан бэ? Бас эмч, эмнэлгийн ажилтнуудын тиймэрхүү хандлага танд харагдаж байсан уу?

Яг манай хүүхдийн хувьд бол урт наслахгүй гэдэг үгийг бол хэлээгүй л дээ. Ер нь бол би олон эцэг эхүүдээс эмч нар тэгж хэлж байсан, наслалт богино гээд. Дэлхий нийтээрээ даунтай хүмүүсийн дундаж наслалт бол бага байсан. Дөч гараад сүүлдээ тавь болоод одоо жар болоод нэмэгдчихсэн. Тэгээд тэр дундаж наслалт бага гэдэг ойлголтыг эмч нар маань ерөөсөө богино настай гэдгийг би ерөөсөө урт насалдаггүй гээд ойлгочихсон байдаг, зарим нэг эмчийн бас дутуу аль мэдлэгээс болж эцэг эхүүдэд тийм ойлголтыг төрүүлдэг юм шиг байгаа юм. Бид хоёрын хувьд бол эмч ерөөсөө л зүгээр маш ёс зүйгүй эмч дээр таарсан л гэж би одоо дүгнэдэг. Тэр эмч маань юу гэж хэлж байсан гэхээр яах гэж ийм хол зайтай хүүхэд төрүүлсэн юм бэ гээд л загнаж байгаа байхгүй юу. Тэгэхээр би хол зайтай хүүхэд төрүүлсэн нь ямар алдаа болсныгоо бас ойлгохгүй яачихсан юм болоо л гээд л бодож байгаа. Тэгэхээр зүгээр л тэр эмч надад одоо ийм хүүхэд төржээ, одоо хүүхдээ ингээд сайхан ингээд аваарай, энэ чинь аягүй хөөрхөн шүү дээ гээд нэг сайхнаар ярьчихвал би аягүй гоё хүлээж авна шүү дээ. Тэгтэл нэг л аймшгийн хүүхэд төрүүлчихсэн чи яах гэж ийм төрүүлж байгаа юм бэ гэдэг байдлаар бүр зандраад л загнаад л. Мэдээж хүлээгээд авчихсан чинь би ерөөсөө уйлаад л, өөр юм өөдөөс нь асууж ч мэдэхгүй бүр шоконд орчихож байгаа байхгүй юу. Тэр тав хоног бол ерөөсөө амьдралын маань маш хүнд үлдсэн, нэг л болохгүй хүүхэд төрүүлчихсэн одоо яана аа л гэж, нөгөө хүүхдээ хараад л уйлаад л байсан. Энэ бол манай эмч нарын ёс зүй. Одоо бол харьцангуй эмч нар ч, эцэг эх нь ч бас арай ойлголт өөр болж байгаа байх л даа. Бид нар бол яах вэ дээ, нэмэгдэж байна, сайжирч байна гэж хардаг. Гэхдээ л одоо бас нэг мэр сэр, эмч нарын энэ харилцааны асуудал дээр бол дутагдалтай эмч нар бас олон байгаад байдаг юм уу? Эсвэл одоо яг ийм эмнэлэгт ийм даунтай хүүхэд төрүүлсэн ээж гарах юм бол тэр нь эмнэлэгт ядаж нэг сэтгэл зүйч байна, шууд очоод зөвлөгөө өгөөд харилцдаг тийм л үйлчилгээ хэрэгтэй байгаа байхгүй юу. Тэгэхгүй тэгээд мэдээж олон хүүхэдтэй ажиллаж байгаа нярайн эмчийн хувьд нэг хүн дээр тэгээд цаг зарцуулж чаддаггүй юм бол, боломжгүй байдаг юм бол одоо тийм сэтгэл зүйчийг л шууд эхтэй уулзуулах ёстой л гэж санагддаг юм.

Та одоо хүүгээ өсгөчхөөд өсгөөд ингээд явж байхад чинь ерөнхийдөө ямар ямар

хүндрэл бэрхшээлүүдэд тулгарч байсан юм бэ? Тэгээд цэцэрлэгт явуулж байсан уу? Тэгээд танай хүүхэд сургуульд одоо явдаг явдаг уу?

Ер нь бид хоёр хүүхдээ хүлээн зөвшөөрсний дараа булчингийн сулралтай байдаг юм байна гэдгийг ойлгоод хувиараа Эх нялхсын нэг сувилагчтай гэрээ байгуулаад гэрээрээ ирж дандаа хөдөлгөөний бариа засал хийлгэдэг байсан л даа. Ердийн хүүхдийг бодвол илүү үйлчилгээ, анхаарал халамж бол маш их шаарддаг. Ямар ч байсан хүүхэд тав зургаа хүртэл бие даах, энэ чадварыг нь сайн хөгжүүлээд өгчих юм бол хүүхдүүд маань бол харьцангуй гайгүй. Түрүүн би хэлж байсан. Манай хүүхдийн хувьд бол тийм, нөгөө дагалдах өвчин байхгүй, харьцангуй бие бялдрын хөгжил нь гайгүй хүүхэд байсан учраас. Ганцхан бэрхшээл нь бид хоёрт хэл ярианы бэрхшээл байсан. Тэгээд л ерөөсөө ярьж уг хэлж чадахгүй, зөв хэлж чадахгүй. Одоо хэлд орчих байх, одоо хэлд орчих юм байх гэж хүлээж байгаад сүүлдээ хэлд орохгүй юм байна гэдэг нөхцөл байдалтайгаа бүр эвлэрчихсэн. Хэлд орохгүй байгаа нь өөрөө бас манай хүүхдийн хөгжилд маш их саад болж байгаа л даа, оюуны хөгжилд нь. Бусад хөгжлийн хувьд бол ер нь хэвийн. Бид хоёр ерөөсөө л хүүхдээ хоёр нас хүрэнгүүт нь цэцэрлэгт өгсөн. Бид хоёр олон хүнээс зөвлөгөө авахад нийгмийнх нь дунд, ердийн хүүхдүүдийн дунд л хөгжүүл гэдэг ийм зөвлөгөө байсан. Бид хоёр ерөөсөө энэ л хамгийн зөв шийдэл юм байна гэдгийг бол ойлгоод тэгээд ердийн цэцэрлэгт өгсөн. Бас цэцэрлэгийн багшид нэг тав арван цаас илүү өгөөд л манай хүүхдэд арай илүү анхаарал тавьчихаарай гээд л, тэгээд л хүүхдүүдийн дунд л өгсөн. Ер нь бол хүүхэд маань долоон нас хүртлээ бол цэцэрлэгээр хүмүүжсэн ерөөсөө нэг ч алгасаагүй тэгээд л нэг цэцэрлэгтээ явдаг. Яг ингээд багш нартаа тулаад ойлгуулчихаар цэцэрлэгийн багш нар бол аягүй сайхан, бүгд л анхаарал сайтай. Тэгээд гурван нас хүртэл нь төрийн цэцэрлэгт өгч байгаад тэгээд дөрвөн наснаас нь эхлээд “Бяцхан найзууд” гээд хувийн цэцэрлэгт өгсөн. Тэр цэцэрлэг бол ер нь бүх багш нар эрхлэгч нь, ингээд бүх хүмүүс нь бол аягүй сайн хүлээгээд л авчихдаг. Эд нар чинь манай хүүхдийн хувьд бол нэг их элдэв ааш гаргахгүй шүү дээ, инээгээд л сууж байдаг. Хүүхдүүдийг дуурайх гээд л ингээд л ороллдог. Мэдээж тэр ердийн хүүхдүүдээс гүйхдээ хүртэл арай удаан ч юм уу, нэг их нэг их ийш тийшээ гүйгээд үймүүлээд байхгүй нэг газраа л тоглоомоороо оролдоод байдаг учраас нэг их саад бэрхшээл нь гайгүй байсан юм байх гэж би боддог юм. Ямар ч байсан өөрөө хоолоо идчихнэ, өөрөө горшонк дээрээ суугаад бие засаад яваад байдаг байсан учраас. Гол нь бол энэ хүүхдүүдийн хувьд бол ерөөсөө юмыг яаж сурна яг тэр дадлаараа байдаг. Нэг удаа цэцэрлэгийн багш тэгж байсан, за Цолмон ерөөсөө хувцсаа эвхэж сурахгүй байна аа гээд. Багш нь ингээд л хувцсыг нь эвхээд л унтуулах, одоо хувцсыг нь эвхээд л тавихаар ингээд бөөрөнхийлж байгаад шидчихдэг гээд. Би нөгөө нэг орон дээрээ нөгөө орны урд нэг юм шиг

шүүгээ байдаг байхгүй юу. Тэгээд л орон дээрээ хэвтүүлээд л өмдийг нь тайлаад л нөгөө шүүгээ рүү шидчихдэг тэгээд л орон дээрээ хэвтдэг байсан тэр зуршлыг цэцэрлэг дээр гаргадаг байсан юм байна лээ. Тэгэхээр ерөөсөө яг л эцэг эх бид нар яаж зааж, ямар зуршил бий болгон яг л тэрүүгээр хүмүүждэг. Цэцэрлэгийн багш нь энэ ингээд хувцсаа бөөрөнхийлээд шидээд байх юм гэхээр би яг ойлгож байгаа юм чинь. Тиймэрхүү л байдалтай байсан шүү дээ.

Долоон настайгаас нь сургуульд оруулахад танд ямар байсан бэ? Хувийн сургуульд оруулсан уу, эсвэл улсын сургуульд оруулсан уу?

За долоон нас хүртлээ бол тэр цэцэрлэгээрээ явж байгаад тэгээд долоон настайд нь сургуульд оруулах болсон чинь маш олон сургууль асууж сураад л явсан л даа. Ер нь угаасаа аав бид хоёр нь тусгай сургуульд өгөхгүй ердийн сургуульд өгнө л гэсэн. Ийм бодлоготой зорилготой байсан учраас ердийн сургуулиудад очихоор ярьдаггүй, нэг асрагч хажууд нь асаргаа шаардлагатай учраас ердийн сургуульд өгөх ерөөсөө боломжгүй байгаад байсан. Хоёулаа гайхаад байж байтал яг тэр үед Дауны холбооны маань эцэг эхчүүд ерөөсөө нэг тусгай анги нээе тэгээд бид туслах бүлэг өөрсдөө нээе гэсэн ийм шийдэлд хүрчихсэн байсан. Тэгээд тэрэнд л ерөөсөө шууд нэгдэж орсон. Арваад эцэг эх байсан. Тэр ангид нь бол өөр ердийн сургуульд сурч байсан, тусгай сургуульд сурч байсан янз бүрийн хүүхдүүд байсан. Манай хүүхдийн хувьд бол анхных нь сургууль нь л байсан. 63-р тусгай сургуулийн захирал гэж байсан олон жилийн туршлагатай Мягмар гэж багшийг тусгай бүлгийнхээ анхны багшаар нь урьж ажиллуулсан. Тэгээд хажууд нь холбооноосоо асаргаанд нь туслах багшаар ажиллуулаад. Ингээд 2 хүнтэй ангиа нээгээд орон сууцны гурван өрөө байранд ажиллуулсан. Тэгээд өөрсдөө хөтөлбөрөө гаргаад багш маань ч гэсэн өөрийнхөө туршлага дээр үндэслээд л хичээл заагаад эхэлсэн. Тэгээд нэг жил хоёр жил явсан. Яг хүүхдүүд маань тусгаарлагдсан хэвээрээ байхгүй юу, хоорондоо л харилцдаг, ердийн хүүхэд нийгмийн дунд орохгүй. Гурван өрөө байр маань бол одоо ерөөсөө биеийн тамирын хичээл, бусад хичээлийг орох боломжгүй. Тийм учраас ерөөсөө сургууль хэрэгтэй юм байна. Тэгэхдээ энэ дээр аягүй олон шинэчлэлүүдийг, хөтөлбөрийн хувьд шинэчилье, багшийгаа шинэчилье, тэгээд ингээд явъя гээд. Бид нар “Идэр” дээд сургууль дээр очиж биеийн тамирын заалыг нь гуйгаад, тэгээд хүүхдүүдээ аваачиж биеийн тамирын хичээлийг нь оруулдаг байж байгаад тэгээд л нэг фитнес клубийн зааланд очиж хаяа техник тоног төхөөрөмжүүд дээр нь хичээллэнэ. Тэгээд хүмүүс бүгд л дэмжээд л, танай хүүхдүүдийг үнэгүй оруулъя гээд ингэсэн ч гэсэн нөгөө хүүхдээс тусгаарлагдаад байсан учраас бид нар 130-р сургууль дээр Дауны холбоо хамтарч ажиллах төсөл хэрэгжүүлье гээд ЖАЙКА-аас нэг арга хэмжээний санхүүжилт аваад тэгээд нэг туршилтын төсөл хэрэгжүүлье гээд

явж байсан чинь 130-р сургууль манайд хүүхдүүдээ нэг анги гаргаад тэгээд та нар өөрсдөө тохижуулаад хүүхдүүдээ хичээллүүл гээд зөвшөөрсөн.

Тэгээд 130-р сургууль дээр тусгай бүлэг нээгээд тэгээд хоёр багштай, хүүхдүүдээ хичээллүүлсэн. Энэ маань маш үр дүнтэй болсон. Гурав гурваар нь ердийн хүүхдүүдтэй холиод дуу хөгжмийн хичээл, зургийн хичээл, биеийн тамирын хичээлд оруулдаг, ангиар нь нэг оруулдаг. Хүүхдүүд гурав гурваар нь гурван өөр ангид хуваагаад биеийн тамирын хичээлд нь хольж оруулдаг, зургийн хичээлд нь оруулдаг. Бас бид өөрсдөө Хүүхдийн ордонтой гэрээ байгуулаад зургийн багш нарыг авчирч анги дээр нь яг хүүхдүүддээ тусгай хичээл оруулдаг. Дуу хөгжмийн хичээлийг бас өөр өөр ангид хуваарилж оруулдаг, гэхдээ бас өөрсдөө багш маань өөрөө дуу хөгжмийн багш учраас ангидаа бол бас хөгжмөөр дамжуулж бусад төрлийн хичээлээ оруулдаг гээд. Ингээд маш олон ийм давуу талууд гарч ирсэн. Ийм хүүхдүүдтэй хамтарч ажиллах, дэмжих сайн дурын хүмүүс маш их байдаг юм байна. Тэр хүмүүс бол бид нар бол үнэгүй очъё, заая, дэмжээд өгье гээд янз бүрийн хичээлүүдийг маань аягүй их хөгжүүлж өгсөн. Тийм учраас энэ анги бол одоо таван жил хичээллээд энэ жилийн хувьд бол хичээлийн жилд нэг ээлж ордог байсан бол одоо хоёр ээлжид болж байгаа юм. Бид эцэг эхчүүд өөрсдөө төлбөрөө төлөөд багшийгаа цалинжуулаад явж байсан. Үргэлж ингэж явах бол одоо бас хэцүү.

Тэгээд хүсэлт тавиад тэгээд энэ хүсэлт маань явсаар байгаад бол 63-р сургуулийн харьяа болгож ангийн маань албан ёсоор бүртгээд улсын сурагчдыг бүртгэх нэмэгдсэн системд манай хүүхдүүд бол нэр хаягаараа бүртгэгдээд 63-р сургуулийн сурагчид, гэхдээ 130-р сургууль дээр хичээллэж байгаа гэдгээр ингэж явж байгаа. Тэгэхээр бол албан ёсны бүртгэлдээ ороод тэгээд хөтөлбөрийнхөө үнэлгээнүүдийг хийлгэхдээ 55-р сургуулийн Ганбилэг захиралтай хамт олныг уриад хичээлийн жилийн төгсгөлд хүүхэд болгоноор үнэлгээ хийлгэдэг. Тэгээд тэр нь бол өмнөх жилүүдээсээ хэр ахиц өөрчлөлт гарсан юм бэ гэдгийг хардаг учраас бол энэ бас их үр дүнтэй болсон. Угаасаа эцэг эх болгон саналаа хэлдэг. Манай хүүхэд бол одоо тоо боддог, одоо энийг үржүүлж сургана гэдэг хүсэлтэй байгаа. Зарим нь бол манай хүүхэд ингээд уншиж байгаа унших чадварыг нь нэмэгдүүлнэ ээ гэж байгаа, зарим нь бол ерөөсөө манай хүүхдийн өнгө ялгадаг, эсвэл нэг дүрслэх хүн дүрсэлдэг тийм зурах чадварыг нь л хэмжээнд сайжруулъя гээд. Ингээд эцэг эх, хүн болгоны хүсэлт өөр байгаа шүү дээ. Тэгэхээр яг нөгөө багш маань бол яг тэр болгонд тохирсон хүүхдийн эцэг эхээс нь даалгаврыг нь аваад ярилцаад за энэ жилийн хувьд гэвэл ахицаа ингэж гаргая гэдэг төлөвлөгөөгөө боловсруулдаг учраас энэ их давуу талтай байна. Ердийн ангид орох юм бол яг гучин зургаан хүүхэд, гучин хүүхэдтэй багш бол яг тэгээд ахиц нь гаргаад явахад бол бас бэрхшээлтэй болов уу. Өөр бусад бэрхшээлийн хувьд бол би мэдэхгүй байна. Тэгэхээр тэр

бусад бэрхшээлтэй нь боломжтой байж магадгүй. Тэргэнцэртэй юм уу, харааны юм уу сонсголын бэрхшээлтэй хүүхдийн хувьд бол оюун ухааны бэрхшээл биш учраас бас яг ингээд ердийн хүүхдүүдтэй сураад байхад бас боломжийн байж магадгүй. Гэхдээ манайд оюуны бэрхшээлтэй ч гэсэн ердийн ангид суралцаад төгсчихсөн хүүхдүүд сайн туршлагууд бол байгаа. Мэдээж эцэг эх болгоны сэтгэл ханамж бол өөр байгаа шүү дэ. Ингээд хүүхдээ ямар түвшинд авч явах вэ гээд. Миний хувьд бол ман манай хүүхэд ярьдаггүй, хэзээ ч бичиг үсэг заагаад ойлгохгүй. Тийм учраас би ерөөсөө хүүхдийн бие даах чадварыг нь л хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлээч гэж багшаасаа гуйдаг байсан. Тэгээд л хоёулаа бол ингэдэг болъё, тэгдэг болъё гээд л янз бүрийн даалгавар аваад л харьцангуй бие даах чадвар нь гайгүй л болж байгаа гэж боддог шүү дээ.

За хичээлээ тараад өөрөө гэртээ хүрээд ирдэг үү?

Миний хүүхдийн хувьд бол гэр сургууль хоёр нь маш ойрхон. Тийм учраас сургуулиас хичээл тараад гэртээ ирнэ гэдэг бол ямар ч асуудал байхгүй, шууд л өөрөө хүрээд ирнэ. Зүгээр бид нар аюулгүй байдлыг нь бодоод ялангуяа багш нь бүр хариуцлага хүлээчихсэн учраас өгч явуулахгүй заавал ирж авах ч гэдэг юм уу тэр шаардлагуудыг бол. Түүнээс биш ингээд ганцаараа бол өөрөө яваад ир ойр орчмынхоо яг дэлгүүр хоршоогоор бол өөрөө яваад үйлчлүүлчихнэ. Тэгээд ойрхон бассейнд явуулдаг, тэгээд л бассейн руугаа бол өөрөө явчихна. Уг нь бол бүх үйлдлийг ганцаараа хийнэ. Гэхдээ зүгээр бид бас ямар ч юм болох юм билээ гэдэг байдлаар бол байнга хамт л явдаг л даа.

Та цаашид ер нь хүүхдийнхээ ирээдүйг ер нь ямар байгаасай гэж боддог вэ?

Ер нь бол бие даалгая л гэж бодож байсан. Ямар нэгэн спортоор хичээллүүлье гэхээр бас их дуртай биш. Одоо ангид нь бол ангийнхаа нөхдүүд аягүй мундаг шүү дээ. Усан спортоор явна, теннисээр явна гээд ер нь янз бүр. Багш нь өөрөө урлагийн хүн, хөгжмийн хичээлүүдийг их түлхүү ордог ч ер нь миний ажигласнаар бол энэ даунтай хүүхдүүд нийтлэг дуу, хөгжмийн хичээлд их дуртай, сонирхолтой, тэгээд хөгжимд их сонирхолтой байдаг. Тэр утгаар нь хөгжмөөр бас явуулах юм уу гэхээр бас нэг их дуртай биш. Бид 2019 онд ямар ч байсан тусгай олимпынхантай хамтраад Азийн хөгжмийн наадамд ангийнхаа гурван хүүхдийг оролцуулсан. Тэгээд бид өөрсдөө зардлаа даагаад л ямар ч байсан наадамд гурвуулаа нэг бөмбөрийн төрлөөр л бөмбөр цохиод тоглолт хийгээд хүрээд ирсэн. Манай том охин дагуулаад явсан л даа, дүүгээ. Тэнд бол ёстой аймаар аймаар урлагийн төгөлдөр хуур, хийл, янз бүрийн хөгжмийн төрлүүдээр хүүхдүүд өрсөлдөж байна, аймаар бэлддэг юм байна, манай энэ чинь бүр эрхэлчихсэн юм байна л гэж байна лээ. Тэгэхдээ бол яах вэ, өөрийнхөө хэмжээнд яг багшийнхаа заасан юмыг л тоглоод л байдаг юм. Тэгэхдээ яг тэрүүгээр дагнаж хичээллэх сонирхол бол багатай. Цаашдаа

бол ямар ч байсан ингээд л сая хоёр жилдээ хорионд гэртээ л байлаа. Багш бол цахимаар хичээл заадаг. Цаашдаа бол одоо ер нь бол гэртээ. Би бол нэг ийм үйлчилгээний ч юм уу, дэлгүүрийн угтах үйлчилгээ байдаг шүү дээ. Тийм газруудтай гэрээ хийгээд насанд хүрэхээр нь тэгээд л байж байг, тэр хэмжээнд өөрөө нийгмийн харилцаанд ороод ажиллавал ажиллана биз гэдэг байдлаар хандъя гэж бодоод л байж байдаг. Түүнээс биш цаашдаа яг бие даан ажиллах боломж бол бас тийм сайн биш л дээ. Одоо бол нэртээ бол өрөөгөө цэвэрлэнэ, хогоо шүүрдэнэ, тэгээд хоол хийхэд хажуугаас би оролцъё гээд л, ингээд л өөрөө авраад л юм хийж л байдаг. Тэгэхдээ мэдээж гүйцэтгэл бол тийм өндөр биш ч гэсэн өөрийнх нь санаачилгаар. Хүү маань охин дүүтэй. Дүүгээсээ бараг илүү ажилсаг тийм л байдаг шүү дээ. Тэгээд зүгээр хүүхдийнхээ ирээдүйг бодохоор бол манайх дөрвөн хүүхэдтэй, дөрвөн хүүхдийн маань гурав дахь нь энэ Цолмон гээд.

Гэхдээ бол ирээдүйг бодохоор ямар ч байсан нэг нь ийм бэрхшээлтэй төрсөн нь бусдынх нь хөгжилд бол саад болох ёсгүй ээ гэж би үздэг. Одоо бусдынх нь хөгжилд саад болгохгүйн тулд би мөнх наслах биш, тийм учраас ирээдүйн асаргаанд нь зориулж бол нэг тодорхой хэмжээний хуримтлал үлдээгээд л өгье. Эгч нь бол тэгээд дүүгээ асаргаанд нь тэр мөнгийг зарцуулаад л дүүгээ хараад л явна биз гэж боддог. Гэхдээ одоо нэг ямар ч гэсэн холбоотойгоо юм уу, төр засгийн байгууллагуудад хандаад хамтраад юм уу яг энэ хөгжлийн бэрхшээлтэй, удамшлын бэрхшээлтэй хүмүүсийг нэг сайхан Хөгжлийн асаргааны төв байгуулчих юм сан гэж бодон, тэгэхдээ бол ямар ч байсан одоогийн байгаа Батсүмбэрийн ахмадын асрамж шиг биш Хөгжлийн төвүүд. Тэнд хүү маань дуртай үйлчилгээгээрээ өдрийн үйлчилгээг очоод авчихдаг байж болно, эсвэл байнга төлбөрөө төлөөд байнгын үйлчилгээнүүд авдаг байж болно. Янз бүрийн одоо юу гэдэг юм, сексийн харилцаанд орох үйлчилгээг хүртэл зохион байгуулалттайгаар тэндээс нь зохион байгуулаад өгчихдөг байж болно. Эсвэл нэг өдрийн хотоор тур хийх, аялах юм сонирхоё юу ч байдаг юм тэр бүх үйлчилгээг нь төлбөрийг нь авъя л даа. Одоо төлбөргүй бол бүр сайн байна. Хүн гэдэг утгаар нь бас үйлчилгээ үзүүлчих тэрийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлчихдэг. Ингээд эцэг эх болгон л юунд цөхөрч байна гэхээр одоо ингэчих юмсан, яах вэ, хаана хандахаа мэдэхгүй, тэгээд зохион байгуулалтад орж мэдэхгүй. Ингээд л эцэг эхээс нь захиалгыг нь аваад хүүхдүүдэд нь магадгүй насанд хүрчихсэн хүмүүс болно шүү дээ, одоо өнөөдөр жаахан бага байгаа ч гэсэн ирээдүйн насанд хүрсэн хүмүүсийн л проблемын асуудлыг бол зохицуулж шийдэж өгдөг тийм зохион байгуулалттай л төв байгаасай л гэж хүсдэг. Энэ бол ерөөсөө өөрөө нийгэмд үүсчихээд байгаа том хэрэгцээ юм байна аа л гэж хараад байгаа юм. Гаднын олон улс оронд бол энэ тийм байна л даа. Бие даан амьдрах одооманай "Энэрлийн түүчээ", "Түгээмэл хөгжил" гээд төрийн бус байгууллагууд бол одоо бас яг энэ тал дээр бол тодорхой

дэмжлэг үзүүлж байгаа. Гэхдээ энэ нь бас оюуны бэрхшээлтэй гэдэг бол бас өөрөө их онцлог бэрхшээл юм байна. Энэ хүмүүс дээр бол бас нэг ийм тусгайлсан төвүүд л байхгүй бол болохгүй юм байна гэж хараад байгаа юм.

Оюуны бэрхшээлтэй хүмүүс маань өөрсдийнхөө эрхийг хамгаалаад тэмцэж чадахгүй болохоор бас тэгээд яг энд ард хоцрогдож үлдээд байна.

Тэгтэл одоо яг гэдэг юм аа. Манай том охин хэдийгээр ийм дүүтэй боловч бас ямар гэр бүл та одоо зохиох вэ, тэр гэр бүлийн амьдралд бас тодорхой хэмжээнд саад болгомооргүй байна гэдэг би ийм үзэл бодолтой. Нэг хүүхдийнхээ амьдралаар, нөгөө хүүхдийнхээ амьдралыг саад болгож болохгүй юм. Миний охин харин эгч хүний хувьд дүүд маань ийм хэрэгцээ байгаа юм байна гэдэг тэр захиалгыг тэр төвдөө өгчихдөг, тэгээд ингээд тэрэн дээр нэг хяналт тавиад төлбөрөө төлөөд дүүгээ, ингээд тэгээд мэдээж эргэж тойроод явах тийм хэмжээний л байлгах юм сан гэж мөрөөдөөд байгаа юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй эцэг эхчүүдийн сэтгэл зүйн асуудал ерөнхийдөө бас нэлээн хоцрогддог юм шиг санагддаг. Тэгээд та өөрийнхөө сэтгэл зүйн асуудлаа хэнд нээж ярьдаг вэ? Тэгээд хэн танд нь ингээд нээгээд яривал илүү ойр дотно ч юм шиг санагддаг вэ?



Эхлээд бол манай нөхөр бид хоёр ерөөсөө хэнд ярихаа ч мэдэхгүй хоёулаа л гээд их ярьдаг байсан л даа. Тэгээд холбоон дээрээ нэгдээд ерөөсөө бид нарын зорилго бол нийгэмд таниулъя гэдэг болчихсон. Тийм учраас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүүхдээ нуудаг, санаа зовоод ил гаргадаггүй олон л бэрхшээлүүд байдаг шүү дээ. Хүмүүс бол тэр болгон бас аа тийм юм уу гэж байгаа ч ёстой ингээд цэрвэсэн болгоомжилсон тэгээд янз бүрийн л харилцаанууд бол нүүрэн дээр байнга л тулгардаг л даа. Тэр үед бол эхлээд бол их эмзэглэдэг байсан. Миний хүүхдийг ингээд л нэг сонин хараад л өнгөрөхөд хүртэл дотор хямраад л энд хүнд ямар гай болсон юм, тэгээд яагаад ингэж хандаад байгаа нь ч гэдэг юм уу. Ингээд эхлээд бол их бухимддаг байсан. Яваандаа бол ерөөсөө яадаг юм, би ийм хүүхэдтэй, миний хүүхэд ийм болж төрсний ямар бурууталй юм гээд л тэмцэх сэтгэл их өндөр байдаг байсан л даа.

Тэгээд л нэг хэсэг бол ерөөсөө хүүхдээ дагуулаад л хүүхдийн тоглоомын талбай дээр гаргачихаад өөрөө холоос харж суудаг ч юм уу, дэлгүүрт оруулчихаад өөрөө юмаа аваад ир гээд л би өөрөө холоос хараад зогсдог. Ингээд тэгээд байхаар миний ажигласан юм бол мэддэг хүмүүсээс хэзээ ч ийм хандлага гардаггүй. Хүүхдийг ойлгочихсон мэдчихсэн хүнээс бол тийм сөрөг хандлага гардаггүй. Тэгэхээр дэлгүүрийн үйлчлүүлэгч маань эхлээд бол ойлгохгүй жаахан эвгүй байдаг байсан. Сүүлдээ бүр мэддэг болоод орж ирэхээр нь тоглоод л харилцана, тоглоом хийгээд л, харилцан яриад л за сайн уу байна уу гээд л. Ингээд ирэхээрээ хүмүүсийн хандлага шал өөр болчихож байгаа юм. Бүгдээрээ тэгээд л Цолмон юу авах гэж байгаа юм, за алив нааш ир гээд нэг нь дагаж яваад л авах юм хумаа сонго гээд л, тэгээд л яг үүдээр баяртай гэж гарах хүртлээ харилцаанд орчихдог болдог юм байна лээ. Тэгэхээр би бол ерөөсөө мэддэггүй хүмүүсээс л ийм сөрөг хандлагууд гарч байгаа. Тэр өөрөө ингээд эмзэг байгаа ээж аав нарыг улам хүнд байдалд оруулдаг юм байна гэж бодсон. Тэгэхээр нийгмээрээ л мэддэг болчихъё тэгээд л ийм хүмүүс ийм л байдаг гээд. Энэ өөрчлөлтийг л бий болгох нь зөв юм байна гэж бодоод ерөөсөө би ингэдэг юм шүү дээ гээд л автобусанд хүүхдээ дагуулаад ороход суухад хүн эвгүй харсан ч өө манай хүүхдүүд чинь аягүй хөөрхөн шүү дээ. Ингээд л энэ тань руу хараад байна уу?

Таны энэ их гоё харагдаад байгаа учраас ингэж байгаа юм байна л даа гээд л. Ингээд шууд нээлттэй өөрөө эхлээд ярьчихаар нөгөө хүн аан тийм байна гээд. Тэгэхгүй хүний юм сонирхоод л, эд нар чинь ингээд л удаан ширтэх ч юм уу янз бүрийн юм болно шүү дээ. Тэгэхээр нөгөө хүн ингээд л өөрөө байж ядаад л, эвгүй байдалд ороод л, болгоомжлоод л нэг их тийм харилцаа үүсээд эхэлж байгаа юм. Тэгэхээр тэрэнд бол ерөөсөө ээж би өөрөө шууд нээлттэй байх нь замыг нь зааж өгч байгаа. Таны энэ их таалагдаж байгаа учраас манай энэ хараад байгаа юм байна аа. Манай хүүд их л гоё санагдаж дээ ч гэдэг юм уу. Би

өөрөө нээлттэй байх тэр арга хэлбэрийг л өөрөө шууд нээж эхлүүлдэг. Тэгэхээр бол хүмүүс ингээд аа тийм байна гээд. Тэгээд ерөөсөө л ийм л байдлыг бид нар эцэг эхчүүд маань шууд нээх ёстой. Тэгэхгүй болохоор ингээд л хүүхдээ урдаа хараад л, бүр ингээд л байж ядаад л өөрөө ингээд улам бухимдлыг өөртөө бий болгоод байна лээ. Ингээд аяндаа яг ийм арга хэлбэрээ олоод ирэхээрээ хүн өөрөө ч гэсэн тайвшралд орчихдог юм байна лээ. Тэгээд бүр ингээд одоо бол хүүгээ дагуулаад явахад юунаас ч санаа зовдоггүй. Тэгээд ингээд ганц нэг тийм сонин байдал бий болж байсан ч тэрэнд ингээд уурлаж бухимдахаа больчихсон, стрессдэхээ больчихсон. Тэгээд л аягүй тайван амьдрал бий болчихдог юм байна лээ, яваандаа бол.

Ковид цар тахал гээд сая та хоёр жил гэртээ байсан гээд ярьсан. Тэгээд энэ ковид цар тахлын нөлөө ер нь дауны синдромтой хүүхдүүдэд хэр байна даа?

Энэ бол мэдээж дэлхий нийтээрээ л тулгарлаа. Хөл хорионы үе гэдэг юмыг үзэцгээлээ. За яах вэ, мэдээж аливаа юм хоёр талтай юм чинь. Ковидын нөхцөл байдал бол хэдий хүнд байсан ч гэсэн бидэнд бас олон юмнуудыг үүсгэлээ шүү дээ. Нөхцлүүд нь хүнд байсан ч цахимаар харилцаж болдгийг, цахимаар үйлчилгээ явуулж болдгийг бид нарт ойлгуулчихлаа гэж бодоод байна л даа. Давуу талууд ч байна, сул тал байна. Сул тал нь юу вэ гэхээр хүүхэд маань бас их мэдээж ганцаардалд орж байна. Тэгээд дүү нь бас байгаа. Хэдийгээр хоёулаа хамт байгаа ч гэсэн нэг нэг өрөөнд ороод хоорондоо харилцах нь бас их багасчихлаа. Нийгмийн харилцаанд орохгүй байгаа нь өөрөө бас их ганцаардлыг бий болгож байна. Өөрийн эрхгүй хүүхэд өөрөө ингээд харилцаанд орох гээд бас үгүйлээд эхэлдэг юм байна. Тэр талаасаа бол жаахан сул талтай санагдсан. Давуу тал нь гэвэл онлайнаар бас их олон мэдээллүүдийг аваад сая өнгөрсөн хугацаанд бол зургийн багш бол зураг мөр яаж дагуулж зурах юм, бүх л юмнуудыг онлайнаар үзүүлсэн, тэгээд тэрнийгээ бол дагаад хийж л байна. Нөгөө талаасаа бол эд нар чинь дархлаа бас тийм сайн байдаггүй учраас амархан өвдчих гээд байдаг, ханиад томуу. Одоо бол ерөөсөө тэгээд өвдсөнгүй шүү дээ. Хоёр жил тийм ханиад шуухнаа ч хүрсэнгүй. Тэгэхээр бас тэр талаасаа бол бас их зүгээр л юм байна. Сая тэгээд бол 12-оос дээш насны хүүхдүүдэд вакцин хийлгэхэд хоёуланд нь очоод л хийлгэсэн, тэгээд ямар нэгэн өвчлөл бага тийм л өнжлөө.

Одоо ер нь Монголын нийгэмд одоо бид нарын хамгийн одоо түрүүлж өөрчилж чадах юм юу байна вэ? Одоо энэ хүртээмжтэй нийгмийг бий болгохын тулд.

Тийм. Олон хууль нь гарчихлаа хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль бий боллоо. Тэр хуулийг дагаад гол нь дүрэм журамд өөрчлөлт орж байна. Ер нь бол хүмүүсийн хандлага бол бас сайжирч байна. Үйлчилгээнүүд бий болж

байна. Гэхдээ би бол энэ дээр дахиад л хандлагаа өөрчилье гэдэг уриаг дахин дахин хэлмээр байна. Яагаад гэхээр хандлагаа өөрчилье гэдэг бол бүх хүнд хамаатай. Ердийн хүмүүс хандлагаа өөрчилье. Аливаа юманд зөвхөн нэг талаас биш, олон талаас нь, олон янзын хүн байгаа, тэр болгоны өнцгөөс нь бас бодолцож байж аливаа юманд ханддаг байхаар хандлагаа өөрчилье. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүмүүс, хүүхэдтэй хүмүүсийн хувьд, эцэг эхийн хувьд ч гэсэн хандлагаа өөрчилье. Бид нар бол одоо ингээд энэ өөрчлөлтийг бий болгоход өөрсдийн хувь нэмрээ оруулъя. Хүүхдээ хөгжүүлэхийн тулд цаг зав, цаг хугацааг зарцуулдаг байя. Ерөөсөө бүх юманд оролцоо чухал учраас би хандлагаа өөрчлөх нь хамгийн чухал асуудал юм гэж хэлэхийг хүсэж байна.

Миний ажигласнаар, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй, тэгээд хүүхдээ анхаарал халамж тавихын тулд ажлаа орхиод гэртээ сууж байгаа олон ээж нар байгаа. Яг хүүхдээ цаг зав зарцуулсан бол тэр хүүхэд тодорхой түвшинд ямар нэг чиглэлээр амжилт гаргадаг юм байна. Үнэхээр арай л илүү байна. Тэгж чадахгүй болохоор ингээд нөгөө нэг ажил амьдралын олон шалтгаанаар хүүхдээ хүнд даатгаад орхиж байгаа, гэрт нь орхиж байгаа хүмүүс байна шүү дээ. Яг тэр хүүхдүүд маань бас хоцрогдолд ордог л юм байна л даа. Тэгэхээр ерөөсөө энэ бол хүүхдээ цаг зав зарцуулах нь хамгийн чухал юм байна. Эцэг эхийн хувьд бас яг энэ тал дээрээ анхаарах ёстой юм байна гэж харж байгаа. За хамгийн сүүлд нь бол төрийн үйлчилгээнүүд сайжирч байгаа. Мэдээж олон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан төвүүд бий болж байна. Биеийн тамир, спортын орднууд бий болж байна аа. Тэгэхдээ ч гэсэн одоо хамгийн сүүлд би Монгол улс асрамжийн нэг тийм сайхан төвтэй болчих юмсан. Тэрнийг хөгжүүлэхийн төлөө сайн дурын оролцоо маш чухал. Бид яаж оролцмоор байна түүнд нь хамтраад ажиллах юм сан гэж хүсэж байна

.

За та ийнхүү цаг зав гаргасанд дахин баярлалаа гэж хэлье. Тэгээд таны цаашдын ажил үйлс болон хүүгийнх нь ирээдүйд амжилт хүсье.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭДТЭЙ ЭЦЭГ ЭХЧҮҮДЭД ЗӨВ МЭДЛЭГ, МЭДЭЭЛЭЛ ХАМГИЙН ЧУХАЛ

С.Сэлэнгэ



Сайн байцгаана уу, эрхэм хүндэт сонсогчид оо, Антолд подкастын маань ээлжит дугаар эхлэхэд бэлэн болоод байна. Энэхүү дугаарт Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбооны захирал Сэлэнгэ оролцож байна. Та манай подкастын урилгыг хүлээн авч оролцож буйд маш их баярлалаа. Та эхлээд манай сонсогчдод өөрийнхөө талаар дэлгэрэнгүй танилцуулахгүй юу?

За тэгье. Намайг Сэлэнгэ гэдэг. Би "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбоо"-нд гүйцэтгэх захирлын ажлыг хийж байна. 2010 оноос хойш 11 жил хийлээ. Уг нь би техник хэрэгсэлтэй ажилладаг инженер хүн байгаа юм л даа. Гэтэл амьдралын шаардлагаар мэргэжлээ солих хэрэгцээ гарсан. Би хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй байсан. Энэ шалтгааны улмаас би энэ эцэг эхийн холбоонд эхнээс нь удирдах зөвлөл, дараа нь гүйцэтгэх захирал гээд ажлуудыг хийгээд явж байна. Манай байгууллага чинь хориод жил болсон. Түүний тал хугацаанд нь энэ байгууллагад ингээд өдөр тутмын үйл ажиллагааг нь удирдан зохион байгуулаад явж байна.

Танай холбооноос ерөнхийдөө ямар үйл ажиллагаа явуулдаг вэ? Тэгээд тэр дундаасаа яг алийг нь голчилж ингээд явуулдаг вэ?

Манай энэ эцэг эхчүүдийн холбоо гэдэг бол яг дооросоо үүсгэл санаачлагатайгаар байгуулагдсан юм. Ингээд 1998-1999 онд "Англий хүүхдийг ивээх сан" гэж байлаа. Тэгээд интеграцчилсан сургалт

гэх мэт цэцэрлэгт явж байсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүдийг сургалтад суулгаж, тэнд сууж байсан эцэг эхчүүд санаачилга гаргаж, ер нь эцэг эхчүүд хоорондоо нийлж нэгдэх ёстой юм биш үү, бүгдээрээ нийлж байж хүүхдүүдийнхээ төлөө дуугарч, дуу хоолой нь болж ажиллая гээд 2000 онд "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо"-г байгуулаад өдий хүртэл ажиллаж байна. Одоо манай холбоо маань зөвхөн Улаанбаатарт байдаг биш. Хүний нийгэмд ер нь энэ хөгжлийн бэрхшээл гэдэг юм байдаг. Байсан, байж байгаа, ирээдүйд ч байх болно. Тэгэхээр энэ хөгжлийн бэрхшээл гэдэг бол өөрөө олон улсад, хөгжингүй улсад нийгмийн хамгийн том бүлэг гэж үздэг юм байна. Тэгэхээр хөгжлийн бэрхшээл гэдэг бол төрөхөд янз бүрийн шалтгаанаар, угаасаа тийм хөгжлийн бэрхшээлтэй хүн төрдөг, осол аваар өвчний улмаас болдог. Гэхдээ л нийгэмд тодорхой хувь нь ийм хөгжлийн бэрхшээлтэйгээр амьдардаг. Мөн насжилттай холбоотойгоор хөгжлийн бэрхшээл гэдгийг хүн бүхэн туулдаг ийм зүйл юм байгаа юм. Тийм учраас энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбоо орон нутгуудад байгуулагдсан. Одоо 16 аймагт байгуулагдан ажиллаж байна. Улаанбаатар хотод дөрвөн дүүрэгт илүү идэвхтэй үйл ажиллагаа явуулаад нийт хорин салбартайгаар манайх үйл ажиллагаа явуулдаг. Үндсэн гол зорилго бол манайх хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрхийг нь эдлүүлэхийн төлөөх үйл ажиллагааг зохион байгуулах. Тэгэхээр эрхээ эдэлнэ гэдгийг бид юу гэж ойлгодог вэ гэхээр хүүхэд төрснөөсөө авахуулаад хэрвээ хөгжлийн хоцрогдолтой байвал аль болох эрт илэрч оношлогдож, бага насны хөгжлийн дэмжлэгийг аль болох эрт авах ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд энэ бүх үйлчилгээг төрөөс үнэ төлбөргүй авч байх ёстой. Өөрөөр хэлбэл төрийн тогтолцоонд энэ бүгд орсон байх ёстой байдаг. Одоо энэ манай тогтолцоонд ороод явж байгаа. Тэгэхдээ бас учир дутагдалтай зүйлүүд байгаа. За тэгээд бага насандаа хөгжлийн дэмжлэгийг авааД дараа нь боловсролд хамрагдах ёстой, хөгжих ёстой. Тэгэхээр цэцэрлэг, сургуулиар өөрийнхөө орон нутагт, үе тэнгийнхээ хүүхдүүдийн хажууд сурч, хөгжих нийгэмших ёстой гэдэг ийм итгэл үнэмшил бид нарт байдаг. Тэгэхээр манай байгууллага болбол нэг төрлийн хөгжлийн бэрхшээлийн төлөө явдаг ийм байгууллага биш. Нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд 11600 хүүхэд Монгол улсад байдаг. Тэгэхээр тэр бүгд өөрөө өөрийнхөө орон нутагт, гэр бүл дотроо өсөж хөгжиж, эрхээ эдэлж байлгуулахын төлөөх үйл ажиллагааг



явуулдаг. Тэгэхээр манай үйл ажиллагааны хэлбэр бол эцэг эхчүүдийг илүү эрх зүйн боловсрол, мэдлэгтэй болгосноор тухайн төрийн тогтолцоон дахь тэр үйлчилгээнд хамруулах. Хэрвээ тэр үйлчилгээнд чанартай хамрагдаж чадах юм бол тэр хүн эрхээ эдэлнэ, тэрхүү эрхээ эдэлж чадах юм бол хөгжинө, дараа нь нийгэмдээ нэг гишүүн нь болоод баяртай жаргалтай амьдрах хэдий хөгжлийн бэрхшээлтэй ч гэсэн. Бид ийм итгэл үнэмшилтэйгээр эцэг эхчүүдийг нь тодорхой хууль, дүрэм журмуудын мэдлэгүүдийг эзэмшүүлэх тал руу сүүлийн 4-5 жил идэвхийлэн ажиллаж байгаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд маань эрхээ эдлээд явахад хамгийн том тулгардаг асуудлууд нь өнөөдөр Монголын нийгэмд яг юу юу байдаг вэ?

Аанхан, тийм. Тэгэхээр яг хүүхдүүдийн өмнө маань маш их асуудал тулгамдаж байна. Үнэхээр эрхээ эдэлж чадахгүй, сурч боловсрох, зарим тохиолдолд эрүүл мэндийн үйлчилгээгээ авах чанартай үйлчилгээг авч чадахгүй ийм байдалд олон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байна. Зөвхөн алслагдсан газрын гэхгүй хотод байгаа нь ч гэсэн Улаанбаатарт байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ч тодорхой



үйлчилгээнүүдийг авч чадахгүй байна. Тэгэхээр сурах, хөгжих, оролцох эрхүүд бол үнэхээр зөрчигдөж байгаа. За би түрүүн хэлсэн 11600 хүүхэд байдаг гэдгийг. Тэднээс 4000 гаруй хүүхэд нь боловсролын ямар нэгэн үйлчилгээнд хамрагдаагүй байдаг. Тэгэхээр энэ бол жаран хэдэн хувь нь хамрагдаж байна. Гучин дөрвөн хувь нь бол боловсролд огт хамрагдаагүй. Гэтэл энэ бол Боловсролын тухай хууль, Монгол улсын үндсэн хуулиараа Монгол улсын иргэн бүр суурь боловсролыг үнэ төлбөргүй эзэмшсэн байна, мөн сурч боловсрох эрхтэй гээд заасан байдаг. Хүн бүр гэдэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ч гэсэн хамрагдаж явдаг. Тийм болохоор энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд маань заавал ангийнхаа Цэцгээ юм уу, Чимгээтэй адилхан болж хөгжье гэсэн үг биш. Хөгжлийн бэрхшээл гэдэг бол мэдээж хөгжлийн хувьд тодорхой ямар нэгэн үйлдлийг, эсвэл хоёр гурван үйлдлийг хийж чадахгүй, эсвэл муу хийдэг гэсэн үг. Тухайн үйлийг хийхдээ хязгаарлалттай болсон, магадгүй харж чадахгүй, эсвэл харах нь маш муу болсон гэсэн үг. Хөдөлж явахдаа их муу, эсвэл бүр хөл нь явж чадахгүйн улмаас тэргэнцэр дээр суудаг ч гэх мэт. Тэгэхээр ийм хөгжлийн хувьд ялгаатай байгаа ч гэлээ гэсэн өөрийнхөө боломжит дээд хэмжээнд хүртэл хөгжих ёстой байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц Нэгдсэн үндэстний байгууллагаас гарсан. Энэ конвенцид ингээд заасан байдаг. Тухайн хүнийг өөрийнх нь л тэр чадахаар дээд хэмжээ хүртэл нь хөгжүүлэх гэж. Тэгэхээр одоо манайх бол 2018 онд Боловсролын сайдын 155-р тушаалаар батлагдсан ганцааршилсан сургалтын төлөвлөгөө гээд байгаа. Тэгэхээр энэ ганцааршилсан сургалт буюу хүүхдийг хөгжүүлэх төлөвлөгөө юм байгаан. Одоо энийг манай сургууль цэцэрлэгт мөрдөөд эхэлнэ. Тэгэхээр энэ хүүхэд бүр хөгжөөд, тухайн хүүхдийг өөрийнх нь боломжит дээд хязгаар хүртэл хөгжүүлэх энэ л эрхээ эдэлж чадахгүй байна гэдэг бол үнэхээр харамсалтай. Мөн эрүүл мэндийн, би түрүүн хэлсэн бага насны дэмжлэгт үйлчилгээг цагт нь авч чадахгүй, өөрөөр хэлбэл нөгөө хөгжлийн хоцрогдолтой байгаа юм чинь бага насандаа нолиос дөрвөн насанд бол хүний тархины болон тэр үйлдэхүйг одоо бүхий л үйлийг сурдаг шүү дээ, хүүхэд чинь. Тэгэхээр тэр бүгдийн 80-90 хувийг хүүхэд сурч байдаг энэ насандаа. Тэгэхээр зургаагаас доош насанд болбол 90 хувь нь энэ бүгдийг хийж сурч байдаг бүх юмны суурь тавигддаг. Тэгэхээр энэ яг суурь тавигдах тэр хүний хөгжлийн алтан үе гэж хэлж байгаа тэр алтан үе дээрээ дэмжлэгээ аваад чадаагүй. Яагаад гэхээр хөгжлийн ялгаатай байдал гэдэг болбол тэр ялгаатай хэрэгцээндээ нийцсэн нэмэлт дэмжлэгийг авах ёстой байдаг. Бусад хөгжлийн бэрхшээлгүй хүүхдүүд бол эцэг эхийг нь багахан дэмжээд явахад болбол болчихдог бол хөгжлийн



ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдийн хувьд бол бүр заавал илүү нэмэлт дэмжлэг, нэмэлт засал эмчилгээ, хэл засал, хөдөлгөөн засал гэх мэт нэмэлт ийм тусгай аргачлал хэрэгтэй болж байдаг. Ийм учраас бага насны хүүхдийн дэмжлэг бол бага насанд нь эцэг эхийг нь сургах ёстой байдаг. Гэр бүлдээ энэ дэмжлэгээ авааД явж байх ёстой. Тухайн тэр заслын юм уу тусгай хэрэгцээт мэргэжилтнүүд эцэг эхийг сургахад нь илүү их анхаардаг. Ийм үйлчилгээ байхгүй байгаа учраас манай эцэг эхчүүд тухайн орон нутагтаа "Хүүхэд хөгжлийн төв" гэдгийг байгуулан төрөөс ийм үйлчилгээ байхгүй учраас өөрсдөө чадан ядан төрийн үйлчилгээг бий болтол нь ажиллаж байгаа. Манай долоон аймагт ийм төв байгаа. Улаанбаатар хотод бас ийм гурван төв ажиллаж байгаа. Тэгэхээр ингээд сурч боловсрох эрхээ, хөгжих эрхээ мөн оролцох, оролцохдоо аливаа нийгмийн харилцаанд оролцох байдал нь хязгаарлагдаж байгаа юм. Тэгэхээр зөвхөн гэртээ байгаад байдаг, нийгмийн харилцаанд орохгүй, үе тэнгийнхэнтэйгээ харилцахгүй байна гэдэг бол хамгийн том шийтгэл болж байгаа юм. Тэгээд энэ бага насандаа хөгжиж чадаагүй, өөрөө сурч хөгжиж чадаагүй, нийгмийн харилцаанд орж чадаагүй байдал нь дараагийн насанд хүрсэн хойноо хөдөлмөр эрхлэх, бусад харилцаануудад ороход бол хамгийн том саад болдог. Өөрөөр хэлбэл бусад эрхээ эдлэх боломжгүй байдалд хүргэдэг. Тийм болохоор бага насандаа хөгжиж, эрхээ эдэлж чадаагүй байгаа юм чинь



том болсон хойноо заавал хэн нэгнээс хараат байдалд ордог. Өөрийнхөөрөө өөрөө хөгжих, өөрөө өөрийгөө авч явах гэдэг байдал байхгүй болж үнэхээр харанхуй болдог. Ийм учраас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн төлөө бид нар эцэг эх нь бүр зайлшгүй багаас нь дуугарах, хэлэх хэрэгцээ шаардлага байгаа юм.

Ингээд ерөнхийдөө хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхчүүдэд ч гэсэн маш их асуудлууд тулгарч байгаа шүү дээ. Тэгэхээр эдгээр асуудлуудаас хамгийн том асуудлууд нь таны бодлоор яг юу байдаг вэ?

За энэ бас чухал асуулт. Тэгэхээр эцэг эхчүүдийн хувьд бол маш их тулгамдсан асуудал байна. Нэгдүгээрт гэхэд бид ийм хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй болчихлоо гэхэд биднийг мэдээллээр хангах хэрэгтэй байдаг. За танай хүүхэд хоцрогдолтой байж болзошгүй байна шүү. Та тэгэхээр ийм зүйлд нь анхааралрай ингээрэй гээд төрийн тогтолцоонд байгаа тэр төрийн үйлчилгээ шууд энэ тохиолдолд манай гэрт орж ирээд надад үйлчилгээ үзүүлэх ёстой байдаг юм байна. Бид Японд ийм туршлага судалж байсан. Америкт туршлага судалж байхад хэрвээ хүүхэд нь ямар нэгэн асуудалтай бол миний хаалгыг тогшоод ороод ирдэг. Тэгээд эцэг эхийг нь мэдээллээр хангаад ингээд ингээд та тэгээрэй гээд залаад чиглүүлээд цааш нь явчихдаг. Тэгэхээр энэ юу гэсэн үг вэ гэхээр төрийн үйлчилгээний тогтолцоо нь тухайн хүүхэд хөгжлөөс хоцрогдож болзошгүй байна шүү гээд эцэг эхэд нь дэмжлэгийг үзүүлээд явчихдаг. Ялангуяа нойлоос хоёр настай хүүхдийн хөгжил бол гэр бүл, эцэг эхийн яг хараа асрамжид явдаг учраас тэр үед нь нэмэлт, бага насны дэмжлэг гэдгийг эцэг эхэд нь үзүүлж байдаг. Нөгөө төрөөс үйлчилгээ нь өөрөө ингээд жишээ нь Японд гэхэд хүүхдээ дөрвөн сартайгаас нь авхуулаад товлолт үзлэгүүдийг хийдэг. Товлолт үзлэг гэдэг маань дөрвөн сартай хүүхэд бүрийг үзнэ гэсэн үг. Тэгээд хүүхэд болгоноо аваад ирэхэд нь шүдний эмч хүртэл зөвлөгөө өгч байна. Хүүхдийн аюулгүй байдлын талаар зөвлөгөө өгч, хүүхдээ яаж хооллох вэ гээд зөвлөгөө өгч байна. Энэ ерөнхий үзлэгийг нь биеийн үзлэгийг нь ингээд хийчихэж байгаа юм. Аа хэрвээ тэгээд нэг ямар нэгэн сэжигтэй тохиолдол гарвал илүү нарийн мэргэжлийн эмч үздэг. Тэр чинь дөнгөж өрхийн эмнэлэг дээр л байгаам шүү дээ. Өрхийн эмнэлэг тодорхой үзлэгүүдийг хийгээд хэрвээ үзүүлэх хэрэгтэй гэх юм бол нарийн мэргэжлийн эмч рүү жишээ нь дүүрэг рүүгээ явуулдаг. Тэгээд дараа дараагийн шатанд нь хэрвээ энэ нэлээн хоцрогдолтой юм уу асуудалтай байна гэвэл дараагийн бага насны хүүхдийн дэмжлэгт үйлчилгээнд оруулах уу үгүй юу гэдгээ шийдэх гээд явдаг тогтолцоо байдаг. Тэгэхээр манайд бол юм хийгдээгүй биш, бас хийгдэж эхэлж байгаа. Энэ товлолт үзлэг бол манай Монголд 18 сар, 36 сартай хүүхэд бүрийг товлолт үзлэгт оруулахаар болсон байгаа эрүүл мэндийн сайдын тушаалаар. Тэгэхээр энэ бол бас их дэвшилтэт тогтолцооны ажил байгаа юм. Яагаад гэхээр үнэхээр 18 сартай, 36 сартай зарим хүүхэд маань манай энэ хэлд

ороогүй, манай энэ хөлд ороогүй л байж байгаа гээд яваад байдаг. Гэтэл тэгээд бас хүлээгээд байлгүй эцэг эх бас мэдээлэл авах гэхээр хаанаас авахаа мэддэггүй, тэгээд мэдээлэлгүйгээсээ болоод миний хүүхэд ийм муу, хүнд бэрхшээлтэй хөгжиж чадахгүй учраас энэ хүүхдийг эмчлэх ёстой гэдэг. Мэдээж эмчилгээ хэрэгтэй. Эмчилгээг бол би үгүйсгэхгүй. Хамгийн гол нь эмчилгээ хийлгэж байхын хажуугаар нөгөө хүүхдийн нас, цаг хугацаа гэдэг чинь бид нарыг хүлээдэггүй. Ингээд сар сараар, жил жилээрээ өнгөрч байдаг. Гэтэл нөгөө хүүхдийг хөгжүүлэх үйл ажиллагаа нь орхигдчихсон байна гэдгийг эцэг эх мэддэггүй. Энэ хамгийн харамсалтай асуудал. Тэгэхээр эцэг эх энийгээ мэдээгүй байдаг нь хамгийн хүндрэлтэй асуудал болдог. Мэдээж эцэг эхийн хувьд хамгийн тулгамддаг асуудал бол сэтгэл санааны байдал, яах учраа мэдэхгүй дээшээ тэнгэр хол, доошоо газар хатуу болох үе байдаг. Тэгэхээр яг энэ үед нь жишээ нь яг ийм мөчид л бид нар хүрч үйлчлэх юмсан гэдэг. Одоо манай холбоо боддог. Тэгэхдээ манайх чинь одоо жижиг төрийн бус байгууллага. Чадах хэрээрээ хүрэх гэж байгаа хэрнээ бас тэр бүр бас хүрч чадахгүй байдаг. Тэгэхээр миний саяын хэлээд байдаг, одоо хэрвээ хүүхэд хоцрогдолтой л байвал тэр сэтгэл зүйн үйлчилгээнд эцэг эхийг хамруулдаг, дэмжлэгт үйлчилгээнүүдэд хамруулах. Ингээд л явчихад тэр эцэг эхийн нөгөө нэг тулгамдсан, үнэхээр одоо юугаа ч мэдэхгүй байгаа энэ үед нь болбол дэмжлэг болоод явдаг. Гэтэл зарим тохиолдолд үнэхээр мэдэхгүй эмч нар нь тийм сөрөг хандлагатай, өөрөө ёс зүйн буруу байдлаасаа болоод эцэг эхийг гомдооход хүргэдэг. Тэгэхээр хөгжлийн бэрхшээлд хандах бас ийм сөрөг хандлага гэж байна. Тэр нь юу вэ гэхээр халамжлах хандлага, эсвэл эрүүл мэндийн хандлага гэж. Тэгэхээр халамжлах эрүүл мэндийн хандлага хоёр бол хоёулаа тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй хөгжилд нь садаа болдог ийм хандлага байгаа. Мэдээж халамжлах гэхээр одоо ойлгож байгаа байх. Ингээд л эвий хөөрхий энэ маань ингээд ийм юм чадахгүй, тийм юм чадахгүй, би өмнөөс нь хоолыг нь өгчихье. Хэзээ ч энэ чинь юм сурахгүй шүү дээ гэсэн шиг ийм хандлага байдаг. Эрүүл мэндийн хандлага гэдэг болбол энэ хөгжлийн бэрхшээлтэй хүнийг өвчтөн гэж хардаг. Өвчтөн юм чинь энэ хүнийг эдгээх ёстой, анагаах хийх ёстой. Зарим тохиолдолд хөгжлийн бэрхшээл өвчин байнаа. Үнэхээр эмчлэх хэрэгтэй байдаг. Гэтэл төрөлхийн зарим үе мөч нь байхгүй төрчихсөн хүн байдаг шүү дээ. Жишээ нь осолд ороод хөл гараа тайрах юм уу, эсвэл хэлгүй болчихсон тохиолдол байдаг. Янз бүрийн шалтгаанаас сонсголгүй болчихсон тохиолдол байдаг. Тэгээд эргэшгүй нэгэнт тийм болчихсон. Тэгэхээр эм өгөөд хэлд оруулна, эсвэл сонсголтой болгоно гэж байдаггүй юм байна. Тэр гар хөлийг нь ургамал шиг ургуулчихна гэж байхгүй, харамсалтай. Тэгэхээр энд ямар ч эрүүл мэндийн хандлага хэрэг байхгүй байхгүй юу. Тэгэхээр бид өөрсдөө, гэтэл эцэг эх нь ийм хандлагатай байгаад л эмээр бөмбөгдөөд л эм өгөөд эсвэл хагалгаанд оруулна гээд л хөл дээр нь





босгож авна гээд яваад байдаг. Гэтэл зарим тохиолдолд энэ маань ганцхан эрүүл мэндийн хандлагаараа хандаад байх нь хүүхдэдээ хохиролтой байдаг. Ийм буруу хандах хандлагууд эцэг эхэд байдаг. Энэ нь үнэхээр тэдэнд хүндрэлийг авчирдаг. Тэгэхээр эцэг эхчүүд маань хэрвээ ийм хүүхэд нь хоцрогдолтой бүр ингээд хөгжлийн бэрхшээлтэй болсон тохиолдолд зөв мэдээлэл мэдлэгүүдийг авах юм бол цаашаагаа зөв тийш нь хүүхдээ залах, хөгжүүлэх рүү хандуулах боломжтой болж байгаа юм.

Ерөнхийдөө эцэг эхчүүд маань хүүхдээ хүлээн зөвшөөрч чадахгүй байна гэсэн үг үү?

Чи яг зөв хэллээ. Хүүхдээ хөгжлийн бэрхшээлтэй болчихлоо гэдгийг хүлээн зөвшөөрөхгүй эцэг эх, эмээ өвөө байдаг. Хүүхдээ хөгжлийн бэрхшээлтэй болсон, хүлээн зөвшөөрнө гэдэг нь тэр хөгжлийн бэрхшээлтэй нь хамт цаашаа амьдарна гэсэн үг. Нэгэнт ийм тийм өвчний улмаас юм уу, эсвэл аваараас юм уу, угаасаа бүр ингээд төрчихсөн юм уу байна шүү дээ. Тэгээд л хэрвээ тийм эргэшгүй юм болчихсон л бол одоо хүлээн зөвшөөрөөд харин цаашаа яах вэ, энэ бэрхшээлтэйгээ энэ хүн цаашид яаж энэ нийгэмд амьдрах вэ гэж эцэг эх зорилгоо өөр болгох хэрэгтэй байдаг. Тэгэхгүй эмчилж анагаагаад л, эдгээчихээд л эрүүл болохоор нь нийгэмд оруулна гэдэг ийм хандлагатайгаа ийм зорилгыг тавьчихаар үнэхээр хэцүү болоод энэ нь сүүлдээ яг хүүхдэдээ л хохиролтой болдог. Бид нар эцэг эх өөрсдөө бид нар мөнх биш, харамсалтай. Тэгэхээр нөгөө хүүхдээ бие даах, хүүхдээ хөгжиж энэ нийгэмд өөрөө өөрийгөө аваад явахад сургах, хөгжүүлэх оролцох боломжуудыг бий болгох тал руугаа. бид илүү анхаарахгүй бол нийгэмд байгаа хүүхдээ зөвхөн засаж залаад эрүүл болгоод орхичихоор энэ нийгэм болчихно гэж бодоод байгаа нь маш их өрөөсгөл болчихно. Олон улсад хөгжлийн бэрхшээл гэдэг бол зөвхөн тухайн хүний асуудал биш болсон. Хөгжлийн бэрхшээл гэдэг бол тухайн хүн тодорхой тэр эмгэг согог юм байна, хөгжлийн хязгаарлагдсан

тийм зүйл байна. Гэхдээ түүн дээр нэмээд нийгэм өөрөө хүнийг хөгжлийн бэрхшээлтэй болгодог юм байна. Одоо хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенциор ингээд заагаад өгчихсөн байж байгаа. Өөрөөр хэлбэл жишээ нь явж чадахгүй хүн байна. Тэр хүн тэргэнцэр дээр суучихсан. Тэгэхээр хамгийн гол зорилго тэр хүний хувьд нэг цэгээс нөгөө рүү шилжилт хөдөлгөөн хийх байгаа биз дээ. Тэгэхээр шилжилт хөдөлгөөнөө тэр хүн хийж чадахаар болсон уу, тэргэн дээр суухаар мөн адил чадна. Өөрөө гараараа залаад явна. Гараараа ингээд явж чадахгүй бол зүгээр нэг товч дараад л, урагшаа хойшоо хөдөлгөөд явдаг автомат тэргэнцэр байдаг болчихсон. Тэгэхээр өөрийнхөө тэр согог хөдөлж, нэг цэгээс нөгөөд шилжилт хөдөлгөөн хийж чадахгүй байдлаа тэргэнцрээр орлуулсан. Тэргэнцрээр орлуулаад гудамд гарахаар яадаг вэ? Энэ гудамны боржур байна. Гудам талбайд явж чадахгүй байдал чинь тухайн хүний өөрийнх нь бэрхшээл мөн үү? Биш шүү дээ. Гэтэл нийгэм, хот нь өөрөө тухайн хүнийг гудамд явж чадахгүй байдалд хүргээд хөгжлийн бэрхшээлийг үүсгэж байгаа байхгүй юу. Тэгэхээр одоо олон нийтээрээ хөгжлийн бэрхшээл гэдгийг хардаг болсон. Тэгэхээр тухайн тэр орон нутгийг хариуцсан хорооны засаг дарга энэ хүнийг хөгжлийн бэрхшээлтэй болгож байна аа гэж хардаг, ханддаг болсон. Хажуу талынхаа дэлгүүрт тэргэнцэртээ орж чадахгүй байна аа гэдэг маань тухайн дэлгүүрийн эзэн тэр хүнийг хөгжлийн бэрхшээлтэй болгочихсон байна шүү дээ гэж олон улсад ханддаг, ойлгодог болсон. Жишээ нь, зурагтаар сонсож чадахгүй хүн юу харах вэ? Ам нь ангалзсан хүнийг л харна шүү дээ, тийм үү? Мэдээ сонслоо гэхэд. Гэтэл энэ чинь тухайн хүнийг тухайн зурагтын суваг, тэр хүнийг хөгжлийн бэрхшээлтэй болгож байгаа байгаа. Тэгэхээс тэр хүн өөрөө хэрвээ дохио гараараа дохиод үзүүлчих юм бол яадаг вэ? Ойлгоно. Гэтэл тухайн телевизийн суваг чинь тэр хүнийг хөгжлийн бэрхшээлтэй болгож байна гэдэг ийм ойлголт бий болсон.

Одоо Монголд хүмүүсийг тэгж хардаг болов уу?

Одоо ер нь бас ийм болгох гээд энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд тэмцэж байна. Өөрөө өөрсдийнхөө төлөө. Одоо ингээд өөрөө өөрсдийнхөө дуу хоолойг гаргаж, энэ хөгжлийн бэрхшээлийн эрхийнхээ төлөө хөдөлгөөн гэдгийг өрнүүлдэг болсон. 1970-аад онд Америкт энэ хөдөлгөөн өрнөөд Капитол гээд Вашингтон Ди Си-д байдаг маш өндөр шаттай, тэр шатуудаар нь хөл гаргүй хүмүүс бүр мөлхөөд, бүгдээрээ дээшээ гараад, тэнд хөгжлийн бэрхшээлийн хөдөлгөөнийг, хувьсгалыг хийж байсан. Тэгээд конгрессоор нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлахгүй ямар ч тохиолдолд рехабилити акт 504 гэж гаргуулж байсан. Тэр нь бол их түүхэн, энэ хөдөлгөөний Америкт бол хөгжлийн бэрхшээлийн хөдөлгөөнөөр гаргасан баримт бичиг байдаг. Тэр нь юу вэ гэхээр төрийн департамент төрийн төсвөөс гаргасан хөрөнгө оруулалттай аливаа ажил,

үйлчилгээ бүтээн байгуулалт нь хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээг хангаагүй, ялгаварлан гадуурхсан байж хэрхэвч болохгүй гэдэг ийм заалтыг оруулж өгсөн. Энэ заалтыг л оруулж өгснөөр тэд үнэхээр баярласан, баяр хийсэн. Америкт нэгэнт ийм хууль гарчих юм бол тэр нь хэрэгждэг. Одоо ганц Америк гэхгүй Солонгос, Япон, бусад орон одоогийн Хятад хүртэл. Тэр дэд бүтэц, гудамж талбай, барилга байшин ямар байгааг манайхан бүгд гадаадад явж үзээж хардаг. Тэгэхээр ядаж хамгийн эхний ээлжид төсвийн хөрөнгө оруулалттай бүх барилга байгууламж, ажил үйлчилгээ бүгд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлахгүйгээр энэ ажил үйлчилгээг гүйцэтгэнэ гээд хуулиндаа оруулчихдаг. Тэгээд энэ хуулиар шаарддаг иргэд бид нарыг ялгаварлан гадуурхаж болохгүй. Тэгэхээр ийм байдлаар хүмүүс өөрсдөө эрхийнхээ төлөө тэмцдэг болгуулах гэж бид нар тэмцсэний хүчинд 2016 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүд хамтарч Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам санаачилж "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль"-ийг батлуулсан. "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенци"-ийг Нэгдсэн үндэстний байгууллагаас 2006 онд баталж гаргаад 2009 онд Монгол улс нэгдэж орсон. Энэ конвенци дээр хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгэмд яаж хамруулах вэ, яаж оролцуулах вэ, эрхийг нь яаж эдлүүлэх ёстойг бүгдийг нь заасан байдаг. Нэгэнт энийг улс орон баталсан болбол бүгдийг нь хэрэгжүүлэх ёстой байдаг. Тэгэхээр энэ эрхийг эдлүүлж хэрэгжүүлүүлэхийн төлөө манай эцэг эхийн холбоо зорьж ажиллаж байгаа юм.

Та сая дурдаж байсан, дөрвөн мянган хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ямар ч боловсролын одоо үйлчилгээнд хамрагдаагүй байна аа гээд ярьсан. Энэ болохоор одоо ерөнхийдөө яагаад энэ хүүхдүүд боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, боловсорч чадахгүй тэгээд тэрнээсээ болон хөгжиж чадахгүй байна вэ?





За маш одоо загатнасан газар маажив гэдэг шиг асуулаа, баярлалаа. Яг үнэн. Яагаад энэ олноороо хэдэн мянгаараа боловсролд хамрагдаж чадахгүй байна вэ? Тэгэхээр энд бол тэр хөгжлийн бэрхшээл, өөрөөр хэлбэл тэр боловсролын ялгаатай хэрэгцээнд нь нийцсэн үйлчилгээг нэгдүгээрт боловсролын байгууллага хүргэж чадахгүй байна. Багш нар ийм хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдтэй ажиллах, бас ялгаатай байдлаар заах аргачлалд бас суралцаагүй байна. Тэгэхээр сургууль, сургуулийн ажилтан, удирдлагууд нөгөө халамжийн хандлагатай, эрүүл мэндийн хандлагатай байсаар байгаагийн гай гэж ойлгож болно. Танай хүүхэд бэрхшээлтэй юм сурч чадахгүй. Ялангуяа энэ ямар хүүхдүүдэд тохиолддог вэ? Хүнд болон хавсарсан бэрхшээлтэй хүүхдүүдэд тохиолддог, харамсалтай нь. Тэгэхээр ямар ч бэрхшээлтэй бай, тэр хүнд хөнгөн гэлтгүй хавсарсан ч бай, бэрхшээлтэй ч бай, танай хүүхэд сургууль болон цэцэрлэгт бүрэн хамрагдах боломжтой, бүр чадна гэж хэлмээр байна. Тэгэхдээ тухайн сургуульд нэмэлт дэмжлэг, арга хэмжээ байдаг юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4-р бүлгийн 14-р дөрөвдүгээр зүйл нь яг боловсрол байдаг. Боловсролын бас хүүхдийн эрхийг хангуулах талаар одоо Боловсролын багц хуульдаа өөрчлөлт оруулаад хэлэлцэгдэж байна. Яг эхэлж байна. Тэгэхээр Боловсролын ерөнхий хууль, сургуулийн өмнөх боловсрол, бага, дунд боловсролын тухай хуулиудад иргэний нийгмийн байгууллагууд, ялангуяа бидний нэгдэж орсон Боловсролд тэгш хамруулах үндэсний сүлжээ, Бүх нийт боловсролын төлөө иргэний нийгмийн үндэсний эвсэл нийлээд бид саналаа өгч байгаа. За энэн дээр бид энэ боловсролын гадна байгаа хүүхдүүдийг яаж боловсрол руу оруулдаг юм бэ гэдгийг гадаад улсад ямар байдгийг судалсан. Тэгээд энийгээ тэр хууль дээр

нь байдаг агуулгаар оруулъя гэж судлаад энэ хуулианд саналаа оруулсан байгаа. Тэгэхээр энд дэмжих үйлчилгээ гэдгийг оруулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд нэн ялангуяа хүнд хэлбэрийн бэрхшээлтэй хүүхдэд энэ энэ дэмжих үйлчилгээ гэдэг зүйл байх юм бол хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсролд хамрагдахад нөгөө тусгай хэрэгцээнд нь нийцсэн хариу үйлчилгээ үзүүлж байгаа ийм ажил байгаа. Тэгэхээр би дэмжих үйлчилгээ гэдгээ тайлбарлая. Дэмжих үйлчилгээ гэдэг нь хөдөлгөөн засал, хэл засал, хөдөлмөр засал, хүүхдийн чөлөөт хичээлээс гадуурх хөгжлийн ажиллагаа, дохионы орчуулга, тээврийн үйлчилгээ, туслах багшийн үйлчилгээ ч бас энэ дэмжих үйлчилгээнд орж болдог, сэтгэл зүйн үйлчилгээ гэх мэт. Америкийн ай ди гэдэг хуульд бол 16 нэмэлт үйлчилгээ байдаг. За тэгэхээр энэ дэмжих үйлчилгээг салбар дундын зохицуулалтаар хийдэг ийм үйлчилгээ байгаа. Өөрөөр хэлбэл боловсролын салбар энийг заавал хүргэнэ гэсэн үг биш. Боловсролын байгууллага чинь өөрөө тодорхой зорилготой, стандарттай, хүүхдийг хөгжүүлэх сургуулийн захирал, багш, менежер чинь бүгдээрээ өөр өөрийн хариуцсан ажлуудтай байдаг. Тэгэхээр тэднээр яг тухайн хариуцсан ажлуудыг нь хийлгэмээр байдаг. Хийлгэх ч ёстой. Боловсролынхоо зорилгын төлөө боловсролын байгууллага нь тэр ажлуудаа л хийх ёстой. Гэтэл манайд бол зарим багш нар хүүхдүүдийг авчихангуут саажилтай хүүхдийг, за одоо хөдөлгөөн, заслыг нь яаж хийх вэ гээд л. Ингээд л багш нь өөрөө тэрийг сурах гээд л мөн үү? Үгүй ээ, тийм хэрэгцээ байхгүй. Тэгэхээр ангийн багш яг хичээлээ заах хичээлээ хүүхдүүддээ хүргэх сургахдаа анхаарна. Магадгүй тэр саажилттай хүүхдэд хөдөлгөөн засал хэрэгтэй байвал тухайн сургуулийн захирал бусдаар





гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ гэдэгт энэ дэмжих үйлчилгээг оруулах хэрэгтэй байгаа юм. Тэгэхээр бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээгээр тухайн сургуульд 1-4 хүүхэд л хөдөлгөөн засал шаардлагатай байж болно. Тэгэхээр хуваарийн дагуу тэр хөдөлгөөн засал хийдэг хүмүүсийг гаднаас авчраад, хөдөлгөөн заслыг хуваарийн дагуу 7 хоногт 1-2 удаа хийгээд л болоо. Тэгэхээр энийг тэр сургуулийн захирлын үүрэгт оруулаад бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ худалдан авах боломжийг олгоод бусдаар л гүйцэтгүүлээд явчих иймж лаар дэмжих үйлчилгээ гэдэг ийм салбар дундын тогтолцооны зүйлийг оруулж ирэх хэрэгтэй байгаа юм. Тэгэхээр энийг чинь эрүүл мэндийн салбар гүйцэтгэнэ, мөн заримыг нь халамжийн байгууллага гүйцэтгэнэ. Зарим нь зүгээр хувийн одоо компаниуд, байгууллагууд эсвэл төрийн бус байгууллагууд хийчих ажил байгаа юм. Тэгэхээр бусад байгууллагын энэ дэмжлэгийг авч сургууль, цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжиж, дэмжих үйлчилгээгээр хангаж, өөрсдийнх нь хөгжилд нь тусгай хэрэгцээг нь дэмжих байдлаар хийж чадах юм бол энэ сургуулийн гадна байгаа боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдүүдийг боловсролд хамруулах үүд хаалга нээгдэх юм. Тэгэхээр бид боловсролд тэгш хамруулна, үе тэнгийнхэнтэйгээ хамт сурна, нийгэмших оролцохуйг нь бий болгоно гэж ярьж байгаа аа. Гэтэл нөгөө дэмжих зарим үйлчилгээнүүд нь байхгүй байгаа нь хүүхдүүд боловсролын гадна байхаас өөр аргагүй байдалд хүргэчхээд байгаа юм. Тэгэхээр энийг боловсролын хуульд бол бүр зайлшгүй оруулахын төлөө бид хэлж ярьж яваа юм.

Ерөнхийдөө манай подкастын цаг өндөрлөх дөхөж байна. Тэгээд танаас сүүлийн асуултаа асууя. Одоо ер нь ковид цар тахал хөгжлийн бэрхшээлтэй ихтэй хүүхдүүд болон тэдгээрийн эцэг эхчүүдэд хэрхэн нөлөөлж байгаа вэ?

За энэ одоо үнэхээр бидний биднээс шалтгаалахгүй, бүх хүүхдүүдэд маань, бүх хүмүүст нөлөөлж байгаа зарим тохиолдолд барьц алдсан нөхцөл байдлыг үүсгэж байна. Бид 2020 онд ковид цар тахал гараад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийнхээ хувьд сурч боловсрох, хөгжихөд нь ямар нөлөө үзүүлж байна гээд судлаад үзсэн. Тэгээд бид нарын яг тэр судалсны үндсэн дээр зайлшгүй хэрэгцээтэй хэд хэдэн зүйлийг гаргаж ирсэн юм. Тэрүүгээр юу вэ гэхээр эцэг эхэд дэмжлэг хэрэгтэй байна. Боловсролын яамнаас хэрвээ цахимаар сургалтыг явуулж байгаа бол эцэг эхэд, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхэд хүүхэдтэйгээ ажиллаарай, хүүхдээ дэмжих хэрэгтэй шүү гэдэг зөвхөн хүүхдэд цахим сургалт биш эцэг эхэд цахим сургалтыг хийгээч ээ, та эцэг эхийг дэмжих үйлчилгээнүүд хэрэгтэй байна шүү гэж. Тэгэхээр бид нөгөө хүүхдээ л хөгжүүлье, хүүхдээ л хөгжүүлье гээд ингээд байдаг. Гэтэл хүүхдээ хөгжүүлэх ажил чинь эцэг эх нь тэр хүүхдээ дэмжиж сургах ажил явагдана. Тэр цахим сургалт гэдэг бол өдөрт 1-3 цаг яваад л дуусдаг ажил. Гэтэл үлдсэн цагт нь эцэг эх нь хүүхдээ хөгжүүлэх ажил байгаа учраас эцэг эхийг гэрийн багш

болгох гэдэг ийм төсөл бас хэрэгжүүлээд харамсалтай нь бид 1-2 байгууллагуудад төсөл өгөөд цуцлагдаад байна. Манай Хөвсгөл аймгийн салбар бол энэ талаар бүр туршлагажаад гэрийн багш гэдгийг өөрсдөө туршаад үнэхээр амжилтад хүрсэн туршлага байгаа. Энэ туршлага дээр үндэслээд бид энэ төслийг боловсруулаад ямар ч байсан санхүүжүүлэгч олно гэж найдаж байгаа. Тэгэхээр гэрийн багш буюу эцэг эхийг гэртээ хүүхдээ хичээлийг нь заадаг, хөгжүүлдэг сурган хүмүүжүүлэгч болгоход нь чиглэсэн үйл ажиллагаа л хамгийн маш чухал юм. Энэ бол зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй ч биш нийтэд хамаатай. Ер нь хүн болгон математикч физикч болдоггүй, харин хүн бүр эцэг эх болдог. Тэгэхээр эцэг эх болох энэ ажил үйлдлийг нь дэмжсэн арга хэмжээг авч явуулах зайлшгүй чухал хэрэгтэй юм. Ялангуяа энэ ковидын нөхцөл байдлын үед. Мэдээж ковидын үе тусгай хэрэгцээнд нийцсэн байдлаар цахим үйлчилгээгээ хүргэх чухал. Сонсголгүй хүүхэд дохионы орчуулга гэж байгаа боловч нөгөө дохионы орчуулгаа харах боломж ямар билээ? Тэр дэлгэцийн бүр найм хуваасны нэг дээр байна уу? Түүнийг харахад маш хүнд байна. За анхаарал дутмагшил, хэт хөдөлгөөний эмгэгтэй хүүхдүүд гэж байдаг. Аутизмтай хүүхэд гэж байдаг. Тэгэхээр энэ тусгай хэрэгцээнүүдэд нийцүүлж богино хугацаатайгаар, багш нь удаан, богинохон үг, өгүүлбэрээр ярьдаг юм уу гэх мэтээр тусгай хэрэгцээнд нь нийцсэн байдлаар сургалтын үйл ажиллагааг явуулах хэрэгтэй байгаа юм. Тэгэхээр энэ байдлаар ерөнхийдөө боловсролын байгууллагууд цахим сургалтад суралцаж байна. Цахимаа бас зайны сургалттайгаа хослуулаад бас танхимынхаа сургалттай явбал бас болох байх гэж бид найдаж байгаа.

За ийнхүү цаг зав гарган бид нарт маш үнэтэй туршлага, мэдлэгээсээ хуваалцсан танд маш их баярлалаа. Тэгээд таны цаашдын ажилд амжилт хүсье!

За за маш их баярлалаа. Хөгжлийн бэрхшээл түүн дундаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд минь нийгэмдээ олонтойгоо үе тэнгийнхэнтэйгээ хамтаараа бага наснаасаа хөгжих нь тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд бус нийт хөгжлийн бэрхшээлгүй хүмүүстээ илүү их ачтай тустай, бүр цаашлаад энэ ардчилсан энэрэнгүй ийм нийгмийг бий болгох үндэс суурь болдог гэдгийг би сүүлд нь хэлье гэж бодлоо. Бидний одоо үнэт зүйл болох энэ тэгш хамруулах, хамтдаа байх, хамтдаа хөгжих гэдэг ийм зорилгын төлөө бол бид эцэг эхчүүд явдаг юм. Тэгээд энэ бүгдийг маань олон нийтэд түгээх боломжийг олгосонд баярлалаа. За баяртай.

СПОРТООР ДАМЖУУЛАН ХҮРТЭЭМЖТЭЙ НИЙГМИЙГ ЦОГЦЛООХ НЬ

Б.Алтанцэцэг



Сайн байцгаана уу, эрхэм хүндэт сонсогчид оо, Антолд подкастын маань ээлжит дугаар эхлэхэд бэлэн болоод байна. Энэхүү дугаарт Монголын тусгай олимпийн хорооны гүйцэтгэх захирал Алтанцэцэг оролцож байнаа. За та ийнхүү манай подкастын урилгыг хүлээн авч манай подкастад орохоор болсонд маш их баярлалаа.

Та юуны түрүүн манай сонсогчдод өөрийгөө танилцуулахгүй юу? Яагаад энэ хороонд орохоор болсон гэх мэт зүйлсийг.

За харин та нарт ийм сайхан ярилцлагад оролцож өөрийнхөө санаа бодлоо хэлэх боломжийг надад өгсөнд баярлалаа.

Миний нэр Алтанцэцэг. Одоо бол яг Монголын тусгай олимпийн хорооны гүйцэтгэх захирал гэж явж байгаа. Би одоо нөхөртэйгөө, хоёр хүүхэдтэй, гурван ач зээтэй. Ер нь бол нэг их залуу хүн биш. Тэгээд хувь тавилангаар ч юм уу ингээд Тусгай олимпийн хөдөлгөөнд хамрагдсан байгаа. Ер нь бол миний үндсэн мэргэжил бол геохимич геологич. Одоо Москвагийн их сургуулийг нэлээн олон жилийн өмнө төгссөн. Тэгээд түүнээс хойш Шинжлэх ухааны академид нэлээн олон жил ажилласан. Геологи, уул уурхайн компаниудад нэлээн олон жил ажиллаж байгаад тэтгэврийн нас дөхөж ирээд тэгээд тэр чиглэлээрээ ажиллахгүй байж байгаад одоо дөрөв таван жилийн өмнө энэ Тусгай олимп гэдэг энэ байгууллагад ажиллах уу гэсэн саналыг авсан. Тэгээд Тусгай олимпийн байгууллагыг тэрнээс өмнө нэг их сайн сонсоогүй байж байгаад

байгууллагын үйл ажиллагаа, чиглэлийг товчхон сонирхоод үзсэн чинь ер нь тийм хөөрхөн гоё зорилготой хүмүүнлэг сонирхолтой ажил санагдаад саналыг хүлээж авсан. Тэгээд 2017 оноос хойш Тусгай олимпдоо бараг таван жил ажиллах гээд ажилдаа маш дуртай, ажиллаад байж байна даа.

Та Тусгай олимпийн хорооныхоо талаар танилцуулна уу. Манай ихэнх сонсогчид маань ч бас мэдэхгүй байж магадгүй байх.

Монголын тусгай олимп гэхээсээ илүү Тусгай олимпийн хөдөлгөөний товч түүхийг би танилцуулсан нь дээр байх. Яагаад гэвэл тэгж байж хүмүүс сайн ойлголт авна. Тусгай олимпийн хөдөлгөөн нь анх 1968 онд Америкт байгуулагдсан. Энэ байгууллагыг байгуулахад Юнис Кеннеди Шрайвер гэж эмэгтэй хүн байгуулсан. Энэ эмэгтэй бол АНУ-ын ерөнхийлөгч байсан Жон Кеннедийн эмэгтэй дүү нь юм. Жон Кеннедигийн гэр бүл чинь угаасаа есөн хүүхэдтэй гэр бүл юм байна лээ. За тэгээд энэ Юнис Кеннедигийн яг дээд талын эгч нь Розмари Кеннеди гэдэг оюуны бэрхшээлтэй охин байсан. Тэгээд Юнис тэр Розмаритайгаа насаар нэлээн ойрхон, гэртээ түүнтэйгээ арай ойрхон тоглож өсөж найзалж байсан боловч бага байхдаа олон юмыг их гайхдаг байсан. Тэр нь юу вэ гэхлээр Розмаригийг ээж аав нь арай илүү ялгаварлаад байгаа ч юм шиг гэр бүлээрээ ийшээ тийшээ найз нөхдөөр ч юм уу зочлон очиход тэр охиныг үлдээдэг ч юм уу, тэгээд ер нь нэг жаахан хөдөлгөөнгүй ганцаардсан, заримдаа тэр эгч нь асрамжийн газарт өгчихдөг байхад жаахан байхдаа ойлгодоггүй байсан байна л даа. Тэгээд том болоод ойлгохдоо ер нь энийг чинь ийм оюуны хөгжлийн бэрхшээлтэй юм байна, тийм учраас манай эгч ингээд тодорхой хэмжээгээр ингээд гадуурхагддаг юм байна гээд эгчийнхээ зовлон дээрээс яаж эгч нь өөрт нь ингээд нөлөөлдгийг мэдсэн учраас би том болсон хойноо хээгээ нэгэн цагт энэ шударга биш байдлыг өөрчлөх ёстой гэсэн үндсэн дээр Юнис Кеннеди насанд хүрээд 1968 онд энэ байгууллагыг анх байгуулсан. Жон Кеннедийн ерөнхийлөгч байсан тулдаа бас тодорхой хэмжээний лобби оролцож Тусгай олимпийг Америкт хүлээн зөвшөөрөх төрийн бус хөдөлгөөн болгоход нэлээн тус болсон учраас анх 1968 онд Чикагод анхны Тусгай олимпийн наадмыг Америкийн болон Канадын оюуны бэрхшээлтэй хэдэн тамирчдыг оролцуулан тусгай наадмыг ингэж бий болгоод үүнээс хойш 53 жил болсон байна.

Монголын тусгай олимпийн хороо гэвэл бас л энэ Юнис Кеннедитэй адилхан. Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн санаачилгаар ийм байгууллага байдгийг нь мэдсэн санаачилгаар 2013 онд Тусгай олимпийг байгуулсан. Үүнээс хойш 8 жил болж байна Дэлхийн тусгай олимп бол одоо 190 оронд үйл ажиллагаагаа явуулдаг зургаан сая гаруй оюуны хөгжлийн бэрхшээлтэй тамирчдыг эгнээндээ багтаан багтаасан маш том дэлхийн, ер нь хамгийн том

спортын хүмүүнлэгийн байгууллага гэж явдаг юм юм. Монгол байгуулагдсанаасаа хойш хоёр мянга таван зуу гаруй оюуны хөгжлийн бэрхшээлтэй, хүүхэд залуус, насанд хүрэгчдийг эгнээндээ багтаагаад олон зуун залуучууд, сайн дурын ажилчид, эцэг эхчүүдийг бас энэ үйл ажиллагаандаа оролцуулсан нэлээн идэвхтэй төрийн бус байгууллага байгуулсан байгаа. Ер нь тусгай олимпийн гол зорилго нь болохоор спортоор дамжуулаад, спортын хүчээр дамжуулаад оюуны бэрхшээлтэй хүүхэд залуус болон насанд хүрэгчдийг эрүүл чийрэг болгох, тэднийг гол нь өөртөө итгэлтэй болгох, уралдаан тэмцээнд оролцуулах, тэгснээрээ энэ хүмүүст нийгэмших, найз нөхөдтэй болох, тэгээд энэ хүмүүсийн талаар нийгмийн хандлагыг өөрчлөх зорилгоор байгуулагдсан иймтом хөдөлгөөн юм.

Алсын хараа нь бол хүртээмжтэй, хэнийг ч гадуурхахгүй ялгахгүй тийм нийгмийг бий болгох бодлоготой байгууллага юм. Манай Тусгай олимп бол ер нь бол төрийн бус байгууллага гэж би хэлсэн. Таван хүн л яг ажилладаг юм манай дээр. Бид бол нэлээн олон чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг. Түрүүн хэлснээр залуучууд, сайн дурын залуучууд болон эцэг эхчүүд маш их тусалдаг. Гол чиглэлүүд нь гэхээр мэдээж спортын байгууллага юм чинь спорт байгаа, үүнд бол дасгал сургуулилат хийнэ, уралдаан тэмцээнүүд хийнэ, Тусгай олимпийн өвөл ба зуны наадамд оролцоно, бүсийн тэмцээнд оролцоно гэсэн спортын хөтөлбөр явагддаг. Эрүүл мэндийн хөтөлбөр нэлээн их явагддаг. Мэдээж тамирчид спортын уралдаанд амжилт гаргахын тулд эрүүл чийрэг байх ёстой гэсэн үзсэнээр эрүүл тамирчин, эрүүл олон нийт, гэр бүлийн эрүүл мэндийн сургалт гэсэн олон чиглэлүүдээр үйл ажиллагаагаа явуулдаг. За бяцхан тамирчин гээд хөөрхөн хөтөлбөр байдаг. Энэ нь бол хоёроос найман настай оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тоглоомын аргаар багаас нь спортод дуртай болгох, хөдөлгөөний чадамжтай болгож яваандаа тамирчид болгох зорилгоор ийм хөөрхөн хөтөлбөр байдаг. Энэ нь бол жаахан хүүхдүүд голдуу ээж аавтайгаа нийлээд манай хөтөлбөрт оролцдог. Хамгийн том чиглэлийн нэг бол залуучуудыг хамруулсан хөтөлбөрүүд маш их байдаг. Одоо арван жилийн сургуулийн ахлах ангийн хүүхдүүд, их дээд сургуулийн хүүхдүүд, зүгээр төрийн болон төрийн бус байгууллагад ажилладаг залуучуудад Тусгай олимпийнхүү талаар танилцуулж, манай үйл ажиллагаанд сайн дураараа оролцоход залуучуудын оролцоо чухал гэсэн үүднээс бид нар залуучуудын маш их хөтөлбөрүүдийг зохион байгуулдаг. За тэгээд хамгийн сүүлд нь хэлэхэд мэдээж олон нийтэд зориулсан хамгийн гол нь нийгмийн хандлагыг өөрчлөхөд зориулсан тийм сургалтуудыг маш их явуулдаг. Үүнд, бид багш нар, эмч нар, нийгмийн ажилчид, төрийн байгууллагууд ажилладаг удирдах хэмжээний хүмүүст зориулж ийм нөлөөллийн ажлыг маш их явуулж одоо нийгэмд юу үүсгэснээс манай энэ Тусгай олимпийн үйл ажиллагаа амжилттай явах учраас энэ чиглэлээр ингээд явагддаг байж байгаа.

Одоо ерөнхийдөө Токиогийн пара олимп болж байгаа шүү дээ. Тэгэхээр зарим хүмүүс маань бас сайн ялгахгүй байж магадгүй. Тусгай олимп болон пара олимпийн ялгаа нь юу байдаг юм бэ?

За тийм, бид нар нөгөө Тусгай олимп гээд ярихаар хүмүүс өөдөөс шууд л пара олим уу гэдэг байхгүй юу. Тэр болгонд нь бид эхлээд жоохон эмзэглэдэг байсан. Дараад нь мэдээж энэ хүмүүс ямар нэгэн мэдээлэлгүй учраас л бид нараас ингэж асуужбайгаабайхгэжбодоодтайлбарлахыг хичээдэг. За Тусгай олимп гэдэг нь бол яг оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуус, насанд хүрэгчид байгаа. Тэр нь одоо юу юм гэхээр дауны хам шинжтэй, аутизмын эмгэгтэй, төрөлхийн болон олон саажилттай, оюуны хомсдол буюу нэлээн хоцрогдолтой яг ийм оюунтай холбоотой тийм бэрхшээлтэй хүмүүс тусгай олимпод хамрагддаг. Тусгай олимп нь бүр өөрөө тусдаа. Ингээд пара олимп болон олон улсын олимпоос тусдаа өөрийн гэсэн бас дөрвөн жилийн зайтай өвлийн зуны олимп ингээд явагддаг байж байгаа. За пара олимп та нар одоо яг мэдэж байгаа байх. Зурагтаар гарч байгаа энэ болохоор. Ерөнхийдөө бол голдуу тулгуур эрхтний бэрхшээлтэй, харааны, сонсголын, хэл ярианы гэсэн, тэгээд осол авaарт ороод ямар нэгэн бэрхшээлтэй болсон хүмүүс оролцож байгааг Пара олимп гэж нэрлэдэг. Тэгээд пара олимп, Тусгай олимп байгуулагдсан он сар нь ч гэсэн өөр. Одоо манай Тусгай олимп 1968 онд байгуулагдсан бол пара олимп албан ёсоор 1989 онд байгуулагдсан. Тийм болохоор ялгаа их. За пара олимп бол олон улсын олимп шиг элит тамирчид гэж ярьдаг шүү дээ. Бүр хамгийн мундаг тамирчдыг шалгаруулаад, олон уралдаан тэмцээн хийж байгаад тийм тамирчдаа явуулдаг бол Тусгай олимпийн нэг жаахан ялгаа нь юу вэ гэхээр яг энэ Тусгай олимпийн тамирчдын хүүхдүүд чинь янз янзын чадвартай байгаа учраас тэр дундаас чадвартайгуудыг нь биш, өөрийнхөө тэр одоо тодорхой хүүхэд өөрийнхөө хийж чадах чадамжийнхаа дээд хэмжээгээ гаргаад үзүүлж байгаа үзүүлэлтээр нь тэр хүмүүсийг л бид нар сонгож авдаг. Тусгай олимп дээр очингуутаа яг тэр хүүхэдтэй ойролцоо чадвартай, ойролцоо техниктэй, ойролцоо бэлтгэлтэй хүмүүсийг Тусгай олимпийн нэг юунд оруулаад тэгээд тийм хүмүүс л хоорондоо өрсөлддөг. Тийм учраас тамирчдыг сонгох ялгаа байдаг. Тусгай олимпийн нэг гол зорилго нь алтан медаль, мөнгөн медальдаа биш ер нь бол оролцоо, оюуны бэрхшээлтэй хүүхдүүдийг хүмүүсийг дэмжих, эднийг нийгэмшүүлэх, өөртөө итгэлтэй болоод бид нар чинь бас нэг ийм юу яасан хүн шүү гэдгийг өөрт нь ойлгуулахгүй, яг л адилхан хүмүүс гэсэн утгаар нь оролцоог л их хангах тийм зорилготой л Тусгай олимп, өвөл болон зуны олимп ингээд явдаг. Тэгээд ийм ялгаатай байдаг юм.

Тэгвэл тусгай олимп гэхээр дотроо хэдэн спортын төрлүүдтэй байдаг вэ?

Ер нь спортын бараг бүх төрлөөр байдаг.

Одоо Тусгай олимп нь болохоор спортын дөчин хоёр төрлөөр уралддаг байгаа. За тэгээд дөчин хоёр төрлөөсөө, мэдээж орон орон чинь өөрийн гэсэн спортын бас соёлтой. Байгаль орчноосоо хамаарч шалтгаалаад янз янзын спорт нь арай илүү хөгжсөн байдаг. Манай Монголын тамирчид бол гол төлөв арваад спортод нэлээн идэвхтэй оролцдог. Яг жишээлбэл, ширээний теннис, хөл бөмбөг, сагсан бөмбөг, бочча, волейбол, бадминтон, бөмбөгтэй хоккей, цанын гуталтай гүйлт гэсэн ийм арваад төрөлд маш амжилттай оролцдог.

Өнгөрсөн зуны Тусгай олимпод Монголоос бас тамирчид оролцсон шүү дээ. Тэгээд та амжилтаас нь хуваалцахгүй юу?

2019 онд Абу-дабид Тусгай олимпийн зуны наадам болсон. Түүнээс өмнө манай монгол тамирчид 2015 онд Лос-Анжелесийн зуныхад 14, 2017 онд Австрийн өвлийн олимпод 14 тамирчин оролцсон. Абу-дабигийн зуны олимпод бол манайхаас 28 тамирчин оролцсон. Бараг хоёр дахин илүү. Нийтдээ манай баг дөчин хүний бүрэлдэхүүнтэй баг. Ингээд Арабын нэгдсэн эмират улс руу явсан. За энд манай хорин найман тамирчид долоон спортын төрлөөр тэмцэлдсэн. Энэ нь жүдо, ширээний теннис, хөл бөмбөг, агаарын теннис, бочча, хөнгөн атлетик, усан сэлэлт гээд. Нэг онцлог нь юу вэ гэхээр Тусгай олимпийн багийн тэмцээнүүдийг дан оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд гэхээсээ илүү багаар тоглодог тэмцээнд оюуны бэрхшээлтэй хүүхэд залуучууд болон оюуны



бэрхшээлгүй залуучуудыг нэг баг болгоод бие биеэ дэмжээд бие биеэсээ сураад бие биедээ заах зорилготойгоор зүгээр энгийн хүүхдүүдийг оролцуулдаг. Тэгэхээр манай энэ хорин найман тамирчны долоон тамирчин нь болохлоор дэмжин тоглогчид гэдэг нэртэй зүгээр энгийн манай Тусгай олимпийн сайн дураар ажиллаж байсан залуучууд оролцсон. Эд бол голдуу хөл бөмбөг болон ширээний теннисний багт оролцсон. Ингээд долоон энгийн тамирчин оролцоод нийтдээ хорин найман тамирчин оролцсон. За мэдээж бид явж ирэхдээ их л амжилттай оролцоно гэж явж байсан. Тэгээд нийтдээ арван есөн медальтай ирсэн. Маш сайн. Тэгээд гурван алтан медаль, долоон ширхэг мөнгөн медаль, есөн хүрэл медаль авсан. Тэгээд манай тамирчдыг онгоцны буудал дээр ирэхэд эцэг эх, дэмжигчид, найз нөхөд нь бүр өглөө бүр хоёр ч янзын үлээвэр хөгжимтэй онгоцны буудал дээр тосож авсан. За дөнгөж ирснийх нь дараа тэр үед Монгол улсын ерөнхийлөгч байсан Баттулга, Боловсролын сайд, Нийгмийн хамгааллын сайд нар Засгийн газрын ордонд манай тамирчдыг хүлээж авч бүгдээрэнд нь баяр хүргээд урамшуулаад дараа дараад нь ер нь дэмжинэ гээд манай хүүхдүүдэд маш сайхан, тийм урам дэмийг өгч манай энэ зуны олимпийн наадам ингээд дууссан.

Тамирчдаа Тусгай олимпод илгээхэд мэдээж угаасаа санхүүгийн дэмжлэг хэрэгтэй шүү дээ. Тэгэхээр чинь магадгүй бас маш их зардал гарна. Тэгээд бас явахаас өмнө бэлтгэл сургуулилт гээд зардлууд гарна. Тэгэхээр ерөнхийдөө танай Тусгай олимпийн хорооноос энэхүү санхүүгийн асуудлаа яаж шийддэг вэ? Та сая таван хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг гэж хэлж байсан. Тэгэхээр энэ тал дээр яаж та бүхэн үйл ажиллагаа явуулдаг вэ?

Манайх төрийн бус байгууллага. Ер нь яг албан ёсоор улсаас ямар нэгэн юу бол авдаггүй. Бидний бүх үйл ажиллагаа бол нэлээн тохиолдолд олон улсын Тусгай олимп зарлагдсан ямар нэгэн хөтөлбөрүүдэд бид өөрсдөө саналаа бичиж явуулаад тэрэнд шалгараад тодорхой хэмжээний хөтөлбөрт оролцож тодорхой хэмжээний санхүүжилт авдаг байгаа. Ихэнх санхүүжилт бол мэдээж одоо Тусгай олимпийг дэмждэг байгууллагууд өөрийнхөө нийгмийн хариуцлагын хүрээнд бид нарыг дэмжинэ. Хувь хүмүүс дэмжинэ. Олон улсын байгууллагуудын хандиваар л ер нь манай үйл ажиллагаанууд явагддаг. Хамгийн хэцүү асуудал бол мэдээж бид олон улс руу аль болохоор л олон хүүхдүүдийгээ хамруулахыг хүсдэг учраас олон улс руу гадаад руу явах зардал бол маш их байдаг. Тэгээд тэрэн дээр бол жишээлбэл, Абу-даби дээр бид дөчин хүний багийг тэр хол улс, тэр хол газар руу авч явахад нэлээн их бэрхшээл гарч байсан боловч олон хүмүүстэй ярьж олон уул уурхайн байгууллагууд, олон улсын байгууллагууд дэмжсэнээс гадна Боловсролын яамны харьяа байсан Биеийн тамир, спортын газраас тодорхой хэмжээгээр манай тамирчдын замын зардлыг дааж бид нарын ачааг нэлээн хөнгөлж өгсөн.

Тийм болохоор бид одоо олон улсад олимпод олон тамирчдаа явуулж дэмжлэг авъя гэж л бодож байгаа бол аль болох Тусгай олимпийнхоо талаар олон түмэнд сурталчлах, зөв ойлголт өгөх, тамирчдынхаа түүхийг хуваалцаж, олон хүнд мэдээлэл өгч байж туслалцаа дэмжлэг авч байгаа. Харьцангуй намайг 2017 онд ажилд орж байхтай харьцуулаад үзэхэд одоо бол нэлээн олон хүмүүс Тусгай олимп гэж ярихад өө тийм гээд мэддэг болсон байна лээ. Тийм болохоор одоо манай тамирчдын амжилтыг хэлээд энд тэнд очоод ингээд яриад байхад бол бид нарыг тусалъя дэмжье гэсэн хүмүүс цөөнгүй болсон байгаа. Тэгээд нэг тийм л аргаар бид ингээд мөнгө санхүүгээ босгодог доо.

Тэгвэл одоо ингээд маш олон газраас ингээд дэмжлэг тусламж өгдөг гэхээр бас Монгол улс нэг үеэ бодвол оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх хандлага нь арай сайжирсан гэж ойлгож болох болов уу?

Харин тийм тийм. Би 2017 онд очоод дөнгөж ажилд орчихоод зөвхөн Монголдоо зохион байгуулах үндэсний наадам гээд хоёр гурван газраар хандив тусламж гуйгаад ороход ихэнх хүмүүс Тусгай олимп гэж ярихаар өөдөөс ойлгохгүй, мэдэхгүй, жаахан төвөгшөөсөн дараа ир гэсэн асуудлууд нэлээн гаргаж байсан. 2019 оны Абу-дабигийн тэмцээнд явахад жишээлбэл энд тэндхийн зурагт телевизээр бид ярих бололцоо их



гарлаа. Байгууллагууд дээр ярихад чинь нийгмийн хариуцлага гэдэг асуудал ихэнх байгууллагууд дээр маш өндөр тавигдаж байгаа учраас энэ хүмүүс мэдсэн болохоор Тусгай олимпийн том хөдөлгөөн бас Монгол улсын нэр гэж боддог ч юм уу хандлага бол маш их өөрчлөгдсөн байна. Тэгээд тэр дундаа бид энэ залуучуудын хандлага их өөрчлөгдөж байгаад би маш их баяртай байдаг. Би дандаа хэлдэг залуучуудад та нар энэ залуучууд л хандлагаа өөрчлөх юм бол та нар чинь ирээдүйн бүгдээрээ шийдвэр гаргагчид та нар бүгдээрээ ирээдүйн сайд нар, ирээдүйн багш, эмч нар. Тийм учраас та нар л одоо энэ хүүхдүүдийг бид нарыг дэмжээд байх юм бол энэ хүүхдүүдэд ямар ч бэрхшээл гэдэг юм байхгүй болно. Бэрхшээлийг бид нар өөрсдөө бий болгоод байгаа юм шүү, эд нарт л боломж олгох хэрэгтэй гэж. Залуучуудад таниулах нөлөөллийн ажлыг их хийдэг байж байгаа. Тэгэхлээр өнөөдөр байсан байдал нэг, гурав, дөрвөн жилийн дараа дахиад бид нар 2023 онд Берлиний наадам болоход яваад очих юм бол бүр ч илүү олон хүмүүс бид нарыг дэмжих байх, бүр ч олон хүмүүсийн хандлага нь өөрчлөгдчихсөн байх байх гэж найдаж байна.

Одоо сайн дурын ажил тогтмол хийдэг тийм залуучууд хэр их байдаг вэ?

Ер нь бол яг одоо бид нарын орон тооны ажилчин шиг ингээд дандаа байгаад байдаггүй. Голдуу бид нар залуучуудынхаа сайн дурын ажил ажилчидтайгаа ямар нэгэн одоо уралдаан



тэмцээн бүсийнх ч юм уу, зүүн, төвийн бүсийн ч юм уу, үндэсний наадам дээр тэд нарыгаа авчирч манайд туслалцаа үзүүлдэг, сайн дурын ажил хийдэг. Тийм боловч бид энэ залуучуудын хөтөлбөр гэж би түрүүн ярьсан. Тэр хөтөлбөрийн шугамаар ингээд залуучуудыг өөрсдөд нь сургалт явуулах тус тусдаа нэг оюуны бэрхшээлтэй, нэг оюуны бэрхшээлгүй залуучуудыг хооронд нь нийлүүлээд ямар нэгэн үйл ажиллагаа явуулах гэсэн юугаар бол өдөр тутмын уулзалдаад байдаг залуучууд байж байна, үйл ажиллагаанд тогтмол оролцдог залуучууд байж байна, зарим сайн дурын ажилчдын дүү нь ч юм уу, хамаатан ч юм уу, оюуны хөгжлийн бэрхшээлтэй болохоор ингээд ойлгоод манай байгууллага дээр өөрсдөө хүрч ирээд ингээд бид нар тусалъя дэмжье гэсэн залуучууд ч зөндөө байж байна. Тийм болохоор бол ер нь байгаа. Би одоо энэ залуучуудаараа бол маш их бахархдаг, ялангуяа энэ одоо арав, арван нэгдүгээр ангийн хүүхдүүд, арван хоёрдугаар ангийн хүүхдүүд хэвлэл хичээлийнхээ хажуугаар сая энэ ковидын хажуугаар ч гэсэн хөөрхий маскаа зүүгээд л, манай оффис дээр ирээд л ирээд л нэлээн их ажил ингээд л хийгээд л, амжуулаад л явж байгаа. Одоо хичээл эхлэхээр нэг жаахан намжина. Яваандаа бид энэ сургуулиудаар Тусгай олимпийн хамтарсан сургууль гэсэн нэлээн том хөтөлбөр хэрэгжиж байгаа. Сургуулиудаар явж нөлөөллийн ажил хийнэ. Тэгэхлээр одоо энэ залуучуудын сайн дурынхан бүр их нэмэгдэх байх гэж бодож байна.

Тэгээд харин саяхан танай фэйсбүүк хуудсаас харсан л даа. Нөгөө Билгүүнээгийн хөтөлбөр гээд. Тэр бас тийм энэний нэг үү?

Тийм. Одоо Билгүүнээгээс болоод бид нар нэг айхтар том хөдөлгөөн өрнүүлсэн. “Боломжийг бүгдэд” гээд чи анзаарсан болов уу, үгүй болов уу. Билгүүнээ гээд оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүү байгаа, манай тамирчин. Тэр Баянхошуунд амьдардаг. Тэгээд өөрөө спортоор хичээллэх дуртай, тэгээд фитнессээр хичээллэхээр Баянхошууны тэр хавьд яг фитнесээр хичээллэх заал байхгүй, клуб байхгүй. Машин унаа гэхлээр арай жаахан тийм хүүхдээ зөөх боломжгүй учраас Баянхошуунаас өөрөө өдөрт 1 цаг 30 минут шахуу алхаад хотын төвд байдаг фитнесс дээр ирж өдөр болгон хичээллэж байгаад нэлээн их амжилт олсон. Тэгээд улсын тэмцээнд оролцдог болсон. Тэгэхлээр энэ хүүгээс бид үүдээд, ер нь энэ гэр хорооллын холын алслагдсан дүүрэгт байж байгаа сургуульд явдаггүй оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг яаж спортод ингээд хамруулах вэ гэж бодоод “Боломжийг бүгдэд” гэдэг аяныг Европын сэргээн босголт хөгжлийн банктай ноднин ингээд хийгээд тодорхой хэмжээний мөнгө босгосон. Тэгээд энийгээ бид нар яах гэж байгаа вэ гэхлээр, одоо Улаанбаатар хотын бүр тэр хаа байсан Толгойтод ч юм уу, Налайхад ч юм уу байгаа ямар нэгэн хороо юм уу, дүүргийн ойролцоох спортын клуб эсвэл сургуульд ч юм уу тодорхой хэмжээгээр спортын, одоо манай тамирчдын хичээллэдэг спортын тоног төхөөрөмжийг үнэгүй

аваачиж байршуулдаг ч юм уу, биеийн тамирын заалыг тохижуулаад үнэгүй өгөөд оронд нь тэнд байгаа багш нартай болон удирдах хүмүүстэй нь ярьж та нар одоо энэ хавьд амьдардаг, одоо 20, 21-р хорооны оюуны хөгжлийн бэрхшээлтэй тамирчдыг долоо хоногт хоёроос гурван удаа үнэгүй хичээллүүлэх тийм гэрээгээр ажиллахаар болж байгаа. За мэдээж тэгж ажиллах гэж байгаа багш нарыг бид нар Тусгай олимпийнхоо сургалтад хамруулна. Ийм хүүхдүүдтэй яаж ажиллах талаар зөвлөгөө өгнө. Үүнээс гадна хөдөө орон нутгийн зарим нэг сумдад ч юм уу аймгуудад яг ийм боломжийг хүүхдүүд гэдэг энэ төслийнхөө хүрээнд бас төслүүдийг хэрэгжүүлнэ гээд эхлээд тодорхой хэмжээний мөнгө цугларчихсан байж байгаа. Энэ ажлаа эхлүүлэх гээд байж байна. Тэгээд Билгүүнээ юу гэдэг нь Билгүүн эрдэм гэсэн байгаа чи анзаарсан бол Эрдэм гэдэг нь болохлоор нөгөө Кембрижийн их сургуульд сурч байсан, манай Тусгай олимпод 2018 оноос хойш сайн дурааараа ажиллаж байсан хүү байгаа. Одоо гурав дөрвөн жил ингээд манай хүүхдүүд ерөөсөө салахгүй л дандаа ажилладаг. Тэгээд саяхан АНУ руу сургуульд явуулаад, тэгээд 28-нд орой одоо сургуульдаа онгоцоор явна гэж байхад л хорин наймны өглөө өөрөө тэр Билгүүнтэйгээ дасгалаа хийгээд хөдөлгөөнөө хийгээд л, арай л онгоцноосоо хоцролгүй тэгж хөөрхөн гүйж явж байгаа нь явсан.

Одоо Америкт оччихоод нөгөө Билгүүн яаж байна гээд явахдаа одоо Билгүүний хоёр дасгалд үлдсэн байгаа. Тэрнийг өөрийнхөө Ананд гээд дүүдээ ингээд даалгавар өгчихөөд одоо дүү нь ахынхаа юуг ингээд үргэлжлүүлээд манай тамирчдадаа энэ наад хөтөлбөрийг чинь хийгээд ингээд явж байгаа. Манайд ажилласан сайн дурын ажилчид бол ихэнхдээ ярихдаа өө бид нар одоо оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй яаж ажилланаа, тэд нарт яаж ойлгуулна аа, тэд нар юм сурах болов уу гэж айж эмээж ирсэн. Хүүхдүүд бид нар тэгдэг байсан гэж ярьдаг юм. Тэгээд эд нартай одоо найзлаад нөхөрлөөд олон арга хэмжээ явуулсных нь дараа хэлэхдээ өө бид нар эд нарт зааж өгэхөөсөө илүү бид нар энэ хүүхдүүдээс маш их юм сурлаа. Энэ хүүхдүүд чинь ямар тэвчээртэй хүүхдүүд байдаг юм, бүр ямар гүргэр хүүхдүүд байдаг юм. Тэгээд дандаа л ингээд хүн хүнтэй сайхан ханддаг бид нарыг хэнийг ч одоо гоё хувцастай ч юм уу, нүдний шилтэй ч юм уу , эсвэл тиймээр ерөөсөө ялгаварлан гадуурхдаггүй бид нарыг харахлаараа л, ингээд л дандаа өөдөөс бариад л, тэврээд л, ингээд л байдаг, тэгээд яг хүн гэдэг чинь яг ийм сайхан байх ёстой юм байна гэдэг юмыг бид нар ингээд маш их сурлаа. Тэгээд энэ хүүхдүүдийн хажууд бид нар өөрсдийгөө харьцуулаад бид ямар их тийм одоо юм боддоггүй, өөр хүмүүсийг боддоггүй, тийм амьдралтай байсан гэдгээ хүртэл бидний амьдралыг харах хандлага маш их өөрчлөгдсөн. Одоо би бол ингээд гудамжинд явж байсан ч гэсэн тийм хүүхэд таарахаар энэ бас л ингээд өөрийн гэсэн зовлон түүхтэй байгаа байх даа гэж боддог болсон гээд манай сайн дурын ажилчид,

манай оюуны бэрхшээлтэй хүүхдээс илүү энэ залуучууд их юм сураад их юм мэдээд байна гэж би бодож байгаа. Ер нь тэгээсэй ч гэж би бодож байна. Тийм болохлоор ингэж сайн дурын ажилчдын нөлөө, залуучуудын нөлөө бол зөвхөн манай тамирчид биш өөрсдөд нь маш их нөлөө, өөрсдийнх нь цаашдын амьдралд нь маш их нөлөөтэй болж байгаа гэж би найдаж байгаа.

Ерөнхийдөө ингээд өнөөгийн Монголын нийгэмд танай холбоо болон танай холбооны тамирчдад яг тулгараад байгаа яг тулгамдсан асуудлууд юу байдаг вэ?

За тэгээд л тулгамдсан асуудал гээд л ярихлаар чинь тоолж баршгүй л зөндөө л юм яригддаг юм л даа. Ер нь бол манай Монголд одоо 110 000 хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байдаг. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын судалгаагаар бол ямар нэгэн улс орны хүн амын 2-3 хувь нь оюуны хөгжлийн бэрхшээлтэй гэсэн нэг тийм дундаж тоо байдаг юм байна. Одоо манай хүн амын хоёр хувь гээд хамгийн багаар нь бодоход манай Монголд бол 60-аад мянга гаруй оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хүүхэд залуучууд, насанд хүрэгчид байдаг юм байна. Тэгэхдээ хүн амынхаа юуг бодоход бол ихэнх нь залуучууд л болж таараад байгаа юм. За тэгээд чи мэдэж л байгаа байх. Манай Монголд тусгай 6 сургууль байдаг. Тэрний 4 сургууль нь болохлоор яг оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан сургууль байдаг. Энэ 4 сургуульд 1600 орчим сурагчид байдаг юм. Аа тэгэхлээр цаана нь ингээд бодоход 40-50 мянган хүүхэд залуучууд ямар ч хүнд сургуульд орохгүй, ажил хийхгүй, ямар ч юманд хамрагдахгүй байна гээд бодоод үзэхлээр их л харамсмаар тоо бидэнд санагддаг л даа. Мэдээж хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ер нь тохиолддог бүх л бэрхшээлүүд манай хүмүүст бас л адилхан тохиолдож байгаа.

Одоо хүртээмжтэй боловсролоос авахуулаад, хүртээмжтэй эрүүл мэндийн үйлчилгээнээс авахуулаад хүртээмжтэй нийгэмд оролцох, ажил хөдөлмөр эрхлэх гээд л энэ асуудлууд бүгдээрэнд нь байгаа. Тусгай олимпийнхоо чигээс гэхэд бол манай Тусгай олимп нэгэн спортын байгууллага юм чинь бид нар юу гэж боддог гэхээр одоо манай энэ оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг яаж спортоор хүртээмжтэй бүх хүмүүст ингээд боломжийг нь олгоод спортоор хичээллэж, ядахдаа тэр хөдлөхгүй байгаа биеийг булчингаа хөдөлгөж цусныхаа хангамжийг сайжруулсан, тэр чинь бас тархинд нөлөөлдөг учраас өөрсдийнх нь байдалд нь ч гэсэн эрүүл мэндэд нь ч хэрэгтэй, тэгээд олон найз нөхөдтэй болж чадахгүй байгаа яаж энийг өөрчлөх вэ гэсэн тийм бэрхшээлүүд их байдаг. Ямар ч газар манай оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ээж аав нь дагуулаад ингээд дугуйланд оруулъя гэхлээр яах вэ, багш нар эхний нэг хоёр удаа авах нь авдаг юм шиг байгаа юм.

Яваандаа нөгөө зүгээр эрүүл

хүүхдүүдтэйгээ өрсөлддөг ч юм уу, тийм чадвар байхгүй, янз янзаас болоод л ингээд л хасагдаад л ирдэг. Эцэг эх нь тэр хүүхдүүдийгээ үргэлж дагуулаад л заавал нэг хүнтэй явна шүү дээ тэр хүүхдүүд бол ганцаараа ирнэ гэж бол байхгүй. Тэгээд явах боломжгүй байдаг учраас л бид энэ бэрхшээлийг ядахдаа хүүхдүүдийг бололцоотой, тэгш спортоор хичээллээд нэг жаахан ч гэсэн дасгал хөдөлгөөнтэй байгаасай гэсэн үүднээс л энэ "Боломжийг бүгдэд" гэдэг аяныг эхлүүлсэн байж байгаа. Түрүүн би хэлсэн Европын сэргээн босголтын банктай энэ нэг аяныг их амжилттай эхлүүлээд одоо хэрэгжүүлэх гэж байна. Дөнгөж саяхан Монголын ротари клуб гэж байгаа шүү дээ. Ротари клуб Монголиа болон Мобикомтой нийлээд "Боломжийг бүгдэд 2" гэсэн аяныг одоо амжилтаа яагаад бас тодорхой хэмжээний санхүүжилтээ бид нар босгож байна. Манай энэ аяны гол зорилго нь юу юм бэ гэхээр хөдөө орон нутаг руу энэ хүмүүст ер нь нөлөөллийн ажиллагаа явуулъя гэсэн үүднээс зүүн бүсийн гурван аймаг, говийн бүсийн дөрвөн аймагт ингээд нийт долоон аймагт хоёр бүсийн гурав гурван өдрийн сургалт, бүх шатны одоо сургуульд, аймгийн тамгын газар, нийгмийн ажилтнууд, бага ангийн багш нар, эмч нарт зориулсан бүтэн өдрийн сургалт, дараагийнх нь нэг өдөр болохоор манай оюуны хөгжлийн бэрхшээлтэй орон нутгийн тамирчдыг зүгээр тамирчид зүгээр эрүүл залуучуудтай нийлүүлсэн хамтарсан спортын өдөрлөг тэрнийхээ хажуугаар бид дандаа эрүүл мэндийн үзлэгийг хийчихдэг байхгүй юу. Бас далимдуулаад энэ хүүхдүүдийгээ эрүүл мэндийн үзлэг. Гурав дахь өдөр нь болохоор орон нутагтаа албан ёсоор эрүүл мэндийн байгууллагатай тамгын газартай нь биеийн тамирын газартай орон нутагтаа Тусгай олимпийн талаар танилцуулаад та нар одоо бид нар ийм үйл ажиллагаа эхлүүллээ та нар ер нь тодорхой хэмжээний санхүүжилт, хөрөнгө мөнгө гаргаж яг манай оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудыг дэмжиж ийм үйл ажиллагааг явуулж байгаарай гэсэн маягтай санамж бичиг зурах тийм үйл ажиллагаа хийх юм. Нэг нь Дорнодод зүүн бүсийнх, говийн бүс нь Даланзадгадад Өмнөговьд болно. Ингээд ийм юмнуудыг төлөвлөчихөөд байж байгаа. За одоо харамсалтай нь энэ ковидын байдал бас эвгүй болох гээд л байна. Тэгээд 9 сарын 20-нд хийх ёстой байсан юмнууд нь хойшлогдож магадгүй. Хэрэв гайгүй бол бид ийм хоёр бүсэд нэлээн том ажил хийх гээд төлөвлөчихсөн байж байгаа.

Та сая ковид гээд ярилаа. Ерөнхийдөө энэ ковид цар тахлын нөлөө хэр хүнд тусаж байна?

За ковид цар тахлын нөлөө чинь одоо ганцхан манай Тусгай олимпод ч биш, бүх л газар, бүх л сургууль соёл, улс орноор ингээд явчихлаа. Ялангуяа манай оюуны хөгжлийн бэрхшээлтэй, ялангуяа даунтай хүүхдүүд бол дандаа тийм давхар оноштой байдаг, одоо зүрхнийх ч юм уу, янз бүрийн. Тийм учраас хэрэв манай энэ хүүхдүүд ч юм уу тусах юм бол арай илүү хүнд тусах учраас бид энэ дээр бол маш

болгоомжтой, эрүүл хүүхдүүдээс илүү маш болгоомжтой хандах ёстой байдаг учраас бид сүүлийн бараг хоёр жил шахуу айхтар уралдаан тэмцээн зохиогоод олноор нь цуглуулах бололцоо гарсангүй. Сая нэг жаахан гайгүй болоод байж байтал 2021 онд болох өвлийн олимп маань 2022 онд болчихсон байсан юм. Тэгээд 2022 оны 1-р сард оролцоно гээд манай 16 тамирчин одоо бэлтгэлдээ бэлтгэлээ эхэлчхээд байж байтал 2 хоногийн өмнө 2022 оны өвлийн олимп маань дахиад нэг жилээр хойшлогдоод 2023 оны 1-р сард болчихлоо. Одоо ингээд л иймэрхүү байдлаар бас нөлөөлж байна. Зөвхөн олимп ч биш, бид Монгол дотроо хөдөө орон нутагтаа явуулах тэмцээнүүдээ явуулж чадахгүйдээ маш их харамсаж байна. Манай оффисын утас бол үргэлж л утсаар, ингээд нөгөө муу хүүхдүүд маань л яриад л, тэмцээн хэзээ болох юм, тэмцээн хийж байгаа болох юм гээд л ингээд л ярьдаг юм. Зарим нь ойлгодог юм, зарим нь ойлгохгүй бид нар юм хийхгүй байгаа юм уу, зарим нь гомддог юм. Ээж аавд нь бид нар тайлбарлана тэгээд яах вэ бид нар ноднин онлайнаар нэлээн виртуал тэмцээн явуулж үзсэн. Тэгээд бололцоотой компьютертэй онлайнаар ингээд ээж аав нь хажууд нь суугаад оролцуулах хүүхдүүд нь оролцож байгаа юм. Одоо хөдөө орон нутгийн компьютергүй ч юм уу, ийм нэт байхгүй газрын хүүхдүүд бол яах аргагүй хаягдаж байгаа юм. Тэгээд л дахиад л бид нар бас ингээд л аягүй олон хүүхдүүдэд хүрэх тэд нарыг одоо дасгал



бэлтэл дасгал хийлгэх энэ юмнууд ингээд л хаягдаж л байна. Маш л харамсалтай байна. Тэгэхлээр ковид бол ёстой айхтар нөлөөлж байгаа.

Тэгээд бас нөгөө хүүхдүүд маань, тамирчид маань бас одоо бэлтгэл сургуулилтаа хийе гэхээр бүх ингээд газрууд хаалттай болохоор тэр бас нөлөөлж байгаа байх.

Тэгээд аваад яваад байх газар байхгүй. За сайндаа бид нар цэцэрлэгт хүрээлэн дээр нэг долоо, долоо юм уу арав арваар нэг жижигхэн жижигхэн одоо энэ Билгүүний дасгал гэдэг шиг ингээд цөөхөн цөөхнөөр нь авчраад юу яаж байгаа. Нөгөө хүүхдүүд маань одоо бүр нэлээн уйдаж байгаа, тэгээд ээж аав нар ярьж байна, хөдлөхгүй байна, уйдаж байна тэгэхэд сэтгэл нь хямарч байна, таргалж байна гээд л одоо ингээд л байгаа. Тэр асуудал бол хурц тавигдаад байна. Одоо өвөл болохоор улам л хөдөлгөөн нь багасах байх даа.

Хүүхдүүдээс гадна танай бол хоронд бас насанд хүрсэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэд маань бас хамрагдаж явдаг уу?

Тийм. Тусгай олимп чинь ер нь бол насны хязгаар дээшээ хязгаар гэж бол байхгүй. Яг албан ёсны уралдаан тэмцээнд бол наймаас дээш насны хүүхдүүд ордог учраас бид нөгөө бяцхан тамирчин гээд хоёроос найман настай хүүхдүүдийн тусгай хөтөлбөр байдаг. Дээшээ бол одоо манай зарим хүүхдүүд нөгөө тусгай сургуулиа төгсчихөөд ихэнх нь ажлын байргүй, ажиллах бололцоогүй учраас хорин тавтай хорин зургаатай гучтай ийм залуучууд байж байна. Тэгээд тэд нар ч гэсэн манай хөтөлбөрт оролцоод ажил дээр ирчихсэн явж л байдаг юм. Тэгэхлээр дээшээ насны хязгаар бол ерөөсөө байхгүй.

Оюуны бэрхшээлтэй иргэд хүмүүс гэхээр өөрсдийнхөө эрхийг хамгаалж чадахгүй, тэгээд тэрнээсээ болоод хүмүүс ялгаварлан гадуурхагддаг ч юм уу тэгээд энэ хүмүүс маань нийгэмтэйгээ зохицоход хэцүү байдаг уу? Ер нь ямар байдаг вэ?

Оюуны бэрхшээлтэй хүмүүс бол одоо аутизм гэхэд л ер нь нийгэмших тал дээр л эмгэгтэй байгаа хүмүүс байгаад байгаа шүү дээ. Даунтай хүүхдүүд бол харин ч эсрэгээрээ их тийм нийгэмших, найзлах, хүмүүстэй ойрхон байх, тэврэх дуртай хүмүүс байдаг. Тэгэхлээр Тусгай олимп саяхан тавин жилийн ойгоор ярихдаа ингэж ярьж байсан гэхлээр. Бид нар одоо өнгөрсөн тавин жилд тусгай олимпийн түүхийн тавин жилд оюуны бэрхшээлтэй хүмүүсийн өмнүүр нь орж одоо бүх юмыг нь хийж өгөөд бэлдэж өгч тэд нарын өмнөөс нь ярьж ингээд л бэлэн юман дээр ингэж яаж явлаа. Одоо дараагийн тавин жилийг бол бид оюуны бэрхшээлтэй хүмүүсийн өмнүүр нь биш одоо хажууд нь буюу урдаа оруулж явуулж тэд нарт өөрсдөд нь даалгавар өгье, өөрсдийг нь тэр хэвлэл мэдээллийнхнээр яриулъя, өөрсдөө тэр спонсор газрууд дээрээ очоод түүхээ яриад өөрсдөө мөнгөө

босгон өөрсдөө хурал зөвлөгөөнөө хий гэсэн, одоо ийм залуу атлет лидершип гэдэг хөтөлбөр байж байгаа. Тэгэхлээр энэ оюуны бэрхшээлтэй бүгдээрээ биш юм аа гэхэд тодорхой хэмжээний хүүхдүүдийг бид ингээд сургаад хэлээд яриад өгөх юм бол эд нар ярих газраа ярьчихна, өөрийнхөө түүхийг ярьчихна. Тийм болохоор энэ өөрсдөө чадахгүй учраас эрх нь хасагддаг, эрх нь их зөрчигдөж байна гэсэн асуудлыг жаахан ч гэсэн шийдэхийн тулд энэ хүмүүсийг өөрсдийг нь сургаж өөрсдийг нь чадавхжуулж өөрсдийнхөө төлөө, өөрсдийнхөө эрхийн төлөө явах талаар илүү их анхаарал өгч ажилла гэсэн чигтэй ер нь Тусгай олимпийн дараагийн тавин жилд тийм юм хийнэ гэсэн алсын хараа байж байгаа. Бид Билгүүнээс авахуулаад, одоо жишээлбэл, энэ 9 сард "Зориг" сантай нийлээд "Тамирчны манлайлал" гэсэн үндэсний сургалт болох юм байна. Тэрэн дээр манай Билгүүн өөрөө нэг хэсгийнх нь модератор болно. Манай нэг ажилчинтай цуг өөрөө түүхээ ярина. Дараа нь нэг спортын хөтөлбөр байгаа, тэрийг Билгүүн удирдаад явуулна. Тэгээд бага багаар нь энэ хүүхдүүдийг өөрсдийг нь ингээд өөрөө өөрсдийгөө удирдаж бусдад үлгэр жишээ үзүүлэх маягаар ингэж сургаж байгаа. Билгүүн анх манайд хоёр гурван жилийн өмнө ирж байхдаа ерөөсөө ярьдаггүй хүү байсан. Тэгээд л нэг хөөрхөн сайхан булчинтай нэг хүү. Ээж нь өмнөөс нь яриад л, хөөрхөн өөдөөс хараад л, инээгээд л суугаад байдаг. Одоо сүүлийн үед манай оффис дээр ирэхэд сайхан чөлөөтэй ярьдаг болчихсон, өөрөө сая телевизийн ярилцлага өгч байна, өөрөө өөрийгөө хэлж байна. Би Тусгай олимпод явахаасаа өмнө ичимхий байсан. Одоо би ярьдаг болчихсон, би чөлөөтэй болсон, би их сайхан байна гээд л манай өрөөнүүдээр сайхан чөлөөтэй яваад аягүй тийм гоё, ингээд нээлттэй болчихсон. Тэгэхлээр маш олон Билгүүн шиг хүүхдийг бид одоо бэлдэх хэрэгтэй байна. Тэгэхэд бол эцэг эхийн нөлөө, энэ залуучуудын нөлөө маш их байгаа, Ингээд цөөхөн дөрөв таван бидний ажил биш. Ер нь одоо бараг одоо муугаар ярих юм бол манай улсын хийх ёстой нэлээн том хандуулах ёстой асуудлын нэг л байгаа л даа. Манай төрийн бус байгууллага улсын хийх юмыг бас жаахан ч гэсэн нэг нэмрээ оруулаад бид ингээд л хийгээд явж байна даа.

Танай хорооны цаашдын зорилго, хэтийн зорилго ер нь юу байгаа вэ? Саяын таны хэлсэн цаашдын тавин жил гээд ярьсантай нийцсэн байгаа юу?

Мэдээж бид нарт цаашдаа хийх юм бол зөндөө л байж байгаа. Би түрүүн хэлсэн шүү дээ, манайд одоо дөч тавин мянган хүмүүс байж байна гээд. Тэгэхлээр бид зөвхөн Улаанбаатар хотод байгаа ч юм уу, тусгай сургуульд байж байгаа ч юм уу, хотын төвд байгаа хүүхдүүдтэй л ажиллаад баймааргүй байна. Бид одоо цаашдаа хүрээгээ бүр сайныг тэлээд, одоо бүр гэртээ өдөржингөө цоожлоостой байгаа, зөвхөн оюуны бэрхшээлтэйгээсээ болоод цоожлоостой байгаа, тэгсэн мөртөө бие бялдар эрүүл ингээд спортоор хичээллэж чадахгүй байгаа тэр олон хүүхэд залуучуудыг гаргаж ирмээр байна. Тэр хавьд амьдарч



байгаа хүмүүсийг ингэж бүр уриалаад та нар эдэнтэй ингээд ажилла гэж одоо бүр тэлээд. Хөдөө орон нутагт гэхэд бид арван нэгэн аймагтай л жаахан идэвхтэй үйл ажиллагаатай байгаа. Үлдсэн арван аймагтай ер нь ямар нэгэн үйл ажиллагаа, Тусгай олимпийн талаар яриагүй учраас энэ аймгуудад одоо Тусгай олимпийн хөдөлгөөнийг өрнүүлж энэ аймгуудын хүмүүст танилцуулж, спорт хөдөлгөөнд энэ хүүхдүүдийг чинь яаж нийгэмшдэг вэ, ээж аав нар нь хүүхдүүдээ яаж ил ил гаргаж нийгмийн хандлагыг өөрчлөх талаар, ер нь бол зогсоо зайгүй нөлөөллийн ажил, таниулах ажил, сурталчлах ажил ийм ажлыг л хийх гол зорилго байна. Нийгмийг өөрчилснөөр л бид нар энэ хүүхдүүдийн байдлыг өөрчилнө. Ер нь бол бэрхшээл бол хүүхдүүдэд байгаа юм биш. Бэрхшээл бол бид нарт байгаад байгаа. Бид нар өөрсдөө бэрхшээл гэдэг юмыг чинь бий болгоод байгаа. Тэгэхлээр одоо бэрхшээл гэдэг үгийг боломж гэдэг үгээр л солимоор байна. Сая тавин жилийн ойгоор манай Тусгай олимпийн нөгөө нэг тэргүүн, Юнис Кеннеди гээд байгуулсан эмэгтэйн хүү нь байдаг юм. Тим Кеннеди Шрайвер гээд. Тэр тэгж хэлсэн. Дэлхий дээр хоёр зуун сая оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүн байдаг юм байна. Долоон тэрбум хүн байгаа шүү дээ, манай дэлхий дээр. Тэгэхлээр бид энэ хүмүүст бүгдээрэнг нь аягүй сайхан хүртээмжтэй, ялгаварлан гадуурхахгүй нийгэм байгуулъя л гэж бид нар хүсэж байгаа бол оюуны бэрхшээлтэй хүмүүстэйгээ ажиллах биш тэр үлдсэн цаад 7 тэрбум хэдэн зуун сая хүмүүстэйгээ л ажиллах ёстой. Тэр хүмүүсийн хандлагыг өөрчилсөн цагт манай энэ хөгжлийн бэрхшээлтэй, оюуны бэрхшээлтэй хүмүүс хэзээ ч өөрсдийгөө бэрхшээлтэй гэж бодохгүй, ингээд л ер нь бүх л юм байдаг юм байдгаараа яг бид нар тэр хүмүүс чинь зүгээр эрүүл хүнтэй хандаж байгаа юм шиг сайхан яриад сайхан нийлээд цуг байна. Тэгж байж л бид энэ зорилгодоо хүрнэ гэж байгаа юм. Тэгэхлээр бид ч гэсэн Монголынхоо гурван сая хүндээ нөлөөллийн ажил хийж ойлгуулж байж хандлагыг өөрчилж байж л энэ хүүхдүүдийнхээ амьдралыг өөрчилнө гэсэн үг л дээ. Тэгэхлээр ажил бол маш их. Одоо хэзээ хэдэн жил яриад гүйцэтгэх ёстой юм бүү мэд.

Анх Тусгай олимпийн хороонд ажилд орохоос өмнө болон ажилд орсны дараа таны ертөнцийг харах өнцөг хэрхэн өөрчлөгдсөн бэ?

Ёстой зөндөө өөрчлөгдсөн байх. Анх би чинь ажилд 2017 онд орохдоо үнэнийг хэлэхэд Тусгай олимп ч гэж бараг сонсоогүй, оюуны бэрхшээлтэй хүүхдүүд, тэдний зовлон бэрхшээлийн талаар мэддэггүй байлаа. Биднийг бага байхад чинь одоо эргээд харахад нэг манай байранд ч юм уу зусланд яг нэг тиймэрхүү хүүхдүүд байдаг юм. Одоо би эргээд бодоход яг даунтай хүүхэд байж дээ, аутизмтай хүүхэд байж дээ, саажилтай хүүхэд байж дээ гэж боддог юм. Тэгтэл манай ээж аав нар ч юм уу, өвөө эмээ өвөө нар юу гэж хэлдэг байсан гэвэл хөөе тийшээгээ битгий ороорой, тэр айлын тэр хүүхэд чинь яаж ч магадгүй шүү, чамайг цохиод авч магадгүй, тэгээд элдэв янзын юм битгий сурчихна хол бай гэдэг л юм заадаг байсан. Ер нь бол бид тийм л юманд хүмүүжсэн.Одоо болохлоор тэгж бодохоор ёстой харамсмаар л байна л даа, тэр хүмүүсийн одоо мэдлэг юу дутагдсандаа л тэгж хэлсэн байх. Одоо бол эцэг эхчүүд бол өөр болсон байна. Ялангуяа залуу ээж аав нар хүүхдүүддээ тайлбарлаж өгөөд хандлагыг өөрчилсөн байна. Тэрэнтэй адилхан хүн ер нь ямар нэгэн юманд хандлагаа зөв эрэг өөрчлөхийн тулд мэдлэгтэй, тэр талаараа мэдээлэлтэй ойлголттой байж л өөрчлөгддөг юм байна. Би мэдэхгүй байхдаа бол яаж хандахаа мэдэхгүй, яаж олон түмэнд ярихаа мэдэхгүй, энэ хүмүүсийг ойлгохгүй байсан бол одоо би бүр эд нартай маш ойрхон байгаад эцэг эхтэй нь яриад тэдний түүхийг сонсоод ойлгодог болсноор би дотроо бүр нэлээн өөрчлөгдсөн. Би өөрийнхөө үүргийг юу гэж боддог вэ гэхээр би зөвхөн ганцхан өөрчлөгдөөд зогсохгүй би энэ эргэн тойронд байгаа бүх хүмүүсээ өөрчлөөд бүх хүмүүс над шиг хандлагатай болоосой л гэж би хүсдэг. Манай хүүхдүүд, манай нөхөр бол бүгдээрээ л манай энэ юманд оролцоод л марафон гэхэд л манай нөхөр чинь тавьтай жартай хүн ингээд л зэрэгцээд л гүйж л байгаа юм. Хүүхдүүдээрээ ч гэсэн ингээд л юмнууд хийлгээд л байж байгаа.

Тэгэхлээр би өөрийнхөө л хэмжээгээр энэ юмыг өөрчлөөд ингээд юу яах ёстой тэгж байж л бид нар энэ өөрчлөлтийг гаргана гэдгийг ойлгосон. Энэ хүүхдүүд чинь ямар хөөрхөн, яг жинхэнэ хүнээрээ, ямар ч юугаа алдаагүй сайхан хүмүүс байдаг юм бэ гэдгийг би бас сая Абу-дабид явахдаа маш их ойлголоо. Манай тамирчид чинь хөөрхий тэмцээнүүд дуусчихаад л медалиа авах нь аваад л авч чадахгүй нь ингээд л юунаасаа гараад л ирнэ. Тэгээд л хөөрхий ингээд л нүдээрээ ингээд л



нэг нөгөө бид нарыг л хайдаг бололтой, багш нарыгаа ч юм уу, надыг ч юм уу хайгаад л харангуутаа зэргээр л гүйж ирээд л тэврээд авдаг байхгүй юу. Би Абу-дабигийн хувьд амьдралдаа их тэврүүлж байгаагүйгээр л их хүүхдүүдэд тэврүүллээ хөөрхий. Тэд нар чинь бүр тийм тэвэрч тэврүүлэх тийм юутай хүүхдүүд байдаг. За гэр орноосоо хол байсныг гэж хэлэх үү. Тэгэхлээр би энэ хүүхдүүдийг аягүй сайн ойлгодог. Энэ хүүхдүүдээс илүү зарим зарим эрүүл хүүхэд залуучууд харин тэд нар өөрсдөө их бэрхшээлтэй, асуудалтай юм шиг санагддаг юм шүү дээ. Эд нарыг бодох юм бол тийм. Би ч өөрчлөгдсөн, миний эргэн тойрон ч өөрчлөгдсөн. Манай настай наян хэдтэй ээжтэйгээ ч ярьдаг, тэгээд л зураггаар ярихаар чи гоё ярьж байна, танай хүүхдүүд чинь ёстой хөөрхөн байлаа гээд л ингээд л одоо бүр миний хүүхдүүд шиг л болчихсон л байгаа л даа.

Харин яг ингээд хүнийг ялгахгүйгээр бүр яг ингээд л байгаагаар нь хайрладаг.

Тийм байгаагаараа л хайрладаг. Дургүй бол хэлчихнэ. Бараг чи яачихсан өнөөдөр ямар хачин юутай байгаа юм гээд хэлчихнэ. Тэгэнгүүт хөөрхөн тэврээд авна. Ямар ч тийм муу санаа байхгүй, тэгээд бид нарыг ч гэсэн тийм гэж боддог. Тэгээд өөрийг нь ялгаварлаад байхлаараа ойлгохгүй тэд нар ингээд өөртөө нөгөө ялгаварлалтай хандаж байна гэж ерөөсөө ойлгохгүй байгаад байгаа байхгүй юу. Хүн ер нь бүгдээрээ ер нь эд нар шиг л ийм сайхан сэтгэлтэй ийм сайхан байх ёстой л юм шиг байна шүү дээ. Тэгж байж л бид нар илүү хүмүүнлэг, илүү бие биеэ ойлгодог, илүү бие биеэ хайрладаг, асуудал бага, бэрхшээл бага л болох байх даа. Энэ хорвоо дэлхийн маань.

Ерөнхийдөө ингээд манай подкастын цаг өндөрлөх гэж байна. Тэгээд та цаашдаа ер нь хороондоо хэр удаан ажиллах төлөвлөгөөтэй байгаа вэ?

Одоо тэр чинь хэлэхэд хэцүү асуудал байна шүү. Мэдээж бол бололцоо л байвал би ажиллана. Тэгэхдээ мэдээж миний зорилго залуучуудад ерөнхийдөө жаахан сургаж, энэ Тусгай олимпийн концепцыг, Тусгай олимпийн талаарх мэдээлэл өгч залуу хүмүүсийг сайн бэлдэх хэрэгтэй байна л даа. Миний нэг анзаарсан юм юу гэхлээр ер нь бусад улсуудын Тусгай олимпийн байгууллагыг анзаараад байхад ажиллаж байгаа захирлууд нь ч юм уу, ТУЗ-ийн гишүүд нь ерөнхийдөө нэлээн ахимаг насны хүмүүс байдаг юм. Манайд надтай ажиллаж байсан нэлээн олон залуучууд байсан. Тусгай олимп чинь ерөнхийдөө нэг жаахан тийм хүмүүнлэг талын төрийн бус байгууллага, цалин бага. Яг карьераар өснө гэхэд залуу хүнд жаахан тийм юутай биш байгууллага шүү дээ. Тэгэхлээр яах вэ надтай ажиллаж байсан зарим залуучууд одоо сургуульд сурах гээд явж байна, зарим залуу хүмүүс хүүхэд гаргах гэж байна, ингээд залуу хүмүүсээ алдаад байгаа болохоор бас нэг жаахан нэлээн тогтчихсон цаанаа сурах ч юм уу, хүнтэй суух ч юм уу, бүр сайд дарга болох ч юм уу, тийм амбицгүй тийм хүмүүс байвал

их зүгээр байгаад байгаа юм. Одоо бид нар шиг. Гэхдээ сайн дурын ажилтнууд байгаад байхад ер нь манай байгууллага үргэлж л залуу хүмүүсийн уур амьсгалаар ингээд амьсгалаад байж л байна.

За ийнхүү цаг зав гарган манай подкастад орсонд тань маш их баярлалаа. Тэгээд спортоор дамжуулан хүмүүнлэг нийгмийг бүтээх гэж яваа танд маш их баярлалаа гэж хэлье.

За баярлалаа. Танай энэ подкастыг сонсдог хүмүүс сонсогчид байвал тодорхой хэмжээгээр тэд нарын одоо хандлагад ч гэсэн жаахан ч гэсэн нэг хоёр хүнд ч гэсэн өөрчлөлт өгсөн бол би ярилцлагынхаа үр дүн гэж ойлгож байна. Тэгээд чамд ч гэсэн баярлалаа. Чиний ажилд бас амжилт хүсье.

За баярлалаа. Танайд сайн дурын ажил хийхийг хүсэж байгаа залуучууд яаж холбогдох вэ?

Манай Спишл олимпс Монголиа (Special Olympics Mongolia) гээд фэйсбүүк хуудас байгаа. Спишл олимпекс Монголиа волюнтирс гэсэн байж байгаа. Залуучууд ерөнхийдөө манайх руу бичдэг юм. Ингээд хэдэн наснаасаа авах вэ? Ямар ажил хийх вэ яах вэ гээд. Тэгээд бид холбогдонгуут нь оффисынхоо утас болон бид өөрсдийнхөө утаснуудыг өгөөд манайх руу ер нь холбогдоод ирээд л байж байгаа. Тэгээд манай оффис бол яг хотын Төв шуудангийн хажууд Экспресс тауэрын 607 тоотод байдаг. Ажлын цагаар бол бид нар ер нь өглөө есөөс орой зургаа болтол байж л байдаг юм. Тэгэхлээр бид нартай биеэрээ ирээд манай ажилтай танилцаад манай өрөөнд байгаа зураг хөргийг хараад ганц хоёр тамирчидтай уулзаад ирэхээр сайн дурын ажилчдад бол маш их мэдээлэл болдог. Тэгээд чөлөөтэй. Тэр бол маш чөлөөтэй. Бид нар бол маш дуртай, хүлээж авдаг байгаа залуучуудыг.

За одоо энийг сонссон залуучууд маань холбогдох байх гэж найдаж байна.

Тэгнэ, тийм байх. Найдаж байна.

За баярлалаа танд.

За баярлалаа дахиад амжилт хүсье.

НИЙГЭМД ЭПИЛЕПСИГ ОЙЛГОХГҮЙ БАЙГАА НЬ ХАРАМСАЛТАЙ



Д.Батзаяа

Сайн байцгаана уу, эрхэм хүндэт сонсогчид оо, Антолд подкастын маань ээлжит дугаар эхлэхэд бэлэн болоод байна. Энэхүү дугаарт дугаарт “Элэгсэг оршихуй” эпилепситэй иргэдийн төрийн бус байгууллагын тэргүүн Батзаяа оролцож байна. Та манай урилгыг хүлээн авч подкастад маань ороход болсонд маш их баярлалаа.

Та манай сонсогчдод өөрийгөө танилцуулахгүй юу?

Баярлалаа. та бүхнийг урилга явуулсанд маш их баярлалаа.

Би одоо далын талыг наслаад байна. Монгол дээд сургуулийг бакалаврыг нягтлан бодогч мэргэжлээр төгссөн. Удирдлагын академид нийгэм, улс төрийн удирдахуйн ухааны магистрыг зэрэг хамгаалаад одоо “Элэгсэг оршихуй” төрийн бус байгууллага буюу эпилепситэй иргэдийн төрийн бус байгууллага ажиллуулж байна.

Одоо энэ төрийн бус байгууллагаа ер нь та өөрөө байгуулсан хүмүүсийн нэг үү? Та төрийн бус байгууллагынхаа талаар танилцуулж өгнө үү?

Би нийслэлийн албанд ажиллаж байсан. Тухайн үед эмч маань зөвлөөд миний оношийг анх тодорхойлсон. Эмч надад төрийн албанд байснаас илүүтэй өөртэйгөө адилхан хүмүүстэй ажиллаад өөрийнхөө талаарх мэдээллийг хүргээрэй гэж зөвлөсөн учраас төрийн бус байгууллагаа байгуулсан юм.

Хэдэн онд байгуулж байсан бэ?

2016 онд байгуулсан. Одоо таван жил болж байна.

Тухайн үед та өөрөө байгуулаад явахад ямар байсан бэ? Тухайн үед Монголд эпилепситэй иргэд хэр их байсан бэ?

Тухайн үед эпилепситэй иргэдийн талаарх мэдээлэл нийтэд байгаагүй. Тэгээд хүмүүс энэ өвчнөөсөө ичиж санаа зовоод нэлээд хаагдмал маягтай. Нийгэмших, нийгэмд оролцох үйл ажиллагаануудад нэлээд хаагдмал байсан.

Эпилепси гэж өвчин юм уу, эсвэл эмгэг юм уу? Манай подкастыг сонсож байгаа хүмүүс тэр талаар мэдэхгүй байж магад.

Эпилепси гэж уналт таталтын өвчин юм. Монгол улсын хэмжээнд сүүлийн үед тусдаа гаргана гэж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн бүлэг дээрээ ярьж байгаа. Тэгээд тухайн өвчнийг болохлоор олон улсын хэмжээнд өвчин гэж үзээд хүндрэл бэрхшээлтэй асуудлыг нэлээн авч үздэг. Хөгжлийн бэрхшээл гэж үздэг.

Эпилепситэй хүмүүс маань юунаас болж эпилепситэй болдог вэ?

Эпилепси өвчний хувьд гэвэл хүн бүрийн онош өөр, оношоосоо шалтгаалаад уух эм нь ч өөр. Зарим эмэгтэйчүүдийн хувьд савнаасаа уналт өгдөг. Зарим хүмүүс гэмтэл авснаас, зарим нь төрөлхийн, олдмол гээд янз бүрээр л байгаа.

Ер нь эдгэдэг өвчин юм болов уу? Эсвэл эдгэдэггүй юм болов уу?

Зарим хүмүүсийн хувьд бол эдгэсэн тохиолдлууд байдаг. Гэхдээ одоо бараг 100 хувь гэхгүйгээр 100/1 хувь хүрэхтэй үгүйтэй л байгаа. Зарим эмэгтэйчүүдийн хувьд төрөөд эдгэсэн удаа ч хүртэл байгаа.

Ер нь ямар давтамжтайгаар унаж татдаг вэ?

Уналт таталт хүн бүрийнх их өөр байгаа. Эмээ ууж тогтмол байнга уудаг ч гэсэн тухайн хүн хүн хэрвээ стресстэй байх юм бол эргэн тойрон орчноосоо шалтгаалаад уналт өгөх тохиолдлууд хүртэл гардаг. Гэр орон, өөрийнх нь нерв, стресс юманд санаа зовох, сэтгэл зүйн асуудал л ер нь ихэвчлэн нөлөөлдөг.

Заримдаа жирийн хүн ч гэсэн амьдралдаа ганц хоёр удаа ч юм уу унаж татах бас үе байдаг болов уу?

Заримдаа тиймэрхүү тохиолдлууд байдаг. Хүмүүс хэтэрхий их ядарснаас болдог. Бас огцом нерв стрессээс хүртэл уналт үүсэх тохиолдлууд байдаг.

Тэгэхээр тэрийг ч гэсэн эпилепси гэж тооцох уу? Эсвэл тухайн үеийнх нь нөхцөл байдал тийм болгосон гэж ойлгох уу?

Тухайн үед л нэг, хоёр удаа уналт өгөх тохиолдол гардаг. Ядаргаанаас шалтгаалаад ч юм уу, эсвэл гэнэт огцом

нервитэх юм уу, тухайн асуудлаас шалтгаалаад. Түүнээс биш тэр яг өөрийнх нь байнгын өвчин биш. Нэг, хоёр удаа л нэг тиймэрхүү зүйлүүд хүний амьдралд тохиолдоно.

Эпилепситэй иргэдэд нийтлэг тохиолддог тулгамдсан асуудлууд юу байдаг вэ?

Ер нь Монгол улсын хэмжээнд чухал зүйл нь эмийн асуудал байгаа. Нийт оюуны бэрхшээлийн 70 орчим төрөл байдаг. Тэдгээрийн нэг нь эпилепси юм. Тэр эпилепси нь дотроо бас задардаг. Тэгээд тэрнээсээ шалтгаалаад уналт таталтаа хүртэл янз бүр тул уух эмийнх нь тунг хүртэл өөр өөр эм уудаг. Тэгээд эмийг Монгол улсад оруулж болохгүй хориотой байгаа нь хамгийн гол асуудал болоод байна. Тэр эмийг бараг нууцаар шахуу хилээр оруулж ирж, өвчтэй хүмүүс хэрэглэж байгаа.

Яагаад эмийг нь оруулж ирэхийг хуулиар хориглосон юм бол?

Зарим эм нь бага зэрэг хориотой бодисын асуудал орсон байгаа. Тэгээд яг тухайн хүнд нь хүргэх тоон хэмжээний эмийг оруулах саналыг Эрүүл мэндийн яаманд тавихад уг асуудлыг зөвхөн “Эрүүл мэндийн яам хариуцахгүй, харин Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Батлан хамгаалах яам гурав харилцан зөвшилцөл хийж байж эм оруулах талын асуудлыг шийдэх болно” гэж хамгийн сүүлд уулзсан Эрүүл мэндийн яамны сайд Энхболд хэлсэн.

Тэгэхээр эмээ ууж байж тухайн хүмүүс маань уналт таталтаа багасгаад явмаар байна. Гэвч эмийг нь цаанаасаа өгөхгүй болохоор давтамж нь ойрхон болно гэсэн үг үү?

Тэгнэ. Ер нь бол өдөртөө хэд хэдэн унах тохиолдол хүртэл гардаг. Уналт таталт нэлээн хүндрэл өгнө. Эрүүл хүнтэй харьцуулахад эм бол бидний бараг хоол гэсэн үг.

Тэгээд оношийг нь Монголд сайн оношлоод яг ямар эм уухыг нь тогтоодог эмч, мэргэжлийн ажилтнууд хэр их байдаг вэ?

Монгол улсын хэмжээнд Монголын неврологийн хүрээлэн ерөнхийд нь хариуцаж ажиллаж байгаа. Манай төрийн бус байгууллагын хувьд зөвлөх эмчийг “Альфа долгион” хувийн мэдрэлийн эмнэлгийн Баярмаа эмч маань хийдэг. Тухайн хүний оношийг тогтоож, уух эм, бүр тунг нь хүртэл нэг бүрчлэн тодорхойлж өгдөг. Зарим хүмүүсийн онош хүртэл тодорхойлогдохгүй байх тохиолдол гардаг.

Монгол улсын хэмжээнд эпилепситэй иргэд хэр их байдаг вэ?

Сүүлийн үед насны тоо нь бууралд, хүрээ нь улам тэлээд байгаа. Одоо 5 жилийн өмнө анх нээж байхад “Альфа долгион” эмнэлэг дээр очоод үзүүлж орох гэхэд чинь өдөртөө хүнгүй байх ч тохиолдол байв. Хоёр гурван хүнтэй ч байх тохиолдол байсан. Одоо бол гадаа нь бол



дүүрэн дараалалтай, өлгийтэй хүүхдүүдээ тэврээд байцгааж байна. Тухайн үед 40-50 орчим насны хүмүүс очиж үзүүлж байсан бол одоо хоёр эрүүл хүнээс тийм хүүхэд төрдөг болчихоод байгаа нь гол асуудал болоод байгаа юм.

Энэ ер нь удам дагадаг юм уу? Эсвэл зүгээр төрөхдөө л тийм этгээд төрчихдөг юм уу? Учир шалтгаан нь юунаас гэдэг нь тодорхойлогдсон болов уу?

Би эмч биш л дээ. Тэгэхдээ ажиглалт хийгээд үзэхэд бол уналт таталтын хувьд удам бол дамжина гэж байхгүй. Хоёр эрүүл хүний сэтгэл зүй нь нэлээд хүндрэлтэй, нерв стресстэй үед биеийн хэсгүүдэд нөлөөлсөн охиолдолд өвчтэй хүүхэд гарч байна гэж ойлгож байна. Ер нь сүүлийн үед сэтгэл зүйн асуудал нэлээн тогтвортой, хэт огцом баярлахгүй, хэт огцом нервтэхгүй, өөрөө өвчнөө хянаад эхэлбэл тухайн хүн уналтаа хүртэл хянаад эхэлнэ.

Тэгэж хянах боломжтой байдаг хүмүүс ер нь хэр их байдаг вэ?

Ер нь нийгэмд илүү нээлттэй орох л хэрэгтэй. Тэр өвчин туслаа гээд нөгөө хүн нь нийгмээс өөрийгөө хязгаарлачихдаг. Ганцаардмал байдалтай болоод сэтгэл зүй нь хүртэл тийм болоод ирэхлээр өөрт нь хүндрэл үүсээд өвчин нь улам бүр хүндрээд эхэлнэ. Тийм болохоор төрийн бус байгууллага байгуулах зорилго маань тухайн хүмүүсийг энэ өвчнөөсөө бүр салахгүй юм аа гэхэд уналтын тоо нь хүртэл багасаасай гэсэн талаасаа илүүтэй хандаад тухайн өвчнийг өөрөө хянаж, нийгэмд нээлттэй оролцохыг уриалж дүүргийнхээ залуучуудын хөгжлийн төвийн дэмжигч байгууллагаар ажилладаг байсан. Тэгээд тухайн үед ийм өвчтэй залуучуудыг нийгэмшүүлэхийн тулд улсын хэмжээнд залуучуудын үйл ажиллагаа, залуучуудын чуулган, үйл ажиллагаануудад нээлттэй оролцуулж байсан. Түүнээс хамаараад одоо тухайн үедээ өдөрт 5-10 удаа унадаг байсан хүмүүс маань гэхэд нэг нь л сүүлийн жил гаруй унаагүй, нэг нь түрүү жил гэхэд 6 удаа унасан гэх мэт жишээтэйгээр тоо нь харьцангуй багасаад ирж байна.

Ер нь нийгэмших асуудал чухал юм байна.

Тийм.Тухайн хүний гэр бүлийнх нь хүмүүс, хамгийн гол нь ойр байгаа тэр хүмүүс л

тухайн өвчнийг ойлгох хэрэгтэй. Ялангуяа залуу эцэг эхчүүд энэ тал дээр бүр илүү анхааараасай гэж боддог. Хүүхдийн өвчнийг зөвхөн эмээр дараад байх биш өөрсдөө тэр хүнтэйгээ зөв харилцаад тухайн хүнийг учиргүй эвийлээд бүх юмыг нь дэмжиж хэлж, хийж өгөөд байх биш, тухайн хүнийг бие дааж сурахад нь дэмжлэг болоод аль алиндаа нээлттэй харилцаж байвал илүү дээр байдаг. Харин хаагдмал байдалтай бол тухайн хүн насанд хүрсэн байвал, жишээ нь өрөөндөө ороод л хаалгаа хаагаад л таг болчихвол тэр хүний уналт нь нэлээн хаагдмал болоод ирнэ. Мөн уналт нь улам ихсээд эхэлнэ.

Таны сая ярьж байсан “Альфа долгион” гээд эмнэлэг хэзээ байгуулагдсан бэ?

Би өөрийн оношоо 2006, 2009 онд байна уу тодорхойлсон. Тэр хүртлээ энд тэндхийн эмнэлэг рүү нэлээн олон удаа явсан. Сонгдо, Шастины гурав, нэгдүгээр эмнэлэг, төмөр замын эмнэлгүүдээр зөндөө явсан ч онош тодорхойлогдоогүй. Эрүүл байна л гэж гарч ирээд байсан.

Та “Альфа долгион” эмнэлэг дээр очиж оношоо тодорхойлуулсан уу?

Тийм.

Тэр эмнэлэг нээгдээд олон хүнийг эпилепситэй гэж оношилсон юм уу, эсвэл хүмүүс жаахан нуугддаг ч байсан юм болов уу?

Эмчийн хувьд болохоор эмнэлгээ нээгээд энэ талаараа өөрөө судлаад бүр мэргэжил ахиулаад суралцсан. Улсын хэмжээнд бол ер нь нэгт гэж явдаг эмч байдаг. Тэгээд тухайн хүний энэ өвчнийхөө талаарх мэдээллүүдийг хүмүүст хүргэх гээд тэр эмийн талаарх асуудлыг хүртэл яамдууд дээр санал хүсэлтээ гаргаад явахад Монгол улсын хэмжээнд хэр баргийн хүмүүс авч хэлэлцэхгүй байгаа юм. Бүр Неврологийн хүрээлэнгээс хүртэл нийлж, Сэлэнгэ эмч, Үүрийнтуяа эмч бүгдээрээ нийлээд эм оруулж ирэх талаар асуудал тавьсанд Эрүүл мэндийн яам хүлээн зөвшөөрөхгүй байгаа юм.

Үүнээс гадна эпилепситэй иргэдэд тулгарч байгаа асуудлууд юу байна вэ?

Хамгийн чухал зүйл нь сэтгэл зүй юм. Хүн сэтгэл зүйгээр тайван байгаад эмээ байнга ууж байвал тухайн хүний уналт нь багасна. Гэхдээ уналт багасаад байна, өөрийгөө эдгэрчихлээ гэж бодоод 2 жил шахуу ерөөсөө унаагүй гээд эмээ орхичихсон хүн байдаг. Гэвч нөгөө хүн маань буцаад уналтаа өгөөд эхэлж байна. Тэгэхээр бас энэ тал дээр бас нэлээн урт хугацаатай эмээ уух шаардлагатай байгаа юм.

Урт хугацаатай гэвэл ер нь хэдэн жилийн хугацаанд уувал болдог вэ?

Миний хувьд бол эм уугаад нэлээн хэдэн жил болчихсон. Тэгээд уналт бол 2006 оноос хойш эхэлсэн. Тэгээд оношоо тодорхойлуулаад 2009 оноос хойш гэхээр бараг 13-14 жил ууж байна гэсэн үг.

2016 онд та анх оношоо тодорхойлуулж байхад ямар үйл явдал болоод таны сэтгэл зүйд нөлөөлсөн бэ?

2006 онд уналт өгөөд эхэлсэн. Тэгээд тухайн үед гэмтэл аваад жирэмсэн байсан. Гэмтэл аваад тэрнээсээ болоод уналт өгөөд эхэлсэн. Тэгээд оношоо тодорхойлж чадахгүй явж байгаад "Альфа долгион" эмнэлэгт үзүүлээд оношоо тодорхойлуулж байсан. Одоо 15 жил болж байна.

Жишээлбэл, миний эргэн тойронд эпилепситэй хүн байлаа гэхэд би тухайн хүнд ямар тусламж үзүүлэх ёстой вэ? Эрүүл мэндийн тусламж үзүүлэх ёстой юу? Эсвэл хажууд хүн уналт таталт өгөөд байвал би яг яах ёстой вэ? Та тэр талаар хүмүүст зөвлөгөө өгөхгүй юу?

Хүүхдийн хувьд бол асран хамгаалагч заавал байх хэрэгтэй. Насанд хүрсэн хүнд ч гэсэн бас байх хэрэгтэй. Өөрөө яаж унаж байгаа мөртөө гадуур зоригтой яваад байна аа гэсэн хүмүүс байдаг. Тухайн үедээ өөрийгөө л сайн хянаад сурчих хэрэгтэй байгаа юм. Нийгэмд байгаа нийгэмшлийн асуудал, хүмүүсийн ухамсрын асуудал нэлээн доройтсоноос шалтгаалаад уналтын хэмжээ илүү ихсээд байна гэж ойлгоод байгаа.

Нэг төрлийн, одоо сэтгэл зүйн өвчин л гэж ойлгох уу? Нийгмээс шалтгаалж байгаа стресс.

Одоо тэр талаасаа сэтгэцийн гэж явахгүй, сэтгэл зүйн гэсэн талаасаа л илүүтэй. Тухайн хүн нь уналт таталт өгдөг ч гэлээ бакалавр, магистр, доктороо хамгаалсан өвчтэй хүмүүс ч байгаа. Тухайн хүний тархи уналт өгөөгүй үедээ бол яг эрүүл хүний тархи шиг ажилладаг.

Тэр хүн уналт өглөө гэхэд тухайн үед нь ямар нэгэн анхны тусламж бас үзүүлэх ёстой байдаг уу?

Ер нь анхны тусламж бол зүрхэн тал. Зүрх, тархи хоёр хоорондоо холбоотой байдаг гэдэг. Тэгээд зүүн тал руу нь харуулахгүй, уналт таталт өгч байгаа тохиолдолд баруун тал руу нь харуулах жишээтэй. Анхны тусламж бол хамрын доодох хүн хонхор дээр дардаг. Хамрын доод талын цэг дээр.

Ойролцоогоор хэдэн минут үргэлжилдэг вэ?

Янз бүр. Хүн бүрээс шалтгаалаад. Бүр уналтаа өгчинө. Түр манараад суух ч үе байна. Янз бүр байгаа. Тухайн үед яаж, юунаас болж уналт өгч байгаагаас шалтгаална.

Одоо эпилепстэй иргэд маань өөрөөсөө ичих ч юм уу, унаж татахаас санаа зовоод нийгэмд гарахгүй байна. Эсвэл нийгэмд гарсан ч хүмүүс ялгаварлан гадуурхах явдал хэр тохиолддог вэ?

Ер нь тиймэрхүү зүйлүүд, ялгаварлал бол нэлээн их байгаа. Одоо тухайн хүн ийм өвчтэй гэдгээ хэлбэл төрийн болон төрийн бус, бизнесийн байгууллагууд

ерөөсөө огт ажилд авахгүй байгаа. Тухайн хүн унана, уналтыг нь бид яахаа мэдэхгүй гээд. Зарим ганц нэг хүнийг л ажилд авч байна. Ажил олдсон ч хамруулахгүй байгаа нь гол асуудал болчихоод байна. Нийгэмд тухайн хүнийг ойлгоод ажлыг нь хийлгэж байвал, ялангуяа хамт олон, найз нөхөдтэй байж тухайн хүний уналт нь багасаад эхэлнэ.

Одоо энэ олон эпилепситэй иргэд маань ажилгүй байгаа болохоор санхүүгийн хувьд хүндрэлүүд тулгарна. Тэгэхээр энэ талаас нийгмийн халамж хэр байдаг вэ?

Энэ талаас бол хүүхэд л асран хамгаалагчтай гэж байдаг. Насанд хүрсэн хүмүүсийг бол асран хамгаалагчийн зүйлд бол ерөөсөө хамруулахгүй байна. Одоо халамж гээд тогтоосон зуун хэдэн мянган төгрөг нийгмийн даатгалаас авч байгаа гурван зуугаад мянган төгрөг. Энэ бол ууж эмэнд, бүтэн сарын эмэнд ерөөсөө огт хүрдэггүй. Энэ нь 5-10 хоногийн эмэнд хүрвэл их юм.

Тэр эм нь тийм аймаар үнэтэй байдаг юм уу?

Тийм. Судалгаа хийхэд ялангуяа ихэвчлэн гадаадаас. Жишээ нь 600 шахам гишүүдтэй байна. Тэр хүмүүсийн бүгдийнх нь судалгааг нь аваад үзэхэд ууж байгаа эмийн төрөл гэхэд 30 гаруй төрөл байна.



Тэр төрлүүдээс Монгол улсын хэмжээнд оруулж ирж байгаа 7-8 төрөл л байгаа. Түүнээс 2 нь л хөнгөлөлттэй. Бусад нь бол дэндүү үнэтэй. Тэгээд хүмүүс ихэвчлэн гадаадаас эмээ авч байгаа. Тэр эмүүдийг бараг нууцаар шахуу оруулж ирж байгаа. Тэгээд үнэ нь нэлээд өндөр. Тэгэхлээр гэр бүлийнх нь хувьд нэлээд хүндрэл үүсч байгаа юм.

Тэгэхээр одоо тийм эмээ авч авах, боломжгүй бол тэгээд л унаад л явна гэсэн үг шүү дээ. Тийм тийм аймаар үнэтэй юм чинь.

Харин тийм уналт нь улам бүр ихсээд л тухайн хүн амиа алдах тохиолдол ч гэсэн бас гарч байсан удаатай.
Давтамж нь ихэсхээр гэсэн үг шүү дээ. Тийм.

Тэгээд эпилепсийг болохоор ерөнхийдөө хөгжлийн бэрхшээлд яг ингэж оруулсан байгаа юу? Одоо Монгол улсын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай хууль байгаа. Түүнд эпилепсийг оруулсан уу, оруулаагүй юу?

Эпилепсийг уг нь оруулсан байгаа. Жи-40 гэсэн кодтой явдаг.

Яг аль төрөлд нь ордог вэ? Оюуны бэрхшээл гэдэгт нь ордог уу?

Оюуны бэрхшээл гээд. Хуучин бол сэтгэцийн гэж явдаг байсан. Энэ нэрээ өөрчлөөч, хүмүүст сэтгэл зүйгээр нөлөөлөөд байна гээд. Даун ч тэр, аутизм



ч тэр бүгдийг нь оруулж явж байсан. Тэгээд даун тусдаа гарсан, аутизм тусдаа гарсан. Одоо “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн форум” болон “Шүхэр” гээд хоёр байгууллага байна улсын хэмжээнд. Тухайн хүмүүс одоо эпилепсийг бас тусдаа гаргана гэж форумынхон уг нь хэлсэн байгаа.

Тусдаа бие даасан том төрөл болж, том өвчин болж таарч байна шүү дээ. Одоо Монголд эпилепсийг хүмүүст зөвөөр ойлгуулж, нийгэмд энэ хүмүүсийн талаарх хандлагыг өөрчлөх ажлууд хэр их болдог вэ?

Олон улсын хэмжээний “Нил ягаан өдөр” болдог. Тэгээд тухайн өдрөө Монголын неврологийн хүрээлэн “ Нил ягаан өдөр” өдрийн үйл ажиллагааг бас хамтран зохион байгуулцгаадаг. Тэгээд сүүлийн үед бол харьцангуй илүү нээлттэй явагдаж байгаа. Одоо хуучин “Залуучуудын хөгжлийн төв” дээрээ байхад жишээ нь дүүргийнхээ ерөнхий боловсролын 8 сургуулиудад “Нил ягаан өдөр”-ийн төлөөллүүдээс оролцуулаад “Энэ өвчин ямар өвчин байдаг вэ?” гэдэг талаар тайлбар хийсэн. Энэ нь насны тоо нь бууруад байгааг тухайн хүмүүст илүүтэй ойлгуулахыг хичээж тухайн өдрийн сургалт явуулсан гэсэн үг. Залуучууд илүүтэй сайн ойлгоцгоож байлаа. Бараг одоогийн үеийн оюутны насныхнаас доош насныхан нь илүүтэй ойлгоцгоож байна. Одоо 25-45 хүртэл, түүнээс дээш насны хүмүүс бол тухайн өвчнийг сайн ойлгодоггүй.

Ойлгохгүй болохоороо яг ер нь ямар хандлага үзүүлдэг вэ?

Монгол улсын хэмжээнд, үнэнийг хэлэхэд төр дэндүү дорой ажиллаж байна гэж үзэж байгаа. Учиргүй бас муулах биш. Сайн талтай зүйл ч байгаа л даа төрийн хувьд. Хүмүүст тухайн өвчнийг ойлгуулах, ганцхан энэ өвчин биш бусад хүмүүстэй бие биедээ сэтгэл зүйгээ нээлттэй харилцаасай гэж хүсдэг. Жишээ нь нэг хүнийг гадаа өмссөн зүүсэн хувцсаас нь илүүтэй хамааралд жаахан муухан хувцас өмсөөд юм уу, эсвэл гадаа уналт өгөөд хэвтсэн ухаан алдаад унасан үед нь эрүүл хүмүүс нь бараг дээгүүр нь алхаад гарах шахдаг болж байна шүү дээ өнөөгийн нийгэмд. “Энэ хүн яасан бэ?” гэдгийг ядаж үзээд өгье гээд харах хүн байхгүй. Ямар сайндаа хуулийн зөвлөх хийдэг ах гэхэд жишээ нь уналт өгөөд байж байхад тухайн хүнийг эрүүлжүүлэхэд аваачаад хийчихсэн байгаа. Тэгэхээр дэндүү хүндрэлтэй байгаа. Ялангуяа эрүүл хүмүүс энэ талын өвчнийг илүүтэй зөвөөр ойлгоосой. Тэгээд согтуу байсан ч тухайн хүн нь ямар нэгэн шалтгаантай өвчний шалтгаанаас болоод ухаан алдаж унасан, гадаа нь ямар нэгэн байдалтайгаар уналт өгч ирсэн тэр тохиолдлуудад анхны тусламж үзүүлж байгаасай л гэж үнэхээр хүсч байна.

Ерөнхийдөө нийгмийн хандлага, нийгмийн хандлагаас гадна ойлголт, мэдлэг бага байна гэсэн үг үү?

Тийм. Ялангуяа олон улсын, төрийн байгууллагууд, цагдаагийн ерөнхий газар зэрэг газрууд бол энэ тал дээр бол илүү

нээлттэй байгаасай. Хороо, дүүргүүдийн хэмжээнд тухайн өвчний талаарх сургалтыг хийцгээдэг.

Танай төрийн бус байгууллагаас одоо тийм нөлөөллийн ажлууд хийдэг үү?

Ер нь бол нээлттэйгээр хийдэг. Тэгээд групп маань паблик нээлттэй байсан. Хамаагүй хүмүүс орвол зар тавих тул зөвхөн гишүүн хүмүүстээ үйлчилдэг болгосон. Оюуны бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхчүүдийн холбооны хүмүүс энэ тал дээрээ илүү ажиллаасай л гэж хүсч байна. Нас нь хүрсэн бол ерөнхий боловсролын сургуульд ангийнх нь хүүхдүүдэд тухайн өвчнийг ойлгуулаад "Энэ хүүхдэд та нар тусалж байгаарай" гээд бас сэтгэл зүйн дэм болоод явбал, тухайн хүүхдийг багаас нь ялгаварлал үзүүлэлгүйгээр нэг ангид цугтаа суулгаж байвал тэр хүүхэд илүүтэй хөгжөөд ирнэ. Гадаадад бол үүнийг нээлттэй явуулдаг. Харин Монгол улсад ерөнхий боловсролын сургуулиуд ер нь авахгүй л гэцгээдэг.

Тэгэхээр эпилепситэй хүүхдүүд ерөнхийдөө яаж сурч боловсрох вэ?

Ерөнхий боловсролын сургуульд ч, ерөнхий боловсролын сургуулийн дараа их дээд сургуулиудад гэхэд хориотой л байгаа. Гэхдээ хуулийн хэмжээнд "хөгжлийн бэрхшээлтэй хүнийг үнэ төлбөргүйгээр сургана" гэсэн хуулийн заалтыг хүртэл Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам гэхэд жишээ нь нээлттэйгээр мэдээлж байх хэрэгтэй байна. Тухайн хүн өвчтэй ч гэсэн ерөнхий боловсролын сургуулиа төгссөн бол дараагийн шатанд үнэ төлбөргүйгээр сурах болно гэсэн хуулийн заалт байгаа. Үүнийгээ хүртэл хэлж яваасай гэж үнэхээр хүсдэг. Мэдээллүүд хүмүүст хүрэх нь нэлээн ховор.

Хууль нь гарсан ч хэрэгждэггүй гэсэн үг үү? Эсвэл мэдээлэхгүй байгаа учраас хүмүүс мэдэхгүйгээс сурч чадахгүй байна уу?

Тухайн мэдээллийг аваад энэ хуулийн дагуу явах эцэг эхчүүд байна. Зарим эцэг эхчүүд тэр тал дээр хүүхдүүдээ ерөөсөө анхаарч үзэхгүй байх тохиолдлууд ч байна.

Хүүхэд нь тэгж унас татдаг эцэг эхчүүд хүүхдээсээ ичдэг ч юм уу, хүлээн зөвшөөрөхгүй ч юм уу, түүнээс болоод гэрээсээ гаргадаггүй тохиолдлууд байдаг болов уу?

Байгаа. Ер нь бол насанд хүрсэн хүмүүс, төрсөн хүнийг хүртэл шахуу гэрээс нь гаргахгүй хориотой л байгаад байна. Тэгээд хориотой байх тусам нөгөө хүн чинь улам уналт өгөөд бачуураад бүр илүүтэй нервтэж стрессэнэ.

Тэгэхээр яг гадуур явж байгаад тухайн хүн маань уналт өгөөд, унаад өгвөл ер нь хэр аюултай вэ?

Тухайн хүнд бас бас осолтой л доо. Тэгээд өнөөгийн нийгэмд үнэхээр үнэн юм гэж байхгүй болчихоод байна. Тухайн хүн одоо дор хаяж утсаа хаяхаас авахуулаад

тухайн хүний юмыг аваад явах ч юм уу, эсвэл бусад асуудал байгаа.

Одоо ерөнхийдөө эпилепситэй иргэдэд сурч боловсроход хүндрэл үүсэж байна. Ажил хөдөлмөр хийе гэхээр ажилд авахгүй байна. Ерөнхийдөө гэртээ л байна. Тэгээд халамжаас авч байгаа мөнгө нь эмэнд нь ч хүрэхгүй байна гэж маш олон асуудлууд ажиглагдаж байна. Танд үүн дээр нэмээд өөр ямар асуудлуудын талаар хэлэх санал байна вэ?

Ер нь уух эмийг нь л голчлон оруулах хэрэгтэй байгаад байна Монгол улсын хэмжээнд. Тухайн хүний уух эм, халамж, нийгмийн даатгал гээд тухайн тэтгэвэр тэтгэмжээсээ илүүтэй тухайн хүн илүү боловсроод нийгэмдээ ажиллаж, хөдөлмөр эрхлэлтийн тал дээр илүү нийгэмших нь дээр байна. Өчигдөр уржигдар гээд 9 сарын 23-ны өдөр “Жайка”-ийнхан сургалт хийсэн. Оюуны бэрхшээлтэй хүмүүсүүдийн талаар. Тэнд ихэвчлэн голчлон даун, аутизмын талаар ярилаа л даа. Тэгэхдээ бас бусад оюуны бэрхшээлийн тал дээр үнэхээр олон зүйл байгаа. Тэгээд энэ талынх нь зүйлсийг нь зөвхөн уналт таталт өгөхөөсөө гадна тухайн хүүхэд нь хэлж ярьж чадахгүй байх тохиолдолд ч гэсэн бас нөгөө хавсарсан өвчний шинж тэмдэг илэрсэн тиймэрхүү хүүхдүүдээ хүртэл хамруулж байх хэрэгтэй байгаад байна. Япон улсын жишээнүүдийг хүртэл оруулсан байгаа. Групп дээр мөн хуралдсан хуралдааныхаа талаарх хөтөлбөрүүд дээр сургалт юу хийсэн, юу гэж ярилцсан талаарх мэдээллүүдийг нээлттэй тавьдаг гишүүддээ.

Ковид цар тахлын нөлөө эпилепситэй иргэдэд хэрхэн нөлөөлж байна?

Ер нь тэр тал дээр өөрсдөө л сэтгэл тайван байгаа юм. Ковид гэхээр гол чухал зүйл нь нөгөө эм дээр нь л нөлөөлчихөөд байна. Хил хаагдах юм бол тэр тал дээр тухайн хүний эмны асуудлыг л голчлон оруулах л шаардлагатай. Эмтэй байвал хүн илүү дээр байх болно. Вакцинуудад шинжилгээ хийгээд эхлээд ямар ч байсан эпилепстэй хүмүүст, уналт таталт өгдөг хүмүүст өгөхгүй ээ гээд нөгөө хориотой 40 орчим төрлийн зүйл байсан. Тэр хүмүүс дотор орж байсан. Тэгээд олон улсын шинжилгээ хийгээд вакцин нь илүү сайжраад байгаа



гээд зөвхөн одоо уналт таталттай хүмүүс пайзер вакцин илүүтэй хийлгэвэл илүү тухайн хүнд нь нөлөөлж байна. Бусад нь болохлоор нөлөөлөхгүй, сөрөг нөлөөтэй гэдгийг ямар ч байсан тогтоосон байгаа. Вакцинуудаа хийх, хамгийн чухал зүйл нь 12-оос доош насны хүүхдүүд л вакцингүй. Тэр нь илүүтэй хүмүүст нөлөөлөх вий. Ялангуяа эцэг эхчүүд хэрвээ өөрсдөө өвчин тусах юм бол тухайн таталттай хүүхдээ илүү их хүндрэл үүсэх болов уу гэж бодож байна.

Гадаадын бусад орнуудын эпилепситэй иргэдийн туршлага ч юм уу, бидний сурч болохоор тиймэрхүү зүйлүүд юу байгаа вэ?

Олон улсын хурал жил бүр явагддаг. Хоёр жилийн өмнө Германд олон улсын оюуны бэрхшээлийн асуудлаар хурал болсон. Тэндээс эпилепсийн талаар хурал цуглаанд оролцоорой гээд урилга наашаа явуулахад эндэхийн монгол элчин гаргаж өгөөгүй. Уг нь Германы элчин нь өөрөө эндээ байхгүй байсан. Өмнөөс нь монгол хүмүүс ажиллацгааж байсан. Энэ өвчтэй хүн өөрөө юу боллоо гэж ганцаараа явах вэ гээд. Тэндээ хүн тосож аваад цаанаа энэ хүмүүстэй би хамт байх болно гэж хэлээд ерөөсөө ойлголцгоогүй. Тухайн үеийн ийм олон улсын үйл ажиллагаа, хурал цуглаанд явахад илүү нээлттэй баймаар байна. Уналт таталттай ч гадны улс орнуудад явж байхад чөлөөтэй. Энэ тал дээр энгийн иргэний хувьд бол чөлөөтэй байсан. Монгол улсад жишээ нь гэхэд наашаа хилээр орж ирэхэд өвөл Орос, Монгол хоёрын хоорондох хилийн яг гол дээр гэхэд уналт өгч байх жишээтэй. Тэгэхлээр энэ бас агаар нэлээн нөлөөлж байгаа. Нээлттэй чөлөөтэй амьсгалж байвал тухайн хүн татах нь бага байдаг. Гадагшаа гараад гадаадад унаагүй мөртөө Монголд орж ирээд уналт өгч байгаа юм. Тэгэхлээр бас энэ агаарын асуудал бас нэлээн нөлөөлөл өгч байна даа л гэж бодоод байгаа.

Өөр танд нэмэх зүйл байгаа болов уу?

За энэ тал дээр юутай ч эпилепси гэсэн өвчнийг энгийн иргэд нь илүүтэй сайн ойлгоосой л гэж хүсч байна. Тэгээд үнэхээр энэ уух эмийнх нь асуудлыг нь шийдээсэй. Өөрсдийн төрийн бус байгууллагаас гаргасан гарын авлагад олон улсын туршлагаас оруулж байна. Иймд тухайн хүмүүс энэ талын мэдээллийг илүүтэй аваасай л гэж хүсч байна. Удахгүй энэ гарын авлага нөлөөлөх болно.

За ийнхүү цаг зав гарган манай подкастад орсонд маш их баярлалаа. Маш олон хүмүүс энэ талаар мэдэж ийм хүмүүсийг зөвөөр ойлгож нийгэмшихэд нь туслаасай гэж хүсч байна. Тэгээд таны цаашдын ажилд, төрийн бус байгууллагаа улам идэвхжүүлээд олон хүмүүсийг нийгэмшүүлж нөлөөллөө сайн хийгээд явахад нь амжилт хүсье!

За баярлалаа. Та бүхэнд ажлын амжилт хүсье!

АСРАН ХАМГААЛАГЧИЙГ ДЭМЖИХГҮЙГЭЭР ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙГ ДЭМЖИХ БОЛОМЖГҮЙ

Т.Туяажаргал



Сайн байцгаана уу, эрхэм хүндэт сонсогчид оо, Антолд подкастын маань ээлжит дугаар эхлэхэд бэлэн болоод байна. Энэхүү дугаарт Ээлтэй ертөнц төрийн бус байгууллагын тэргүүн Туяажаргал оролцож байна. Та манай подкастын урилгыг хүлээн авч, оролцохоор болсонд маш их баярлалаа.

Та юуны өмнө манай сонсогчдод өөрийгөө танилцуулахгүй юу?

Баярлалаа. Подкастад ярилцах болсондоо баяртай байна. Намайг Туяажаргал гэдэг. Сэтгүүлч мэргэжилтэй, Ээлтэй ертөнц гэдэг төрийн бус байгууллагыг 2009 онд үүсгэн байгуулаад, өнөөдрийг хүртэл энэ байгууллагад ажиллаад явж байгаа 3 хүүхэдтэй эмэгтэй байна.

Та анх 2009 онд яагаад Ээлтэй ертөнц төрийн бус байгууллага байгуулах болсон бэ? Та төрийн бус байгууллагынхаа талаар танилцуулахгүй юу?

Би сэтгүүлч гэдэг мэргэжилдээ маш дуртай, хайртай байсан, одоо хүртэл хайртай байдаг. Энэ чиглэлд ажиллах болсон шалтгаан нь 2005 онд төрсөн миний дунд хүү 2007 онд бүх чадвараа алдаад байнгын асаргаа шаардлагатай хүүхэд болсон. Тэгээд 2009 он хүртэл хүүхдээ асраад, эмнэлгээр явдаг байсан. Монголд хөгжлийн бэрхшээлтэй гэж хэлэгдэх хүүхдийн нөхцөл байдал хүнд. Дээрээс нь асаргааны мөнгө гэж маш бага мөнгө өгдөг. Тэгээд энэ мөнгөөр нь ээжүүд амьдрах шаардлагатай болдог



гэх мэтчилэн тухайн үед нэлээн олон асуудлууд харагдаж байсан. Угаасаа өөрөө нэлээн нийгмийн идэвхтэй хүн учраас зүгээр байж чадаагүй. Тэгээд 2009 онд хүүгээ хөгжлийн бэрхшээлтэй болсноос хойш 2 жилийн дараа ямар нэгэн юм хиймээр санагдсан. Тэгээд ч манай хүү явах цэцэрлэгийн анги байдаггүй байсан. Тэгээд цэцэрлэгийн ийм анги байгуулъя гэсэн санаа хэсэг хүмүүсийн дунд гараад, төрийн бус байгууллага байгуулсан. Тэгээд Ээлтэй ертөнцийн маань эхлэл тавигдаж байсан. Тэрнээс хойш нэлээн олон ажлуудыг хийсэн байна. Бидний зорьж байсан цэцэрлэгийн анги маань хамгийн анхны тэгш хамруулах боловсролын эхлэл болж 187-р цэцэрлэг дээр байгуулагдаж байсан. Тэр анги 2010-2017 он хүртэл хүүхдүүдээ аваад явсан.

Танай Ээлтэй ертөнц төрийн бус байгууллагын үйл ажиллагаа юунд чиглэж ажилладаг вэ?

Бидний зорилго эсвэл амин сүнс гэвэл яг энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нийгэмд бие хүн болж төлөвшихөд нь нөлөөлөх том зорилгыг агуулж байдаг. Хувь хүн гэдэг өөр ойлголт, бие хүн гэдэг бас арай өөр ойлголт. Том хүрээгээрээ нийгэмд өөрийгөө аваад явах чадамжтай, бусдад туслах боломжтой хүмүүс болгох тухай бодсон. Тийм учраас бид нар Монголд байгаа 12,000 орчим хүүхдүүдийг нийгэмд өөрийгөө аваад явах боломжтой хүмүүс болгох юмсан гэж зорьж, мөрөөдөж ажилладаг. Энэ хүрээндээ бид Эм Си Эс Стейтс (MCS Estates) компанийн дэмжлэгтэйгээр Энэрэл гээд хүүхэд хөгжүүлэх төвийг нээгээд, 4 дэх жилдээ үйл ажиллуулж байна. Энэрэл хүүхэд хөгжүүлэх төвийн санхүүжилтийг шийдэх зорилгоор бид Хоони гээд зөөлөн тоглоомын үйлдвэрийг дэргэдээ ажиллуулж байгаа. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд ээлтэй хууль эрх зүйн орчныг бий болгох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй асран хамгаалагчдын эрх ашгийг хамгаалах чиглэлд анхаарах зорилготой бодлогод нөлөөлөх ажлуудыг хийж байна. Бас хүүхдүүдийг нийгэмшүүлэх, нийгэмд хүүхдүүдийнхээ талаар эерэг ойлголт өгөх зорилготой өдөрлөг, оролцооны хөтөлбөрүүдийг зохион байгуулах гэсэн үндсэн 4 чиглэлд ажиллаж байна.

Та анх Хоони буюу чихмэл тоглоомын үйлдвэрийнхээ санааг яаж гаргаж байсан бэ?

Ээлтэй ертөнцийн салгаж болохгүй нэг асуудал бол яах аргагүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөгөө талд ээж эсвэл аав эсвэл асран хамгаалагч нь 1 тэрэгний 2 дугуй шиг зааваал байдаг. Асран хамгаалагчийг дэмжиж байж бид хүүхдийн хөгжлийг дэмжих ёстой. Асран хамгаалагчийг эдийн засаг, хувь хүний хөгжлийн хувьд дэмжихгүйгээр хүүхдийн хөгжлийг ярих ямар ч боломжгүй. Тэр утгаараа 2011 онд нэг гэнэтийн зүйл бидэнд тохиолдсон. Тухайн үед энэ чиглэлд тийм ч олон төрийн бус байгууллага байдаггүй байлаа. Яг хүүхдээ хараад сууж байгаа ээж, аавуудаас маань олон хүсэлтүүд бид нарт ирдэг байсан. Тэр хүсэлтүүдийн ихэнх нь эм тарианы мөнгөгүй боллоо, түлээ нүүрсний мөнгөгүй боллоо эсвэл хүүхдээ эмнэлэгт үзүүлэх санхүүгийн туслалцаа хүссэн хүсэлтүүд манай байгууллагад нэлээн их ирдэг байсан. Яг байнгын асаргаатай хүүхэдтэй ээж аавууд санхүүгийн хувьд ямар байгаа вэ, энэ асуудлыг сайжруулах ямар боломж байна вэ? гээд эргээд бид нар судалгаа хийж үзсэн. Тухайн 2010 онд байнгын асрах шаардлагатай хүүхэд нь улиралдаа 30,000 төгрөг, хүүхдээ асарч байгаа ээж аавууд сардаа 48,000 төгрөгийн тэтгэмжийг авдаг байсан. Халамжийн тэтгэмж одоо харьцангуй гайгүй болоод хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 188,000 төгрөг сар бүр авч байгаа. Асран хамгаалагч нь 123,100 төгрөгийг аваад тухайн үеэс бол хамаагүй дээр болсон. Гэтэл яг тэр үед улиралдаа 30,00 мянган төгрөг гэдэг сардаа 10,000 мянган төгрөг гэсэн үг. Яг энэ мөнгө нь хүүхдийн асаргаанд битгий хэл гол зогоох хэмжээний мөнгө байсан. Хүүхдээ асрангаа эсгий бүтээгдэхүүн хийх эсвэл



гоёл чимэглэл хийх зэргээр ээж аавууд маань тэр үед дандаа гар урлалын зүйл хийдэг байсан юм билээ. Тэгээд тэрийгээ борлуулна гэдэг нэлээн асуудалтай байдаг нь энэ судалгааны дүнд гарсан.

Бид нар ээж аавуудынхаа хийсэн бүтээгдэхүүнийг борлуулах тал дээр нь дэмжлэг үзүүлж ажиллая гэсэн зорилгоор 2011 оноос хойш олон хүмүүстэй уулзаж явсан. Тэгэхэд 2011 онд Баяр хөөрийн ивээл гээд жүжигчин Жэки Чан Монголд ирээд явахдаа байгуулсан хүмүүнлэгийн сан бид нарт "танай аав ээжүүд зөөлөн тоглоом хийх боломжтой юу? Бид нар 500 ширхэг зөөлөн тоглоом захиалах гэсэн юм. Танай аав ээжүүд хийж чадна гэвэл бид нар захиалга өгье" гэсэн санал тавьсан. Санал анх удаа авч байгаа учраас ер нь хийгээд үзье гэж бодсон. Тэр төсөл амжилттай хэрэгжиж бид нар 500 ширхэг зөөлөн тоглоом хийсэн. Гэхдээ тухайн үед бид нар зөөлөн биш хатуу тоглоомууд хийчихсэн. Материал нь үстэй л материал байхад болно гэж бодож тухайн үед захаас бамбарууш хийж болохоор үстэй материал авч, дотор нь чихдэг материал нь юу байдгийг ч мэдэхгүй зүгээр сентфон авч хийж эхэлж байсан. Зөөлөн тоглоомуудаа хийгээд дуусах явцад маш хүнд байсан. Жижигхэн тоглоомыг хийхэд хамгийн багадаа 20 орчим деталиас бүрддэг. Жижиг жижиг юмнуудыг хайчилна, хайчилсныгаа оёно, тэгээд тэрийгээ чихнэ гээд нэлээн хүнд ажил байдаг. Бид нар тэрийг хийж



дууссаныхаа дараа ер нь ахиж ийм ажил хийхгүй, ээж аавуудынхаа хийсэн юмнуудыг л аваад заръя гэж бодсон. Тэгээд зөөлөн тоглоомыг ерөнхийдөө больё гээд тогтчихоод 2011 оны сүүлээр ийм үйл явдал боллоо, хийхэд нэлээн хүндрэлтэй байлаа гээд бид нар багаараа хуралдсан. Тэгээд хийсэн тоглоомуудын маань орлого орж ирээд, бид нар ээжүүддээ хуваагаад өгөхөд хамгийн боломжтой хувилбар юм шиг санагдсан. Яагаад гэвэл 1 тоглоом худалдаалсан мөнгийг бид нар материалаасаа гадна эсгүүр, оёдол, чихэлт, чимэглэл гээд 4 дамжлага болгоод, 1 тоглоомыг хийхэд 4 хүнд цалин бодогдож очих юм байна гэж мэдсэн. Тэгээд бид нар үүнийг цаашаа үргэлжлүүлээд явъя гэж шийдээд 2011-2018 он хүртэл байгууллагуудын захиалгаар ээжүүд маань хүүхдээ харангаа гэртээ өрхийн үйлдвэрлэл болгоод, зөөлөн тоглоомууд хийсэн. Энэ үйлдвэрлэлд ойролцоогоор 120 орчим ээж аавууд оролцсон байдаг. Энэ өрхийн бичил үйлдвэрлэл 2018 онд Хоони гэдэг нэрэн дор үйлдвэрийн хэмжээнд ирсэн. Одоо бид нар оёдлын, эсгүүрийн машинтай яг үйлдвэрийн хэмжээнд ажиллаад 4 дэх жилдээ ороод явж байна.

Анх чихмэл тоглоом хийхэд дандаа байгууллагуудаас захиалга авдаг байсан уу?

Бид нар зах зээлийн маркетинг гэхээсээ илүүгээр ийм ээжүүд нэгдээд зөөлөн тоглоом хийж эхэллээ гэхэд байгууллагууд илүү дэмжсэн. Жишээлбэл, 1-р эмнэлэгт



зориулж бамбарууш, Батаарын музейд Батаар гээд динозаврыг хийж байсан. Хамгийн сүүлд нь бид нар ер нь Монголынхоо нэг дүрийг гаргаж ирье гээд унага хийж эхэлсэн. Унага хийж эхэлсэнтэй холбоотойгоор маш олон байгууллагууд унаганы захиалга өгдөг болсон. Тэгээд 1-р эмнэлэг манай унаганд цагаан халат өмсгөж эмч нарыг бэлгэдсэн бүтээгдэхүүн болж байсан. Дараа нь Монголын цахилгаан холбоо компани манай унаганы бөгсөн дээр нь унаганы тамга шиг цахилгаан холбооны логог тавиулаад цахилгаан холбооны унага болж байлаа. Моннис групп бид нарыг жил болгон дэмждэг, Дэт пайз гэдэг компаниас жил болгон дэмжиж хүүхдүүдийнхээ шинэ жил, 6 сарын 1-ний бэлгэнд манай хийсэн бүтээгдэхүүнийг авдаг. Бид нар яг мэргэжлийн хүмүүс биш л дээ. Гэхдээ

бид нарыг голоогүй, сайхан сэтгэлтэй хүмүүсийн дэмээр үйл ажиллагаа маань явагдаж өнөөдөр хүрлээ.

Нэг төрлийн старт ап маягаар сонсогдож байна. Тэгээд борлуулалтаа та бүхэн яаж хийдэг вэ? Бас цар тахал борлуулалтад хэрхэн нөлөөлж байгаа вэ?

Одоо 2018 онд бид нарт аз тохиосон. Эм Си Эс Стэйтс компанийнхан бид нарт нэг байрыг үнэ төлбөргүй ашиглах боломж өгч, бид нар Вива Ситид одоо үйл ажиллагаа явуулж байгаа. Өмнө нь гэр гэртээ хийдэг байхад чанар сайжрахгүй байсан. Гэтэл үйлдвэр болоод тогтмол үйл ажиллагаа явуулах боломж бүрдэн бүтээгдэхүүн болгоны чанар сайжраад эхлэхэд бид зах зээл лүү худалдаалах боломжтой гэж үзээд Си Юү (CU) сүлжээ дэлгүүрийн 22 салбарт бүтээгдэхүүнээ тавьсан байгаа. Мэдээж цар тахал хаа хаанаа л нөлөөлж байна. Одоо бүтээгдэхүүний борлуулалт эрс буурсан. Бид нарын төлөвлөсөн маркетингийн төлөвлөгөө, яг төлөвлөгөөний дагуу явагдахгүй хойшлогдоод бараг жил гаран болж байна. Энэ хооронд санхүүгийн эргэлт байхгүйгээс болоод цалин тасалдах гэх мэтчилэн тогтмол хүндрэлүүд үүссээр л байна л даа.

Анх зөөлөн тоглоом хийж эхэлснээс хойш хэдэн эцэг эхчүүдийн санхүүгийн нөхцөл байдал сайжирсан бэ?



Манай ээж аавууд бүгдээрээ, миний хувьд ч гэсэн ямар нэгэн ажил хийгээд явж байхад гэнэт хүүхэд маань өвдөх асуудал их байдаг учраас бид нарын хамгийн сул тал бол маркетингийн үйл ажиллагааны доголдолтой байдаг. Тэр утгаараа манайд ажиллаж байсан ээж аавууд тийм мундаг санхүүгийн эрх чөлөөнд хүрсэн гэж хэлж чадахгүй. Хүний амьдралд нөлөөлж, өнөөдрийн талхны мөнгө, хүүхдийн эм тарианы мөнгөнд нь бага ч гэсэн тус болоод явж чадаж байна. Тэрнээс бүр өөрчлөлт авч ирсэн зүйл байхгүй. Гэхдээ бидний хийж байгаа гол зорилго маань хүүхэд хөгжүүлэх төвийн санхүүжилт гэдэг маш том зүйлийг хариуцдаг учраас энэ бол ашгийн төлөө газар биш. Бүгдээрээ багахан хэмжээний цалин авааД ч гэсэн давхар хүүхэд хөгжүүлэх төвөө өнөөдрийг хүртэл авч явж байна гэдэг бид нарын хувьд хамгийн том зорилго, амжилт маань гэж хэлэх байх.

Та анх хүүхэд хөгжүүлэх төвийг яагаад байгуулах болсон бэ? Монголд хүүхэд хөгжүүлэх төв хэр олон байдаг вэ?

Тэр 2011 онд бид анх зөөлөн тоглоомын өрхийн үйлдвэрлэл эхлээд явж байхдаа л "бүгдээрээ зөөлөн тоглоомоо хийгээд эсвэл өөр ямар нэгэн юм хийгээд хажуудаа хүүхдүүдээ хөгжүүлдэг газартай болох юмсан" гэж хоорондоо ярьдаг байсан. Өглөө ажилдаа хүүхэдтэйгээ хамт ирээд л, орой явахдаа хүүхэдтэйгээ хамт явдаг ийм л газартай болох юмсан гэж бид нар мөрөөддөг байсан. Тэгээд мөрөөдлөө биелүүлэх гэж олон жил явсан. Ye үеийн улсын их хурлын гишүүн болгонтой 12-р сарын 3-ны өдөр буюу олон улсын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах өдрөөр уулздаг, сонгууль болгоноор албан тоотууд өгдөг байсан. Нийслэлийн засаг даргын тамгын газар луу ч гэсэн бид нар олон удаа хандаж "актлагдсан байруудаасаа бидэнд ажлын байр гаргаж өгөөч ээ, бид иймгазар байгуулах гэсэн юм" гээд маш олон жил явсан. Энэ бид нарын том мөрөөдөл байсан. Тэгээд нэг талаасаа хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг 6 хүртэлх насанд нь Улаанбаатар хотод бол 186-р цэцэрлэг эсвэл Хүслийн ордон гэх мэтчилэн цэцэрлэгүүдэд хамруулж болно. Харин 6-аас дээш насны хүүхдээ бид нар хаана ч хамруулж чадахгүй, хандах газаргүй байдаг.

Монголд тэгш хамрагдах боловсрол гээд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд энгийн сургууль, цэцэрлэгт явах боломжтой гэж хуульдаа заасан боловч яг хүүхэд болгон тэгш хамрагдах боловсролд суралцах боломжгүй байдаг. Тэгэхээр бид нар ийм л газартай болох юмсан гэж олон жил гүйсний эцэст Өгөх өдөр төрийн бус байгууллагаар дамжуулаад Эм Си Эс Стэйтс компанийнхан байр гаргаж өгснөөр бидний мөрөөдөл биелэгдсэн. Одоо бид нар мөрөөдлөө биелүүлчхээд, мөрөөдөл дотроо л амьдраад явж байна. Тэгэхээр энэ хүүхэд хөгжүүлэх төв Монгол улсад ганцхан байдаг гэж ам бардам хэлнэ. Яагаад гэвэл манайх хүүхдүүддээ цогц үйлчилгээ үзүүлдэг. Эмчилгээ гэвэл сэргээн засал, хөдөлгөөн засал, хөдөлмөр засал,

хэл засал, бариа массаж гээд хүүхдүүд юу хэрэгтэй бүх цогц үйлчилгээг нь бид нар үзүүлж чадаж байгаа. Энэрэл төв маань нийтдээ 2 бүлэгтэй. Энэ 2 бүлгийн маань нархан бүлэгт байнгын булчингийн чангаралттай, тархины саажилт оноштой хүүхдүүд байдаг, ахлах бүлэгт маань оюуны бэрхшээлтэй хүүхдүүд явдаг. Энэ хоёр бүлэг маань хоёулаа хоёр өөр стандартын дагуу, хоёр өөр хөтөлбөрөөр хүүхдүүдэд үйлчилгээ үзүүлдэг. Оюуны бэрхшээлтэй хүүхдүүдээ ирээдүйд Хоони зөөлөн тоглоомын үйлдвэрийн ажилтнууд болгохоор одооноос бид нар хөдөлмөр заслаар дамжуулж бэлдэж байна. Нархан бүлгийн хувьд хүүхдүүдийн оюуны ухаан эрүүл байдаг учраас хүүхдүүдээ хөдөлгөөн заслын эмчилгээнүүдээр дамжуулаад ирээдүйд энгийн тэгш хамрагдах боловсролыг нь өгөх юмсан гэсэн тэмүүлэлтэй явж байна.

Ганц байдаг төв болохоор магадгүй маш олон хүүхэд хамрагдахыг хүсдэг байх. Жилд танай Энэрэл хүүхэд хөгжүүлэх төвд хэдэн хүүхэд хамрагдах хүсэлт явуулдаг вэ?

Ер нь олон хүүхдийн эцэг эхчүүдээс хүсэлт ирдэг. Нархан бүлэгт хамгийн дээд тал нь 12-15 хүүхэд өдөр тутам үйлчилгээ авдаг бол оюуны бэрхшээлтэй хүүхдүүд



явдаг ахлах бүлэгт маань 10-12 хүүхэд явж байгаа. Гадаадад 1 хүүхэд дээр 3 хүний үйлчилгээ байдаг бол Монголд эсрэгээрээ 1 ангид 3 багш байна гэсэн тойм төдий стандартад, журам байдаг. Тэгэхээр багш нарын хангамжаас шалтгаалаад, мөн бид нарын үйлчилгээ үзүүлж байгаа зай талбай яах аргагүй 15-аас хүүхдээс хэтрэх ямар ч боломж байдаггүй. Тэгээд бид нарын гол зорилго маань энэ цэцэрлэг гэж хэлж болохгүй. Яагаад гэвэл цэцэрлэгт 6-аас дээш насны хүүхдүүд явах боломжгүй байдаг. Тэгэхээр 6-аас дээш насны хүүхдүүдээ авахын тулд бид нар тусгай цэцэрлэгийн стандарт зөвшөөрлийг аваагүй. Төрөөс ямар нэгэн санхүүжилт авахын тулд бид нар хүүхэд харах үйлчилгээ гэдэг стандартыг хангаад, авч болдог ч бид нар өнөөдрийг хүртэл авахгүй явж байгаа. Төрөөс Энэрэл дээр ямар нэгэн санхүүжилт байхгүй явж байгаа гол шалтгаан нь Монголд стандарт, журамтай болж манай Энэрэл шиг төв илүү олон байгуулагдаасай, төрөөс дэмжлэг үзүүлдэг болоосой гэдэг утгаараа төрөөс дэмжлэг үзүүлэх үүд хаалгыг нь нээж өгөх юмсан гэж зорьж 3 дахь жилдээ бүсээ чангалаад л явж байна. Уг нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 16-р зүйлийн 8-р хэсэгт "хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хөгжүүлэх төв ажиллуулсан тохиолдолд төр захиргааны төв байгууллага дэмжлэг үзүүлнэ" гэсэн байдаг. Тэгэхээр энэ дэмжлэг гэдэг үг өөрөө ерөнхий утгатай үг учраас бид нар "энэ хуулийн заалт дээр дагалдах журмыг нь гаргаж өгөөч, ийм төвүүдийг төрөөс санхүүждэг болгож өгөөч" гээд 3 дахь жилдээ хамтарч ажиллах хүсэлт гаргаад яваад л байна. Одоохондоо ямар нэгэн тодорхой шийдэл гараагүй л байна.

Та Энэрэл хүүхэд хөгжүүлэх төв, Ээлтэй ертөнц төрийн бус байгууллагаа удирдаад явж байхад өнөөгийн Монголын нийгэмд ямар хүндрэл бэрхшээлүүд тулгардаг вэ?

Асуудал гэвэл зөндөө л олон асуудлууд байгаа байх. Бид нарын харах өнцгөөс шалтгаалан юмыг асуудал байна гээд харвал асуудал, энэ асуудал биш гээд бодвол асуудал биш гэж бодогддог. Тэр утгаараа өнөөдрийг хүртэл явж байгаа. Нийгмийн ойлголт, хандлага, санхүүжүүлэх боломж гэх зэрэг маш олон бэрхшээл саадууд бид нарын өмнө байна. Зөвхөн Ээлтэй ертөнц дээр бодоход маркетингийн асуудал гэх мэтчилэн байдаг. Одоо би Анагаах ухааны их сургуулийн хөдөлмөр заслын ангийн 2-р курсийн оюутан. Бид нар эргээд бүх юмны уг үндэс, суурь юу байна гэхэд Монгол мэргэжлийн хүмүүсийн дутагдалд орсон байна. Хүүхдүүддээ үйлчилгээ үзүүлье, нийгэмшүүлж, чадваруудыг нь нэмэгдүүлье гэсэн ч яг хөдөлмөр засалч гэдэг энэ мэргэжлийн хүмүүс байхгүйгээс болоод маш олон асуудлууд дээр дээрээсээ давхардаж гарч байна гэж би хардаг. Тэр утгаараа бид нар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Боловсролын яамны сайд нар руу яг энэ мэргэжлийн боловсон хүчнийг Монголд бэлтгэж байгаа учраас дэмжлэг үзүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ажиллах боловсон хүчин, хүний нөөцийг бэлтгэхэд нь хамтарч ажиллаач ээ гээд хандаад явж

байна. Яагаад би энэ хөдөлмөр засалч гэдэг мэргэжлийг Монголд илүү олон хүмүүс эзэмшээсэй гэж хүсээд байна гэвэл миний нөгөө мөрөөдөл байгаад байгаа юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бие хүн болж төлөвшихөд нь нөлөөлж чадах хамгийн чухал хүн нь хөдөлмөр засалч гэдэг мэргэжлийн хүн байгаа. Тэгэхээр хөдөлмөрөөр дамжуулж, бүр анагаах ухааны суурьтай мэргэжилтнүүд ажиллаж байж хүүхэд ирээдүйд бид нарын хүсээд байгаа шиг хүн болох эхлэл нь тавигдана.

Дээрээс нь Монгол улс өнөөдөр хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг нэмэгдүүлэх гэдэг маш том хөтөлбөрүүдийг зарлаад, олон тэрбум төгрөгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрны тохируулгад нь зориулж зарцуулж байна. Гэтэл яг энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг яаж хөдөлмөрт бэлтгэх юм бэ гэхэд хөдөлмөр засалч гэдэг мэргэжилтэн байхгүйгээс болоод хундамент нь байхгүй байхад дээр нь зүгээр тоосго өрөөд байна уу даа гэж энэ мэргэжлээр сураад явж байхад анзаарагддаг. Сүүлийн үед жоб көүч (job coach) гэдэг мэргэжил гаргаж ирж байна. Тэгэхээр жоб күйч бол хөдөлмөр засалч гэдэг мэргэжлийн зөвхөн нэг хэсэг нь байдаг. Тэрнээс тэр хүнийг хөдөлмөрт бүрэн бэлтгэж, дадлуудыг эзэмшүүлэх мэргэжилтэн биш гэж миний хувьд үзэж байгаа. Тэгэхээр энд олон асуудлуудыг ярьж болох боловч хамгийн чухал амин сүнс нь болсон хүний нөөц байхгүй ч, энэ байхгүй мэргэжилтнүүдийг бэлтгэх боломж байна гэж хараад төр рүү хандаад байгаа юм.

Тэгэхээр төрөөс нийгэмд бодитой үр



дүн үзүүлж байгаа, үр дүн үзүүлэхийг хүсэж байгаагаа хүмүүс, төрийн бус байгууллагуудаа олж харж, дэмжиж чадаж байна гэж та боддог уу?

Хоёр талтай. Хөгжлийн бэрхшээлтэй хүний чиглэлд үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын дуу хоолой төрд бол маш хүчтэйгээр нөлөөлж чаддаг гэж миний хувьд үздэг. Тэр ч утгаараа 2016 онд бид нар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуультай болж чадсан. Олон хөтөлбөр, халамжийн бодлого ч бас дэмжүүлж чадсан. Ер нь Монголд хөгжлийн бэрхшээлтэй иргэний төлөө ажилладаг, төрөөсөө түрүүлээд чадавхжсан төрийн бус байгууллагууд олон байдаг. Гэхдээ төрд нэг дарга гарч ирээд л манай асуудлыг дөнгөж ойлгуулж байтал дараагийн дарга нь гарч ирээд дахиад л бид нар эхнээс нь тайлбарлах хэрэгтэй болдог. Тэгэхээр энэ тал дээр жоохон сул гэж би хэлэхэд болох байх. Монголын бүх нийгмийн асуудал ийм тойрогт орчихсон явж л байна.

Таны цаашдын хүсэл мөрөөдөл юу вэ? Ээлтэй ертөнц болон Энэрэл хүүхэд хөгжүүлэх төвийнхөө алсын харааг та юу гэж хардаг вэ?

Өчигдөр би “би юу хийгээд байна аа, яг яах вэ?” гээд нэг хүнтэй ярьж байсан юм. Одоо бол Энэрэл хүүхэд хөгжүүлэх төв маш хүнд байдалтай байгаа, гэхдээ үйл ажиллагааны хувьд биш. Манай үйл ажиллагаа маш сайн явж байгаа, хүүхдүүд маань хөгжиж, багш нар маань мэргэжлийн хүмүүс учраас бүх юм маш гоё байгаа. Гол нь ажиллаж байгаа хүмүүсийн







маань цалин, нийгмийн асуудал гэдэг яг миний толгой дээр байгаа хамгийн хүнд асуудал. Тэгэхээр энэ асуудалтай 3-4 жил зууралдаж байгаа хүний хувьд үнэндээ бүр яах вэ гэж бодоод байгаа. Энэ асуудал цаашдаа ингэж үргэлжлээд байх уу, яах вэ гээд өчигдөр бид нар ярилцаж байсан. Бид "ийм төв байгуулж өгөөч ээ, бид нар ингэж ажиллах гэсэн юм" гэхэд төрд ажилладаг, бидний асуудлыг сонссон хүн бүхэн "ёстой гоё ажил байна, та нар ёстой мундаг байна. Үнэхээр хэрэгтэй юм хийж байна." гэж хэлдэг. Тэгсэн хэрнээ шийдээд, дэмжсэн зүйл байдаггүй.

Энэрэл гэдэг ийм төв байгуулж болдог юм байна, энд хүүхдүүд яваад хөгждөг юм байна, ингээд ийм мэргэжлийн хүмүүс нь ажиллаад хүүхдүүд нь ийм хөөрхөн болдог юм байна гэдгийг төрд харуулчихсан учраас ийм төвүүдийг илүү олон болгож бараг 3 хорооны дунд нэг төв байгуулж, яг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нь гараад л одоо сургууль цэцэрлэгт хамрагддаг шиг яг ийм мэргэжлийн хүмүүстэй, мэргэжлийн үйлчилгээнүүдийг авах зайлшгүй шаардлагатай гэдгийг бид үндэслээд явж байна. Тэгэхээр бид нарын зорилго бол Энэрэл шиг ийм төвүүд байгуулагдаасай, илүү олон болоосой гэдэг төрийн бодлого гараасай гэж чин сэтгэлээсээ хүсэж байна. Тэгэхээр энэ бид нарын ойрын зорилго болчхож байгаа юм. Ойрын зорилго маань одоо төрөөс хамааарч байгаа учраас уг нь бид 3 жилийн өмнө 3 жилийн дотор хийчихнэ гэсэн зорилго тавьчихсан байтал яах аргагүй хойшилсоор одоо 3 жилийн дотор дахиад энэ хугацаа сунгагдаж байна. Миний зорилго бол миний хүү өөрийн гэсэн ажлын байртай болоод өөрийн гэсэн чадвартай болоод, цалин аваад амьдраасай гэж хүсдэг. Тэгэхээр яг одоо Монголд байгаа хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 5,000 орчим хүүхдүүд бүгдээрээ бие хүн болж төлөвшсөн байгаасай гэсэн зорилготой явж байна. Тэгэхийн тулд олон ажлууд бид нарыг хүлээж байгаа.

Энэрэл хүүхэд хөгжүүлэх төвийн санхүүгийн асуудлыг Хоони зөөлөн тоглоомын үйлдвэр ихэвчлэн хариуцдаг гэсэн. Сүүлийн үед залуучууд сайн дурын ажлыг маш их хийдэг болсон. Тэгэхээр танд маркетингийн эсвэл сайн дурын ажилтнууд авч ажиллуулъя гэсэн бодол байдаг уу?

Үүний талаар бодож байгаагүй юм байна. Санхүү эдийн засгийн их сургуулийн оюутнууд манай дээр 48 цагийн сайн дурын ажил хийдэг. Гэхдээ тэд нар маань зөвхөн бид нарын өдөр тутмын ажилд оролцоод тусалдаг. Энэ подкастыг сонсоод бид нартай холбогдвол үнэхээр их баярлах болсон шүү гэж хэлмээр байна.

Би сүүлийн үеийн залуучууд маш их сайн дурын ажил хийдэг болсон гэж сонсож байсан. Магадгүй манай подкастыг сонсож байгаа маркетингаар сурдаг эвсэл ажилладаг хүмүүс байвал Туяажаргал эгчтэй холбогдоорой гэж хүсье.

Баярлалаа. Ер нь зөөлөн тоглоомын

үйлдвэр, зөөлөн тоглоомыг англиар софт тоой (soft toy), Орос оор мягкие игрушки гээд зөөлөн гэдэг утгыг агуулсан нэршилтэй байдаг. Тэгэхээр зөөлөн тоглоомыг чихмэл гэхээсээ илүү зөөлөн гэдэг үгийг би нэлээн ашигладаг. Чихмэл гэхээр музейд тавигддаг, ан амьтны чихмэлүүдийг бид нар чихмэл гэж ярьдаг гэж би боддог. Энэ зөөлөн тоглоомын үүсэл нь гэвэл 1900-аад онд амьдарч байсан тэргэнцэртэй Герман эмэгтэй тоглоом даавуугаар хийж, дотор нь чихээс чихэж байсан юм билээ. Одоо Тэди гэдэг бамбаруушийг хүн болгон мэддэг болчихсон. Тэди гэдэг нэр нь Америкийн ерөнхийлөгч Теодор Рузвелтийн найзууд дундаа дуудагддаг нэр болох Тэди гэдэг нэрийг нь аваад эхэлж байсан юм билээ. Зөөлөн тоглоом өөрөө хүнд хайрыг, дулаан, дотно байдлыг өгдөг их гоё утга агуулгатай. Тэгээд Монголын анхны зөөлөн тоглоомын үйлдвэр гэдгээрээ бид нар бахархдаг. Хоони гэдэг мэргэшил нь бол зүгээр л оноосон нэр л дээ. Бид нар жоохон хүүхдийг "хаана байна" гэж нэг өхөөрдөж дууддаг шүү дээ. Тэр хэллэгийг нь сонсоход хоони гэж сонсогддог. Эхлээд бид нар ямар нэр өгөх вэ гэж нэлээн их ярилцсан. Тухайн үед унага хийж байсан болохоор чүчү гэдэг нэр өгчихье гэтэл орчуулгыг нь олон улсад харахаар муу сүнсний утга гарч ирсэн. Тэгээд бид нар чүчү гэдгээ болиод, яг юу гэж нэрлэх вэ? гэж ярьсаар байгаад хоони гэдэг аялгаар нэрлэсэн. Орчуулга нь ч гэсэн зөгийн бал ч байж болно, нэг бол хонгор минь ч байж болно гэх мэтчилэн олон хувилбартай. Дөнгөж хэлд орж байгаа хүүхэд ч гэсэн хоони гэдэг үгийг амархан хэлж сурна гэдэг утгаараа бид нар хоони гэдэг нэрийг зөөлөн тоглоомдоо өгсөн юм.

Манай подкастын цаг өндөрлөх дөхөж байна. Танаас сүүлийн асуултаа асууя. Та цаашдаа хүүхдээ бие хүн болж төлөвшихийг мөрөөддөг гэсэн. Тэрний тулд хийгдэх нэлээн хэдэн алхмууд таны нүдэнд магадгүй харагдаж байгаа байх. Ойрын хугацаанд хууль эрх зүйн байдлаас гадна энэ нийгэмд юу хийгдээсэй гэж та бодож байна вэ?

Ямар ч байсан Ээлтэй ертөнцийнхний хувьд өөрсдийнхөө чадахаас илүүгээр ажиллаж байгаа. Энд хүний хийж чадах хамгийн дээд цэг байдаг гэвэл бид нар тэр дээд цэгээсээ илүү ажиллаж байгаа гэж миний хувьд үзэж байгаа, тэгж ажилласаар ч ирсэн. Энэ подкастаар дамжуулаад нийт Ээлтэй ертөнцийн хамт олондоо бүгдэд нь "баярлалаа, хайртай шүү" гэдэг үг дамжуулж хэлмээр байна. Бас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асраад гэртээ сууж байгаа ээж болгондоо та нар минь үнэхээр бурхны бэлгүүдийг тэврээд сууж байгаа учраас бүгдээрээ маш хүчтэй ээжүүд шүү. Асуудал байдаг. Гэхдээ бас түүнийг даван туулах хүч нь бас хамт байгаа шүү гэж хэлмээр санагдаж байна. Би 6 жилийн өмнө гадуур явахдаа байнга л хүүтэйгээ хамт автобусанд суугаад явдаг байсан. Тэгэхэд нийгмээс маш их эвгүй хандлага ирдэг байсан. "Би хүүгээ дагуулаад гудамжаар явахдаа, автобусанд суухдаа цайны газар орж хоол идэхдээ, далдын хар малгай өмссөн байдаг. Миний хүүхдийн гаргаж байгаа авирыг хараад

хүмүүс янз бүрийн хандлага илэрхийлэхэд, би тэд нарыг хараагүй юм шиг өөртөө хана босгочихсон явж байгаа." гээд постыг би оруулж байсан юм. Тэр постыг фэйсбүүк жил болгон надад сануулаад, мемори дотор ороод ирэхэд нь би "Монгол хүмүүс өөрчлөгдсөн, би ийм зүйл мэдрээгүй нэлээн удаж байна" гэж дотроо дүгнэдэг байлаа.

Гэтэл сая бид 2 хоёулаа ковид тусаад өрхийн эмнэлэг дээр очоод дугаарлаж байхдаа, үгүй юм байна гэдгийг мэдсэн. Миний хүүтэй 5 жилийн өмнө харьцаж байсан харилцаа яг хэвээрээ байсан. Нэг тийм нохойтой харилцаж байгаа юм шиг эсвэл миний хүүд хүрч болохгүй, өргөстэй юм шиг харьцаж байсан. Миний ээжийн үеийн эмэгтэй "Энэ нэг юмаа зайлуулаач ээ" гэсэн тиймэрхүү үг, хандлага гаргасан. Залуучууд бүр ярвайгаад, өмсөж байсан куртканыхаа захыг хамартаа хүргээд байсан. Миний хүүгээс тийм аймаар үнэр үнэртээгүй гэж би мэдэж байна. Тийм хандлага одоо болтол байгаад байна, хэзээ ч энэ өөрчлөгдөхгүй. Би энийг хэзээ ч өөрчлөгдөхгүй гэдгийг нь одоо хүлээн зөвшөөрсөн. Би яагаад 5-6 жилийн хугацаанд энэ хандлагыг арилсан гэж бодсон гэвэл миний эргэн тойронд дандаа миний хүүг ойлгодог эсвэл ойлгохыг чин сэтгэлээсээ хичээдэг, тийм гоё хүмүүсээр дандаа хүрээлүүлж явсан. Тэгээд нийгэм дээр гарахад миний хүүг ойлгохгүй хэвээрээ байна гэдгийг мэдсэн. Тэгэхээр одоо би нийгмийг өөрчилнө эсвэл би тэднийг өөрчилнө гэж нэг их том юм бодохгүй гэж бодсон. Энэ бол хэзээ ч өөрчлөгдөхгүй юм байна. Юм чинь цаг хугацааны эрхээр өөрчлөгддөг учраас 10 жилийн дараа магадгүй хүмүүс арай өөрчлөгдөх байх. Ээлтэй ертөнцийнхний хувьд бид нар ойрын үед өөрсдийнхөө хийх ёстой гэхээсээ илүү ажлаа хийсээр яваа гэж л бодож байна.

Цаг зав гарган өөрийнхөө үнэтэй яриа, олж мэдсэн туршлагаа бид нартай хуваалцсан танд маш их баярлалаа.

Баярлалаа. Намайг урьж оролцуулсанд баярлалаа. Тэгээд илүү олон сонсогчтой болоод олон хүмүүст юмыг зөвөөр харах, тэгээд олон олон гоё зочидтой үргэлжлэх болтугай.

БОЛОВСРОЛЫН ТЭГШ ХҮРТЭЭМЖИЙГ ХАНГАЖ ЧАДААГҮЙ ШАЛТГААНЫ ТУХАЙ



Ц.Уянга

Энэхүү дугаарт Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбооны паралегал Уянга оролцож байна. Та манай подкастын урилгыг хүлээн авч, орохоор болсонд маш их баярлалаа.

Та юуны өмнө өөрийгөө танилцуулаад, яагаад Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбоо (МХБХЭЭХ)-ны паралегал болсон талаараа ярьж өгөхгүй юу?

Сайн байцгаана уу? Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе! Өнөөдрийн подкастдаа намайг урьж оролцуулж байгаад баярлалаа. Манай хүүхэд тархины саажилт, эпилепси хавсарсан оноштой, хэвтрийн хүүхэд байдаг. Хүүхдээ асрангаа МХБХЭЭХ-ны зөвлөх эцэг эх бэлтгэх хөтөлбөрт хамрагдсан. Энэ хөтөлбөрт би 2 удаа хамрагдаж, 2 сертификаттай болсон. Хөтөлбөрт хамрагдаад 2013 оноос би өөрийнхөө ойр орчинд амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй бусад эцэг эхчүүдэд хаана, юу болж байгаа талаар мэдээлэл түгээх, тэдэнд тулгамдаж байгаа асуудлыг сонсоод төв байгууллага руугаа мэдээлэл хүргэх, сар болгон эцэг эхчүүдтэй уулзаж тэд нарынхаа сэтгэлийг сонсох маягаар анх ажилладаг байсан. Хүний тийм хэрэгцээ байдаг шүү дээ. Эдгээр эцэг эхчүүдэд нэг асуудал тулгарахад л дотроо маш их бухимдаж байдаг. Нэг талаараа эцэг эхчүүдийн сэтгэл санааг нь ойлгож, зовлон жаргалыг сонсоно гэдэг тухайн эцэг эхчүүдэд стресс бухимдлаа тайлах боломж байсан гэж би боддог. Тэгээд сард ганц удаа ирээд асуудлаа яриад явдаг биш, дуртай

үедээ зөвлөгөө авдаг, зовлонгоо ярьж сэтгэлээ онгойлгодог, хүүхдээ авч ирээд тоглуулангаа өөрөө сургалтад суучихдаг төв хэрэгтэй гэж бодсон юм. Би 2014 онд эцэг эхчүүдтэйгээ нийлж гэр бариад, МХБХЭЭХ-ны маань Сэлэнгээ захирал зуучлаад Монголын эмэгтэйчүүдийн сангаас дэмжлэг авч Гэгээлэн төвийг байгуулж байсан. Бид нар төвтэй болоод түлээ, нүүрсээ Монголын эмэгтэйчүүдийн сангаараа бэлдүүлж аваад, галаа түлээд гэр дотроо чадваржуулах сургалт, уулзалтаа хийдэг байсан. Чадваржуулах сургалтаар эцэг эхчүүдэд оёдлын хичээл зааж, цаасан хайрцгаар хүүхдэдээ хэрэгтэй сандал зэрэг зүйл хийх арга заадаг байсан. Олны чихэнд сонсогдоод ирэхээр тухайн үеийн дүүргийн засаг дарга дэмжээд бид нар сүүлдээ сайхан байртай болсон. Бас МХБХЭЭХ-ныхоо шугамаар би Япон руу туршлага судлах боломж олдож Японы сургууль, цэцэрлэг, эмнэлгүүдийн үйл ажиллагаатай танилцаад ирсэн. Тэгээд өөрийнхөө үзэж харсан болгоныг энэ төвдөө хэрэгжүүлэх гэж хичээгээд 7 дахь жилдээ явж байна. Өмнө нь МХБХЭЭХ-ныхоо зөвлөх эцэг эх байсан бол энэ жилээс паралегал гээд машинтай болсон. Паралегал гэдэг нь Монголоор бол эрх зүйн хөтөч юм байна. Бид нар сургууль, цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа хүүхдүүд эсвэл халамжийн үйлчилгээнд хамрагдах ёстой хүүхдүүд хамрагдаж чадаж байна уу, хамрагдаж чадахгүй байгаа хүүхдүүд байвал тэдний эцэг эхчүүдэд хуулиараа танай хүүхэд хамрагдах ёстой, та хуулийг дагуу ингээрэй гээд хууль эрх зүйн зөвлөгөө өгдөг. Тэгээд МХБХЭЭХ-ны шугамаар бид Улаанбаатар хотын 6 дүүрэг, орон нутгаас нийт 100 гаруй хүнийг хамруулсан зөвлөх эцэг эхчүүдийг бэлтгэх хөтөлбөр хэрэгжүүлээд, зөвлөгч эцэг эхчүүддээ кэйс хэлэлцүүлэг хийх сургалт, аргачлалд сургаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүд ямар төрлийн хууль эрх зүйн зөвлөгөө авах гэж ирдэг вэ?

Манай дээр хүүхдийг цэцэрлэгт хамруулахгүй байна, цэцэрлэгт хаана хамруулах вэ, манай хүүхэд 6 нас, 7 нас хүрсэн, сургуульд оруулах уу, хаана сургуульд оруулах вэ гээд асууж ирдэг. Зарим хүмүүс харьяа сургуульдаа хамруулах гэхээр сургууль хамруулахгүй байна, одоо яах вэ гэдэг асуудлуудаар их ирж байгаа. Дийлэнх хувь нь боловсролын асуудлаар ирдэг ч эрүүл мэнд, халамжийн асуудлуудаар хүмүүс бас ирдэг. Сургуульд хамрагдах ёстой хүүхдүүдийн эцэг эхчүүдэд наад зах нь өргөдлийг хэрхэн бичих, өргөдлөө хорооныхоо засаг даргад өгөх, дараагийн шатанд нь хууль ийм байна, сургууль дэмжлэгийн баг байгуулах ёстой, дэмжлэгийн баг хуралдаад, ингэж ажиллах юм байна гээд зөвлөгөө өгөөд явдаг. Би өөрийнхөө амьдарч байгаа хорооныхоо бага сургуулиудтай нэлээн хамтарч ажилладаг. Тэд нар маань миний хийж байгаа ажлыг дэмжээд, миний саналыг хүлээж аваад, дэмжлэгийн баг байгуулах, хүүхдүүдээ хамруулах дээр маш санаачлагатай ажилладаг.

Хүүхдээ хөгжүүлье гэсэн хандлагатай

эцэг эхчүүд хэр их байгаа вэ?

Нэг үеэ бодвол эцэг эхчүүд хүүхдээ сургуульд сургая, хөгжүүлье гэдэг болсон. Эцэг эхчүүдийн ойлголт маш сайжирч, наад зах нь “би хүүхдээ нийгэмшүүлэх ёстой” гэдгээ хүмүүс ойлгодог болсон. “Манай хүүхэд цэцэрлэгт явж чадахгүй байна, одоо цэцэрлэгт нь явуулмаар байна” гэдэг. Цэцэрлэгт явуулахдаа багшаас зөвхөн цахимаар хичээл авах биш, манай хүүхэд олон хүүхдүүд дунд ороод хүүхдүүдтэй харьцаж сурахаас эхлээд нийгэмших хэрэгтэй байна гэдгийг хүмүүс ойлгосон байна. Бид нарынхаар хэвтрийн, өөрөө хооллож чаддаггүй хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй хүмүүс хаашаа хандахаа мэдэхгүй хаашаа явах вэ, яах вэ гээд ирж байна. Эцэг эхчүүд хүүхдээ ямар нэгэн хөгжүүлэх үйл ажиллагаанд хамруулахыг маш их хүсдэг. Нөгөө талаараа бид хүүхдээ зөвхөн эмнэлгийн үйлчилгээ гэхгүй, яг насанд нь тохирсон боловсролын үйлчилгээнд давхар хамруулаад явдаг тогтолцоо руу шилжиж орохоор явж байна. Хүмүүсийн хандлага тодорхой хэмжээгээр өөрчлөгдсөн ч манай хүүхэд сурч чадахгүй гэсэн хүмүүс мэр сэр байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн хууль эрх зүйн талаарх мэдлэгийн хувьд хөдөө орон нутгийн болон хотын иргэдийн ялгаа танд ажиглагдсан уу?



Орон нутагт ч гэсэн мундаг хүмүүс байдаг. Би маш мундаг ярьдаг, маш идэвх чармайлттай зарим эцэг эхчүүдийг биширдэг. Тэр битгий хэл 60 гарсан ч хүүхдийнхээ төлөө мундаг явдаг өвөө, эмээ нар ч байна. Аймгийн төвөөсөө зайтай орон нутагт мэдээллээс жоохон тасрах гээд байдаг тал ажиглагддаг. Тэр хүмүүс аймгийн төвөөсөө хол учраас хүүхдэдээ боловсролын болон бусад үйлчилгээ авахад хүндрэлтэй асуудал их тулгардаг. Жишээлбэл, харааны бэрхшээлтэй хүүхдийг хотод авч ирээд сургуульд оруулаа гэхэд сургуулийн дотуур байрны асуудал бэрхшээлтэй. Харааны бэрхшээлтэй хүүхдийн сургууль ганцхан дотуур байртай, тооны хязгаартай хүүхэд авдаг. Тэгэхэд Монгол улсын хэмжээнд ганц байгаа сургууль бүх хүүхдүүдийг хамруулж чадахгүй байх жишээтэй. Тэгвэл орон нутгийн хүмүүс байр түрээсэлж, хүүхдийнхээ төлөө хотод суух хэрэгтэй болдог гээд асуудлууд тулгардаг.

Эцэг эхчүүд боловсролын асуудлаар танд их ханддаг гэж ярьсан. Боловсролын хуулийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд тэгш хамруулах боловсролд хамрагдах бүрэн боломжтой. Тэгэхэд яагаад энэ эрхийн хэрэгжилт нь муу байна вэ?

Хууль эрх зүйн баримт бичгүүд, маш сайхан зүйлс зөндөө гарч байна. Багш нар энэ бэрхшээлтэй хүүхэдтэй яаж ажиллах вэ, энэ хүүхдэд ямар хэрэгцээ байгаа вэ? гэдгийг тодорхойлно. Тэгээд тэр хэрэгцээ шаардлагад нь тохирсон аргаар сургалтаа явуулна гэхэд багш нарын хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, хандлага, тухайн хүүхдийн онцлог, хэрэгцээг тодорхойлох ур чадвар шаардлагатай болж байгаа юм. Яг энэ талаар зөвлөгөө өгдөг хүмүүс маш цөөхөн. Анхнаасаа багш бэлтгэхэд хөгжлийн бэрхшээлийн талаар ордог хичээлийн цаг нь маш бага байдаг. Бас ордог хэдхэн цагтаа хангалттай мэдээлэл авч чадаж байна уу гэдэг асуудал байна. Тэгэхээр энэ хүмүүст мэдэхгүй, чадахгүй зүйл их байгаа. Хууль нь байхад ямар нэгэн зүйлийг шууд хэрэгжүүлэхгүй байна гэдэг нэг бол хандлагын асуудал эсвэл ойлгож мэдэхгүйгээсээ болоод хэрэгжүүлж чадахгүй байгаа гэж би боддог. Бид хэн нэгнийг буруутгахаасаа илүүтэй багш нарыг ойлгох хэрэгтэй. Тэд хөөрхий минь бэрхшээлтэй хүүхдээ авчихлаа, оюуны бэрхшээлтэй хүүхдийг яах вэ, яаж энэ хүүхэдтэй ажиллах вэ, оюуны бэрхшээлтэй хүүхэд чинь ямар онцлогтой юм бэ, энэ хүүхдэд би юуг, яаж заах вэ гэдэг зүйлээ мэдэж, ойлгож, ажиллаж чадахгүй байгаа учраас тэр хүмүүст чиглүүлэг өгөх хэрэгтэй. Уг нь манай боловсролын Энх-Амгалан сайд хүүхдүүдээ цэцэрлэг, яслиас нь эхлээд тэгш хамруулъя, 5 настай бүх хүүхдүүдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулсан байх ёстой гээд холбогдох арга хэмжээнүүдийг авахаар ажиллаж байна. Мөн ерөнхий боловсролын сургуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш нарт 10%-ийн нэмэгдэл олгох сайхан санаачилга гарсан боловч 10%-ийн нэмэгдлийг 2020 онд ч аваагүй, одоо ч авч эхлээгүй байна. Тэгэхээр “би энэ хүүхэдтэй ажиллах байгаа учраас

надад 10%-ийн нэмэгдэл өгч байгаа. Би энэ нэмэгдлийг авч байгаа болохоор хүүхдээ сэтгэл гаргаж ажиллах хэрэгтэй" гэдгийг тухайн багшид ойлгуулах хөшүүрэг болж байгаа юм. Угаасаа манай өнөөгийн нийгэмд эмч, багш нарын цалин бага, юмны үнэ өссөн, бензин олдохоо болилоо гээд асуудлууд олон байна. Гэтэл тэд бид нартай л адилхан амьдрах гээд явж байгаа хүмүүс учраас наад захын хөшүүргийг төрөөс шийдвэрлээд явбал боломж нэлээн гарч ирнэ. Би хүүхдээ 5 жил ерөнхий боловсролын сургуульд зөөж, 5-р анги төгсөхөд нь монтаж дээр бид 2 тэврэлдээд авхуулсан зураг байдаг. Тэр 5 жилийн хугацаанд би багшид туслаад хүүхэдтэйгээ ажиллах биш, миний оронд туслах багш ажилласан бол илүү үр дүнтэй байх байсан гэж боддог. Хамгийн наад зах нь хүүхэд ээжээсээ хол байж үзнэ. Одоо бол байнга ээжтэйгээ хамт байж, бүх юмыг ээжтэйгээ хамт хийнэ, ээж бол мөнхийн туслагч багш. Ядаж сургууль дээр туслах багш байвал багшдаа дэмжлэг болоод явна. Бид нар мэргэжлийн багш биш, дээрээс нь хүүхдээ ээж нь харагдаж байгаа учраас хүүхдийн хүлээж авах байдал, харах өнцгөөсөө ч гэсэн өөр. Бусад хүүхдүүд ч гэсэн Номин бие муутай эсвэл Номин өөрөө явж чадахгүй учраас байнга ээжтэйгээ байх ёстой юм шиг ойлгож, хүлээж авч байгаа. Тусгай сургуульд нэг ангидаа 8-10 хүүхэдтэй, нэг ангид нэг туслах багш, анги даасан багш гээд хоёр хүн ажилладаг. Сая 8 сард Боловсролын сайд тусгай сургуулийн захирлууд болон төрийн бус байгууллагуудын төлөөллүүдтэй уулзахдаа тусгай сургууль дээр туслах багшийн асуудлыг шийдэж өгнө гэж ярьж байсан. Миний яриад байгаа юмны гол утга нь гэвэл ерөнхий боловсролын сургуулиудыгаа яг тусгай сургууль шигээ дэмжээд явах хэрэгтэй. Нэг ангид багш 40 хүүхэдтэй ажиллаж байгаад дээр нь нэмж хоёр бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллана гэдэг бол багшид нэлээн ачаалал үүсгэнэ. Тэгэхээр заавал багшийг дэмжих ямар нэгэн зүйл байх хэрэгтэй. Боловсролын сайдын тушаалаар дэмжлэгийн баг гэж байгуулах ба тэр багт сургуулийн захирал өөр бусад хүмүүс байна. Тэгээд дэмжлэгийн багаараа тэгээд энэ хүүхэдтэй яаж ажиллах вэ гэсэн ганцаарчилсан сургалтын хөтөлбөр гаргаж баталаад, тэр хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу урт, богино хугацааны зорилтынхоо дагуу ажиллана. Улиралдаа нэг удаа хуралдахдаа тухайн зорилтоо шат дараатайгаар өөрчлөөд, энийг сурсан учраас дараагийн зүйлийг нь хэрэгжүүлье, энийгээ хийж чадаагүй бол дахиад үзнэ гэх зэргээр өөрчлөөд явна гэсэн хэлбэртэй байх болов уу. Тэр нь ч багшид нэлээн дэмжлэг болно. Гэтэл тэр дэмжлэгийн багт яг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ ойлгодог, тэр хүүхдийн онцлог хэрэгцээг мэддэг учраас та ийм хөтөлбөрөөр ажиллаарай гээд зөвлөөд явах мэргэжлийн хүн хэрэгтэй байгаа юм. Жишээлбэл хөдөлгөөн засалч байна бодъё. Энэ хүүхдийн баруун гар нь саажилттай байна. Тэгвэл зүүн гараар нь юм бариулах, зүүн гарыг нь илүү хөдөлгөх тал дээр анхаараад өгөөрэй, багш аа. Нэг тоглоом тоглосон ч, нэг юм хийлгэхдээ ч гэсэн зүүн гарыг нь хөдөлгөхөд

анхааараарай, ийм ийм юм хийлгэж болно гээд хэлээд өгөх хэрэгтэй. Манайх хүн ам цөөтэй жижиг улс болохоор мэргэжилтнүүд маш дутмаг байна. Тэгэхээр зөвхөн сайд, сургууль, цэцэрлэг шийдэх биш, бүр бодлогын хэмжээнд мэргэжилтнүүдээ бэлтгэх асуудал байна. Жишээлбэл, хөдөлмөр засалч гэдэг мэргэжилтэй хүн Монгол улсад маш их хэрэгтэй байна. Хөдөлмөр засалч хүн гэдэг “хүүхдийг яаж сургах вэ, яаж гар хөлийг нь хөдлөх вэ, энэ гарыг хөдөлгөхийн тулд ийм юм хэрэгтэй, энэ хүүхдийг ойлгуулахын тулд ингэж ажиллана, хүүхдийг амьдрах ухаан, бие даахад сургахын тулд ингэнэ” гээд хэлнэ. Бас одоо сургуульд хэл ярианы бэрхшээлтэй хүүхдүүд их орж байна. “Манай хүүхэд ярьж чадахгүй яана аа, сургуульд яах вэ” гэсэн эцэг эхчүүд олон байна. Хэл яриа хөгжүүлэх хэл засалч гэдэг мэргэжилтэй хүн Монгол улсад маш их хэрэгтэй. Тийм хүн тоотой хэдхэн бараг байхгүйтэй адилхан болсон. Сургуулиуд хэл засалчаас зөвлөгөө авах гэтэл тийм хүн олдохгүй, дүүргийн эмнэлэг дээр ч тийм хүн байхгүй байх жишээтэй.

Хууль эрх зүйн хэрэгжилт нь муу байна



гэж та үзэж байна уу?

Хууль эрх зүйн хэрэгжилт муу. Дээрээс нь мэргэжлийн боловсон хүчин байхгүй байхад мянга хууль байгаад яах юм. Нөөц боломж байхгүй байхад тэр хуулийг хэн хэрэгжүүлэх юм бэ?

Тэрнээс гадна дэд бүтэц, нөөц бололцоо хангалттай юу?

Маш олон жил яригдаж, хэрэгждэггүй асуудал бол дэд бүтэц. Бас нэг үе бодвол мэдээнээс харахад ЖАЙКА зэрэг олон улсын байгууллагууд төр лүү ч нөлөөлөөд, янз бүрийн мониторинг хийгээд, хүмүүсийг сургагч багшаар бэлтгээд явж байна. Нэг дүүрэг ч гэсэн тухайн дүүрэгт байгаа дэлгүүрүүдийг бүгдийг нь түгээмэл загвараар налуу замтай болгох аян зохион



худалдаа, үйлчилгээ эрхэлж л байгаа бол бүх хүмүүс тэрийг дагаад мөрдвөл болно гэж би боддог. Тэрэн дээр жоохон сэтгэл, хандлагын асуудал байгаа юм болов уу?

Надад 15 настай тэргэнцэртэй хүүхдийг ингэж ярьж байсан. "Би өөрөө дэлгүүр ороод юмаа сонгож авч чаддаггүй. Дандаа тийм юм авъя гээд ээжийг оруулаад, би дандаа гадаа нь хүлээгээд байж байдаг." Яагаад гэвэл адаглаад л манай энэ хавийн дэлгүүрүүд бүгд өндөр өндөр шаттай эсвэл хаалганы өндөр босготой. Тэгээд 15 хүрчихсэн хүүхэд том болчихсон, нэлээн жинтэй байгаа. Ээж битгий хэл аав ч дийлхээргүй хүүхдүүд байна. Тийм болохоор тэр хүүхэд дэлгүүрийн гадна үлдээд, өөрөө сонголтоо хийж чадахгүй байгаа юм. Ээжийгээ тийм юм аваад ирээрэй гээд хэлэхэд ээж өөрөө харж байгаад л сонгоод авч өгнө. Гэтэл тэр хүүхдийн авах гээд байгаа зүйл маш олон сонголттой байж болно. Уг нь бол хүүхэд өөрөө сонголт хийхийг хүсээд байна шүү дээ. Тэр хүүхэд Монголын, Германы, Английн эсвэл гялгар цаастай, цаасгүй, бор эсвэл шар өнгөтэйг нь авмаар байна. Гэтэл өөрөө сонгож чадахгүй байгаа нь тэр хүүхдэд маш хэцүү санагдаад яриад байна. Тэр чинь хүүхдийн үйлчилгээ авах, сонголт хийх эрхийг зөрчөөд л явж байна гэсэн үг. Тэгээд л сонголт хийх ямар ч боломжгүй болоод хүний авчирсныг л хэрэглээд байж байдаг.

Таны бодлоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хамгийн их зөрчигдөж байгаа эрхүүд нь юу юу байгаа вэ?

Зөрчигдөж байгаа эрх олон байна даа. Боловсрол дээр ч хүүхдүүдийн эрх зөрчигдөж байна. Саяхан фэйсбүүк дээр багш нь сургалтын менежерийнхээ өрөөнд ороод "би аутизмтай хүүхдийг авч чадахгүй" гээд уйлаад ярьсан асуудал гарсан. Багш тэр хүүхэдтэй яаж ажиллах вэ гэдгээ мэдэхгүй, ойлгохгүй, чадахгүй болохоор багшид өөрт нь хэцүү байгаа. Гэтэл цаанаа нь тэр хүүхдийн эрх зөрчигдөөд байдаг. Тэр багшид та энэ хүүхэдтэй ингэж ажиллана шүү гээд ядаж мэдээлэл өгөөд, "та хүүхэдтэй ажиллах үүрэгтэй болохоор та багш хүний хувьд аль ч хүүхдийг сургах ёстой" гээд асуудлыг бүр том болгохгүйгээр сургуулиас арга хэмжээ авах боломжтой байсан гэж би бодож байна. Багшийн талаас бол "энэ хүүхэдтэй ажиллах үнэхээр хэцүү, ажиллаж чадахгүй" гэдэг ойлголт, хандлагатай байгаа учраас тэгж уйлж унжсан гэж бодсон. Багш хүн "би энэ хүнтэй ажиллана, энэ хүнтэй ажиллахгүй" гэж хэлж болохгүй л байх. Энд хүүхдийг ялгаварлан гадуурхах байдал үүсэж байна. Тэгээд бодоход хүүхдийг ялгаварлан гадуурхах, сурч боловсрох эрх, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх маш их зөрчигдөж байна шүү дээ. Уналт таталттай хүүхдүүдийн эм олдохоо больсон. Нэлээн олон эм хөнгөлөлтөнд орсон боловч хөнгөлөлтөөр олдохгүй байна гэдэг бол эмийн хангалттай холбоотой асуудал байгаа юм.

Энэ хүүхдүүд маань сургуульд явлаа гэж бодъё. Тэгэхээр тэрний дараа хөдөлмөр эрхлэлийн асуудал ямар байгаа вэ?

Яг одоо хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын асуудал маш их яригддаг болж байна. Сүүлийн хэдэн жил яригдаж байгаа ч гэсэн хэрэгжилт нь сайхан болоогүй л байна. Хүүхдүүд боловсролд хамруулах гэж зарим сургууль дээр бөөн асуудал болж байна. Яг бусад хүүхдүүд шиг боловсролын үйлчилгээг чанартай, бүрэн авч чадаж байна уу гэвэл бас үгүй. Гэтэл чанартай боловсрол эзэмшиж чадаагүй, бусадтай өрсөлдөхүйц хэмжээний ойлголт, мэдлэг авч чадаагүй хүүхдүүд 8-р анги, 9-р анги төгслөө гээд зүгээр гэрчилгээтэй л хүн болно. Мэдлэг авч чадаагүй хүүхдүүд ихэнх нь ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй. Тэр хүмүүсийг сургаад авдаг, хөдөлмөрт бэлтгэх дэмжлэг алга. Нөгөө талаараа тэр хүүхдүүдийг багаас нь амьдрах ухаан, бие даах чадвар, хөдөлмөрт бэлтгэсэн бол тэд арван хэдэн жилд ямар нэгэн юмыг сайн хийж сураад, ядаж нэг газар гологдохгүй аяга угаадаг болно шүү дээ. Гэтэл одоо хөгжлийн бэрхшээлтэй ялангуяа оюуны бэрхшээлтэй хүмүүсийг ажилд авах газар байхгүй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажилд авч байгаа газар тэргэнцэртэй хүмүүсийг л авч байна. Хүмүүсийн ажил хийх чадвар бас хэцүү байдаг. Тэгээд манайх тохируулга хийдэггүй. Гэхдээ хөдөлмөр эрхлэлт дээр ажлын байр бол маш бага. Хөдөлмөрт бэлтгэхийн тулд яаж, ямар тохируулга хийх вэ? Жишээлбэл, оёдлын машин дээр ажиллаж байгаа хүний машинд хөлөөрөө гишгэж чадахгүй бол гараараа ажиллуулах боломжтой тохируулга хийгээд явах зүйл манайд алга. Юуг, яаж, хэн хийх юм гэдэг зүйл алга. Жишээлбэл, хөдөлмөрт

бэлтгэхийн тулд хэн энэ хүмүүсийг сургах вэ, ямар хөдөлмөрт сургах вэ, яаж сургах вэ, сургасныхаа дараа хаана, яаж хамруулах вэ гээд явах ёстой. Зарим төрийн байгууллагуудад тэргэнцэртэй хүмүүсийг хөтчөөр авах тохиолдол байна. Бас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээс дээд боловсрол эзэмшсэн хүн маш цөөхөн тоотой байдаг. Манайд сурч боловсрох ямар ч орчин бүрдээгүй байхад, хөдөлмөр эрхлэх нөхцөл яаж бүрдэхэв дээ, юм чинь шат дараатай байдаг шүү дээ. Одоо Японы туршлагыг аваад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөрт бэлтгэх жоб коуч (job coach) гээд хүмүүс бэлтгэж, хэрэгжүүлж үзэх гээд байх шиг байна. Янз янзын төсөл хөтөлбөр хэрэгжүүлээд л байна л даа. Гэтэл бид тэр төсөл хөтөлбөрт хамрагдах ямар ч боломжгүй, маш өндөр цензуртэй байдаг. Тэгээд тендер авахын тулд хөөрхөн материал бүрдүүлнэ, мөнгө төгрөг гаргана. Тэгэхээр би хүүхдийнхээ асаргааны мөнгөөр л амьдардаг, сайн дурын ажил хийдэг хүний хувьд тендер болгонд ороод байж чадахгүй. Төсөл хэрэгжүүлж байгаа байгууллагуудыг хянах тогтолцоон нэлээн сайн байх хэрэгтэй гэж би хардаг. Зарим газрууд, сургалтын төвүүд төсөл аваад хэрэгжүүлдэг. Гэтэл яг хэдэн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилтай, орлоготой болгосон бэ, яг ажилтай, орлоготой болж уу гэдгийг нь нүдээрээ очиж хараад явах хэрэгтэй санагддаг. Миний мэдэхийн Ээлтэй ертөнц гээд төрийн бус байгууллага байдаг. Тэднийх хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээр чихмэл тоглоом хийлгээд, тэдний хийсэн бүтээгдэхүүнийг борлуулаад хүүхдийн цэцэрлэг эсвэл багш нарыгаа цалинжуулдаг зохицуулалт хийдэг. Тиймэрхүү хийж байгаа, чадаж байгаа хүмүүсдээ өндөр цензур тавиад байхгүй, дэмжээд явмаар санагддаг.

Та сая охиноо 5 жил сургуульд сургасан гэж ярьсан. Та өөрийнхөө үзэж харсан туршлагаасаа хуваалцахгүй юу?

Намайг хүүхдээ аваад явахад маш сайхан хүмүүс таарч байсан. "Хүүхдийг чинь авахгүй" гэж нэг ч хүн хэлээгүй. Би бусад эцэг эхчүүд шиг хүүхдээ сурч чадна гэж боддог байгаагүй. Манай хүүхдийн сонсох, харах 2 мэдрэмж сайн хөгжсөн, юмыг сонсоод, хараад ойлгодог ч ярьж чадахгүй, гараараа бичиж чадахгүй, өөрөө алхаад явж, сууж чадахгүй учраас миний хүүхэд сургуульд сурна гэдэг бараг үлгэр шиг надад санагддаг байсан. Тэгээд хүүхдээ хаашаа хамруулах вэ гэтэл ганц байдаг 10-р цэцэрлэгт нас нь өнгөрчихсөн гээд хүүхэд авахгүй байсан. Хүүхдээ хамруулах газар хайгаад, хаашаа явахаа мэдэхгүй хорооныхоо зохион байгуулагч дээр очоод, сэтгэлээ онгойлгоод ярьтал "сургуульд оруулах уу?

Танай бага чинь угаасаа сургуульд орох юм бол багатайгаа хамт оруулчих. Би сургуультай яриад өгье" гэж хэлэхэд надад маш гоё санагдсан. Авах газар үнэндээ олдохгүй байсан болохоор "сургуульд хүүхдээ оруулах уу, хүүхдийг чинь сургуульд оруулаад өгье" гээд хүн хэлэхээр маш их баярладаг. Тэгээд би "тэгье, тэгье" гэсэн. Нөгөө нийгмийн ажилтан маань

сургуулийн нийгмийн ажилтантай ярилаа, сургуулийн нийгмийн ажилтан дээр бид нар очиж уулзаад, сургуулийн захирал дээр нь орсон. Хүмүүс маш гоё хүлээж аваад, "өө тэг, хүүхдээ аваад суу, танай хүүхэд ганцаараа сууж чадахгүй учраас та хүүхдээ аваад суувал болно" гэсэн.

Хүн чинь нөхцөлийг нь бүрдүүлээд өгч байхад олон хүүхдүүд дунд хүүхдээ оруулах гээд дуртай зөвшөөрнө биз дээ. Сургуульд анхны өдөр бид хоёрыг ирэхэд нийгмийн ажилтан маань түрүүлээд хүүхдүүд, багшид тайлбарлаад, ойлгуулсан байсан. Тэгээд л анги руу яваад ороход хүүхдүүд бүгдээрээ "Номин сайн уу?" гээд л мэндэлсэн. Сургуульд явснаараа наад зах нь хүүхдүүдтэй, багштай мэндлэх гэдэг юмыг сураад эхэлж байгаа юм. Өдөр болгон багш мэндлэхдээ "Номин сайн уу?" гээд гараа өгдөг байсан. Манай хүүхэд багш гараа өгөөд байгаа болохоор тэр хүнд хариу үзүүлэх хэрэгтэй гэдгээ ойлгоод, өөдөөс нь гараа өргөөд дөхүүлдэг байсан. Ингэж явсаар 5 жил сурахад манай хүүхэд тод өнгөнүүдийг мэддэг болсон байсан. Би хүүхдээ ерөөсөө өнгө мэддэг болсон гэж боддоггүй. Санаандгүй хоёр өөр өнгөтэй юмыг зэрэгцүүлж тавиад асуусан чинь мэдэж байсан. Дараа нь сэтгэцийн эмнэлгийн АйКю (IQ) тогтоодог эмч нар судалгаа авна гэж ирээд, өнгө өнгийн юмнууд харуулаад, энэ өнгө цэнхэр өнгө мөн үү? Мөн бол гараа өргөөрэй, биш бол гараа буулгаараа гэсэн чинь манай хүүхэд гараа өргөж, буулгаж байсан. Тэгээд л би хүүхдээ тод өнгөнүүдийг мэддэг юм байна гэдгийг мэдэж авсан.

Би хүүхдээ авч хичээлд сууж байхдаа хүүхдээ нийгэмшүүлж байна гэдэг бодолтой байсан болохоос хүүхдээ юм сураад, ойлгоод, мэдрээд байгааг нь ерөөсөө мэдээгүй. Тэгээд 5 жил сурахад манай хүүхдэд гарсан ахиц нь өнгө таньдаг болсон байна. Хэлж ярьж чадахгүй ч гэсэн энэ хүүхэд юм ойлгочихсон байгаа юм. Тэгээд гараа өргөөд эсвэл нүүрнийхээ хувирлаар эвсэл ямар нэг үйлдлээр өөрийгөө ойлгуулдаг болсон. Ангийн хүүхдүүд нь маш гоё хүлээж авдаг байсан. Өөрөө барьж чадахгүй болохоор би гарыг нь бариулж байгаад будуулна. Номингийн гар нь л оролцож, бараг л би будчихаж байна гэсэн үг. Тэгж л би хүүхдийнхээ оролцоог хангаад явж байсан. Тэгээд хүүхэд болгон хийсэн юмаа багшид үзүүлэхээр "Номин юу хийсэн бэ?" гээд багш асуухаар. Өвөр дээр нь дэвтрийг нь тавиад, түрж багшийн ширээний хажууд очоод, юмаа үзүүлэхээр багш "Номин ёстой сайн байна, ээжтэйгээ хамт ингээд хийсэн байна шүү" гээд таван хошуу тавиад л, хүүхдүүд "Номин сайн байна, илүү хичээгээрэй" гээд хэлэхээр Номингийн баярлахыг яана аа.

Тэгэхээр "би энэ юмыг хийхэд оролцсон, би энийг хийх ёстой юм байна, энийг хийж байж би сурагч болоод байгаа юм байна" гээд хүний амьдралын нэг хэсгийг хүүхэд ойлгож аваад, тэнд болж байгаа процессыг мэдрээд байгаа юм. Тэгэхээр хүүхэд шал өөр болдог. Бас өдөр болгон дургүй тариагаа хийлгээд, хатгуулаад, өвдөөд эмнэлэгт байгаа хүүхдийн сэтгэл санаа яаж сайхан байхав дээ. Тэгэхэд л

эцэг эхчүүд, багш, ангийн хүүхдүүдийн төлөөлөл эргээд ирэхээр, хараад аймаар их баярладаг юм байна лээ. Энэ бүх зүйлс чинь хүүхдэд баяр баяслыг өгч, цаашдаа би гадуур явах ёстой юм байна, би иймм юманд оролцох ёстой юм байна, би хийх ёстой юм байна гэдэг ойлголыг өгч, сэтгэл зүйд нь маш их нөлөөлдөг юм байна гэж харсан. Тэргэнцэр дээрээ суух их дургүй байсан хүүхэд чинь сургуульд ороод 5 жил сурсных яах аргагүй ангийнхаа хүүхдүүдийн дунд байхын тулд тэргэнцэр дээр маш сайн сурдаг болсон. Өдөрт 5 цаг хичээллэхэд тэр 5 цагт суугаад гардаг байсан. Би хоёр цаг суулгаад, бага багаар хүүхдээ дасгая гэтэл бүр суух гээд, хичээл таран тартал суудаг байсан. Өөрөө сургуульд явах маш дуртай. Тэгээд хүнд мэдэхгүй, чадахгүй, хожуу ойлгодог алдаатай юмнууд бас гарч ирдэг юм байна. Анхандаа сургуульд оруулахдаа би хүүхдээдээ форм авч өгнө гэж бодоогүй байж байтал хүүхэд маань сурагч гэдгээрээ яг бусадтай адилхан байх гээд форм нэхдэг юм байна. Тэгээд л хүүхэд өөрийн гэсэн юмтай болоод ирэхээр маш баяртайгаар юмаа хийх гээд оролдоно. Тэгээд "анги дунд би оролцож байна, энэ ангид би хувь нэмрээ оруулж байна, би энд байх ёстой гэдгээ" хүүхэд мэдэрч байна гэдэг хүүхдийн сэтгэл зүйд нөлөөлөх маш том зүйл байдаг. Тэр л нийгэмших нэгдүгээр хувилбар юм болов уу гэж би боддог.

Гэртээ өдөржингөө хоёулаа эрхлэлдээд байж байхын оронд ямар нэгэн юманд явуулахыг хүссэн маань биелээд боломжтой болсон. Багш бол үнэхээр мундаг байсан. Багш өөрөө манай хүүхдийг түрж самбарын өмнө авч ирээд, гарт нь шохой бариулаад, самбар дээр хүртэл зуруулж үзэж байсан. Тэгэхээр тэр бүх юмыг хийж үзэж байна гээд хүүхэд маань баярлаад, өөрт нь маш сайхан байсан. Тэгээд дунд ангийн 17-18 хичээлийг манай хүүхэд яаж үзэхэв дээ, хөөрхий минь. Одоо насан туршийн боловсролын төвд орсон ч хичээл эхэлснээс хойш ханиад хүрээд, эрүүл мэндийн шалтгаанаас болоод явж чадаагүй байгаа. Хичээлд явах гээд формоо бас бэлдчихсэн байгаа. Сая ч гэсэн би аймаар том алдаа гаргасан. Би багынхаа формыг бэлдчихье, Номин яахав гээд үлдээчихсэн. Гэтэл 8 сарын 30-ны орой нь дүү нь формоо индүүдээд, хичээлдээ явах бэлтгэлээ хийсэн чинь Номин өнхрөөд хажууд нь оччихсон нөгөө формыг татаад булаацалдаж байсан. Тэгээд сүүлд нь дүүгийнх нь багадсан форм байж тараад, тэрийг нь хасуулж өгөөд нэг хүүхдээ тайвшруулсан. Тэгэхгүй бол нэхээд, уурлаад өөрийгөө бас илэрхийлж байгаа юм. Хүүхэд өөрөө би сургуульд сурдаг гээд чин сэтгэлээсээ бэлдээд, бүр тэр мэдрэмж нь байгаа юм.

Тархины саажилттай хүүхдийн онцлог юу байдаг вэ?

Хүүхэд хүүхдийн онцлог өөр. Саажилт янз янзын бэрхшээлүүдтэй хавсардаг тохиолдлууд их байдаг. Бүх зүйлийг ойлгох чадвар сайтай хүүхдүүд дийлэнх хувийг нь эзэлдэг ч оюун хавсарсан нэг хэсэг хүүхдүүд байдаг. Миний хүүхэд л гэхэд хүний ярьсан юмыг "хүмүүс өөрийг

нь муу хэлж байна, сайн хэлж байна" гээд нэг бүрчлэн маш сайн ойлгоно. Би цахимаар сургалтад суугаад, дэлгэцээр юм хийж байхад өөрийнхөө таньдаг хүмүүсийг хайгаад, хараад байж байдаг. Тэгээд таньдаг хүн нь харагдвал онгирч инээгээд, ярих гээд л үзээд байдаг. Гэхдээ л бэрхшээлийн хувьд тухайн хүүхдийн бэрхшээлийн онцлог, өөрийн онцлогоос шалтгаалаад өөр өөр байдаг. Тэгэхээр яг тэр хүүхэд ийм, энэ хүүхэд ийм гэж таамгаараа хэлэхэд жоохон тиймхэн. Гэхдээ саажилттай хүүхдүүд дунд тулгуур эрхтний эсвэл хөдөлгөөний бэрхшээл илүү давамгай байдаг. Тэр талын асуудлуудыг зохицуулаад явбал сурч хөгжих, сайхан нийгэмдээ ороод, зэрэгцээд амьдраад явах боломжууд нэлээн байгаа. Эцэг эхчүүд "би бэрхшээлтэй хүүхэдтэй, би хэцүү байна" гэж бодохоосоо илүүтэй, ээж аав мөнх биш, хэзээ нэгэн цагт яваад өгөх учраас "надаас хойш яаж энэ нийгэмтэй амьдрах вэ, яаж ээж аавгүй өөрийгөө аваад явах вэ?" гэдгийг бодож л хүүхдээ сургаж, хүмүүжүүлэх хэрэгтэй. Тэгэхгүй бол би мөнх биш, надаас хойш миний хүүхдийг байнга асраад байх хүн хаана байгаа билээ? Тэгэхээр ядаж л энэ нийгэмд яаж амьдрах вэ? гэдгийг нэлээн сайн бодож байх хэрэгтэй. Хэвтрийн хүүхдүүдийн хувьд бас хэцүү л дээ, энэ хүүхдүүдийг асрах зайлшгүй шаардлагатай.

Манай подкастын цаг өндөрлөх дөхөж байна. Танаас сүүлийн асуултаа асууя. Таны цаашдын хүсэл мөрөөдөл юу байдаг вэ?

Угаасаа миний амьдрал үр хүүхдийнхээ төлөө л болчихлоо. Би 15-16 жил хүүхдээ асарлаа, цаашаа ахиад би олон жил хүүхдээ асарна. Тэгэхээр хүүхдээ л сайн сайхан байлгах юмсан, хүүхдийнхээ төлөө л өөрийнхөө хийж чадах бүхнийг хийе гэж бодож байна. Тиймдээ ч би олон хүнд туслах юмсан, олон хүмүүст хэрэгтэй мэдээллийг нь өгөх юмсан гэж хүссэн болохоор энэ сайн дурын ажлыг хийгээд явж байгаа. Олон хүүхэд ирээдүйд сургууль, цэцэрлэгтээ хамрагдаад, хүүхдүүдийн орчин нөхцөл гоё болоод, нийгэм яг л хүн гэдэг талаас нь хүлээгээд авдаг сайхан нийгэм хүртээсэй л гэж хүсэж байна. Одоо бол хэцүү байгаа шүү дээ. Нэг автобусанд хүүхдээ аваад суухад л эвэртэй туулай үзсэн юм шиг харна. Зарим хүмүүс яагаад ийм болчихсон юм, яачихсан юм гээд л аймаар асуудалтай. Нийтийн тээвэрт суухад налуу зам байхгүй, суудал олдохгүй гээд асуудлууд маш их байдаг. Нийгмийн хандлага нь өөрөө маш сайхан болж байж л энэ хүмүүсийг хүн гэдэг талаас нь ойлгож, ханддаг болчихвол зүйлс сайхан болоод явчихна гэж бодож байгаа. Дээрээс нь төр засаг маань тогтолцоогоо эргэж хараад, энэ хүүхдүүдийн боловсрол, эрүүл мэндийн тал дээр шийдэх, хөрөнгө оруулалт хийх ёстой асуудлууд нэлээдгүй харагдаад байдаг учраас тэр асуудлууд луугаа анхааараасай гэж хүсэж байна.

Цаг зав гарган өөрийнхөө олж мэдсэн туршлага, мэдлэгээ бид нарт хуваалцсанд маш их баярлалаа.

ЭПИЛЕПСИТЭЙ ХҮҮХЭДТЭЙ ААВ ЭЭЖ НАРТ ТУСЛАХЫГ ХҮСДЭГ

Ч.Элбэгдорж



Энэхүү дугаарт Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбооны эпилиппстэй хүүхдүүдийн эцэг эхчүүдийн бүлгийн ахлагч Элбэгдорж оролцож байна. Та манай подкастын урилгыг хүлээн авсанд маш их баярлалаа. Юуны өмнө та өөрийгөө танилцуулахгүй юу? Яагаад энэ холбоонд орохоор болов? Мөн бүлгийн ахлагч болсон талаараа ярьж өгөхгүй юу?

Та бүхэнд ч гэсэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар ойлголт, хандлагыг нийгэмд өгөх гэж байгаад баярлалаа.

Энэ подкастыг сонсож байгаа та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе! Намайг Элбэгдорж гэдэг. Би сайхан ханьтай, 4 сайхан хүүхэдтэй эх хүн. Би нийтийн хоолны техник технологич мэргэжлээр төгссөн. Хорвоогийн зовлон жаргал ээлжилдэг амьдралын жамаар амьдарч байгаа. Тэтгэвэртээ гараад хоол судлалаар ажиллана гэж зорьж байсан хүн өнөөдөр хөгжлийн бэрхшээлийн талаар яриад сууж байгаа нь хүний амьдрал таашгүй гэдгийн нэг жишээ юм. Би хөгжлийн бэрхшээлтэй холбогдох болсон шалтгаан гэвэл миний хүү анх 8 настай эв эрүүл, сав саруул хүүхэд гүйж яваад ухаан алдаж унаснаас хойш эпилэпситэй хүүхдүүдтэй холбогдох болсон. Тэгээд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбоо (ХБХЭЭХ)-той холбогдсон нь гэвэл

2011 онд хүүгээ сайн гэсэн болгон луу авч явж байсан үед Германы эмч ХБХЭЭХ-нд ирсэн гэж сонсоод хүүгээ үзүүлэхээр очсон. Энэ үед хорвоогийн үнэнтэй нүүр тулж миний хүүгийн эпилипси маш хүнд хэлбэртэй гэдгийг мэдсэн. Энэ үеэсээ л ХБХЭЭХ, тэр тусмаа эпилепситэй хүүхдүүдийн эцэг эхчүүдтэй холбогдож эхэлсэн.

Эпилепси гэж ярихаар ойлгохгүй хүмүүс зөндөө байдаг. Энэ хөгжлийн бэрхшээлийн яг ямар төрөл вэ?

Эпилепсийн уналт таталт гэхээр эмч нар, гэр бүлийнхэн мэднэ, нийгэм бол ойлгодоггүй. Яг үнэндээ аргыг нь олж, аяыг нь даахад маш хэцүү өвчин байдаг. Хүн харахад эрүүл саруул юм шиг мөртлөө хаана ч, хэзээ ч унаж татах магадлалтай. Манай нийгэмд байгаа ойлголт бол ухаан алдаад уначихдаг гэж айж сандардаг. Эпилепси судлаач эмч нар энийг маш сайн судлаад, арга эвийг нь олох гэж ажиллаж байгаа. Гэвч бусад эмч нар, эрүүл мэндийн байгууллага, нийгэмд энэ өвчнийг тэр бүр мэддэггүй. Анх 2003 онд миний хүү унаж татсанаас хойш бараг 20 жил энэ өвчний арга эвийг олох гэж явна. Тэгэхээр хаа хамаагүй ухаан алдаад унадаг гэсэн ойлголт байдаг. Яг нарийндаа бол маш хэцүү. Нийгмээс илүү тэр гэр бүлийг цочроосон, гэр бүлийн өвчин гэж бараг хэлж болохоор байдаг. Яагаад гэвэл хэзээ, хаана унах бол гэсэн байнгын айдастай амьдардаг. Яг хөгжлийн бэрхшээлийн төрөл зүйл гэхээр сурч хөгжөөд нийгэмд ажил хөдөлмөр эрхлээд явах боломжтой нэг хэсэг байхад, нөгөө хэсэг нь эдгэдэггүй, тэсвэртэй эпилепси гээд маш хүнд хэлбэртэй, их хэцүү өвчин байдаг.

Та нэлээн хэцүү өвчин гэж их дурдлаа. Яг ямар байдлаараа хэцүү байдаг вэ?

Эм нь таардаг хүмүүс эмээ уугаад, өвчнийхөө арга эвийг олоод нийгмийнхээ дунд ороод хүүхэд бол сураад, насанд хүрэгчид нь хөдөлмөр эрхлээд явах боломжтой хүмүүс байхад, яах аргагүй насан туршдаа энэ өвчнөөр өвдөөд байгаа хүмүүс байна. Жишээлбэл, дэлхий нийтэд эпилипсигийн 80 хувь нь мэс засал, кето хоол, эмээр эмчлэх боломжтой ч, хүн хэлбэрийн эпилепситэй 20 хувийг нь эмчлэх эмчилгээ өдийг хүртэл олдоогүй байгаа гэж үздэг. Яг тэдний нэг нь миний хүү болохоор би энэ үгийг хэлэх шиг боллоо.

Та 80 хувь нь эмчлэгддэг, 20 хувь нь эмчлэгдэхгүй байгаа гэж ярьсан. Эмчлэх ямар ямар арга замууд байдаг вэ?

Эмчилгээн дээр хамгийн нэгдүгээрт эм, эмийн бэлдмэл. Дараагийн тодорхой хэсэг хүмүүс нь хагалгаанд ордог. Хүүхдүүдийн тодорхой хэсэг нь кетогийн хоолны дэглэмээр эмчлэгддэг юм шиг байгаа юм. Яг эм эмчилгээний талаар би ярих эрхгүй яагаад гэвэл би нийтийн хоолны технологич мэргэжилтэй хүн. Би энэ бүлгийг яагаад ажиллуулж, зөвлөгөө өгч, эпилепси луу гүнзгий ороод байна вэ гэвэл энэ ганцхан эмнэлгийн зүгээс эсвэл нийгмийн зүгээс шалтгаалахгүй, эцэг

эхчүүд, гэр бүлээс асар их шалтгаалдаг өвчин юм. Дээрээс нь эмч өвчтөн, гэр бүл гэсэн маш олон жилийн хамтын хөдөлмөрийн үр дүнд засарч, сайжрал авдаг. Түүнээс ийм ийм гэж эмнэлгийн үг яриагаар би ярих боломжгүй байна.

Та сая гэр бүлд нь зөвлөгөө өгдөг гэж хэллээ. Тэгэхээр гэр бүлийнх нь хүмүүст ямар төрлийн зөвлөгөө өгдөг вэ?

Эцэг эхчүүд сайн дурааараа нэгдээд, нэг ийм бүлэг байх хэрэгтэй юм байна гээд бид 2015 онд эпилепситэй хүүхдүүдийн эцэг эхчүүдийн бүлэг байгуулсан. Энэ бүлэгт өөрт тохиолдсон, хуримтлагдсан туршлага, олж мэдсэн зөвлөгөө зөвлөмжүүдээ хуваалцах, нийгэмд эерэг хандлага өгөх гэсэн маш олон зорилготойгоор энэ группийг эхлүүлсэн. Дөнгөж эпилепси гэдэг оношийг сонсоод эцэг эхчүүд маш их сандардаг, би ч гэсэн сандарч байсан. Хаана, хэнд хандахаа мэдэхгүй, хорвоогийн бүхий л сайн гэсэн болгоноор яваад маш их цаг хугацаа алддаг. Тэр нь хэрэгтэй ч юм байгаа, хэрэггүй ч юм байгаа. Энэ цаг хугацааг хэмнэж, ирээдүйд миний хүүхэд ямар хүн болох вэ гээд энэ алдсан цаг хугацаагаа хүүхдийнхээ хөгжил, боловсролд зарцуулсан бол гэж харамсах уе надад байдаг. Энэ харамслыг олон эцэг эхчүүдэд давтуулахгүй юмсан гэсэндээ би сайн дурын ажил хийдэг. Бидэнд эмчээс сурсан зүйлүүд маш их байгаа. Гэхдээ энэ бүлэгтээ эмчийн зөвлөгөө биш, сандарсан, анхны тусламж хэрхэн үзүүлэхээ мэдэхгүй эцэг эхчүүд олон байдаг учраас жишээлбэл анхны тусламжийг яаж үзүүлэх вэ, эм эмийн бэлдмэлийг тогтмол цагт, тогтмол яаж хэрэглэх вэ, нойр, хоол, хориглох зүйлс, халуун нар гэх мэтчилэн эплепситэй хүмүүсийн хориглох болон анхаарах зүйлс, хэдийд түргэн тусламж дуудах вэ, яах вэ гэсэн энгийн гэр бүлээс хамааралтай зүйлүүдийн зөвлөгөө өгдөг. Эмч бол хүүхдээ үзээд эмээ зөвлөнө, янз бүрийн зөвлөгөө өгнө. Тэрийг зөвлөгөөг дагаж мөрдөөд, цаашдаа энэ урт амьдралын замд хамт явна гэдэг гэр бүлийн асуудал байдаг. Энэ дээр нь анхаарч зөвлөгөө зөвлөмж өгөх бүлэг байгаа юм.

Та эцэг эхчүүдэд зөвлөгөө өгөөд явж байхад тэдний зүгээс ийм асуудал л илүү их тулгамдаад байна, ийм саад бэрхшээл байна гэсэн зүйлүүд юу байдаг вэ?

Эпилепситэй хүүхдүүдийн эцэг эхчүүдийн хувьд маш олон саад бэрхшээл байдаг. Жишээлбэл ялангуяа шөнө уналттай хүүхэдтэй эцэг эхчүүд хэзээ ч бүтэн нойртой хонож чаддаггүй. Хажууд байгаа хүнээ барьж аваад, хүүхдээ тэмтрээд байдаг. Тэнд хамгийн гол нь тайван байх хэрэгтэй. Мөн Монгол улсад байгаа эмийн эрэл хайгуулын ажил. Би эпилепсийн тухай ярья гэсэн цахим бүлэг интернетээр ажиллуулдаг. Тэнд бид нар зөвлөгөө зөвлөмж өгч, нэг нэгэндээ хэрэгтэй, сайн туршлагуудаа хуваалцаж, эмч нарын зөвлөгөө, зөвлөмжийг гаргах зорилготой нээсэн чинь одоо “ийм эм байна уу, ганцхан ширхгийг өгөөч, хоёрхон ширхгийг өгөөч манай хүүхдийн эм дууслаа” гэдэг болсон. Энэ нь эм, эмийн

бэлдмэлийн нөөц Монголд үнэхээр хэцүү байна гэдгийг харуулж байна. Дээрээс нь эпилепси судлаач цөөхөн хэдэн эмч нар дээр байнгын дараалал ихтэй байдаг. Энэ байдал нь эмчдээ ч, эцэг эхчүүддээ ч хүндрэлтэй байдаг. Бас нийгэм хүүхдүүдийг хүлээж авахад бэлэн биш байдаг. Ялангуяа энд тэнд гудамжинд татаад унах юм бол бүгд тойрч шавснаа, бүгдээрээ зугтчихдаг, хэн ч тусалдаггүй. Тэр нийгмийн, ард түмний буруу биш. Яагаад гэвэл тэр талаар мэдлэг, мэдээлэл ард түмэнд өгдөггүй. Унаж татсан хүн гудамжинд таарах юм бол та анхны тусламж үзүүлээрэй, түргэн тусламж дуудаарай гэх мессеж нийгэмд алга. Тийм болохоор эцэг эхчүүдэд асуудал дээр нь асуудал нэмээд байна.

Эмч нар нь яагаад тийм цөөхөн байдаг юм бол? Тэрнээс гадна яг эпилепситэй хүмүүс хэр их байдаг вэ?

Би яг тэд байдаг гэж тоо баримт хэлж чадахгүй байна. Эпилепси хөгжилтэй улс оронд ч байдаг, буурай улс орон гэж байдаг. Бусад хөгжлийн бэрхшээлийн нэгэн адил цаашдаа тасраад, устах ямар ч нөхцөлгүй. Эпилепситэй хүүхдийг гаднаас нь хараад энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд гэж мэддэггүй, унаж татсан үед нь л сандардаг. Тэргэнцэртэй эсвэл таяг тулсан хүн гудамжинд, автобусанд явж байвал хөгжлийн бэрхшээлтэй хүн байна гээд зам, суудал тавиад өгдөг. Эпилепситэй хүнийг мэдэхгүй учраас автобусанд бүгчим агаартай газар зогсож явж байгаад татаж унах тохиолдлууд олон байдаг. Унахаар нь хүмүүс өвчин нь бараг шууд хүнд халдварлах юм шиг айж, сандардаг. Энэ нь эцэг эхчүүдэд маш хүнд тусдаг.

Эмч, мэргэжилтний хувьд ямар байдаг вэ?

Эмч мэргэжилтний хувьд эпилепси судлаач гарын хуруунд багтахаар цөөхөн байдаг. Эпилепси бол мэдрэлийн өвчин. Улс энэ тал дээр бодлогоор анхаарч мэдрэлийнхээ эмч нарыг ялангуяа хүүхдийн мэдрэлийн эмч нарыг бэлдэж багаас нь хүүхдийг унаж татахаас нь урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч, цаашдаа нийгмийн дунд амьдрах боломжийг олгох ёстой. Тэгэхээр эмч нараа сайн сургаж, дадлагажуулаач ээ гэж хэлмээр байдаг юм.

Эпилепсигийн талаарх нийгмийн хандлага хэр байдаг вэ?

Эпилепсигийн талаар нийгмийн хандлага маш ойлголт муутай байдаг. Жишээлбэл зарим эпилепситэй хүмүүс эм уугаад ажил хийх боломжтой. Гэтэл ажлынх нь газрын хүмүүс эпилепситэй гэж мэдэнгүүт шууд ажлаас нь халсан ч тохиолдол байдаг. Дээрээс нь манай улс нийгэмд энэ талын мессежийг маш бага өгдөг. Энэ бол гэр бүлийн гэж хэлэхээсээ илүү нийгэмд бас хамааралтай өвчин байдаг. Яагаад гэвэл тэр хүн татаж байгаа тохиолдолд хажууд нь таарсан хүн нь эвтэйхэн түшээд, юм мөргүүлэхгүй нэг удаагийн давталтыг нь аврах юм бол тэр хүнд цаашдаа үүсэх хүндрэлийг нь хамгаалж байгаа гэсэн үг. Тэгэхээр нийгэмд энэ талаар маш их

мессеж өгөх шаардлагатай. Миний хүү 2003 онд татдаг болсон. Тэрнээс өмнө би энэ талаар ямар ч мэдлэг, мэдээлэлгүй байсан. Тэгэхээр зөвхөн гэр бүл, ах дүү, хамаатан садан дотроо л энэ өвчнийг байлгаад байдаг. Гадаа сүүдрэвчид сууж байгаа хүнд миний хүүхэд унаж татдаг гээд хэлэх юм бол хүүхдээ хөтлөөд явчихдаг. Би "унаж татсан үед нь миний хүүд тусалчихаарай, бариад авах ч юм уу эсвэл түшээд аваарай" гэсэн ойлголттой хэлж байхад тэр хүн "хүүе наадах чинь унадаг хүүхэд байна" гээд хүүхдээ авааД зугтаачихдаг жишээтэй. Энэ бол өөрийнхөө хувь заяатайгаа эвлэрээд явж байгаа эцэг эхчүүдэд нийгмээс зүгээс хамгийн хүнд тусдаг хүндрэл байдаг.

Хажууд хүн унаж татвал анхны ямар тусламж үзүүлэх шаардлагатай байдаг вэ?

Хүн унаж татвал нэгдүгээрт тэр хүний хажууд байгаа хүмүүс энэ халдварт өвчин биш гэдгийг хамгийн түрүүнд ойлгох ёстой, эпилепси хэзээ ч хүнээс хүнд халддаггүй. Хоёрдугаарт тэр хүнийг бариад эсвэл түшээд аль болох боломжийн эрсдэлгүй газар хэвтүүлэх хэрэгтэй. Хэрвээ яг замын голд байвал тэр эрсдэлээс нь хамгаалах



хэрэгтэй. Эпилепси чинь зүгээр байж байгаад тодорхой хугацаанд гэнэтхэн гарч ирээд, хаана ч, хэзээ ч хамаагүй татах магадлалтай. Яг тэрэнтэйгээ адилхан хэдхэн секунд эсвэл хэдэн минутын дараа аяндаа өөрөө гэнэт зогсдог таталт байдаг. Таталт зогсохыг нь хүлээгээд хажуу тийш нь харуулаад эсвэл тэр эрсдэлтэй орчноос хүнийг зайлуулж, гэнэт юм мөргөхөөс нь хамгаалахыг эхний ээлжинд хүмүүсээс хүсээд байгаа юм. Анхны тусламж гэвэл тэр хүнийг хэдэн минут, хэдэн секунд татах нь вэ гэдгийг тооцож цагаа харна. Дээрээс нь үргэлжлэх хугацаанаас шалтгаалаад түргэн тусламж дуудах уу, үгүй юу гэдгээ шийднэ. Хүн татангуут л түргэн тусламж дуудах шаардлагагүй байдаг. Тодорхой хэсэг нь таталт өгөөд, дараа нь таталт өөрөө зогсчихдог. Тэгэхээр тэр хүнийг нэг удаагийн эрсдэлээс нь л хамгаалчих юм бол нэг удаагийн тусламж болж байгаа юм. Цаашлаад анхны тусламж гэвэл бүр нарийн байдаг. Амьсгалын тоо нь хэд байна, угсарсан таталт өгч байна уу, ямар үед түргэн тусламж дуудах вэ гээд бас нарийн л даа. Бид 2016 оноос хойш л анхны тусламж үзүүлэх талаар жижигхэн зурагт хуудас хийж группдээ байрлуулаад, амьхандаа шинээр эпилепситэй гэж оношлогдсон хүүхдүүдийн эцэг эхчүүдэд анхны тусламж гэдэг зүйлээрээ эмээ ингэж уулгаараа, хоолоо ингээд зохицуулаарай гээд л зөвлөгөө зөвлөмжүүдийг өгдөг. Энийгээ одоо нийгэмд түгээмээр байгаа ч яаж түгээх аргаа мэдэхгүй байна л даа. Эпилепситэй хүмүүст ингэж тусламж үзүүлээрэй, энэ хүмүүсийг ингэж ойлгоорой гэсэн мессеж өгөх ажлыг хувь хүмүүс, ХБХЭЭХ биш, төр хариуцаад хийх ёстой. Төр бид нартай хамтраад хийгээсэй гэж бас боддог.

Эпилепситэй хүүхдүүд сургуульд хамрагдах эсвэл сургуулиа төгсөөд ажил төрөл хийх тал дээр ямар байдаг вэ?

Энэ харин маш чухал бөгөөд сайхан асуулт байна. Эпилепситэй хүн гэхээр л насан туршдаа гэрийн мухар сахих асуудал биш л дээ. Хүмүүс бол “энэ унадаг юм чинь гэртээ л байна” гэж боддог. Хэдэн жилийн өмнө өдрийн уналт өгдөг хүүхдийг сургууль авахгүй, буцаадаг байсан. Тэгэхээр дэлхий нийтийн чиг хандлагад гэвэл эпилепситэй хүн эмээ уугаад л, бусдын адил сурч, хөгжиж, ажил хөдөлмөр эрхлээд явах бүрэн боломжтой. Онгоц, машин жолоодохгүй гэх зэрэг хориглосон тодорхой хэдхэн мэргэжил байдаг. Тэрнээс бусад ажлыг хийгээд явах боломжтой гэж үздэг. Харин Монголд жоохон хэцүү байна. Яагаад гэвэл эм хангамжийн хүрэлцээ, эпилепси дээр ажиллаж байгаа эмч нарын хүрэлцээ хангамж муу байна. Би яг группийнхээ жишээгээр л ярьж байгаа шүү. Манай групп 1,700 хүнтэй эпилепсигийн тухай ярья гэсэн групп байгаа. Тэнд бичиж байгаа эцэг эхчүүдийг харахаар ихэнх нь манай хүүхэд хүндрээд байна гэсэн мэдээлэл маш их явдаг. Энэ миний сэтгэл эмзэглэж явдаг юмны нэг. Эпилепси эдгэрэх ёстой өвчин юм чинь эдгэрч байгаа цөөхөн хувь бас байгаа. Саяхан бид нар уулзалт хийж байхад “би магистраа төгсчихсөн,

одоо докторт сурах гэж байгаа" гээд нэг охин ярьж байсан. Тэгэхээр эпилепси бол тэр хүний ажил мэргэжил, боловсролыг хязгаарлахгүйгээр аль болох уух ёстой эмээ цагт нь уугаад, эмчийнхээ хяналтад ороод явах боломжтой юм байна. Бас эпилепситэй хэрнээ сайхан эрүүл саруул хүүхэд гаргаад, өсгөж өндийлгөсөн хүмүүс олон байгаа. Тэгэхээр эпилепси гэдэг нийгмээс гадуурхаад байх өвчин биш, дундаа бөөцийлөөд аваад явбал нийгэмд бусадтай адилхан хөл нийлээд алхах боломжтой хүмүүс олон байдаг гэдгийг хэлмээр байна.

Ажил хөдөлмөр эрхлэх тал дээр хэр байдаг вэ? Монголд яг эпилепситэй иргэд ажил хөдөлмөр эрхэлж байгаа баримт жишээ байгаа болов уу?

Энэ дээр бол маш хэцүү. Үнэнийг хэлэх хэрэгтэй байгаа юм. Яагаад гэвэл төрөөс маш олон төсөл хөтөлбөрүүдийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулаад хэрэгжүүлж, маш их арга хэмжээ авч байна. Тэр төсөл хөтөлбөрүүд харааны бэрхшээлтэй эсвэл тэргэнцэртэй буюу оюун ухааны нь эрүүл хүмүүс л тусдаг. Үүний нэг жишээ нь миний хүү. Эпилепси өвчнөөр олон жил өвдөхөөр оюун ухаан нь нөлөөлдөг, хүндрэх юм бол маш хортой. Би энэ төсөл хөтөлбөрүүд авч байгаа аж ахуйн нэгжүүд, төрийн болон төрийн бус байгууллагуудад маш олон удаа "тусгай сургууль төгссөн, маш их хичээл зүтгэлтэй залуу байгаа юм, ажилд аваач ээ" гээд санал тавьсан. Тэгэхэд хамгийн түрүүн ямар оноштой юм бэ гээд оношийг нь асуудаг. Төсөл хөтөлбөр хэрэгжүүлээд үнэхээр хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулъя гэж бодож байгаа бол онош чухал биш, хүнтэйгээ л ажиллах хэрэгтэй. Онош нь эпилепси, оюун ухаан гэхээр "манайх чадахгүй юм байна эсвэл дараа хариу өгье" гээд л алга болдог. Энэ төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байгаа хүмүүсийг би энийг сонсоосой гэж бодож байна. Яг оюун ухааны бэрхшээлтэй, уналт таталттай хүмүүсийг авч ажиллуулсан тохиолдолд маш цөөхөн байх. Би "яг тэр сайхан ажиллаад явж байна" гэж үнэндээ хэлж мэдэхгүй байна. Гэхдээ би Монгол улсыг тэр аяар нь мэднэ гэж байхгүй л дээ, тодорхой орон зайд судалж үзсэн. Олон тийшээ "эпилепситэй, оюун ухааны бэрхшээлтэй хүмүүсийг ажилд аваач ээ" гэж санал санаачилга тавьсан ч "уналт таталттай, оюун ухааны бэрхшээлтэй хүнийг авъя аа" гэсэн газар байхгүй байна. Гэхдээ ажиллаад явж байгаа цөөхөн хүмүүс байдаг жишээ би сонсож байсан.

Эпилепситэй хүмүүсийг эпилепситэй гэдгийг нь ажлынхан нь мэдчихвэл ажлаас нь хална гэж айгаад, нуугаад нийгэмд гараад ажил хийдэг эсвэл бүр нийгмээс тусгаарлагддаг гэж сонсож байсан?

Яг зөв. Нэг үеэ бодвол хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхчүүд хүүхдүүдээ нуухаа больсон. Нэгдүгээрт, ялангуяа төв суурин газруудад эцэг эхчүүд хүүхдээ ил гаргаад, ийм хүүхэд байгаа шүү, хүүхдээ нийгэмшүүлэх юмсан, хөгжүүлэх юмсан, боловсрол эзэмшүүлье гээд



хамт олон хүлээн зөвшөөрөхгүй байна гэдэг бол үнэхээрийн хатуу нийгэм гэж харагдаж байгаа юм. Ер нь бол нуугаад байх шалтгаан байхгүй. Нийгмийнхээ дунд гаргамаар байна. Нийгмийнхээ дунд л нийгэмшдэг юм. Залуучууд гэхэд залуучуудынхаа дунд хамгийн идэвхтэй, баяр хөөртэй, жаргалтай байдаг. Тэр дунд нь оруулмаар байна шүү дээ. Тэгэхэд нийгэм бэлэн биш, гараад явангуут нь унаж татдаг, оюун ухааны бэрхшээлтэй юм байна эсвэл саажилттай гээд хүмүүс зугтаад байна. Тэгэхээр үүн дээр нийгмийн хандлагыг өөрчлөхөд дуу хоолойгоо гаргах зайлшгүй хэрэгтэй байна.

Эпилепситэй иргэд нийгмээс тусгаарлагдаад ирэхээр уналт таталт нь улам ихэсдэг гэж сонсож байсан. Энэ ямар байдаг вэ? Энийг яаж шийдвэрлэх вэ? Уг нь нийгэмд л оруулах ёстой юм шиг байгаа юм?

Тийм, яг үнэн. Бид нар ч гэсэн эрүүл саруул хүн ч ялгаагүй нийгмээс тусгаарлагдвал тухайн хүнд гажуудал үүсээд ирдэг. Бид нар найз нөхөдтэйгөө гадагшаа сайхан салхинд гараад эсвэл нэг амралтын газар амраад ирэхээр ямар сайхан эрч хүч авдаг билээ? Зүгээр нэг гадуур гараад хүмүүсийн дунд ороод ирэхээр ямар сайхан болдог билээ? Тэгэхээр тусгаарлагдах тусам л хүний өвчин хүндэрч, тусгаарлагдах тусам

яваад байгаа. Гэхдээ хүлээж авах нийгэм хэцүү. Хоёрдугаарт, ажилд орчхоод унадаг татдагаа нуудаг шалтгаан гэвэл би өмнө нь ярьж байсан “унаж татдаг юм бол манайд таарахгүй юм байна” гээд ажлаасаа нь халсан ч хүртэл тохиолдол байдаг. Миний сонсож байсан бас нэг жишээн дээр нягтлан байгууллага дээрээ ухаан алдаж унаад бас ажлаасаа халагдаж байсан. Нягтлан бодогч болтлоо өндөр төвшинд тэр хүний оюун ухаан ажиллаж чадаж байна. Хэр баргийн хүн нягтлан бодогч гэдэг мэргэжлийг эзэмшээд хийж чадахгүй. Тийм өндөр төвшинд ажиллаж чадаж байхад 1, 2 удаагийн таталтыг тэр

л нийгмээ үгүйлээд байдаг. Нийгмийн дунд л байгаад байвал тэр хэмжээгээр тэр хүн бие бялдар, оюун ухаан нь сэргээд ирдэг. Хүн гэдэг чинь нийгмийн амьтан болохоор бэрхшээлтэй байна уу, уналт таталттай байна уу хамаагүй яах аргагүй нийгмийнхээ дунд л байх ёстой. Тэр чинь өндөр нам, өргөн нарийн гэдэгтэй адилхан хүний зүгээр л ялгаатай байдал. Тэгэхээр тэр ялгаатай байдлаасаа болоод яагаад тусгаарлагдах ёстой гэж? заавал нийгмийн дунд байх л ёстой.

Та сая хүндрээд ирэхээр тодорхой хэмжээгээр оюун ухаанд нь нөлөөлдөг гэж ярьсан. Энэ талаар дэлгэрүүлж ярьж өгөхгүй юу? Уналт таталт яагаад оюунд нь нөлөөлдөг юм бэ?

Энэ талаар надаас илүү эмч нар нарийн хэлэх байх. Би эмчийн хэлснээр ярьж байна л даа. Гэрлийн утас масслаад шатдагтай яг адилхан тархинд өөрчлөлт өгдөг. Тэгэхээр таталт өдөр бүр, хоёр хоногийн давтамжтай, гурван хоногийн давтамжтай эсвэл сард нэг удаа эсвэл улиралд нэг удаа, сард гурван удаа ч гэх зэрэг хүнийхээ бие махбод, тухайн өвчнийхөө хэлбэрээс шалтгаалаад өөр өөр байдаг. Өдөр бүхэн эсвэл өнжөөд гэрлийн утас масслаад байвал юу болох билээ яг тэрэнтэй адилхан. Тийм болохоор оюун ухаанд зайлшгүй нөлөөлдөг. Дээрээс нь эпилепсигийн хүнд хэлбэрүүдэд сэтгэцэд нөлөөтэй эмүүдийг хавсарч уух зайлшгүй шаардлагатай байдаг. Тэгэхээр унах тоолонд л хүний тархинд байгаа эд эс үхээд байдаг. Шинээр эд эс бий болно гэхээс тэр үхсэн эд эсүүд нь сэргэдэггүй. Хаяа нэг татдаг эсвэл хөнгөн хэлбэрийн эпилепситэй эмээ уугаад татахаа больчихсон хүмүүс байдаг. Бүх эпилепситэй хүмүүсийн оюун ухаанд нөлөөлөхгүй шүү, үүнийг зөвөөр ойлгоорой.

Танаас сая бүлгийн ахлагчийн хувиар олон асуултууд асуулаа. Одоо танаас эпилепситэй хүүхэдтэй эх хүний хувиас асуулт асууя. Таны хүсэл мөрөөдөл юу вэ? Хүүхдийнхээ ирээдүйг ямар байгаасай гэж боддог вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүдийн санааг зовоож явдаг хамгийн гол асуултыг асуулаа. Эх хүний хувьд бид нар мөнх биш, 10 жилийн дараа, 5 жилийн дараа, 20 жилийн дараа үр минь ямар нийгэмд үлдэх вэ гэдэгт хамгийн их санаа зовдог. Яг өнөөдрийн нийгэм бол ийм байна. Харин 10 жилийн дараа манай нийгэмд сайхан өөрчлөгдөөсэй, энэ хүмүүсийг хүлээж авахад бэлэн, айдасгүй нийгэмд хүүхдээ үлдээх юмсан гэдэг бол миний эцсийн бодол байдаг. Бид хүүхдүүдээ биеэ даагаад, өөрийгөө аваад явах чадамжтай хүн болгож л үлдээх ёстой. Би 2000-аад оны үед “та хүүхдээ биеэ даагаад үлдэх чадамжтай, бие хүн болгож өсгөж хүмүүжүүлээрэй, та насан үүрд хүүхдээ дагаж явахгүй шүү” гээд хэлээд өгөх хүн надад байсан ч болоосой гэж бодохоор их хэцүү санагддаг. Тийм учраас би энэ бүлгийг ажиллуулаад нэг ч гэсэн эцэг эхэд тусалж, нэг ч гэсэн эцэг эхийг хүүхдийнхээ ирээдүйд хөрөнгө оруулалт хийгээсэй гэж хүсдэг. Хөрөнгө оруулалт гэхээр хүмүүс эд хөрөнгө, баялаг

гэж боддог гэвч энэ хэзээ эд хөрөнгийн тухай асуудал биш. Хожуу ухаарсан нь миний нэлээн том алдаа. Хүүгээ өөрт нь тохирсон хөдөлмөр эрхлүүлчих юмсан. Би ажил хийж байгаа хүн шүү гээд сэтгэл өөдрөг яваасай гэж боддог. Гэхдээ миний хүүгийн эпилепси хэт хүнд хэлбэртэй бараг өнжөөд, хоёр өнжөөд татдаг. Тийм тохиолдолд манай Монголд ажил хөдөлмөр эрхлүүлнэ гэхэд бас хэцүү л дээ. Гэхдээ эх хүний хүсэл хязгааргүй болохоор би яаж ийгээд л өөрт нь тохирсон ажил хөдөлмөртэй болгочих юмсан гэж боддог.

Анх хүүгээ эпилепси гэдэг оноштойг нь мэдээд таны сэтгэл зүй ямархуу байсан бэ?

Анх миний хүү цоо эрүүл саруул 8 настай хүүхэд сургуульд сурдаг байсан. Сургуулийн нэгдүгээр ангид сураад, эрүүл саруул бусдын адил сурч хөгжөөд явж байснаа гэнэтхэн л нэг өдөр ухаан алдаж унаад, эпилепси гэдэг онош тавигдсан. Тэр үед хорвоогийн бүх л зовлонг ганцхан над дээр нөмөргөсөн юм шиг санагдаж байсан. Гэвч олон жилийн хугацаанд энд тэндхийн зүйл олж үзээд, олон эцэг эхчүүдтэй уулзаад явахад энэ ганцхан надад байгаа зовлон биш юм байна гэдгийг ойлгосон. Тухайн үед үнэхээр хүнд байсан. Би яг эпилепси гэж оношлогдож байгаа хүүхэдтэй залуу эцэг эхчүүдэд яг л миний энэ мэдрэмж ирж байгаа гэж бодоод туслах юмсан, ганц сайхан өгүүлбэрээр ч гэсэн тайвшрал өгөх юмсан гэж боддог. Тийм хэцүү мэдрэмжийг авч байсан хүн тэр шокноосоо гарах гэж нэлээд уддаг. Одоо тэр үеэ бодохоор дэндүү удаан шоктойгоо зууралдсан санагддаг. Миний "яана даа" гэж бодсон хугацаа бол би хүүгээ ирээдүйдээ хөдөлмөр эрхлүүлэх, биеэ даах, бие хүн болох, өөрийнхөө хоол ундаа хийх, хувцас хунараа өмсөж сургахад зарцуулах цаг хугацаа байсан. Бусад эцэг эхчүүд миний алдсан цаг хугацааг битгий алдаасай гэж бодох миний хамгийн чин хүсэл байдаг юм.

Эпилепситэй иргэдийн сэтгэл зүйн асуудлаас гадна эцэг эхчүүдийн сэтгэл зүйн асуудлыг хөндөх хэрэгтэй байх. Эцэг эхчүүд сэтгэлээр унах үед хэнд хандах ёстой байдаг юм бэ? Та хэнд хандаж байсан бэ?

Тухайн 2000-аад оны үед бараг 20 жилийн өмнө ингээрэй гээд зааж өгөх хүн надад байгаагүй, одоо бол шал өөр болсон. Сэтгэл зүй хямрах нь зайлшгүй. Гэхдээ миний хэлсэнчлэн тэр үетэйгээ зууралдаад байх утгагүй. Энэ юунаас болов, яав, яагаад заавал би гэж гээд эцэг эхчүүд маш их хямардаг. Би ч гэсэн тэгж хямарч явсан. Тэр хямрал ерөөсөө хэрэггүй. Юунаас болов, яах вэ, яачихсан юм бол гэж өнгөрсөн үетэйгээ зууралдахгүй цаашдаа яах вэ, яавал хүүхдэдээ боловсрол эзэмшүүлэх вэ, яавал хүүхдээ хөгжүүлэх вэ, яавал энэ уналт таталтыг нэг хоног, хоёр хоног ч гэсэн байлгахгүй байх вэ? гээд урагшаа хараад л тэмүүлэх юм бол бас тийм аймаар хүнд биш. Миний үеийг бодвол одоо интернет, фэйсбүүк, гадаадын орчуулга гээд залуу эцэг эхчүүдэд маш их боломжууд байгаа. Тэр үед "танай хүүхэд тахир дутуу болчихсон юм байна" гэдэг тархин дундуур татаад авч байгаа юм

шиг сонсогдмоор ганц хатуу өгүүлбэрээр онош өгдөг байсан. Одоо бол өөрсдөө санаачлагатай, идэвхтэй байвал зөвлөгөө зөвлөмж өгдөг газрууд ч байна, сэтгэл зүйчээс зөвлөгөө авах боломжууд ч байна. Идэвхжиж, чадавхжсан төрийн бус байгууллагуудаас зөвлөгөө авах боломж ч байна. Эмч нар ч гэсэн тухайн үед нэг хүнд олон талын зөвлөгөө өгөх боломжгүй, ачаалалтай байсан бол одоо чи хүүхдээ ингэж хөгжүүлээрэй гээд зөвлөгөө өгдөг болсон. Дээрээс нь фэйсбүүкийн группүүдийг авах гээх ухаанаар л хандах хэрэгтэй юм байна. Тэр группүүд дээр эцэг эхчүүд асуудлаа бичээд, бусад нь гоё сэтгэлийн дэм өгөөд, "чи энийг даваад гарч чадна, чиний хүүхдээс ч хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүд байна, ингэж байна, тэгж байна" гээд нэгэндээ сайн туршлагаа яриад, бас гарч байгаа олон арга аргачлалууд байна. Эцсийн эцэст "буцаж ухралгүй, урагшаа хараад л явчихвал давж гарахад арай хөнгөн байдаг" гэж хэл гэсэн юм.

Манай подкастын цаг өндөрлөх дөхөж байна. Танаас сүүлийн асуултаа асууя. Ковид цар тахлын нөлөө танай гэр бүл болон танай хүүд хэрхэн нөлөөлж байгаа вэ?

Манай гэр бүл, манай хүүхэд гэлтгүй нийгэмд маш хүнд тусаж байна. Тэр тусмаа эрүүл мэндийн байгууллага, эрүүл мэндийн салбарт бүр хүндээр тусаж байгаа. Өмнө нь "эпилепситэй хүмүүс агаар салхигүй, бүгчим орчинд гэрт суугаад, нийгэм лүүгээ орохгүй байх тусам улам л сэтгэл санаагаар хямардаг" гээд ярьсан. Дээр нь бид нарт ямар зөвлөгөө өгч байна гэвэл "хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, өндөр настангууд аль болохоор гэртээ байгаарай" гэдэг. Нэг талаараа тэр мессеж бид нарыг хамгаалж байгаа. Гэхдээ эрүүл хүн ч гэсэн гэртээ нэг сар суугаад үзвэл, үнэхээр гэртээ байнга байна гэдэг тийм сайхан асуудал биш. Нийгмийнхээ дунд л байлгамаар байна. Би нэг мартсан зүйлээ тодруулаад хэлчихье гэж бодож байна. Эпилепмигийн талаар манай Эрүүл мэндийн яамны судалгаа шинжилгээ их муу байдаг юм шиг санагддаг. Яагаад гэвэл сая цар тахалтай холбогдуулаад вакцинжуулалт явагдахад "нэг жилийн хугацаанд таталт өгөөгүй хүнд вакцин хийнэ ээ" гэсэн зөвлөмж Эрүүл мэндийн яамнаас өгсөн байсан. Тэгэхээр нэг өдөр таталтгүй өнждөггүй, нэг сар татахгүй байж чаддаггүй хүмүүсийг яа гэх гэсэн юм бэ, насан туршдаа гэртээ бай гэдэг зөвлөгөө өгч байгаа юм уу? Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас ийм зөвлөмж өгсөн ч байж магадгүй, би яг нарийн мэдэхгүй байна. Бодит амьдрал дээр жишээлбэл миний хүүхэд бараг өдөр бүхэн, өнжөөд татдаг гэхэд харьяалалд нь байдаг эпилепси судлаач эмчдээ хандахад "эпилепситэй хүнд ямар нэгэн гаж нөлөө байхгүй учраас вакцинаа хийлгээрэй" гэж зөвлөсний дагуу эмчээсээ бүх бичиг авч байж хийлгэсэн. Манай хүүхэд хоёр тун вакцин хийлгэхэд ямар ч гаж нөлөө өгөөгүй. Тиймээс би бусад эцэг эхчүүддээ хүүхдийнхээ вакциныг хийлгээрэй гээд зөвлөмөөр санаагдаж байна. Тэгэхээр бодит амьдрал, дээрээс гарч байгаа шийдвэр хоёр зөрүүтэй байна. Ковидтой холбоотой бүр тод жишээ энэ

байна. Хэрвээ энэ подкастыг сонсож байвал ийм бодитой зөрүү яваад байна, эпилепситэй хүмүүс дээрээ анхаараач ээ гэж хэлэх гэсэн юм. Өдөр болгон татдаг хүмүүсийг яг яа гээд байгаа юм бэ, гэртээ л бай гэж зөвлөөд байгаа юм уу? Энэ маш хүнд байна.

Ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх хууль эрх зүйн асуудал, бодит байдлын хэрэгжилт нэлээн ялгаатай санагддаг. Энэ хуулийн тал дээр таны бодол ямар байдаг вэ?

ХБХЭЭХ-ийг гол зорилго нь эцэг эхчүүдтэйгээ хууль эрх зүй, хүний эрхийн талаар мэдлэгтэй болгож чадавхжуулах байдаг. Энэ тогоонд чанагдсаныхаа хүчинд би чадахынхаа хэрээр эцэг эхчүүдэд зөвлөгөө өгье гээд явж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой хууль, зөвлөгөө зөвлөмж гараагүй биш гараад байгаа ч хэрэгжилтийн хувьд маш их асуудалтай байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль гэхэд яг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс л энэ хуулийг хэрэглэх учраас тэр хүмүүсийнхээ дуу хоолойг тусгаад хийвэл хөрсөн дээрээ буусан хуульд болно гэж боддог. Нэг үеэ бодвол төр засаг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний эцэг эхчүүд, асран хамгаалагчдыг нэлээд сонсож байгаа ч болохгүй байгаа зүйлүүдийн нэг нь хөдөлмөр эрхлэлтийн жишээ байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтэд зориулж төр маш олон тэрбум төгрөг гарсан гэж би сонссон. Гэтэл хөдөлмөр эрхэлье гээд явж байгаа хорин хэдэн настай залуучуудын хөдөлмөр эрхлэх боломжийг судалж үзэлгүйгээр хэдэн газар хуваарилсан.

Тэгэхээр оюуны бэрхшээлтэй хүн яаж хөдөлмөр эрхэлдэг юм бэ, унаж татдаг хүний ажлын байр ямар байх юм бэ гэдэгт төр зайлшгүй анхаарч, зарцуулж байгаа мөнгөө зөв хүнд, зөв газарт нь олгох шаардлагатай байгаа юм. Жишээлбэл, ХБХЭЭХ дээр нь уржнан жил саури гэдэг гар урлалын машин оруулж ирэхэд миний хүү хэдэн залуучуудтай тэр машин дээр ажилласан. Тэнд байхдаа би хүүгийнхээ хамгийн аз жаргалтай, хамгийн баяр баясгалантай нүдийг харж байсан. Дээрээс нь энгийн оюутан залуучуудыг хамруулаад тусгай хөтөлбөр явуулж байсан. Тэр хөтөлбөр дээр би хүүгийнхээ аз жаргалтай, баяр баясгалантай, оч гэрэлтсэн нүдийг олж харж байсан. Тэгэхээр бид юу хүсээд байна гэвэл миний хэрэгцээ биш, яг тэд нарын хэрэгцээг л хүсээд байна. Яг тэр “эпилепситэй хүн хэзээ, хаана хамгийн хамгийн аз жаргалтай байдаг юм бэ гэдэг мэдрэмжтэйгээр л энэ хөдөлмөр эрхлэлтийн хууль, зохицуулалтыг гаргаач ээ, тэд нарын дуу хоолойг сонсооч ээ” л гэж хэлмээр байна.

Цаг зав гарган өөрийнхөө үзэж харсан туршлага, мэдлэгийг бид нарт харамгүй хуваалцсан танд маш их баярлалаа.

Намайг подкастдаа урьж оролцуулсан танай хамт олонд ч гэсэн баярлалаа. Бидний дуу хоолойг хүргэсэнд баярлалаа.

СЭТГЭЛЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮССЭН ХҮН БОЛГОН НЬ АВАХ ХЭРЭГТЭЙ

Г.Болормаа



Энэхүү дугаарт Монголын харааны бэрхшээлтэй хүүхэд залуучуудын холбооны тэргүүн Болормаа оролцож байна. Та манай подкастын урилгыг хүлээн авч орохоор болсонд маш их баярлалаа.

Та юуны өмнө манай сонсогчдод өөрийгөө танилцуулахгүй юу?

Сайн байцгаана уу? Энэ нэвтрүүлгийг сонсож байгаа бүх хүнд энэ өдрийн мэндийг хүргэе!

Миний нэрийг Болормаа гэдэг. Миний үндсэн мэргэжил бол эдийн засагч, нягтлан бодогч. Гэвч сүүлд сэтгэл судлаач болж шинээр мэргэжил эзэмшээд одоо сэтгэл судлалын докторантурт сурч байна.

Монголын харааны бэрхшээлтэй хүүхэд залуучуудын холбооныхоо талаар манай сонсогчдод мэдээлэл өгөхгүй юу?

Хэсэг эцэг эхчүүд 2016 онд харааны бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан, тэдний хөгжлийг дэмжсэн төвтэй болмоор байна гэж ярилцаад, 2017 онд улсын бүртгэлийнхээ гэрчилгээг авч энэ байгууллагыг байгуулсан. Энэ байгууллага маань харааны бэрхшээлтэй хүүхэд залуучуудын эрхийг хамгаалах, боловсролыг нь дэмжих, амьдрах ур чадвар олгох, сургалт судалгааны ажил хийх, зөвлөгөө өгөх үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага юм. Ер нь хүүхэд залуучуудад бүгдэд нь амьдрах ухааны ур чадвар олгох ёстой. Бид

мэргэжлийн боловсрол олгохын зэрэгцээ хүн энэ хорвоод амьдрахдаа янз бүрийн ур чадвар эзэмшсэн байхад зөв, зохистой амьдарч чадна гэж үзээд түүнд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг. Амьдрах ухааны ур чадвар гэдэгт өөртөө итгэлтэй байх, харилцааны ур чадвар, шийдвэр гаргах гэх мэтчилэн амьдралд хэрэгцээтэй ур чадварыг л хэлээд байгаа юм.

Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо болон танай холбоо хоёрын хооронд ялгаа юу байгаа вэ?

Хараагүйчүүдийн холбоо анх социализмын үед хараагүй хүмүүсийн үйлдвэр, сургалтын төв гэгддэг 40-өөд жилийн түүхтэй нийгэмлэг байж байгаад, зах зээл хөгжсөнөөс хойш холбоо нэртэй болоод 20-иод жил үйл ажиллагаа явуулж байна. Бүх хараагүй иргэдийн эрхийг дэмжсэн, хөдөлмөр, үйл ажиллагаанд нь туслах зорилгоор байгуулагдсан төрийн бус байгууллага. Манайх бол 35 хүртэлх насны хүүхэд залуучуудаа хөгжүүлье гэсэн зорилготой. Хараагүйчүүдийн үндэсний холбоо хэдийгээр үйл ажиллагаа явуулж байгаа ч гэсэн зарим зүйлд олон талын үйл ажиллагаа явуулахад төдийлөн хүрэлцэхгүй байна. Ер нь бүх юм төгс төгөлдөр байх албагүй. Тэгээд эцэг эхчүүд нийлээд бүгдээрээ ийм байгууллага байгуулъя гэж ярьсан. Зорилго бол яг адилхан.

Монголын өнөөгийн нөхцөлд харааны бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад тулгамдсан хамгийн чухал асуудлууд юу байгаа вэ?

Хамгийн чухал асуудал бол боловсрол. Хүүхдүүддээ багаас нь яаж боловсрол эзэмшүүлэх вэ л гэдэг асуудал байна. Гэтэл манай улсад өнөөдөр харааны бэрхшээлтэй хүүхэд сурч боловсрох асуудал ямар байгаа билээ. Улсын хэмжээний 186-р цэцэрлэгт харааны бэрхшээлтэй хүүхэд суралцах ганцхан анги байдаг нь 15 хүүхэдтэй. Жил бүхэн тэр цэцэрлэгийг мэддэг эцэг эхчүүд хүүхдүүдээ өгдөг, мэддэггүй нь гэртээ хүүхдүүдээ байлгаж боловсролын тал дээр хоцрогдох асуудал гардаг. Харааны бэрхшээлтэй 2-5 насны хүүхдүүд өнөөдөр энгийн цэцэрлэгүүдэд суралцах ямар ч боломжгүй байна. Хоёрдугаарт, харааны бэрхшээлтэй хүүхдүүдэд 116-р сургууль гээд ерөнхий боловсролын ганцхан сургууль байна. Гэтэл энэ сургуулиа мэддэг ч хүмүүс байна, мэддэггүй ч хүмүүс байна. Эцэг эхчүүд нь хүүхдүүдээ харааны бэрхшээлтэй учраас сурах, хөдөлмөр эрхлэх боломжгүй гэсэн ойлголттой байгаа нь одоохондоо нийгмийн хэрэгцээ хангах төвшинд хөгжөөгүй байна. Гэхдээ энэ байдал өдрөөс өдөрт сайжирч, улс орон маань хөгжиж байгаа гэж бодож байгаа. Улсын хэмжээнд 116-р сургуульд 120-иодхон хүүхэд сурч байгаа. Гэтэл Монгол улсад 7,000 гаруй харааны бэрхшээлтэй хүүхэд байдаг. Цэцэрлэгтэй нийлээд 135 хүүхэд сурч байна гэхэд бусад нь яаж хөгжих юм бэ гэдэг үүднээсээ манай холбоо эдгээр хүүхдүүдийг нэгийг 1 гэхгүй, тавыг 5 гэхгүй хөгжүүлэх боломжтой гэж үзсэн юм. Түүнээс биш бид 100 зуугаар нь одоохондоо хөгжүүлж чадахгүй л дээ.

Та бүхэн боловсролын үйлчилгээ олгож байна уу эсвэл сургуульд ороход нь тусалж байна уу? Яг ямар үйлчилгээ явуулж байна вэ?

Бид нар өнөөдөр аль алийг нь л хийж байна. Жишээлбэл би сэтгэл судлаач учраас ялангуяа зорилтот бүлэгт төрийн ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх ажил хийдэг юм. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээний магадлан итгэмжлэлийг манай төрийн бус байгууллага аваад 2 жил болж байна. Зорилтот бүлгийн иргэдэд төрийн өмнөөс сэтгэл зүйн зөвлөгөө өгөх ажил хийх явцдаа бид Налайх эсвэл бусад дүүргүүдэд энэ тухай мэдэхгүй, мэдээлэлгүй хүмүүсийг олж, ийм байгууллага байдаг, хүүхдүүд чинь суралцах хэрэгтэй гэдэг мэдээлэл өгдөг. Нэгдүгээрт энэ хүүхдүүд ирээдүйн Монгол улсын иргэд. Хоёрдугаарт аав ээж нь мөнх биш, энэ хорвоогийн мөнх бусыг үзээд явна. Тэр үед эдгээр хүүхэд залуучууд хаачих вэ гэвэл амьдрах ёстой. Сайхан амьдрах, бие даах ёстой гэдгийг одооноос эцэг эхчүүдийнх нь оюун санаанд суулгаж өгөх ёстой гэж боддог.

Та мэргэжлийн сэтгэл зүйч хүн. Өмнө нь эдийн засагч байж байгаад яагаад сэтгэл зүйн салбар руу орох болсон бэ?

Амьдралын эрхээр гэж хэлэхэд болох байх. Би Санхүү эдийн засгийн сургуулийг эдийн засагч, нягтлан бодогч мэргэжлээр 1994 онд төгсөөд, төрийн тусгай албанд 18 жил ажилласан. Тэгээд 2010 оноос харааны бэрхшээлтэй болсон. Харааны бэрхшээлтэй болоод өөрийгөө үнэхээр юу ч хийж чадахгүй юм байна гэсэн бодолтой гэртээ 3-4 жилийг өнгөрөөсөн. Тэр үед маш хэцүү байсан. Тэрийг даваад “би гарах ёстой, юм хийх ёстой, нийгэм рүүгээ буцаад орох ёстой юм байна” гэж бодсон. Гэртээ байх үедээ юу мэдэрсэн гэвэл нийгэм рүү орохгүй, ард түмэн дотроо байхгүй байхад хүн өөрийгөө алдаж эхэлдэг юм байна. Хэдийгээр миний хажууд сайхан хань, үр хүүхдүүд, зээ гээд миний гэр бүл, маш сайн найз нөхөд байгаад, дээр нь санхүүгийн хувьд бүх асуудлаа шийдчихсэн байсан ч надад дутаад байсан юм бол би өөрийгөө гээж, би хэн ч биш болж эхэлсэн. Өдөр өнгөрөөх маш хэцүү байсан. Тэгээд “буцаад нийгэм рүүгээ орж ямар нэгэн ажил олж хийх ёстой юм байна” гэж бодож байтал зурагтаар сэтгэл судлаачийн оройн анги элсэлт авна гэсэн зар гарсны дагуу эчнээ ангид ороод энэ шинжлэх ухаанд дурласан. Харааны бэрхшээлтэй хүн оператор, сэтгэл судлаач, синхроны орчуулагч гээд янз бүрийн ажил хийх бүрэн боломжтой гэдгийг дэлхий нийт нотолчихсон болохоор би өнөөдөр маш их баяртай байгаа.

Танд сэтгэл судлаачаар ажиллаж байхад давуу эсвэл бэрхшээлтэй талд ямар ямар асуудлууд үүсдэг вэ?

Харааны бэрхшээлтэй хүн оператор, сэтгэл судлаач, синхроны орчуулагч зэрэг мэргэжил эзэмшихэд маш зохистой, эдгээр ажлыг хийх бүрэн боломжтой гэдгийг нотолчихсон гээд өмнө нь яриандаа

хэлж байсан. Энэ ямар учиртай вэ гэвэл харааны бэрхшээлтэй хүн үйлчлүүлэгчээ харж чадахгүй. Сэтгэл судлалын зөвлөгч хүн тухайн үед үйлчлүүлэгчийн биеийн хэлэмжийг хар гэж уг нь зөвлөдөг. Гэхдээ харж чадахгүй байлаа гээд сэтгэл судлаачийн анхаарал хэзээ ч сарнидаггүй. Сарнихгүй байна гэдэг нь эмэгтэй ч бай, эрэгтэй ч бай, гоо үзэсгэлэнтэй эсвэл ямар гадаад төрхтэйг нь тэр хүн харахгүй болохоор мэдэхгүй. Үйлчлүүлэгчийн маань яг юун дээр асуудал үүсээд байна, ямар гарц гаргалгаа байх вэ, ямар байдлаар тэр хүний байгаа байдлыг мэдрэх вэ гэдгийг олж тогтоох ёстой болохоор харааны бэрхшээлтэй сэтгэл судлаачийн мэдрэмж нь тархин дотроо эргэлдэж байдаг. Тухайн хүнтэйгээ адилхан тэр мэдрэмжийг мэдэрдэг, логик сэтгэлгээ сайтай болохоор зөвлөгөө өгөх явцдаа зөв гарцыг гаргаж ирэх боломжтой гэж үздэг. Нөгөө талаар харааны бэрхшээлтэй синхроны орчуулагч нарыг олон нийтийн ялангуяа нууцлал өндөртэй олон улсын орчуулганд гэрээгээр авч явдаг. Яагаад гэвэл үйлчлүүлэгчийнхээ царай зүсийг харахгүй учраас хэзээ ч, ямар ч тохиолдолд тэр хүний тухай мэдээлэл алдагдахгүй, эргээд янз бүрийн асуудлыг үүсгэхгүй. Тиймээс харааны бэрхшээлтэй хүмүүсийг тусгайлан бэлтгэж, дэлхий даяараа нууцлалын зэрэглэлтэй зарим нэгэн ажилд авч явдаг туршлага байдаг. Харааны бэрхшээлтэй хүний сул тал бол тухайн үйлчлүүлэгч намайг яаж хүлээж авах вэ гэсэн хаалт тавих гээд байдаг нь хэцүү байдаг. Би ч гэсэн үйлчлүүлэгч ороод ирэхэд "намайг яаж хүлээж авах бол, миний харааны бэрхшээлтэй гэдгийг мэдэх вий" гэсэн айдастай, өөртөө хаалт тавиад байдаг. Тийм болохоор би бүх хүмүүсийг авдаггүй. Тухайн хүнийг ямар хүн бэ гэдгийг тэр хүний анкетыг нэлээд судалж, эхний ганц хоёрхон асуулт асууж байж зөвлөгөө өгөх эсэхээ шийднэ. Хэрвээ тэр хүнийг авах боломжгүй хаалт үүсэх мэдрэмж төрвөл би бусад сэтгэл судлаач нартаа санал болгодог. Утсаар ярьж байхдаа л яг хэн бэ гэдэг нь ерөнхийдөө хүний ярианаас мэдрэгддэг. "Энэ харааны бэрхшээлтэй хүнээс зөвлөгөө аваад байхдаа яадаг юм" гэсэн хандлага тэр хүнд байвал надад шууд мэдрэгддэг. Тийм болохоор би бусад сэтгэл судлаач нартаа санал болгодог. Яагаад гэвэл тэр хүн орж ирээд л намайг харааны бэрхшээлтэй учраас намайг өөрөөсөө доогуур гэж үнэлнэ гээд би өөртөө хаалт тавьчихдаг.

Та яаж энэ холбооныхоо үйл ажиллагаанд оролцоод бүр цаашлаад холбооныхоо тэргүүн болж ажилласан бэ?

Сэтгэл судлалын зөвлөгөөг би харааны бэрхшээлтэй хүмүүстээ эхэлж өгдөг байсан. Би 2016 онд сургууль төгсөөд хэд хэдэн ээж нарт зөвлөгөө өгсөн. Мэдээж харааны бэрхшээлтэй хүн сэтгэл судлаараа зөвлөгөө өгөхөд хэн надад хандах вэ гэвэл миний эргэн тойронд байгаа, надтай ижил төстэй хүмүүс хандана. Нэгдүгээрт, надад туршлага байхгүй байсан. Хоёрдугаарт, зөвлөгөө өгөх явцдаа эргэн тойронд байгаа хүмүүстээ зөвлөгөө өгөөд эхлэхэд харааны бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг

эхчүүд ямар их сэтгэл зүйн асуудалтай байдаг юм гэдгийг олж харсан. Тэдэнтэй ярилцаж, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх явцад ийм эрэлт хэрэгцээ байна гээд тэр хүмүүс “холбоо байгуулъя, та нэг хэсэгтээ удирдлагаар хангаад өгөөч” гэсэн санал тавьсан. Тэгээд би одоохондоо удирдлагаар хангаж ажиллаж байгаа юм.

Та харааны бэрхшээлтэй хүүхэд залуучуудад зөвлөгөө өгч байхад тэдэнд сэтгэл зүйн хувьд ямар асуудлууд үүсээд байсан бэ?

Харааны бэрхшээлийг дэлхий дахинд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээл гэж үздэг. Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлийг дотор нь хүнд, хөнгөн гэж ангилдаг. Хүнд



хэлбэрийн бэрхшээл дундаа харааны бэрхшээл нэг номерт ордог. Жишээлбэл тулах эрхтний бэрхшээлтэй эсвэл бусад бэрхшээлтэй хүмүүс та нар хөлөөрөө явдаг, амаараа ярьдаг учраас харааны бэрхшээлийг төдийлөн хүнд бэрхшээл биш гэж хардаг. Үнэндээ яагаад хүнд хэлбэр гээд байна гэвэл хүн хараа буюу нүд гэдэг эрхтнээрээ дамжуулаад танин мэдэхүйнхээ 80%-ийг авч байдаг. Хараагүй болно гэдэг нь танин мэдэхүйн 100% гэж үзвэл хараагаараа авах ёстой 80%-ийг бүгдийг нь алдчихаж байгаа юм. Өөрөөр хэлбэл танин мэдэх процесс нь харахгүй болохоор явахгүй болчихно. Хүн энэ хорвоо дээр амьтнаас юугаараа ялгаатай билээ? Зөвхөн оюун ухаан, сэрж мэдэрдгээрээ ялгаатай. Гэтэл тэр сэрж мэдэрдэг танин мэдэх процесс нь байхгүй болчихлоор тэр хүнд ямар хэцүү байх вэ? Дээр нь оюун ухаан эрүүл саруул байна. Бид нар хорвоо ертөнцийн өнгө будгийг харж баясаж, хорвоо ертөнцийн сайхан муухайг харж инээж, уйлмаар байна гэтэл тэр нь харагдахгүй байна гэдэг үнэхээр хэцүү. Та бүхэн ч гэсэн нүдээ боогоод туршаад үзвэл энэ хүмүүсийн бэрхшээлийг яагаад хүнд гээд байдгийг ойлгох байх. Тийм учраас харааны бэрхшээлтэй хүмүүс сэтгэл зүйн хувьд оюун ухаан нь эрүүл, сэрж мэдрэх процесс нь маш сайн болохоор гуниглах, түгших, айх гэх мэтчилэн сэтгэл зүйн янз бүрийн үзэгдлүүдэд хариу урвал өгөхдөө маш хэцүү байдаг. Тиймээс харааны бэрхшээлтэй хүмүүсийг хөгжлийн хүнд хэлбэрийн бэрхшээлтэй гэж үзээд байгаа юм. Зарим хүмүүс зөвхөн харах эсвэл хөлөөрөө явахгүй байх гэдэг, үнэндээ бүх бэрхшээл хэцүү. Нэг хурууны хумс хугарахад хүртэл ямар хэцүү байдаг билээ. Тэгэхээр миний ард түмэн бүгдээрээ эрүүл байх ёстой.

Монголын нөхцөл байдлыг харахаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сэтгэл зүйн асуудал нэлээн мартагдсан эсвэл авч хэлэлцэгдэхгүй байгаа юм шиг санагддаг. Энэ тал дээр таны бодол ямар байдаг вэ?

Хөгжлийн бэрхшээлийн төрөлхийн, олдмол гэсэн хоёр үндсэн ангилал байдаг. Төрөлхийн бэрхшээл нь төрөхдөө л хөгжлийн бэрхшээлтэй гарах, олдмол нь осол, амьдралын байдал, эрүүл мэнд гэх мэтчилэн янз бүрийн зүйлээс болоод хөгжлийн бэрхшээлтэй болж байна. Гэтэл олдмол хөгжлийн бэрхшээлтэй болоод сэтгэл зүйн хувьд бэрхшээлээ даван гарах ямар хэцүү вэ гэдгийг л манайхан их анхаарах хэрэгтэй санагддаг. Гэтэл эдгээр хүмүүсийг сэргээн засна гэхээр янз бүрийн массаж хийж эсвэл булчинг нь суллаад эсвэл эмийг нь өгөөд эсвэл нөхөн сэргээхэд явуулаад эдгээгээд авна гэж боддог, гэтэл үгүй. Цаана нь хамгийн чухал зүйл бол сэтгүүл зүй байдаг. Сэтгэл зүй буюу тэр өдрийг яаж өнгөрөөх вэ, тэр тархинд байгаа бодол ямар байгаа вэ, өглөөнөөс орой хүртэл хугацааг өнгөрөөхдөө тэр хүн зөвхөн бэрхшээлээ бодоод байх уу, өдөржингөө гэрээсээ гарахгүй, хэвтэрт байх ямар байх вэ гэдэг нь өөрөө маш хүнд асуудал байдаг. Тэгэхээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг

нөхөн сэргээх үйл ажиллагаа нь дандаа сэтгэл зүйтэй цуг байх ёстой. Манайд зөвхөн булчин, бие эрхтэн физиологийнх нь хувьд нөхөн сэргээх асуудлыг шийдээд, сэтгэл зүйг нь нөхөн сэргээх асуудал руу орж чадахгүй байгаа нь харамсалтай. Гэхдээ өдрөөс өдөрт аятайхан болох байх гэж бодож байгаа. Энэ бүгдийг өөрөө бие сэтгэлээрээ туулж яваа хүний хувьд энэ мэргэжлийг эзэмших нь маш хэрэгтэй, олон хүний хэрэгцээг хангах боломжтой гээд энэ ажлыг хийгээд явж байна.

Яг тань шиг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хандсан сэтгэл зүйч нар Монголд хэр их байдаг вэ?

Би бакалавраа хамгаалаад, магистраа хамгаалаад одоо Монгол Улсын Их Сургуульд докторантурт сурч байна. Би 2014 оноос хойш өнөөдөр хүртэл 7 жилийн хугацаанд олон сэтгэл судлаач, олон мэргэжлийн хүмүүсийн дунд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах бодлого, хууль, дүрэм журамд өөрчлөлт оруулах ажлын хэсэгт нь ороод явж байна. Ингээд явж байхад үнэхээр хөгжлийн бэрхшээлтэй хүнд сэтгэл зүйн зөвлөгөө өгдөг мэргэжил эзэмшсэн ганц хоёр хүн байдаг ч, төрөөс цалинжуулаад, энэ ажлыг хийгээрэй гэсэн сэтгэл зүйч одоохондоо ховор байгаа. Тийм болохоор олон нийтийн оролцоо гэдэг утгаараа төрийн бусаараа гэрээлээд нэлээн хүнд ажил одоохондоо хийж байгаа. Үнэлгээний хувьд бид нарыг хэтэрхий багаар үнэлдэг. Жишээ нь би нэг удаа зөвлөгөө өгөхөд төр миний зөвлөгөөг 10,000 төгрөгөөр үнэлдэг. Гэтэл гадуур эрүүл хүмүүст үйлчилж байгаа төвүүдэд докторант хүн дор хаяж 50,000-иас дээш төгрөгөөр үнэлж зөвлөгөө өгдөг. Гэтэл би өнөөдөр хэдий докторант ч гэсэн зорилтот бүлгийн сэтгэл зүй маш хүнд хүмүүст зөвлөгөө өгөх ажлыг хийхийн төлөө явдаг. Гэхдээ үнэлгээний 10,000 төгрөг төдийлөн надад сонин биш. Надад маш их туршлага сууж байна. Дээр нь би сэтгэл зүйн шинжлэх ухааныг судалж байгаа хүний хувьд бэлэн кэйсүүд дээр ажилладаг нь надад сайхан байдаг. Гэтэл нөгөө талаараа яг энэ үнэлгээгээр сэтгэл судлаач нар ажиллах уу гэвэл ажиллахгүй. Тэгэхээр л хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорилтот бүлэг рүү сэтгэл судлаач нар орж ажиллахгүй байна. Сэтгэл судлаач мэргэжил бол дэлхий дээр маш өндөр үнэлгээтэй байдаг. Үнэлгээний хувьд өндөр байж болно, гэхдээ маш их эрсдэл өндөртэй мэргэжил гэж үздэг. Сэтгэл судлаачийг сэтгэл зүйн асуудалтай хүмүүс маш их эрсдэл оруулах боломжтой, амь насаа ч алдах боломжтой маш хүнд ажил гэдэг. Манайхан болохоор нэг хүний асуудлыг яриад л, сонсоод л байдаг гэж сэтгэл судлаачдын ажлыг хараад байдаг. Гэтэл үгүй, тэнд бүх шинжлэх ухаан явж байдаг. Тэгэхээр бүгд энэ тухай ойлголттой, энэ шинжлэх ухааны тухай мэдлэгтэй болвол бүгдээрээ нэгнийгээ ойлгодог болно. Өнөөдөр сургуулийн сэтгэл судлаач гээд 50, 60 сэтгэл судлаач бэлдлээ л гэнэ. Үнэндээ нийгмийн ажилтан, сэтгэл судлаач гэж хоёр мэргэжил байдаг. Нийгмийн ажилтан бол зөвхөн нийгмийн асуудлыг шийддэг бол сэтгэл судлаач бол сэтгэл, оюун бодол, бүх харилцааны

асуудлыг шийднэ. Тэгэхээр энийг хоёрыг зааглах хэрэгтэй. Хоёрдугаарт, сэтгэл судлалын шинжлэх ухаан Монголд үүсээд 30-аадхан жил болж байна. Эхний 20-иод жил төдийлөн эрчимтэй хөгжөөгүй бол сүүлийн 10 жил нэлээн эрчимтэй хөгжлөө. Хүний амьдралд зөөлөн чадвар, оюун ухааны чадварыг хөгжүүлэх ёстой гэдгийг төр засаг маань ч, гэр бүлийн хүмүүс ч мэдээд эхэлж байгаа учраас олон хүн энэ шинжлэх ухаанд дурлаж, энэ мэргэжлийг эзэмшихээр суралцаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд дундаас танд өөрөө хандаад, өнөөгийн сэтгэл судлалын тарифыг нь өгөөд сэтгэл зүйн зөвлөгөө авъя гэсэн хүмүүс хэр их байдаг вэ?

Байхгүй байгаа. Сэтгэл судлаачидтай ярилцмаар байна гэсэн шийдвэр гаргаад, надад ийм асуудал тулгарч байна гээд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс харилцаа тогтоосон тохиолдолд би дандаа үнэгүй зөвлөгөө өгдөг. Зорилтот бүлэг буюу олон нийтийн оролцоотой төрийн байгууллагад гэрээлээд ажиллаж байгаагийн хувьд заримдаа зөвлөгөө авах тухайгаа мэдэхгүй ч ярьж байгаа хүмүүс байдаг. Халамжийн ажилчид нь зөвлөгөө өгөхдөө энэ тухай бас хэлээгүй бол сайн мэдэхгүй. Хүмүүс зөвлөгөө авна гэхээр яг юу авах ёстой юм бол, юу хийх ёстой юм бол гээд төдийлөн мэдэхгүй хүмүүсч бас байдаг. Надад цөөхөн чанартай хэдхэн үйлчлүүлэгч байдаг. Тэд нар маань удаан хугацаагаар зөвлөгөө авч явдаг. Би зөвлөгөө өгөөд 4 жил явахад цөөхөн хэдэн үйлчлүүлэгчид маань надаас холдоогүй буцаад л ярьдаг. Хүний амьдралд янз бүрийн юм тохиолдоно. Зарим нь том болно, зарим нь хүнтэй сууна, зарим нь хоёрдогч амьдрал эхэлнэ гэсэн амьдралын янз бүрийн сэтгэл зүйн үеүд байдаг. Тэр үе бүхэнд хүний амьдралд янз бүрийн асуудал гарч байдаг. Тэгэхээрээ л ярьдаг хэдхэн үйлчлүүлэгч байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд шууд танд хандаж, сэтгэл зүйн зөвлөгөө авч чадахгүй байгаа нь тухайн хүний санхүүгийн боломжгүй байдлаас болж байна уу?

Энд янз бүрийн л шалтаг, шалтгаан байгаа байх. Зарим нь санхүүгээсээ болж байгаа байх. Өнөөдөр 168,000 төгрөгөөр юун сэтгэл зүйн зөвлөгөө авах, сарын хоолондоо хүрэхгүй шүү дээ. Халамжид байдаг төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сард 168,000 төгрөг авч байхад төрийн тусгай албанд 16 жил ажилласан мөртлөө би 350,000 мянган төгрөгийн тэтгэвэр авч байна. Бодит байдал нэг талаас үнэхээр ийм байгаа. Нөгөө талаасаа одоо л ойлгоод байгаа болохоос манай иргэдийн сэтгэл зүйн тухай ойлголт дутуу байна. Тиймээс сэтгэл судлаачид хандахын оронд лам бөө, ах дүү, хамаатан садан, найз нөхөдтэйгөө сэтгэл зүйн асуудлаа хуваалцахыг хичээдэг. Гэтэл тэд нар нь хэзээ ч хувь хүний сэтгэл зүйн асуудлыг хөндөж ярихгүй. Таны найз сайн найз байж болно, гэхдээ яг мэргэжлийн бидэн шиг ярьж, зөвлөж чадах уу? Таны аав ээж мундаг байж болно, гэхдээ яг

сэтгэл судлаач шиг зөвлөж чадах уу? Үгүй, өөрийнхөө байр суурь, үзэл бодлоор л ханддаг. Таны хамаатан садан мундаг байгаад та хувийнхаа амьдралыг ярина. Өнөөдөр хэлдэггүй юм гэхэд 5, 10 жилийн дараа буцаад та өөрөө эвгүй байдалд орох зүйл болохыг үгүйсгэхгүй. Тийм болохоор тантай ямар ч хамаагүй, таныг ямар ч байдлаар шүүхгүй, шүүмжилж эсвэл магтахгүй хөндлөнгийн мэргэжлийн хүмүүст хандвал та сэтгэл зүйн асуудлаа ямар ч асуудалгүй шийдүүлээд, сэтгэцийн ямар нэгэн стресст орсон л бол тэрнээсээ салаад, эрүүл сэтгэл зүйгээр амьдрах боломжтой.

Эрүүл сэтгэл зүйтэй байх үед хүний бие эрүүл байдаг юм. Тэгэхээр энэ ойлголт, мэдлэг нь маш чухал байдаг. Сэтгэл судлалын шинжлэх ухаан гэж юу байдаг юм бол, юуг судалдаг юм бол, сэтгэл судлаач нар юун тухай зөвлөгөө өгдөг вэ гэдгийг ойлгож мэдэх хэрэгтэй. Хүн бүхэн адилгүй гэдэг шиг бүх сэтгэл судлаач нар төгс төгөлдөр байхгүй. Зарим нь практик, оюун дутсан байж болно, зарим нь үнэхээр мэдлэгтэй байж болно. Тэгэхээр нэг хүн дээр очоод таны урам хугарсан бол дараа сайн судалж байгаад зөв сонголтоо хийвэл таны хувьд маш хэрэгтэй зүйл гэж боддог. Ялангуяа цахим хэрэглээ ийм төгс төгөлдөр болсон үед хэнийг ч хайгаад, зөв хүнээ олоод өөрийнхөө асуудлыг шийдүүлбэл маш хэрэгтэй гэж боддог. Шинжлэх ухаанд миний гаднаас харагдаж байгаа өнцөг, доторх оюун ухаан хоёр



шал өөр явж байгаа гэдгийг хүмүүс ойлгохгүй, гадаад үзэмжийг нь хараад л шийдчихээд байдаг гэж үздэг. Ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хандахдаа таны хараад байгаа бэрхшээлтэй хүний бие, эрхтний согог эсвэл харагдаж байгаа нүүрний согог танд төдийлөн хамаатай зүйл биш, цаана нь хэн ч байж болно гэдгийг л би энэ сонсож байгаа хүмүүс мэдээсэй гэж боддог.

Нийгэмд сэтгэл судлаач дээр очоод зөвлөгөө авах гэхэд эргэн тойрны хүмүүс нь чи яачихсан юм бэ? гэсэн огт очиж болохгүй газар очих гэвд байгаа юм шиг сөрөг хандлага байдаг. Энэ хандлагыг хөгжлийн бэрхшээлтэй иргэд юу гэж хардаг вэ?

Адилхан хүн юм чинь "намайг очихоор харааны бэрхшээлтэйн дээр ёо ёотой болчихсон юм байна гэж бодох вий" гэж боддог. Гэтэл сэтгэл судлалын шинжлэх ухаан нь өөрөө ганцхан бид нарын яриад байгаа ёо ёотой юм гэнэ лээ, тиймэрхүү болсон юм гэнэ лээ, гутралд орчихсон юм гэнэ лээ, гэдэг бол биш. Энэ шинжлэх ухаан өөрөө бүхэл бүтэн таны ой тогтоолт яаж явагддаг, зан төлөв яаж үүсдэг, тантай цуг төрчихсөн темперамент гэж хэнийг хэлээд байгаа, ярилцлага, үйл ажиллагаа яаж тархитай холбогдоод байдаг, шийдвэр гаргах зоригийн чанарууд, сэтгэл хөдлөл зэргийг судалдаг. Гэтэл хүмүүс зөвхөн сэтгэл хөдлөлийн тухай яриад, сэтгэл хөдлөлийн сөрөг байдлыг л засаад залруулчих л юм бодоод байдаг. Гэтэл үгүй. Сэтгэл судлалын шинжлэх ухаанд олон салбар байдгийн ганц нь л сэтгэл хөдлөл байдаг. Гэтэл нэг талаасаа таны анхаарал яагаад сарниад байна вэ, та яагаад анхаарч чадахгүй байна вэ, таны сэтгэл яагаад түгшээд байна вэ, та яагаад шийдвэр гаргаж чадахгүй байна вэ, та яагаад өөртөө итгэлгүй байгаад байгаа юм, та яагаад харддаг болчихсон юм бэ, та яагаад архинд донтоод байгаа юм бэ? Нөгөө талаасаа та спортын яг тэр хэсэгт 3 секундийг зөв барьж чадаагүйгээс аваргын алтан медалиа алдчихсан байдаг. Тэр үед сэтгэл хөдлөл явж байдаг.

Сэтгэл судлалын шинжлэх ухаан өөрөө 55-56 салбартай, өнөөдөр бид нарын оршин байгаа бүхий газар энэ шинжлэх ухааны салбар явж байна. Жишээлбэл, та бид хоёр ярьлаа харилцааны сэтгэл зүй, ажил дээрээ очлоо байгууллагын сэтгэл зүй, шүүхэд очлоо шүүхийн сэтгэл зүй, спорт дээр спортын сэтгэл зүй, хүүхдүүд дээр очлоо хүүхдийн сэтгэл зүй, сурган хүмүүжүүлэх боловсролд сурган хүмүүжүүлэх сэтгэл зүй, эмнэлэгт очлоо клиник сэтгэл зүй, янз бүрийн өвчин эмгэг туслаа эмгэг сэтгэл зүй, шашны асуудлыг яриад эхэлбэл шашны сэтгэл зүй, хамт олон дотроо ажиллаж байгаа бол хөдөлмөрийн сэтгэл зүй гээд явдаг. Энэ хүн гэдэг бодгал хаана оршин тогтноно тэр бүхэнд сэтгэл зүй байж байдаг юм. Бид нар нийгэм рүү ороод нийгмийн сэтгэл зүйтэй тулгарч байна л ойлгох ёстой. Тэгэхээр зөвхөн сэтгэл хөдлөлийн сөрөг байдлыг бид нар гаргаад байгаа юм биш. Гэр бүлийн сэтгэл зүй гээд ямар чухал хэсэг байна тэ? Гэр бүлтэй болоход яах ёстой юм, амьдралд гуньж гутраад 3-4 жилийн дараа

насныхаа онцлог, өөр өөр байдлаасаа болоод хүмүүс яагаад хоорондоо маргаад эхэлдэг юм, яагаад хөгшрөхөөрөө хүний сэтгэл зүй өөрчлөгдөөд үглээ яншаа болдог юм, зарим нь яагаад ой тогтоолт нь муутай болдог юм гэх мэтчилэн энэ бүгдээрээ хамаардаг. Тэгэхээр эрхэм таны анхаарал сулраад, ажилдаа идэвхгүй болоод, ажил дээрээ очихоор уур чинь хүрээд л эхэлбэл та ажлаасаа халшрах эмгэг туссан эсвэл магадгүй гэр бүл дотроо асуудалтай байна. Одоо бүр ургаас эхэлж сэтгэл зүйг нь судалж байна. Ургийн тархи ямар хөгжилтэй байгаагаас шалтгаалаад насан туршдаа хэн болох вэ гэдэг нь гарч байгаа гэсэн үг.

Танд хандаж байгаа харааны бэрхшээлтэй эсвэл бусад төрлийн бэрхшээлтэй иргэд ямар төрлийн асуудал дээр илүү зөвлөгөө авдаг вэ?

Нэгдүгээрт, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрөө бэрхшээлтэй учраас нийгэм рүү гарч чадахгүй, нийгэмшихгүй байна. Эсвэл нийгмийн хандлага сөрөг байвал маш хэцүүгээс гадна дэд бүтэц хөгжөөгүй манай улсад гадаа гараад дураараа яваад, гудамжаар алхаад, автобусанд суугаад нэг газар очоод үйлчилгээ авна гэхээр төдийлөн болохгүй байна гэх зэрэг гэрээсээ гарах болгонд сэтгэл зүйн янз бүрийн асуудлууд тулгарч байдаг. Автобусны буудал дээр эргэн тойронд байгаа хүмүүсээсээ энэ ямар автобус вэ гэж асуухад л сонирхолтой нь хүмүүс дуугардаггүй. Хүн зогсож байхад дуугарахгүй байна гэдэг бол манай нийгмийн сэтгэл зүй их хэцүү болсон байна гэж л харагдаад байгаа. Тэгэхээр бүгдээрээ ганц хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн биш бүх хүмүүсийн сэтгэл зүй рүү хандах ёстой. Сая ковид цар тахал болоход хүмүүсийн сэтгэл зүй ямар байгаа нь харагдаж байсан. Ямар их хувиа хичээсэн, аминч болсон байна.

Нөгөө Монгол хүний тэнүүн уужуу, тал шигээ ухаантай зан хаачсан юм бэ? Сая бензин дууслаа гэхэд л, 100 лирт бензинтэйгээ тэгээд яах гээд байгаа юм? Энэ хэрэгцээ шүү дээ. Ийм аминчхан хэрэгцээгээ хангахын тулд шөнөжин цагаа барж 100 литр бензин авч байсан. Тэгээд та яах гээд байгаа юм? Тэр бензин 3 өдөр яваад л дуусна. Дараагийн өдрөөс эхлээд та бусадтай адилхан бензингүй сууна. Тэгэхэд л тэр хооронд бүгдээрээ хошуураад, нийгмийн сэтгэл зүй тогтворгүй байгаа нь харагдаж байсан. Мөн цахимаар явж байгаа янз бүрийн буруу, сөрөг мэдээллийг шүүн тунгааж, мэдээллээс яг алийг нь тархиндаа авч өөрийн хэрэгцээгээ хангах вэ гэдэг маш чухал чадвар байдаг. Хэрвээ манайхан энэ чадварыг сайн эзэмшвэл энэ олон мэдээлэл дундаас зөв мэдээллээ сонгож чаддаг болно. Гэтэл тийм чадваргүйгээс янз бүрийн сөрөг мэдээллүүд нийгмийн сэтгэл зүйг давлагаалуулаад хямруулчихдаг. Жишээлбэл ковид гэдэг өвчнөөс илүү энэ сэтгэл зүйгээр хамаг аюулыг үүсгэж байна. Бүгдээрээ би өвчин тусчих вий, янз бүрийн бараа дуусчих вий, бараа үнэд орох вий гэсэн энэ олон айдсаас болоод гэртээ тогтвор суурьшилтай байж

чадахгүй, гэрийнхэндээ эсвэл хажуудаа байгаа хүндээ уураа гаргана. Бүгдээрээ энэ айдсаасаа салъя гэсэн ч сэтгэл зүйн асуудлаа шийдэж чадахгүй учраас архинд донтох зэргээр айдсаа дарахын тулд буруу зүйл хэрэглэж хорт зуршил руу ордог. Тэгээд архидсан хүмүүс хүчирхийлэл, гэмт хэрэг үйлдэн маш жижигхэн асуудлаас маш том аюул үүсэх боломжтой байдаг. Тэгэхээр буруу, сөрөг мэдээлэл цар тахлаас илүү аюултай гэдэг нь ингэж гарч ирээд байгаа юм.

Гэтэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрүүл хүмүүстэй харьцуулахад нэг талаараа ямар орчинд, ямар бэрхшээлтэй, хэн байгаагаасаа шалтгаалаад зарим нь энэ тухай бүр мэдэхгүй хүмүүс ч явж байгаа. Жишээлбэл, оюуны ухааны хүнд хэлбэрийн бэрхшээлтэй хүмүүс бол сэтгэл зүй гэдгийг мэдэхгүй, эрүүл хүн шиг шийдвэр гаргаж чадахгүй. Юугаа ч мэдэхгүй хүнд хэлбэрийн саажилттай байлаа гэж бодоход тэр хүмүүс хооллох хэрэгцээгээ л хангана, зөвхөн гар хөл нь хөдөлнө гэх зэргээр ямар бэрхшээлтэй байгаагаасаа шалтгаалаад сэтгэл зүйгээ таних асуудал өөр өөр байдаг. Тэгэхээр хөгжлийн бэрхшээлтэй ч бай, бэрхшээлгүй ч бай бүх хүмүүс өөрийнхөө сэтгэл зүйг таних хэрэгтэй гэж санагддаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн сэтгэл зүй нэлээн хүнд байдаг гэж та яриандаа дурдаж байсан. Бид хөгжлийн бэрхшээлтэй хүнийг л бодоод эцэг эх, гэр бүлийг нь хаяад байдаг. Тэр хүмүүст сэтгэл зүйн ямар асуудал байдаг вэ?

Маш зөв. Миний сэтгэл судлалын мэргэжлийг сонгох болсон шалтгаан бол асран халамжилсан сэтгэл зүй гэж би ойлгоод байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тухай л яриад байгаа болохоос эргэн тойронд нь байгаа хүмүүс ямар их сэтгэл зүйн асуудалд орж, ямар хэцүү байдаг юм бэ? гэдгийг би мэдэрсэн. Жишээлбэл, би өөрийнхөө амьдралаар бодъё л доо, та бодоод үз дээ. Миний хүүхэд 3-4 настай байсан. Тэр жаахан хүүхэд уг нь дурааараа гүйж тоглож байх ёстой. Бусад хүүхдийн адил дурааараа аз жаргалтай гүйж явсан хүн яагаад намайг хөтөлж явдаг вэ, явж байхдаа яагаад дээшээ доошоо гэж хэлээд байгаа юм? Тэгэх ёстой юм уу? Тэр хүүхэд зүгээр л аз жаргалтай гүйх ёстой шүү дээ. Би тэр хүүхдийг сэтгэл зүйн хувьд цочролд оруулаад байна. Миний хань намайг хайрладаг байж дээр нь яагаад дурааараа ч хоол идэж чадахгүй намайг өдөр шөнөгүй асраад л, хянаад л, хараад л байх ёстой юм? Тэгэхээр гэр бүл гэдэг бол үнэхээр бүгдээрээ аз жаргалтай байх ёстой.

Бид нар хөгжлийн бэрхшээлтэй болсныхоо төлөө өөрсдөө хэцүү байхад, дээр нь гэр бүлийнхээ гишүүдийг ядрааж зүдрээж, тэр хүмүүсийн эрхэнд нь халдаж, муухай байлгаж болохгүй. Тийм болохоор л бүгдээрээ өөр өөрсдийнхөө амьдралаар амьдрахдаа гэр бүлийнхээ хүмүүсийг нэг өдөр ч гэсэн аз жаргалтай байлгая гэж бодох ёстой гэдгийг маш сайн ухаарсан. Тэгээд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн хувьд маш хүнд байдаг. Яагаад гэвэл хөөрхий хүүхдээ харж байгаа

эх хүн ямар байх билээ, өвчтэй хүнийг 3-4 хоног асраад ямар их ядардаг билээ дээ. Эхний 7 хоног хачин сайхан асран халамжлагч 8 дахь хоногоос эхлээд л чи хар, би хар гэдэг. Бүр өр нимгэн сэтгэлтэй нь би энэний оронд өвдчих юмсан, энийг харж зүдэрч байхын оронд би өмнөөс нь өвдчихсөн бол гээд л хүүхдийнхээ өмнөөс шаналдаг. Тэгэхэд тэд нар зарим нь төрөхөөс нь эхлээд насан туршдаа үр хүүхдээ хайрлаад, аваад явж байдаг. Тэгээд тэр аав ээжийн бүхэл бүтэн амьдрал нь тэр чигээрээ хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэйгээ хамт дуусдаг. Энэ бол туйлын харамсалтай. Тийм болохоор аав ээжтэй маш сайн зөвлөлдөж, ярилцаж байх нь чухал. Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ээж аавуудын мөрөөдөл юу вэ гэвэл "нэг өдөр сайхан унтаж үзэх юмсан" гэж байсан.

Та нар оюун ухаантай хүмүүс өөрсдөө дотроо нэг асуулт тавиад үзээрэй. Тэгэхэд л ганцхан энэ өгүүлбэрээс л тэр хүмүүсийн сэтгэл зүй ямар хэцүү байдаг вэ гэдэг нь харагдах байх. Тэгэхээр манайхан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдэд хүүхдийг нь гоочлохгүй, гадуурхахгүй байж, адилхан хүн гэдэг талаас нь яаж туслах вэ гэвэл гэгээлгээр хараад үзээрэй. Тэгвэл бид нар яг адилхан хүн шүү дээ. Гэхдээ тэр хүмүүст жаахан туслаад, дэмжлэг өгвөл зүгээр байх. Дэмжлэг үзүүлнэ гэдэгт янз бүрийн дэмжлэг байж болно, зүгээр л сайхан хандахад л маш том дэмжлэг болно. Тэгэхээр үүнийг нийгмээрээ сайн хараарай л гэж боддог. Асран халамжлаад байгаа гэр бүлийг нь бас ойлгох хэрэгтэй. Гэр бүлийнхэн ч гэсэн тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүнээ ойлгох хэрэгтэй. Тэр хөгжлийн бэрхшээлтэй хүн бол өвчтөн биш. Сонсохгүй байлаа гээд ойлгохгүй байна гэсэн үг биш, харахгүй байлаа гээд мэдрэхгүй байна гэсэн үг биш, явахгүй байлаа гээд мөрөөдөлгүй байна гэсэн үг биш. Бүгд л адилхан, зөвхөн танаас ялгаатай л байна. Тарган бүдүүн, өндөр нам, царайлаг царайлаг биш яг үүнтэй адилхан нэг төрлийн ялгаатай л байдаг. Тийм болохоор бүгдээрээ энийг эрх тэгш л ойлгох ёстой гэж боддог.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэйгээ хүлээн зөвшөөрөхгүй байгаагаасаа болоод гэр бүл салах асуудал нийгэмд нэлээн ажиглагдаж байна. Та энэ тал дээр ямар бодолтой байдаг вэ?

Би "Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгэм сэтгэл зүйн хандлагыг өөрчлөх" гэсэн сэдвээр магистрын дипломын ажлаа бичиж, хамгаалж байсан. Өөрөөр хэлбэл нийгмийн хандлага ямар байдаг вэ гэдгийг шинжлэх ухааны үндэстэй бодит судалгаанууд дээр тулгуурлан бичиж хамгаалсан. Одоо би "Олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүний сэтгэл зүй, дасан зохицол" гэсэн сэдвээр докторын ажлын судалгаа хийж эхэлсэн. Тэр судалгаанаас юу харагддаг бэ гэвэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн гэр бүлд салалт их өндөртэй байдаг юм байна. Тэгээд ээж нь эсвэл аав нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ хараад хоцорсон эсвэл хүүхэд нь харааны шилтэй болмогц хадам дээрээ

авааччиж хаяад, өөрөө усанд хаясан чулуу шиг алга болсон ээж ч байж байна. Дээр нь хүний амьдрал баялаг учраас дөнгөж гэр бүл болоод байж байтал осолд ороод, гэмтэл аваад бэрхшээлтэй болсон үед хаяад явдаг гэр бүл маш их байдаг. Тэгэхээр энд гэр бүлийн боловсрол гэдэг юм маш их хэрэгтэй байна. Та өнөөдөр эв эрүүл, сав саруул хүний сайхан охин, хүүг сайхан амьдарна гэж авч суусан байж яагаад өвдөх үед нь, бэрхшээлтэй болох үед нь орхиод явж байна? Та яагаад өнөөдөр хүүхэд чинь өвднийх нь төлөө орхиод явж байна гэдгийг хүн бүхэнд багаас нь боловсролоор дамжуулан хайр ямар их хэрэгтэй зүйл вэ гэдгийг ойлгуулах ёстой гэж боддог.

Сая 30 жил манай засгийн газрын нь бодлого эдийн засаг, эдийн засаг, эдийн засаг байсан. Эдийн засаг гэдэг юмыг чинь бүрдүүлэх юм нь хүн. Хүн ард газар нутаг дээр байж Монгол улс оршин тогтноно. Тэгэхээр бүрдүүлж байгаа хүн лүүгээ хандахгүй эдийн засаг, эдийн засаг, мөнгө мөнгө гээд явахаар тэрийг дагаад хайр гэдэг зүйл алга болчихлоо гэж харагддаг. Тийм болохоор хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй болмогцоо хаях, гэр бүлийн хүн нь хөгжлийн бэрхшээлтэй болохоор орхиж явах үзэгдлүүд маш их байна. Ийм зүйл хөгжиж байгаа оронд байдаг ч гэсэн болох байх гэж боддог.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сэтгэл зүйн асуудалд ковид цар тахлын нөлөө хэр байгаа вэ?

Сэтгэл судлаач хүний хувьд би үүнийг өөр өнцгөөс харж байгаа. Ковид гарсан хоёр жилд бид нар янз бүрийн байдлаар гэртээ байлаа. Энэ хугацаанд эрүүл хүмүүс бачимдаад гадаа гараад чөлөөтэй алхах юмсан гээд ямар хэцүү байдалд орж байгаа вэ гэдгийг том жижиггүй, эмээ өвөөгүй бүр нийгмээрээ, дэлхийгээрээ мэдэрлээ. Энэ ковидын хүмүүст өгсөн гэртээ ганцаардах, хорионд байх, гарах чадваргүй байх бол хөгжлийн бэрхшээлтэй хүний өдөр тутамд авдаг мэдрэмж. Заримд нь өдөр тутамд, заримд нь насан туршдаа мэдэрдэг энэ мэдрэмжийг эдгээр эрүүл саруул хүн төрөлхтөнд бүгдэд нь мэдрүүлсэн юм болов уу гэж би боддог. "Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг гэртээ орхиод зүгээр хоол идээд л, хувцас өмсөөд байж байхад болно" гэж боддог хүмүүс энэ мэдрэмжийг өөрийн биеэрээ мэдрээд ирэхэд гэртээ долоо хоног байх нь ямар хэцүү гэдгийг жоохон ч гэсэн ухаарах боломж гарсан гэж бодож байна. Та нар хамгийн гол нь зөвөөр ойлгоорой би бусаддаа атаархсандаа хэлээд байгаа юм биш. Яагаад гэвэл хүн тухайн цаг хугацаагаар нь эсвэл өөрийн биеэр туулж байж аливаа мэдрэмжийг мэдэрдэг. Харахгүй байх мэдрэмжийг нүдээ аньж мэдэрдэг болохоос хараад байвал тухайн мэдрэмж тархинд нь буухгүй. Тэрэнтэй адилхан явж чадахгүй, хүссэнээрээ гарч чадахгүй, хүссэнээрээ идэж ууж, наргиж цэнгэж чадахгүй байх мэдрэмж тохиож байгаа болохоор жоохон ч гэсэн ойлгосон болов уу гэж бодсон.

Хүмүүс хэцүү байна гэсэн ч энэ бол цаг

хугацааны л асуудал, 2-3 жил үргэлжлээд дуусна. Бэрхшээлтэй хүний хувьд бол дуусахгүй. Жишээлбэл, хэзээ ч харахгүй хүн үргэлж мэдрээд явж байгаа учраас хэцүү гэдгийг харуулсан байх. Гэхдээ та бүхэн маш сайн бодоод үзээрэй. Ер нь бол юмыг танин мэдэхийн тулд бодох л хэрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэхээс илүү эрүүл хүмүүс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сэтгэл зүйн энэ хэцүү байдлыг ойлгосон болов уу гэж би харсан. Жишээлбэл, миний хувьд ковид цар тахал гараад надад онц өөрчлөлт гараагүй. Харин ч надад ямар ч асуудалгүй, хэнийг ч гуйхгүй гэрээсээ цахимаар хичээллэх боломж гарч танхимынхаа бүх хичээлийг шахаж үзээд дууссандаа би маш баяртай байна. Хүмүүс сонсвол ямар муухай хүүхэн бэ гэж бодож магадгүй гэтэл би өөрийнхөө тухай, хөгжлийн бэрхшээлтэй хүнийхээ тухай л ярьж байна. Ковид гарлаа гээд энэ байдлыг 2010 оноос хойш өдөр тутамдаа мэдэрсэн болохоор нэг их өөрчлөгдсөн зүйл байгаагүй дээ.

Магадгүй манай подкастыг сонсож байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эсвэл тэдний гэр бүл сонсож байвал та ямар зөвлөгөө өгөх вэ?

Би хүмүүст хөгжлийн бэрхшээлийг айхтар байдлаар гаргаж харуулъя гэж ерөөсөө боддоггүй. Бүгдээрээ адилхан хэрэгцээтэй, зөвхөн тухайн мэдрэх мэдрэмж дээрээ л алдаа гарсан байгаа. Харахгүй байх мэдрэмж нь л хоцрогдоод, бусад мэдрэмж нь байж байна. Тийм болохоор би нэгдүгээрт хөгжлийн бэрхшээлтэй иргэддээ юу гэж хэлэх вэ гэвэл нэг хаалга хаагдсан ч нөгөө хаалгаа заавал нээлттэй байдаг юм. Алтан дэлхий бүх хүнд яг адилхан нараа өгдөг болохоор бүгдээрээ энэ хорвоо дээр адилхан л амьдрах ёстой учраас бүгдээрээ сайхан амьдралын төлөө хичээх хэрэгтэй. Эзэн хичээвэл заяа хичээнэ гэдэг л болно гэж бодож байна. Хоёрдугаарт, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг асардаг халамжилдаг, тэд нарын төлөө зүрх сэтгэлээ зориулдаг хүмүүс, төрийн болон төрийн бус байгууллагынхандаа та бүгдэд баярлалаа гэж хэлнэ. Гуравдугаарт, дэм дэмэндээ, дээс эрчиндээ явбал бид нарт ч гэсэн маш олон давуу тал байгаа болохоор яг л зэрэгцээд, эрх тэгш сайхан ажиллаж амьдаръя. Алтан наран доор яг адилхан амьдарцгаая гэж хэлье л гэж боддог.

Манай подкастын цаг өндөрлөх дөхөж байна. Танаас сүүлийн асуултаа асууя. Тань дээр зорьж очъё гэсэн хүмүүс яаж холбогдох вэ? Хаана очих вэ?

Манай Сэтгэл зүйн боловсролын төв Баянгол дүүрэгт Модны хоёрт ажиллаж байгаа. Манай төв дээр 5 сэтгэл судлаач ажиллаж байгаагаас би ганцаараа харааны бэрхшээлтэй. Сэтгэл судлаач нар маань зарим нь гэрээгээр ажилладаг. Манай утас 1900-1050 дээр байж байдаг. Бас 80843838 гэдэг дугаарт залгаад цагаа авч болно. Би цагаа бүртгээд, бусад сэтгэл судлаач нартаа үйлчлүүлэгчдээ бас санал болгодог. Сэтгэл судлаач хүний хамгийн чухал үүрэг бол холбон зуучлах байдаг. Бүх юманд зөвлөгөө өгөх чадвар төгс төгөлдөр биш учраас сэтгэл судлаачид

харилцаа, мансуурал зэрэг аль нэг чиглэлээр дагнаж ажилладаг. Хүүхдийн сэтгэл зүйн зөвлөгөө авмаар байна гэхэд бид хүүхдэд сэтгэл судлаачийг дуудаад, төвөөрөө дамжуулаад сайн зөвлөгөө өгөх үйл ажиллагааг явуулдаг. Энэ үйл ажиллагаа явуулаад бид нар 4 жил болно болж байна. Уг нь бид 2019 оноос хойш 1900-1050 утсаар зөвлөгөө өгч ажилласан ч харамсалтай нь өндөр төлбөртэй учраас үйлчлүүлж чадахгүй хаачихсан байгаа. Гэхдээ цаашид үргэлжлүүлээд ажиллана гэж бодож байгаа. Тэгээд 7707-5010 гээд бас манай байгууллагын утас байна. Гол нь 8843838 руу ярихад л бид нар нийгэмд үйлчлэхэд бэлэн байгаа.

Цаг зав гарган манай подкастад орсон Болормаа эгчдээ баярлалаа.

Та бүхэнд бүгдэд нь ажлын өндөр амжилт хүсэж, эрүүл энх, аз жаргалтай, урт удаан наслах болтугай гэж Монголын ард түмэндээ хүсье!

ДОХИОНЫ ХЭЛНИЙ ВИДЕО ДУУДЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭГ НЭВТРҮҮЛСЭН

Л.Соёлмаа



Сайн байцгаана уу, эрхэм хүндэт сонсогчид оо, Антолд подкастын маань ээлжит дугаар эхлэхэд бэлэн болоод байна. Энэхүү дугаарт Монголын Дохионы хэлний хэлмэрч, орчуулагчдын холбооны тэргүүн Соёлмаа оролцож байна.

Юуны өмнө та манай сонсогчдод өөрийгөө танилцуулахгүй юу?

Маш их баярлалаа. Намайг Соёлмаа гэдэг. Дохионы хэлний хэлмэрч орчуулагчдын холбоо (ДХХОХ)-ны тэргүүнээр ажилладаг. Сонсголгүй хүүхдийн боловсрол, сонсголгүй иргэдийн дохионы хэлний орчуулгын үйлчилгээний чиглэлээр сүүлийн бараг 30 жил ажиллаж байна.

ДХХОХ-ны талаар танилцуулахгүй юу? Магадгүй маш олон хүмүүс мэдэхгүй байгаа байх.

Энэ ДХХОХ-г 2011 онд сонсголгүй иргэдээс өөрсдөөс нь дохионы хэлийг сураад, дохионы хэлний хэлмэрчээр ажиллаж байсан 5 хэлмэрч санаачилж, үүсгэн байгуулсан. Би анх 1992 онд их сургуульд ороод, ээжийгээ “хагас цагийн ажил олж өгөөч ээ” гэж гуйсан. Тэр үед хөдөлмөрийн баатар Гүнжлхам гуай Алтан овоо ХХК гэдэг жижигхэн үйлдвэр байгуулаад, тэндээ сонсголгүй иргэдийг авч ажиллуулж байсан. Би тэр үйлдвэрт ороод анх сонсголгүй иргэдтэй танилцсан. Тэгээд тэр хүмүүсээс



дохионы хэлийг сураад, өөрсдийнх нь ертөнцөд нэвтэрч орж байсан. Надад төрсөн сэтгэгдэл гэвэл хүний амьдралын бэрхшээл зовлон гэж байдаг бол сонсголгүй хүний амьдралд бүр 2 давхар байдаг. "Хэрвээ би сонсголтой байсан бол" гэсэн харуусал тээж яваа санагдсан. Тэгээд би энэ хүмүүст яаж туслах вэ? Бүх чадлаараа энэ хүмүүст туслах юмсан гэсэн хүсэлтэйгээр сонсголгүй хүмүүсийн дохионы хэлийг сураад, өнөөдрийг хүртэл сонсголгүй иргэдийн нийгмийн бүлэгтэй хамт ажиллаж байна. Тэр үедээ би сонсголгүй иргэдийн урилгаар Христ сүмд очиж байсан. Тэнд маш олон сонсголгүй иргэд Есүс Христийн тухай сайн мэдээ сонсоод, итгээд амьдрал нь өөрчлөгдөж байгааг хараад, энэ хүмүүст мэдээллийг маш нээлттэйгээр хүргэх нь чухал гэдгийг ойлгосон. Тухайн үедээ би сонсголгүй хүмүүстэй яг над шиг орчуулга хийгээд ажиллах хүмүүс байна уу? гэж санал тавихад Сайнбаяр, Цэнгэл гэдэг хоёр хэлмэрч маань орж ирсэн. Дараа нь 1993 оны 9 сард найдвар гээд чуулган үүсгэн байгуулагдах үед сонсголгүй иргэдийн үйлчилгээг анхааръя гэсэн учраас бид тийшээ шилжсэн. Тэр үед орчуулагч

Бямбадэлгэр, И.Болормаа хоёр маань бидэнтэй нэгдсэн. Энэ 2 хэлмэрч маань одоо үндэсний телевизээр орчуулга хийдэг. Бид 5 үндсэндээ 2011 онд ДХХОХ-г үүсгэн байгуулсан юм.

Байгуулж байхдаа ямар ажлуудыг та нар ихэвчлэн хийдэг байсан бэ?

Дохионы хэлийг сонсголгүй иргэдээс сурсан болохоор дандаа орчуулга хийдэг байсан. Цагдаа дээр, сургалтуудад орчуулдаг хийдэг. Зарим сонсголгүй иргэд "би гэр бүлийнхэнтэйгээ ойлголцохгүй байна, манай гэрт ирээд орчуулаад өгөөч" гэхэд дагаж очоод ээж хүүхэд хоёрын хооронд эсвэл хадам ээж, бэрийн харилцаан дунд хүртэл орчуулга хийсэн тохиолдлууд байдаг. Бид нар дохионы хэлний орчуулагчийн ажил мэргэжлийг Монгол улсад таниулъя, түгээн дэлгэрүүлье хэмээн зорьж байсан. Сонсголгүй хүмүүсд мэдээлэл авах хэрэгцээ байна, орчуулагчийн үйлчилгээ байна. Гэхдээ систем нь ерөөсөө байгаагүй. Манай холбоо 2011 онд байгуулаад явж байгаад олон улсын төсөл хөтөлбөр хэрэгжүүлээд бусад иргэний нийгмийн болон сонсголгүй иргэдийн төрийн бус байгууллагуудтай хамтарч ажилласан. Энэ хугацаандаа бид Монгол улсын үндэсний ажил мэргэжлийн жагсаалтад дохионы хэлний хэлмэрч орчуулагч гэдэг мэргэжил байхгүй гэдгийг олж мэдээд, 2018 оны 10 сард Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам руу албан бичиг хүргүүлж байсан. Ингэхдээ бид олон улсын дохионы хэлний орчуулагчийн АйСиӨү (ICO) ангиллаас тухайн мэргэжлийн гүйцэтгэх үүргийг судалж, тэр хэлбэрээр нь албан бичигтээ тусгасан. Энэ нь 2019 онд үндэсний ажил мэргэжлийн тодорхойлолтод орсон байдаг. Тэгэхээр 2019 оноос Монгол улсад дохионы хэлний хэлмэрч орчуулагч гэдэг мэргэжил үндэсний ажил мэргэжлийн тодорхойлолт орж эхэлсэн гэсэн үг. Тэрнээс өмнөх бүх хугацаанд бид сайн дураараа энэ мэргэжлийн суурийг тавих гээд ажиллаж байсан. Бид 2013-2017 онд Финландын Флом байгууллагатай хамтраад дохионы хэлний хэлмэрч бэлтгэх сургалтыг зохион байсан. Тэр үед Сонсголгүйн боловсролын Баасанжав захирал маань хэлмэрч бэлтгэх сургалтад багшлаад, хариуцаад явж байсан. Одоо ч хэлмэрч бэлтгэх сургалтыг тэдний төрийн бус байгууллагатай манайх хамтраад үргэлжлүүлээд хийж байгаа. Бид таваас хойш сүүлийн үед телевизээр гарч, энд тэнд орчуулга хийж байгаа залуу орчуулагч нар маань бүгд тэр сургалтын үр дүнд гарч ирсэн орчуулагч хэлмэрчид байдаг. Тэд нар маань ихэнхдээ эцэг эх нь сонсголгүй ч өөрсдөө сонсголтой, багаасаа дохионы хэл болон Монгол хэл гэсэн хос хэл эзэмшсэн хүүхдүүд байгаа. Дохионы хэлний хэлмэрч болох хүсэлтэй залуучуудыг илүү хэлмэрчийн ёс зүй, хэлмэрчлэх арга зүй, техник энэ тал руу нь сургаад, хэлмэрчээр бэлтгэдэг. Одоо манай холбоонд 13-14 хэлмэрч байгаа гэж ойлгож болно.

Зөвхөн дохионы хэлмэрч орчуулагчийн

үүрэг гүйцэтгэхээсээ гадна сонсголын бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулдаг гэж би харсан?

Дохионы хэлний орчуулгын үйлчилгээний мэргэжлийн онцлог нь өөрөө сонсголгүй хүний мэдээлэл авах, үг хэлэх эрхийг хангах байдаг. Тэгэхээр бидний хийж байгаа ажил бол тухайн хүний мэдээлэл авах, нийгмийн хүртээмжтэй үйлчилгээг хангаад зогсохгүй тодорхой тохиолдлуудад манай байгууллагын дүрэм журам, бодлогын баримт бичгүүдэд байдаг хүчирхийллээс хамгаалах, бэлгийн мөлжлөг, дарамтаас урьдчилан сэргийлэх эсвэл хүүхэд хамгаалах гэсэн журмуудын дагуу дохионы хэлний хэлмэрч давхар үүрэгтэйгээр ажилладаг гэсэн үг. Жишээлбэл тухайн үед хүүхэд ямар нэгэн байдлаар хүчирхийлэлд өртөж байгаа мэдээлэл авбал, холбогдох албан тушаалтнуудад мэдэгдэх давхар үүрэгтэй байдаг. Миний хувьд зөвхөн ДХХОХ-ны чиглэлээр ажиллаагүй, 2006 оноос сонсголгүй хүүхдийн боловсролыг дэмжих төсөл эхлүүлээд, сонсголгүй хүүхдийн Бамбарууш цэцэрлэгийг 29-р сургуулийг түшиглэн байгуулж байсан. Энэ цэцэрлэг маань өнөөдрийн Сүхбаатар дүүргийн 186-р цэцэрлэг буюу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгодог цэцэрлэг болсон. Энэ хугацаандаа зөвхөн сонсголгүй хүүхэдтэй ажиллах биш, багш, эцэг, эхчүүдтэй цогцоор нь ажиллах чухал гэдгийг бид харсан. Сонсголгүй хүүхэдтэй эцэг эхчүүдэд хүүхэдтэй нь зэрэг дохионы хэлийг заахад хүүхдийн төрөлх хэл учраас хүүхдийнх нь дохионы хэлний чадвар эцэг эхээсээ түрүүлээд гайхалтай хөгждөг. Эцэг эхийн хувьд дохионы хэл бол 2 дахь хэл нь учраас гадаад хэл сурах үйл явц шиг цаг хугацаа, хичээл зүтгэл шаардагддаг. Дохионы хэлний сургалтад хамрагдсан эцэг эхчүүд ихэнх цагаа гэр бүлтэйгээ өнгөрөөдөг учраас хүүхдүүдтэйгээ чөлөөтэй харилцаад, сэтгэлээ нээгээд явж байгаа. Тэгэхээр ийм эцэг эхчүүдтэй хүүхдүүдийн сурч боловсрох нь хүртэл амжилттай байдаг гэж ойлгож болно.

Таны хэрэгжүүлж байсан төсөл хөтөлбөрүүд дотор хос хэл, соёлын арга зүй гэдэг төсөл байсан. Энэ яг юуны талаарх төсөөлөл байсан бэ?

Хос хэл, соёлын арга зүй гэдэг маань сонсголгүй хүүхдэд боловсрол олгох хамгийн шилдэг, дэлхийн хамгийн сүүлийн үеийн арга зүй байгаа юм. Тэгэхээр нэг түүх ярихад 1880 онд Итали улсын Мелан хотод болсон дэлхийн сонсголгүй боловсролын багш нарын 2-р чуулганаар тухайн үедээ ажиллаж байсан орон орны сонсголгүйн багш нар нэгдээд "сонсголгүй хүүхдүүдэд боловсрол олгохдоо аман яриагаар ярьж сургах хэрэгтэй" гэдэг шийдвэр гаргасан. Бараг 13-14-р зуунаас дохионы хэл, дохио зангаагаар сонсголгүй хүүхдийг сургаад явж байсан түүх байж байтал 19-р зуунд дохионы хэлийг хорьсон. Ингээд явж байтал 1960-аад оны үеэс сонсголгүй хүний дохионы хэлийг нь хорьж аман ярианд сургах нь хүний эрхийн зөрчил, нэг талаараа харгислал юм байна гэж хүний эрхийн зүтгэлтнүүд дуугарч эхэлсэн. Би зөвхөн Монгол улсын

жишээ яриагүй, дэлхий даяар бараг 1970 он хүртэл сонсголгүй хүүхдүүдийг сургахад Европ, Азид янз бүрийн арга хэрэглэж байсан. Жишээлбэл Азид хулсанд гарыг нь хийгээд, тохойгоороо хөдөлгөхгүй болгоод, аманд нь янз бүрийн төмөр аппарат хийж хэлийг нь өргөж авиа хэлүүлж сургадаг, зарим улсуудад гарыг нь ард нь хүлж байж хүүхдийг авиа тавиулдаг хэл заслын аргыг хэрэглэж байсан. Үүнийг нэг талаараа харгислал гэж үзсэн. Сүүлийн үеийн сонгог зүйч багш нар тэгээгүй л дээ. Тэр 1940-1950 оны үед тэгж байсан гэсэн түүхийг настай сонсголгүйчүүд ярьдаг. Тэгэхээр 1960-аад оноос хойш огт авиа сонсоогүй, ямар ч авиа дуудлагын ойлголтгүй хүнд хүчээр авиаг хэлүүлэх арга зүй бол хүний эрхийн зөрчил юм гэдэг ойлголт нийгэмд гараад, хүний эрхийн тунхгуудад дохионы хэлийг хүлээн зөвшөөрсөн алхмууд хийгдэж эхэлсэн.

Боловсролын шинэчлэл өөрчлөлтүүд 1980-аад оноос хойш туршигдаад, Скандинавын хойгоос эхэлсэн хос хэл, соёлын арга зүй нь хамгийн үр дүнтэй арга зүй юм байна гэдгийг 1996 онд бүх дэлхий даяараа ойлгож эхэлсэн байдаг. Ингээд 2010 онд Канадын Ванкувер хотод болсон сонсголгүй боловсролын багш нарын 21-р чуулганаар сонсголгүй хүүхдийн боловсролд хос хэл, соёлын арга зүйгээр явах нь чухал гэдэг шийдвэр гарсан. Бидний өмнөх багш мэргэжилтнүүдийн 1880 онд гаргасан Меланы конференсийн шийдвэр маш буруу шийдвэр байжээ. Энэний улмаас бид нар маш олон сонсголгүй хүмүүсийн эрхийг хохироож, тэдний бүрэн дүүрэн сурч, боловсрол эзэмших эрхийг хаасан байна. Яагаад



гэвэл энэ хүмүүс зөвхөн мужаан, гар урлал, оёдолчин гэх зэрэг биеэр хийх хөдөлмөр эрхлэхэд суралцсан. Оюуны хөдөлмөр эрхлэх химич, физикч, философич, эмч, инженер гэсэн мэргэжлийг эзэмшиж болохооргүй байдлаар сургалтын арга зүйг нь хязгаарласан байна гээд, дэлхий даяарх сонсголгүй иргэдээс тэр чуулганы боловсролын мэргэжилтнүүд уучлал хүссэн байдаг. Ингээд 2010 оноос хойш хос хэл, соёлын арга зүйг нэвтрүүлье гэсэн хөдөлгөөнүүд өрнөж эхэлсэн.

Хос хэл гэдэгт тухайн хүүхдийн эх хэл болох дохионы хэл, тухайн орны албан ёсны хэлний бичгийн хэл нь орно. Өөрөөр хэлбэл Монгол сонсголгүй хүүхдийн хувьд Монгол дохионы хэл эх хэл нь болоод, хоёр дахь хэл нь Монгол хэлний бичгийн хэлбэрийг л заана. Тэр хүүхдийг Монгол хэлээр аав гэж цаг үрж, яриулж сургах ямар ч шаардлага байхгүй. Тэрний оронд дохионы хэлээр аав ээж, аяга таваг, ширээ сандал гэдгийг нь заагаад, сургуульд ороход нь аав ээж, аяга таваг, ширээ сандал гэдгийг ингэж бичнэ гэдэг арга зүйг хос хэлний арга зүй гэж байгаа юм. Мөн сонсголгүй иргэд өөрийн гэсэн хэл соёлтой, нийгмийн хэлний цөөнх бүлэг гэдгийг олон улсад хүлээн зөвшөөрсөн. Тэдний соёл нь хараанд суурилсан соёл байдаг. Өөрөөр хэлбэл харааны мэдрэхүйгээрээ илүү мэдээллийг хүлээж авдаг учраас хараан дээр суурилсан мэдээлэл байна. Хараанд суурилсан мэдээллийн үр дүнд хүмүүс



ярилцахдаа нуруу нуруугаа харахгүй, заавал өөд өөдөөсөө харж ярилцана. Эсвэл бие биенээ дуудахдаа гараа даллана. Цаашаа харсан байвал мөрөн дээр нь аяархан хүрнэ гэх зэрэг хараанд суурилсан мэдээллийн орчны онцлог соёлыг сонсголгүй хүний ахуй соёл гэж хэлж байгаа юм. Мөн Соёлмаа гэж хэлээд сонсохгүй учраас сонсголгүй хүн болгонд Соёлмаа гэдгийг илэрхийлэх дохио нэр байдаг. Тэгэхээр сонсголгүй хүнд сонсголгүй соёл, Монгол ахуй соёл гэсэн 2 соёлыг эзэмшүүлэх арга зүйг хамтад нь хос соёлын арга зүй гэж хэлээд байгаа юм. Энийг бид нар 2014-2016 онд ЮЭсАйДи (USAID) гэж хүмүүс мэддэг Америкийн олон улсын хөгжлийн агентлагийн тусламжтайгаар Хэл соёлын арга зүйг бага боловсролд нэвтрүүлэх, эрт оролцооны хөтөлбөр гэсэн хөтөлбөр хэрэгжүүлж байсан. Эрт оролцооны хөтөлбөр гэдэг маань бас нэг чухал зүйл. Яагаад гэвэл эцэг эх хүн хүүхдээ ямар нэгэн бэрхшээлтэй төрнө гэж огт боддоггүй. Гэтэл сонсголгүй хүүхдүүдийн эцэг эхчүүдийн бараг 95% нь сонсголтой байдаг. Тэр сонсголтой эцэг эхийн хувьд магадгүй өмнө нь сонсголгүй хүнийг огт хараагүй, дохионы хэл мэдэхгүй байдаг. Тэгэхээр энэ үед нь сонсголгүй гэж анх оношилж байгаа эх нялхсын эмч эсвэл төрөхийн эмч нар эцэг эхчүүдэд маш шударгаар, хүмүүнлэг байдлаар үнэн зөв мэдээллийг өгөх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл "танай хүүхэд сонсголгүй юм байна.

Танай хүүхэд нийгмийн болон эрүүл мэндийн ийм үйлчилгээг авч болно." Үнэхээр сонсгол нь зүгээр сэргэхээргүй хүүхэдтэй бол "та дохионы хэл сураарай. Эцэг эхчүүдэд дохионы хэл заадаг, эрт оролцооны буюу эцэг эхчүүдэд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлдэг ийм ийм төвүүд байна. Тэнд та очоорой" гээд холбох хэрэгтэй байгаа юм. Манай улсад эрт оролцооны буюу эцэг эхчүүд хүүхдээ анх хөгжлийн бэрхшээлтэй гэдгийг сонсоод, сэтгэл зүйн шок, дарамтад ороход тэдэнд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх систем байдаггүй. Эцэг эхчүүд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй боллоо гэхэд тэр хүүхдийг 6 сар хүртэл нь эрт оролцооны төвийн үйлчлэгч, мэргэжилтнүүд гэрээр нь очиж хүүхдээ хэрхэн асрах вэ, хүүхэдтэйгээ хэрхэн харьцах вэ, хүүхдээ хэрхэн хөгжүүлэх вэ? гэдэг зөвлөгөө, мэдээллийг эцэг эхчүүдэд өгч байх ёстой байдаг. Энэний дараагаар 6 сараас хойш бараг 2 нас хүртэл нь эцэг эх хүүхэдтэйгээ хамт тэр төвүүд дээр долоо хоногийн 2-3 өдөр ирээд, сонсголгүй хүүхэдтэй эцэг эхчүүд хэл засал, авиа тавилт, дохионы хэлний хичээлүүдэд явна. Саажилттай эсвэл хөгжлийн бусад бэрхшээлтэй хүүхдүүдтэй бол яг тохирох, ганцаарчилсан хөтөлбөрийнх нь дагуу хөгжүүлэх хөтөлбөрүүдэд нь яваад, болж өгвөл 3 нас хүрэхээс нь өмнө хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг эрт оношлоод, эрт оролцооны хөтөлбөрт хамруулж чадвал дараа дараагийн гарах маш олон хүндрэлээс сэргийлж чадна. Нэгдүгээрт, хэл яриа, харилцааны суурийг нь тавьж өгч болно. Хоёрдугаарт, хөдөлгөөн заслыг багаас нь хийснээр булчингийн хөгжил буюу ураг тархитай холбоотой тархи булчингийн хөгжлийг дэмжсэн дасгалуудаар хүүхдийн хөгжлийг дэмжиж

болно. Тэгэхээр манай улсад маш чухал цаг үеийг алдаад байгаа юм. Зарим эцэг эхчүүд хүүхдээ сонсголгүй эсвэл ямар нэгэн бэрхшээлтэй гэдгийг нь ч мэдэлгүй явсаар байгаад 5, 6 хүрсэн хойно нь мэддэг. "Өө яахав, наадах чинь бараг 5 настайдаа хэлд ордог юм, тийм хүүхэд байдаг юм" гэдэг буруу юманд итгэсээр байгаад хэл яриа сурах хамгийн таатай цагийг нь өнгөрөөдөг. Тэгэхээр эрт оролцооны хөтөлбөр гэдэг ийм хэрэгтэй зүйл байдаг гэдгийг бид нар төсөл хэлбэрээр эхлүүлж харуулж байсан. Манай улсад эрт оношилгоо, эрт оролцооны баг ажиллахаас гадна яг тэрний дараа эцэг эхчүүдэд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, дэмжих бүлэгт урих, тэдний сэтгэл зүйтэй ажиллах сэтгэл зүйчдийг түлхүү ажиллуулах ёстой. Тэгэхгүй бол хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй болсноо мэдсэн эцэг эхчүүд энэ байдлаа хүлээн зөвшөөрөх хүртлээ дасан зохицох гэж дор хаяж 3-5 жилийн хугацаа зарцуулдаг. Гэтэл эцэг эхчүүдийн сэтгэл санааны байдлаа хүлээн зөвшөөрөх хугацаанд нь хүүхдийн хэл ярианы хөгжлийн хамгийн чухал 0-6 насны үетэй давхцдаг.

Тэгэхээр хүүхдийг эрт оношиллоо гэхэд эцэг эх, гэр бүлтэй нь эрт ажиллах хэрэгтэй. Манай улсад тийм систем байдаггүй. Тогтсон загвар нь Монголд байхгүй шинэ үйлчилгээг гаднын хөрөнгө оруулалт төслөөр шийдээд, тодорхой хугацаанд туршиж үзээд, ийм арга зүй байна, ийм загвар байна, энийг үргэлжлүүлэх хэрэгтэй байна гэхэд төр тодорхой хэмжээгээр өөрийнхөө бүтэц тогтолцоонд суулгаад, улсын төсвөөр үргэлжлүүлэх ёстой гэж манай багийнхан үздэг. Гэтэл хүмүүс "төсөвт мөнгө байхгүй" гэдэг. Шинэ юмыг санаачилъя гэхэд төсвийн мөнгөөр бид нар юу ч хийж чадахгүй, тэр мөнгө нь олдохгүй. Шинэ зүйлийг хийж байгаа төрийн бус байгууллагынхныг дэмжье гэсэн олон улсын төсөл хөтөлбөрүүд, хөрөнгө оруулалтын сангууд байна. Эд нартай бид төрийн бус байгууллагын хувьд хамтарч ажиллаж байгаа. Хамтарч ажиллахдаа урт богино хугацаатай, их бага хэмжээтэй төслүүдийг хэрэгжүүлээд, ийм үйлчилгээ манайд хэрэгтэй байна гэдгийг хэрэгжүүлж туршиж үзээд, үр дүнгээ харуулаад явдаг гэсэн үг. Иргэний нийгэм тэгж л ажилладаг л юм байна. Тэгэхээр хос хэл, соёлын арга зүйн талаар ярихын тулд бид нар энэ төслийг хэрэгжүүлсэн. Яг хүлээж аваад хэрэгжүүлэх 29-р сургуулийн багш хамт олон өөрсдөө маш их эсэргүүцсэн. Яагаад гэвэл насаараа боловсрол эзэмшээд, хүүхдэд авиа тавилт, хэл заслын арга зүйгээр заагаад сурчихсан хүмүүс арга зүй өөрчлөхийг хүсэхгүй байгаа. Гэтэл эцсийн эцэст энэ арга зүй л хүүхдийн төлөө арга зүй юм гэдгийг бараг одооноос л жоохон ойлгож эхлэх гэж байна. Бид нарыг төсөл хэрэгжүүлэх гэж байхад "бид нарыг шалгах гэж ирлээ эсвэл Соёлмаа сургуулийн захирал болох гээд ирлээ" гэсэн байдлаар хүмүүс хандаж байсан. Гэтэл тийм биш.

Энэ 29-р сургуульд хүүхдүүдэд боловсрол эзэмшүүлэхээр хичээл зааж байгаа багш нар дохионы хэлийг маш сайн эзэмшсэн байх ёстой. Тэгж байж тэд "за хүүхдүүд

ээ, багшийгаа хараарай, А үсгийг хурууны үсгээр ингэдэг, А үсгийг ингэж бичдэг" гэж хичээл заах процессоо дохионы хэлээр тайлбарлах ёстой. Гэтэл 29-р сургуульд сургууль төгссөн, дохионы хэлгүй багш нарыг шууд авааД, тэр багш нь хүүхдүүдээсээ дохионы хэл сураад, эргээд хүүхдүүдээс сурсан маш энгийн дохионы хэлээрээ хичээлээ заана гэхээр ямар хэмжээнд боловсрол эзэмшүүлж байгаа нь ойлгомжтой. Тэгэхээр 29-р сургуульд туслах багш нар гээд маш олон сонсголгүй багш нар байдаг. Тэр багш нарыг жинхлэх хэрэгтэй. Тэр багш нарыг үндсэн багш болгож хичээл заалгаад, дохионы хэлээрээ хүүхдүүдэд ойлгуулаад, шинэ сургууль төгссөн багш нар нь туслах багшаар ажиллаад, дохионы хэлээр сургаад, хэрэглэгдэхүүн материалаа бэлдээд, хүүхдүүдтэй танилцаад, хүүхдийнхээ дохионы хэл, орчин, сонсголгүй хүний ахуй соёлыг мэдээд явж байх ёстой. Яг тэр бүтэц нь маш буруу. Одоогийн байгаа хандлага нь "сонсголгүй хүн чадахгүй, эд нар мэдэхгүй" гэдэг байдлаар ханддаг. Тэгэхээр энэ талаар иргэний нийгмийнхэн маш олон санал хүсэлт гаргаж, Боловсролын үе үеийн сайдуудад албан бичиг өгсөн ч одоо хүртэл уулзаж чадахгүй байна. Гэтэл бодит амьдрал дээр сонсголгүй хүүхдүүд нь хохироод үлддэг. Дээрээс нь авиа тавилт, хэл заслын аргыг 10 жил сурсан боловч бүтэн өгүүлбэрээр ярьж чадахгүй л төгсөж байна. Би энд Монголыг яриагүй дэлхий даяар Америк, Япон, Англид хийсэн судалгаа ярьж байна.

Японд 10 жилээ төгссөн хүн 3-р анги, 2-р ангийн хүүхдийн төвшний ханз үсгийн мэдлэгтэй байсан. Английн ахлах сургууль төгссөн 17,000 сонсголгүй хүүхдүүдэд судалгаа хийхэд 4-р ангийн тооны мэдлэгтэй, Америкийн 12-р анги төгссөн бараг 18,000 сонсголгүй хүүхдүүдэд судалгаа хийхэд дөнгөж 3-р ангийн англи хэлний төвшинтэй байна. Энэ чинь авиа тавилт, хэл заслын аргаар сургаад, үр дүнд хүрэхгүй байна гэдгийг харуулаад байгаа юм. Энэ судалгаа 1996 онд маш том цохилт өгч, сургалтын арга зүй бол буруу байна,



одоо дохионы хэлэнд суурилсан буюу хос хэлний арга зүйг нэвтрүүлэх нь чухал юм байна гэдэг рүү бүгд өөрчлөлтийг хийж, 2010 оноос баталгаажсан. Тэгэхээр энэ дэлхийд болж байгаа мэдээ мэдээлэл, өөрчлөлтийг англи хэл мэддэг багш нар нь мэдээд, ийм байна гээд улс орондоо ярихаар бид нарыг эсэргүүцэх гээд байдаг. Энэ чинь дэлхий даяар болж байгаа өөрчлөлт. Тэгэхээр сонсголгүй хүүхдийн боловсролын төлөө 29-р есдүгээр сургуульд, бусад сургуульд ажиллаж байгаа бүх хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн багш нар өөрсдийгөө сургаж хөгжүүлэх, боловсруулах, шинэ соргог мэдээ мэдээлэл хаана байна, сонсголгүй хүүхдийг сургах арга зүйнүүдийн аль нь зөв бэ? гэдгийг л маш сайн судлах хэрэгтэй гэж ойлгосон. Бид нар төслийн хүрээнд эцэг эхчүүд, багш нарт үнэ төлбөргүй дохионы хэл зааж байсан.

Бид "үнэ төлбөргүй дохионы хэл заагаад өгье өө" гэхэд бараг яах гэсэн юм, бид нарт хэрэггүй гээд багш нар орж ирэхгүй байгаа шүү дээ. Тэгэхээр үүн дээр тухайн хүний сэтгэл, хандлага гээд маш олон зүйлийг ярьж болно. Дээрээс нь хүүхдийн хэрэгцээнд тулгуурласан арга зүй бас чухал. Яг үнэндээ 29-р сургуульд барьж байгаа сургалтын хөтөлбөр байна уу, сурах бичиг байна уу, ангийн төлөвлөгөө байна уу? гэхэд байдаггүй. Тэгэхээр үүн дээр өргөн хүрээтэйгээр, олон жилийн турш маш нарийн ажиллах ёстой. Бид нар энэ төслийн хүрээнд хос хэл, соёлын арга зүйгээр цэцэрлэгт боловсрол эзэмшүүлсэн хүүхдүүдээ 1-р ангид ороход нь бас хос хэл, соёлын арга зүйг ашиглах төслийг хэрэгжүүлсэн. Хүүхдүүддээ хичээлийн дараа дохионы хэлний сургалтууд орж байсан. Одоо энэ хүүхдүүд дунд ангид орох үед бид эцэг эхчүүдэд санал тавиад, өөрсдийнх нь хүсэлтээр ердийн ерөнхий боловсролын сургууль буюу 16-р сургуульд 2 сонсголгүй хүүхдийг явуулж байгаа. Ингэхдээ бид нар дохионы хэлний хэлмэрчээр хангаж өгч байгаа. Өөрөөр хэлбэл тэр хүүхэд цэцэрлэгийн боловсрол, бага боловсролоо хос хэл буюу дохионы хэл, бичгийн хэлээр эзэмшээд, дунд ангиасаа дохионы хэлээр, хэлмэрчийн тусламжтайгаар багшийнхаа лекцийг сонсоод, ойлгоод, авна. Хэрвээ багш нь тэмдэглэлээ өгвөл түүнийг уншиж судлаад өөрийнхөө ойлголтоор тэмдэглэж аваад, даалгавраа хийгээд явна. Тэгэхээр энэ бол арай шинэлэг, сонсголгүй хүүхдийг боловсролд тэгш хамруулах арга зүй юм болов уу гэж бодож байгаа. Сонсголгүй хүүхдийг зүгээр ерөнхий боловсролын сургуульд оруулаад, нэг ангид суулгачихвал тэр тэгш хамруулалт биш. Тэр бол зөвхөн биеэр хамруулж байгаа хэрэг болно. Харин үндэс суурьтайгаар тухайн хүүхдийг сургуулийн өмнөх боловсрол, бага боловсролоос нь хос хэлний арга зүйгээр сургаад, дохионы хэл, бичгийн хэлтэй болсны дараа дунд ангиас нь хэрвээ ерөнхий боловсролын сургууль руу шилжүүлбэл болох юм байна гэдгийг харуулах зорилготой бид нар туршилтын төсөл байгаа юм. Сая Японы ЖАЙКА-гийн хүмүүс бидний туршлагыг судлаад, "өө энэ чинь бараг Японд ч хийгдээгүй юмыг та нар энд сонсголгүй хүүхдийг тэгш хамруулахаар туршиж

байна" гээд ярьж байсан. Тэгэхээр бид нарын 2006 оноос хойш бага багаар хийсэн ажил маань бид нарын нүдэнд яст мэлхий шиг л харагддаг. Бидний ажил бага багаар, алхам алхмаар урагшилдаг, ийм л байдалтайгаар ажиллаж байна. Энэ туршлага Монгол улсад түгэн дэлгэрвэл олон сонсголгүй хүүхдийн боловсрол, амьдралд их хэрэгтэй юм болно.

Та сая яриан дундаа сонсголын бэрхшээлтэй иргэд маань хоёр давхар шаналгаатай, харуусалтай байдаг гэж байсан. Сонсголын бэрхшээлтэй иргэдийн хувьд Монголын нийгэмд эрх тэгш оролцох боломж бололцоо хэр байдаг вэ? Түүнд нь саад болоод байгаа хүчин зүйлс юу байдаг вэ?

Бид нар хүртээмжтэй орчин гээд ярихад, хүмүүс зөвхөн налуу зам, лифт гэж ойлгоод байдаг. Гэтэл хараагүй болон сонсголгүй хүний хувьд хүртээмжтэй орчин маш нарийн, тодорхой байх ёстой. Өөрөөр хэлбэл сонсголгүй хүний хувьд хараан дээр мэдээллээ хүлээн авдаг учраас аливаа эмнэлэг, байгууллагад ороход тухайн байгууллагын танилцуулга, өрөөний байрлал, хэдэн номерын өрөөнд ямар үйлчилгээ үзүүлэх вэ, хэнээс яаж үйлчилгээ авах вэ? гэдэг тэр бүхэн зурган болон дүрслэл, схем хэлбэрээр байх нь маш чухал. Хоёрдугаарт, бүх байгууллагын рэсэпшн эсвэл үйлчилж байгаа хүн сонсголгүй хүнтэй ойлголцох дохионы хэлгүй байгаа. Тэгэхээр дохионы хэлний видео дуудлага гэдэг фэйсбүүк үйлчилгээг бид нар 2020 онд фэйсбүүкийн видео чат колыг ашиглаад нээсэн. Тэрийг ашиглаад хоорондоо харилцах боломжтой. Тэгэхгүй бол сонсголгүй хүн алхам тутамдаа харилцааны хүндрэлтэй тулгарч байдаг. Энэ сонсголгүй хүний буруу биш, нийгмийн буруу, нийгмийн хариуцлага. Яагаад гэвэл нийгэм хүртээмжтэй биш байна. Энэ ардчилсан, эрх чөлөөт гээд 30 жил тунхаглаад байгаа нийгэм чинь хүртээмжгүй байгааг л харуулж байгаа юм. Тэгэхээр сонсголгүй хүмүүст хамгийн гол тулгардаг бэрхшээл бол харилцааны бэрхшээл. Өөрөөр хэлбэл мэдээлэл авч, үгээ хэлж чадахгүй байна. Яг энэ хэрэгцээн дээр гол зогсох үйлчилгээ юу вэ? гэвэл дохионы хэлний хэлмэрчийн үйлчилгээ. Ютүб (youtube) дээр бүх зүйлс сабтайтл (subtitle) буюу хадмал орчуулгатай болчихсон. Яг үүн шиг зурагтын бүх нэвтрүүлгүүд хадмал орчуулгатай болж байж сонсголгүй иргэд мэдээллийг хүртээмжтэйгээр хүлээж авна. Сонсголгүй иргэд чинь гаднаасаа харахад хөгжлийн бэрхшээлтэй гэдэг нь мэдэгддэггүй, сонсголгүй хүн гээд таних ямар ч боломж байдаггүй. Хоёр гурвуулаа явж байхдаа дохионы хэлээр ярьж байвал энэ сонсголгүй хүн байна гэж харагдахаас биш ганцаараа явж байгаа тохиолдолд хэн ч "тэр хүнийг сонсохгүй байна, энэ хүний ард машин тулаад ирэхэд, тэр машины сигналыг сонсохгүй шүү" гэдэг ойлголт байхгүй. Хараагүй эсвэл тэргэнцэр хэрэглэдэг хүмүүс бол маш ойлгомжтой байдаг. Нийгэм энэ хүн хөгжлийн бэрхшээлтэй байна, магадгүй энэ хүнд тусламж хэрэгтэй юм болов уу, туслах уу? гэдэг байдлаар хардаг. Гэтэл сонсголгүй

хүмүүс тийм биш. Дээрээс нь хүмүүстэй ярилцахад зарим хүмүүс их нүүрэмгий дохио зангаагаар ойлголцох гээд л, бичиг бичээд л харьцдаг. Тэр харилцаа их дөхөмтэй байдаг. Нийгмийн хандлага бол хөгжлийн бэрхшээлтэй эсвэл сонсголгүй хүмүүсийг маш их доош нь хийж, дорд үзэж хардаг. Яагаад гэвэл дэлхий даяар тэр дундаа Азийн соёлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг удам судрын нүгэл хилэнцтэй холбоотойгоор хөгжлийн бэрхшээлтэй болсон гэж тайлбарлах үзэл маш их байдаг. Түүнээс болоод тухайн хүнийг ялгаварлан гадуурхах үзэгдэл үүсдэг. Гэтэл яг үнэндээ энэ тухайн хүний буруу биш.

Тухайн хүн удмынхаа нүгэл хилэнцийг үүрээд ийм болж байгаа юм биш. Дэлхийн хүн амын 15% нь хөгжлийн бэрхшээлтэй байгаа, энэ бол маш бодит тоо. Дэлхий дээрх 7 тэрбум хүний 15% гэхээр маш олон сая хүн байгаа шүү дээ. Тэгэхээр нийгэм үүн дээр хандлагаа өөрчлөх нь зүйтэй. Одоо хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах тухай Боловсролын сайдын тушаал гарсан. Аутизм эсвэл Дауны хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургууль, цэцэрлэгт хамруулаад явж байгаа. Гэхдээ “энэ хүүхдийг яагаад миний хүүхдийн ангид байлгаж байгаа юм” гэсэн бусад эцэг эхчүүдээс ирж байгаа гомдол маш их сөрөг нөлөөтэй. Яагаад гэвэл хөгжлийн бэрхшээл бол халдварт өвчин биш. Танай хүүхэд хөгжлийн бэрхшээлээс халдварлаад өвчин авна гэсэн юм байхгүй. Харин ч хүнийг ойлгодог, энэрдэг сэтгэл зүй багаас нь сууна. Би таны урилгыг аваад өөрийнхөө бага насыг санасан. Намайг жоохон байхад манай өөдөөс харсан хөрш айлд саажилттай хүү байсан. Багаасаа дүү нар найзлаад, ах эгч нар найзлаад явчихдаг, үе үеийн найзууд байдаг шүү дээ. Тэр хүүхэдтэй бид нар найзалдаг байсан. Тэр хүүгийн баруун гар, хөл нь саажилттай байсан. Тухайн үедээ энэ хүүхэд надаас ах байж яагаад бичиг үсэг сураагүй юм бол гээд бичиг заах гээд л үзэж тарж байсан. Тэгээд энэ хүүхэд бол миний найз, надаас ерөөсөө ялгаагүй гэдэг тийм ойлголтыг надад өгсөн. Би сонсголгүй хүнийг эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ямар нэгэн байдлаар дорд үздэггүй. Яг хувь хүн гэдэг талаас нь хүндэлж, тэр хүн бас эрхтэй, надтай адилхан хүн гэдэг талаас нь ханддаг. Энэ хандлага маань хаанаас суусан бэ гээд би бодоход яг тэр бага насны найз нөхөрлөлөөс үүссэн гэдгийг ойлгож байгаа юм. Тэгэхээр нийт эцэг эхчүүдэд хэлэхэд хэрвээ танай хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй найзалж байвал, танай хүүхдийн ангид хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байвал хүүхдэдээ маш эергээр ойлгуул. “Энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бол чамтай л адилхан хүүхэд, харилцааны хэлбэр нь л өөр. Чи гүйдэг бол энэ хүүхэд тэргэнцэр хэрэглэдэг, чи амаараа ярьдаг бол энэ хүүхэд дохионы хэлээр ярьдаг” гэдэг байдлаар хүүхдэд маш зөв, эерэг ойлголтыг өгч байгаач гэж эцэг эхчүүдэд хандаж хэлмээр байна.

Монгол улсын статистикийг харахад 2020 оны байдлаар 8,000 гаруй сонсголын бэрхшээлтэй хүн байдаг гэж

бүртгэгдсэн байна. Эдгээр иргэдийн маань боловсрол, ажил хөдөлмөр эрхлэлт, гэр бүл зохиох гэх мэт амьдралын үйл явц нь ямархуу байна вэ?

Монголд яг өнөөгийн байдлаар сонсголын бэрхшээлтэй 8,000 хүн байгаа ч, хэл ярианы бэрхшээлтэй бараг 14,000 хүн байна гэж ярьдаг. Тэр нь хожуу сонсголоо алдсан эсвэл тагнай цоорхой гэх зэрэг хэл ярианы янз бүрийн бэрхшээлтэй хүмүүсийн тоо, статистик байдаг. Тэгэхээр энэ 2 тоог хамтад нь харж явах хэрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй орчныг бүрдүүлэхэд нийт хүн амд маш таатай орчин бүрддэг. Тэгэхээр телевизээр хадмал орчуулгатай нэвтрүүлэг явахад хожуу сонсголоо алдсан бидний эмээ, өвөө нарт ч гэсэн мэдээлэл хүртээмжтэй болно гэсэн үг. Сонсголгүй хүмүүс яг бусдын л адил гэр бүл болж, үр хүүхэд төрүүлж, ажил хөдөлмөр эрхлээд явдаг. Хэл ярианы хувьд бие биеэ ойлгох ёстой учраас ихэнх нь хоорондоо суудаг. Ихэнхдээ тохиолдолд хүүхдүүд нь сонсголтой төрдөг. Тэгэхээр сонсголгүй эцэг эхтэй гэр бүлд төрж байгаа сонсголтой хүүхдүүдийг бид нар КОДА (CODA, Children of Deaf Adults) гэдэг. Эд нар маань хос хэлтэй болдог. Тэгэхээр угаасаа хэлээ мэдэж байгаа учраас эд нар дундаас бид хэлмэрчдийг бэлдэж авах сонирхолтой байдаг. Тэд маш богино хугацаанд хэлмэрч болох боломжтой. Ажил хөдөлмөр эрхлэх харилцаанд гэрээ байгуулах үед тухайн байгууллага нь хэлмэрч дуудаагүй тохиолдолд хөдөлмөрийн хувьд хохирох асуудал их байдаг. Хэрвээ та хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилд авахыг хүсэж байгаа бол тухайн хүнтэйгээ харилцах, гэрээ байгуулахдаа хэлмэрч захиалаад, маш сайн ойлголцвол хэрэгтэй байдаг. Мэдээж бүх ажлыг хэлмэрчтэй хийхгүй



ч гэсэн байгууллагын гол хуралд эсвэл гол гэрээний үед хэлмэрчээр дамжуулж тухайн хүнтэйгээ ойлголцвол илүү үр дүнтэй. Сонсголгүй хүмүүс маш хөдөлмөрч, шударга хүмүүс байдаг. Ер нь харилцааны 93% нь үгийн бус харилцаа байдаг шүү дээ. Тэр 93% буюу нүүр амны хөдөлгөөн, царайны хувьсал, биеийн хэл гэдгээс сонсголгүй хүн тухайн хүнийг ямар хандлагатай, ямар хүн бэ гэдгийг ойлгоод л мэдээд л явж байгаа. Тэгэхээр харилцааны 7% дээр л та тэр хүнтэй харьцахдаа нэг бол бичгээр, нэг бол дохионы хэлний хэлмэрчээр харьцах шаардлагатай.

Та өмнө нь яриандаа сонсголын бэрхшээлтэй хүмүүс ихэвчлэн биеийн хүчний ажил хийдэг гэж дурдаж байсан. Монголд сонсголын бэрхшээлтэй иргэд ямар төрлийн ажил хийж байна вэ?

Сонсголгүй иргэдийг мужаан, цэцэгчин, оёдолчин гэсэн чиглэлээр бэлтгэж байгаа. Хэрвээ бид нар багаас нь хүүхдийг эцэг эхийнх нь хамт эрт оролцооны хөтөлбөрт хамруулаад, сургуулийн өмнөх боловсрол, арван жилийн бүрэн дунд боловсролыг хос хэлээр ороод явчихвал тэр хүүхэд их, дээд сургуульд сураад ямар ч мэргэжлийг эзэмшээд, ямар ч ажил хийх боломжтой. Хэн ч болж болно. Тэгэхийн тулд бид энэ боловсролын арга зүй, систем дээрээ маш их өөрчлөлтийг хийх шаардлагатай. Сүүлийн үед цэцэрлэгийн багш, биеийн тамирын багш зэрэг мэргэжлээр маш олон сонсголгүй иргэд их, дээд сургууль төгсөж байна. Түүхч, философич гээд шинжлэх ухааны академид ажиллаж байгаа сонсголгүй хүн ч байдаг. Янз бүрийн менежерийн, бичиг хэргийн, оффисын туслах ажилтан хийж байгаа сонсголгүй хүмүүс бас байдаг. Мэдээж барилга барилаа гэхэд тоосгыг маш сайхан жигдхэн өрдөг, вакуум цонх хийлээ гэхэд маш нарийн хэмжиж, төгс нямбай хийдэг гээд хийсэн ажил дээрээ маш үр дүнтэй ажилладаг. Гэхдээ боловсрол эзэмшиж оюуны хөдөлмөр хийж явдаг хүмүүс бас байна.

Нийгмийн хандлага ч гэсэн сүүлийн үед сайжирч байна гээд хүмүүс ярьдаг. Тэгэхээр танай ДХХОХ-нд хандаж дохионы хэлний хэлмэрч орчуулагчийн үйлчилгээ авч байгаа газрууд хэр их байна? Та фэйсбүүкээр бас үйлчилгээ үзүүлдэг болсон гэсэн. Тэр үйлчилгээг нийгмийн зүгээс хэр хүлээж авч, ашиглаж байна вэ?

Дохионы хэлний видео дуудлага гээд фэйсбүүкт суурилсан үйлчилгээг бид нар Монголд ковидын анхны тохиолдол гарсан яг тэр үед байгуулж байсан. Яагаад гэвэл хэрвээ сонсголгүй хүн эмнэлэгт хандвал, тэр үйлчилгээ хүртээмжгүй юм байна. Тийм учраас хэлмэрчид бид нар сонсголгүй иргэдийн хамгийн түгээмэл ашигладаг нийгмийн сүлжээ болох фэйсбүүкийг ашиглаад үйлчилгээ нээж байсан. Одоо сонсголгүй хүмүүсээс өдөрт 30-40 дуудлага байнга авдаг. Өөрөөр хэлбэл эмнэлэг, цагдаа дуудаж байна, эцэг эх, хүүхдийнхээ багштай ярьж байна, хөдөлмөр эрхэлж байна эсвэл оюутан бол багштайгаа ярьж байна. Бас банкны үйлчилгээ авахад

ашиглаж байна гэх мэтчилэн амьдрал баян учраас бүх л харилцаанд энэ үйлчилгээг ашиглаж байна. ДХХОХ-той гэрээ байгуулаад тодорхой сургалт, үйл ажиллагаандаа хэлмэрчдийг биечлэн эсвэл зүүмээр хөлсөлж ажиллуулдаг бараг 40-50 байгууллага байдаг. Энэ жил Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам маань дуудлага цэг мн (www.duud-laga.mn) гээд зайн үйлчилгээ нээсэн. Яамны сайд Ариунзаяа маань санаачилга гаргаад, дохионы хэлний видео дуудлага болон дуудлага цэг мн 2-ыг нэгтгэе гэсэн процесс үйл явц дундаа явж байгаа. Энэ шилжилт бүрэн хийгдээгүй байгаа учраас одоо хүртэл бид нар дохионы хэлний видео дуудлагаараа үйлчилгээ авсаар байгаа. Сонсголгүй хүмүүс мэддэг учраас тэд нар ихэнхдээ энэ үйлчилгээг ашигладаг. Болвол бүх байгууллагууд угтах үйлчилгээндээ энэ үйлчилгээг ашиглавал их зүгээр санагддаг. Яагаад гэвэл тухайн сонсголгүй хүнтэй харьцах үед тэр хүний хүсэж байгаа үйлчилгээг асууж, үйлчлэхийн тулд дохионы хэлний видео дуудлагыг ашиглах боломжтой. Дуудлага цэг мн дээр өдөртөө ирж байгаа дуудлагыг харахад хоёр гуравхан ч юм уу ер нь цөөхөн дуудлага ирдэг. Шалтгааныг нь үзэхэд сонсголгүй хүмүүс ороод ирэхэд аппликэйшн, систем, интернет сүлжээний аль нэг нь маш их удаж, их хүлээгдэж байна гэсэн гомдлыг бидэнд ирүүлдэг. Дохионы хэлний видео дуудлага бол их хурдтай байна, дуудахад шууд авчхаж байна гэж хэлдэг. Тэгэхээр бид "та нар хүлээ, бид нар энэ шилжилтийн үйл явцад техник талаасаа, сүлжээ талаасаа сайжруулах хэрэгцээ байгаа байх" гээд тайлбарлаж байгаа. Гэхдээ бид нар дохионы хэлний видео дуудлагаа бүрэн хаагаагүй, зэрэг ажиллуулаад явж байгаа. Яагаад би үүнийг онцолж хэлж байгаа вэ гэвэл энэ шилжилтийн үйл явц мэдээж хугацаа, хөрөнгө, хүн хүч шаардана. Тэгэхээр ирээдүйд энэ үйлчилгээ сайжирна, харин энэ хийх явцдаа бид нар хаана, ямар алдаа дутагдал байна, аль нь илүү үр дүнтэй байна вэ? гэдгийг хараад, ярилцаад, шийдээд явах байх. Манай холбоонд хандаад дохионы хэлний хэлмэрч болъё гэсэн хүмүүс маш их байдаг. Дохионы хэлний хэлмэрч болохын тулд дохионы хэлээ сурах хэрэгтэй. Тэрний дараа хэлмэрч болно. Тэгвэл дохионы хэлийг сурах үнэгүй сургалтуудыг янз бүрийн хэлбэрээр Сонсголгүйн боловсрол гэдэг төрийн бус байгууллага маань зааж байгаа. Тэндээс дохионы хэлийг сураад, дараа нь гүнзгийрүүлээд хэлмэрч болоход боломж нээлттэй байгаа шүү.

Манай подкастын цаг өндөрлөх дөхөж байна. Танаас сүүлийн асуултаа асууя. Танай холбооны цаашдын алсын хараа, зорилго нь юу вэ? Цаашдаа юу хийхээр төлөвлөж байна вэ?

ДХХОХ яг мэргэжлийн дохионы хэлний хэлмэрчдийг бэлтгээд, сонсголгүй иргэдэд хүртээмжтэй үйлчилгээ үзүүлье гэсэн зорилготой. Тэгэхээр энэ алсын харааныхаа чиглэлээр бид нар ажиллана. Мөн ижил зорилготой сонсголгүй хүүхдийн боловсролын чиглэлээр ажилладаг бусад төрийн бус байгууллага,

төр, олон нийтийн байгууллагатай хамтарч ажилладаг. Тэгэхээр бид нарын хүсэл мөрөөдөл бол дуудлага цэг мн-ийн видео дуудлага нь нийтэд түгээд, ямар ч байгууллагад ороход тухайн байгууллагын ажилтнууд тэр үйлчилгээг бүгд мэддэг, ашиглаад сонсголгүй хүнтэй ярьдаг, сонсголгүй хүмүүс хаана ч орсон, хэнтэй ч уулзсан зайн дүрс яриа, орчуулгын үйлчилгээгээр нийгэмд хүртээмжтэйгээр харьцаад, эрх тэгш амьдраад яваасай л гэж бид хүсдэг.

Цаг зав гарган манай подкастын урилгыг хүлээн авч, үнэтэй яриа өгсөн танд маш их баярлалаа. Таны болон танай холбооны цаашдын ажил үйлст томоос том амжилтыг хүсье ээ!

Маш их баярлалаа. Танай хамт олонд бас өндөр амжилтыг хүсэн ерөөе! Урьж оролцуулсанд маш их баярлалаа.

МОНГОЛД ДОХИОНЫ ХЭЛНИЙ ХЭЛМЭРЧ, ОРЧУУЛАГЧ НАР ИЛҮҮ ОЛОН БОЛООСОЙ



Ж.Оюунчимэг

Сайн байцгаана уу, эрхэм хүндэт сонсогчид оо, Антолд подкастын маань ээлжит дугаар эхлэхэд бэлэн болоод байна. Энэхүү дугаарт Монгол улсын гавьяат багш согог зүйч, хэл засалч Оюунчимэг оролцож байна. Та манай подкастын урилгыг хүлээн авсанд маш их баярлалаа. Юуны өмнө манай сонсогчдод өөрийгөө танилцуулахгүй юу?

Жамбал овогтой Оюунчимэг би Улаанбаатар хотын Сүхбаатарын нэрэмжит арван жилийн 2-р дунд сургуулийг 1970 онд төгсөөд, өөрийнхөө хүсэл эрмэлзлийнхээ дагуу багшийн сургуульд элсэн орсон. Багшийн сургуулийг тусгай хэрэгцээт боловсролын багш мэргэжлээр төгссөн ч би багаасаа сонсголын болон харааны бэрхшээлтэй хүүхдүүдэд туслах хүсэлтэй байсан. Багшийн сургуулиа төгсөөд боловсролын яамны сайдын томилолтоор 29-р тусгай дунд сургуульд бага ангийн багшаар очиж 2 жил ажиллан 2 анги төгсгөсөн. Надад 1-р анги өгнө гэхэд нь би 2 жилийн дараа энэ чиглэлээрээ дээд сургуульд явж нарийн мэргэжил эзэмших хүсэлтэй гэдгээ сургуулийн захиргаанд хэлсэн. Аз болж 2 багш жирэмсний амралт аваад би 2 анги төгсгөсөн түүхтэй. Яагаад тэр ангиудыг авсан бэ гэвэл би 2 жил ажиллаад явах учраас хүүхдүүдийн хувь заяаг харгалзан үзсэн юм. Тэгээд сургуульдаа 2 жил ажиллаад Оросын Холбооны улсын Иркутск хотын Багшийн дээд сургуулийн технологийн факультетад

суралцаж ирээд эргээд 29-р тусгай дунд сургуульдаа согог зүйч, хэл засалч багшаар томилогдон 2019 он хүртэл ажилласан.

Та анх 29-р сургуульд очоод багшилъя гэсэн сэтгэгдэл юунаас төрсөн бэ? Тэрний талаар дэлгэрүүлж ярихгүй юу?

Би арван жилд 2-р дунд сургуульд сурч байхдаа нэгдүгээр эмнэлгийн хамар хоолойн тасагт хагалгаа хийлгэхээр хэвтсэн юм. Тэгэхэд тэнд нэг сонсголын бэрхшээлтэй охин байсан. Манай өрөөнд ихэвчлэн настайвтар хүмүүс байсан. Тэр охин над дээр ирэхэд би сонсголын бэрхшээлтэй хүүхэд гэдгийг нь мэдэрсэн. Би хурууны үсгийг бага зэрэг сурчихсан байсан учраас дохиод юм хэлэхээр нь би бүгдийг нь маш сайхан ойлгож байсан. Эмнэлэгт шил хэрэгтэй, шүлсээ хаяна. Шил гэвэл ингээрэй, ус ууна гэвэл ингээрэй гээд надад хурууны үсгээр хэлж өгч байсан. Тэр цаг үеэс би энэ сургуульд ажиллах гэсэн хүсэл мөрөөдөлтэй болсон.

Та анх 29-р сургуульд социализмын үед багшилж байсан. Мөн ардчилал руу шилжиж байх үед бас багшилж байсан. Тэгэхээр таны багшилж байх үед сургуулийн арга зүй хэрхэн өөрчлөгдөж байсныг та харж байсан байх. Тэр талаар ярьж өгөхгүй юу?

Намайг 29-р сургуульд социализмын үед багшаар очиход Полина Грамаева гэдэг Оросын мэргэжилтэн багш манай сургуульд мэргэжилтнээр ажиллаж байсан. Төр засгаас манай сургуулийг цаашид хөгжүүлэх тал дээр зөв бодлого явагдаж байсан гэж би бодож байна. Тухайн үед Хорлоо гээд Боловсролын яамны сайд байхдаа манай 29-р сургуулийг байгуулагдахад энэ хүүхдүүдийг сургах хэрэгтэй гэсэн анхны том алхмыг хийсэн хүн гэж би боддог. Тэнд ажиллаж байх үедээ Полина багшаасаа маш зүйлийг сурч авсан учраас би их азтай хүн. Мөн Светлана Чупрова гээд Якут багш манайд ажиллахаар ирж байсан. Эхний үедээ Светлана Монгол хэл мэдэхгүй, бид хоёр харьцаж, Светланагаас би нэлээд зүйлийг суралцаж байсан.

Тухайн үед сургалтын арга зүй нь ямар байсан бэ? Одоо яаж өөрчлөгдсөн бэ?

Тухайн үед захирал Лантуу гээд Орост төгссөн согог зүйч багш байсан. Хичээлийн эрхлэгч Батхүү гээд Унгарт төгссөн хүн байсан. Энэ хүмүүс тухайн цаг үедээ сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулан монгол хэлний багш нар, бид нарыг татан оролцуулж дохионы хэлний ном бичих, цагаан толгой хийх ажил хийж байсан. Анх ерөөсөө л 2 багш, 1 мэргэжилтэн, Светлана багш байсан бол 1980-90-ээд оны үед согог зүйч багш 30 гаруй болсон.

Одоо хос хэл соёлын арга зүй маягаар явдаг гэж би сонсож байсан. Социализмын үед ихэвчлэн яаж сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдэд хичээл заадаг байсан бэ?

Тэр 1970-аад оны үед хурууны үсэг,



тодорхой хэмжээгээр дохионы хэл дээр хичээл заадаг байсан. Дохионы хэлний жижигхэн гарын авлагыг Лантуу багш өөрөө зохиож гаргасны дагуу багш нар сургалтаа явуулж байсан. Тухайн үедээ дохионы хэлэнд суурилаад аман ба бичгийн хэл гэсэн арга зүйгээр хичээллэж байсан.

Одоо дандаа дохионы хэлээр яваад хажууд нь бичгийн хэлийг авч явдаг уу?

Юм чинь байнга урагшаа хөгжиж явдаг учраас сүүлийн үед дэлхий нийтээрээ "сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийн төрөлх хэл бол дохионы хэл" гэдэг болсон. Дохионы хэлийг илүү чухалчилна гэсэн арга зүй яригдаж байгаа.

Та анх 29-р сургуульд 2 жил багшилж байхад ямар байсан бэ? Тэрний дараа Орост явж сурч ирчхээд дахиад багшлахад танд ямар байсан бэ? Танд ямар ямар саад бэрхшээлүүд тулгарч байсан бэ?

Анх багш болоод очиход нэгдүгээрт би хараагүй хүүхдүүдэд цагийн хичээл ордог байсан. Тэгэхэд брайль үсэг үнэхээр мэдэхгүй учраас анх тэнд очоод сурч байсан. Дохионы хэлийг би бараг тухайн үедээ хүүхдүүдээсээ суралцаж эхэлсэн. Энэ бол их давуу тал. Тэгээд би Полина багштайгаа хамтраад дохионы хэлийг суралцаж, авиаг яаж хүүхдэд тавих вэ гэсэн анхан шатны арга зүйг 2 жил ажиллах хугацаандаа эзэмшиж байсан. Тэнд 10-аад жил ажилласан ахмад туршлагатай багш

нар өөр өөрсдийн гэсэн өвөрмөц арга зүйгээ шинээр ирж байгаа багш нартаа зааж сургаж ажилладаг байсан.

Одоо сургалтын систем нь багш нар Монгол Улсын Боловсролын их сургуулийг төгсөөд шууд 29-р сургууль дээр очдог уу?

Боловсролын их сургуулийг төгссөн багш нарыг бид авч сургадаг. Хамгийн гол нь тэр сургуулийг зорин очиж байгаа залуу багш гэдэг утгаар нь бид нар маш хүндэтгэлтэй хүлээж авдаг. Согог зүйч болоод олон жил ажилласан дадлага туршлагатай багш нараасаа бид эхний ээлжинд сургалт зохион байгуулж, зөвлөгөө өгч, хамтран ажиллах, халамжлан хүмүүжүүлэх сайхан үйл ажиллагаа явагддаг байсан. Ахмад, туршлагатай багш нар залуу багш нарыгаа дагаад өөрийнхөө туршлага, мэдлэг, орчин үеийн арга зүйгээс суралцах тал дээр үнэтэй зөвлөгөөгөө өгч ажилладаг байсан.

Тухайн үед 29-р сургуульд сурч байгаа сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдэд тулгардаг ямар нийтлэг асуудал, саад бэрхшээл гарч байсан бэ?

Манайх улсын хэмжээний ганц сургууль байсан учраас дотуур байртай, хөдөө орон нутгаас хүүхдүүдийг авч сургадаг. Тухайн үедээ 8 настай хүүхдүүд ирдэг байсан бол сүүлийн үед 6 настанууд ирдэг болсон. Ээж аавынхаа өврөөс дөнгөж гарсан хүүхдүүд ээж аав нь буцаад явахаар маш хүнд санагддаг байсан. Гэхдээ бид нар хоорондоо ярилцаад ээж аавтай нь боломжтой бол нэг сар, боломжгүй бол 7-14 хоног хамт байранд нь байлгаад, сэтгэл зүйн тал дээр нь сургуульдаа, байрандаа дасаж өөрийн гэр шиг амьдрах боломжийг бүрдүүлдэг байсан. Бид сургалтдаа анхаарал төвлөрүүлээд зогсохгүй дотуур байрныхаа, өөрийнхөө ангийн хүүхдүүдэд илүү их анхаарал тавих хэрэгтэй болдог байсан. Яагаад гэвэл тэд хөдөө орон нутгаас ирсэн, манайх 3 давхар дотуур байртай, 2 асрагч хонодог. Мөн залуу багш нарыг асрагч багш нартай хамт жижүүр хийж хонуулна. Хүүхдүүдийг унтуулах гэхээр зарим нь унтахгүй, зарим нь яг ээжийнхээ өврөөс ирсэн учраас шөнө хүүхдүүдийг босгож бие засуулах зэрэг туслах ажлыг бид сэтгэлээсээ хийж ажилладаг байлаа.

Улсын хэмжээнд ганц л сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан сургууль байгаа. Тэгэхээр заримдаа бүр олон хүүхэд элсэх хүсэлтэй тийм тохиолдол одоо гарч байсан уу?

Тийм тохиолдлууд гарч байсан. Гэхдээ аль болохоор бид нар хүүхдүүдээ элсэлтийн комиссоор оруулж намар 8 сарын 15-аас эхлээд хүүхдүүдээ шалгаж авдаг байсан. Үүний хажуугаар цэвэр сонсголгүй хүүхдээс гадна сул сонсголтой, сонсгол нь бага зэрэг алдагдсан хүүхдүүдийг зарим эцэг эхчүүд манай сургуульд оруулах гээд байдаг байсан. Уг нь эрүүл, манай сургуулийн хүүхэд биш байхад л манайх дотуур байртай, хоол ундтай учраас оруулах хүсэлтэй байдгаас энэ байдал

дээр жаахан маргаанууд гардаг байсан.

Тэгэхээр зарим эцэг эхчүүд амьдралын хэцүү шаардлагаар оруулах хүсэлтэй байж ээ?

Амьдралын шаардлагаас болж тийм асуудлууд гардаг байсан.

Таныг багшилж байх хугацаанд эцэг эхчүүдийн хандлага ямар байдлаар ажиглагддаг байсан юм бэ?

Би дөнгөж багш болоод ажиллаж байхад зарим эцэг эхчүүд үнэхээр хүүхдийнхээ төлөө гэсэн сэтгэлтэй хичээлийн хэрэглэгдэхүүн, хувцас хунар бүх юмыг нь сайхан бэлтгээд өгдөг байхад зарим нь ангийн багш, сургуульд даатгаад явдаг хүмүүс ч бас байдаг байсан. Хотынхон бол тийм биш л дээ. Тухайн үедээ хүүхдийн тоо харьцангуй цөөхөн байсан учраас хотын Яармаг, Нисэх, Амгалангаас ирсэн хүүхдүүдээ бид дотуур байрандаа оруулдаг байсан. Тэр үед ойролцоогоор 300 гаруй хүүхэд байсан гэтэл 1990-ээд оноос эхлээд 600 гаруй хүүхэдтэй бид нар ажилладаг байсан. Тэгээд 2019 онд гэхэд манай сургуулийн хүүхдийн тоо цөөрөөд 300 гаруй болсон санагдаж байна. Яагаад хүүхдийн тоо цөөрснийг мэдэхгүй. Биднийг залуу байхад цалин хөлсний улсын хорооноос шууд томилолтоор явуулаад, бид нар хөдөө орон нутгаас өөрсдөө хүүхдүүдээ шалгаад, сонгож авдаг байсан. Тухайн үед үнэхээр сонсголын буюу харааны бэрхшээлтэй хүүхдүүдийг сургуульд хамруулах үйл ажиллагаа маш сайн явагдаж байсан. Төгсөөд ирсний дараа энэ байдал алдагдсан. Гэтэл сүүлд Хөвсгөлийн бүр захын суманд гэртээ сонсголын бэрхшээлтэй бараг 5-6 хүүхэд нь сургуульд хамрагдаагүй явдлууд байна гээд янз бүрийн төслүүд маш их хэрэгжсэн нь үр дүнтэй болсон.

Та цэцэрлэгтэй холбоотой нэг төсөл хэрэгжүүлж байсан гэсэн. Тэрнийхээ талаар ярьж өгөхгүй юу?

Өнгөрсөн 2006-07 оны хичээлийн жилд манай сургуулийг төгссөн Юмжирдулам, Хэлмэрчийн холбооны тэргүүн Соёлмаа 2 надтай уулзахаар ирсэн. Аялалд явж байсан нэг хүн өөрт байсан 1,000 доллароор баянтай ажил хийх хүсэлтэй байна гэснийг би сайхнаар хүлээж авсан,





сайхан ч санагдсан. Бид нар цэцэрлэгтэй болохыг их хүсэж мөрөөддөг байсан. Тэгээд би дотуур байрныхаа урд талын хэсэгт газар өгөөд, 186-р цэцэрлэгийн суурь анх тавигдаж, Бамбарууш нэртэй цэцэрлэг нээгдсэн. Энд цэцэрлэгт манай сургуулийн туршлагатай согог зүйч багш нар хамтарч хөтөлбөр боловсруулаад хүүхдүүдэд хичээл зааж байсан. Швецарийн Хөгжлийн Агентлаг үнэхээр манай сургуульд их зүйлийг хийж тусалж өгсөн.

Өмнө нь сонсголын бэрхшээлтэй хүүхдүүд явах цэцэрлэг байдаггүй байсан гэсэн үг үү?

Сүүлд хороололд 76-р цэцэрлэг байсан. Би 1993 онд шинээр анги авахад 76-р цэцэрлэгээс манай ангид нэлээд олон хүүхэд орж ирсэн. Манай согог зүйч багш нар очиж тусгай сурганы хэл засал, дохио, биет гэсэн хичээлүүдийг ордог байсан. Яг тэр 1993 онд миний авсан хүүхдүүд дохиотой, хурууны үсэгтэй, хоорондоо хөөрхөн харьцдаг байсан. Цэцэрлэгийн давуу талыг тэндээс би олж харсан. Яг энэ ангиа би 1993-2003 он хүртэл авч явсан. Манайх суурь боловсрол олгодог байсан юм. Сүүлдээ бид нар хүүхдүүдийнхээ боловсролд анхаараад тэр үед ч гэсэн улсын хэмжээгээр гүнзгийрүүлсэн сургалттай анги нээгдэж байсан. Манай согог зүйч багш нар, сургуулийн удирдлагууд ярилцаад өөрсдийнхөө оюуны чадавх сайтай хүүхдүүдийн ирээдүйг нь бодож их, дээд сургуульд оруулах бэлтгэл болгоод гүнзгийрүүлсэн анги нээж 8-р ангид суурь боловсрол олгоод, 9-10-р ангид нь гүнзгийрүүлсэн сургалттай ангид сургаж бүрэн дунд боловсрол олгох анхны үе шат эхэлж байсан.

Одоо ч гэсэн тэр маягаар явдаг уу?

Одоо манайх бүрэн дунд боловсрол олгодог.

Одоо ахлах ангидаа яаж хичээлээ зааж байгаа вэ? Дунд, бага ангид нь яаж заадаг вэ?

Бага ангид ихэвчлэн дохионд суурилаад аман ба бичгийн хэлээр хичээл явагдаж бага боловсрол олгож байгаа. Гэхдээ төрийн бус байгууллагуудын санал болгосны дагуу хичээлийн хөтөлбөрт нэлээд өөрчлөлт орсон. Ахлах ангид дохионы хэлэнд суурилаад аман ба бичгийн хэлэнд сургах үйл ажиллагаа явж байгаа байх. Гэхдээ би сургууль дээр ажиллаагүй удсан учраас одоогийн үйл ажиллагаа яаж явагдаж байгааг тодорхой хэлэхэд жаахан тийм байна. Янз янзын

шүүмжүүд их байгаа. Аль болохоор дохионы хэл, дохионы хэл, дохионы гээд л байгаа. Дохионы хэл бол үнэхээр хэрэгтэй. Дохионы хэлээр ялангуяа олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд бага хугацаанд маш их юмыг ойлгож мэдрүүлэхэд маш үр дүнтэй байдаг. Хэлмэрчдийн холбоо болон манай сургуулийг төгссөн бусад хүүхдүүдтэй сургууль залгамж холбоотой ажиллаж байгаа гэж бодож байна. Би удирдлага байхдаа янз бүрийн шугамаар сургалт хүмүүжил, хүмүүнлэгийн талаар нэлээд хамтарч ажилладаг байлаа.

Миний гайхаж байгаа зүйл гэвэл сонсголын бэрхшээлтэй хүүхэд аман хэлийг сурна гэхээр яаж сурдаг, яаж сургадаг байсан юм бол?

Би нэг жишээ татъя. Яг 1975 оны хичээлийн жил хотын боловсролын газрын дарга Батмагнай гэж хүн байсан юм. Тухайн үед сургуулиудаар шалгалт хийж, сургалтын үйл ажиллагаанд нь хяналт шинжилгээ хийж явдаг байсан. Батмагнай дарга манай ангид суухад миний анги 4-р анги байсан учраас урууллараа унших, биет зүйл гэсэн хичээлүүд ордог байсан. Ялангуяа биет зүйлийн хичээл хүүхдүүдийг бодитой хэл ярианд сурахад маш чухал хичээл. Мөн бид урууллаас унших тусгай хичээл ордог байсан. Багш шууд орж ирээд амнаасаа “сайн байцгаана уу, хүүхдүүд ээ, сайхан амарцгаасан уу, бүгдээрээ хичээлдээ оръё” гээд хэлдэг. Жишээлбэл өвлийн тухай сэдэв байхад өвлийн холбогдолтой цас, ичих гэх зэрэг үг хэллэгүүдийг дандаа урууллаас өгдөг. Та нарт ойлгуулахад амнаас сонсоно гэсэн үг. Тэр хичээлийн яг дараагийн цагт өмнөх цагийн хичээлийнхээ агуулгаас оруулаад Монгол хэлнийхээ хичээлтэй холбоод амнаасаа цээж бичиг бичүүлдэг байсан. Яг тэр цаг дээрээ Батмагнай дарга орж ирсэн. Хүүхдүүд маань миний амнаас гарч байгаа үг, холбоо өгүүлбэрүүдийг уншаад, яг цээж бичиг бичдэг шиг бичиж байсан. Хичээлийн дараа Батмагнай дарга цээж бичгийг нь харъя гэсэн. Нэгдүгээрт, тэр үед бид нар энэ хичээлийг маш сайн оруулж байсан. Хоёрдугаарт, монгол хэлний багшийнхаа амнаас хүүхэд маш чөлөөтэй, сонсож байгаа юм шиг үгийг авдаг гэдгийг Батмагнай дарга гайхаад, “яаж дүлий хүн цээжээр бичдэг юм, чи бараг өмнө нь цээжлүүлээд бэлтгэчихсэн юм биш үү?” гэж надад хэлж байсан. Тэгэхээр нь би уучлаарай дарга аа, тийм юм ерөөсөө байхгүй. Та тэгвэл надад хэдэн өгүүлбэр бичээд өг. Таны урууллаа уншиж чадахгүй учраас би өөрийнхөө урууллаас уншуулъя. Тэгээд “үнэхээр ямар сонин юм бэ?” гээд гайхаад гарч байсан. Нэг хэсэг энэ арга барил нэлээд их явж байсан ч сүүлийн үед энэ арга зүй байхгүй болсон.

Байхгүй болсон шалтгаан нь юу вэ?

Нэгдүгээрт яг ийм хичээл байхгүй болсон. Урууллаас унших гэдэг чинь биет зүйл, математик гэдэг шиг л хичээл. Урууллаас унших хичээлийг сургалтын цагаас хассан. Гэхдээ энэ хичээл бага ангид л ордог байсан. Манай төгссөн хүүхдүүдээс зарим нь амнаас маш сайн уншиж, хүлээж авч, ярьдаг.

Тэгэхээр өөрсдөө ойлгож байна. Буцаагаад тухайн хүндээ ойлгуулахын тулд яаж ойлгуулах вэ?

Бас яг өгөгдсөн үг хэллэгээр хариулна. Гэхдээ хүүхдүүд бусад ярих зүйлээ ч гэсэн амаараа ярихыг эрмэлздэг. Одоо ийм хүүхэд байхгүй юм шиг байна лээ. Би дохиог үгүйсгэхгүй, дэмжиж байгаа. Жишээлбэл, автобусны буудал дээр хүүхэд хаашаа явахаа мэдэхгүй эсвэл “Амгалан явъя” гээд дохиогоор хэлэхэд хүмүүс ойлгохгүй. “Би Амгалангийн автобусанд суух гэсэн юм, хэдэн номер байдаг вэ?” гээд бичээд өгвөл хүмүүс тусална. Гэхдээ одоо аман ба бичгийн арга зүй байхгүй болсон байх.

Сонсголын бэрхшээлтэй хүнийг гаднаас нь хараад мэдэх боломжгүй. Та энэ хүмүүстэй маш удаан ажилласан хүний хувьд нийгэмд эдгээр иргэдэд тулгараад байгаа асуудлууд юу байна вэ?

Сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд эмнэлэгт үзүүлэх зэрэг бусадтай харилцахад маш их асуудал үүсдэг. Саяхан ч гэсэн энэ дохионы хэлнийхээ нэг сарын өдрөөр талбай дээр хүүхдүүд зогсоод өөрийнхөө тулгамдаад байгаа асуудлуудыг маш их ярьж байсан. Энийг төр засаг сонссон байх гэж бодож байна. Тэргэнцэртэй иргэдэд би бас их санаа зовдог. Замаар явах, байгууллага руу орж гарахад маш хэцүү. Гэхдээ сүүлийн үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хандах хандлага ерөнхийдөө өөрчлөгдсөн гэж боддог.

Нийгмээс ирэх хандлага нь уу?

Тийм. Хандлага арай өөр, эерэг болсон гэж би боддог.

Танд цаашид ялангуяа сонсголын бэрхшээлтэй иргэдэд ийм зүйл бий болоосой, ийм бодлого хэрэгжээсэй гэсэн бодол байгаа юу?

Сургууль маань бүрэн дунд боловсрол эзэмшүүлдэг болсноос хойш хүүхдүүд их, дээд сургуульд шалгалт өгөөд орж байгаа. Гэтэл их, дээд сургуульд ороход хэлмэрч маш их хэрэгтэй. Бүр мэргэжлийн, шинжлэх ухааны үг хэллэгийг төгс орчуулдаг хэлмэрч хэрэгтэй байгаа. Болдог бол нэг хүүхдийг дагаад нэг хэлмэрч явах ёстой. Манай ангийн Аюурзана Монгол HD-д байхад заримдаа Саранчимэг багшийг, заримдаа ээжийгээ аваачдаг байсан. Ийм бэрхшээлүүд зөндөө гарч байгаа. Шинжлэх ухааны төвшинд мэргэжлийн хэлмэрчдийг бэлтгэх нь маш чухал. Гэхдээ манай хүүхдүүдийн үр хүүхдүүд нь хэлмэрч хийгээд явж байна. Соёлмаа Хэлмэрчдийн холбоо байгуулсан нь сонсголын бэрхшээлтэй хүмүүс цаашид сурч хөгжих үйл ажиллагаанд их үр дүн өгч байгаа учраас би Соёлмаад баярлаж, талархаж явдаг.

Монгол улсын хэмжээнд дохионы хэлний хэлмэрч, орчуулагч хэр их байдаг вэ?

Цөөхөн байгаа, 30 хүрэх үү, үгүй юу мэдэхгүй байна. Зөвхөн Боловсролын их сургууль биш бусад хувийн сургуульд ч

олон хүүхдүүд суралцаж байгаа болохоор бүх хичээлүүдийг нь сайхан орчуулаад, хэлмэрчлээд өгдөг л байх хэрэгтэй. Энийг боловсролын яам, шийдвэр гаргагч, бодлого боловсруулагч нар анхаарал аваасай гэж хүсэж байна.

Сонсголын бэрхшээлтэй иргэд мэдээллийг хэр хүртээмжтэй авч байна гэж боддог вэ?

Зарим дутагдалтай тал байгаа ч болж байгаа гэж би үзэж байна. Гэхдээ алдааг хөгжих боломж гэж харах ёстой. Хамтарч ажилладаг төрийн бус байгууллагууд сонсголын бэрхшээлтэй хүмүүсээс өөрсдөөс нь юу болж байна, яамаар байна гээд санал онолыг нь сонсож дээшээ төр засагт мэдээллээ өгвөл их үр дүнтэй болно. Эргээд бас мэдээлдэг байх хэрэгтэй. Сүүлийн үед төр засгийн шийдвэрүүдийг үнэхээр сайхан орчуулаад өгч байгаа. Бас аппликэйшн гаргасан. Миний бодлоор байнга очдог нийгмийн даатгал, эмнэлэг зэрэг газруудын ажилчдад дохионы хэлний сургалт хийх хэрэгтэй. Бид 30 сургагч багш бэлтгэж байсан. Тэрний хажуугаар 2008 онд цагдаа, эмч гээд хүүхдүүдэд үйлчилдэг байгууллагын хүмүүст сургалт зохион байгуулснаар тодорхой хэмжээний үр дүнд хүрч байсан.

Дохионы хэл сурахад амархан уу?

Үнэхээр бусдын төлөө гэсэн чин сэтгэлтэй хүн дохионы хэлийг сонирхвол сурна, хэн ч сурна.

Хэр хугацаанд суралцах боломжтой байдаг вэ?

Аливаа мэргэжлийг эзэмшихэд байнга хувьсан өөрчлөгдөж байгаа учраас байнга суралцах хэрэгтэй. Хэл заслын багш нар тухайн хүүхдэд энэ авиаг яаж тавих вэ, ямар аргаар хүүхдэдээ хүргэх вэ гэдэг арга зүй суралцахын зэрэгцээгээр, яг хүүхдээс өөрөөс нь намайг ингээч гэсэн арга бид нарт бодогдож орж ирдэг. Тэрэнтэй адилхан гэж би үзэж байна.





Сонсголын бэрхшээлтэй хүүхдүүд гэлтгүй хэл ярианы бэрхшээлтэй хүүхдүүд ч гэсэн 29-р сургуульд явдаг байсан уу?

Дээр үед маш олон ангитай байсан. Сүүлийн үед хүүхдийн тоо 1 анги дүүргэх боломжгүй бол сул сонсголтой хүүхдүүдтэйгээ хамт хэл ярианы бэрхшээлтэй хүүхдүүдийг сургаж байсан. Гэхдээ хэл ярианы бэрхшээлтэй хүүхдүүд харьцангуй цөөхөн байдаг байсан. Хэл ярианы бэрхшээлтэй, ерөнхий боловсролын сургуульд сурдаг хүүхдүүд байна. Зарим нь Р үсэг хэлж чадахгүй. Корона гарахаас өмнө Ховд, Увс, Дархан, Сэлэнгээс ирсэн ийм хүүхдүүдтэй би нэлээд тааралдсан. Тэд нарын сонсгол сайн учраас онлайнаар хэд хэдэн сургалтыг зохион байгуулж байсан.

Хэл ярианы бэрхшээлтэй хүүхдүүд ерөнхий боловсролын сургуульд явж байгаа гэсэн үг үү?

Тийм учраас ерөнхий боловсролын сургуульд хэл засалч багш байх шаардлагатай. Хэл засалч багш нарыг бэлтгэх хэрэгтэй. Над дээр эр авиа хэлж чаддаггүй, оюутан болчихсон 2-3 хүүхэд “мэргэжилдээ гологдох гээд байна” гээд ирж байсан. Тэд нар мэргэжил нь чухал гэдгийг ойлгосон учраас хэл яриа нь засагдсан. Тэр хүүхдүүд “сургуулиа хэлэхгүй, нэрээ хэлэхгүй” гэж байсан. Би “зүгээр ээ, зүгээр зүгээр. Гол нь би та нарт тусалж чадах нь уу” гэтэл буцаад “багш аа гоё болчихсон шүү” гэж байсан. Зарим хүмүүс “аав эсвэл ээж нь орой хэлд орсон, тэгж байгаад л болчихно” гэж байдаг. Тэгээд хүүхдээ баллаад байгаа юм. Битгий тийм байгаасай гэж бодож байна.

Монголд хэл засалч багш нар хэр их байдаг вэ?

Манай 29-р сургууль ажиллаж байсан 2 согог зүйн багш өнгөрсөн жил тэтгэвэртээ гарсан ч эргээд ажилдаа орсон. Гэхдээ бид нар залуу байхдаа авианууд ыг яаж

тавих вэ, яаж засах вэ? гэсэн арга зүйг бага ангийн багш нартаа сургаад, тэд бидэнтэй адилхан эзэмшээд, ажиллаад явдаг байсан. Одоо бол орхигдсон байх гэж бодож байна.

Тэгэхээр хүн хүчний дутагдалд орсон гэж үг үү?

Үнэхээр тусгай хэрэгцээт боловсролыг жаахан анхааараасай гэж бодож байна. Боловсон хүчин байхгүй болсон. Гэхдээ яамнаас Унгар зэрэг хэд хэдэн орон руу хүүхдүүдийг явуулсан, зарим нь төгсөж ирсэн. Манайхаас явсан математикийн багш Бямбажав боловсролын их сургуулийн тусгай хэрэгцээт факултетад багшаар орсон гэсэн сайхан мэдээ би сонсоод баярлаад байгаа.

Улсын хэмжээнд тийм цөөхөн багштай байна гэдэг бас л хэцүү зүйл байна даа.

Тийм тийм. Бид нар зөвхөн 29-р сургуулийн багш байсан бол ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүд дээр бас ажиллаж байгаа. Би маршал таун дээр Бяцхан монгол гэдэг цэцэрлэгт Р үсэг хэлж чаддаггүй нэг хүүхэдтэй дуу хөгжмийнх нь кабинетад ажилладаг байсан. Тэгэхэд хүүхдүүд маш хөөрхөн "багш аа, багш аа, хэлний багш аа би энийг хэлж чадахгүй байна, би С-ийг Ш-ээр хэлээд байдаг юм" туслаач гэсэн хүүхдүүдийг харахаар өрөвдөөд байдаг юм.

Сүүлийн үед тань дээр хэлээ сайжруулах гээд ирж байгаа эцэг эхчүүд, хүүхдүүд хэр их байна?

Ер нь бол байгаа. Саяхан "би хувийн ажилтай болоод байна чи үүн дээр нэг ажиллаач" гээд Наранчимэг захирал өгсөн. Бас эцэг эхчүүдийн группууд байдаг юм байна. "Та манай хүүхдийг үзээд, хараад өгөөч" гэдэг. Одоо цаг үе нь маш хэцүү, хамт сууж хичээл хийх ёстой зарим хүүхдүүдэд хамт хичээл хийх боломж байхгүй. Төгс ярьдаг болсон ч хэдхэн авиан дээр асуудалтай хүүхдийг онлайн аваад хэдэн удаа өгүүлэх эрхтний дасгал хийгээд, зааварчлаад, түргэн хэллэг, зугаа үг гээд янз янзын дасгал хийлгэхэд зарим хүүхдүүд маш хөөрхөн цэвэр дууддаг болдог. Цэвэр ярьдаг болсон хүүхдүүддээ үнэхээр баярладаг. Энэ дээр хэлж засалч багш үнэхээр хэрэгтэй. Гэхдээ манай сайд нэлээн хөдөлгөөнтэй, сүрхий сүрхий юм хийдэг сайд байна гэж би бодоод байгаа. Хамгийн эхэнд бараг тусгай хэрэгцээт боловсролын салбарынхантай уулзсан. Зарим уулзалт дээр хэл засалч багшийн асуудал гарч ирж байсан. Тэгээд Энх-Амгалан сайдыг эрч хүчтэй, дажгүй сайн ажиллах юм байна. Салбарынхаа бүх ажилтнуудыг ялангуяа тусгай хэрэгцээт боловсролын багш нарыг хамгийн түрүүн хүлээж авч байгаад нь би сайн байна гэж хүлээж авч байгаа.

Манай подкастын Цаг өндөрлөх дөхөж байна. Танаас сүүлийн асуултаа асууя. Та тусгай хэрэгцээт боловсролын салбарт олон жил ажилласан хүний хувьд цаашид энэ салбарыг ямар болоосой гэж боддог вэ? Бас нийгэм хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг яаж хараасай, яаж хүлээж аваасай гэж боддог вэ?

